

# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2006 оны 8 дугаар сарын 1-ний өдөр

ТУСГАЙ ДУГААРЫН VI БОТЬ

## ГАРЧИГ

92. Олон улсын зэвсэгт мөргөлдөөнд хэлмэгдэгсийг хамгаалах тухай 1949 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн Женевийн конвенцуудын нэмэлт I протокол .....	1246
93. Олон улсын бус шинж чанартай зэвсэгт мөргөлдөөнд хэлмэгдэсдийг хамгаалах тухай 1949 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн Женевийн конвенцуудын нэмэлт II протокол .....	1314
94. Зэвсэгт мөргөлдөөний үед соёлын үнэт зүйлийг хамгаалах тухай конвенц .....	1325
95. Байгаль орчинд нөлөөлөх арга хэрэгслийг цэрэг дайны болон дайсагнах бусад аливаа зорилгоор ашиглахыг хориглох тухай конвенц.....	1347
96. Амьсгал боогдуулагч, хортой буюу тэдгээртэй ижил бусад хий болон бактериологийн хэрэгслийг дайнд хэрэглэхийг хориглох тухай протокол.....	1351
97. Бактериологийн (биологийн) болон токсины зэвсэг боловсруулах, үйлдвэрлэх, нөөцлөхийг хориглох болон тэдгээрийг устгах тухай конвенц.....	1352
98. Үлэмж хохирол учруулах буюу нэлд нь хөнөөх чанартайд тооцогдох тодорхой төрлийн ердийн зэвсэг хэрэглэхийг хориглох буюу хязгаарлах тухай конвенц.....	1357
99. Илрүүлэх боломжгүй хэлтэрхийн тухай протокол (I протокол).....	1363
100. Мина, урхин мина болон бусад төхөөрөмж хэрэглэхийг хориглох буюу хязгаарлах тухай протокол (II протокол).....	1364
101. Шатаах зэвсгийг хэрэглэхийг хориглох буюу хязгаарлах тухай протокол (III протокол).....	1369
102. Нүд сохлогч лазерийн зэвсгийн тухай протокол (IV протокол).....	1371
103. Химийн зэвсгийг боловсруулах, үйлдвэрлэх, нөөцлөх болон хэрэглэхийг хориглох, түүнийг устгах тухай конвенц.....	1372

**92. ОЛОН УЛСЫН ЗЭВСЭГТ МӨРГӨЛДӨӨНД ХЭЛМЭГДЭГСДИЙГ ХАМГААЛАХ  
ТУХАЙ 1949 ОНЫ 8 ДУГААР САРЫН 12-НЫ ӨДРИЙН ЖЕНЕВИЙН  
КОНВЕНЦУУДЫН НЭМЭЛТ I ПРОТОКОЛ**

*1977 оны 6 дугаар сарын 8-ны өдөр баталж,  
1978 оны 12 дугаар сарын 7-ны өдөр хүчин төгөлдөр болсон\**

*Удиртгал*

Хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд,

ард түмэн энх амгалан нөхцөлд аж төрөх чин эрмэлзлэлээ илэрхийлж,

улс бүр Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрмийн дагуу олон улсын харилцаандаа аливаа улсын бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал болон улс төрийн тусгаар тогтолын эсрэг хүч хэрэглэхээр сүрдүүлэх буюу хүч хэрэглэх, Нэгдсэн Үндэстний Байгууллагын зорилготой үл нийцэх аливаа үйлдлээс зайлсхийх үүрэгтэйг сануулж,

зэвсэгт мөргөлдөөнд хэлмэгдэгсдийг хамгаалах тухай заалтуудыг бататган хөгжүүлэх, тэдгээрийг улам үр нөлөөтэй хэрэгжүүлэх явдлыг хангахад чиглэсэн нэмэлт арга хэмжээ шаардлагатай байна гэж үзэж,

энэхүү протокол болон 1949 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн Женевийн конвенцуудийн аль ч заалтыг Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрэмтэй үл нийцэх аливаа түрэмгийлэл, эсхүл хүч хэрэглэх аливаа явдлыг хуульчлан зөвшөөрсөн гэж тайлбарлаж болохгүй гэсэн итгэл үнэмшилээ илэрхийлэн,

1949 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн Женевийн Конвенцууд болон энэхүү протоколын заалтуудыг эдгээр баримт бичгээр хамгаалагдаж байгаа бүх хүмүүсийн хувьд зэвсэгт мөргөлдөөний мөн чанар, гарал үүсэл болон түүнд оролцогч талуудаас гаргаж буй, эсхүл тэдгээрт хамаарах шалтгаануудад үндэслэсэн аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхалгүйгээр бүх нөхцөлд бүрэн хэрэглэх ёстойг дахин нотолж,

дараах зүйлийг хэлэлцэн тохиров:

**I АНГИ**

**НИЙТЛЭГ ЗААЛТ**

*1 дүгээр зүйл*

**Нийтлэг зарчим, хэрэглэх хүрээ**

1. Хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд энэхүү протоколыг бүх нөхцөл байдалд хүндэтгэн сахих буюу хүндэтгэн сахих явдлыг хангах үүрэг хүлээнэ.

\* Монгол Улс 1977.12.12-нд гарын үсэг зурж, 1995.11.17-нд нэгдэн орсон

2. Энэхүү протокол, эсхүл олон улсын бусад хэлэлцээрт хамрагдаагүй тохиолдолд ч энгийн иргэд болон цэргийн хүмүүс нь тогтсон заншил, хүмүүнлэг ёсны зарчмууд болон нийгмийн ухамсрын шаардлагаас үүдэн гарсан олон улсын эрх зүйн зарчмуудын хамгаалалт, ивээлийн дор байсаар байна.

3. 1949 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн Женевийн Конвенцуудад нэмэлт болгож буй дайнд хэлмэгдэгсдийг хамгаалах тухай энэхүү протоколыг Женевийн Конвенцуудын нийтлэг 2 дугаар зүйлд дурдсан нөхцөлд хэрэглэнэ.

4. Нэгдсэн Үндэстний Байгууллагын` дүрэм болон уг дүрмийн дагуу гаргасан Улс түмний хоорондын найрсаг харилцаа, хамтын ажиллагааны талаархи олон улсын эрх зүйн зарчмуудын тухай тунхаглалд бататган тусгасан өөртөө засан тохинох эрхийг хэрэгжүүлэх зорилгоор ард түмэн колонийн дарлал, гадаадын түрэмгийлэл, арьсны үзэлт дэглэмийн эсрэг тэмцэж байгаа зэвсэгт мөргөлдөөнийг өмнөх хэсэгт дурдсан нөхцөл байдалд мөн хамааруулна.

*2 дугаар зүйл*

#### **Тодорхойлолт**

Энэхүү протоколын зорилгод:

(a) "Нэгдүгээр конвенц", "Хоёрдугаар конвенц", "Гуравдугаар конвенц" болон "Дөрөвдүгээр конвенц" гэж Дайны талбарт байгаа зэвсэгт хүчний шархтан, өвчтөний нөхцөл байдлыг сайжруулах тухай 1949 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн Женевийн конвенц, Тэнгисийн зэвсэгт хүчний шархтан, өвчтөн болон хөлөг онгоцны сүйрэлд өртөгдөгсдийн нөхцөл байдлыг сайжруулах тухай 1949 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн Женевийн конвенц, Дайнд олзлогдогчидтой харьцах тухай 1949 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн Женевийн конвенц, Дайны үед энгийн хүмүүсийг хамгаалах тухай 1949 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн Женевийн конвенцийг тус тус хэлнэ. "Конвенцууд" гэж Дайнд хэлмэгдэгсдийг хамгаалах тухай 1949 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн Женевийн дөрвөн конвенцийг хэлнэ.

(b) "Зэвсэгт мөргөлдөөний үед хэрэглэх олон улсын эрх зүйн хэм хэмжээ" гэж зэвсэгт мөргөлдөөний үед хэрэглэх мөргөлдөөнд оролцогч талуудын нэгдэн орсон олон улсын хэлэлцээрүүдэд тусгагдсан хэм хэмжээ, түүнчлэн зэвсэгт мөргөлдөөний үед хэрэглэж болох олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, хэм хэмжээг тус тус хэлнэ.

(c) "Хамгаалагч гүрэн" гэж Конвенцууд болон энэхүү протоколын дагуу хамгаалагч гүрэнд ногдуулсан үүргийг гүйцэтгүүлэхээр мөргөлдөөнд оролцогч аль нэг талаас томилсон бөгөөд эсрэг тал нь хүлээн зөвшөөрсөн, тийм үүрэг биелүүлэхийг өөрөө зөвшөөрсөн, төвийг сахисан буюу мөргөлдөөнд оролцогч бус аль нэг улсыг хэлнэ.

(d) "Орлогч" гэж 5 дугаар зүйлийн дагуу хамгаалагч гүрний үүргийг орлон гүйцэтгэх байгууллагыг хэлнэ.

**3 дугаар зүйл**

**Хэрэглэж эхлэх, дуусгавар болгох**

Дараахь зүйлийн хувьд хэрэглэх заалтуудыг аль ч үед хөндөхгүйгээр:

(а) Энэхүү протоколын 1 дүгээр зүйлд дурдсан аливаа нөхцөл байдал бий болох үеэс эхэлж Конвенцууд болон энэхүү протоколыг хэрэглэнэ.

(б) Мөргөлдөөнд оролцогч талуудын нутаг дэвсгэр дээр цэргийн үйл ажиллагаа ерөнхийдөө зогссон үед, харин эзлэгдсэн нутаг дэвсгэрийн хувьд эзлэн түрэмгийлэл зогссон тохиолдолд Конвенцууд болон энэхүү протоколыг хэрэглэхийг дуусгавар болгоно. Харин дараа нь бүрмөсөн чөлөөлөх, эх оронд нь буцаах, эсхүл төвхнөн суурьшуулах этгээдийн хувьд дээрх тохиолдол хамаarahгүй. Эдгээр хүмүүст бүрмөсөн чөлөөлөгдөх, эх орондоо буцах, эсхүл төвхнөн суурьших хүртлээ Конвенцууд болон энэхүү протоколын холбогдох заалтын дагуу ивээл хамгаалалд байсаар байна.

**4 дүгээр зүйл**

**Мөргөлдөөнд оролцогч талуудын эрх зүйн байдал**

Конвенцууд болон энэхүү протоколыг хэрэглэх, түүнчлэн эдгээр баримт бичигт тусгасан хэлэлцээрүүдийг байгуулах нь мөргөлдөөнд оролцогч талуудын эрх зүйн байдлыг хөндөхгүй. Аливаа нутаг дэвсгэрийг эзлэн түрэмгийлэх буюу Конвенцууд болон энэхүү протоколыг хэрэглэх явдлын аль нь ч тухайн нутаг дэвсгэрийн эрх зүйн байдлыг мөн хөндөхгүй.

**5 дугаар зүйл**

**Хамгаалагч гүрнүүд болон тэдгээрийн үүргийг орлон  
гүйцэтгэх байгууллагыг томилох**

1. Мөргөлдөөнд оролцогч талуудын үүрэг нь дараахь заалтуудын дагуу хамгаалагч гүрнүүдийг томилох, хүлээн зөвшөөрөх, түүнчлэн хамгаалагч гүрний тогтолцоог буй болгох замаар мөргөлдөөн эхлэх үеэс Конвенцууд болон энэхүү протоколыг дагаж мөрдөх, хэрэглэхэд оршино. Хамгаалагч гүрнүүд мөргөлдөөнд оролцогч талуудын эрх ашгийг хамгаалах үүрэгтэй.

2. Конвенцууд болон энэхүү протоколыг хэрэглэх зорилгоор мөргөлдөөнд оролцогч тал тус бүр 1 дүгээр зүйлд дурдсан нөхцөл байдал үүсэх үеэс хамгаалагч гүрнийг даруй томилж, түүнчлэн эл зорилгоор эсрэг талаас томилсон хамгаалагч гүрнийг хүлээн зөвшөөрч, үйл ажиллагаагаа даруй явуулж эхлэхийг зөвшөөрнө.

3. Хэрэв хамгаалагч гүрнийг 1 дүгээр зүйлд дурдсан нөхцөл байдал үүсэх үеэс томилоогүй буюу хүлээн зөвшөөрөгүй тохиолдолд мөргөлдөөнд оролцогч талуудын зөвшөөрснөөр хамгаалагч гүрнийг даруй томилох зорилгоор Олон улсын улаан загалмайн хороо, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулах хүмүүнлэгийн бусад байгууллагын эрхийг хохирохгүйгээр мөргөлдөөнд оролцогч талуудад өөрийн сайн санааны туслалцааг санал болгоно. Тухайлбал эл зорилгоор эсрэг талын хувьд өөрийн нь нэрийн өмнөөс хамгаалагч гүрнээр ажиллаж болно гэж үзсэн наад зах нь 5 улсын нэrsийн жагсаалт, мөн эсрэг тал нь нөгөө талынхаа хувьд түүний нэрийн өмнөөс хамгаалагч гүрнээр ажиллаж болохыг нь зөвшөөрнө гэж үзсэн мөн наад зах нь 5 улсын нэrsийн

жагсаалтыг гаргаж өгөхийг Хороо тал тус бүрээс хүсч болно. Талууд ийм хүсэлтийг хүлээн авсаас хойш 2 долоо хоногийн дотор уг нэrsийн жагсаалтыг гаргаж Хороонд мэдээлэх ёстой бөгөөд Хороо эдгээр нэrsийн жагсаалтыг харьцуулан үзэж, хоёр талын нэrsийн жагсаалтад орсон аль нэг улсаас зөвшөөрлийг нь хүснэ.

4. Хэрэв дээр дурдсанаар хамгаалагч гүрний талаар тохиролцож чадаагүй тохиолдолд мөргөлдөөнд оролцогч талууд Олон улсын улаан загалмайн хороо, эсхүл чин шударгаар үр нөлөөтэй ажиллах бүх талын баталгаа өгч байгаа аливаа бусад байгууллагаас мөргөлдөөнд оролцогч талуудтай зөвлөлдсөний дараа уг зөвлөлдөөний үр дүнг харгалзан хамгаалагч гүрнийг орлох талаар гаргасан саналыг даруй хүлээн авна. Тухайн орлогч мөргөлдөөнд оролцогч талуудын зөвшөөрснөөр үйл ажиллагаага явуулна. Тухайн орлогч Конвенцууд болон энэхүү протоколын дагуу үйл ажиллагаага явуулах, зорилгоо хэрэгжүүлэхд нь мөргөлдөөнд оролцогч талууд бүх талын тус дэмжлэг үзүүлнэ.

5. Конвенцууд болон энэхүү протоколыг хэрэглэх зорилгоор 4 дүгээр зүйлийн дагуу хамгаалагч гүрнийг томилж, хүлээн зөвшөөрөх нь мөргөлдөөнд оролцогч талуудын буюу эзлэгдсэн нутаг дэвсгэрийг оролцуулан аливаа нутаг дэвсгэрийн эрх зүйн байдлыг хөндөхгүй.

6. Мөргөлдөөнд оролцогч талууд хоорондоо дипломат харилцаатай байх, эсхүл дипломат харилцааны талаархи олон улсын эрх зүйн хэм хэмжээний дагуу аль нэг талын болон түүний иргэдийн эрх ашгийг хамгаалах асуудлыг гурав дахь улсад даалгах нь Конвенцууд болон энэхүү протоколыг хэрэгжүүлэх зорилгоор хамгаалагч гүрнийг томилоход саад болохгүй.

7. Энэхүү протоколд хамгаалагч гүрний талаар дурдсан зүйл нь түүний орлогчид нэгэн адил хамаарна.

#### *6 дугаар зүйл*

#### **Тусгайлан бэлтгэсэн ажилтан**

1. Хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд Улаан загалмай (Улаан хавирган сар, Улаан арслан болон нар)-н үндэсний нийгэмлэгүүдийн тусlamжтайгаар тайван цагт ч Конвенцууд болон энэхүү протоколыг хэрэглэх, тухайлбал хамгаалагч гүрний үйл ажиллагаанд тус дөхөм үзүүлэх зорилгоор тусгайлан ажилтан бэлтгэх талаар хүч чармайлт гаргана.

2. Ийм ажилтныг дотоодын хууль тогтоомжийн хүрээнд шилж сонгож, бэлтгэнэ.

3. Олон улсын улаан загалмайн хороо нь хэлэлцэн тохирогч эрхэм дээд талуудын ийнхүү бэлтгэсэн бөгөөд эл зорилгоор уг хороонд илгээж болох ажилтны нэrsийн жагсаалтыг хэлэлцэн тохирогч эрхэм дээд талуудад өгөхөөр хадгална.

4. Эдгээр ажилтныг гадаад улсад ажиллуулах нөхцлийг холбогдох талуудын хооронд байгуулсан тусгай хэлэлцээрээр тухай бүр зохицуулж байна.

7 дугаар зүйл

### **Үулзалт**

Энэхүү протоколыг хадгалагч хэлэлцэн тохирогч эрхэм дээд тал нэг буюу хэд хэдэн талын хүсэлт болон хэлэлцэн тохирогч эрхэм дээд талуудын олонхийн зөвшөөрснөөр Конвенцууд болон энэхүү протоколыг хэрэгжүүлэхтэй холбогдсон нийтлэг асуудлыг хэлэлцэхээр Хэлэлцэн тохирогч эрхэм дээд талуудын уулзалтыг зарлан хуралдуулна.

## **II АНГИ**

### **ШАРХТАН, ӨВЧТӨН БОЛОН ХӨЛӨГ ОНГОЦНЫ СҮЙРЭЛД ӨРТӨГДӨГСӨД I ХЭСЭГ**

#### **Нийтлэг хамгаалалт**

8 дугаар зүйл

#### **Нэр томъёо**

Энэхүү протоколын зорилгод:

(а) "Шархтан" болон "өвчтөн" гэж гэмтэл, өвчин, бие махбодь, эсхүл сэтгэхүйг нь сарниулсан, эсхүл тахир дутуу болсны улмаас эмнэлгийн тусламж авах, эсхүл асуулах шаардлагатай байгаа дайтах аливаа ажиллагаанаас татгалзсан цэргийн албан хаагч, эсхүл энгийн хүнийг хэлнэ. Эдгээр нэр томъёонд амаржсан эх, нярай хүүхэд болон тухайн үед эмнэлгийн тусламж авах, эсхүл асуулах шаардлагатай бусад хүн, тухайлбал аливаа дайтах ажиллагаанаас татгалзаж байгаа жирэмсэн эхчүүд буюу биеэ асран хамгаалах чадваргүй хүмүүс мөн хамаарна.

(б) "Хөлөг онгоцны сүйрэлд өртөгдөгсөд" гэж тээвэрлэж яваа усан онгоц буюу агаарын хөлөг нь, эсхүл өөрсдөө золгүй тохиолдлын улмаас далай буюу бусад усанд аюулд орсон дайтах аливаа ажиллагаанаас татгалзсан цэргийн албан хаагч, эсхүл энгийн хүнийг хэлнэ. Эдгээр хүмүүсийг аливаа дайтах ажиллагаанаас үргэлжлүүлэн татгалзах тохиолдолд, тэднийг аврах үеийн туршид, түүнчлэн Конвенцууд болон энэхүү протоколын дагуу эрх зүйн өөр байдалтай болох хүртэл нь хөлөг онгоцны сүйрэлд өртөгдөгсдөд үргэлжлүүлэн хамааруулна.

(с) "Эмнэлгийн ажилтнууд" гэж "е" заалтад дурдсан зөвхөн эмнэлгийн зорилгоор, эсхүл эмнэлгийн албаны захиргаа, эсхүл эмнэлгийн тээврийн хэрэгслийн удирдлага, үйл ажиллагаанд ажиллуулахаар мөргөлдөөнд оролцогч талаас томилсон хүмүүсийг хэлнэ. Тэднийг байнга, эсхүл түр ажиллуулахаар томилж болно. Энэ нэр томъёонд дараах хүмүүсийг хамааруулна:

(i) Нэгдүгээр болон Хоёрдугаар конвенцид дурдсан хүмүүс, түүнчлэн иргэний хамгаалалтын байгууллагад томилогдсон ажилтнуудыг оролцуулан мөргөлдөөнд оролцогч талын эмнэлгийн ажилтан нь цэргийн, эсхүл энгийн байж болно;

- (ii) мөргөлдөөнд оролцогч тал зохих ёсоор хүлээн зөвшөөрч эрх олгосон Улаан загалмай (Улаан хавирган сар, Улаан арслан болон нар)-н үндэсний нийгэмлэгүүд, тусlamжийн сайн дурын үндэсний бусад нийгэмлэгийн эмнэлгийн ажилтан;
- (iii) 9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт дурдсан эмнэлгийн алба, эмнэлгийн тээврийн хэрэгсэл , эсхүл эмнэлгийн ажилтан.

(d) "Шашны ажилтан" гэж дор дурдсан газарт болон байгууллагад харьялагдан, зөвхөн сүсэг бишрэлийн үйл ажиллагааг дагнан гүйцэтгэдэг цэргийн, эсхүл энгийн хүнийг хэлнэ:

- (i) мөргөлдөөнд оролцогч талын зэвсэгт хүчинд;
- (ii) мөргөлдөөнд оролцогч талын эмнэлгийн алба, эсхүл эмнэлгийн тээврийн хэрэгсэлд;
- (iii) 9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт дурдсан эмнэлгийн алба, эсхүл эмнэлгийн тээврийн хэрэгсэлд;
- (iv) мөргөлдөөнд оролцогч талын иргэний хамгаалалтын байгууллагад.

Шашны ажилтныг байнга, эсхүл түр хугацаагаар ажиллуулахаар томилж болох бөгөөд энэ зүйлийн "k" -д дурдсан холбогдох заалтыг тэдэнд хэрэглэнэ.

(e) "Эмнэлгийн алба" гэж шархтан, өвчтөн, хөлөг онгоцны сүйрэлд өртөгдөгсдийг эрж хайх, цуглуулах, тээвэрлэх, онош тогтоох, эсхүл эмчлэх, тэдэнд анхны тусlamж үзүүлэх, түүнчлэн өвчинөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах зэрэг эмнэлгийн зорилгоор байгууллагдсан цэргийн буюу иргэний байгууллагууд, бусад албыг хэлнэ. Энэ нэр томъёонд, тухайлбал эмнэлгүүд, түүнтэй төстэй эмнэлгийн бусад нэгж, цусны болон эмийн төвүүд, хүрээлэн, эдгээрийн эмнэлгийн эд хөрөнгө, эмийн агуулахыг хамааруулна. Эмнэлгийн алба нь суурин, эсхүл нүүдлийн, байнга, эсхүл түр ажиллагаатай байж болно.

(f) "Эмнэлгийн тээвэрлэлт" гэж Конвенцууд болон энэхүү протоколын хамгаалалд байгаа шархтан, өвчтөн, хөлөг онгоцны сүйрэлд өртөгдөгсөд, түүнчлэн эмнэлгийн болон шашны ажилтан, эмнэлгийн тоног төхөөрөмж, эсхүл эмнэлгийн хангамжийн зүйлсийг хуурай газар, ус, эсхүл агаараар зөөвөрлөхийг хэлнэ.

(g) "Эмнэлгийн тээврийн хэрэгсэл" гэж зөвхөн эмнэлгийн тээвэрлэлтэд зориулагдсан бөгөөд мөргөлдөөнд оролцогч талын эрх бүхий байгууллагын хяналтанд байгаа цэргийн, эсхүл иргэний, байнгын, эсхүл түр хугацаагаар ажиллах тээврийн аливаа хэрэгслийг хэлнэ.

(h) "Эмнэлгийн тээврийн газраар явагч хэрэгсэл" гэж хуурай газраар тээвэрлэлт хийхэд хэрэглэх эмнэлгийн тээврийн аливаа хэрэгслийг хэлнэ.

(i) "Эмнэлгийн хөлөг онгоц болон хөвөгч хэрэгсэл" гэж усаар тээвэрлэлт хийхэд хэрэглэх эмнэлгийн тээврийн аливаа хэрэгслийг хэлнэ.

(j) "Эмнэлгийн агаарын хөлөг" гэж агаараар тээвэрлэлт хийхэд хэрэглэх эмнэлгийн тээврийн аливаа хэрэгслийг хэлнэ.

(k) "Эмнэлгийн байнгын ажилтан", "эмнэлгийн байнгын алба", "эмнэлгийн байнгын тээврийн хэрэгсэл" гэж тодорхой бус хугацаагаар, зөвхөн эмнэлгийн зорилгоор ажиллаж буюу ашиглаж байгааг хэлнэ. "Эмнэлгийн түр ажилтан", "эмнэлгийн түр алба" "эмнэлгийн тээврийн түр хэрэгсэл" гэж нэгэн тодорхой үеийн турш хязгаарлагдмал хугацаанд зөвхөн эмнэлгийн зорилгоор ажиллаж буюу ашиглаж байгааг хэлнэ. Өөрөөр заагаагүй тохиолдолд "эмнэлгийн ажилтан", "эмнэлгийн албад", "эмнэлгийн тээврийн хэрэгсэл" гэсэн нэр томьёонд байнгын болон түр хугацаагаар ажиллахын аль алийг хамааруулна.

(l) "Ялгах тэмдэг" гэж эмнэлгийн алба, эмнэлгийн тээврийн хэрэгсэл, эмнэлгийн болон шашны ажилтан, тоног төхөөрөмж, эсхүл хангамжийн зүйлсийг хамгаалахад ашиглаж буй Улаан загалмай, Улаан хавирган сар, эсхүл Улаан арслан, улаан нарыг цагаан дэвсгэр дээр буулгасан ялгах тэмдгийг хэлнэ.

(m) "Ялгах дохио" гэж энэхүү протоколын I хавсралтын III бүлгийн дагуу зөвхөн эмнэлэг, эсхүл эмнэлгийн тээврийн хэрэгслийг таних зорилгоор тогтоосон аливаа дохио, эсхүл мэдээллийг хэлнэ.

*9 дүгээр зүйл*

#### **Хэрэглэх хүрээ**

1. Шархтан, өвчтөн, хөлөг онгоцны сүйрэлд өртөгдөгсдийн нөхцөл байдлыг сайжруулахад чиглэсэн энэ ангийн заалтуудыг 1 дүгээр зүйлд дурдсан нөхцөлд өртсөн бүх хүнд арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэсний, эсхүл нийгмийн гарал үүсэл, эд хөрөнгө, төрсөн болон бусад байдал, эсхүл эдгээртэй төсөөтэй аливаа бусад шалгуурт үндэслэн ялгаварлан гадуурхалгүйгээр хэрэглэнэ.

2. Нэгдүгээр конвенцийн 27, 32 дугаар зүйлийн холбогдох заалтыг мөргөлдөөнд оролцогч талд хүмүүнлэгийн зорилгоор дор дурдсан этгээдээс гаргах эмнэлгийн байнгын алба, эмнэлгийн тээврийн хэрэгсэл (Хоёрдугаар конвенцийн 25 дугаар зүйлийг эмнэлгийн хөлөг онгоцонд хэрэглэнэ) болон тэдгээрийн ажилнуудын хувьд хэрэглэнэ:

(a) төвийг сахисан, эсхүл мөргөлдөөнд оролцогч бус улсаас;

(b) тийм улсын хүлээн зөвшөөрч бүрэн эрх олгосон тусlamжийн нийгэмлэгээс;

(c) олон улсын хүмүүнлэгийн байгууллагаас.

*10 дугаар зүйл*

#### **Хамгаалах болон асрах**

1. Бүх шархтан, өвчтөн, хөлөг онгоцны сүйрэлд өртөгдөгсдөд аль талд харьяалагдаж байгааг үл харгалзан хүндэтгэл үзүүлж хамгаалалтанд байлгана.

2. Бүх нөхцөл байдалд тэдэнтэй хүnlэг ёсоор харьцаж, тэдний эрүүл мэндийн байдал шаардаж байгаа тохиолдолд эмнэлгийн тусламж, асрамжийг аль болох түргэн хугацаанд бүрэн хэмжээгээр үзүүлнэ. Эмнэлгийн бус өөр ямар нэг шалтгаанаар тэдэнд ялгавартай хандаж болохгүй.

### *11 дүгээр зүйл*

#### **Зарим хүмүүсийг хамгаалах**

1. 1 дүгээр зүйлд дурдсан нөхцөл байдал бий болсны улмаас эсрэг талынхаа эрх мэдэлд орсон, эсхүл эрх чөлөө нь хязгаарлагдсан, албадан саатуулагдсан, эсхүл ямар нэг байдлаар эрх чөлөө нь хасагдсан хүмүүсийн бие маходь, сэтгэхүйн эрүүл мэнд болон тэдний халдашгүй байдалд аливаа хууль бус үйлдэл хийх, эсхүл алдаа гарган хохирол учруулж болохгүй. Энэ зүйлд заасан хүмүүсийг тэдний эрүүл мэндийн байдал шаардаагүй байхад нь эмнэлгийн үйл ажиллагааг гүйцэтгэж буй талын иргэдэд болон эрх чөлөө нь хязгаарлагдаагүй аливаа хүмүүсийн адил нөхцөл байдалд хэрэглэх нийтээр хүлээн зөвшөөрсөн эмчилгээний хэм хэмжээнд нийцэхээргүй аливаа эмчилгээнд оруулахыг хориглоно.

2. Эдгээр хүмүүс өөрсдөө зөвшөөрсөн ч, тухайлбал:

- (a) бие маходид нь хүнд гэмтэл учруулах;
- (b) эмнэлгийн болон шинжлэх ухааны туршилт хийх;

(c) эд эсийг авах, эсхүл эрхтэн шилжүүлэн суулгахыг тус тус хориглоно. Гэхдээ энэ зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан нөхцлийн дагуу зөвтгэж болох үйлдлийг үүнд үл хамааруулна.

3. Сайн дураараа аливаа албадлага, ятгалагагүйгээр, зөвхөн эмчилгээний зорилгоор, нийтээр хүлээн зөвшөөрсөн эмчилгээний хяналт, хэм хэмжээний дагуу, донор болон цус сэлбүүлэгчийн аль алины нь эрүүл мэндэд ашигтай байх нөхцөлд арьс, цус өгөх явдлыг энэ зүйлийн 2-ын “с” хэсэгт заасан хориглосон зүйлд үл хамааруулна.

4. Аль нэг талын эрх мэдэлд байгаа өөр талын харьят аливаа хүмүүсийн бие маходь болон сэтгэхүйн эрүүл мэнд, эсхүл тэдний халдашгүй байдалд ноцтой заналхийлсэн, эсхүл энэ зүйлийн 1 болон 2 дахь хэсэгт дурдсан аль нэг хоригийг зөрчсөн, эсхүл мөн зүйлийн 3 дахь хэсгийн шаардлагыг биелүүлээгүй санаатай аливаа үйлдэл, эсхүл зориуд гаргасан алдааг энэхүү протоколыг ноцтой зөрчсөн гэж үзнэ.

5. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан хүмүүс аливаа мэс засал хийлгэхээс татгалзах эрхтэй. Ийнхүү татгалзсан тохиолдолд эмнэлгийн ажилтан тухайн өвчтнөөс татгалзсан тухай гарын үсэг зурсан, эсхүл нотолсон өргөдлийг бичгээр гаргуулж авахыг эрмэлзэнэ.

6. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан хүмүүс мөргөлдөөнд оролцогч аль нэг талын хяналтын дор арьс, цус өгсөн тохиолдол бүрт тухайн тал энэ тухай эмнэлгийн магадлагаа гаргаж хадгална. Үүнээс гадна мөргөлдөөнд оролцогч тал тус бүр 1 дүгээр зүйлд дурдсан нөхцөл байдлын улмаас эрх чөлөө нь хязгаарлагдсан,

албадан saatuuлагдсан, эсхүл ямар нэг байдлаар эрх чөлөө нь хасагдсан хүмүүст хийсэн бүх эмчилгээний талаар магадлагаа гаргаж байхыг эрмэлзэнэ. Эдгээр магадлагааг хамгаалагч гурэнд шалгуулахад ямагт боломжтой байлгана.

*12 дугаар зүйл*

**Эмнэлгийн албадын хамгаалалт**

1. Эмнэлгийн албадад ямар ч цагт хүндэтгэл үзүүлж хамгаалах бөгөөд эдгээр албад уруу дайрч довтолж болохгүй.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг дараах нөхцөлд иргэний эмнэлгийн албаны хувьд хэрэглэнэ:

(а) мөргөлдөөнд оролцогч аль нэг талд харьялагдаж байгаа бол;

(б) мөргөлдөөнд оролцогч аль нэг талын эрх бүхий байгууллага хүлээн зөвшөөрсөн буюу эрх олгосон бол;

(с) энэхүү протоколын 9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг болон Нэгдүгээр конвенцийн 27 дугаар зүйлийн дагуу эрх олгосон бол.

3. Мөргөлдөөнд оролцогч талуудад өөрсдийн суурин эмнэлгийн албадын байрлалыг бие биедээ мэдэгдэнэ. Харилцан мэдэгдээгүй тохиолдол нь талуудыг энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үүргээс чөлөөлөхгүй.

4. Цэргийн обьектуудыг дайралт довтолгооноос хамгаалах зорилгоор эмнэлгийн албадыг ямар ч нөхцөл байдалд ашиглаж болохгүй. Мөргөлдөөнд оролцогч талууд эмнэлгийн албадыг цэргийн обьектууд уруу довтлох үед аюулд өртөхгүй байх газарт байрлуулах явдлыг боломжийн хэрээр хангана.

*13 дугаар зүйл*

**Иргэний эмнэлгийн албадын хамгаалалтыг  
дуусгавар болгох**

1. Иргэний эмнэлгийн албад нь өөрийн хүмүүнлэг үйл ажиллагаанаас гадуур, эсрэг талд хохирол учруулах зорилгоор ашиглагдаж байгаагаас бусад тохиолдолд тэдэнд олгогдсон хамгаалалтыг зогсоохгүй. Гэхдээ тодорхой хугацаа бүхий урьдчилсан сануулга өгч, харин түүнийг анхаарч үзээгүй тохиолдолд хамгаалалтыг дуусгавар болгож болно.

2. Дор дурдсаныг эсрэг талд хохирол учруулах үйл ажиллагаа гэж үзэхгүй:

(а) эмнэлгийн албаны ажилтан өөрийгөө буюу асрамжиндаа байгаа шархтан болон өвчтнийг хамгаалах зорилгоор биедээ хөнгөн зэвсэгтэй байхыг;

(б) харуул, манаа, эсхүл харгалзагч нар эмнэлгийн албадыг хамгаалж байхыг;

(с) шархтан болон өвчтнөөс гаргуулж авсан бөгөөд холбогдох байгууллагуудад нь хараахан шилжүүлээгүй байгаа зэвсэг, байлдааны хэрэгслийг эмнэлгийн албадад байлгахыг;

(d) зэвсэгт хүчний цэрэг, эсхүл байлдаж байгаа хүмүүс эрүүл мэндийн шалтгаанаар эмнэлгийн нэгжид байрлаж байхыг.

*14 дүгээр зүйл*

**Иргэний эмнэлгийн албадыг дайчлан авахыг хязгаарлах**

1. Эзлэгч гүрэн эзэлсэн нутаг дэвсгэртээ байгаа энгийн хүн амын эмнэлгийн үйлчилгээг үргэлжлүүлэн явуулах нөхцлөөр хангах үүрэгтэй.

2. Иймд эзлэгч гүрэн энгийн хүн амыг зохих ёсны эмнэлгийн үйлчилгээгээр хангах, эмчлүүлж байгаа шархтан болон өвчтнийг үргэлжлүүлэн асрахад шаардлагатай байгаа нөөц боломжийг, тухайлбал, иргэний эмнэлгийн албад, тэдгээрийн тоног төхөөрөмж, эд материал, эсхүл албадын ажилтнуудыг дайчлан авч болохгүй.

3. Энэ зүйлийн 2 дахь хэсэгт дурдсан нийтлэг журмыг дагаж мөрдөж байгаа тохиолдолд эзлэгч гүрэн дараахь тодорхой нөхцөлд дээр дурдсан нөөц боломжийг дайчлан гаргуулж болно:

(a) эзлэгч гүрний зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүний шархтан болон өвчтөн, эсхүл дайнд олзлогдогчдод зохих ёсны эмнэлгийн хойшлуулшгүй тусlamж үзүүлэхэд шаардлагатай байгаа бол;

(b) зөвхөн дээрх шаардлага байсаар байгаа тохиолдолд л эд зүйлийг үргэлжлүүлэн дайчлан гаргуулах;

(c) нөөц боломжийг дайчлан гаргуулсан нь энгийн хүн ам, түүнчлэн эмчлүүлж байгаа шархтан болон өвчтөнд хохирол учруулах тохиолдолд эмнэлгийн хэрэгцээг үргэлжлүүлэн хангах яаралтай арга хэмжээ авсан байвал.

*15 дугаар зүйл*

**Иргэний эмнэлгийн болон шашны ажилтны хамгаалалт**

1. Иргэний эмнэлгийн ажилтанд хүндэтгэл үзүүлж хамгаалалтанд байлгана.

2. Байлдааны ажиллагааны улмаас иргэний эмнэлгийн үйлчилгээ тасарсан бүсэд шаардлагатай үед иргэний эмнэлгийн ажилтанд боломжтой бүх туслалцааг үзүүлнэ.

3. Эзлэгч гүрэн эзэлсэн нутаг дэвсгэртээ байгаа иргэний эмнэлгийн ажилтанд хүмүүnlэгийн үйл ажиллагаагаа амжилттай явуулах боломжийг олгох зорилгоор бүхий л туслалцааг үзүүлнэ. Эзлэгч гүрэн эмнэлгийн бус шалтгаанаар аливаа нэг хүнд илүү анхаарал тавихыг үүргээ гүйцэтгэж байгаа иргэний эмнэлгийн ажилтнаас шаардаж болохгүй. Иргэний эмнэлгийн ажилтнаас тэдгээрийн хүмүүnlэгийн үйл ажиллагаанд үл нийцэх аливаа үйлдэл хийхийг албадаж болохгүй.

4. Иргэний эмнэлгийн ажилтан нь мөргөлдөөнд оролцогч тухайн талын шаардлагатай гэж үзсэн хяналтын болон аюулгүй байдлын арга хэмжээг биелүүлэх нөхцөлтэйгээр тэдний үйлчилгээ нь шаардлагатай байгаа бүх газарт

нэвтрэх эрхтэй.

5. Шашны энгийн ажилтанд хүндэтгэл үзүүлж хамгаалалд байлгана. Конвенцууд болон энэхүү протоколын эмнэлгийн ажилтныг хамгаалах, ялган танихтай холбогдсон заалтуудыг шашны ажилтны хувьд нэгэн адил хэрэглэнэ.

*16 дугаар зүйл*

**Эмчлэх үүргээ биелүүлж байгаа  
хүмүүсийн нийтлэг хамгаалалт**

1. Чухам хэний тузын тулд ажиллаж байгаагаас үл хамааран эмнэлгийн ёс зүйд нийцсэн үүргээ гүйцэтгэж байгаагийнх нь төлөө аливаа хүнд ямарч нөхцөлд ял шийтгэл хүлээлгэхгүй.

2. Шархтан болон өвчтөнд үйлчлэхтэй холбогдсон эмнэлгийн ёс зүй, эсхүл эмнэлгийн бусад хэм хэмжээ, эсхүл Конвенцууд болон энэхүү протоколын заалтыг зөрчиж буй аливаа үйлдлийг хийх, эсхүл эдгээр хэм хэмжээ, заалтын дагуу хийгдэх ёстой үйлдэл, эсхүл ажлыг биелүүлэхгүй байхыг эмнэлгийн үүргээ гүйцэтгэж байгаа хүмүүст албадан тулгаж болохгүй.

3. Хууль тогтоомжид нь зааснаас бусад тохиолдолд асрамжинд нь байгаа, эсхүл байсан шархтан болон өвчтөн, тэдний гэр бүлийн хүмүүст гэм хор учруулна гэж үзэж байгаа тохиоддолд дурдсан шархтан болон өвчтний тухай ямар нэг мэдээллийг эсрэг талын, эсхүл өөрийн талын аливаа хүнд өгөхийг эмнэлгийн үүргээ гүйцэтгэж байгаа хэнд ч албадан тулгаж болохгүй. Чингэхдээ халдварт өвчний талаархи мэдээллийг заавал өгөх журмыг мөрдлөгө болгоно.

*17 дугаар зүйл*

**Энгийн хүн ам болон тусlamжийн байгууллагуудын үүрэг**

1. Энгийн хүн ам нь эсрэг талд харьялагдаж байсан ч шархтан, өвчтөн, хөлөг онгоцны сүйрэлд өртөгдөгсөдтэй хүндэтгэлтэй харьцах бөгөөд тэдний эсрэг хүчирхийлэл үйлдэж болохгүй. Эзлэн түрэмгийлсэн, эсхүл булаан эзлэгдсэн нутаг дэвсгэрт ч, өөрсдийн санаачилгаар шархтан, өвчтөн, хөлөг онгоцны сүйрэлд өртөгдөгсдийг цуглувулж, асран хамгаалахыг энгийн хүн ам болон Улаан загалмай (Улаан хавирган сар, Улаан арслан болон нар)-н үндэсний нийгэмлэг зэрэг тусlamжийн байгууллагад зөвшөөрнө. Ийм хүмүүнлэгийн үйл ажиллагаа явуулсан аливаа хүнийг хяхан хавчих, мөрдөн мөшгөх, шийтгэх, эсхүл ял эдлүүлж болохгүй.

2. Мөргөлдөөнд оролцогч талууд шархтан, өвчтөн, хөлөг онгоцны сүйрэлд өртөгдөгсдийг цуглувулж, асрах, амь эрсэдсэн хүмүүсийг эрж хайх, байгаа газрыг нь мэдээлж байхыг энэ зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан энгийн хүн ам болон тусlamжийн нийгэмлэгүүдэд хандан уриалж болно. Мөргөлдөөнд оролцогч талууд энэ уриалгыг хүлээж авсан энгийн хүн ам болон тусlamжийн нийгэмлэгүүдийг хамгаалж, шаардлагатай туслалцааг үзүүлнэ. Хэрэв эсрэг тал нутаг дэвсгэрийг буцаан эзэлж, дахин хяналтандaa авсан тохиолдолд тухайн тал шаардлагын хэрээр дээрх хамгаалалт, дэмжлэгийг нэг адил үзүүлнэ.

*18 дугаар зүйл*

### Танъж тогтоох

1. Мөргөлдөөнд оролцогч тал тус бүр эмнэлгийн болон шашны ажилтан, түүнчлэн эмнэлгийн албад, тээврийн хэрэгслийг танигдахуйц байлгах явдлыг хангахыг эрмэлзэнэ.
2. Мөргөлдөөнд оролцогч тал тус бүр ялгах тэмдэг, ялгах дохио хэрэглэж буй эмнэлгийн албад болон тээврийн хэрэгслийг таних бололцоо олгох аргачлал, журмыг баталж хэрэгжүүлэхийг мөн эрмэлзэнэ.
3. Мөргөлдөөн болж байгаа, эсхүл болж болзошгүй талбар, түүнчлэн эзлэгдсэн нутаг дэвсгэрт иргэний эмнэлгийн болон шашны ажилтан нь ялгах тэмдгээр болон түүний эрх зүйн байдлыг нь нотолсон хувийн үнэмлэхээр ялгагдана.
4. Эрх бүхий байгууллагын зөвшөөрснөөр эмнэлгийн албад, тээврийн хэрэгсэлд ялгах тэмдэг тавина. Энэхүү протоколын 22 дугаар зүйлд дурдсан усан онгоц болон хөвөгч хэрэгслийг Хоёрдугаар конвенцийн дагуу ялгах тэмдэгтэй болгоно.
5. Мөргөлдөөнд оролцогч тал ялгах тэмдгээс гадна энэхүү протоколын 1 дүгээр хавсралтын III бүлэгт заасны дагуу ялгах дохиог хэрэглэхийг эмнэлгийн албад болон тээврийн хэрэгсэлд зөвшөөрнө. Тэрхүү бүлэгт заасан онцгой тохиолдолд эмнэлгийн тээврийн хэрэгсэл нь ялгах тэмдэг хэрэглэхгүйгээр ялгах дохиог ашиглаж болно.
6. Энэ зүйлийн 1 – 5 дахь хэсэгт дурдсан заалтуудыг энэхүү протоколын 1 дүгээр хавсралтын I-III бүлэгт заасны дагуу хэрэглэнэ. Энэхүү хавсралтын III бүлэгт зөвхөн эмнэлгийн албад, тээврийн хэрэгсэлд ашиглахад зориулан тодорхойлсон дохиог уг бүлэгт өөрөөр зааснаас бусад тохиолдолд эмнэлгийн алба болон хэрэгслийг ялан танихаас өөр зорилгод ашиглаж болохгүй.
7. Энэ зүйлийн заалтууд ялгах тэмдгийг тайван цагт Нэгдүгээр конвенцийн 44 дүгээр зүйлд заасан хэмжээ хязгаараас хэтрүүлэн хэрэглэхийг зөвшөөрөхгүй.
8. Ялгах тэмдгийг хэрэглэхэд хяналт тавих, түүнийг урвуулан ашиглах явдлаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоохтой холбогдсон Конвенцууд болон энэхүү протоколын заалтуудыг ялгах дохионы хувьд мөн хэрэглэнэ.

19 дүгээр зүйл

### Төвийг сахисан болон мөргөлдөөнд оролцогч бус бусад улс

Төвийг сахисан болон мөргөлдөөнд оролцогч бус улсууд энэ ангийн дагуу хамгаалалтанд байгаа хүмүүсийг нутаг дэвсгэртээ хүлээн авах, эсхүл эрх чөлөөг нь хязгаарлах тохиолдолд, түүнчлэн дээрх нутаг дэвсгэрт илрүүлсэн, уг мөргөлдөөнд оролцогч талуудад харьяалагдаж байгаад амь эрсэдсэн хүмүүсийн хувьд Конвенцийн болон энэхүү протоколын холбогдох заалтуудыг хэрэглэнэ.

20 дугаар зүйл

**Хариу арга хэмжээ авахыг хориглох**

Энэ ангийн дагуу хамгаалалтанд байгаа хүмүүс болон объектын эсрэг хариу арга хэмжээ авахыг хориглоно.

**II ХЭСЭГ**

**Эмнэлгийн тээвэрлэлт**

21 дүгээр зүйл

**Эмнэлгийн тээврийн газраар явагч хэрэгсэл**

Эмнэлгийн тээврийн газраар явагч хэрэгсэлд Конвенцууд болон энэхүү протоколын дагуу эмнэлгийн нүүдлийн албадын нэгэн адил хүндэтгэл үзүүлж хамгаалалтанд байлгана.

22 дугаар зүйл

**Эмнэлгийн хөлөг онгоц болон эргийн аврах завь**

1. Конвенцуудийн, тухайлбал:

(a) Хоёрдугаар конвенцийн 22, 24, 25 болон 27 дугаар зүйлд тодорхойлсон хөлөг онгоцтой холбогдох;

(b) аврах завь, жижиг хөлөг онгоцтой холбогдох;

(c) тэдгээрийн ажилтнууд, бие бүрэлдэхүүнтэй холдбогдох;

(d) хөлөг онгоцны тавцан дахь шархтан, өвчтөн, хөлөг онгоцны сүйрэлд өртөгдөгсөдтэй холбогдох заалтуудыг Хоёрдугаар конвенцийн 13 дугаар зүйлд дурдсан ангилалын аль нэгтэй холбогдолгүй энгийн шархтан, өвчтөн, хөлөг онгоцны сүйрэлд өртөгдөгсдийг хөлөг онгоцоор тээвэрлэх тохиолдолд мөн хэрэглэнэ. Чингэхдээ эдгээр энгийн хүмүүсийг өөрийн нь харьяаны бус ямар нэг талын мэдэлд шилжүүлэх, эсхүл далайд олзолж болохгүй. Хэрэв тэд мөргөлдөөнд оролцогч бөгөөд өөрийн нь харьяаны бус талын мэдэлд орсон тохиолдолд тэднийг Дөрөвдүгээр конвенц болон энэхүү протоколд хамааруулна.

2. Энэ зүйлд тодорхойлсон шаардлагуудыг биелүүлж байгаа нөхцөлд дараах улс болон байгууллагаас хүмүүнлэгийн зорилгоор мөргөлдөөнд оролцогч талд олгосон эмнэлгийн зориулалт бүхий хөлөг онгоцыг Конвенцуудийн заалтын дагуу Хоёрдугаар конвенцийн 25 дугаар зүйлд заасан хөлөг онгоцны нэгэн адил хамгаална:

(a) Төвийг сахисан, эсхүл мөргөлдөөнд оролцогч бус улсууд, эсхүл;

(b) олон улсын хүмүүнлэгийн байгууллага.

3. Хоёрдугаар конвенцийн 27 дугаар зүйлд тодорхойлсон жижиг усан онгоцыг мөн зүйлд заасан мэдээллийг өгөөгүй байсан ч хамгаална. Гэхдээ тийм усан онгоцыг таньж, тодорхойлох явдлыг хөнгөвчлөх бүхий л мэдээллийг өгөхийг мөргөлдөөнд оролцогч талууд өөр хоорондоо хүсэлт болгоно.

**23 дугаар зүйл**

**Эмнэлгийн бусад хөлөг онгоц, хөвөгч хэрэгсэл**

1. Далайд, эсхүл бусад усанд байгаа Хоёрдугаар конвенцийн 38 дугаар зүйл болон энэхүү протоколын 22 дугаар зүйлд дурдсанаас бусад эмнэлгийн хөлөг онгоц, хөвөгч хэрэгсэлд Конвенцууд болон энэхүү протоколын дагуу эмнэлгийн нүүдлийн албадын нэгэн адил хүндэтгэл үзүүлж хамгаалалтанд байлгана. Хөлөг онгоц, хөвөгч хэрэгсэл нь эмнэлгийн усан онгоц буюу хөвөгч хэрэгсэл гэж танигдахаар байгаа тохиолдолд л үр дүнтэй хамгаалалтанд орох учраас тийм хөлөг онгоцууд нь Хоёрдугаар конвенцийн 43 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг боломжийн хэрээр дагаж мөрдөхийн хамт ялгах тэмдэгтэй байх ёстай.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан хөлөг онгоц болон хөвөгч хэрэгсэлд дайны үеийн хууль үргэлжлэн мөрдөгдөнө. Өөрийн өгсөн тушаалыг хөлөг онгоц болон хөвөгч хэрэгслийн хувьд албадан гүйцэтгүүлж чадахуйц цэргийн хөлөг онгоц тэдэнд зогсох, тухайн бүсээс гарах, эсхүл тодорхой чиглэлээр явахыг тушааж болох бөгөөд тэд өгсөн тушаалд захирагдах ёстай. Хөлөг онгоц дахь шархтан, өвчтөн болон хөлөг онгоцны сүйрэлд өртөгдөгсдөд шаардлагатай байгаа үед эдгээр хөлөг онгоц болон хөвөгч хэрэгслийг эмнэлгийн үүрэгт ажлаа гүйцэтгэх явдлаас нь хөндийрүүлж болохгүй.

3. Хоёрдугаар конвенцийн 34 болон 35 дугаар зүйлд тодорхойлсон зөвхөн тийм нөхцөлд л энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хамгаалалтыг дуусгавар болгоно. Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу өгсөн тушаалд захирагдааас илэрхий татгалзахыг Хоёрдугаар конвенцийн 34 дүгээр зүйлийн дагуу эсрэг талд хохирол учруулсан үйлдэл гэж үзнэ.

4. Мөргөлдөөнд оролцогч тал эмнэлгийн хөлөг онгоц болон хөвөгч хэрэгсэл, ялангуяа бохир даац нь 2 000 тонноос дээш усан эзэлхүүнтэй хөлөг онгоцны нэр, техникийн үзүүлэлт, хөдлөхөөр товолосон цаг, чиглэл, тооцоолсон хурдны талаар хөлөг онгоц хөдлөхөөс аль болох өмнө аливаа эсрэг талд мэдэгдэж болох бөгөөд мөн хөлөг онгоцыг таньж, тодорхойлох явдлыг хөнгөвчлөх аливаа мэдээллийг өгч болно. Эсрэг тал ийм мэдээллийг хүлээн авснаа нотлоно.

5. Хоёрдугаар конвенцийн 37 дугаар зүйлийн заалтуудыг эдгээр хөлөг онгоц, хөвөгч хэрэгсэл дээр байгаа эмнэлгийн болон шашны ажилтны хувьд хэрэглэнэ.

6. Хоёрдугаар конвенцийн заалтуудыг эмнэлгийн хөлөг онгоц, хөвөгч хэрэгслүүд дээр байж болох Хоёрдугаар конвенцийн 13 дугаар зүйл болон энэхүү протоколын 44 дүгээр зүйлд тодорхойлсон ангилалд хамаарах шархтан, өвчтөн, хөлөг онгоцны сүйрэлд өртөгдөгсдөд хэрэглэнэ. Хоёрдугаар конвенцийн 13 дугаар зүйлд дурдсан ангилалын алинд ч үл хамаарах шархтан, өвчтөн, хөлөг онгоцны сүйрэлд өртсөн энгийн иргэдийг далайд байгаа үед нь өөрийн нь харьяа бус аливаа талд шилжүүлэх, эсхүл эдгээр хөлөг онгоц буюу хөвөгч

хэрэгслээс буулгаж болохгүй. Хэрэв тэд мөргөлдөөнд оролцогч бөгөөд өөрийн нь харьяаны бус талын мэдэлд орсон тохиолдолд тэднийг Дөрөвдүгээр конвенц болон энэхүү протоколд хамааруулна.

*24 дүгээр зүйл*

**Эмнэлгийн агаарын хөлөгний хамгаалалт**

Эмнэлгийн агаарын хөлгөнд энэ ангид заасны дагуу хүндэтгэл үзүүлж хамгаалалтанд байлгана.

*25 дугаар зүйл*

**Эсрэг талын хяналтын бус нутагт байгаа**

**эмнэлгийн агаарын хөлөг**

Аль нэг талын нөхөрсөг хүчний бодитой хяналтанд байгаа хуурай газрын бус, түүний дээрх агаар мандал, эсхүл эсрэг талаас бодитой хяналт тогтоогоогүй байгаа далайн бус, түүний дээрх агаар мандалд мөргөлдөөнд оролцогч аль нэг талын эмнэлгийн агаарын хөлгийг хүндэтгэж хамгаалах явдал эсрэг талтай байгуулсан ямар нэг хэлэлцээрээс үл хамаарна. Гэхдээ мөргөлдөөнд оролцогч тал эдгээр бус нутагт эмнэлгийн агаарын хөлөг ашиглахдаа аюулгүй байдлыг илүү хангах үүднээс 29 дүгээр зүйлд заасны дагуу эсрэг талдаа, тухайлбал, эсрэг талын "газар-агаар" ангилалын зэвсгийн тусах зайд нислэг хийх эмнэлгийн агаарын хөлөгний тухай мэдэгдэж болно.

*26 дугаар зүйл*

**Уулзвар бус, түүнтэй төсөөтэй бүсэд байгаа**

**эмнэлгийн агаарын хөлөг**

1. Аль нэг талын нөхөрсөг хүчинээс бодитой хяналт тавьж байгаа бүсийн уулзвар газар, ямар нэг хүчинээс бодитой хяналт тогтоогоогүй байгаа бус, тэдгээрийн дээрх агаар мандалд эмнэлгийн агаарын хөлгийг 29 дүгээр зүйлд зааснаар мөргөлдөөнд оролцогч талуудын цэргийн эрх бүхий байгууллагуудын урьдчилан тохиролцсоны үндсэн дээр бүрэн хамгаална. Ийм хэлэлцээр байхгүй үед эмнэлгийн агаарын хөлөг аюулгүй байдлаа өөрөө хариуцан үйл ажиллагаагаа явуулж болох бөгөөд чингэхдээ эмнэлгийн агаарын хөлөг болох нь танигдсан үед тэдэнд зохих хүндэтгэлийг үзүүлнэ.

2. "Уулзвар бус" гэж сөргөлдөгч хүчинүүдийн тэргүүн ангиуд зэрэгцэн оршиж байгаа бус бөгөөд бие бие рүүгээ газраас шууд гал нээхэд тусгал нь хүрэх зайд байрласан хуурай газрыг хэлнэ.

*27 дугаар зүйл*

**Эсрэг талын хяналтанд байгаа нутаг дахь**

**эмнэлгийн агаарын хөлөг**

1. Мөргөлдөөнд оролцогч аль нэг талын эмнэлгийн агаарын хөлөг эсрэг талын эрх бүхий байгууллагаас нислэгийн зөвшөөрөл урьдчилан авсан тохиолдолд эсрэг тухайн талын бодитой хяналтанд байгаа хуурай газар, эсхүл далайн бүсийн дээгүүр нисэж байх үедээ хамгаалалтыг үргэлжлэн авна.

2. Эсрэг талын бодитой хяналтанд байгаа бүсийн дээгүүр нислэг үйлдэж

буй өмнэлгийн агаарын хөлөг энэ зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан зөвшөөрлийг аваагүй, эсхүл зөвшөөрөл авсан боловч навигацийн алдаа, эсхүл нислэгийн аюулгүй байдалд аюул учруулсан онцгой байдлын улмаас уг зөвшөөрлийн нөхцлөөс гажсан тохиолдолд энэхүү нөхцөл байдлын тухай эсрэг талдаа мэдэгдэх, өөрийгөө таниулах талаар бүхий л хүчин чармайлтыг гаргана. Эсрэг тал ийм өмнэлгийн агаарын хөлгийг танимагц 30 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн дагуу газар, эсхүл усан дээр буух тушаал өгөх, эсхүл өөрийн эрх ашгийг хамгаалах бусад арга хэмжээг авах талаар бүхий л үндэслэлтэй алхмыг хийх бөгөөд ямар ч тохиолдолд тухайн хөлөг рүү довтлооосоо өмнө түүнд тушаалыг дагаж биелүүлэх цаг хугацаа олгоно.

*28 дугаар зүйл*

**Эмнэлгийн агаарын хөлгийг ашиглахад тогтоох хязгаарлалт**

1. Мөргөлдөөнд оролцогч талууд эсрэг талынхаа хувьд ямар нэг давуу байдал олж авах зорилгоор өмнэлгийн агаарын хөлгийг ашиглахыг хориглоно. Цэргийн объектуудыг довтолгоонд өртүүлэхгүй байх зорилгоор өмнэлгийн агаарын хөлгийг ашиглаж болохгүй.

2. Эмнэлгийн агаарын хөлгийг тагнуулын мэдээ сэлт цуглуулах, эсхүл дамжуулах зорилгоор ашиглаж болохгүй бөгөөд тийм зорилгоор аливаа тоног төхөөрөмж бүхээгтээ авч явж болохгүй. Эмнэлгийн агаарын хөлгөөр 8 дугаар зүйлийн “f” тодорхойлолтод хамрагдаагүй хүмүүс, эсхүл ачаа тээвэрлэхийг хориглоно. Харин өмнэлгийн агаарын хөлгийн бүхээгт байгаа хүмүүсийн хувийн эд зүйлс, эсхүл навигацийн болон холбооны ажиллагаанд хэрэглэх, эсхүл агаарын хөлгийг танихад зориулагдсан тоног төхөөрөмжийг авч явахыг хориглосон ачаанд тооцохгүй.

3. Эмнэлгийн агаарын хөлгөнд байгаа шархтан, өвчтөн, хөлөг онгоцны сүйрэлд өртөгдөгсдөөс хурааж авсан бөгөөд зохих газарт нь хараахан шилжүүлээгүй байгаа зэр зэвсэг, өмнэлгийн ажилтанд өөрийгөө болон түүний асрамжинд байгаа шархтан, өвчтөн, хөлөг онгоцны сүйрэлд өртөгдөгсдийг хамгаалах шаардагдаж болох хөнгөн зэвсгээс бусад өөр ямар нэг зэвсгийг өдгөэр хэрэгслээр тээвэрлэж болохгүй.

4. 26 болон 27 дугаар зүйлд дурдсан нислэгийг гүйцэтгэж байгаа үед өмнэлгийн агаарын хөлгийг эсрэг талтай урьдчилан тохиролцсоноос бусад тохиолдолд шархтан, өвчтөн, хөлөг онгоцны сүйрэлд өртөгдөгсдийг эрж хайхад ашиглаж болохгүй.

*29 дүгээр зүйл*

**Эмнэлгийн агаарын хөлөгтэй холбогдох мэдэгдэл, хэлэлцээр**

1. 25 дугаар зүйлийн дагуу хийх мэдэгдэл, эсхүл 26, 27 дугаар зүйл, 28 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, эсхүл 31 дүгээр зүйлийн дагуу гаргах урьдчилсан тохиролцооны тухай хүсэлтэд өмнэлгийн агаарын хөлгийн тоо, тэдгээрийн нислэгийн төлөвлөгөө, таних тэмдгийн тухай заах бөгөөд нислэг бүрийг 28 дугаар зүйлийн дагуу хийнэ гэж ойлголцсон гэж үзнэ.

2. 25 дугаар зүйлийн дагуу өгсөн мэдээллийг хүлээн авсан тухайгаа хүлээн

авагч тал тэр даруй нотолно.

3. 26, 27 дугаар зүйл, 28 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, эсхүл 31 дүгээр зүйлийн дагуу гаргасан урьдчилан тохиролцооны тухай хүсэлтийг хүлээн авагч тал хүсэлт гаргаж байгаа талд дор дурдсан зүйлийг аль болох шуурхай мэдэгдэнэ:

- (a) хүсэлтийг хангах тухай;
- (b) хүсэлтэд хариу өгөхөөс татгалзаж буй тухай; эсхүл
- (c) хүсэлтэд хариу болох үндэслэл бүхий эсрэг саналын тухай.

Уг тал тухайн бүсэд хийх бусад нислэгийг тодорхой хугацаагаар хориглох, эсхүл хязгаарлах талаар санал болгож болно. Хэрэв хүсэлт гаргасан тал нөгөө талын эсрэг саналыг хүлээн авсан тохиолдолд энэ тухайгаа нөгөө талд мэдэгдэнэ.

4. Талууд мэдээлэл хийх, тохиролцох явдлыг шуурхай гүйцэтгэх зорилгоор шаардлагатай арга хэмжээг авна.

5. Талууд эдгээр мэдээлэл болон тохиролцооны агуулгыг холбогдох цэргийн ангийн сонорт түргэн хүргэх шаардлагатай арга хэмжээг авах бөгөөд тухайн эмнэлгийн агаарын хөлгийг таних арга хэлбэрийн талаар уг цэргийн ангид зааварчилга өгнө.

### 30 дугаар зүйл

#### Эмнэлгийн агаарын хөлгийг газардуулах, шалгах

1. Эсрэг талын бодитой хяналтад байгаа, эсхүл хэний хяналтанд байгаа нь тодорхойгүй бүсийн дээгүүр нислэг үйлдэж буй эмнэлгийн агаарын хөлгийг дараахь заалтын дагуу шалгах зорилгоор шаардлагатай үед хуурай газар, эсхүл усан дээр буух тушаалыг өгч болно. Эмнэлгийн агаарын хөлөг ийм тушаалыг биелүүлэх ёстой.

2. Тушаалаар, эсхүл өөр шалтгаанаар хуурай газар, эсхүл усан дээр буусан агаарын хөлгийг энэ зүйлийн 3 болон 4 дэх хэсэгт дурдсан нөхцлийг биелүүлж байгаа эсэхийг л тогтоохоор шалгаж болно. Шалгалтыг даруй эхэлж, богино хугацаанд явуулна. Шалгалт хийж байгаа тал шалгалтын үед шархтан, өвчтнийг агаарын хөлгөөс зайлшгүй гаргах шаардлагатайгаас бусад тохиолдолд тийнхүү шаардлага тавьж болохгүй. Шалгаж байгаа тал шархтан, өвчтний биеийн байдлыг шалгалтын, эсхүл тэднийг агаарын хөлгөөс гаргасны улмаас дордуулахгүй байх явдлыг хангана.

3. Хэрэв ийм шалгалтаар уг агаарын хөлөг нь:

- (a) 8 дугаар зүйлийн “j” хэсэгт заасан эмнэлгийн агаарын хөлөг мөн болох;
- (b) 28 дугаар зүйлд тодорхойлсон нөхцлийг зөрчөөгүй болох;
- (c) урьдчилсан тохиролцоо шаардлагатай үед тийм тохиролцоогүйгээр, эсхүл тийм тохиролцоог зөрчсөн нислэг үйлдээгүй болохыг тус тус тогтоовол эсрэг талд, эсхүл мөргөлдөөнд оролцогч бус улсад, эсхүл төвийг сахисан улсад харьялагдаж

байгаа тухайн агаарын хөлөг болон түүний бүхээгт нь буй хүмүүст сааталгүйгээр нислэгээ үргэлжлүүлэхийг зөвшөөрнө.

4. Хэрэв ийм шалгалтаар уг агаарын хөлөг нь:

(a) 8 дугаар зүйлийн “j” хэсэгт заасан эмнэлгийн агаарын хөлөг биш болох;

(b) 28 дугаар зүйлд тодорхойлсон нөхцлийг зөрсөн болох;

(c) урьдчилсан тохиролцоо шаардлагатай үед тийм тохиролцоогүйгээр, эсхүл тийм тохиролцоог зөрчсөн нислэг үйлдсэн болохыг тус тус тогтоовол тухайн агаарын хөлгийг албадан саатуулж болно.

Агаарын хөлөгт байгаа хүмүүстэй Конвенцууд болон энэхүү протоколын холбогдох заалтын дагуу харьцана. Эмнэлгийн байнгын агаарын хөлгөөр ажиллуулахаар томилсон бөгөөд албадан саатуулагдсан агаарын хөлгийг хожим нь зөвхөн эмнэлгийн зориулалтаар л ашиглаж болно.

*31 дүгээр зүйл*

### **Төвийг сахисан, эсхүл мөргөлдөөнд оролцогч бус бусад улс**

1. Урьдчилан тохиролцсоноос бусад тохиолдолд эмнэлгийн агаарын хөлөг төвийг сахисан, эсхүл мөргөлдөөнд оролцогч бус бусад улсын нутаг дэвсгэр дээгүүр нислэг үйлдэх, тэнд буухыг хориглоно. Харин тийнхүү урьдчилан тохиролцсон тохиолдолд эдгээр агаарын хөлгийг нислэгийн бүх үед, түүнчлэн дурдсан нутаг дэвсгэр дээр түр буух үед ч хүндэтгэл үзүүлнэ. Гэхдээ тэдгээр нь нөхцөл байдлаас шалтгаалан газардах, эсхүл усан дээр буух тушаалыг биелүүлэх үүрэгтэй.

2. Төвийг сахисан, эсхүл мөргөлдөөнд оролцогч бус бусад улсын нутаг дэвсгэр дээгүүр нислэг үйлдэж буй эмнэлгийн агаарын хөлөг зөвшөөрөл аваагүй, эсхүл зөвшөөрөл авсан боловч навигацийн алдаа, эсхүл нислэгийн аюулгүй байдалд аюул учруулсан онцгой байдлын улмаас уг зөвшөөрлийн нөхцөлөөс гажсан тохиолдолд энэхүү нөхцөл байдлын тухай мэдэгдэх, өөрийгөө таниулах талаар бүхий л хүчин чармайлтыг гаргана. Ийм эмнэлгийн агаарын хөлгийг танимагц тухайн улс 30 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн дагуу газарт, эсхүл усан дээр буух тушаал өгөх, эсхүл өөрийн эрх ашгийг хамгаалах бусад арга хэмжээг авах талаар бүхий л үндэслэлтэй алхмыг хийх бөгөөд ямар ч тохиолдолд тухайн хөлөг рүү довтлоохосоо өмнө түүнд тушаалыг дагаж биелүүлэх цаг хугацаа олгоно.

3. Тохиролцооны дагуу, эсхүл энэ зүйлийн 2 дахь хэсэгт дурдсан нөхцөл байдал буй болсны улмаас, түүнчлэн тушаалаар, эсхүл өөр шалтгаанаар төвийг сахисан, эсхүл мөргөлдөөнд оролцогч бус бусад улсын нутаг дэвсгэрт хуурай газар, эсхүл усан дээр буусан агаарын хөлгийг эмнэлгийн агаарын хөлөг мөн эсэхийг шалгана. Шалгалтыг даруй эхэлж, богино хугацаанд явуулна. Шалгаж хийж байгаа тал шалгалтын үед шархтан, өвчтнийг агаарын хөлгөөс зайлшгүй гаргах шаардлагатайгаас бусад тохиолдолд тийнхүү шаардлага тавьж болохгүй. Шалгаж байгаа тал шархтан, өвчтний биеийн байдлыг шалгаль хийсний, эсхүл тэднийг агаарын хөлгөөс гаргасны улмаас дордуулахгүй байх явдлыг хангана. Эмнэлгийн агаарын хөлөг болох нь шалгалтаар тогтоогдсон тохиолдолд зэвсэгт мөргөлдөөнийй

үед хэрэглэх олон улсын эрх зүйн хэм хэмжээний дагуу албадан саатуулагдах ёстойгоос бусад хүмүүст нислэгээ үргэлжлүүлэхийг зөвшөөрөх бөгөөд нислэгээ ийнхүү үргэлжлүүлэхэд нь шаардлагатай арга хэмжээ авна. Агаарын хөлөг нь эмнэлгийн бус болох нь шалгалтаар тогтоогдсон тохиолдолд агаарын хөлгийг хүмүүсийнх нь хамт албадан саатуулах бөгөөд тэдэнтэй энэ зүйлийн 4 дэх хэсгийн заасны дагуу харьцана.

4. Мөргөлдөөнд оролцогч талууд болон тухайн улсын хооронд өөрөөр тохиолдоогүй тохиолдолд төвийг сахисан, эсхүл мөргөлдөөнд оролцогч бус улсын нутаг дэвсгэрт орон нутгийн захиргааны зөвшөөрлөөр эмнэлгийн агаарын хөлгөөс буулгасан шархтан, өвчтөн, хөлөг онгоцны сүйрэлд өртөгдөгсдийг байдааны ажиллагаанд дахин оролцуулахгүй байх зорилгоор шаардлагатай тохиолдолд мөргөлдөөний үед хэрэглэх олон улсын эрх зүйн хэм хэмжээний дагуу тухайн улс албадан саатуулна. Эдгээр хүмүүсийг эмчлэх, эрх чөлөөг нь хязгаарлахтай холбогдох зардлыг харьяалах улс нь хариуцна. Эдгээр хүмүүст агаарын хөлгөөс түр буулгасан хүмүүсийг оролцуулахгүй.

5. Төвийг сахисан, эсхүл мөргөлдөөнд оролцогч бус улсууд өөрийн нутаг дэвсгэр дээгүүр нислэг үйлдэж буй, эсхүл тэнд буусан эмнэлгийн агаарын хөлөгний тухайд аливаа нөхцөл болон хязгаарлалтыг мөргөлдөөнд оролцогч бүх талд адил хэрэглэнэ.

### **III ХЭСЭГ**

#### **Сураггүй бологсод болон амь үрэгдэгсэд**

*32 дугаар зүйл*

#### **Нийтлэг зарчим**

Конвенцууд болон энэхүү протоколд дурдсан хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд, мөргөлдөөнд оролцогч талууд болон олон улсын хүмүүнлэгийн байгууллагууд энэ хэсгийн заалтуудыг хэрэгжүүлэхдээ юуны өмнө өөрсдийн төрөл төрөгсдийнхөө хувь заяаг мэдэх гэр бүлийн эрхийг үйл ажиллагаандаа иш үндэс болгоно.

*33 дугаар зүйл*

#### **Сураггүй бологсод**

1. Шаардлагатай нөхцөл байдал бий болмогц, цаад зах нь дайтах идэвхтэй ажиллагаа зогссон дараа мөргөлдөөнд оролцогч тал сураггүй бологсод гэж эсрэг талын мэдээлсэн хүмүүсийг эрэн сурвалжилна. Ийнхүү тэднийг эрэн сурвалжлахад нь тус дөхөм үзүүлэх зорилгоор эсрэг тал эдгээр хүмүүстэй холбогдох бүхий л мэдээллийг өгнө.

2. Конвенцууд болон энэхүү протоколын дагуу илүү таalamжтай эрх эдлэхгүй хүмүүсийн хувьд өмнөх заалтын дагуу мэдээлэл цуглуулахад тус дөхөм үзүүлэх зорилгоор мөргөлдөөнд оролцогч тал тус бүр:

(а) дайтах ажиллагаа, эсхүл түрэмгийлэн эзэлсний улмаас албадан саатуулагдсан, тусгаарлан хоригдсон, эсхүл хоёр долоо хоногоос дээш хугацаагаар ямар нэг хэлбэрээр эрх чөлөөгөө хасуулсан, эсхүл ийнхүү албадан саатуулагдах

хугацаандаа нас нөгчсөн хүмүүсийн хувьд Дөрөвдүгээр конвенцийн 138 дугаар зүйлд тодорхойлсон мэдээллийг бүртгэн хөтлөнө.

(b) дайтах ажиллагаа, эсхүл түрэмгийлэн эзэлсний улмаас бусад нөхцөл байдалд нас нөгчсөн хүмүүсийн талаархи мэдээллийг эрэн сурвалжлах, бүртгэн хөтлөхөд хамгийн өргөн утгаар нь дэмжлэг, туслалцаа үзүүлэх, шаардлагатай тохиолдолд өөрсдөө мэдээллийг эрэн сурвалжлах, бүртгэн хөтлөх ажлыг гүйцэтгэнэ.

3. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу сураггүй болсон гэж мэдээлсэн хүмүүсийн тухай мэдээлэл болон уг мэдээллийг авах хүсэлтийг шууд, эсхүл хамгаалагч гүрэн, Олон улсын улаан загалмайн хорооны төв лавлах агентлаг, эсхүл Улаан загалмай (Улаан хавирган сар, улаан арслан болон нар)-н үндэсний нийгэмлэгүүдээр дамжуулна. Эдгээр мэдээллийг Олон улсын улаан загалмайн хороо болон түүний төв лавлах агентлагаар дамжуулаагүй тохиолдолд ч мөргөлдөөнд оролцогч тал бүр уг мэдээллийг төв лавлах агентлагт мөн хүргүүлэх явдлыг хангана.

4. Мөргөлдөөнд оролцогч талууд амь үрэгдэгсдийг эрэн сурвалжлах, танъж тогтоох болон тэднийг дайтах ажиллагаа явагдаж буй бүсээс гаргах зорилго бүхий баг байгуулах, ялангуяа тийм баг нь эсрэг талын хяналтанд байгаа бүсэд дээрх үүргийг гүйцэтгэхэд эсрэг талын хүмүүсээр шаардлагатай үед дагалдуулах асуудлаар тохиролцохыг эрмэлзэнэ. Багийн ажилтанг үүргээ биелүүлж байхад нь хүндэтгэл үзүүлж хамгаалалтад байлгана.

### *34 дүгээр зүйл*

#### **Амь үрэгдэгсдийн цогцос**

1. Түрэмгийлэн эзлэх үед, эсхүл дайтах ажиллагаа болон түрэмгийлэн эзэлсний улмаас хорих газарт нас нөгчсөн, түүнчлэн өөрийн харьят бус оронд дайтах ажиллагааны улмаас амь үрэгдсэн хүмүүсийн цогцсыг хүндэтгэнэ. Тийнхүү амь үрэгдэгсдийн цогцос болон тэднийг оршуулсан газрын хувьд Конвенцууд болон энэхүү протоколоор илүү таатай эрх олгохгүй тохиолдолд Дөрөвдүгээр конвенцийн 130 дугаар зүйлд дурдсан ёсоор тэдгээрийг хүндэтгэн хамгаалж, таних тэмдэг тавина.

2. Шаардлагатай нөхцөл байдал болон эсрэг талуудын хоорондын харилцаа ийм боломж олгомогц нутаг дэвсгэр дээр нь булш байгаа, түүнчлэн дайтах ажиллагаа, эсхүл түрэмгийлэн эзэлсний улмаас нутаг дэвсгэрт нь байгаа хорих газарт нас барсан хүмүүсийн цогцсыг оршуулсан бусад газар байж болох хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд дараахь зорилгоор хэлэлцээр байгуулна:

(a) амь үрэгдсэн хүмүүсийн төрөл төрөгсөд болон шарил бүртгэх албаны төлөөлөгчдийг оршуулгын газарт нэвтрүүлэх, ийнхүү нэвтрүүлэхтэй холбогдох бусад арга хэмжээ авах;

(b) оршуулгын газрыг байнга хамгаалж, арчлах;

(c) амь үрэгдсэн хүмүүсийн цогцос болон тэдний хувийн эд хогшлыг эх оронд нь тухайн орны хүсэлтээр буцаах, эсхүл эх орон нь эс татгалзсан тохиолдолд төрөл төрөгсдийн нь хүсэлтээр буцаахад туслах.

3. Энэ зүйлийн 2 дахь хэсгийн “б” болон “с” хэсэгт дурдсан хэлэлцээрийг байгуулаагүй тохиолдолд, түүнчлэн амь үрэгдсэн хүмүүсийн эх орон нь эдгээр оршуулгын газрыг өөрийн зардлаар хамгаалахыг үл зөвшөөрөх тохиолдолд нутагт нь уг оршуулгын газар байгаа хэлэлцэн тохирогч эрхэм дээд тал амь үрэгдэгсийн цогцсыг эх оронд нь буцаахад дөхөм үзүүлэх санал гаргаж болно. Энэхүү саналыг нь хүлээн аваагүй тохиолдолд хэлэлцэн тохирогч эрхэм дээд тал санал гаргасан өдрөөс хойш 5 жилийн дараа амь үрэгдэгсийн эх оронд зохих ёсоор мэдэгдэж оршуулгын газар болон булшны тухай өөрийн хууль тогтоомжид заасан арга хэмжээг авч болно.

4. Энэ зүйлд дурдсан оршуулгын газрууд нутаг дэвсгэрт нь байгаа хэлэлцэн тохирогч эрхэм дээд талд зөвхөн дараах тохиолдолд оршуулгын газарт буй шарилыг хөндөхийг зөвшөөрнө:

(а) энэ зүйлийн 2 дахь хэсгийн “с” болон 3 дахь хэсгийн заалтын дагуу;

(б) эмнэлгийн шинжилгээ буюу мөрдөн байцаалт явуулах зэрэг нийгмийн зайлшгүй шаардлагын үүднээс оршуулгын газарт буй шарилыг хөндөж болох бөгөөд энэ тохиолдолд хэлэлцэн тохирогч эрхэм дээд тал амь үрэгдэгсийн цогцост үргэлж хүндэтгэлтэй хандана. Ийнхүү шарилыг хөндөх гэж байгаагаа болон дахин оршуулахаар төлөвлөж буй газрын тухай эх оронд нь тодорхой мэдээлнэ.

### **III АНГИ**

#### **ДАЙНЫ АРГА ХЭРЭГСЭЛ, БАЙЛДАЖ БАЙГАА ХҮМҮҮС БОЛОН ДАЙНД ОЛЗЛОГДОГЧДЫН ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ I ХЭСЭГ**

##### **Дайны арга хэрэгсэл**

*35 дугаар зүйл*

##### **Үндсэн журам**

1. Аливаа зэвсэгт мөргөлдөөний үед ашиглах дайны арга хэрэгслийг сонгож авах мөргөлдөөнд оролцогч талуудын эрх хязгаартай.

2. Үлэмж хэмжээний гэмтэл, зовиур учруулах дайны арга хэрэгсэл, зэр зэвсэг, сум, бодис хэрэглэхийг хориглоно.

3. Байгаль орчинд удаан хугацааны, их газар нутгийг хамарсан ноцтой хохирол учруулах, эсхүл учруулж болох дайны арга хэрэгсэлийг хэрэглэхийг хориглоно.

*36 дугаар зүйл*

##### **Зэвсгийн шинэ төрлүүд**

Хэлэлцэн тохирогч эрхэм дээд тал дайны шинэ төрлийн арга хэрэгсэл, зэвсгийн шинэ төрлүүдийг судлах, хөгжүүлэх, олж авах, эсхүл зэвсэгт хүчиндээ нийлүүлэхдээ эдгээрийг зарим тохиолдолд, эсхүл бүх нөхцөл байдалд хэрэглэх нь

энэхүү протокол болон хэлэлцэн тохирогч эрхэм дээд талуудын хувьд хүчинтэй олон улсын эрх зүйн бусад хэм хэмжээний дагуу хориглогдох эсэхийг тогтоох үүрэгтэй.

*37 дугаар зүйл*

**Итгэл эвдэхийг хориглох**

1. Эсрэг талынхаа хүмүүсийг итгэл эвдэж хороох, шархдуулах, эсхүл олзлохыг хориглоно. Зэвсэгт мөргөлдөөний үед хэрэглэх олон улсын эрх зүйн хэм хэмжээний дагуу хамгаалуулах эрхтэй буюу түүнийг хамгаалах ёстой гэж эсрэг талаа хүчээр итгүүлэх, эсхүл түүнд ийм итгэл бий болгоход чиглэсэн хурамч явуулгыг итгэл эвдсэнд тооцно. Дараахь үйлдэл нь итгэл эвдсэн үйлдэл мөн:

(a) эвлэрлийн хэлэлцээ хийх гэж байгаа, эсхүл бууж өгөх дүр үзүүлэх;

(b) шархадсан, эсхүл өвчний улмаас жагсаалаас гарсан дүр үзүүлэх;

(c) энгийн буюу байлдаанд оролцоогүй хүмүүсийн эрх зүйн байдалтай мэт дүр үзүүлэх;

(d) Нэгдсэн Үндэстний Байгууллага, төвийг сахисан, эсхүл мөргөлдөөнд оролцогч бус улсын тэмдэг, бэлгэ тэмдэг дүрэмт хувцсыг ашиглах замаар хамгаалагдах эрх зүйн байдалтай мэт дүр үзүүлэх.

2. Дайны ов мэх хэрэглэхийг үл хориглоно. Эсрэг талаа төөрөгдүүлэх, эсхүл буруу үйл ажиллагаа явуулахад чиглэсэн үйлдлийг дайны ов мэх гэж үзнэ. Гэхдээ эдгээр үйлдэл нь зэвсэгт мөргөлдөөний үед хэрэглэх олон улсын эрх зүйн хэм хэмжээг зөрчих ёсгүй бөгөөд энэхүү эрх зүйгээр олгогдож буй хамгаалалтын талаархи эсрэг талын итгэлийг хөсөрдүүлэхгүй байгаа учраас итгэл эвдсэнд үл тооцогдоно. Өнгөлөн далдлах, отолтод оруулах, байлдааны хурамч ажиллагаа явуулах, худал мэдээлэл зориуд өгөх зэрэг нь дайны ов мэхийн жишээ болно.

*38 дугаар зүйл*

**Хүлээн зөвшөөрсөн бэлгэ тэмдэг**

1. Улаан загалмай, улаан хавирган сар, эсхүл улаан арслан буюу улаан нарын ялгах тэмдэг, эсхүл Конвенцууд болон энэхүү протоколд дурдсан бусад тэмдэг, дохиог зориулалтаас нь өөрөөр ашиглахыг хориглоно. Түүнчлэн олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрсөн хамгаалах тэмдэг, дохио, түүний дотор эвлэрэх далбаа, соёлын үнэт зүйлсийг хамгаалах тэмдгийг зэвсэгт мөргөлдөөний үед зориуд урвуулан ашиглахыг хориглоно.

2. Нэгдсэн Үндэстний Байгууллагын ялгах тэмдгийг түүний зөвшөөрөлгүйгээр ашиглахыг хориглоно.

*39 дүгээр зүйл*

**Үндэсний бэлгэ тэмдэг**

1. Төвийг сахисан, эсхүл мөргөлдөөнд оролцогч бус улсын далбаа, эсхүл цэргийн бэлгэ тэмдэг, цэргийн ялгах тэмдэг, эсхүл дүрэмт хувцсыг зэвсэгт мөргөлдөөний үед ашиглахыг хориглоно.

2. Эсрэг талын далбаа, эсхүл цэргийн бэлгэ тэмдэг, цэргийн ялгах тэмдэг, эсхүл дүрэмт хувцсыг довтолгооны үед, эсхүл цэргийн үйл ажиллагааг далдлах, түүнд тус дөхөм үзүүлэх, хамгаалах, эсхүл хүндруүлэх зорилгоор ашиглахыг хориглоно.

3. Энэ зүйлийн, эсхүл 37 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалт нь тагнуул хийх, эсхүл далайд болж буй зэвсэгт мөргөлдөөний үед далбааг ашиглахад хэрэглэх олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээг хөндөхгүй.

*40 дүгээр зүйл*

**Хүлцэх**

Хэнийг ч амьд үлдээхгүй байх, үүгээр эсрэг талаа сүрдүүлэх, эсхүл ийм үндсэн дээр байлдааны ажиллагаа явуулах тушаал өгөхийг хориглоно.

*41 дүгээр зүйл*

**Жагсаалаас гарсан эсрэг талын этгээдийг хамгаалах баталгаа**

1. Жагсаалаас гарсанд тооцогдсон, эсхүл тухайн нөхцөл байдалд жагсаалаас гарсанд тооцогдох хүмүүс рүү довтлохыг хориглоно.

2. Аливаа дайтах үйлдлээс татгалзаж, оргон зайлахыг оролдоогүй хүмүүсийг дараах тохиолдолд жагсаалаас гарсанд тооцно:

(a) эсрэг талын эрх мэдэлд байгаа хүн;

(b) олзлогдох санаагаа илт илэрхийлж байгаа хүн;

(c) ухаангүй байгаа, шарх, эсхүл өвчний улмаас ямар нэг байдлаар жагсаалаас гарсан бөгөөд өөрийгөө хамгаалах чадваргүй болсон хүн.

3. Дайнд олзлогдогчдын хувьд хамгаалуулах эрхтэй хүмүүс Гуравдугаар конвенцийн III ангийн I хэсэгт дурдсан нүүлгэн шилжүүлэлтийг хийх боломжгүй болсон нөхцөлд эсрэг талын эрхшээлд орсон тохиолдолд тэднийг суллах бөгөөд тэдний аюулгүй байдлыг хангах бололцоотой бүх арга хэмжээг авна.

*42 дугаар зүйл*

**Агаарын хөлгийн бүхээгт байгаа этгээд**

1. Сүйрэлд орсон агаарын хөлгөөс шүхрээр бууж байгаа нэг ч хүн рүү газардах хүртэл нь довтолж болохгүй.
2. Сүйрэлд орсон агаарын хөлгөөс эсрэг талын хяналтанд байгаа нутаг дэвсгэрт шүхрээр бусан хүн рүү, дайтах үйлдэл явуулж буй нь илэрхий байгаагаас бусад тохиолдолд довтлохын өмнө бууж өгөх боломжийг түүнд олгоно.
3. Агаарын десантын цэргүүд энэ зүйлээр хамгаалагдахгүй.

**II ХЭСЭГ**

**Байлдаж байгаа хүмүүс болон дайнд олзлогдогчдын эрх зүйн байдал**

*43 дугаар зүйл*

**Зэвсэгт хүчин**

1. Мөргөлдөөнд оролцогч талын зэвсэгт хүчин нь захирагдаж байгаа хүмүүсийнхээ үйл ажиллагааны талаар тухайн талын өмнө хариуцлага хүлээсэн хүний удирдлагын дор байгаа зохион байгуулалттай зэвсэгт хүчин, бүлэг болон нэгжүүдээс бүрэлдэнэ. Тухайн талыг эсрэг тал нь хүлээн зөвшөөрөгүй засгийн газар, эсхүл засаг захиргаа төлөөлж болно. Тийм зэвсэгт хүчин зэвсэгт мөргөлдөөний үед хэрэглэх олон улсын эрх зүйн хэм хэмжээг дагаж мөрдөх бөгөөд дотоодын сахилгын тогтолцоонд захирагдана.
2. Мөргөлдөөнд оролцогч талын зэвсэгт хүчиний бүрэлдэхүүний гишүүдийг (Гуравдугаар конвенцийн 33 дугаар зүйлд дурдсан эмнэлгийн болон шашны ажилтнаас гадна) байлдаж байгаа хүмүүст тооцох бөгөөд өөрөөр хэлбэл эдгээр хүмүүс дайтах ажиллагаанд шууд оролцох эрхтэй болно.
3. Мөргөлдөөнд оролцогч тал зэвсэгт хүчинийхээ бие бүрэлдэхүүнд цэргийн хагас зохион байгуулалттай байгууллага, эсхүл дэг журам сахиулах зэвсэглэсэн байгууллагыг оруулах бүртээ энэ тухай мөргөлдөөнд оролцогч бусад талд мэдэгдэнэ.

*44 дүгээр зүйл*

**Байлдаж байгаа хүмүүс болон дайнд олзлогдогчид**

1. 43 дугаар зүйлд байлдаж байгаа хүн гэж тодорхойлсон бөгөөд эсрэг талын эрх мэдэлд орсон хүнийг дайнд олзлогдогч гэнэ.
2. Хэдийгээр байлдаж байгаа бүх хүмүүс зэвсэгт мөргөлдөөний үед хэрэглэх олон улсын эрх зүйн хэм хэмжээг дагаж мөрдөх үүрэгтэй боловч эдгээр хэм хэмжээг зөрчсөн нь энэ зүйлийн 3, 4 дэх хэсэгт зааснаас бусад тохиолдолд байлдаж байгаа хүмүүсийн эрхийг, хэрэв эдгээр хүмүүс эсрэг талынхаа эрх мэдэлд орвол дайнд олзлогдогчдын эрх эдлэхийг хөндөхгүй.

3. Энгийн хүн амыг дайтах ажиллагааны үр дагавараас хамгаалахад тус дөхөм үзүүлэх зорилгоор байлдаж байгаа хүмүүс довтолгоонд, эсхүл түүнд бэлтгэж байгаа цэргийн ажиллагаанд оролцох үедээ өөрсдийгөө энгийн хүн амаас ялгах үүрэгтэй. Гэхдээ дайтах ажиллагааны шинж чанараас болж байлдаж байгаа хүмүүс зэвсэгт мөргөлдөөний үед өөрсдийгөө энгийн хүн амаас ялгаж чадахгүйд хүрвэл дараах тохиолдолд буу зэвсгээ ил авч явах бөгөөд зөвхөн энэ нөхцөлд эрх зүйн байдлаа хадгална:

(а) цэргийн тулгаралт бүрийн үед;

(б) өөрийн оролцох ёстой довтолгооны өмнө байлдааны журамд орох явцад эсрэг талд ил байрлаж байгаа үед.

Энэ хэсэгт дурдсан шаардлагад нийцэж байгаа үйлдэл нь 37 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “с” хэсгийн заалтын дагуу итгэл эвдсэнд үл тооцогдоно.

4. З дахь хэсгийн “в” хэсгийн заалтад тодорхойлсон шаардлагыг биелүүлээгүйн улмаас эсрэг талын эрх мэдэлд орсон байлдаж байгаа хүн дайнд олзлогдогчийн эрхийг эдлэхгүй. Гэхдээ Гуравдугаар конвенц болон энэхүү протоколын дагуу дайнд олзлогдогчдод олгодогтой бүх талаараа адил хамгаалалтыг түүнд олгоно. Хууль зөрчсөний учир шүүхэд шилжсэн буюу шийтгэл хүлээж байгаа дайнд олзлогдогчид Гуравдугаар конвенцийн дагуу олгодогтой адил хамгаалалт энэхүү хамгаалалтад багтана.

5. Довтолгоонд, эсхүл түүнд бэлтгэж байгаа цэргийн ажиллагаанд оролцоогүй байхдаа эсрэг талын эрх мэдэлд орсон байлдаж байгаа хүн урьд үйлдсэн үйлдлээс үл хамааран байлдаж байгаа хүний болон дайнд олзлогдогчийн эрхийг эдэлнэ.

6. Энэ зүйл нь Гуравдугаар конвенцийн 4 дүгээр зүйлийн дагуу дайнд олзлогдогч гэж тооцогдох аливаа хүний эрхийг хөндөхгүй.

7. Энэ зүйл мөргөлдөөнд оролцогч талын байнгын цэргийн зэвсэгт хэсгүүдийн дүрэмт хувцас өмсдөг бүрэлдэхүүнд багтан байлдаж байгаа хүмүүс дүрэмт хувцас өмсөх тухайд улс орнуудад тогтсон дадлыг өөрчлөх зорилгыг үл агуулна.

8. Нэг болон Хоёрдугаар конвенцийн 13 дугаар зүйлд дурдсан хүмүүсээс гадна мөргөлдөөнд оролцогч талын зэвсэгт хүчний бүрэлдэхүүний шархадсан, өвчилсөн бүх гишүүн энэхүү протоколын 43 дугаар зүйлийн дагуу, харин далайд буюу өөр усанд хөлөг онгоцны сүйрэлд өртөгдөгсөд Хоёрдугаар конвенцийн дагуу хамгаалуулах эрхтэй.

#### *45 дугаар зүйл*

#### **Дайтах ажиллагаанд оролцогчдын хамгаалалт**

1. Дайтах ажиллагаанд оролцож байгаад эсрэг талын эрх мэдэлд орсон хүн дайнд олзлогдогчийн эрх эдлэхийг өөрөө хүсэх, эсхүл тийм эрх олгогдох эрхтэй, эсхүл түүнийг харьяалах тал нь түүнд тийм эрх олгохыг шаардаж байгаагаа олзлогч гүрэн, эсхүл хамгаалагч гүрэнд мэдэгдэх тохиолдолд тэрбээр дайнд олзлогдогчийн эрх эдлэх бөгөөд ингэснээрээ Гуравдугаар конвенцийн дагуу хамгаалагдана. Аливаа

хүн дайнд олзлогдогчийн эрх эдлэх эрхтэй гэдэгт эргэлзээ төрөх тохиолдолд ч тийм эрхээ үргэлжлэн хадгалах бөгөөд эрх бүхий шүүхийн байгууллагаас түүний эрхийг тодорхойлох хүртэл Гуравдугаар конвенц болон энэхүү протоколоор хамгаалагдана.

2. Эсрэг талынхаа эрх мэдэлд орсон этгээдийг дайнд олзлогдогч гэж саатуулаагүй бөгөөд харин тухайн этгээдийг дайтах ажиллагаанаас үүдсэн гэмт хэрэгт буруутган шүүхэд татах байгаа тохиолдолд ч тэрбээр шүүхийн байгууллагын өмнө болон уг асуудлаар шийдвэр гаргах үед дайнд олзлогдогчийн эрх зүйн байдалтай байх эрхээ хамгаалах эрхтэй. Ийм шийдвэрийг бололцоотой үед түүнийг хууль зөрчсөний улмаас хийх шүүх хурлын өмнө, дагаж мөрдөж буй журмын дагуу гаргана. Энэ асуудлаар шийдвэр гаргах шүүх хурал улсын аюулгүй байдлын эрх ашгийн үүднээс хаалттай явагдаагүй тохиолдолд хамгаалагч гүрний төлөөлөгчид түүнд байлцах эрх эдэлнэ. Хаалттай явагдсан тохиолдолд олзлогч гүрэн хамгаалагч гүрэнд зохих ёсоор мэдэгдэнэ.

3. Дайтах ажиллагаанд оролцсон бөгөөд дайнд олзлогдогчийн эрх эдэлдэггүй, Дөрөвдүгээр конвенцийн дагуу илүү тааламжтай эрх олгогдоогүй хүн ямар ч үед энэхүү протоколын 75 дугаар зүйлд заасан хамгаалалтыг эдлэх эрхтэй. Эзлэгдсэн нутаг дэвсгэр дээр тагнуул гэж албадан саатуулагдаагүй аливаа хүн Дөрөвдүгээр конвенцийн 5 дугаар зүйлээс үл хамааран энэхүү конвенцоор олгосон холбоо барих эрхийг мөн эдэлнэ.

#### *46 дугаар зүйл*

##### **Тагнуул**

1. Мөргөлдөөнд оролцогч талын зэвсэгт хүчний аливаа гишүүн тагнуул хийж байгаад эсрэг талын эрх мэдэлд орсон тохиолдолд Конвенцууд болон энэхүү протоколын бусад заалтыг үл хамааран дайнд олзлогдогчийн эрх эдлэхгүй бөгөөд түүнтэй тагнуул гэж харьцана.

2. Мөргөлдөөнд оролцогч талын зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүнд орж, түүний нэрийн өмнөөс эсрэг талын хяналтанд байгаа нутаг дэвсгэр дээр өөрийн зэвсэгт хүчний дүрэмт хувцсыг өмсөн мэдээлэл цуглувулж байгаа, эсхүл цуглувулахыг оролдсон хүнийг тагнуул хийсэнд үл тооцогдоно.

3. Эсрэг талд эзлэгдсэн нутаг дэвсгэрт оршин сууж байгаа бөгөөд харьяалагдах талынхаа нэрийн өмнөөс уг нутаг дэвсгэр дээр цэргийн ач холбогдол бүхий мэдээ цуглувулж байгаа, эсхүл цуглувулахыг оролдсон мөргөлдөөнд оролцогч талын зэвсэгт хүчний бүрэлдэхүүний гишүүнийг, санаатайгаар далд арга хэрэглээгүй, эсхүл мэхлэх замаар энэ үйл ажиллагаагаа явуулаагүй бол тагнуул хийсэнд үл тооцно. Түүнчлэн уг этгээд тагнуул хийж яваад баригдаагүй бол дайнд олзлогдогчийн эрхээ алдахгүй бөгөөд түүнтэй тагнуулын нэгэн адил харьцаж болохгүй.

4. Эсрэг талд эзлэгдсэн нутаг дэвсгэрт оршин суудаггүй бөгөөд уг нутаг дэвсгэр дээр тагнуул хийж яваа мөргөлдөөнд оролцогч талын зэвсэгт хүчний бүрэлдэхүүний гишүүн өөрийн харьялагдах зэвсэгт хүчинд эргэж нэгдэхээсээ өмнө баригдсанаас бусад тохиолдолд дайнд олзлогдогчийн эрхээ үл алдах бөгөөд түүнтэй тагнуулын нэгэн адил харьцаж болохгүй.

47 дугаар зүйл

### Хөлсний этгээд

1. Хөлсний этгээд нь байлдаж байгаа хүмүүс болон дайнд олзлогдогчийн эрхийг эдлэхгүй.

2. Дараахь хүмүүсийг хөлсний этгээд гэнэ:

(а) зэвсэгт мөргөлдөөнд оролцож байлдах зорилгоор дотоодод буюу хилийн чанадад тусгайлан бэлтгэсэн хүн;

(б) дайтах ажиллагаанд хэрэг дээрээ шууд оролцож байгаа хүн;

(с) мөргөлдөөнд оролцогч тал, эсхүл түүний нэрийн өмнөөс уг талын зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүнд багтах адил зэрэг дэв, чиг үүрэгтэй байлдаж байгаа хүмүүст амласан, эсхүл төлж буй шангаас ихээхэн давсан шан амласан, хувийн ашиг хонжоо олох, авах хүсэлдээ хөтлөгдөн дайтах ажиллагаанд оролцож байгаа хүн;

(д) мөргөлдөөнд оролцогч аль нэг талын иргэн биш бөгөөд мөргөлдөөнд оролцогч талын хяналтанд байгаа нутаг дэвсгэрт байнга оршин суугч биш хүн;

(е) мөргөлдөөнд оролцогч талын зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүний гишүүн биш;

(f) мөргөлдөөнд оролцогч бус улсаас түүний зэвсэгт хүчний бүрэлдэхүүнд ордог хүмүүсийн албан үүргийг гүйцэтгэх зорилгоор явуулаагүй.

## IV АНГИ

### ЭНГИЙН ХҮН АМ

#### I ХЭСЭГ

##### Дайтах ажиллагааны үр дагавраас хамгаалах

#### I бүлэг

##### Үндсэн хэм хэмжээ, хэрэглэх хүрээ

48 дугаар зүйл.

##### Үндсэн хэм хэмжээ

Мөргөлдөөнд оролцогч талууд энгийн хүн ам болон иргэний объектуудыг хүндэтгэн хамгаалах явдлыг хангах зорилгоор энгийн хүн амыг байлдаж байгаа хүмүүсээс, түүнчлэн иргэний объектуудыг цэргийн объектуудаас цаг ямагт зааглан ялгаж байх ёстой бөгөөд зөвхөн цэргийн объектуудын эсрэг байлдааны ажиллагаа явуулна.

*49 дүгээр зүйл*

**Довтолгооны тодорхойлолт, хэрэглэх хүрээ**

1. "Довтолгоо" гэж давшилтын, эсхүл хамгаалалтын алинаас нь үл хамааран эсрэг талынхаа хувьд явуулж буй хүч хэрэглэсэн үйлдлийг хэлнэ.

2. Довтолгооны талаархи энэхүү протоколын заалтуудыг эсрэг талын хяналтанд байгаа бөгөөд мөргөлдөөнд оролцогч эхний талд харьялагдаж буй үндэсний нутаг дэвсгэрийг оролцуулан, ямар нутаг дэвсгэр дээр довтолгоо явагдаж байгаагаас үл хамааран бүх довтолгоонд хамааруулан хэрэглэнэ.

3. Энэ хэсгийн заалтуудыг хуурай газар дээр байгаа энгийн хүн ам, иргэд, эсхүл иргэний объектуудад хохирол учруулж болох хуурай газар, агаар, эсхүл далайд явагдаж буй дайны аливаа ажиллагаанд хамааруулан хэрэглэнэ. Эдгээр заалтыг газар дээр байгаа объектуудад далайгаас, эсхүл агаараас хийж байгаа бүх довтолгоонд нэг адил хамааруулан хэрэглэх бөгөөд харин эдгээр нь далай, эсхүл агаарт болж буй зэвсэгт мөргөлдөөний үед хэрэглэх олон улсын эрх зүйн хэм хэмжээг аливаа байдлаар хөндөхгүй.

4. Энэ хэсгийн заалтууд нь Дөрөвдүгээр конвенцийн II ангид дурдсан хүмүүнлэгийн хамгаалалтын хэм хэмжээ болон хэлэлцэн тохирогч эрхэм дээд талуудын заавал даган мөрдөх ёстой олон улсын бусад хэлэлцээр, түүнчлэн газар дээр, далайд, эсхүл агаарт байгаа энгийн хүмүүс болон иргэний объектуудыг дайтах ажиллагаанаас хамгаалахтай холбогдсон олон улсын эрх зүйн бусад хэм хэмжээнд нэмэлт болно.

**II бүлэг**

**Энгийн иргэд, энгийн хүн ам**

*50 дугаар зүйл*

**Энгийн иргэд болон энгийн хүн амын тодорхойлолт**

1. Гуравдугаар конвенцийн 4 дүгээр зүйлийн А хэсгийн (1), (2), (3) болон (6) дахь хэсэг болон энэхүү протоколын 43 дугаар зүйлд дурдсан ангиллалын алинд ч үл хамаарах этгээдийг энгийн иргэн гэнэ. Ямар нэг хүнийг энгийн иргэн байх эсэх тухайд эргэлзэх тохиолдолд түүнийг энгийн иргэнд тооцно.

2. Энгийн хүн ам нь энгийн бүх иргэнээс бүрдэнэ.

3. Энгийн хүн амын дотор энгийн иргэний тодорхойлолтод хамаарахгүй хүмүүс байх нь уг хүн амын энгийн шинж чанарыг хөндөхгүй.

*51 дүгээр зүйл*

**Энгийн хүн амын хамгаалалт**

1. Цэргийн ажиллагаанаас үүдэх аюулаас энгийн хүн ам болон энгийн иргэдийг нийтээр нь хамгаална. Ийм хамгаалалтыг хэрэгжүүлэхдээ олон улсын

эрх зүйн бусад хэм хэмжээнээс гадна бүх нөхцөлд дараахь нэмэлт хэм хэмжээг дагаж мөрдөнө.

2. Энгийн хүн ам бүхэлдээ, түүнчлэн тодорхой иргэд довтолгооны объект болох ёсгүй. Энгийн хүн амыг терроризмын үндсэн зорилготой хүч хэрэглэсэн үйлдэл хийх, эсхүл хүч хэрэглэхээр заналхийлэхийг хориглоно.

3. Дайтах ажиллагаанд шууд оролцож байгаагаас бусад хугацаанд болон тохиолдолд энгийн иргэд энэхүү хэсэгт заасны дагуу хамгаалалтад байна.

4. Нэлд нь устгах довтолгоон хийхийг хориглоно. Нэлд нь устгах довтолгоонд дараахь довтолгоог хамааруулна:

(а) цэргийн тодорхой объект руу чиглээгүй довтолгоо;

(б) цэргийн тодорхой объект уруу чиглээгүй дайны арга хэрэгсэл хэрэглэж буй довтолгоо;

(с) энэхүү протоколын шаардлагын дагуу үр дагаврыг нь хязгаарлах боломжгүй дайны арга хэрэгслийг хэрэглэж буй довтолгоо.

Эдгээр бүх тохиолдолд цэргийн объектууд болон энгийн иргэд, эсхүл иргэний объектуудыг ялгалгүй нэрвэгдүүлэх довтолгоо хамрагдана.

5. Дараахь хэлбэрийн довтолгоог нэлд нь устгах довтолгоонд мөн хамааруулна:

(а) энгийн иргэд, эсхүл иргэний объектууд төвлөрсөн хот, тосгон буюу бусад бүсэд байгаа бие биеэсээ илэрхий тусгаарлагдмал бөгөөд ялгаж болох цэргийн хэсэг объектуудыг цэргийн ганц объект болгон аливаа арга хэрэгслээр бөмбөгдөх довтолгоо;

(б) олж авахаар төлөвлөж байгаа цэргийн тодорхой давуу байдалтай харьцуулахад энгийн хүн амын амь насыг хөнөөх, энгийн иргэдийг шархдуулах, иргэний объектуудад хохирол учруулах, эсхүл эдгээрийн аль нэгийг нь хамарсан асар их хохирол учруулах довтолгоо.

6. Хариу авах арга хэмжээ болгож энгийн хүн ам, эсхүл энгийн иргэд рүү довтлохыг хориглоно.

7. Энгийн хүн ам, эсхүл энгийн иргэдийн байрлал, хөдөлгөөнийг тодорхой байрлал буюу бүсийг цэргийн ажиллагаанаас хамгаалах, тухайлбал цэргийн объектуудыг довтолгооноос хамгаалах, эсхүл цэргийн ажиллагааг далдах, түүнд тус дөхөм үзүүлэх, эсхүл саад хийх зорилгод ашиглаж болохгүй. Мөргөлдөөнд оролцогч талууд цэргийн объектуудыг довтолгооноос хамгаалах, эсхүл цэргийн ажиллагааг далдах зорилгоор энгийн хүн ам, эсхүл энгийн иргэдийн хөдөлгөөнийг шууд удирдан чиглүүлж болохгүй.

8. Эдгээр хориглолтыг зөрчих нь энгийн хүн ам болон энгийн иргэдийн талаархи эрх зүйн үүргээс болон 57 дугаар зүйлд дурдсан урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах үүргээс мөргөлдөөнд оролцогч талыг чөлөөлөхгүй.

### **III бүлэг**

#### **Иргэний объект**

*52 дугаар зүйл*

#### **Иргэний объектын нийтлэг хамгаалалт**

1. Иргэний объектыг довтолгооны, эсхүл хариу арга хэмжээ авах объект болгох ёсгүй. Энэ зүйлийн 2 дахь хэсэгт тодорхойлсон цэргийн объектуудаас бусад бүх объектыг иргэний объект гэнэ.

2. Довтолгоо нь зөвхөн цэргийн объектуудаар хатуу хязгаарлагдана. Шинж чанар, байрлал, зориулалт, эсхүл ашиглалтаараа цэргийн ажиллагаанд үр нөлөөтэй хувь нэмэр оруулж байгаа бөгөөд эдгээрийг бүрэн буюу хагас эвдэж сүйтгэх, эзлэн авах, эсхүл ажиллагаагүй болгох нь тухайн үеийн нөхцөл байдалд цэргийн илэрхий давуу байдал олгох объектуудыг цэргийн объектуудад хамааруулна.

3. Иргэний зориулалттай объектууд, тухайлбал мөргөлийн газар буюу ийм төрлийн бусад орон сууц, эсхүл сургуулийг цэргийн ажиллагаанд үр нөлөөтэй дэмжлэг үзүүлэхэд ашиглаж байгаа тухайд эргэлзэх тохиолдолд уг объектыг иргэний зорилгод ашиглаж байгаад тооцно.

*53 дугаар зүйл*

#### **Соёлын үнэт зүйлс болон мөргөлийн газрын хамгаалалт**

Зэвсэгт мөргөлдөөний үед соёлын үнэт зүйлсийг хамгаалах тухай 1954 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн Гаагийн конвенц болон олон улсын холбогдох бусад баримт бичгийн заалтуудыг үл хөндөн дараах үйлдлийг хориглоно:

- (а) улс түмний соёлын болон оюуны өв болсон түүхийн хөшөө дүрсгалууд, урлагийн бүтээлүүд, мөргөлийн газруудын эсрэг дайтах ажиллагаа явуулах;
- (б) эдгээр объектыг цэргийн ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгод ашиглах;
- (с) эдгээр объектыг хариу арга хэмжээ авах объект болгох.

*54 дүгээр зүйл*

#### **Энгийн хүн амыг аж төрөхөд шаардагдах объектын хамгаалалт**

1. Энгийн хүн амын дунд өлсгөлөн бий болгож, түүнийг дайны арга хэрэгсэл болгохыг хориглоно.

2. Энгийн хүн амыг аж төрөхөд шаардагдах хүнсний бүтээгдэхүүний нөөц, түүнийг үйлдвэрлэх хөдөө аж ахуйн бүс, тариалангийн талбай, мал сүрэг, ундны усаар хангах байгууламж, түүний нөөц, түүнчлэн услалтын байгууламж зэрэг объектыг амьдралыг тэтгэх хэрэгслийн нь хувьд энгийн хүн ам болон эсрэг талдаа үл ашиглуулах зорилгоор, мөн иргэдийн дунд өлсгөлөн бий болгох, тэднийг

гадагш гарч явах нөхцлийг бүрдүүлэх, эсхүл бусад ямар нэг шалтгаанаар довтлох, устгах, нүүлгэх, эсхүл хэрэгцээгүй болгохыг хориглоно.

3. Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан хоригийг мөн зүйлд хамаарах эсрэг талын дараах зорилгоор ашиглаж буй объектын тухайд үл хэрэглэнэ:

(а) зөвхөн түүний зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүний оршин тогтох явдлыг дэмжих;

(б) оршин тогтох явдлыг дэмжих зорилгоор биш ч цэргийн ажиллагааг шууд дэмжих. Гэхдээ ямар ч тохиолдолд эдгээр объектын эсрэг явуулах ажиллагаа нь энгийн хүн амыг хүрэлцэхүйц бус хүнсний бүтээгдэхүүн, эсхүл усгүй болгосны улмаас өлсгөлөн бий болох, эсхүл тэднийг гадагш гарч явахад хүргэх ёсгүй.

4. Эдгээр объектыг хариу арга хэмжээ авах объект болгож болохгүй.

5. Мөргөлдөөнд оролцогч аль ч тал довтолгооноос нутаг дэвсгэрээ хамгаалах нэн чухал хэрэгцээ шаардлагыг хүлээн зөвшөөрөх үүднээс цэргийн зайлшгүй хэрэгцээ шаардаж байгаа үед мөргөлдөөнд оролцогч тал өөрийн хяналтанд байгаа нутаг дэвсгэр дээр энэ зүйлийн 2 дахь хэсэгт дурдсан хориглолтоос ухарч болно.

### *55 дугаар зүйл*

#### **Байгаль орчны хамгаалалт**

1. Дайтах ажиллагаа явуулахдаа удаан хугацааны, өргөн цар хүрээтэй, ноцтой хохиролоос байгаль орчинг хамгаалах асуудлыг анхаарна. Энэхүү хамгаалалтанд байгаль орчинд тийм хохирол учруулах зорилготой, эсхүл учруулж болох, ингэснээр хүн амын эрүүл мэнд, эсхүл аж төрөх асуудлыг хөндөж, хохирол учруулах дайны арга хэрэгсэлийг ашиглахыг хориглох явдал хамаарна.

2. Хариу арга хэмжээ авах зорилгоор байгаль орчинд хохирол учруулахыг хориглоно.

### *56 дугаар зүйл*

#### **Аюултай хүч агуулсан төхөөрөмж болон байгууламжуудын хамгаалалт**

1. Аюултай хүч агуулсан төхөөрөмж, эсхүл байгууламж, тухайлбал усны далан хаалт, атомын цахилгаан станц уруу довтолсноор аюултай хүч алдагдаж энгийн хүн амд хүнд хохирол учруулахаар бол уг байгууламжууд нь цэргийн объект байсан ч тэдгээрийг довтолгооны объект болгож болохгүй. Эдгээр төхөөрөмж болон байгууламж дотор, эсхүл тэдгээрийн ойролцоо байгаа цэргийн бусад объектыг довтолсноор эдгээр төхөөрөмж, байгууламжаас аюултай хүч алдагдаж энгийн хүн амд хүнд хохирол учруулахаар бол тэдгээрийг довтолгооны объект болгож болохгүй.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан тусгай хамгаалалтыг дараах нөхцөлд зогсооно:

(а) хэвийн ажиллагаанаас өөр байдлаар ашиглагдан, цэргийн ажиллагаанд байнга болон шууд нөлөө бүхий дэмжлэг үзүүлж байгаа бөгөөд тэдгээрийг довтлох нь энэхүү дэмжлэгийг зогсоох цорын ганц боломжтой арга зам болж байгаа усны далан хаалтын хувьд;

(б) цэргийн ажиллагаанд байнга болон шууд нөлөө бүхий дэмжлэг үзүүлэх зорилгоор эрчим хүчээр ханган, ашиглагдаж байгаа бөгөөд тэдгээрийг довтлох нь энэхүү дэмжлэгийг зогсоох цорын ганц боломжтой арга зам болж байгаа атомын цахилгаан станцын хувьд;

(с) дээр дурдсан төхөөрөмж болон байгууламжууд дотор, эсхүл тэдгээрийн ойролцоо байгаа бөгөөд цэргийн ажиллагаанд байнга болон шууд нөлөө бүхий дэмжлэг үзүүлэх ашиглагдаж байгаа бөгөөд тэдгээрийг довтлох нь уг дэмжлэгийг зогсоох цорын ганц боломжтой арга зам болж байгаа цэргийн бусад объектын хувьд.

3. Энгийн хүн ам болон энгийн иргэд 57 дугаар зүйлд дурдсан урьдчилан сэргийлэх арга хэмжээний хамгаалалтыг оролцуулан олон улсын эрх зүйн дагуу олгох бүх хамгаалалтад хамрагдана. Хэрэв энэ зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан төхөөрөмж, байгууламжууд, эсхүл цэргийн объектуудын хамгаалалтыг зогсоож, тэдгээр рүү довтолсон бол аюултай хүч үйлчлэхээс сэргийлэх бололцоотой бүх арга хэмжээг авна.

4. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан аливаа төхөөрөмж, байгууламж, эсхүл цэргийн объектуудыг хариу арга хэмжээ авах объект болгохыг хориглоно.

5. Мөргөлдөөнд оролцогч талууд цэргийн аливаа объектыг энэ зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан төхөөрөмж, эсхүл байгууламжийн ойролцоо байрлуулахгүй байхыг эрмэлзэнэ. Гэхдээ зөвхөн хамгаалалтад байгаа төхөөрөмж, эсхүл байгууламжийг хамгаалах зорилгоор, тэдгээр рүү хийсэн довтолгоог эсэргүүцэх хамгаалалтын ажиллагаанаас өөр дайтах ажиллагаанд ашиглагдахгүй бөгөөд зэвсэг нь зөвхөн тухайн төхөөрөмж болон байгууламжууд руу хийсэн довтолгоог няцаах төдий чадвартай байхаар хязгаарлах бол зохих байгууламжийг байрлуулахыг зөвшөөрөх бөгөөд эдгээр байгууламжийг довтолгооны объект болгож болохгүй.

6. Аюултай хүч агуулсан объектыг сайтар хамгаалах зорилгоор өөр хоорондоо хэлэлцээр байгуулахыг хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд болон мөргөлдөөнд оролцогч талуудад уриалж байна.

7. Энэ зүйлийн дагуу хамгаалагдах объектыг таньж мэдэх явдлыг хөнгөвчлөх үүднээс мөргөлдөөнд оролцогч талууд тэдгээрт энэхүү протоколын 1 дүгээр хавсралтын 16 дугаар зүйлд тодорхойлсон нэг тэнхлэг дээр байрласан хурц улбар шар өнгийн дугуйнуудаас бүрдсэн тусгай тэмдгийг тавьж болно. Ийм тэмдэг байхгүй байгаа нь мөргөлдөөнд оролцогч аль ч талыг энэ зүйлийн дагуу хүлээсэн үүргээс чөлөөлөхгүй.

## **IV бүлэг**

### **Урьдчилан сэргийлэх арга хэмжээ**

*57 дугаар зүйл*

#### **Довтолгооны үед авах урьдчилан сэргийлэх арга хэмжээ**

1. Цэргийн ажиллагаа явуулахдаа энгийн хүн ам, энгийн иргэд болон иргэний объектыг хамгаалах талаар байнга анхаарна.

2. Довтолгооны үеэр дараахь урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна:

(a) довтлох төлөвлөгөө болон түүнийг хэрэгжүүлэх тухай шийдвэр гаргаж буй хүн:

(i) довтлох объект нь энгийн иргэд биш, иргэний объект биш, онцгой хамгаалалтад хамаарахгүй, харин тэдгээр нь 52 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалтын дагуу цэргийн объект мөн бөгөөд энэхүү протоколын дагуу түүн рүү довтлохыг хориглоогүй гэдгийг гэрчлэх талаар бололцоотой бүхнийг хийнэ.

(ii) энгийн иргэдийн амь насыг тохиолдлын чанартай хохироох, тэднийг шархдуулах, иргэний объектуудад тохиолдлын чанартай хохирол учруулахаас зайлсхийх, аль болох бага хохирол учруулах үүднээс довтлох арга хэрэгслийг сонгоходоо урьдчилан сэргийлэх бололцоотой бүх арга хэмжээг авна.

(iii) энгийн иргэдийн амь насыг тохиолдлын чанартай хохироох, тэднийг шархдуулах, иргэний объектад тохиолдлын чанартай хохирол учруулах, эсхүл эдгээр нь хамтдаа олж авахаар төлөвлөж буй цэргийн тодорхой, шууд давуу байдалтай харьцуулахад асар их хохирол учруулахаар байвал тийм довтолгоо хийх тухай шийдвэр гаргахаас татгалзана.

(b) довтлох гэж байгаа объект нь цэргийн биш, эсхүл онцгой хамгаалалтад хамаардаг, эсхүл уг довтолгоо энгийн иргэдийн амь насыг тохиолдлын чанартай хохироох, тэднийг шархдуулах, иргэний объектад тохиолдлын чанартай хохирол учруулах, эсхүл эдгээр нь хамтдаа олж авахаар төлөвлөж буй цэргийн тодорхой, шууд давуу байдалтай харьцуулахад асар их хохирол учруулах нь илэрхий болбол уг довтолгоог хүчингүй болгох, эсхүл зогсоноо;

(c) энгийн хүн амыг хамарч болзошгүй довтолгооны талаар боломжтой бүх нөхцөлд урьдчилан мэдэгдэнэ.

3. Цэргийн хэд хэдэн объектыг довтлоход адил хэмжээний цэргийн давуу байдал олж авах боломжтой байгаа тохиолдолд энгийн иргэдийн амь нас болон иргэний объектуудад хамгийн бага аюул учруулах объектыг сонгож авна.

4. Мөргөлдөөнд оролцогч талууд далай, эсхүл агаарт цэргийн ажиллагаа явуулахдаа зэвсэгт мөргөлдөөний үед хэрэглэх олон улсын эрх хэмжээгээр хүлээсэн өөрийн эрх, үүргийн дагуу энгийн иргэдийн амь насыг хохироох болон иргэний объектад хохирол учруулахгүй байх зорилгоор

урьдчилан сэргийлэх боломжит бүх арга хэжээг авна.

5. Энэ зүйлийн аль ч заалтыг энгийн хүн ам, энгийн иргэд, эсхүл иргэний объект уруу довтлохыг зөвшөөрч байгаа мэтээр тайлбарлаж болохгүй.

## 58 дугаар зүйл

### Довтолгооны үр дагавараас урьдчилан сэргийлэх арга хэмжээ

Мөргөлдөөнд оролцогч талууд хамгийн боломжтой хэмжээнд:

(а) Дөрөвдүгээр конвенцийн 49 дүгээр зүйлийг зөрчихгүйгээр цэргийн объектын ойролцоо байрласан өөрсдийн хяналтанд байгаа энгийн хүн ам, энгийн иргэд болон иргэний объектыг тэндээс нүүлгэн холдуулахыг эрмэлзэнэ;

(б) хүн ам шигүү суурьшсан нутагт, эсхүл тэдгээрийн ойролцоо цэргийн объект байрлуулахаас зайлсхийнэ;

(с) өөрсдийн хяналтанд байгаа энгийн хүн ам, энгийн иргэд болон иргэний объектыг цэргийн ажиллагаанаас үүдэн гарах аюулаас хамгаалах шаардлагатай бусад арга хэмжээг авна.

## V бүлэг

### Онцгой хамгаалалтанд байгаа газар, бүс

#### 59 дүгээр зүйл

### Хамгаалалтгүй газар

1. Мөргөлдөөнд оролцогч талууд ямар ч хэрэгслээр хамгаалалтгүй газар уруу довтлохыг хориглоно.

2. Мөргөлдөөнд оролцогч талын холбогдох засаг захиргаа нь зэвсэгт хүчин байрлаж байгаа бүсэд, эсхүл түүний ойролцоо байгаа бөгөөд эсрэг тал эзлэхэд нээлттэй аливаа суурин газрыг хамгаалалтгүй газар гэж мэдэгдэж болно. Эдгээр газар нь дараах нөхцөлийг хангасан байна:

(а) байлдаж байгаа хүмүүс, түүнчлэн байлдааны зөөврийн хэрэгсэл болон байлдааны зөөврийн тоног төхөөрөмжийг нүүлгэн зайлцуулсан байх ёстой;

(б) цэргийн суурин төхөөрөмж, эсхүл байгууламжийг дайтах зорилгоор ашиглахгүй байх;

(с) засаг захиргаа болон хүн ам дайтах ажиллагаа явуулахгүй байх;

(д) цэргийн ажиллагааг хөхиүлэн дэмжсэн аливаа үйлдэл хийхгүй байх.

3. Конвенцууд болон энэхүү протоколын дагуу онцгой хамгаалалтанд хамрагдах хүмүүс, зөвхөн хууль, дэг журам сахиулах зорилгоор үлдсэн цагдаагийн хүчин энэ газарт байх нь энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан нөхцөлд үл харшилна.

4. Хамгаалалтгүй газрын байрлал, хил хязгаарыг аль болох нарийвчлан тодорхойлсон мэдэгдлийг энэ зүйлийн 2 дахь хэсгийн дагуу эсрэг талд хандаж гаргана. Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан нөхцлийг бодит байдалд хангахгүй байгаагаас бусад тохиолдолд уг мэдэгдлийг хүлээн авагч мөргөлдөөнд оролцогч тал мэдэгдлийг хүлээн авснаа нотлох бөгөөд уг мэдэгдэл дурдсан газрын хувьд түүнийг хамгаалалтгүй газартай адилтган үзнэ. Харин 2 дахь хэсэгт заасан нөхцлийг хангахгүй тохиолдолд энэ тухай уг тал мэдэгдэл хийсэн талд яаралтай мэдэгдэнэ. Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан нөхцлийг хангахгүй байсан ч уг газар нь энэхүү протоколын бусад заалт болон зэвсэгт мөргөлдөөний үед хэрэглэх олон улсын эрх зүйн бусад хэм хэмжээгээр олгогдох хамгаалалтанд байна.

5. Эдгээр газар энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан нөхцлийг хангахгүй байсан ч гэсэн мөргөлдөөнд оролцогч талууд түүнийг хамгаалалтгүй газар гэж зарлахаар хэлэлцэн тохирч болно. Уг хэлэлцээрт хамгаалалтгүй газрын байрлал, хил хязгаарыг аль болох нарийн тодорхойлох бөгөөд шаардлагатай үед хяналт тавих аргын талаар хэлэлцээрт тусгаж болно.

6. Уг хэлэлцээрээр зохицуулах газрыг хяналтандaa байлгаж буй тал нөгөө талтай тохиролцсоны дагуу тэмдгээр тэмдэглэх бөгөөд тэдгээрийг тод харагдах газарт, ялангуяа уг газрын хил хязгаар, эргэн тойронд болон гол замууд дээр байрлуулна.

7. Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан нөхцөл, эсхүл 5 дахь хэсэгт дурдсан хэлэлцээрийн нөхцлийг хангахаа больсон газар нь хамгаалалтгүй газар байх эрх зүйн байдлаа алдана. Энэ тохиолдолд уг газар нь энэхүү протоколын бусад заалт болон зэвсэгт мөргөлдөөний үед хэрэглэх олон улсын эрх зүйн бусад хэм хэмжээгээр олгогдох хамгаалалтанд байсаар байна.

*60 дугаар зүйл*

### **Цэрэггүй бүс**

1. Хэрэв цэрэггүй бүсийн эрх зүйн байдал олгох тухай хэлэлцээрийн заалтад харшилж байгаа бол, тийм эрх зүйн байдал олгосон бүсэд цэргийн ажиллагаагаа өргөжүүлэн явуулахыг мөргөлдөөнд оролцогч талуудад хориглоно.

2. Тийм хэлэлцээрийг шууд, эсхүл хамгаалагч гүрэн, эсхүл аль нэг хүмүүнлэгийн байгууллагын зуучлалтайгаар амаар, эсхүл бичгээр тохиролцон байгуулах бөгөөд харилцан тохиролцсон мэдэгдэл хэлбэртэй байж болно. Хэлэлцээрийг тайван цагт, эсхүл дайтах ажиллагаа эхэлснээс хойш байгуулж болох бөгөөд түүнд цэрэггүй бүсийн байрлал, хил хязгаарыг аль болох нарийн тодорхойлж, шаардлагатай үед хяналт тавих аргын талаар хэлэлцээрт тусгаж болно.

3. Дараахь нөхцлийг хангаж буй аливаа бүсийн хувьд энэ хэлэлцээрийг байгуулна:

(a) байлдаж байгаа хүмүүс, түүнчлэн байлдааны зөөврийн хэрэгсэл болон байлдааны зөөврийн тоног төхөөрөмжийг заавал нүүлгэн зайлзуулсан байх;

(b) цэргийн суурин төхөөрөмж, эсхүл байгууламжийг дайтах зорилгоор ашиглахгүй байх;

(с) засаг захиргаа болон хүн ам дайтах ажиллагаа явуулахгүй байх;

(д) цэргийн ажиллагааг хөхиүлэн дэмжсэн аливаа үйл ажиллагааг заавал зогсоосон байх.

Мөргөлдөөнд оролцогч талууд энэ зүйлийн 3 дахь хэсгийн “d” хэсгийн заалтад тусгасан нехцлийг тайлбарлах болон цэрэггүй бүсэд нэвтрэх эрхтэй энэ зүйлийн 4 дэх хэсэгт дурдсан хүмүүсээс бусад хүмүүсийн талаар хэлэлцэн тохирно.

4. Конвенцууд болон энэхүү протоколын дагуу онцгой хамгаалалтанд хамрагдах хүмүүс, зөвхөн хууль, дэг журам сахиулах зорилгоор үлдсэн цагдаагийн хүчин энэ бүсэд байх нь энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан нөхцөлд үл харшилна.

5. Уг хэлэлцээрээр зохицуулах бүсийг хяналтанд байлгаж буй тал нөгөө талтай тохиролцсоны дагуу тэмдгээр тэмдэглэх бөгөөд тэдгээрийг тод харагдах газарт, ялангуяа уг бүсийн хил хязгаар, эргэн тойронд болон гол замууд дээр байрлуулна.

6. Дайтах ажиллагаа цэрэггүй бүсэд ойртоож ирсэн тохиолдолд хэрэв мөргөлдөөнд оролцогч талууд хэлэлцэн тохирвол аль ч тал энэ бүсийг цэргийн ажиллагаа явуулахтай холбогдсон зорилгод ашиглах, эсхүл түүний эрх зүйн байдлыг дангаараа өөрчилж болохгүй.

7. Хэрэв мөргөлдөөнд оролцогч аль нэг тал энэ зүйлийн 3, эсхүл 6 дахь хэсгийн заалтуудыг ноцтой зөрчвөл нөгөө тал уг бүсэд цэрэггүй бүсийн эрх зүйн байдал олгох тухай хэлэлцээрээр хүлээсэн үүргээсээ чөлөөлөгдөнө. Энэ тохиолдолд уг бүс эрх зүйн байдлаа алдах боловч энэхүү протоколын бусад заалт болон зэвсэгт мөргөлдөөний үед хэрэглэх олон улсын эрх зүйн бусад хэм хэмжээгээр олгогдох хамгаалалтанд байсаар байна.

## VI бүлэг

### Иргэний хамгаалалт

61 дүгээр зүйл

#### Тодорхойлолт, хэрэглэх хүрээ

Энэхүү протоколын зорилгод:

1) "иргэний хамгаалалт" гэж энгийн хүн амыг аюулаас хамгаалах, дайтах ажиллагааны, эсхүл гамшгийн шууд учруулсан хор уршигийг арилгахад тэдэнд туслах, түүнчлэн энгийн хүн амыг аж төрөхөд шаардагдах нөхцлийг бүрдүүлэхэд чиглэсэн дор дурдсан хүмүүнлэг зорилтыг хэсэгчлэн, эсхүл бүрэн хэрэгжүүлэхийг хэлнэ:

(a) анхааруулах;

(b) нүүлгэн шилжүүлэх;

(c) хоргодох байр, оромжоор хангах, зохион байгуулах;

- (d) гэрэл далдах арга хэмжээ авах;
- (e) аврах ажлууд;
- (f) анхны тусlamж, эмнэлгийн үйлчилгээ, түүнчлэн шашны тусlamж;
- (g) гал түймэртэй тэмцэх;
- (h) аюултай бүсийг илрүүлэх, онцлон тэмдэглэх;
- (i) халдвартгүй болгох болон эмнэлгийн хамгаалалтын бусад төстэй арга хэмжээ;
- (j) байр сууц болон хангалтыг яаралтай олгох;
- (k) гамшиг тохиолдсон бүсэд сэргээн босгох болон дэг журам сахиулахад яаралтай тусlamж үзүүлэх;
- (l) нийтийн ахуйн шаардлагатай үйлчилгээг яаралтай сэргээх;
- (m) цогцсуудыг яаралтай оршуулах;
- (n) аж төрөхөд зайлшгүй шаардлагатай объектуудыг хамгаалан үлдээхэд тусlamж үзүүлэх;
- (o) төлөвлөлт, зохион байгуулалтаар хязгаарлахгүйгээр дээр дурдсан зорилтуудыг хэрэгжүүлэхэд шаардагдах нэмэлт үйл ажиллагаа.

2) "Иргэний хамгаалалтын байгууллага" гэж энэ зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан аливаа зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор мөргөлдөөнд оролцогч талын эрх бүхий байгууллагаас бүрэн эрх олгосон, эсхүл зохион байгуулагдсан, зөвхөн эдгээр зорилтыг биелүүлэх зорилготой байгууллагууд болон бусад нэгжийг хэлнэ.

3) иргэний хамгаалалтын байгууллагын "ажилтан" гэж зөвхөн эдгээр байгууллагыг удирдах зорилгоор мөргөлдөөнд оролцогч талын эрх бүхий байгууллагаас томилсон хүмүүсийг, түүнчлэн мөргөлдөөнд оролцогч талын томилсон, энэ зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан зорилтуудыг хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн хүмүүсийг тус тус хэлнэ.

4) иргэний хамгаалалтын байгууллагуудын "эд материал" гэж эдгээр байгууллагаас энэ зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан зорилтуудыг хэрэгжүүлэх зорилгоор ашиглаж байгаа тоног төхөөрөмж, материал болон тээврийн хэрэгслийг хэлнэ.

62 дугаар зүйл

### Нийтлэг хамгаалалт

1. Иргэний хамгаалалтын иргэний байгууллагууд болон тэдгээрийн ажилтнуудад энэхүү протокол, тухайлбал энэхүү хэсгийн заалтуудын дагуу хүндэтгэл үзүүлж хамгаалалтанд байлгана. Цэргийн онцгой шаардлага гарахаас бусад тохиолдолд тэд иргэний хамгаалалтын зорилтуудыг хэрэгжүүлж эрх эдэлнэ.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг иргэний хамгаалалтын иргэний байгууллагын гишүүн бус бөгөөд эрх бүхий байгууллагын уриалгаар, тэдний хяналтын дор иргэний хамгаалалтын зорилтуудыг хэрэгжүүлж байгаа иргэдэд нэгэн адил хэрэглэнэ.

3. Энэхүү протоколын 52 дугаар зүйлд иргэний хамгаалалтын зорилгоор ашиглаж буй байшин болон эд материал, түүнчлэн энгийн хүн амд олгосон хоргодах газрууд хамаарна. Иргэний хамгаалалтын зорилгоор ашиглаж буй объектыг устгаж, эсхүл тэдгээрийг өмчилж байгаа талаас бусад тал өөр зориулалтаар ашиглаж болохгүй.

*63 дугаар зүйл*

**Эзлэгдсэн нутаг дэвсгэр дэх иргэний хамгаалалт**

1. Эзлэгдсэн нутаг дэвсгэр дэх иргэний хамгаалалтын иргэний байгууллагууд өөрийн зорилтыг хэрэгжүүлэхэд шаардагдах тус дэмжлэгийг эрх бүхий байгууллагаас авна. Өөрийн зорилтоо зохих ёсоор хэрэгжүүлэхэд нь хүндрэл учруулах үйл ажиллагаа явуулахыг эдгээр байгууллагын ажилтанаас ямар ч нөхцөл байдалд албадаж болохгүй. Эдгээр байгууллагын зорилтыг үр нөлөөтэй хэрэгжүүлэхэд саад учруулахаар байвал эзлэгч гүрэн тэдгээр байгууллагын бүтэц, эсхүл ажилтнуудыг өөрчилж хэрхэвч болохгүй. Эзлэгч гүрний эрх ашиг, эсхүл түүний иргэдэд давуу байдал олгохыг эдгээр байгууллагаас шаардаж болохгүй.

2. Өөрийн зорилтуудыг энгийн хүн амын эрх ашигт хортой нөлөө үзүүлэхүйцээр хэрэгжүүлэхийг эзлэгч гүрэн иргэний хамгаалалтын иргэний байгууллагуудаас шаардах, албадах, эсхүл тэднийг өдөөн турхирч болохгүй.

3. Эзлэгч гүрэн аюулгүй байдлыг хангах үүднээс иргэний хамгаалалтын ажилтны зэвсгийг хурааж болно.

4. Иргэний хамгаалалтын байгууллагуудад харьяалагдаж байгаа, эсхүл тэдний ашиглаж буй барилга байшин, эд материалын үндсэн зориулалтыг өөрчлөх, дайчлан авах нь энгийн хүн амд хохирол учруулах бол эзлэгч гүрэн ийм үйлдлийг хийж болохгүй.

5. Энэ зүйлийн 4 дэх хэсэгт заасан нийтлэг хэм хэмжээг үргэлжлүүлэн мөрдөж байгаа тохиолдолд эзлэгч гүрэн дараахь тодорхой нөхцөлд эдгээр нөөцийг дайчлан авах, эсхүл тэдгээрийн зориулалтыг өөрчилж болно:

- а) эдгээр барилга, байшин, эд материал нь энгийн хүн амын бусад хэрэгцээнд зайлшгүй шаардагдаж байгаа бол;
- б) ийнхүү дайчлан авах, эсхүл зориулалтыг өөрчлөх нь зөвхөн тийм шаардлага байгаа хугацаанд л явагдана.

6. Энгийн хүн амын хэрэгцээнд зориулан олгосон, эсхүл тэдэнд шаардлагатай байгаа хоргодах байрын зориулалтыг эзлэгч гүрэн өөрчлөх, дайчлан авч болохгүй.

*64 дүгээр зүйл*

**Төвийг сахисан, эсхүл мөргөлдөөнд оролцогч бусад улсын  
иргэний хамгаалалтын иргэний байгууллага болон олон улсын  
зохицуулагч байгууллага**

1. Мөргөлдөөнд оролцогч тухайн талын зөвшөөрснөөр, түүний хяналтын дор, нутаг дэвсгэрт нь 61 дүгээр зүйлд дурдсан иргэний хамгаалалтын зорилтуудыг хэрэгжүүлж байгаа төвийг сахисан, эсхүл мөргөлдөөнд оролцогч бусад улсын иргэний хамгаалалтын иргэний байгууллагын ажилтан болон эд материалын хувьд 62, 63, 65, 66 дугаар зүйлийн заалтуудыг мөн хэрэглэнэ. Эсрэг талд уг тусlamжийн тухай аль болох эрт мэдээлнэ. Ямар ч нөхцөл байдалд энэ үйл ажиллагааг мөргөлдөөнд хөндлөнгөөс оролцсон мэтээр үзэж болохгүй. Гэхдээ энэ үйл ажиллагааг мөргөлдөөнд оролцогч холбогдох талуудын аюулгүй байдлын эрх ашгийг зохих ёсоор харгалзан үзсэний үндсэн дээр явуулна.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан тусlamжийг авч буй мөргөлдөөнд оролцогч талууд болон уг тусlamжийг олгож буй Хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд шаардлагатай үед иргэний хамгаалалтын салбар дахь энэ үйл ажиллагааг олон улсын хэмжээнд зохицуулахад тус дөхөм үзүүлнэ. Ийм тохиолдолд энэхүү бүлгийн заалтуудыг холбогдох олон улсын байгууллагуудад хэрэглэнэ.

3. Эзлэгч гүрэн өөрийн, эсхүл эзлэгдсэн нутаг дэвсгэрт байгаа нөөц бололцоогоор иргэний хамгаалалтын зорилтыг зохих ёсоор хэрэгжүүлж чадах тохиолдолд л төвийг сахисан, эсхүл мөргөлдөөнд оролцогч бусад улсын иргэний хамгаалалтын иргэний байгууллагууд болон олон улсын зохицуулагч байгууллагуудын үйл ажиллагааг эзлэгдсэн нутаг дэвсгэрт хориглож, эсхүл хязгаарлаж болно.

*65 дугаар зүйл*

**Хамгаалалтыг дуусгавар болгох**

1. Хамгаалуулах эрх бүхий иргэний хамгаалалтын иргэний байгууллагууд, тэдгээрийн ажилтан, барилга, хоргодох байр болон эд материалын хамгаалалтыг үндсэн зорилтоос нь өөрөөр, эсрэг талд хохирол учруулах үйлдэл хийсэн, эсхүл ийм үйлдэл хийхэд ашиглаж байгаагаас бусад тохиолдолд дуусгавар болгохгүй. Гэхдээ уг хамгаалалтыг зөвхөн шаардлагатай үед, хүрэлцэхүйц хугацаа бүхий сануулга өгсний дараа, сануулгыг хүлээж аваагүй тохиолдолд л дуусгавар болно.

2. Дараахь үйлдлийг эсрэг талдаа хохирол учруулсан үйлдэлд тооцохгүй:

(а) цэргийн эрх баригчдын удирдлага, хяналтын дор иргэний хамгаалалтын зорилтыг хэрэгжүүлэх;

(б) иргэний хамгаалалтын зорилтыг хэрэгжүүлэхэд иргэний хамгаалалтын ажилтан цэргийн бие бүрэлдэхүүнтэй хамтран ажиллаж байгаа, эсхүл цэргийн зарим албан хаагчдыг иргэний хамгаалалтын иргэний байгууллагуудад томилсон бол;

(с) иргэний хамгаалалтын зорилтыг хэрэгжүүлэх нь дайнд хэлмэгдэгсдэд, ялангуяа жагсаалаас гарсан хүмүүст ашигтай байх бол.

3. Дэг журам сахиулах, эсхүл өөрийгөө хамгаалах зорилгоор иргэний хамгаалалтын ажилтан хөнгөн зэвсэг биедээ авч явахыг эсрэг талд хохирол учруулах үйлдэлд мөн тооцохгүй. Гэхдээ мөргөлдөөнд оролцогч талууд хуурай газрын байлдаан болж байгаа, эсхүл байлдаан гарч болох бүсэд иргэний хамгаалалтын ажилтныг байлдаж байгаа хүмүүсээс ялгах явдлыг хөнгөвлөхийн тулд тэдгээр хүмүүсийн зэвсгийг гар буу зэрэг гар зэвсгээр хязгаарлах шаардлагатай арга хэмжээ авна. Эдгээр бүсэд иргэний хамгаалалтын ажилтан биедээ бусад төрлийн хөнгөн зэвсэг авч явсан ч иргэний хамгаалалтын ажилтан гэж танигдмагц түүнд хүндэтгэл үзүүлж хамгаалалтад байлгана.

4. Иргэний хамгаалалтын иргэний байгууллагуудыг цэргийн маягаар байгуулах, тэдгээрт заавал алба хаах нь энэ бүлгээр олгогдох хамгаалалтыг мөн хөндөхгүй.

#### *66 дугаар зүйл*

#### **Танъж тогтоох**

1. Мөргөлдөөнд оролцогч тал бүр зөвхөн иргэний хамгаалалтын зорилтуудыг хэрэгжүүлж байгаа өөрийн иргэний хамгаалалтын байгууллагууд, тэдгээрийн ажилтан, барилга болон эд материалыг танигдахуйц байлгах явдлыг хангахыг эрмэлзэнэ. Түүнчлэн энгийн хүн амд зориулан олгосон хоргodoх байр мөн танигдахуйц байна.

2. Мөргөлдөөнд оролцогч тал бүр иргэний хамгаалалтын олон улсын ялгах тэмдэг байрлуулсан иргэдийн хоргodoх байр, иргэний хамгаалалтын ажилтан, барилга болон эд материалыг таних бололцоотой болгох талаархи арга, журмыг баталж хэрэгжүүлэхийг мөн эрмэлзэнэ.

3. Эзлэгдсэн нутаг дэвсгэрт болон байлдаан болж байгаа, эсхүл байлдаан үүсэж болох бүсэд байгаа иргэний хамгаалалтын ажилтныг иргэний хамгаалалтын олон улсын ялгах тэмдэг болон тэдний эрх зүйн байдлыг нотолсон хувийн үнэмлэхээр танина.

4. Иргэний хамгаалалтын олон улсын таних тэмдэг гэж иргэний хамгаалалтын байгууллагууд, тэдгээрийн ажилтан, барилга болон эд материал, түүнчлэн иргэдийн хоргodoх байрыг хамгаалах зорилгоор ашиглаж байгаа улбар шар дэвсгэр дээр дүрсэлсэн тэнцүү талтай цэнхэр гурвалжинг хэлнэ.

5. Мөргөлдөөнд оролцогч талууд иргэний хамгаалалтын таних тэмдгийн зэрэгцээ ялгах дохиог ашиглах талаар тохиролцож болно.

6. Энэ зүйлийн 1 – 4 дэх хэсгийн заалтуудыг энэхүү протоколын 1 дүгээр хавсралтын 5 дугаар бүлэгт дурдсаны дагуу хэрэглэнэ.

7. Энэ зүйлийн 4 дэх хэсэгт тодорхойлсон таних тэмдгийг тайван цагт дотоодын эрх бүхий байгууллагуудын зөвшөөрлийн дагуу иргэний хамгаалалтыг ялгаж таних зорилгоор ашиглаж болно.

8. Хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд болон мөргөлдөөнд оролцогч талууд иргэний хамгаалалтын олон улсын таних тэмдгийн ашиглалтыг хянах, түүнийг хортой урвуулан ашиглахаас урьдчилан сэргийлэх, ийнхүү ашиглахыг таслан

зогсоох зорилгоор шаардлагатай арга хэмжээ авна.

9. Иргэний хамгаалалтын эмнэлгийн ажилтнууд болон шашны хүмүүс, эмнэлгийн албад, эмнэлгийн тээврийн хэрэгслийг ялгаж таниулах явдлыг 18 дугаар зүйлээр мөн зохицуулна.

*67 дугаар зүйл*

**Иргэний хамгаалалтын байгууллагуудад томилогдсон зэвсэгт хүчний  
бие бүрэлдэхүүн болон цэргийн анги, нэгтгэл**

1. Иргэний хамгаалалтын байгууллагуудад томилогдсон зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн болон цэргийн анги, нэгтгэлийг дараахь нөхцөлд хүндэтгэл үзүүлж хамгаалалтанд байлгана :

(a) ийм бие бүрэлдэхүүн болон цэргийн анги, нэгтгэл байнга томилогдсон бөгөөд зөвхөн 61 дүгээр зүйлд дурдсан аль нэг зорилтыг хэрэгжүүлж байгаа бол;

(b) ийнхүү томилогдсон бие бүрэлдэхүүн мөргөлдөөний үед цэргийн бусад ямар нэг үүрэг гүйцэтгээгүй бол;

(c) ил харагдах газарт аль болох том хэмжээтэй хийж зүүсэн иргэний хамгаалалтын олон улсын таних тэмдгээр уг бие бүрэлдэхүүн нь зэвсэгт хүчний бүрэлдэхүүний бусад гишүүнээс ялгагдах бөгөөд уг бие бүрэлдэхүүн нь энэхүү протоколын 1 дүгээр хавсралтын 5 дугаар бүлэгт дурдсан түүний эрх зүйн байдлыг нотолсон хувийн үнэмлэхтэй байна;

(d) уг бие бүрэлдэхүүн болон цэргийн анги, нэгтгэл нь дэг журам сахиулах, эсхүл өөрийгөө хамгаалах зорилгоор зөвхөн хөнгөн зэвсгээр зэвсэглэсэн байна. 65 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн заалтуудыг энэ тохиолдолд мөн хэрэглэнэ;

(e) уг бие бүрэлдэхүүн дайтах ажиллагаанд шууд оролцохгүй бөгөөд иргэний хамгаалалтын зорилгоос өөр эсрэг талд хохирол учруулах үйлдэл хийгээгүй, эсхүл ийм үйлдэл хийхэд ашиглагдаагүй байх;

(f) уг бие бүрэлдэхүүн болон цэргийн анги, нэгтгэл иргэний хамгаалалтын зорилтыг зөвхөн өөрийн талын нутаг дэвсгэрийн хүрээнд хэрэгжүүлж байгаа бол.

Энэ зүйлийн “a” болон “b” хэсэгт дурдсан нөхцлийн дагуу үүрэг хүлээсэн зэвсэгт хүчний бүрэлдэхүүний аливаа гишүүн энэ зүйлийн “e” хэсэгт заасан нөхцлийг зөрчихийг хориглоно.

2. Иргэний хамгаалалтын байгууллагад алба хааж байгаа цэргийн албан хаагчид, хэрэв эсрэг талын мэдэлд орвол тэд дайнд олзлогдогчид болно. Тэднийг шаардлагатай үед эзлэгдсэн нутаг дэвсгэрт, тухайн нутгийн энгийн хүн амын эрх ашгийн тусын тулд иргэний хамгаалалтын зорилтуудыг хэрэгжүүлэх зорилгоор ашиглаж болно. Гэхдээ энэ нь аюултай ажил байвал сайн дураараа зөвшөөрсөн үед л тэднийг ашиглана.

3. Иргэний хамгаалалтын байгууллагуудад томилогдсон цэргийн анги, нэгтгэлийн байшин барилга, томоохон хэмжээний тоног төхөөрөмж болон тээврийн хэрэгслийг иргэний хамгаалалтын олон улсын таних тэмдгээр тодорхой

тэмдэглэнэ. Уг таних тэмдэг нь аль болох том байна.

4. Иргэний хамгаалалтын байгууллагуудад байнгын хугацаагаар томилогдсон бөгөөд зөвхөн иргэний хамгаалалтын зорилтыг хэрэгжүүлэх зорилготой цэргийн анги, нэгтгэлийн эд материал, байшин барилга эсрэг талын мэдэлд орвол дайны хуулиар зохицуулагдана. Энгийн хүн амын эрэлт хэрэгцээг хангах холбогдох арга хэмжээний талаар урьдчилан тохиролцоогүй, эсхүл цэргийн зайлшгүй шаардлагатай тохиолдлоос бусад үед иргэний хамгаалалтын зорилтыг хэрэгжүүлэхэд шаардагдах эд материал, байшин барилгыг иргэний хамгаалалтаас бусад зорилгод ашиглаж болохгүй.

## II ХЭСЭГ

### Энгийн хүн амд үзүүлэх тусlamж

68 дугаар зүйл

#### Хэрэглэх хүрээ

Энэхүү хэсгийн заалтуудыг энгийн хүн амын хувьд энэхүү протоколд тодорхойлсон байдлаар хэрэглэх бөгөөд эдгээр заалт нь Дөрөвдүгээр конвенцийн 23, 55, 59, 60, 61 болон 62 дугаар зүйл болон холбогдох заалтын нэмэлт болно.

69 дүгээр зүйл

#### Эзлэгдсэн нутаг дэвсгэр дэх үндсэн эрэлт хэрэгцээ

1. Хүнсний болон эмийн хангамжийн талаархи Дөрөвдүгээр конвенцийн 55 дугаар зүйлд дурдсан үүргээс гадна эзлэгч гүрэн өөртөө байгаа нөөц боломжийг бүрэн ашиглаж, эзлэгдсэн нутаг дэвсгэрийн энгийн хүн амын аж төрөхөд нэн шаардлагатай хувцас, ор дэр, байр оромж болон хүнсний зүйл, шашны зан үйлээ явуулахад шаардагдах зүйлээр ямар нэг ялгаваргүйгээр хангана.

2. Эзлэгдсэн нутаг дэвсгэрийн энгийн хүн амд тусlamж үзүүлэх явдлыг Дөрөвдүгээр конвенцийн 59, 60, 61, 62, 108, 109, 110 болон 111 дүгээр зүйл, түүнчлэн энэхүү протоколын 71 дүгээр зүйлээр зохицуулж, даруй хэрэгжүүлнэ.

70 дугаар зүйл

#### Тусlamж үзүүлэх ажиллагаа

1. Мөргөлдөөнд оролцогч талын хяналтанд байгаа, эзлэгдсэн нутаг дэвсгэрээс бусад аливаа нутаг дэвсгэр дэх энгийн хүн ам 69 дүгээр зүйлд дурдсан зүйлээр дутмаг хангагдаж байгаа тохиолдолд хүмүүнлэгийн тусlamжийг талуудын хооронд байгуулсан хэлэлцээрийн дагуу ямар нэг ялгаваргүйгээр хэрэгжүүлнэ. Дээр дурдсан тусlamжийг үзүүлэх тухай санал дэвшүүлснийг зэвсэгт мөргөлдөөнд хөндлөнгөөс оролцсон, эсхүл найрсаг биш үйлдэл гэж үзэхгүй. Тусlamжийг хуваарилахдаа Дөрөвдүгээр конвенц болон энэхүү протоколын дагуу онцгой хамгаалалтад байх, эсхүл хөнгөлөлт үзүүлбэл зохих хүүхэд, жирэмсэн эмэгтэйчүүд, амаржсан эхчүүд болон хөхүүл хүүхэдтэй эмэгтэйчүүдэд давуу эрх олгоно.

2. Мөргөлдөөнд оролцогч талууд болон хэлэлцэн тохирогч эрхэм дээд тал бүр энэ хэсгийн дагуу нийлүүлж байгаа бүх тусlamжийн бараа, тоног төхөөрөмж болон ажилтныг чөлөөтэй, түргэн нэвтрүүлэх бөгөөд ийм тусlamж нь эсрэг талын энгийн хүн амд зориулагдаж байсан ч тус дөхөм үзүүлнэ.

3. Тусlamжийн журмаар нийлүүлж буй бараа, тоног төхөөрөмж болон ажилтныг энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу нэвтрүүлэхийг зөвшөөрч байгаа мөргөлдөөнд оролцогч талууд болон хэлэлцэн тохирогч эрхэм дээд тал:

(а) ингэж нэвтрүүлэх зөвшөөрөл олгоходоо үзлэг шалгалт хийх зэрэг шаардлагатай арга хэмжээг авах эрх эдэлнэ;

(б) дээрх зөвшөөрлийг олгоходоо уг тусlamжийг газар дээр нь хамгаалагч гүрний хяналтын дор хуваарилах нөхцөл тавьж болно;

(с) энгийн хүн амын эрх ашгийн тусын тулд яаралтай шаардлага гараагүй тохиолдолд тусlamжийн үндсэн зориулалтыг өөрчлөх, тээвэрлэлтийг саатуулж болохгүй.

4. Мөргөлдөөнд оролцогч талууд үзүүлж буй тусlamжийг хамгаалж, тэдгээрийг шуурхай хуваарилахад тус дөхөм үзүүлнэ.

5. Мөргөлдөөнд оролцогч талууд болон хэлэлцэн тохирогч эрхэм дээд холбогдох тал бүр энэ зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан тусlamж үзүүлэх ажиллагааг олон улсын хэмжээнд үр ашигтай зохицуулах явдлыг хөхиүлэн дэмжиж, түүнд тус дөхөм үзүүлнэ.

### *71 дүгээр зүйл*

#### **Тусlamж үзүүлэх ажиллагаанд оролцогч ажилтан**

1. Тусlamж үзүүлэх ажиллагааг явуулах, ялангуяа тусlamжийг тээвэрлэж, хуваарилахад тус дөхөм үзүүлэх зорилгоор шаардлагатай үед ажилтан томилох нь эл ажиллагааны хэсэг бөгөөд тусlamж үзүүлэхэд эдгээр ажилтныг оролцуулахдаа нутаг дэвсгэрт нь үүргээ гүйцэтгэх талаас зөвшөөрөл авна.

2. Эдгээр ажилтанд хүндэтгэл үзүүлж хамгаалалтад байлгана.

3. Тусlamж хүлээн авч буй тал бүр энэ зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан ажилтанд тусlamж үзүүлэх үүргээ хэрэгжүүлэхэд нь бүх талаар, бололцооны хэрээр тусална. Зөвхөн цэргийн зайлшгүй шаардлага гарах тохиолдолд л эдгээр ажилтны үйл ажиллагааг хязгаарлаж, тэдний зорчих хөдөлгөөнийг түр хориглож болно.

4. Тусlamж үзүүлэх ажиллагааг явуулах ажилтан ямар ч нөхцөл байдалд энэхүү протоколоор хүлээсэн өөрийн үүргийн хүрээнээс хэтэрсэн аливаа ажиллагаа явуулж болохгүй. Тухайлбал, нутаг дэвсгэрт нь үүргээ хэрэгжүүлж буй тухайн талын аюулгүй байдлын шаардлагыг анхаарч байх ёстой. Эдгээр нөхцлийг дагаж мөрдөөгүй тохиолдолд аливаа ажилтны үйл ажиллагааг зогсоож болно.

### III ХЭСЭГ

#### Мөргөлдөөнд оролцогч талын мэдэлд байгаа хүмүүстэй харьцах

##### I бүлэг

###### Хэрэглэх хүрээ болон хүмүүс, объектын хамгаалалт

72 дугаар зүйл

###### Хэрэглэх хүрээ

Энэхүү хэсгийн заалтууд нь мөргөлдөөнд оролцогч талын мэдэлд байгаа энгийн иргэд болон иргэний объектыг хүмүүнлэгийн ёсоор хамгаалахтай холбогдсон Дөрөвдүгээр конвенц, тухайлбал түүний I болон III ангид заасан хэм хэмжээ, түүнчлэн олон улсын зэвсэгт мөргөлдөөний үед хүний үндсэн эрхийг хамгаалахтай холбогдсон олон улсын эрх зүйн бусад хэм хэмжээнд нэмэлт болно.

73 дугаар зүйл

###### Дүрвэгсэд, харьяалалгүй этгээд

Холбогдох талуудын хүлээн зөвшөөрсөн олон улсын холбогдох баримт бичгүүд, орогнол олгосон улсын, эсхүл амьдарч буй улсын үндэсний хууль тогтоомжийн дагуу дайтах ажиллагаа эхлэхээс өмнө харьяалалгүй этгээд, эсхүл дүрвэгч гэж тооцогдож байсан хүмүүсийг бүх нөхцөл байдалд аливаа ялгаваргүйгээр Дөрөвдүгээр конвенцийн I болон III ангид зааснаар хамгаалалтад байгаа хүмүүс гэж үзнэ.

74 дүгээр зүйл

###### Сарнисан гэр бүлийг нэгтгэх

Хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд болон мөргөлдөөнд оролцогч талууд зэвсэгт мөргөлдөөний уршгаар сарнисан гэр бүлийг нэгтгэхэд бололцоотой бүх арга хэлбэрээр дэмжлэг үзүүлэх бөгөөд, тухайлбал, энэ зорилтыг хэрэгжүүлж байгаа хүмүүнлэгийн байгууллагуудын үйл ажиллагааг Конвенцууд болон энэхүү протоколын заалтууд, өөрсдийн аюулгүй байдлыг хангахтай холбогдсон журмын дагуу хөхиулэн дэмжинэ.

75 дугаар зүйл

###### Үндсэн баталгаа

1. Энэхүү протоколын 1 дүгээр зүйлд дурдсан нөхцөл байдалд тодорхой хэмжээгээр өртөгдж, мөргөлдөөнд оролцогч талын мэдэлд байгаа бөгөөд Конвенцууд болон энэхүү протоколын дагуу илүү таатай эрх эдэлдэггүй хүмүүстэй бүх нөхцөл байдалд хүнлэгээр харьцаж, арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэсний буюу нийгмийн гарал, эд хөрөнгийн байдал, төрсөн байдал болон эдгээртэй адилтгах бусад байдлаар тэднийг ялгаварлахгүйгээр энэ зүйлд заасан хамгаалалтыг тэдэнд эдлүүлнэ. Тал

бүр эдгээр хүмүүсийг хувь хүний нь хувьд болон тэдний нэр төр, үзэл бодол, шашны зан үйлийг хүндэтгэнэ.

2. Иргэний, эсхүл цэргийн байгууллагын төлөөлөгчийн хэн ч дараахь үйлдлийг хийхийг хэзээ ч, хаана ч хориглоно:

(a) хүмүүсийн амь нас, эрүүл мэнд, бие махбодь болон сэтгэл санаанд хүч хэрэглэх, тухайлбал:

- (i) амийг нь хөнөөх;
- (ii) бие махбодь болон сэтгэл санаанд аливаа төрлийн эрүү шүүлт тулгах;
- (iii) бие махбодийг зовоон тарчлаах ял ногдуулах;
- (iv) хүнд гэмтэл учруулах.

(b) хувь хүний нэр хүндийг доромжлон гутаах, тухайлбал дайрч доромжлох, биеэ үнэлэхийг албадах буюу аливаа хэлбэрээр эвгүй, зүй зохисгүй халдах;

- (c) барьцаанд авах;
- (d) хамтын шийтгэл ногдуулах;
- (e) дээр дурдсан аливаа үйлдлийг хийхээр заналхийлэх.

3. Зэвсэгт мөргөлдөөнтэй холбогдох үйлдлийн төлөө баривчлагдсан, албадан saatuuлагдсан, тусгаарлагдан хоригдсон аливаа хүнд ийм арга хэмжээ авах болсон шалтгааны талаар ойлгогдох хэлээр нь даруй мэдэгдэнэ. Гэмт хэрэг үйлдсэний улмаас баривчлагдсан, эсхүл албадан saatuuлагдаж байгаагаас бусад тохиолдолд баривчлах, албадан saatuuлах, тусгаарлагдан хорих үндэслэл болсон нөхцөл байдал нь арилмагц эдгээр хүмүүсийг ямар ч нөхцөлд богино хугацаанд суллана.

4. Зэвсэгт мөргөлдөөнтэй холбогдох гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай гэж үзэж байгаа хүнд таслан шийдвэрлэх тогтоол гаргаж болохгүй бөгөөд түүнийг зохих ёсоор байгуулагдсан, дор дурдсан шүүн таслах ажиллагааны нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмуудыг мөрдөж байгаа шударга шүүхийн ажиллагаанаас гадуур ямар ч ял ногдуулахгүй:

(a) яллагдагчид тулгаж байгаа гэм буруу, хэргийн нарийн зүйлийн тухай өөрт нь нэн даруй мэдэгдэх, шүүх хурлаас өмнө болон хурлын үед шаардлагатай бүх эрх, өмгөөлүүлэх арга хэрэглүүрийг яллагдагчид олгож байхаар журамд тусгах ёстой;

(b) аливаа хүнийг эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэлгүйгээр шийтгэж болохгүй;

(c) аливаа хүн ямар нэг үйлдэл хийх, эсхүл эс хийх үед хүчин төгөлдөр дагаж мөрдөж байсан үндэсний болон олон улсын эрх зүйн хэм хэмжээгээр дээрх үйлдэл нь эрүүгийн гэмт хэрэгт тооцогддоггүй бол түүнийг гэмт

хэрэгт буруутгаж, яллахыг хориглоно. Түүнчлэн эрүүгийн гэмт хэрэг үйлдэх үед ногдуулж байсан ялаас илүү хатуу ял ногдуулж болохгүй бөгөөд хэрэв тухайн хэргийг үйлдсэнээс хойш илүү хөнгөн ял ногдуулахаар хуульд заасан бол тухайн хөнгөн ялыг ногдуулна;

(d) гэмт хэрэг үйлдсэн гэж яллагдаж байгаа хүний гэм бурууг хуулийн дагуу нотлох хүртэл түүнийг гэм буруугүйд тооцно;

(e) гэмт хэрэг үйлдсэн гэж яллагдаж байгаа хүн бүр шүүх хуралд биечлэн оролцох эрхтэй;

(f) өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхийг албадах, эсхүл гэм буруутай болохоо хүлээн зөвшөөрөхийг аливаа хүнээс тулган шаардахыг хориглоно;

(g) гэмт хэрэг үйлдсэн гэж яллагдаж байгаа хүн бүр түүний эсрэг мэдүүлэг өгч буй гэрчийг байцаах, тэдгээрийг байцаалгахыг шаардах, түүнчлэн өөрийн талын гэрчийг дуудуулж, эсрэг мэдүүлэг өгч байгаа гэрчтэй нэгэн адил нөхцөлд байцаалгах эрх эдэлнэ;

(h) гэмт хэрэг үйлдсэний улмаас урьд нь тухайн талын хууль болон шүүхээр ял шийтгүүлсэн, эсхүл цагаатгагдсан хүнийг дахин мөрдөн байцаах, эсхүл шийтгэх ёсгүй;

(i) гэмт хэрэг үйлдсэний улмаас мөрдөн байцаагдаж байгаа хүн бүр шүүхийн шийдвэрийг олон нийтэд нээлттэй зарлуулах эрхтэй;

(j) шүүхийн таслан шийдвэрлэх тогтоол гаргахдаа шүүгдэгчдэд шүүхийн буюу өөр журмаар даваж заалдах эрхтэй болох, түүнчлэн түүний хугацааны талаар мэдэгдэнэ.

5. Зэвсэгт мөргөлдөөнтэй холбогдох шалтгаанаар эрх чөлөөг нь хязгаарласан эмэгтэйчүүдийг эрэгтэйчүүдээс тусгай байранд байлгана. Тэднийг эмэгтэй харгалзагчийн шууд хараа хяналтанд байлгана. Гэхдээ албадан саатуулагдсан, тусгаарлагдан хоригдсон гэр бүлийг бололцоотой бол нэг газар, тус тусад нь гэр бүлийн байдлаар байршуулна.

6. Зэвсэгт мөргөлдөөнтэй холбогдох шалтгаанаар баривчлагдсан, албадан саатуулагдсан, эсхүл тусгаарлагдан хоригдсон хүмүүсийг зэвсэгт мөргөлдөөний дараа ч гэсэн бүрмөсөн чөлөөллөгдөх, нутагтаа буцах, төвхнөн суурьших хүртэл нь энэ зүйлийн дагуу хамгаална.

7. Хүн төрөлхтний эсрэг, эсхүл дайны гэмт хэрэгт шүүгдсэн этгээдийг мөрдөн байцаах, эсхүл шүүх тухайд аливаа эргэлзээ төрүүлэхгүй байх зорилгоор шүүх нь дараах зарчмуудыг хэрэглэнэ:

(а) ийм гэмт хэрэг үйлдсэн гэж шүүгдэж байгаа хүн, эсхүл ийм гэмт хэргийг олон улсын эрх зүйн холбогдох хэм хэмжээний дагуу мөрдөн байцаалгах, шүүлгэхээр шилжүүлнэ;

(b) Конвенцууд болон энэхүү протоколын дагуу илүү таатай эрх эдэлдэггүй эдгээр хүмүүстэй, үйлдсэн гэмт хэрэг нь Конвенцууд болон энэхүү протоколыг ноцтой зөрчиж байгаа эсэхээс үл хамааран энэ зүйлд заасны дагуу харьцана.

8. Олон улсын эрх зүйн холбогдох аливаа хэм хэмжээний дагуу энэ зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан хүмүүст олгосон хамгаалалтын илүү таатай эрхийг хязгаарласан, эсхүл хөндсөн байдлаар энэ зүйлийн аль ч заалтыг тайлбарлаж болохгүй.

## II бүлэг

### **Эмэгтэйчүүд, хүүхдийг хамгаалах арга хэмжээ**

#### *76 дугаар зүйл*

##### **Эмэгтэйчүүдийн хамгаалалт**

1. Эмэгтэйчүүдэд онцгой хүндэтгэл үзүүлэх бөгөөд тухайлбал хүчиндэх, биеэ үнэлэхийг албадах буюу ямар нэг зүй зохисгүй хэлбэрээр тэдэнд халдахаас хамгаална.

2. Зэвсэгт мөргөлдөөнтэй холбогдох шалтгаанаар баривчлагдсан, албадан saatuuulagdsan, тусгаарлагдан хоригдсон жирэмсэн эмэгтэйчүүд болон өөрсдийн нь шууд халамжинд байгаа бага насын хүүхэдтэй эхчүүдийн хэргийг эн тэргүүнд хянан шийдвэрлэнэ.

3. Мөргөлдөөнд оролцогч талууд зэвсэгт мөргөлдөөнтэй холбогдох гэмт хэрэг үйлдсэн жирэмсэн эмэгтэйчүүд болон өөрсдийн нь шууд халамжинд байгаа бага насын хүүхэдтэй эхчүүдэд цаазаар авах ял ногдуулахаас аль болох зайлсхийнэ. Ийм хэрэг үйлдсэнний улмаас цаазаар авах ял ногдуулсан таслан шийдвэрлэх тогтоолыг эдгээр эмэгтэйчүүдийн хувьд гүйцэтгэхгүй.

#### *77 дугаар зүйл*

##### **Хүүхдийг хамгаалалт**

1. Хүүхдэд онцгой хүндэтгэл үзүүлэх бөгөөд ямар нэг зүй зохисгүй халдлагаас тэднийг хамгаална. Мөргөлдөөнд оролцогч талууд тэдний нас болон бусад ямар нэг байдлыг үндэслэн тэдэнд шаардлагатай байгаа халамж, тусламжийг үзүүлнэ.

2. Мөргөлдөөнд оролцогч талууд 15 нас хүрээгүй хүүхдийг дайтах ажиллагаанд шууд оролцуулахгүй байх, тухайлбал цэрэгт татахгүй байх үүднээс бүхий л арга хэмжээ авна. Мөргөлдөөнд оролцогч талууд 15 нас хүрсэн боловч 18 нас хүрээгүй хүмүүсийг цэрэгт татахдаа аль болох ах настайг нь авахыг эрмэлзэнэ.

3. Хэрэв онцгой тохиолдолд 15 нас хүрээгүй хүүхдүүд энэ зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг зөрчин дайтах ажиллагаанд шууд оролцож, эсрэг талын мэдэлд орсон бол тэднийг дайнд олзлогдогчид мөн эсэхийг үл харгалзан энэхүү зүйлд дурдсан онцгой хамгаалалтанд үргэлжлүүлэн байлгана.

4. 75 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт зааснаар гэр бүлийг тусад нь байлгахаас

бусад тохиолдолд зэвсэгт мөргөлдөөнтэй холбогдох шалтгаанаар баривчлагдсан, албадан саатуулагдсан, тусгаарлагдан хоригдсон хүүхдийг насанд хүрэгчдийн байрнаас тусгаарласан байранд байрлуулна.

5. Зэвсэгт мөргөлдөөнтэй холбогдох гэмт хэрэг үйлдсэний улмаас цаазаар авах ял ногдуулсан таслан шийдвэрлэх тогтоолыг уг хэргийг үйлдэх үедээ 18 нас хүрээгүй байсан хүмүүсийн хувьд гүйцэтгэхгүй.

### 78 дугаар зүйл

#### Хүүхдийг нүүлгэн шилжүүлэх

1. Эзлэгдсэн нутаг дэвсгэрт байгаа хүүхдүүдийн аюулгүй байдлын шаардлага, түүнчлэн тэдний эрүүл мэндийн болон эмчлэх зорилгоор түр хугацаагаар нүүлгэх шаардлага байгаагаас бусад тохиолдолд мөргөлдөөнд оролцогч аль ч тал харьяат бус орны хүүхдүүдийг гадаад улс уруу нүүлгэн шилжүүлэхийг хориглоно. Хүүхдийн эх эцэг, эсхүл хууль ёсны асран хамгаалагч нь олдвол хүүхдийг нүүлгэн шилжүүлэх талаар тэднээс бичгээр зөвшөөрөл авах шаардлагатай. Хэрэв ийм хүмүүс олдохгүй бол хууль буюу зан заншлын дагуу хүүхдийг асран хамгаалах гол хариуцлагыг хүлээж байгаа хүнээс нүүлгэн шилжүүлэх тухай бичгээр зөвшөөрөл авах шаардлагатай. Нүүлгэн шилжүүлэх ажлыг хариуцан гүйцэтгэж байгаа тал, хүүхдүүдийг хүлээн авч байгаа тал, нүүлгэн шилжүүлж буй иргэдийг харьяалах тал зэрэг холбогдох бусад талтай тохиролцсоны үндсэн дээр хамгаалагч гүрний хяналтын дор нүүлгэн шилжүүлэх ажлыг гүйцэтгэнэ. Мөргөлдөөнд оролцогч бүх тал нүүлгэн шилжүүлэх явдалд аюул учираас зайлсхийх бүхий л боломжтой арга хэмжээг авна.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсгийн дагуу нүүлгэн шилжүүлэх явцад түүнд хамрагдаж байгаа хүүхэд бүрт эх эцгийн нь хүсэлтийн дагуу шашны болон ёс суртахууны хүмүүжил олгох, сурч боловсрох бололцоогоор аль болох тасралтгүй хангана.

3. Энэ зүйлийн дагуу нүүлгэн шилжүүлэх хүүхдийг гэр оронд нь болон эх оронд нь буцаахад тус дөхөм үзүүлэхийн тулд нүүлгэн шилжүүлж байгаа талын болон хүлээн авч байгаа орны эрх бүхий байгууллагууд Олон улсын улаан загалмайн хорооны лавлах төв агентлагт явуулах маягтыг хүүхэд тус бүр дээр зохих ёсоор хөтөлж, гэрэл зургийг нь хавсаргана. Маягт тус бүрт хүүхдэд хүндрэл учруулахгүй байхуйц дараах мэдээллийг бололцооны хэрээр тусгана:

(a) хүүхдийн овог;

(b) хүүхдийн нэр;

(c) хүүхдийн хүйс;

(d) төрсөн газар, он, сар, өдөр (төрсөн он тодорхойгүй бол ойролцоо насыг нь бичих);

(e) эцгийн бүтэн овог нэр;

(f) эхийн бүтэн нэр болон нөхөрт гараагүй үеийн овог;

(g) хүүхдийн ойрын төрөл садан;

- (h) хүүхдийн үндэс угсаа;
- (i) хүүхдийн төрөлх хэл, бусад ярьж чаддаг хэл;
- (j) хүүхдийн гэрийн хаяг;
- (k) хүүхдийн хувийн ямар нэг дугаар;
- (l) хүүхдийн эрүүл мэндийн байдал;
- (m) хүүхдийн цусны бүлэг;
- (n) хүүхдийн онцлох шинж тэмдэг;
- (o) хүүхэд олдсон газар, он, сар, өдөр;
- (p) хүүхдийн амьдарч байсан газрын нэр, эх орноосоо явсан он, сар, өдөр;
- (q) хэрэв шүтлэгтэй бол ямар шашин шүтдэг;
- (r) хүлээж авсан улс оронд байх хүүхдийн одоогийн хаяг;
- (s) хүүхэд буцахаасаа өмнө нас барсан бол ямар нөхцөл байдалд, хаана нас нөгчсөн он, сар, өдөр, оршуулсан газар.

### III бүлэг

#### Сэтгүүлчид

79 дүгээр зүйл

#### Сэтгүүлчийг хамгаалах арга хэмжээ

1. Зэвсэгт мөргөлдөөний бүсэд мэргэжлийнхээ дагуу аюултай томилолтоор ажиллаж байгаа сэтгүүлчийг 50 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан энгийн иргэдтэй адилтган үзнэ.
2. Сэтгүүлчийг энгийн иргэдийн эрх зүйн байдалд үл нийцэх ямар нэг үйлдэл хийгээгүй бол, Гуравдугаар конвенцийн 4 дүгээр зүйлийн А хэсгийн 4 дэх заалтад заасан зэвсэгт хүчний дэргэд томилогдсон цэргийн сурвалжлагчдын эрхийг хөндөхгүйгээр Конвенцууд болон энэхүү протоколын дагуу энгийн иргэдийн нэгэн адил хамгаалалтад байлгана.
3. Сэтгүүлчид энэхүү протоколын II хавсралтад заасан загварын дагуу хувийн үнэмлэх авч болно. Сэтгүүлчийг харьялах улс, эсхүл нутаг дэвсгэрт нь байнга оршин амьдардаг, эсхүл түүний ажилладаг мэдээллийн байгууллага нь байрладаг улсын засгийн газраас олгох энэхүү үнэмлэх нь түүнийг эзэмшигч сэтгүүлчийн эрх зүйн байдлыг нотолно.

## V АНГИ

### КОНВЕНЦУУД БОЛОН ЭНЭХҮҮ ПРОТОКОЛЫГ БИЕЛҮҮЛЭХ

#### I ХЭСЭГ

Нийтлэг заалт

80 дугаар зүйл

#### Биелүүлэх арга хэмжээ

1. Хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд болон мөргөлдөөнд оролцогч талууд Конвенцууд болон энэхүү протоколоор хүлээсэн үүргээ биелүүлэх шаардлагатай бүх арга хэмжээг хойшшуулалгүй авна.

2. Хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд болон мөргөлдөөнд оролцогч талууд Конвенцууд болон энэхүү протоколыг дагаж мөрдөхийг хангах зорилгоор тушаал, заавар өгч тэдгээрийн биелэлтэд хяналт тавина.

81 дүгээр зүйл

#### Улаан загалмай болон хүмүүнлэгийн бусад байгууллагын үйл ажиллагаа

1. Мөргөлдөөнд оролцогч талууд дайн, мөргөлдөөнд хэлмэгдэгсийг хамгаалах, тэдэнд тусlamж үзүүлэх явдлыг хангах зорилгоор Конвенцууд болон энэхүү протоколоор Олон улсын улаан загалмайн хороонд хүлээлгэсэн хүмүүнлэгийн үйл ажиллагааг явуулахад боломжтой бүхий л талаар тусlamж үзүүлнэ; Олон улсын улаан загалмайн хороо мөргөлдөөнд оролцогч холбогдох талуудтай тохиролцсоноор хэлмэгдэгсийн тусын тулд бусад аливаа хүмүүнлэгийн үйл ажиллагааг явуулж болно.

2. Мөргөлдөөнд оролцогч талууд Олон улсын улаан загалмайн бага хурлаас тодорхойлсон Улаан загалмайн хөдөлгөөний үндсэн зарчим, Конвенцууд болон энэхүү протоколын заалтын дагуу мөргөлдөөнд хэлмэгдэгсийн тусын тулд өөрсдийн Улаан загалмайн (Улаан хавирган сар, улаан арслан болон нар) холбогдох байгууллагад хүмүүнлэгийн үйл ажиллагаагаа явуулахад нь шаардлагатай тусlamжийг үзүүлнэ.

3. Хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд болон мөргөлдөөнд оролцогч талууд Олон улсын улаан загалмайн бага хурлаас тодорхойлсон Улаан загалмайн хөдөлгөөний үндсэн зарчим, Конвенцууд болон энэхүү протоколын заалтын дагуу Улаан загалмайн (Улаан хавирган сар, улаан арслан болон нар) байгууллага, Улаан загалмай, улаан хавирган сар нийгэмлэгийн холбооноос хэлмэгдэгсдэд тусlamж үзүүлэхэд боломжтой бүх дэмжлэгийг үзүүлнэ.

4. Хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд болон мөргөлдөөнд оролцогч талууд Конвенцууд болон энэхүү протоколын заалтын дагуу энэ зүйлийн 2 болон 3 дахь хэсэгт дурдсантай адил хүмүүнлэгийн үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд Конвенцууд болон энэхүү протоколын хүрээнд мөргөлдөөнд оролцогч холбогдох талуудаас зохих ёсоор бүрэн эрх олгосон бусад байгууллагад тусlamжийг боломжийн хэрээр үзүүлнэ.

82 дугаар зүйл

### Зэвсэгт хүчний хуулийн зөвлөх

Хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд бүхий л үед, мөргөлдөөнд оролцогч талууд зэвсэгт мөргөлдөөний үед Конвенцууд болон энэхүү протоколыг хэрэглэх талаар цэргийн дарга наарт зохих түвшинд зөвлөх, мөн энэ асуудлаар шаардлагатай үед зэвсэгт хүчний бүрэлдэхүүнд зохих заавар өгч байх хуулийн зөвлөхөөр хангана.

83 дугаар зүйл

### Түгээн дэлгэрүүлэх

1. Хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд энхийн цагт болон зэвсэгт мөргөлдөөний үед Конвенцууд болон энэхүү протокол, ялангуяа эдгээр баримт бичгийг зэвсэгт хүчин, энгийн хүн амд таниулан ойлгуулах зорилгоор цэргийн сургалтын хөтөлбөрт оруулах, энгийн хүн амаар судлуулах замаар өөрийн улсад аль болох өргөн түгээн дэлгэрүүлэх үүрэг хүлээнэ.

2. Конвенцууд болон энэхүү протоколыг зэвсэгт мөргөлдөөний үед хэрэглэхээр өөртөө үүрэг хүлээсэн цэргийн буюу иргэний эрх бүхий аливаа байгууллага эдгээр баримт бичигтэй бүрэн танилцсан байна.

84 дүгээр зүйл

### Хэрэглэх журам

Хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд протоколыг дагаж мөрдөх зорилгоор гаргасан хууль тогтоомж болон энэхүү протоколын албан ёсны орчуулгыг эх хадгалагч, эсхүл шаардлагатай үед хамгаалагч гүрнээр дамжуулан богино хугацаанд өөр хоорондоо илгээнэ.

## II ХЭСЭГ

### Конвенцууд болон энэхүү протоколыг зөрчихийг таслан зогсоох

85 дугаар зүйл

### Энэхүү протоколыг зөрчихийг таслан зогсоох

1. Конвенцуудыг зөрчих, ноцтой зөрчих явдлыг таслан зогсоохтой холбогдсон тэдгээрийн заалт нь энэ хэсгийн заалтаар нэмэгдсэн бөгөөд энэхүү протокол зөрчих, ноцтой зөрчихийг таслан зогсооход мөн хэрэглэнэ.

2. Ноцтой зөрчил гэж Конвенцуудад тодорхойлсон эсрэг талын мэдэлд орсон бөгөөд энэхүү протоколын 44, 45, 73 дугаар зүйлээр хамгаалагдаж байгаа хүмүүс, энэхүү протоколоор хамгаалагдаж байгаа эсрэг талд харьялагдах шархдагсад, өвчтөн, хөлөг онгоцны сүйрэлд нэrvэгдэгсэд болон энэхүү протоколоор мөн хамгаалагдаж буй эсрэг талын хяналтад байгаа эмнэлгийн нэгж, тээврийн хэрэгсэл буюу эмнэлгийн болон шашны ажилтны эсрэг үйлдсэн бол түүнийг энэхүү протоколыг ноцтой зөрчсөн гэж үзнэ.

3. 11 дүгээр зүйлд тодорхойлсон ноцтой зөрчлөөс гадна энэхүү протоколын холбогдох заалтыг зөрчихөөр санаатай үйлдсэн бөгөөд хүний амь насыг хөнөөх, бие махбодид нь ноцтой гэмтэл болон эрүүл мэндэд нь хохирол учруулах дараах үйлдлийг энэхүү протоколыг ноцтой зөрчсөн гэж үзнэ:

- (a) энгийн хүн ам буюу иргэнийг довтолгооны объект болгох;
- (b) ийм довтолгоо нь 57 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “а” дэд хэсгийн (iii)-т тодорхойлсноор энгийн хүн амыг олноор хөнөөх, шархдуулах шалтгаан болох буюу иргэний объектод ихээхэн хохирол учруулах нь тодорхой байхад энгийн хүн ам, иргэний объектыг алагчилахгүйгээр довтлох;
- (c) 57 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “а” дэд хэсгийн (iii)-т тодорхойлсноор ийм довтолгоо нь энгийн хүн амыг олноор хөнөөх, шархдуулах шалтгаан болох буюу иргэний объектод ихээхэн хохирол учруулах нь тодорхой байхад, аюултай хүч агуулсан төхөөрөмж буюу байгууламж уруу довтлох;
- (d) хамгаалалтгүй газар нутаг, цэрэггүй бүс рүү довтлох;
- (e) байлдааны ажиллагаанд оролцохоо болж жагсаалаас гарсан хүн рүү довтлох;
- (f) Конвенцууд болон энэхүү протоколоор зөвшөөрсөн Улаан загалмай, улаан хавирган сар буюу Улаан арслан болон нарын таних тэмдэг болон бусад хамгаалах тэмдгийг 37 дугаар зүйлийг зөрчин итгэл эвдэж ашиглах.

4. Өмнөх зүйл болон Конвенцуудад заасан ноцтой зөрчлөөс гадна Конвенцууд болон энэхүү протоколыг санаатайгаар зөрчин үйлдсэн дараах үйлдлийг энэхүү протоколыг ноцтой зөрчсөн гэж үзнэ:

- (a) эзлэгч улс хүн амынхаа зарим хэсгийг эзэлж авсан нутаг дэвсгэртээ шилжүүлэн суулгах, эсхүл эзэлсэн нутаг дэвсгэрийн хүн амьг бүхэлд нь буюу аль нэг хэсгийг Дөрөвдүгээр конвенцийн 49 дүгээр зүйлийг зөрчин энэ нутаг дэвсгэрийн дотор, эсхүл түүний гадна хүчээр авч явах буюу шилжүүлэн суулгах;
- (b) нутаг буцаж байгаа цэргийн олзлогдогч болон энгийн хүн амьг хууль бусаар saatuuлах;
- (c) арьсны өнгөөр алагчилах үндсэн дээр апартейд болон бусад хувь хүний нэр төрийг гутаан доромжлох зэрэг хүнлэг бус үйлдлийг хэрэглэх;
- (d) мөргөлдөөнд оролцогч эсрэг тал 53 дугаар зүйлийн “b” дэд хэсгийг зөрчсөн тухай нотолгоо байхгүй буюу түүхийн дурсгалт зүйл, урлагийн бүтээл болон шашны газар нь цэргийн объекттой нэг дор байрлаагүй байхад ард түмний болон оюун санааны соёлын өв бөгөөд нэр хүнд бүхий олон улсын байгууллагын хүрээнд байгуулсан тусгай хэлэлцээрийн дагуу онцгой хамгаалалтад багтах, тодорхой танигдаж байгаа түүхийн хөшөө, урлагийн бүтээл буюу сүсэг бишрэлийн газарруу довтолж үлэмж хохирол учруулах;
- (e) Конвенцууд болон энэ зүйлийн 2 дахь хэсэгт дурдсан хамгаалалтад байгаа хүний шударга, хэвийн байдлаар шүүн таслах ажиллагааны эрхийг хасах.

5. Конвенцууд болон энэхүү протоколыг хэрэгжүүлэх явдлыг хөндөхгүйгээр тэдгээр баримт бичгийг ноцтой зөрчсөн үйлдлийг цэргийн гэмт хэрэг гэж үзнэ.

*86 дугаар зүйл*

**Арга хэмжээ аваагүй байдал**

1. Хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд болон мөргөлдөөнд оролцогч талууд авах ёстай байсан арга хэмжээг авч чадаагүйн улмаас зарим зөрчлийг зогсоож чадаагүй бол Конвенцууд болон энэхүү протоколын ноцтой зөрчил, бусад бүх зөрчлийг таслан зогсоох талаар шаардлагатай арга хэмжээ авна.

2. Захирагдаж байгаа этгээд Конвенцууд болон энэхүү протоколыг зөрчвөл, уг зөрчлийг үйлдэж байгааг, эсхүл үйлдэх гэж завдаж байгааг мэдэж байсан буюу тийм дүгнэлтэд хүрэх бололцоо олгож буй мэдээллтэй байсан эсэхээс шалтгаалан энэ зөрчлийг сээрэмжлэн зайлзуулах буюу таслан зогсоох талаар өөрийн бүрэн эрхийн хүрээнд боломжтой бүх арга хэмжээг аваагүй удирдах албан тушаалтныг эрүүгийн болон сахилгын хариуцлагаас чөлөөлөхгүй.

*87 дугаар зүйл*  
**Захирагч нарын үүрэг**

1. Хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд болон мөргөлдөөнд оролцогч талууд Конвенцууд болон энэхүү протоколыг тэдний удирдлагын дор байгаа зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн, тэдний хяналтад байгаа бусад хүмүүс зөрчих явдлыг гаргуулахгүй байх, шаардлагатай үед ингэж зөрчих явдлыг таслан зогсоож, энэ тухай эрх бүхий газарт мэдэгдэж байхыг цэргийн захирагч нараас шаардах эрхтэй.

2. Зөрчил гарахаас урьдчилан сэргийлж, таслан зогсоох зорилгоор хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд болон мөргөлдөөнд оролцогч талууд захируч байгаа зэвсэгт хүчнийхээ бие бүрэлдэхүүнд багтдаг хүмүүст Конвенцууд болон энэхүү протоколоор хүлээсэн үүргийг нь сурталчлан таниулах арга хэмжээг эрх мэдлийнхээ хүрээнд авч байхыг захирагч нараас шаардах эрхтэй.

3. Хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд болон мөргөлдөөнд оролцогч талууд захирагч нэг бүрээс захирагаанд нь буюу хяналтад байгаа бусад хүмүүс Конвенцууд болон энэхүү протоколыг зөрчихөөр завдаж байсан буюу зөрчиж байсан эсэх, мөн эдгээр конвенц болон энэхүү протоколыг зөрчихөөс урьдчилан сэргийлэх зорилгоор шаардлагатай үед тухайн зөрчлийг үйлдсэн хүмүүсийн эсрэг сахилгын буюу эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж байсан эсэх талаар лавлана.

*88 дугаар зүйл*  
**Эрүүгийн асуудлаар харилцан туслалцаа үзүүлэх**

1. Хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд Конвенцууд болон энэхүү протоколыг ноцтой зөрчсөнтэй холбогдуулан эрүүгийн мөрдөн байцаалт явуулахад өөр хоорондоо дээд зэргийн дэмжлэг үзүүлнэ.

2. Конвенцууд болон энэхүү протоколын 85 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан эрх, үүргийг хөндөхгүйгээр нөхцөл байдал боломжтой байгаа үед хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд хэрэгтэн шилжүүлэн өгөх талаар хамтран ажиллана. Тэд нутаг

дэвсгэрт нь хэрэг үйлдсэн байж болох тухайн улсын хүсэлтийг зохих ёсоор харгалzan үзнэ.

3. Хүсэлт гаргасан хэлэлцэн тохирогч эрхэм дээд талын хууль тогтоомжийг бүх тохиолдолд хэрэглэнэ. Өмнөх зүйлд дурдсан заалт нь эрүүгийн мөрдөн байцаалтын талаар харилцан туслалцаа үзүүлэх явдлыг бүхэлд нь буюу хэсэгчлэн зохицуулж байгаа буюу зохицуулах хоёр талын, эсхүл олон талын гэрээгээр хүлээсэн үүргийг хөндөхгүй.

*89 дүгээр зүйл*  
**Хамтын ажиллагаа**

Конвенцууд болон энэхүү протоколыг ноцтой зөрчсөн тохиолдолд, хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд хамтдаа буюу дангаараа Нэгдсэн Үндэстний Байгууллагатай хамтран ажиллаж, Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрмийн дагуу арга хэмжээ авах үүрэгтэй.

*90 дүгээр зүйл*  
**Баримт тогтоох олон улсын комисс**

1. (a) Баримт тогтоох олон улсын комисс (цаашид "Комисс" гэх) дээд зэргийн ёс суртахуунтай, шударга болох нь тогтоогдсон арван таван гишүүнтэй байгуулна.

(b) Хэлэлцэн тохирогч хорь (20)-оос цөөнгүй эрхэм дээд талууд Комиссын эрх хэмжээг 2 дахь хэсгийн дагуу хүлээн зөвшөөрч тохиролцсоны дараа энэхүү протоколын эх хадгалагч улс комиссын гишүүдийг сонгох зорилгоор хэлэлцэн тохирогч эрхэм дээд талуудын төлөөлөгчдийн хурлыг 5 жил тутам зарлан хуралдуулна. Хурлаар хэлэлцэн тохирогч эрхэм дээд тал тус бүр нэг хүний нэр дэвшүүлсэн нэrsийн жагсаалтаас нууцаар санал хурааж Комиссын гишүүнийг төлөөлөгчид сонгоно.

(c) Комиссын гишүүд үүргээ өөрийн эрх хэмжээний хувьд гүйцэтгэж дараагийн хурлаас шинэ гишүүдийг сонгох хүртэл ажиллана.

(d) Хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд сонгуулийн үеэр Комисст сонгогдож буй хүн нэг бүр хувийн зан чанарын талаар тэнцэх эсэх болон Комисст газар зүйн байрлалын үүднээс улс бүр тэгш төлөөлөлтэй эсэх талаар хяналт тавина.

(e) Сул орон тоо гарсан үед түүнийг өмнөх дэд хэсгийг үндэслэн Комисс өөрөө сул орон тоог нөхнө.

(f) эх хадгалагч Комиссын үйл ажиллагаагаа явуулахад шаардлагатай захиргааны туслалцаа үзүүлнэ.

2. (a) Хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд энэхүү протоколд гарын үсэг зурах, түүнийг соёрхон батлах буюу нэгдэн орох үед, эсхүл аль ч үед, хэлэлцэн тохирогч эрхэм дээд аливаа бусад талын хувьд адил үүрэг авч буй мөн аль нэг талын гомдлын дагуу мөрдөн байцаалт явуулах, комиссын эрх мэдлийг тусгай хэлэлцээргүйгээр *ipso facto* хүлээн зөвшөөрч байгаагаа мэдэгдэж болно.

(b) Дээрхи заалтад дурдсан мэдэгдлийг протокол хадгалагчид хадгалуулах бөгөөд тэрээр хэлэлцэн тохирогч эрхэм дээд талуудад мэдэгдлийн хуулбарыг хүргүүлнэ.

(c) Комисс дараахь эрх мэдэлтэй байна:

(i) Конвенцууд болон энэхүү протоколд ноцтой зөрчил гэж тодорхойлсон буюу конвенц болон энэхүү протоколыг ноцтой зөрчсөн байж болох аливаа хэргийг мөрдөн байцаах;

(ii) Конвенцууд болон энэхүү протоколыг хүндэтгэх харилцааг сэргээхэд өөрийн сайн санааны тусламжаар дамжуулан хөнгөвчлөх.

(d) Бусад тохиолдолд, Комисс мөргөлдөөнд оролцогч аль нэг талын хүсэлтээр негөө тал буюу холбогдох бусад талтай зөвшилцсөөр мөрдөн шалгах ажлыг гүйцэтгэнэ.

(e) Энэ зүйлийн дээр дурдсан заалтын дагуу Нэгдүгээр конвенцийн 52 дугаар зүйл, Хоёрдугаар конвенцийн 53 дугаар зүйл, Гуравдугаар конвенцийн 132 дугаар зүйл, Дөрөвдүгээр конвенцийн 149 дүгээр зүйлийг Конвенцуудыг зөрчиж болох аливаа тохиолдолд хэрэглэхээс гадна энэхүү протоколыг зөрчсөн аливаа тохиолдолд нэгэн адил хэрэглэнэ.

3. (a) Холбогдох талууд өөрөөр тохиролцоогүй бол дор заасны дагуу томилогдсон 7 хүний бүрэлдэхүүнтэй танхим мөрдөн шалгах бүх ажлыг явуулна:

(i) Мөргөлдөөнд оролцогч аль ч талын харьяат бус иргэн Комиссын таван гишүүнийг мөргөлдөөнд оролцогч талуудтай зөвшилцсөний дараа газар зүйн бүсийг тэгш төлөөлүүлэх үндсэн дээр комиссын ерөнхийлөгчийг томилно;

(ii) *ad hoc* хоёр гишүүнийг мөргөлдөөнд оролцогч аль ч талын харьяат иргэн биш тал бүрээс дэвшиүүлсэн нэг хүнийг томилно.

(b) Мөрдөн шалгах тухай хүсэлтийг хүлээж авсны дараа комиссын ерөнхийлөгч танхимийг байгуулах тохиромжтой хугацааны хязгаарыг тогтооно. Хэрэв тогтоосон хугацаанд *ad hoc* хоёр гишүүн томилдоогүй бол Комиссын ерөнхийлөгч танхимийн бүрэлдүүлэхэд шаардлагатай комиссын нэмэлт буюу үндсэн гишүүдийг даруй томилно.

4. (a) Мөрдөн шалгах ажлыг явуулах 3 дахь хэсгийн дагуу байгуулагдсан танхим мөргөлдөөнд оролцогч талуудад хандаж нотлох баримт гарган, дэмжлэг үзүүлэхийг хүснэ. Танхим чухал гэж үзэж байгаа бусад нотлох баримтыг эрэлхийлж газар дээр нь шалгаж болно.

(b) Бүх нотлох баримтын талаар Комисст өөрийн байр сууриа илэрхийлэх эрх бүхий талуудад бүрэн мэдэгдэнэ.

(c) Аль ч тал ийм нотолгооны талаар маргах эрхтэй.

5. (a) Комисс танхимын үйл байдлын дүгнэлтийн талаархи илтгэлийг шаардлагатай гэж үзвэл зохих зөвлөмжийн хамт талуудад илгээнэ.

(b) Хэрэв танхим шударга дүгнэлт гаргахад болон бодитой нотолгоо олж чадаагүй бол Комисс уг шалтгааны талаар мэдээлнэ.

(с) Мөргөлдөөнд оролцогч бүх тал ингэхийг хүсээгүй бол Комисс өөрийн дүгнэлт нотолгооны талаар нийтэд мэдээлэхгүй.

6. Комисс өөрийн болон танхимиин тэргүүлийн дүрмийг оролцуулан өөрийн хуралдааны дүрмийг батлана. Тэдгээр дүрэм нь Комиссын өрөнхийлөгч ямар ч үед ногдсон үүргээ биелүүлэх, мөрдөн байцаах ажиллагааг мөргөлдөөнд оролцогч талын иргэн бус этгээд гүйцэтгэх бололцоогоор хангасан байна.

7. Комиссын захиргааны зардал нь 2 дахь хэсгийн дагуу мэдэгдэл хийсэн хэлэлцэн тохирогч эрхэм дээд талуудаас оруулж байгаа болон сайн дурын хандиваас бүрдэнэ. Мөрдөн байцаалт явуулах хүсэлт гаргасан мөргөлдөөнд оролцогч тал эсхүл талууд танхимиин шаардлагатай зардлыг урьдчилан төлөх бөгөөд танхимиин шаардлагатай зардлын 50 хувьтай тэнцэх зардлыг гомдол гаргасан тал буюу талууд негөө талдаа эргүүлэн төлнө. Талууд танхимд сөрөг гомдол гаргасан тохиолдолд тал бүр шаардлагатай зардлын 50 хувийг урьдчилан төлнө.

*91 дүгээр зүйл*

### **Хариуцлага**

Конвенцууд болон энэхүү протоколыг зөрчсөн мөргөлдөөнд оролцогч аль нэг тал нөхцөл байдал шаардвал учруулсан хохирлыг нөхөн төлөх ёстой. Өөрийн зэвсэгт хүчний бүрэлдэхүүнд багтдаг хүмүүсээс үйлдсэн аливаа хэргийн хариуцлагыг хүлээнэ.

## **VI АНГИ**

### **ТӨГСГӨЛИЙН ЗААЛТУУД**

*92 дугаар зүйл*

### **Гарын үсэг зурах**

Энэхүү протокол төгсгөлийн баримт бичигт гарын үсэг зурснаас хойш 6 сарын дараа Конвенцуудад оролцогч талууд гарын үсэг зурахад нээлттэй байх бөгөөд дараагийн 12 сарын турш нээлттэй хэвээр байна.

*93 дугаар зүйл*

### **Соёрхон батлах**

Энэхүү протоколыг нэн даруй соёрхон батлана. Протоколыг соёрхон батласан батламж жуух бичгээ конвенцийн эх хадгалагч Швейцарын Холбооны Зөвлөлд хадгалуулахаар хүргүүлнэ.

*94 дүгээр зүйл*

### **Нэгдэж орох**

Энэхүү протоколд гарын үсэг зураагүй Конвенцуудад оролцогч аль ч улсын хувьд нэгдэн ороход нээлттэй байна. Нэгдэн орсон тухай баримт бичгийг конвенцийн эх хадгалагчид хадгалуулахаар хүргүүлнэ.

95 дугаар зүйл

### Хүчин төгөлдөр болох

1. Энэхүү протокол хоёрдахь соёрхон батласан тухай батламж жуух бичиг буюу нэгдэж орсон баримт бичгийг хадгалуулахаар өгснөөс хойш 6 сарын дараа хүчин төгөлдөр болно.

2. Үүнээс хойш энэхүү протоколыг соёрхон баталж, түүнд нэгдэн орж байгаа Конвенцуудад оролцогч улсын хувьд соёрхон батласан тухай батламж жуух бичиг буюу нэгдэн орсон баримт бичгээ хадгалуулахаар өгсөн өдрөөс хойш 6 сарын дараа уг протокол хүчин төгөлдөр болно.

96 дугаар зүйл

### Энэхүү протоколыг хүчин төгөлдөр болсны дараахь гэрээ эрхийн харилцаа

1. Хэрэв Конвенцуудад оролцогч тал энэхүү протоколд мөн оролцогч тал болбол Конвенцуудыг энэхүү протоколоор оруулсан нэмэлтийн хамт хэрэглэнэ.

2. Хэрэв мөргөлдөөнд оролцогч талуудын нэг нь энэхүү протоколын дагуу үүрэг хүлээгээгүй бол протоколд оролцогч тал тэдгээрийн хоорондын харилцаагаар үүрэг хүлээнээ. Түүнчилэн энэхүү протоколын дагуу үүрэг хүлээгээгүй аль ч тал түүний заалтыг хүлээн зөвшөөрч хэрэглэж байгаа бол тэдгээр нь заалтыг мөрдөх үүрэгтэй.

3. 1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт дурдсан зэвсэгт мөргөлдөөнд хэлэлцэн тохирогч эрхэм дээд талуудын аль нэгний эсрэг байлдаж байгаа ард түмнийг төлөөлж байгаа эрх бүхий байгууллага протоколын эх хадгалагчид хандан дангаараа мэдэгдэл хийж уг мөргөлдөөний хувьд Конвенцууд болон энэхүү протоколыг дагаж мөрдөх үүрэг авч болно. Протоколын эх хадгалагчийн хүлээж авсан энэхүү мэдэгдэл уг мөргөлдөөний хувьд дараах үйлчлэлтэй байна:

(а) Конвенцууд болон энэхүү протокол мөргөлдөөнд оролцож байгаа дурдсан эрх бүхий байгууллагын хувьд даруй хүчин төгөлдөр болно;

(б) тухайн эрх бүхий байгууллага Конвенцууд болон энэхүү протоколоор хэлэлцэн тохирогч эрхэм дээд талуудын эдлэх эрх, хүлээх үүргийг нэгэн адил хүлээж авна;

(с) Конвенцууд болон энэхүү протоколыг тус мөргөлдөөнд оролцож байгаа бүх талууд нэгэн адил заавал дагаж мөрдөх үүрэгтэй.

97 дугаар зүйл

### Нэмэлт өөрчлөлт

1. Хэлэлцэн тохирогч эрхэм дээд талуудын аль нь ч энэхүү протоколд нэмэлт өөрчлөлт оруулах тухай санал гаргаж болно. Санал болгосон аливаа нэмэлт өөрчлөлтийн эх бичвэрийг протоколын эх хадгалагчид илгээх бөгөөд эх хадгалагч хэлэлцэн тохирогч эрхэм дээд бүх талууд болон Олон улсын улаан загалмайн

хороотой зөвлөлдсөний үндсэн дээр санал болгосон нэмэлт өөрчлөлтийг хэлэлцүүлэхээр бага хурал хуралдуулах эсэхийг шийдвэрлэнэ.

2. Протоколын эх хадгалагч хэлэлцэн тохирогч эрхэм дээд тал, мөн энэхүү протоколд гарын үсэг зурсан эсэхийг үл харгалзан Конвенцуудад оролцогч бүх талыг энэ бага хуралд урина.

*98 дугаар зүйл*

**Нэгдүгээр хавсралтыг хянан үзэх**

1. Олон улсын улаан загалмайн хороо энэхүү протоколыг хүчин төгөлдөр болсноос хойш 4 жилийн дотор болон дараагийн 4-өөс доошгүй жил тутамд хэлэлцэн тохирогч эрхэм дээд талуудтай энэхүү протоколын нэгдүгээр хавсралтын талаар зөвлөлдөж, хэрэв шаардлагатай гэж үзвэл нэгдүгээр хавсралтыг хянан үзэх, нэмэлт өөрчлөлт оруулах зорилгоор шинжээчдийн зөвлөлдөөнийг хийлгэх санал оруулж болно. Ийм зөвлөлдөөнийг хийлгэх тухай саналыг хэлэлцэн тохирогч эрхэм дээд талуудад мэдэгдсэнээс хойш 6 сарын хугацаанд эдгээр талуудын гуравны нэг нь эсэргүүцээгүй бол Олон улсын улаан загалмайн хороо ийм зөвлөлдөөнийг зарлан хуралдуулж зөвлөлдөөнд олон улсын холбогдох байгууллагаас ажиглагчдыг урина. Ийм зөвлөлдөөнийг хэлэлцэн тохирогч эрхэм дээд талуудын гуравны нэгийн хүсэлтээр Олон улсын улаан загалмайн хороо ямар ч үед зарлан хуралдуулж болно.

2. Хэрэв зөвлөлдөөний дараа Олон улсын улаан загалмайн хороо буюу хэлэлцэн тохирогч эрхэм дээд талуудын гуравны нэг нь хүсвэл шинжээчдийн зөвлөлдөөнөөс санал болгосон нэмэлт өөрчлөлтийг хэлэлцүүлэхээр хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд болон Конвенцуудад оролцогч талуудын бага хурлыг энэхүү протоколын эх хадгалагч зарлан хуралдуулна.

3. Бага хурал дээр санал хураахад оролцсон хэлэлцэн тохирогч эрхэм дээд талуудын гуравны хоёрын саналаар нэгдүгээр хавсралтад оруулах нэмэлт өөрчлөлтийг батална.

4. Протоколын эх хадгалагч батласан аливаа тийм нэмэлт өөрчлөлтийг хэлэлцэн тохирогч эрхэм дээд талуудад болон Конвенцуудад оролцогч талуудад мэдэгдэнэ. Нэмэлт өөрчлөлтийн талаар мэдэгдсэнээс хойш нэг жилийн дотор хэлэлцэн тохирогч эрхэм дээд талуудын гуравны нэгээс цөөнгүй нь уг нэмэлт өөрчлөлтийг хүлээж аваагүй тухай мэдэгдлийг энэхүү протоколын эх хадгалагчид ирүүлээгүй бол нэмэлт өөрчлөлтийг хүлээн авсанд тооцно.

5. Энэ 4 дэх хэсгийн дагуу батлагдсан гэж үзэж байгаа нэмэлт өөрчлөлт, мөн заалтын дагуу түүнийг хүлээж аваагүй тухай мэдэгдэл хийсэн талуудаас бусад хэлэлцэн тохирогч эрхэм дээд талуудын хувьд түүнийг баталснаас хойш гурван сарын дараа хүчин төгөлдөр болно. Тийм мэдэгдэл хийсэн аливаа тал ямар ч үед энэ мэдэгдлээ буцаан авч болох бөгөөд уг нэмэлт өөрчлөлт нь гурван сарын дараа тухайн талын хувьд хүчин төгөлдөр болно.

6. Протоколын эх хадгалагч аливаа нэмэлт өөрчлөлт хүчин төгөлдөр болсон болон нэмэлт өөрчлөлтөд холбогдох талууд, тэдгээрийн хувьд хүчин төгөлдөр болсон хугацаа, нэмэлт өөрчлөлтийг хүлээж аваагүй тухай 4 дэх хэсгийн дагуу хийсэн мэдэгдэл, мэдэгдлийг буцааж авсан талаар хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд Конвенцуудад оролцогч талуудад мэдээлнэ.

**99 дүгээр зүйл  
Цуцлах**

1. Хэрэв хэлэлцэн тохирогч аль нэг эрхэм дээд тал энэхүү протоколыг цуцалвал цуцалсан тухай баримт бичгийг хүлээж авснаас нэг жилийн дараа цуцлалт хүчин төгөлдөр болно. Хэрэв цуцлах тухайгаа мэдэгдсэн тал нэг жилийн хугацаанд 1 дүгээр зүйлд дурдсан нөхцлийн аль нэгэнд орвол, зэвсэгт мөргөлдөөн, эсхүл түрэмгийлэл дусахаас өмнө Конвенцууд болон энэхүү протоколоор хамгаалагдаж байгаа хүмүүсийг бүрэн чөлөөлж нутаг уруу нь буцаах буюу суурьшуулах хүртэл цуцлалт хүчин төгөлдөр болохгүй.

2. Цуцалсан тухай мэдэгдлийг бичгээр энэхүү протоколын эх хадгалагчид илгээх бөгөөд тэрбээр түүнийг хэлэлцэн тохирогч эрхэм дээд бүх талуудад тараана.

3. Цуцлалт нь зөвхөн цуцалсан талын хувьд хүчин төгөлдөр болно.

4. 1 дэх хэсгийн дагуу хийгдсэн аливаа цуцлалт нь хүчин төгөлдөр болохоос өмнө үйлдсэн аливаа үйлдлийн хувьд энэхүү протоколын дагуу зэвсэгт мөргөлдөөнтэй холбогдуулан цуцлах тухай мэдэгдэл хийсэн талын хүлээсэн үүргийг хөндөхгүй.

**100 дугаар зүйл  
Мэдэгдэл**

Эх хадгалагч энэхүү протоколд гарын үсэг зурсан эсэхийг үл харгалзан дараах зүйлийн талаар хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд, түүнчлэн Конвенцуудад оролцогч талуудад мэдээлнэ:

- (a) энэхүү протоколд гарын үсэг зурсан болон 93, 94 дүгээр зүйлийн дагуу соёрхон батласан батламж жуух бичиг, нэгдэж орох тухай баримт бичгийг хадгалулахаар өгсөн;
- (b) 95 дугаар зүйлийн дагуу энэхүү протокол хүчин төгөлдөр болсон огноо;
- (c) 84, 90 болон 97 дугаар зүйлийн дагуу хүлээж авсан мэдээлэл болон мэдэгдэл;
- (d) 96 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн дагуу хүлээж авсан шуурхай мэлээлэх ёстой мэдэгдэл;
- (e) 99 дүгээр зүйлийн дагуу хийсэн цуцлалт.

**101 дүгээр зүйл**

**Бүртгэл**

1. Эх хадгалагч энэхүү протоколыг хүчин төгөлдөр болсны дараа Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрмийн 102 дугаар зүйлийн дагуу бүртгүүлж, нийтлүүлэхээр Нэгдсэн Үндэстний Байгууллагын Нарийн бичгийн дарга нарын газарт хүргүүлнэ.

2. Эх хадгалагч энэхүү протоколтой холбоотой хүлээн авсан бүх соёрхон батласан, нэгдэн орсон болон цуцалсан тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын

Нарийн бичгийн дарга нарын газарт мэдэгдэнэ.

*102 дугаар зүйл*

**Адил хүчинтэй эх бичвэр**

Энэхүү протоколын англи, араб, испани, орос, франц, хятад хэлээрхи адил хүчинтэй эх бичвэрийг эх хадгалагчид хадгалуулах бөгөөд эх хадгалагч нь баталгаат хуулбарыг Конвенцуудын оролцогч бүх талд илгээнэ.

**I ХАВСРАЛТ**

**ТАНЬЖ ТОГТООХТОЙ ХОЛБОГДСОН ЖУРАМ**

**I бүлэг**

**ҮНЭМЛЭХ**

*1 дүгээр зүйл*

**Шашны болон иргэний эмнэлгийн байнгын ажилтны үнэмлэх**

1. Энэхүү протоколын 18 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт дурдсан иргэний эмнэлгийн болон шашны байнгын ажилтны үнэмлэх нь:

(a) халаасанд авч явахаар хэмжээний, ялгах тэмдэгтэй байх;

(b) аль болох бат бөх;

(c) үндэсний, эсхүл албан ёсны хэлээр бичсэн (бусад хэлээр нэмэлт хийсэн байж болно);

(d) нэр, төрсөн огноо (хэрэв төрсөн огноо боломжгүй бол үнэмлэх олгосон үеийн нас) болон хэрэв зэмшигч хувийн дугаартай бол түүнийг бичих;

(e) Конвенцууд болон энэхүү протоколоор олгох ямар хамгаалалтыг эзэмшигч эдлэх эрхтэй болохыг заах;

(f) эзэмшигчийн гэрэл зураг, түүний гарын үсэг буюу эрхий хурууны хээ, эсхүл аль аль нь байх;

(g) эрх бүхий байгууллагын тамга буюу гарын үсэг байх;

(h) үнэмлэхийг олгосон өдөр болон үнэмлэхний хугацаа дуусах өдрийг бичих.

2. Хэлэлцэн тохирогч эрхэм дээд тал бүрийн нутаг дэвсгэрт үнэмлэх нэг янзыг байх бөгөөд мөргөлдөөнд оролцогч талын хувьд аль болохоор ижил байх хэрэгтэй. Мөргөлдөөнд оролцогч талууд 1 дүгээр зурагт дүрсэлсэн нэг хэлээрхи үнэмлэхний загварыг мөрдөж болно. Өөрсдийх нь ашиглаж байгаа үнэмлэх 1 дүгээр зурагт дүрсэлснээс өөр байвал талууд байлдааны ажиллагаа эхлэхэд түүний загварыг нөгөө талдаа илгээнэ. Үнэмлэхийг боломжтой бол 2 хувь үйлдэх бөгөөд нэг хувийг олгосон

үнэмлэхэд хяналт тавих зорилгоор олгосон эрх бүхий байгууллага хадгална.

3. Ямар ч тохиолдолд иргэний эмнэлгийн болон шашны байнгын ажилтныг үнэмлэхээс салгаж болохгүй. Үнэмлэхийг үрэгдүүлбэл тэд үнэмлэхний хувийг авах эрхтэй.

## 2 дугаар зүйл

### Иргэний эмнэлгийн болон шашны түр ажилтны үнэмлэх

1. Иргэний эмнэлгийн болон шашны түр ажилтны үнэмлэх энэхүү журмын 1 дүгээр зүйлд заасан үнэмлэхтэй аль болох адил байх ёстой. Мөргөлдөөнд оролцогч талууд 1 дүгээр зурагт үзүүлсэн үнэмлэхний загварыг дагаж болно.

2. Энэхүү журмын 1 дүгээр зүйлд заасан үнэмлэхийг иргэний эмнэлгийн болон шашны түр ажилтанд олгох бололцоогүй бол эрх бүхий байгууллага түр ажилтны бүрэлдэхүүнд багтаж, үүрэг гүйцэтгэх ёстой хүн болохыг нь нотолж, боломжтой бол томилолтын хугацаа, ялгах тэмдэг зүүх эрхийг заасан гарын үсэгтэй гэрчигээ зэдгээр хүмүүст олгож болно. Гэрчилгээнд эзэмшигчийн нэр, төрсөн огноо (хэрэв өдөр нь боломжгүй бол гэрчилгээ олгох үеийн насыг) хэрэв байгаа бол хувийн дугаар болон түүний гүйцэтгэх үргийг бичнэ. Гэрчилгээнд эзэмшигчийн гарын үсэг буюу эрхий хурууны хээ, эсхүл аль аль нь байх.

### НҮҮРЭН ТАЛ

	(Энэхүү үнэмлэхийг олгосон улс, засгийн газрын нэрийг энд бичнэ)				
Иргэний	эмнэлгийн шашны	байнгын түр	ажилтны		
<b>ҮНЭМЛЭХ</b>					
Нэр .....					
Төрсөн огноо (нас) .....					
Хувийн дугаар (хэрэв байдаг бол) .....					
Энэхүү үнэмлэхийг эзэмшигч нь ..... мөн тул 1949 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн Женевийн конвенцууд, тэдгээрийн Олон улсын зэвсэгт мөргөлдөөнд хэлмэгдэгсдийг хамгаалах тухай нэмэлт протокол (I протокол)-ын дагуу хамгаалагдах эрхтэй.					
Олгосон огноо..... Үнэмлэхийн дугаар .....					
..... хүртэл хүчинтэй		Үнэмлэхийг олгогчийн гарын үсэг			

**АР ТАЛ**

Биеийн өндөр .....	Нүдний өнгө .....	Үсний өнгө .....
-----------------------	----------------------	---------------------

Бусад онцлог шинж  
.....  
.....  
.....

---

**ЭЗЭМШИГЧИЙН ГЭРЭЛ ЗУРАГ**

Тамга хурууны хээ	Эзэмшигчийн гарын үсэг буюу түүний эрхийн
----------------------	--

1 дүгээр зураг. Үнэмлэхийн загвар (хэмжээ 74мм x 105 мм)

**II бүлэг**

**ЯЛГАХ ТЭМДЭГ**

*3 дугаар зүйл*

**Хэлбэр болон онцлог**

1. Ялгах тэмдэг (цагаан дээр улаанаар зурсан) нь аль болох үзэгдэхээр том байна. Загалмай, хавирган сар, арслан болон нарыг дүрслэхдээ хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд 2 дугаар зурагт үзүүлсэн загварыг дагаж болно.
2. Шөнө, эсхүл үзэгдэх орчин хязгаарлагдсан үед ялгах тэмдгийг гэрэлтүүлэх, эсхүл гэрэлтдэг байж болно; Техникийн тусlamжтайгаар таних материалаар ялгах тэмдгийг хийсэн байж болно.



2 дугаар зураг. Цагаан дээр улаанаар дүрслэх ялгах тэмдэг

**4 дүгээр зүйл**

**Хэрэглэх**

1. Ялгах тэмдгийг аль болох хол олон зүгээс үзэгдэхээр хавтгай зүйл буюу далбаан дээр боломжтой үед үзүүлнэ.

2. Дайны талбарт үүргээ гүйцэтгэж байгаа эмнэлгийн болон шашны ажилтан эрх бүхий байгууллагаас өгсөн зааврын дагуу ялгах тэмдэгтэй малгай, хувцсыг бүхий л боломжоороо өмсөнө.

**III бүлэг**

**ЯЛГАХ ДОХИО**

**5 дугаар зүйл**

**Заавал бус хэрэглээ**

1. Энэхүү журмын 6 дугаар зүйлийн заалтыг харгалзан энэ бүлэгт заасан эмнэлгийн алба, тээвэрт хэрэглэх дохиог ямар нэг өөр зорилгоор ашиглаж үл болно. Энэ бүлэгт заасан бүх дохиог заавал хэрэглэхгүй.

2. Цаг хугацааны буюу техникийн боломжгүйгээс ялгах тэмдэг хэрэглээгүй түр хугацааны эмнэлгийн нисдэг тэрэг энэ бүлэгт зөвшөөрсөн ялгах дохиог ашиглаж болно. Гэхдээ эмнэлгийн нисдэг тэргийг ялгах, таниулах сайн арга нь 6 дугаар зүйлд тодорхойлсон ялгах тэмдэг, гэрлэн дохио зэрэг харагдах хэрэгслийг ашиглах, эсхүл энэхүү журмын 7, 8 дугаар зүйлд тодорхойлсон нэмэлт дохиог хослуулан хэрэглэх.

**6 дугаар зүйл**

**Гэрлэн дохио**

1. Хөх өнгөөр анивчих асах гэрлэн дохиог эмнэлгийн нисдэг тэрэгт тэдгээрийг танихад хэрэглэнэ. Өөр ямар ч нисдэг тэрэг энэ дохиог ашиглаж болохгүй. Санал болгосон хөх өнгийн цацрах хэмжигдэхүүнийг хэрэглэнэ.

Ногоон өнгийн зааг

$Y = 0,065 + 0,805$

Цагаан өнгийн зааг

$Y = 0,400 - x$

Ягаан хөх өнгийн зааг

$Y = 0,133 + 0,600 y$

Хөх өнгийн анивчих хэлбэлзэл нь минутад жараас зуун удаа байна.

2. Эмнэлгийн нисэх тэрэгний гэрлэн дохио нь аль болох олон чиглэлээс харагдахуйц гэрэлтүүлэх төхөөрөмжөөр тоноглогдсон байна.

3. Эмнэлгийн тээврийн хэрэгсэл, онгоц, хөлөг онгоцыг таних зорилгоор хөх өнгийн анивчих гэрлийг хэрэглэх тухай мөргөлдөөнд оролцогч талуудын хооронд тусгай хэлэлцээр байхгүй бол ийм дохиог бусад тээврийн хэрэгсэл болон хөлөг онгоцонд хэрэглэхийг хориглохгүй.

**7 дугаар зүйл**

**Радио дохио**

1. Радио дохио нь олон улсын цахилгаан холбооны Дэлхийн радио удирдлагын бага хурлаар батласан болон тогтоосон ялгах тэргүүлэх дохио бүхий радио телефоны буюу радио телеграфын мэдээгээс бүрдэнэ. Үүнийг эмнэлгийн тээврийн хэрэгслийн дудлагын дохионы өмнө 3 удаа дамжуулна. Радио мэдээг энэ зүйлийн 3 дахь хэсэгт тодорхойлсон давтамжийн долгиноор, эсхүл зохих завсарлагатай давтамжтайгаар англи хэлээр дамжуулна. Ялгах тэргүүлэх дохио ашиглахыг зөвхөн эмнэлгийн албад, эмнэлгийн тээврийн хэрэгсэлд зөвшөөрнө.

2. 1 дэх хэсэгт дурдсан ялгах тэргүүлэх дохиотой радио мэдээ нь дараах мэдээг агуулна:

- (a) эмнэлгийн тээврийн хэрэгслийг дуудах дохио;
- (b) эмнэлгийн тээврийн хэрэгслийн байгаа газар;
- (c) эмнэлгийн тээврийн хэрэгслийн тоо болон төрөл;
- (d) төлөвлөж буй чиглэл;
- (e) замын барагцаалсан цаг болон нөхцөл байдлаас шалтгаалж явах, ирэх цаг;
- (f) нислэгийн өндөр, хамгаалагдсан радио долгион, хоёрдогч системийн радио долгионыг таних, томъёолсон тэмдэг зэрэг бусад мэдээлэл.

3. Энэхүү протоколын 22, 23, 25, 26, 27, 28, 29, 30, 31 дүгээр зүйлд дурдсан мэдээлэл болон 1, 2 дахь хэсэгт дурдсан мэдээллийг хөнгөвчлөх зорилгоор хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд, мөргөлдөөнд оролцогч талууд, эсхүл мөргөлдөөнд оролцогч аль нэг тал хэлэлцэн тохиролцож, эсхүл дангаараа Цахилгаан холбооны олон улсын конвенцийн хавсралт болж буй Радио холбооны журмын хэлбэлзэл хуваарилах хүснэгтийн дагуу ийм мэдээллийг ашиглах үндэснийхээ хэлбэлзлийг тогтоож болно. Эдгээр хэлбэлзлийг Дэлхийн радио улирдлагын бага хурлаар батласан журмын дагуу Олон улсын цахилгаан холбоонд мэдэгдэнэ.

**8 дугаар зүйл  
Цахилгаан тоног төхөөрөмжөөр таних**

1. Олон улсын иргэний нисэхийн тухай 1944 оны 12 дугаар сарын 7-ны өдрийн Чикагогийн конвенцийн 10 дугаар хавсралтад тодорхойлсон радио долгиноор таниулах журмыг эмнэлгийн тээврийн хэрэгслийг таних, түүний нислэгт ашиглаж болно. Хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд, мөргөлдөөнд оролцогч талууд, эсхүл мөргөлдөөнд оролцогч аль нэг тал дангаараа эмнэлгийн нисэх хэрэгслийг радио долгиноор таних ажлын дэглэм, томъёолсон тэмдгүүдийг Олон улсын иргэний нисэхийн байгууллагаас зөвлөмж болгосон журмын дагуу тодорхойлно.

2. Мөргөлдөөнд оролцогч талууд өөр хоорондын тусгай хэлэлцээрээр эмнэлгийн тээврийн хэрэгсэл, эмнэлгийн хөлөг онгоц болон агаарын хөлгийг тэдгээрийн ижил цахилгаан системийг хэрэглэхэд байгуулж болно.

## IV бүлэг

### ХОЛБОО

9 дүгээр зүйл

#### Радио холбоо

Эмнэлгийн алба болон тээврийн хэрэгсэл энэхүү протоколын 22, 23, 25, 26, 27, 28, 29, 30, 31 дүгээр зүйлд тодорхойлсон журмыг хэрэглэхдээ энэхүү журмын 7 дугаар зүйлд заасан ялгах тэргүүлэх дохиог радио мэдээллийнхээ өмнө нэвтрүүлж болно.

10 дугаар зүйл

#### Олон улсын томъёолборыг хэрэглэх

Олон улсын цахилгаан холбоо, Олон улсын иргэний нисэхийн байгууллага, Далайн асуудлаархи засгийн газар хоорондын зөвлөлдөх байгууллагаас тогтоосон тэмдэг болон дохиог эмнэлгийн алба болон тээврийн хэрэгсэлд ашиглаж болно. Эдгээр тэмдэг болон дохиог тухайн байгууллагаас тогтоосон стандарт болон журмын дагуу хэрэглэнэ.

11 дүгээр зүйл

#### Холбооны бусад хэрэгсэл

Хэрэв хоёр сувагтай радио холбоо шууд барих боломжгүй үед Далайн асуудлаархи засгийн газар хоорондын зөвлөлдөх байгууллагаас батласан олон улсын дохионы нууц дугаар, эсхүл 1944 оны 12 дугаар сарын 7-ны өдрийн Олон улсын иргэний нисэхийн тухай Чикагогийн конвенцийн хавсралтад оруулсан дохиог хэрэглэж болно.

12 дугаар зүйл

#### Нислэгийн төлөвлөгөө

Энэхүү протоколын 29 дүгээр зүйлд заасан нислэгийн төлөвлөгөөтэй холбогдолтой хэлэлцээр, мэдээллийг аль болох Олон улсын иргэний нисэхийн байгууллагаас тогтоосон журмын дагуу тодорхойлно.

13 дугаар зүйл

#### Эмнэлгийн нисэх онгоцыг замаас нь барих дохио болон журам

Хэрэв нисч яваа эмнэлгийн агаарын хөлгийг энэхүү протоколын 30, 31 дүгээр зүйлийн дагуу таниулах буюу буулгахыг шаардахаа Олон улсын иргэний нисэхийн тухай 1944 оны 12 дугаар сарын 7-ны өдрийн Чикагогийн конвенцийн нэмэлт өөрчлөлт оруулсан 2 дугаар хавсралтад заасан журмыг хэрэглэнэ.

**V бүлэг**


**ИРГЭНИЙ ХАМГААЛАЛТ**

*14 дүгээр зүйл*

**ҮНЭМЛЭХ**

1. Протоколын 66 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан иргэний хамгаалалтын этгээдийн үнэмлэхийг энэхүү журмын 1 дүгээр зүйлийн заалтаар зохицуулна.
2. Иргэний хамгаалалтын этгээдийн үнэмлэхийг 3 дугаар зурагт үзүүлснээр дагаж болно.
3. Хэрэв иргэний хамгаалалтын этгээд хөнгөн зэвсэг авч явахыг зөвшөөрвөл үнэмлэхэнд нь энэ байдлыг картанд тэмдэглэсэн байна.

**НҮҮРЭН ТАЛ**



(Энэхүү үнэмлэхийг олгосон улс,  
засгийн газрын нэрийг энд бичнэ)

Иргэний хамгаалалтын  
байгууллагын этгээдийн

**ҮНЭМЛЭХ**

Овог, нэр.....  
Төрсөн огноо (буюу нас) .....

Хувийн дугаар (хэрэв байгаа бол) .....

Энэхүү үнэмлэхийг эзэмшигч нь .....  
.....мөн тул 1949 оны наймдугаар сарын 12-ны өдрийн  
Женевийн конвенцууд, тэдгээрийн Олон улсын зэвсэгт мөргөлдөөнд хэлмэгдэгсдийг  
хамгаалах тухай нэмэлт протокол (I протокол)-ын дагуу хамгаалагдах эрхтэй.

Олгосон огноо

Үнэмлэхийн дугаар

.....

.....  
үнэмлэхийг олгогчийн  
гарын үсэг .....

.....хүртэл хүчинтэй

**АР ТАЛ**

Биеийн өндөр .....	Нүдний өнгө .....	Үсний өнгө .....
Бусад онцлог шинж: ..... ..... .....		
<b>ЭЗЭМШИГЧИЙН ГЭРЭЛ ЗУРАГ</b>		
Тамга	Эзэмшигчийн гарын үсэг буюу түүний эрхийн хурууны хээ	

3 дугаар зураг. Иргэний хамгаалалтын байгууллагын ажилтны үнэмлэхийн загвар (хэмжээ 74мм x 105мм)

*15 дугаар зүйл*

**Олон улсын ялгах тэмдэг**

1. Энэхүү протоколын 66 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан иргэний хамгаалалтын олон улсын ялгах тэмдэг нь улбар шар өнгийн дэвсгэр дээр адил талтай хөх өнгийн гурвалжин байна. Загварыг 4 дүгээр зурагт үзүүлэв:



4 дүгээр зураг. Улбар шар дэвсгэр дээр хөх гурвалжин

2. Таних тэмдэг дараахь байдалтай байна:

- (а) Хэрэв хөх гурвалжин далбаа, эсхүл гарны тууз, эсхүл нөмрөг дээр байвал далбаа, гарын тууз, эсхүл нөмрөг нь улбар шар өнгөтэй байна;
- (б) гурвалжингийн нэг өнцөг нь босоогоор дээшээ байх;
- (с) гурвалжингийн өнцгийн аль нь ч улбар шар дэвсгэрийн захад хүрэхгүй байх.

3. Олон улсын ялгах тэмдэг нь нөхцөл байдалд тохирсон аль болох том хэмжээтэй байх ёстой. Ялгах тэмдгийг аль болох хол олон зүгээс үзэгдэхээр хавтгай зүйл буюу далбаан дээр боломжтой үед үзүүлнэ. Эрх бүхий газрын зааврын дагуу иргэний хамгаалалтын этгээд боломжтой үед олон улсын ялгах тэмдэгтэй малгай, хувцсыг өмсөнө. Шөнө буюу бүрхэг үед таних тэмдгийг гэрэлтүүлэх юмуу өөрөө гэрэлтдэг байхаар хийж болно. Техник хэрэгслийн тусламжтайгаар тодорч харагддаг материалыар таних тэмдгийг хийсэн байж болно.

## VI бүлэг

### **АЮУЛТАЙ ХҮЧ АГУУЛЖ БАЙГАА ТӨХӨӨРӨМЖ, БАЙГУУЛАМЖ**

*16 дугаар зүйл  
Олон улсын тусгай тэмдэг*

1. Нэг шугам дээр байрласан тод шар өнгийн ижил хэмжээтэй 3 дугуй нь энэхүү протоколын 56 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт заасан аюултай хүч агуулж байгаа төхөөрөмж, байгууламжад зориулсан олон улсын тусгай тэмдэг болдог бөгөөд 5 дугаар зурагт дүрсэлсэн загварын дагуу дугуй тус бүр нь дугуйн радиусын зайд байрлана.

2. Тухайн нөхцөл байдалд тохируулан тэмдгийг аль болох томоор хийнэ. Том талбайд тэмдгийг байрлуулахдаа тухайн нөхцөл байдалд тохируулан олныг байрлуулж болно. Ялгах тэмдгийг аль болох хол олон зүгээс үзэгдэхээр хавтгай зүйл буюу далбаан дээр боломжтой үед үзүүлнэ.

3. Далбаан дээрхи тэмдгийн гадна хүрээ болон далбааны зах хоорондын зайд дугуйн нэг радиусын зйтэй тэнцүү байна. Далбаа тэгш өнцөгт хэлбэртэй, цагаан өнгөтэй байна.

4. Шөнө буюу үзэгдэх орчин хязгаарлагдсан тохиолдолд тэмдгийг гэрэлтүүлэх, эсхүл өөрөө гэрэлтдэг байж болно. Техник хэрэгслийн тусламжтайгаар тодорч харагдах материалыар тусгай тэмдгийг хийж болно.



5 дугаар зураг. Аюултай төхөөрөмж, байгууламжид байрлуулах олон улсын тусгай тэмдэг

# II ХАВСРАЛТ АЮУЛТАЙ НӨХЦӨЛД ТОМИЛОЛТООР АЖИЛЛАЖ ЯВАА СЭТГҮҮЛЧИЙН ҮНЭМЛЭХ

The details and increased responsibilities are dangerous professional interests in spite of their advantages. The reader is invited to pay attention to the following three recommendations to strengthen and even addendum. Please note: The rules must be carried out in accordance with the requirements of the Committee on Uniform Model Rule of the Disciplinary Admissions Committee.

**مقدمة**  
تعمير عبد اللطيف العصيري الكثیر سیارات تهیأ طلاق، في سطور المؤرخ العجمي وهم  
لهمانها من سهل سهل سهل العصر الذي وردوا لاستئصاله عبد المؤمن بن أبي شيبة <sup>رض</sup>، عبد الله بن مالک <sup>رض</sup>  
وأبا عبيدة <sup>رض</sup>، الأسماء الباردة ... وعند كل خطوة حاتم العظام هنا خوب وذا صبر

En el año 2000, el 22,2% de los hogares en el país vivían en la pobreza, lo que equivalía a 10,8 millones de personas. Los hogares más desfavorecidos son los que viven en zonas rurales y tienen una menor formación y menor nivel socioeconómico. La tasa de pobreza es más alta en las provincias de Catamarca (el 32,8%) y en Jujuy (el 31,1%).

AMIS  
La dernière vague d'opinion en date nous montre que les jeunes préfèrent le philo au sport (41% contre 36%). Le pourcentage de ceux qui jouent quelque chose est pratiquement stable (47% contre 46% l'an dernier). Les hommes sont plus nombreux que les femmes à faire du sport (52% contre 41%).

**INTERVIEW WITH**  
HAROLD S. STERK, JR., AND ROBERT L. STERK, JR., OF STERK & STERK, INC., A CONSULTANT IN THE FIELD OF INDUSTRIAL RELATIONS, ON THE PROBLEMS OF MANUFACTURING COMPANIES IN THE UNITED STATES.

(Name of country issuing this card)  
 (نامه اخراج این کارت را کدام کشور دارد)  
 (Nombre del país que expide esta tarjeta)  
 (Nom du pays qui a délivré cette carte)  
 (Кодынанын тапшырылган мекенжайынын негизги аты)

**IDENTITY CARD FOR JOURNALISTS  
ON DANGEROUS PROFESSIONAL MISSIONS**

بطاقة علمية للدراسة بالمحضر

المكتبة بمهمات هنية حظر

**TARJETA DE IDENTIDAD DE PERIODISTA  
EN MISIÓN RELIGIOSA**

**CARTE D'IDENTITÉ DE JOURNALISTE  
EN MISSION PÉRILLEUSE.**

**УДОСТОИВШИХСЯ ЖУРНАЛИСТА,  
НАХОДЯЩЕГОСЯ В ОПАСНОЙ  
КОМАНДЫ РИЧИК**

**94. ОЛОН УЛСЫН БУС ШИНЖ ЧАНАРТАЙ ЗЭВСЭГТ МӨРГӨЛДӨӨНД ХЭЛМЭГДЭГСДИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ 1949 ОНЫ 8 ДУГААР САРЫН 12-НЫ ӨДРИЙН ЖЕНЕВИЙН КОНВЕНЦИҮҮЛЫН НЭМЭЛТ II ПРОТОКОЛ**

1977 оны 6 дугаар сарын 8-ны өдөр баталж,  
1978 оны 12 дугаар сарын 7-ны өдөр хүчин төгөлдөр болсон\*

Улиртгал

Хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд 1949 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн Женевийн конвенцуудын 3 дугаар зүйлд хүмүүнлэгийн дурдсан зарчмууд олон улсын бус шинж чанартай зэвсэгт мөргөлдөөнд хувь хүнийг хүндэтгэх үндсийг бий болгодгийг сануулж.

хүний эрхийн талаархи олон улсын баримт бичиг нь хувь хүний үндсэн хамгаалалт боллгийг санаж.

ийм зэвсэгт мөргөлдөөнд нэрвэгдэгсийг илүү сайтар хамгаалах шаардлагатайг онцлон тэмдэглэж,

\* Монгол Улс 1977.12.12-нд гарын үсэг зурж, 1995.11.17-нд нэгдэн орсон

хүчин төгөлдөр байгаа эрх зүйн хэмжээнд заагаагүй тохиолдолд хувь хүн хүмүүнлэгийн зарчим болон нийгмийн ухамсрын дагуу хамгаалагдах учиртайг санаж,

дараахь зүйлийг хэлэлцэн тохиров:

## I АНГИ

### ЭНЭХҮҮ ПРОТОКОЛЫГ ХЭРЭГЛЭХ ХҮРЭЭ

*1 дүгээр зүйл*

#### Хэрэглэх үндсэн хүрээ

1. 1949 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн Женевийн конвенцуудын 3 дугаар зүйлийн нөхцөл, эсхүл үйлчлэлийг өөрчлөлгүйгээр хөгжүүлж буюу нэмж буй энэхүү протоколыг 1949 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн Женевийн конвенцуудын нэмэлт болох Олон улсын зэвсэгт мөргөлдөөнд хэлмэгдэгсийг хамгаалах тухай нэмэлт протокол (I протокол)-ын 1 дүгээр зүйлд заагаагүй бүх зэвсэг мөргөлдөөнд болон хэлэлцэн тохирогч эрхэм дээд талын нутаг дэвсгэрт түүний зэвсэгт хүчний хооронд, эсхүл энэхүү протоколын дагуу тухайн талын нутаг дэвсгэрийн аль нэг хэсэгт хяналтаа тогтоож, цэргийн тасралтгүй, зохицуулсан үйл ажиллагаа явуулах боломж бүхий зохион байгуулалттай зэвсэгт бүлэглэлийн хооронд болж буй мөргөлдөөний хувьд энэхүү протоколыг хэрэглэнэ.

2. Энэхүү протоколыг дотоодын хэв журмыг зөрчих, дотоодын эмх замбараагүй байдал, хүч хэрэглэсэн үйл ажиллагаа, тусгаарлах болон хүчирхийлэл, иймэрхүү бусад үйлдэл зэрэг зэвсэгт мөргөлдөөнд үл тооцогдох бусад үйлдэлд хэрэглэхгүй.

*2 дугаар зүйл*

#### Тодорхой этгээдийн тухайд хэрэглэх хүрээ

1. Энэхүү протоколыг арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн буюу бусад үзэл бодол, үндэсний буюу нийгмийн гарал, эд хөрөнгийн байдал, төрсөн буюу эдгээртэй адилтгах бусад байдалд (цаашид “тааламжгүй ялгаа” гэх) үндэслэсэн аливаа ялгаа гаргалгүйгээр 1 дүгээр зүйлд дурдсан зэвсэгт мөргөлдөөнд өртсөн бүх хүмүүсийн хувьд хэрэглэнэ.

2. Зэвсэг мөргөлдөөн дуусахад өөрсдийн эрх чөлөөгөө хасуулсан, эсхүл тийм мөргөлдөөнтэй холбоотой шалтгаанаар эрх чөлөөгөө хязгаарлуулсан, тэр дундаа адил шалтгаанаар өөрсдийн эрх чөлөөгөө хасуулсан, эсхүл мөргөлдөөний дараа эрх чөлөөгөө хязгаарлуулсан хүмүүс тийм эрх чөлөөг хассан буюу хязгаарласан хугацааг дуустал 5 болон 6 дугаар зүйлд заасан хамгаалалт эдэлнэ.

*3 дугаар зүйл*

#### Дотоод хэрэгт үл оролзох

1. Энэхүү протокол нь улсын тусгаар тогтнол, хууль ёсны бүхий л аргаар улсынхаа дотор дэг журмыг сэргээн тогтоох, эсхүл үндэсний эв нэгдлийг хамгаалах

болон улсын газар нутгийн бүрэн бүтэн байдлыг хамгаалах засгийн газрын үүргийг хөндсөн гэж тайлбарлахгүй.

2. Энэхүү протоколыг зэвсэгт мөргөлдөөн буюу нутаг дэвсгэрт нь зэвсэгт мөргөлдөөнд болж байгаа хэлэлцэн тохирогч эрхэм дээд талын дотоод болон гадаад хэрэгт ямар нэг шалтгаанаар шууд буюу шууд бусаар оролцохыг зөвтгөсөн гэж тайлбарлаж болохгүй.

## II АНГИ

### ХҮНЛЭГ ХАРЬЦАА

4 дүгээр зүйл

#### Үндсэн баталгаа

1. Дайтах ажиллагаанд шууд оролцоогүй, эсхүл оролцоо болысон этгээд эрх чөлөө нь хязгаарласан эсэхээс үл хамааран өөрийн бие, нэр төр, үзэл бодол болон шашны зан үйлийг хүндэтгүүлэх эрх эдэлнэ. Тэдгээртэй бүх тохиолдолд хүнлэг ёсоор аливаа ялгаварлан гадуурхалгүйгээр харьцана. Хэнийг ч амьд үлдээхгүй байх тушаал өгөхийг хориглоно.

2. Дээр заасан нийтлэг заалтыг зөрчихгүйгээр 1 дэх хэсэгт дурдсан хүмүүсийн эсрэг дараах үйлдлийг хэзээ ч, хаана ч хийхийг хориглох бөгөөд цаашид ч хориглох болно:

- (a) хүмүүсийн амь нас, эрүүл мэнд, бие махбодийн болон сэтгэл зүйн байдалд халдах, ялангуяа амийг нь хөнөөх буюу эрүүдэн шүүх зэрэг хүнлэг бус харьцах, гэмтээх, эсхүл бие махбодийг зовоон тарчлаах аливаа бусад үйлдэл;
- (b) хамтын шийтгэл;
- (c) барьцаанд авах;
- (d) терроризмын үйлдэл;
- (e) хүний нэр төрийг гутаах, ялангуяа басамжлан доромжлох, хүчиндэх, биеэ үнэлэхийг албадах болон бусад аливаа хэлбэрээр зүй бусаар халдах;
- (f) боолчлох, боол худалдах, тэдгээрийн бүх хэлбэр;
- (g) дээрэмдэх;
- (h) дээр дурдсан аливаа үйлдлийг хийлгэхээр сүрдүүлэх.

3. Хүүхдэд шаардагдах халамж болон тусlamж үзүүлнэ. Тухайлбал:

(a) эцэг эхийн хүсэлтийг харгалзан, эсхүл эцэг эхгүй бол тэдний асран хамгаалагчийн хүсэлтийн дагуу хүүхдэд шашны болон ёс суртахууны боловсрол эзэмшүүлнэ;

(b) түр хугацаагаар сарнисан гэр бүлийг нэгтгэхэд тус дөхөм үзүүлэхэд шаардагдах бүх арга хэмжээг авна;

(c) 15 нас хүрээгүй хүүхдийг зэвсэгт хүчин, эсхүл зэвсэглэсэн бүлэгт элсүүлэх, эсхүл дайтах ажиллагаанд оролцуулахыг хориглоно;

(d) 15 нас хүрээгүй хүүхэд энэ зүйлийн “с” дэд хэсэгт заасныг зөрчиж дайтах ажиллагаанд шууд оролцож байгаа, түүнчлэн хэрэв олзлогдсон бол түүнийг энэ зүйлийн дагуу тусгай хамгаалалтаар хангана;

(e) шаардлагатай буюу боломжтой үед эцэг эхийн, эсхүл хуулиар болон зан заншлаар тэдгээрийг нэн тэргүүнд халамжлах үүрэгтэй этгээдийн зөвшөөрснөөр дайтах ажиллагаа явагдаж байгаа газраас тухайн орны нутаг дэвсгэр дэх аюулгүй газарт хүүхдийг түр нүүлгэх бөгөөд тэдний аюулгүй байдал, сайн сайхныг хариуцах хүн дагалдуулах арга хэмжээ авна.

### *5 дугаар зүйл*

#### **Эрх чөлөө нь хязгаарлагдсан этгээд**

1. Зэвсэгт мөргөлдөөнтэй холбогдсон шалтгаанаар эрх чөлөөгөө хасуулсан хүмүүсийн хувьд тэднийг албадан saatuulsan буюу эрх чөлөөг нь хязгаарласнаас үл хамааран 4 дүгээр зүйлийн заалтад нэмэлт болгон дараахъ наад захын заалтыг мөрдөнө:

(a) шархагдагсад, өвчтөнтэй 7 дугаар зүйлийн дагуу харьцана;

(b) энэ хэсэгт дурдсан этгээдийг нутгийн хүн амын нэгэн адил хүнс болон ундны усаар хангаж, эрүүл мэндээ хамгаалах, ариун цэврээ сахих нөхцөлийг бүрдүүлж цаг уурын хатуу ширүүн нөхцөл болон зэвсэгт мөргөлдөөний аюулаас хамгаална;

(c) хувийн болон хамтын тусламж авахыг тэдэнд зөвшөөрнө;

(d) өөрсдөө хүсвэл шашины зан үйлээ явуулах, шашины үүргээ гүйцэтгэж байгаа санваартан зэрэг хүмүүсээс бололцоотой үед сэтгэл санааны дэмжлэг авахыг тэдэнд зөвшөөрнө;

(e) тэднийг хөдөлмөрт татан оролцуулбал нутгийн хүн амын нэгэн адил ажлын нөхцөл, хөдөлмөр хамгааллаар хангана.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан албадан saatuulagsan буюу эрх чөлөө нь хязгаарлагдсан этгээдийг хариуцах хүмүүс өөрсдийн боломжийн хүрээнд тухайн этгээдтэй холбоотой дараахъ заалтыг дагаж мөрдөнө:

(a) нэг гэр бүлийн эрэгтэй, эмэгтэйг хамт байлгахаас бусад тохиолдолд эмэгтэйчүүдийг эрэгтэйчүүдээс тусад нь байрлуулж, эмэгтэй хүний шууд хяналтын дор байлгана;

(b) захидал, ил захидал илгээх, хүлээж авахыг тэдэнд зөвшөөрөх бөгөөд эрх бүхий байгууллага шаардлагатай гэж үзвэл захидал, ил захидалын тоог хязгаарлаж болно;

(с) албадан саатуулагдсан, эрх чөлөө нь хязгаарлагдагсдыг байлдааны бүсэд ойрхон байрлуулахгүй. 1 дэх хэсэгт дурдсан хүмүүсийг албадан саатуулах, эрх чөлөөг нь хязгаарлах байр зэвсэгт мөргөлдөөний уршгаар аюулд учирвал тэднийг шилжүүлэн нүүлгэх бөгөөд энэ ажлыг аюулгүй байдлын зохистой нөхцөлд гүйцэтгэнэ;

(д) тэд эмнэлгийн тусламж авах эрх эдэлнэ;

(е) аливаа зүй бус үйлдэл буюу осол эндэгдэл гаргаснаас болж тэдний бие махбодь буюу сэтгэл зүйн эрүүл мэнд, халдашгүй байдалд хохирол учруулж болохгүй. Түүнчлэн, энэ зүйлд заасан хүмүүст тэдний эрүүл мэндийн байдал шаардаагүй байхад анааах ухааны ойлголтоор эрх чөлөөтэй хүмүүст хэрэглэдэг нийтээр хүлээн зөвшөөрсөн эмнэлгийн хэм хэмжээг хангаж чадахгүй эмнэлгийн тийм аливаа шинжилгээг хийж болохгүй.

3. Энэ зүйлийн заалтад хамарагдахгүй боловч дайтаж байгаатай холбогдсон шалтгаанаар эрх чөлөөг нь хязгаарласан хүмүүстэй 4 дүгээр зүйл болон энэ зүйлийн 1 дэх хэсгийн “а”, “с”, “д”, 2 дахь хэсгийн “б” хэсэгт заасны дагуу хүнлэг ёсоор харьцана.

4. Эрх чөлөө нь хасагдсан хүмүүсийг суллах тухай шийдвэр гаргаж байгаа хүмүүс тэдгээрийн аюулгүй байдлыг хангах талаар шаардагдалатай арга хэмжээ авна.

*6 дугаар зүйл*  
**Эрүүгийн мөрдөн байцаах ажиллагаа**

1. Энэ зүйлийг зэвсэгт мөргөлдөөнтэй холбогдсон эрүүгийн хэргийг мөрдөн байцаах, ял ногдуулах үед хэрэглэнэ.

2. Гэм буруутай болохоо өөрөө хүлээн зөвшөөрсөн хэдий ч бие даасан хараат бус шударга байх баталгааг дор дурдсанаар хангасан шүүхийн таслан шийдвэрлэх тогтоолгүйгээр шүүхийн ямар ч шийдвэр гаргаж болохгүй бөгөөд ямар ч ял ногдуулж болохгүй. Тухайлбал:

(а) тулгаж буй гэмт үйлдлийн тодорхой учрыг яллагдагчид нэн даруй мэдээлэх, шүүх хурлын өмнө буюу үеэр шаардлагатай бүх хамгаалуулах арга болон эрхийг түүнд олгосон байхаар журамдаа тусгана;

(б) эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэлгүйгээр аливаа этгээдийг гэмт хэрэг хийсэн гэж шийтгэж болохгүй;

(с) аливаа үйлдэл, эсхүл эс үйлдлээс эрүүгийн хэрэгт холбогдсон этгээд нь түүнийг үйлдэх үеийн хуулиар уг хэргийг эрүүгийн хэрэгт хамааруулаагүй байсан бол түүнийг эрүүгийн хариуцлагад буруутгаж болохгүй. Түүнчлэн гэмт хэргийг үйлдэх үед тохирч байсан ялаас илүү хатуу ял ногдуулж болохгүй. Хэрэв гэмт хэрэг үйлдсэний дараа хуулиар илүү хөнгөн ял ногдуулахаар тогтоосон бол гэмт этгээдийн хувьд хуулийн тухайн заалтыг хэрэглэнэ;

(д) хуулийн дагуу гэм буруутай болохыг нь нотлох хүртэл гэмт үйлдэлд холбогдсон хэнийг ч гэм буруугүйд тооцно;

(е) гэмт хэрэгт ял ногдуулах гэж буй этгээд шүүх хуралд биечлэн байлцах эрхтэй;

(f) өөрийнхөө эсрэг, эсхүл өөрийгөө гэм буруутайг хүлээн зөвшөөрсөн мэдүүлэг гаргуулахаар хэнийг ч албадан тулгаж болохгүй.

3. Шүүхийн болон бусад журмаар давж заалдах эрхтэй болохыг нь түүнчлэн эн эрхийг эдлэх хугацааны талаар таслан шийдвэрлэх тогтоол гаргах үед шүүгдэгчид мэдэгдэнэ.

4. Гэмт хэрэг үйлдэх үедээ арван найман нас хүрээгүй хүнд цаазаар авах ялыг ногдуулахгүй бөгөөд ийм ялыг жирэмсэн эмэгтэй болон бага насын хүүхэдтэй эхчүүдийн хувьд гүйцэтгэж болохгүй.

5. Дайтах ажиллагаа зогсмогц эрх баригч байгууллага зэвсэгт мөргөлдөөнд оролцсон, эсхүл тэднийг албадан саатуулсан буюу эрх чөлөө нь хязгаарлагдсаныг харгалзахгүйгээр зэвсэгт мөргөлдөөний улмаас эрх чөлөөгөө хасуулсан этгээдэд аль болох өргөн хүрээнд өршөөл үзүүлнэ.

### III АНГИ

#### **ШАРХТАН, ӨВЧТӨН БОЛОН ХӨЛӨГ ОНГОЦНЫ СҮЙРЭЛД ӨТӨГДӨГСӨД**

7 дугаар зүйл

##### **Хамгаалалт болон асрамж**

1. Бүх шархтан, өвчтөн болон хөлөг онгоцны сүйрэлд өртөгдөгсдийг зэвсэгт мөргөлдөөнд оролцсон эсэхээс үл хамааран хүндэтгэж хамгаална.

2. Бүх тохиолдолд тэдэнтэй хүмүүнлэг ёсоор харьцаж, тэдний нөхцөл байдалд шаардлагатай эмнэлгийн тусламж, асрамжийг богино хугацаанд боломжийн хэрээр үзүүлнэ. Эмнэлгээс бусад шалтгаанаар тэднийг аливаа үндсэн дээр ялгаварлан үзэж болохгүй.

8 дугаар зүйл

##### **Эрэн сурвалжлах**

Боломжтой бүх нөхцөлд, ялангуяа тулалдааны дараа шархтан, өвчтөн болон хөлөг онгоцны сүйрэлд өртөгсдийг эрэн сурвалжлах, цугларуулах, тэднийг тонож дээрэмдэх болон зүй бусаар харьцаахаас хамгаалах, шаардагдах тусламж, асрамж үзүүлэх болон амь үрэгдсэн хүмүүсийг эрэн сурвалжлах, тэднийг тонохоос сэргийлэх, зохих ёсоор оршуулах бололцоотой бүх арга хэмжээг даруй авна.

9 дүгээр зүйл

##### **Эмнэлгийн болон шашны ажилтны хамгаалалт**

1. Эмнэлгийн болон шашны ажилтныг үүргээ гүйцэтгэхэд нь тэдэнд бололцоотой бүх туслалцааг үзүүлж хүндэтгэн хамгаална. Тэднээр хүмүүнлэг ажиллагаанд харшилсан үйлдлийг албадан гүйцэтгүүлж болохгүй.

2. Аливаа этгээдэд эмнэлгийн бус шалтгаанаар илүү анхаарал тавихыг үүрэгт ажлаа гүйцэтгэж байгаа эмнэлгийн ажилтнаас шаардаж болохгүй.

*10 дугаар зүйл*

**Эмнэлгийн үүргээ гүйцэтгэж байгаа ажилтны  
нийтлэг хамгаалалт**

1. Хэний ашиг сонирхолын төлөө тухайн үйл ажиллагаагааг гүйцэтгэж байгаагаас үл хамааран эмнэлгийн ёс зүйн дагуу эмнэлгийн чиг үүргээ гүйцэтгэж байгаа хэнийг ч, ямар ч тохиолдолд шийтгэж үл болно.

2. Шархтан болон өвчтний эрх ашигт үйлчлэх эмнэлгийн хэм хэмжээ, эмнэлгийн ёс зүй болон энэхүү протоколын заалтуудад харш үйлдэл хийх буюу ажил гүйцэтгэхийг дээр дурдсан заалт, хэм хэмжээний дагуу эмнэлгийн чиг үүргээ гүйцэтгэж байгаа этгээдэд албадаж болохгүй.

3. Эмнэлгийн чиг үүргээ гүйцэтгэж байгаа этгээдийн асрамжид байгаа шархтан буюу өвчтөнтэй холбоотой олж авч болох мэдээлэлтэй холбогдсон мэргэжлийн үүргийг үндэсний хууль тогтоомжийн дагуу хүндэтгэнэ.

4. Асрамжид нь байгаа буюу байсан шархтан болон өвчтний талаар мэдээлэл өгөхөөс татгалзсан буюу өгөөгүй эмнэлгийн чиг үүргээ гүйцэтгэж байгаа хэнийг ч үндэсний хууль тогтоомжийг үндэслэн шийтгэж болохгүй.

*11 дүгээр зүйл*

**Эмнэлгийн байгууламж болон эмнэлгийн тээврийн  
хэрэгслийг хамгаалах**

1. Эмнэлгийн алба болон эмнэлгийн тээврийн хэрэгслийг ямар ч үед довтолж болохгүй бөгөөд тэдгээрийг хүндэтгэж хамгаална.

2. Эмнэлгийн алба болон эмнэлгийн тээврийн хэрэгсэл хүмүүнлэг ажиллагаанаас хэтэрсэн, дайсагнах үйл ажиллагаа явуулбал түүний хамгаалалтыг зогсоно. Гэхдээ шаардлагатай үед тогтоосон сануулга өгөөд хангалттай хугацаа өнгөрсний дараа уг сануулгыг анхаарч үзээгүй нөхцөлд хамгаалалтыг зогсоно.

*12 дугаар зүйл*

**Ялгах тэмдэг**

Эмнэлгийн буюу шашны ажилтан цагаан дэвсгэр дээр байрлуулсан Улаан загалмай, улаан хавирган сар буюу улаан арслан болон нарны ялгах тэмдгийг эрх бүхий холбогдох байгууллагын хяналтын дор зүүх буюу эмнэлгийн алба, эмнэлгийн тээврийн хэрэгсэлд байрлуулж болно. Бүх нөхцөлд уг тэмдгийг хүндэтгэнэ. Түүнийг зориулалтын бус зорилгоор ашиглахгүй.

## IV АНГИ

### ЭНГИЙН ХҮН АМ

*13 дугаар зүйл*

#### **Энгийн хүн амын хамгаалалт**

1. Энгийн хүн ам болон иргэдийг дайтах ажиллагаатай холбогдож үүсэх аюулын нийтэд нь хамгаална. Ийнхүү хамгаалах зорилгоор дор дурдсан хэм хэмжээг бүх нөхцөл байдалд дагаж мөрдөнө.
2. Энгийн хүн ам, иргэдийн эсрэг довтлохгүй. Энгийн хүн амыг терроризмын зорилгоор хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр айлан сүрдүүлэхийг хориглоно.
3. Дайтах ажиллагаанд шууд оролцоогүй иргэдийг энэ хэсэгт заасны дагуу хамгаална.

*14 дүгээр зүйл*

#### **Энгийн хүн амыг аж төрөхөд нь шаардагдах объектыг хамгаалах**

Энгийн хүн амын өлсгөлөнг дайтах ажиллагаа явуулах арга болгохыг хориглоно. Иймд энэ зорилгоор хүнсний нөөц, хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг хөдөө аж ахуйн бүс, тариалан, мал, ундны усны төхөөрөмж, түүний нөөц, түүнчлэн услалтын байгууламж зэрэг энгийн хүн амд шаардагдах объектыг довтлох, устгах, зөөвөрлөх, эсхүл ажиллагаагүй болгохыг хориглоно.

*15 дугаар зүйл*

#### **Аюултай хүч агуулсан төхөөрөмж болон байгууламжийн хамгаалалт**

Аюултай хүч агуулсан төхөөрөмж, байгууламж, тухайлбал усан далан, хаалт, атомын цахилгаан станцыг довтлоход аюултай хүч алдагдаж, энгийн хүн амд ноцтой хохирол учруулахаар бол эдгээр объект цэргийн байсан ч үл довтолно.

*16 дугаар зүйл*

#### **Соёлын объект болон сүм хийдийг хамгаалах**

Зэвсэгт мөргөлдөөний үед соёлын үнэт зүйлсийг хамгаалах тухай 1954 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн Гаагийн конвенцийн заалтыг хөндөхгүйгээр ард түмний соёлын болон оюуны өв болсон түүхийн хөшөө дурсгал, урлагийн бүтээл, шашны газрын эсрэг аливаа дайсагнасан ажиллагаа явуулах, тэдгээрийг дайтах ажиллагааг дэмжих зорилгод ашиглахыг хориглоно.

17 дугаар зүйл

### Иргэдийг албадан нүүлгэхийг хориглох

1. Иргэдийн аюулгүй байдлыг хангах шаардлага буюу цэргийн зайлшгүй шалтгаан байхгүй бол зэвсэгт мөргөлдөөнтэй холбогдсон шалтгаанаар энгийн хүн амыг нүүлгэж болохгүй. Ийнхүү нүүлгэх шаардлагатай үед энгийн хүн амыг орон байр, эрүүл ахуй, эрүүл мэнд, аюулгүй байдал, хоол хүнсээр хангахуйц нөхцөл бүрдүүлсэн үед л боломжтой бүх арга хэмжээг авна.

2. Мөргөлдөөнтэй холбогдсон шалтгаанаар өөрийн нутаг дэвсгэрийг орхиж явахыг энгийн хүн амд тулган хүлээлгэж болохгүй.

18 дугаар зүйл

### Тусlamжийн нийгэмлэг болон тусlamжийн үйл ажиллагаа

1. Хэлэлцэн тохирогч эрхэм дээд аль нэг талын нутаг дэвсгэр дээр байгаа Улаан загалмайн байгууллага (Улаан хавирган сар, Улаан арслан болон нар) зэрэг тусlamжийн нийгэмлэг зэвсэгт мөргөлдөөнд нэрвэгдсэн хүмүүст туслах уламжлалт үүргээ гүйцэтгэх талаар санал гаргаж болно. Шархтан, өвчтөн болон хөлөг онгоцны сүйрэлд өртөгсдийг энгийн хүн ам санаачилгаараа нэг дор байрлуулан асарч болно.

2. Энгийн хүн ам хоол хүнс болон эмнэлгийн материал зэрэг амьжиргааны зайлшгүй чухал зүйлээр ихээхэн гачигдаж байгаа үед хэлэлцэн тохирогч эрхэм дээд холбогдох талын зөвшөөрсний дагуу тэдэнд тусlamж үзүүлнэ. Гэхдээ үүнийг жинхэнэ хүмүүнлэг бөгөөд энэрэнгүй байх зарчмын дагуу ялгavarлан гадуурхахгүйгээр хэрэгжүүлнэ.

## V АНГИ

### ТӨГСГӨЛИЙН ЗААЛТ

19 дүгээр зүйл

### Түгээн дэлгэрүүлэх

Энэхүү протоколыг аль болох өргөнөөр түгээн дэлгэрүүлнэ.

20 дугаар зүйл

### Гарын үсэг зурах

Энэхүү протокол нь төгсгөлийн баримт бичигт гарын үсэг зурснаас хойш 6 сарын дараа Конвенцуудад оролцогч талууд гарын үсэг зурахад нээлттэй байх бөгөөд дараагийн 12 сарын турш нээлттэй хэвээр байна.

*21 дүгээр зүйл*

### **Соёрхон батлах**

Энэхүү протоколыг нэн даруй соёрхон батлана. Протоколыг соёрхон батласан батламж жуух бичгээ конвенцийн эх хадгалагч Швейцарын Холбооны Зөвлөлд хадгалуулахаар хүргүүлнэ.

*22 дугаар зүйл*

### **Нэгдэж орох**

Энэхүү протоколд гарын үсэг зураагүй Конвенцуудад оролцогч аль ч улсын хувьд нэгдэн ороход нээлттэй байна. Нэгдэн орсон тухай баримт бичгийг конвенцийн эх хадгалагчид хадгалуулахаар хүргүүлнэ.

*23 дугаар зүйл*

### **Хүчин төгөлдөр болох**

1. Энэхүү протокол хоёрдахь соёрхон батласан тухай батламж жуух бичиг буюу нэгдэж орсон баримт бичгийг хадгалуулахаар өгснөөс хойш 6 сарын дараа хүчин төгөлдөр болно.

2. Үүнээс хойш энэхүү протоколыг соёрхон баталж, түүнд нэгдэн орж байгаа Конвенцуудад оролцогч улсын хувьд соёрхон батласан тухай батламж жуух бичиг буюу нэгдэн орсон баримт бичгээ хадгалуулахаар өгсөн өдрөөс хойш 6 сарын дараа уг протокол хүчин төгөлдөр болно.

*24 дүгээр зүйл*

### **Нэмэлт өөрчлөлт**

1. Хэлэлцэн тохирогч эрхэм дээд талуудын аль нь ч энэхүү протоколд нэмэлт өөрчлөлт оруулах тухай санал гаргаж болно. Санал болгосон аливаа нэмэлт өөрчлөлтийн эх бичвэрийг протоколын эх хадгалагчид илгээх бөгөөд эх хадгалагч хэлэлцэн тохирогч эрхэм дээд бүх талууд болон Олон улсын улаан загалмайн хороотой зөвлөлдсөний үндсэн дээр санал болгосон нэмэлт өөрчлөлтийг хэлэлцүүлэхээр бага хурал хуралдуулах эсэхийг шийдвэрлэнэ.

2. Протоколын эх хадгалагч хэлэлцэн тохирогч эрхэм дээд тал, мөн энэхүү протоколд гарын үсэг зурсан эсэхийг үл харгалзан Конвенцуудад оролцогч бүх талыг энэ бага хуралд урина.

*25 дугаар зүйл*

### **Цуцлалт**

1. Хэрэв хэлэлцэн тохирогч аль нэг эрхэм дээд тал энэхүү протоколыг цуцалвал цуцалсан тухай баримт бичгийг хүлээж авснаас нэг жилийн дараа цуцлалт хүчин төгөлдөр болно. Хэрэв цуцлах тухайгаа мэдэгдсэн тал нэг жилийн хугацаанд 1 дүгээр зүйлд дурдсан нөхцлийн аль нэгэнд орвол, зэвсэгт мөргөлдөөн дуустал цуцлалт хүчин төгөлдөр болохгүй. Зэвсэгт мөргөлдөөнтэй холбогдсон шалтгаанаар эрх чөлөөгөө

хасуулсан, эсхүл эрх чөлөөгөө хязгаарлуулсан этгээд бүрэн чөлөөлөгдөх хүртлээ энэхүү протоколын заалтын дагуу хамгаалагдана.

2. Цуцалсан тухай мэдэгдлийг бичгээр энэхүү протоколын эх хадгалагчид илгээх бөгөөд тэрбээр түүнийг хэлэлцэн тохирогч эрхэм дээд бүх талуудад тараана.

*26 дугаар зүйл*

#### **Мэдэгдэл**

Эх хадгалагч энэхүү протоколд гарын үсэг зурсан эсэхийг үл харгалзан дараахь зүйлийн талаар хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд, түүнчлэн Конвенцуудад оролцогч талуудад мэдээлнэ:

- (a) энэхүү протоколд гарын үсэг зурсан тухай болон 21, 22 дугаар зүйлийн дагуу соёрхон батласан батламж жуух бичиг, нэгдэж орсон тухай баримт бичгийг хадгалулахаар өгсөн;
- (b) 23 дугаар зүйлийн дагуу энэхүү протокол хүчин төгөлдөр болсон огноо;
- (c) 24 дүгээр зүйлийн дагуу хүлээж авсан мэдээлэл, мэдэгдлийн тухай.

*27 дугаар зүйл*

#### **Бүртгэл**

1. Эх хадгалагч энэхүү протоколыг хүчин төгөлдөр болсны дараа Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрмийн 102 дугаар зүйлийн дагуу бүртгүүлж, нийтлүүлэхээр Нэгдсэн Үндэстний Байгууллагын Нарийн бичгийн дарга нарын газарт хүргүүлнэ.

2. Эх хадгалагч энэхүү протоколтой холбоотой хүлээн авсан бүх соёрхон батласан, нэгдэн орсон болон цуцалсан тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын Нарийн бичгийн дарга нарын газарт мэдэгдэнэ.

*28 дугаар зүйл*  
**Адил хүчинтэй бичвэр**

Энэхүү протоколын англи, араб, испани, орос, франц, хятад хэлээрхи адил хүчинтэй эх бичвэрийг эх хадгалагчид хадгалуулах бөгөөд эх хадгалагч нь баталгаат хуулбарыг Конвенцуудын оролцогч бүх талд илгээнэ.

## 94. ЗЭВСЭГТ МӨРГӨЛДӨӨНИЙ ҮЕД СОЁЛЫН ҮНЭТ ЗҮЙЛСИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ КОНВЕНЦ

1954 оны 5 дугаар сарын 14-ний өдөр баталжс,  
1956 оны 8 дугаар сарын 7-ны өдөр хүчин төгөлдөр болсон\*

Хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд,

зэвсэгт мөргөлдөөний үед соёлын үнэт зүйлс ноцтойгоор гэмтэж, дайны арга техник хөгжиж байгаагийн улмаас улам бүр устгах аюул нэмэгдэж байгааг хүлээн зөвшөөрч,

дэлхийн соёлд ард түмэн бүр өөрийн хувь нэмрээ оруулснаас үүдэн аливаа ард түмний соёлын үнэт зүйлст хохирол учруулах нь хүн төрөлхтөний соёлын үнэт зүйлст хохирол учруулна гэдэгт итгэл төгс байж,

соёлын өвийг хамгаалах нь дэлхийн бүх ард түмний хувьд чухал ач холбогдолтой бөгөөд эдгээр өвийг олон улсын хамгаалалтад авах нь чухал гэж үзэж,

Гаагийн 1899 болон 1907 оны конвенцууд, Вашингтоны 1935 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн тунхаглалд заасанчлан зэвсэгт мөргөлдөөний үед соёлын үнэт зүйлсийг хамгаалах зарчмуудыг удирдлага болгож,

тайван цагт соёлын үнэт зүйлсийг хамгаалах үндэсний болон олон улсын арга хэмжээ авахгүйгээр тийм хамгаалалт ямар ч үр дүнгүй болохыг анхааралдаа авч,

соёлын үнэт зүйлсийг хамгаалах бүхий л боломжтой арга хэмжээ авахаар шийдвэрлэж,

дараахь зүйлийг хэлэлцэн тохиро:

**I бүлэг**  
**Хамгаалалттай холбогдсон ерөнхий заалтууд**

*I дүгээр зүйл*

### Соёлын үнэт зүйлсийн тухай тодорхойлолт

Энэхүү конвенцийн зорилгод “соёлын үнэт зүйлс” гэж түүний гарал үүсэл буюу өмчлөгчөөс нь үл хамааран дараахь зүйлийг хэлнэ:

(а) ард түмэн бүрийн соёлын өвд чухал ач холбогдол бүхий хөдлөх буюу үл хөдлөх үнэт зүйлс, түүний дотор шашны буюу давтагдашгүй уран барилга, урлагийн буюу түүхийн хөшөө дурсгал, археологийн барилга, түүх буюу урлагийн бүхий л барилга байгууламжийн хэсэг, урлагийн бүтээл, гар бичмэл, түүхийн буюу археологийн ном буюу бусад зүйл, түүнчлэн шинжлэх ухааны бүтээлүүдийн цуглуулга болон дээр дурдсан үнэт зүйлсийг сэргээн засварласан архив буюу номын чухал цуглуулга;

\* Монгол Улс 1964.11.04-нд нэгдэн орсон

(b) “а” дэд хэсэгт дурдсан соёлын хөдлөх үнэт зүйлсийг хадгалах буюу үзэсгэлэнгийн үндсэн гол зориулалт бүхий музей, том номын сан, архивын байр, түүнчлэн зэвсэгт мөргөлдөөний үед “а” дэд хэсэгт заасан соёлын хөдлөх үнэт зүйлсийг хадгалж хамгаалах зориулалт бүхий хоргodoх байр зэрэг байгууламж;

(c) “а” болон “б” дэд хэсэгт заасан соёлын үнэт зүйлсийг нэлээд олон тоотойгоор агуулсан “соёлын үнэт зүйлсийн цогцолбор төв” гэж нэрлэгдэх төвүүд.

**2 дугаар зүйл**

**Соёлын үнэт зүйлсийн хамгаалалт**

Энэхүү конвенцийн зорилгод соёлын үнэт зүйлсийн хамгаалалтад тухайн үнэт зүйлсийн хадгалж хамгаалах, хүндэтгэх асуудал хамаарна.

**3 дугаар зүйл**

**Соёлын үнэт зүйлсийг хадгалж хамгаалах**

Хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд зэвсэгт мөргөлдөөний үед гарч болох үр нөлөөний эсрэг өөрсдийн нутаг дэвсгэрт байрлаж буй соёлын үнэт зүйлсийг хадгалж хамгаалах бэлтгэлийг тайван цагт хангахад өөрсдийн зүгээс шаардлагатай гэж үзэж буй тийм арга хэмжээ авах үүрэг хүлээнэ.

**4 дүгээр зүйл**

**Соёлын үнэт зүйлсийг хүндэтгэх**

1. Хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд зэвсэгт мөргөлдөөний үед өөрсдийн болон хэлэлцэн тохирогч эрхэм дээд талуудын нутаг дэвсгэрт байгаа соёлын үнэт зүйлсийг эвдэрч сүйдэх буюу гэмтээх аюул учруулахаас хамгаалах зорилгоор эдгээр үнэт зүйлс буюу түүний эргэн тойронд байгаа аливаа байгууламжийг ашиглахыг хориглох, эдгээр үнэт зүйлсийн эсрэг чиглэсэн дайсагнах аливаа үйлдлээс татгалзаж соёлын үнэт зүйлсийг хүндэтгэх үүрэг хүлээнэ.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үүргийг зөвхөн цэргийн зайлшгүй шаардлагын улмаас зөрчихийг шаардаж байгаа тохиолдолд л зөрчиж болно.

3. Хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд соёлын үнэт зүйлсийн эсрэг шууд чиглэсэн аливаа үйлдэл, хулгай, дээрэм буюу хууль бусаар эзэмших бусад хэлбэрийг хэрэв шаардлагатай бол зогсоох, урьдчилан сэргийлэх, хориглох үүрэг хүлээнэ. Тэд хэлэлцэн тохирогч эрхэм дээд нөгөө талын нутаг дэвсгэрт байрлаж буй соёлын хөдлөх үнэт зүйлсийг албадан шаардахаас татгалзах үүрэг хүлээнэ.

4. Хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд соёлын үнэт зүйлсийг дайны төлбөр болгоход чиглэсэн аливаа үйлдлээс татгалзах үүрэг хүлээнэ.

5. Хэлэлцэн тохирогч эрхэм дээд аль ч тал 3 дугаар зүйлд заасан хадгалж хамгаалах арга хэмжээг хэлэлцэн тохирогч эрхэм дээд нөгөө тал аваагүй байна гэсэн үндэслэлээр энэ зүйлд заасан үүргээс татгалзаж болохгүй.

**5 дугаар зүйл**

**Эзлэлт**

1. Хэлэлцэн тохирогч эрхэм дээд нөгөө талын нутаг дэвсгэрийг бүхэлд нь буюу хэсэгчлэн эзэлсэн хэлэлцэн тохирогч аливаа эрхэм дээд тал соёлын үнэт зүйлсийг хадгалж хамгаалах болон хадгалах зорилгоор эзлэгдсэн улсын үндэсний эрх бүхий байгууллагыг боломжийн хэрээр дэмжинэ.

2. Хэрэв цэргийн ажиллагааны дүнд эзлэгдсэн нутаг дэвсгэрт байгаа соёлын үнэт зүйлс гэмтэж, эрх бүхий үндэсний байгууллага хадгалахад шаардлагатай арга хэмжээ авч чадахгүйн улмаас соёлын үнэт зүйлсиг хадгалах талаар яаралтай арга хэмжээ авах шаардлага гарвал эзлэгч гүрэн эдгээр үнэт зүйлсийг хадгалж хамгаалах талаар дурдсан байгууллагатай нягт хамтран ажиллах шаардлагатай арга хэмжээг боломжтой бол нэн даруй авна.

3. Эсэргүүцлийн хөдөлгөөний гишүүдээс бүрдсэн засгийн газрыг хууль ёсны гэж үзэж буй хэлэлцэн тохирогч эрхэм дээд аливаа тал хэрэв боломжтой бол, соёлын үнэт зүйлстэй холбоотой конвенцийн заалтуудыг биелүүлэх үүрэгт тэдгээрийн анхаарлыг хандуулна.

**6 дугаар зүйл**

**Соёлын үнэт зүйлсийг онцолж тэмдэглэх**

Соёлын үнэт зүйлсийг танихад хялбар болгох үүднээс 16 дугаар зүйлд заасан ялгах тэмдгээр илэрхийлнэ.

**7 дугаар зүйл**

**Цэргийн арга хэмжээ**

1. Хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд энэхүү конвенцийг дагаж мөрдөх заалтууд бүхий цэргийн журам буюу зааварчилгааг тайван цагт таниулах, өөрийн зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүнд ард түмнүүдийн соёл болон соёлын үнэт зүйлсийг хүндэтгэн үзэх үзэл санааг төлөвшүүлэх үүрэг хүлээнэ.

2. Хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд өөрсдийн зэвсэгт хүчний хүрээнд соёлын үнэт зүйлсийг хүндэтгэх явдлыг хангах зорилготой алба, эсхүл мэргэшсэн албан хаагчдыг тайван цагт томилж, соёлын үнэт зүйлсийг хамгаалах үүрэг бүхий энгийн байгууллагатай хамтран ажиллах үүрэг хүлээнэ.

**II бүлэг**  
**Тусгай хамгаалалт**

**8 дугаар зүйл**

**Тусгай хамгаалалт олгох**

1. Зэвсэгт мөргөлдөөний үед соёлын хөдлөх үнэт зүйлсийг хамгаалах зориулалт бүхий хязгаарлагдмал тооны байр, соёлын бусад ихээхэн чухал ач холбогдолтой үл

хөдлөх үнэт зүйлсийг төвлөрүүлэх төвийг дараахь тохиолдолд тусгай хамгаалалтад авна:

(а) том үйлдвэрийн аливаа төв, эсхүл өртөмтгий төвүүдийг агуулсан цэргийн аливаа гол объект, тухайлбал, нисэх онгоцны буудал, холбоо дамжуулах станц, үндэсний батлан хамгаалахад ажиллаж буй байшин барилга, далайн чухал боомт, эсхүл төмөр замын буудал, харилцаа холбооны гол шугамаас зохих зайд байрлах;

(б) цэргийн зорилгоор ашиглагдаггүй бол.

2. Соёлын хөдлөх үнэт зүйлсийн хоргodoх байрыг хаана байгаагаас үл хамааран тийнхүү баригдсан бол бөмбөгдөлтөд өртүүлж сүйрүүлэхгүй байхаар тусгай хамгаалалтад авна.

3. Соёлын үнэт зүйлсийн цогцолбор төвийг цэргийн бие бүрэлдэхүүн, эсхүл цэргийн материал шилжүүлэх, түүнчлэн дамжуулахад ашигласан бол түүнийг цэргийн зорилгоор ашигласан гэж үзнэ. Уг төвийг цэргийн ажиллагаанд шууд хамаарах үйл ажилалгаа, цэргийн бие бүрэлдэхүүнийг байршуулах, эсхүл уг төвд цэргийн материал үйлдвэрлэвэл түүнийг мөн цэргийн зорилгоор ашигласан гэж үзнэ.

4. Дээрх 1 дэх хэсэгт дурдсан соёлын үнэт зүйлсийг тийнхүү хамгаалахаар томилогдсон цэргийн харуулаар, эсхүл соёлын тухайн үнэт зүйлсийн ойролцоо байгаа нийтийн хэв журам сахиулах ердийн үүрэгтэй цагдаагийн хүчинээр хамгаалуулж байвал соёлын үнэт зүйлсийг цэргийн зорилгоор ашиглаж байна гэж үзэхгүй.

5. Хэрэв энэ зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан соёлын үнэт аливаа зүйлс нь дээрх хэсэгт тодорхойлсон цэргийн чухал объектын ойролцоо байрлаж байгаа бөгөөд хэрэв хэлэлцэн тохирогч эрхэм дээд тал зэвсэгт мөргөлдөөний үед уг объектыг аль ч тохиолдолд ашиглахгүй байх, ялангуяа уг обеъкт нь далайн боомт, төмөр зам, эсхүл нисэх онгоцны буудал бол тэнд үүсэх хөдөлгөөнийг saatuuлах үүрэг хүлээж хамгаалалтад авахыг хүсвэл уг үнэт зүйлсийг тусгай хамгаалалтад авна. Ийм нөхцөлд хөдөлгөөн saatuuлах талаар авах арга хэмжээг тайван цагт бэлтгэсэн байна.

6. Тусгай хамгаалалтад байх соёлын үнэт зүйлсийн олон улсын бүртгэлд орсон соёлын үнэт зүйлст л тусгай хамгаалалтыг олгоно. Энэхүү конвенцийн заалт болон конвенцийг хэрэгжүүлэх журамд заасан нөхцлийн дагуу бүртгэлийг хийнэ.

#### 9 дүгээр зүйл

#### Тусгай хамгаалалтын дагуух соёлын үнэт зүйлсийн дархан эрх

Хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд 8 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасан нөхцлөөс бусад тохиолдолд Олон улсын бүртгэлд орсон цагаас эхлэн тусгай хамгаалалтад байх үнэт зүйлсийн эсрэг чиглэсэн дайсагнах аливаа үйлдэл болон түүний ойролцоо зүйлийг цэргийн зорилгоор ашиглахаас татгалзаж, соёлын үнэт зүйлсийг дархан эрхээр хангах үүрэг хүлээнэ.

*10 дугаар зүйл*

### **Тодорхойлох, хяналт тавих**

Зэвсэгт мөргөлдөөний үед тусгай хамгаалалтад байгаа соёлын үнэт зүйлсийг 16 дугаар зүйлд заасан бэлгэ тэмдгээр ялгаж, энэхүү конвенцийг хэрэгжүүлэх журамд заасан олон улсын хяналт явуулахад нээлттэй байлгана.

*11 дүгээр зүйл*

### **Дархан эрхийг түдгэлзүүлэх**

1. Хэрэв хэлэлцэн тохирогч эрхэм дээд аль нэг тал тусгай хамгаалалтад байгаа соёлын үнэт зүйлсийн хувьд 9 дүгээр зүйлд заасан үүргийг зөрчсөн тохиолдолд эсрэг тал нь уг зөрчлийг арилтал тухайн үнэт зүйлсийн халдашгүй байдлыг хангах үүргээс чөлөөлөгднө. Гэхдээ боломжтой үед сүүлчийн тал зохих хугацаанд дурдсан зөрчлийг арилгуулахыг эхэлж шаардана.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас бусад тохиолдолд цэргийн зайлшгүй шаардлага байгаа болон үргэлжлэх нөхцөлд л тусгай хамгаалалтад байгаа соёлын үнэт зүйлсийн дархан эрхийг түдгэлзүүлж болно. Тийм шаардлагыг зэвсэгт хүчний дивиз, эсхүл түүнтэй тоогоор буюу хэмжээгээр адил, эсхүл илүү байх хэсгийг удирдаж буй офицер тодорхойлно. Аль ч тохиолдолд нөхцөл байдал шаардаж байвал эсрэг тал нь дархан эрхийг түдгэлзүүлэх тухайгаа боломжтой хугацаанд урьдчилан мэдэгдэнэ.

3. Дархан эрхийг түдгэлзүүлж буй тал конвенцийг хэрэгжүүлэх журамд заасан соёлын үнэт зүйлсийн асуудал эрхэлсэн Ерөнхий комиссарт энэ тухайгаа аль болох богино хугацаанд шалтгааныг зааж, бичгээр мэдэгдэнэ.

### **III бүлэг**

#### **Соёлын үнэт зүйлсийг тээвэрлэх**

*12 дугаар зүйл*

### **Тусгай хамгаалалтын дор тээвэрлэх**

1. Хэлэлцэн тохирогч холбогдох эрхэм дээд талын хүсэлтээр зөвхөн соёлын үнэт зүйлсийг тухайн нутаг дэвсгэр дотор, эсхүл өөр талын нутаг дэвсгэрт гүйцэтгэх тээвэрлэлтийг конвенцийг хэрэгжүүлэх журамд заасан нөхцлийн дагуу тусгай хамгаалалтын дор хийнэ.

2. Конвенцийг хэрэгжүүлэх журамд заасан нөхцлийн дагуу тусгай хамгаалалт бүхий олон улсын хяналтын дор гүйцэтгэх тээвэрлэлтийг 16 дугаар зүйлд заасан бэлгэ тэмдгээр илэрхийлнэ.

3. Хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд тусгай хамгаалалттай тээвэрлэлтийн эсрэг чиглэсэн дайсагнах аливаа үйлдлээс татгалзана.

13 дугаар зүйл

### Яаралтай тохиолдолд тээвэрлэх

1. Хэрэв хэлэлцэн тохирогч эрхэм дээд тал соёлын зарим үнэт зүйлсийн аюулгүй байдлыг хангах үүднээс түүнийг тээвэрлэх, ийнхүү хийх тээвэрлэлтийг яаралтай гүйцэтгэх, 12 дугаар зүйлд заасан журмыг ялангуяа зэвсэгт мөргөлдөөний эхэн үед мөрдөх боломжгүй гэж үзвэл тухайн тээвэрлэлтийг 16 дугаар зүйлд тодорхойлсон бэлгэ тэмдгээр илэрхийлж болох бөгөөд 12 дугаар зүйлд заасан дархан эрхийг олгох тухай хүсэлт өмнө нь гаргаагүй буюу татгалзсан гэж үзнэ. Хэрэв боломжтой бол тээвэрлэлтий тухай эсрэг талдаа мэдэгдэнэ. Дархан эрх тусгайлан олгогдоогүй бол соёлын үнэт зүйлсийг өөр улсын нутаг дэвсгэрт тээвэрлэх аль ч тохиолдолд бэлгэ тэмдэг ашиглахгүй.

2. Хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан бэлгэ тэмдэг бүхий тээвэрлэлтийн эсрэг чиглэсэн дайсагнах үйлдлийг таслан зогсооход шаардлагатай урьдчилан сэргийлэх арга хэмжээг нэн даруй авна.

14 дүгээр зүйл

### Албадан хураах, шагналын журмаар хураах, олзлохын эсрэг дархан эрх

1. Дор дурдсан зүйлд албадан хураах, шагналын журмаар хураах, олзлохын эсрэг дархан эрхийг олгоно:

- (a) 12 буюу 13 дугаар зүйлд заасан хамгаалалтад байх соёлын үнэт зүйлс;
  - (b) эдгээр үнэт зүйлсийг тээвэрлэхэд зөвхөн хамаарах тээврийн хэрэгслүүд.
2. Энэ зүйлийн аль ч заалт үзлэг болон хяналт хийх эрхийг хязгаарлахгүй.

### IV бүлэг

#### Ажилтан

15 дугаар зүйл

#### Ажилтан

Аюулгүй байдлын шаардлага боломж олговол соёлын үнэт зүйлсийг хамгаалах ажилтанд тухайн үнэт зүйлсийн хадгалалт хамгаалалтын ашиг сонирхлын үүднээс хүндэтгэлтэй хандах бөгөөд хэрэв тухайн ажилтан эсрэг талд олзлогдвол тухайн талд мөн олзлогдсон соёлын үнэт зүйлсийг хадгалж хамгаалах чиг үүргээ үргэлжлүүлэн хэрэгжүүлэх боломжийг түүнд мөн олгоно.

**V бүлэг  
Бэлгэ тэмдэг**

*16 дугаар зүйл*

**Конвенцийн бэлгэ тэмдэг**

1. Конвенцийн бэлгэ тэмдэг нь цэнхэр, цагаан өнгөөр дөрөв хуваасан доошоо шовх бамбай хэлбэртэй (бамбай нь дараахь зүйлэс бүрдэнэ: нэг өнцөг нь бамбайн шовх хэсэг рүү харсан цэнхэр өнгийн кавадрат, уг кавдратын дээр цэнхэр өнгийн гурвалжин байх бөгөөд уг квадрат, гурвалжин нь хоёр хажуугаараа цагаан өнгийн гурвалжингаар хүрээлэгдсэн байна) байна.

2. Бэлгэ тэмдгийг дангаар нь, эсхүл 17 дугаар зүйлд заасан нөхцлийн дагуу гурвалжин хэлбэртэйгээр гурваар нь хэрэглэнэ.



*17 дугаар зүйл*

**Бэлгэ тэмдгийг хэрэглэх**

1. Гурван удаа давтсан бэлгэ тэмдгийг зөвхөн дараахь тохиолдолд хэрэглэнэ:

(a) тусгай хамгаалалтад байгаа соёлын хөдлөх үнэт зүйлс;

(b) 12 болон 13 дугаар зүйлд заасан нөхцлийн дагуу соёлын үнэт зүйлсийг тээвэрлэх;

(c) конвенцийг хэрэгжүүлэх журамд заасан нөхцлийн дагуух түр хугацаагаар хоргодох байшин барилга.

2. Дангаар нь хэрэглэх бэлгэ тэмдгийг дараахь тохиолдолд хэрэглэнэ:

(a) тусгайлан хамгаалаагүй соёлын үнэт зүйлс;

(b) конвенцийн хэрэгжүүлэх журмын дагуу хяналтын үүрэг гүйцэтгэх хүмүүс;

(c) соёлын үнэт зүйлсийг хамгаалах үүрэгтэй ажилтан;

(d) конвенцийг хэрэгжүүлэх журамд заасан биеийн байцаалт.

3. Зэвсэгт мөргөлдөөний үед энэ зүйлийн өмнөх хэсэгт зааснаас бусад бүх тохиолдолд бэлгэ тэмдгийг хэрэглэх, эсхүл конвенцийн бэлгэ тэмдэгтэй аливаа байдлаар төстэй тэмдгийг ямар ч зорилгоор ашиглахыг хориглоно.

4. Хэлэлцэн тохирогч эрхэм дээд талын эрх бүхий байгууллагаас гарын үсэг зурж, өдөрлөсөн холбогдох зөвшөөрөлгүйгээр соёлын хөдлөх аливаа үнэт зүйлст бэлгэ тэмдгийг байрлуулахгүй.

## VI бүлэг

### Конвенцийг хэрэглэх хүрээ

18 дугаар зүйл

### Конвенцийг хэрэглэх

1. Тайван цагт хүчин төгөлдөр байх заалтуудаас бусад тохиолдолд энэхүү конвенцийг хэлэлцэн тохирогч эрхэм дээд хоёр буюу түүнээс дээш талуудын хооронд зарласан дайн, эсхүл тэдгээрийн хооронд үүсэж болох зэвсэгт мөргөлдөөнд, уг дайн нэг буюу хэд хэдэн улсын хувьд хүлээн зөвшөөрөгдөөгүй байсан ч хэрэглэнэ.

2. Хэлэлцэн тохирогч эрхэм дээд талын нутаг дэвсгэрийг хэсэгчлэн, эсхүл бүхэлд эзэлсэн бүх тохиолдолд, түүнчлэн дурдсан эзлэлт нь цэргийн ямар ч эсэргүүцэлтэй тулгараагүй байсан ч энэхүү конвенцийг мөн адил хэрэглэнэ.

3. Хэрэв мөргөлдөөнд оролцож буй улсуудын нэг нь энэхүү конвенцийн оролцогч тал биш байсан ч энэхүү конвенцийн оролцогч тал болох улсуудын хувьд өөр хоорондын харилцаандаа түүний заалтуудыг хэвээр мөрдөнө. Үүнээс гадна дурдсан улс энэхүү конвенцийг батлах талаар мэдэгдэл хийж, түүний заалтуудыг биелүүлж байвал бусад улс тухайн улстай цаашид харилцаах харилцаандаа энэхүү конвенцийг хэрэглэнэ.

19 дүгээр зүйл

### Олон улсын бус шинж чанартай зэвсэгт мөргөлдөөн

1. Хэлэлцэн тохирогч эрхэм дээд талуудын аль нэгний нутаг дэвсгэрт гарч буй олон улсын шинж чанартай бус зэвсэгт мөргөлдөөний үед мөргөлдөөнд оролцогч тал бүр соёлын үнэт зүйлсийг хүндэтгэхэд хамаарах энэхүү конвенцийн хамгийн наад захын хэмжээг хэрэглэх үүрэг хүлээнэ.

2. Мөргөлдөөнд оролцогч талууд энэхүү конвенцийн заалтуудыг бүхэлд буюу хэсэгчлэн хэрэгжүүлэх талаар тусгай хэлэлцээр байгуулахад бүхий л хүчин чармайлтаа дайчлана.

3. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага мөргөлдөөнд оролцогч талуудад өөрийн үйлчилгээг санал болгож болно.

4. Дээр дурдсан заалтуудыг хэрэглэх нь мөргөлдөөнд оролцогч талуудын хууль эрх зүйн байдлыг хөндөхгүй.

## VII бүлэг

### Конвенцийг хэрэгжүүлэх

*20 дугаар зүйл*

### Конвенцийг хэрэгжүүлэх журам

Энэхүү конвенцийг түүнийг бүрэлдэхүүн хэсэг болох конвенцийг хэрэгжүүлэх журамд заасны дагуу хэрэгжүүлнэ.

*21 дүгээр зүйл*

### Хамгаалагч гүрэн

Энэхүү конвенц болон түүнийг хэрэгжүүлэх журмыг мөргөлдөөнд оролцогч талуудын ашиг сонирхолыг хамгаалах үүрэг бүхий хамгаалагч гүрнүүдийн оролцоотойгоор хэрэгжүүлнэ.

*22 дугаар зүйл*

### Эвлэруүлэх журам

1. Соёлын үнэт зүйлст хамгаалах ашиг сонирхолд нийцнэ гэж үзэж болох бүхий тохиолдол тухайлбал, энэхүү конвенц буюу түүнийг хэрэгжүүлэх журмын заалтуудыг хэрэглэх буюу тайлбарлахад мөргөлдөөнд оролцогч талуудын хооронд саналын зөрүү гарсан тохиолдолд хамгаалагч гүрэн сайн санааны үүднээс үйлчилгээ үзүүлнэ.

2. Эл зорилгоор хамгаалагч гүрэн бүр аль нэг тал, эсхүл Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын урилгаар, эсхүл өөрийн санаачлагаар хэрэв шаардлагатай гэж үзвэл төвийг сахисан улсын нутаг дэвсгэрийг сонгон соёлын үнэт зүйлсийг хамгаалах үүрэгтэй байгууллагууд, тэдгээрийн төлөөлөгчид оролцох зөвлөлдөөн хийхийг мөргөлдөөнд оролцогч талуудад санал болгож болно. Мөргөлдөөнд оролцогч талууд зөвлөлдөөн хийх саналыг хэрэгжүүлэх үүрэгтэй. Хамгаалагч гүрэн уг зөвлөлдөөнд даргалагчийн хувьд оролцох этгээдийг төвийг сахисан улсын харьят нь байх, эсхүл Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын Ерөнхий захирлаас санал болгосон хүнээр батлуулах саналыг мөргөлдөөнд оролцогч талуудад тавина.

*23 дугаар зүйл*

### Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын туслалцаа

1. Хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд соёлын үнэт зүйлсийг хамгаалах ажлын зохион байгуулах, энэхүү конвенц, түүнийг хэрэгжүүлэх журмыг хэрэглэхэд үүсэх аливаа бусад асуудлыг шийдвэрлэхэд техникийн туслалцаа үзүүлэхийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагаас хүсч болно. Уг байгууллага нь өөрийн хөтөлбөр болон боломжийн хүрээнд эл туслалцааг үзүүлнэ.

2. Уг байгууллага нь өөрийн санаачлагаар хэлэлцэн тохирогч эрхэм дээд талуудад энэ асуудлаар санал гаргах эрхтэй.

*24 дүгээр зүйл*

**Тусгай хэлэлцээр**

1. Хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд тусад нь заалт гаргах шаардлагатай гэж үзэх бүхий л асуудлаар тусгай хэлэлцээр байгуулж болно.

2. Соёлын үнэт зүйлс болон түүнийг хамгаалах үүрэг бүхий ажилтанд энэхүү конвенцийн дагуу олгосон хамгаалалтыг бууруулах ямар ч тусгай хэлэлцээрийг байгуулж болохгүй.

*25 дугаар зүйл*

**Конвенцийг түгээн дэлгэрүүлэх**

Хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд тайван цагт болон зэвсэгт мөргөлдөөний үед энэхүү конвенц, түүнийг хэрэгжүүлэх журмын эх бичвэрийг өөрсдийн холбогдох улсад аль болох өргөн хүрээнд түгээн дэлгэрүүлэх үүрэг хүлээнэ. Тухайлбал тэд өөрсдийн цэргийн хөтөлбөр, хэрэв боломжтой бол иргэний сургалтын хөтөлбөрт үүнийг оруулж, нийт хүн ам ялангуяа, соёлын үнэт зүйлсийг хамгаалах үүрэг бүхий зэвсэгт хүчин болон ажилтанд энэхүү конвенц, түүнийг хэрэгжүүлэх журмын зарчмуудыг таниулах үүрэг хүлээнэ.

*26 дугаар зүйл*

**Орчуулга, илтгэл**

1. Хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд энэхүү конвенц, түүнийг хэрэгжүүлэх журмын албан ёсны орчуулгыг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын Ерөнхий захирлаар дамжуулан өөр хоорондоо хүргүүлнэ.

2. Тиймээс хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд энэхүү конвенц, түүнийг хэрэгжүүлэх журмыг биелүүлэхэд өөрсдийн холбогдох байгууллагаас авсан, бэлтгэсэн буюу төлөвлөсөн аливаа арга хэмжээтэй холбоотой өөрсдийн шаардлагатай гэж үзсэн мэдээллийн талаарх илтгэлийг дөрвөн жилд нэг удаа Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын Ерөнхий захиралд хүргүүлнэ.

*27 дугаар зүйл*

**Зөвлөлдөөн**

1. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын Ерөнхий захирал Гүйцэтгэх зөвлөлөөс зөвлөсний дагуу хэлэлцэн тохирогч эрхэм дээд талуудын төлөөлөгчдийн зөвлөлдөөнийг зарлан хуралдуулна. Тэрбээр уг зөвлөлдөөнийг хэлэлцэн тохирогч эрхэм дээд талуудын тавны нэг хүсэлт гаргасан тохиолдолд зарлан хуралдуулах ёстой.

2. Энэхүү конвенц, түүнийг хэрэгжүүлэх журамд заасан аливаа үүргийг хөндөхгүйгээр, зөвлөлдөөний зорилго нь конвенц, түүнийг хэрэгжүүлэх журмыг хэрэглэх болон түүнд холбогдох зөвлөмжийг бэлтгэх асуудлыг судлахад оршино.

3. Хэрэв хэлэлцэн тохирогч эрхэм дээд талуудын олонхи нь зөвлөдөөнд хүрэлцэн ирсэн бол зөвлөдөөний явцад 39 дүгээр зүйлийн дагуу конвенц, түүнийг хэрэгжүүлэх журамд өөрчлөлт оруулж болно.

*28 дугаар зүйл*

### **Шийтгэл**

Хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд энэхүү конвенцийг зөрчсөн болон зөрчихийг тушаасан аливаа этгээдийг харьялалаас нь үл хамаарч эрүүгийн, эсхүл захиргааны шийтгэлийг ногдуулахад шаардлагатай бүхий л арга хэмжээг өөрсдийн эрүүгийн хууль тогтоомжийн хүрээнд авна.

### **Төгсгөлийн заалтууд**

*29 дүгээр зүйл*

### **Хэл**

1. Энэхүү конвенцийг англи, франц, орос, испани хэлээр үйлдсэн бөгөөд дөрвөн эх бичвэрүүд адил хүчинтэй байна.

2. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага нь түүний Ерөнхий бага хурлын албан ёсны бусад хэлнээ конвенцийг орчуулах ажлыг зохион байгуулна.

*30 дугаар зүйл*

### **Гарын үсэг зурах**

Энэхүү конвенцийг 1954 оны 5 дугаар сарын 14-өөр өдөрлөж, Гаага хотноо 1954 оны 4 дүгээр сарын 21-ээс 5 дугаар сарын 14-ны өдөр хүртэл хуралдсан Бага хуралд уригдсан бүх улсуудын хувьд 1954 оны 12 дугаар сарын 31-ны өдөр хүртэл гарын үсэг зурахад нээлттэй байна.

*31 дүгээр зүйл*  
**Соёрхон батлах**

1. Энэхүү конвенцийг гарын үсэг зурсан улсууд өөрсдийн үндэсний хууль тогтоомжийн дагуу соёрхон батална.

2. Соёрхон батласан батламж жуух бичгийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын Ерөнхий захиралд хадгалуулна.

*32 дугаар зүйл*  
**Нэгдэн орох**

Энэхүү конвенц нь хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 30 дугаар зүйлд заасны дагуу гарын үсэг зураагүй бүх улсын хувьд, түүнчлэн Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын Гүйцэтгэх зөвлөлөөс нэгдэн орохыг урьсан аливаа улсын хувьд нэгдэн ороход нээлттэй байна. Нэгдсэн

Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын Ерөнхий захиралд нэгдэн орсон тухай баримт бичгийг хадгалуулснаар тухайн улсыг нэгдэн орсонд тооцно.

*33 дугаар зүйл*  
**Хүчин төгөлдөр болох**

1. Энэхүү конвенц нь түүнийг соёрхон батласан тухай таван батламж жуух бичгийг хадгалуулснаас хойш гурван сарын дараа хүчин төгөлдөр болно.

2. Түүнээс хойш хэлэлцэн тохирогч эрхэм дээд тал бүрийн хувьд соёрхон батласан батламж жуух бичиг, эсхүл нэгдэн орсон тухай баримт бичгийг хадгалуулснаас хойш гурван сарын дараа энэхүү конвенц хүчин төгөлдөр болно.

3. 18 болон 19 дүгээр зүйлд заасан нөхцлийн хувьд мөргөлдөөнд оролцогч талууд дайтах ажиллагаа буюу эзлэгдэхээсээ өмнө, эсхүл хойно соёрхон батласан батламж жуух, эсхүл нэгдэн орсон баримт бичгээ хадгалуулсан бол энэхүү конвенц нэн даруй хүчин төгөлдөр болно. Тийм тохиолдолд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын Ерөнхий захирал аль болох богино хугацаанд 38 дугаар зүйлд заасан мэдээллийг хийнэ.

*34 дүгээр зүйл*  
**Үйлчилгээг эхлүүлэх**

1. Энэхүү конвенцийн оролцогч тал болсон улс бүр түүнийг хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш зургаан сарын дотор Конвенцийн үйлчилгээг эхлүүлэхэд шаардагдах бүхий л арга хэмжээг авна.

2. Энэхүү конвенцийг хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш соёрхон батласан батламж жуух, эсхүл нэгдэн орсон тухай баримт бичгийг хадгалуулсан бүх улсын хувьд тухайн хугацаа нь соёрхон батласан батламж жуух, эсхүл нэгдэн орсон тухай баримт бичгийг хадгалуулснаас хойших мөн зургаан сар байна.

*35 дугаар зүйл*

**Конвенцийн үйлчлэх нутаг дэвсгэрийн хүрээ**

Хэлэлцэн тохирогч эрхэм дээд аль ч тал олон улсын харилцаанд үүрэг хүлээх нутаг дэвсгэрийн бүхэлд нь, эсхүл аливаа хэсэгт энэхүү конвенц үйлчилнэ гэсэн мэдэгдлийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын Ерөнхий захиралд хандан соёрхон батлах буюу нэгдэн орохдоо, эсхүл хэдийд ч хийж болно. Дурдсан мэдэгдэл нь түүнийг хүлээн авсан өдрөөс хойш гурван сарын дараа хүчин төгөлдөр болно.

*36 дугаар зүйл*

**Өмнөх конвенцуудтай холбогдох нь**

1. Хуурай газраар дайтах хууль, зан заншил (IV), 1899 7 дугаар сарын 29 буюу 1907 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн Дайны үед тэнгисийн цэргийн бөмбөгдөлтэй (IX) холбоотой Гаагийн конвенцуудын дагуу үүрэг хүлээсэн болон энэхүү конвенцийн оролцогч болсон гүрнүүдийн хоорондын харилцаанд энэхүү конвенц нь дээр дурдсан

(IX) конвенц болон (IV) конвенцийн хавсралт болох журамд нэмэлт болох бөгөөд энэхүү конвенц, түүнийг хэрэгжүүлэх журамд бэлгэ тэмдгийг хэрэглэхээр заасан тохиолдол бүрт (IX) конвенцийн 5 дугаар зүйлд заасан бэлгэ тэмдгийг энэхүү конвенцийн 16 дугаар зүйлд заасан бэлгэ тэмдэг орлоно.

2. Шинжлэх ухааны болон урлагийн байгууллага, түүхийн дурсгалт хөшөөг хамгаалах тухай 1951 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн Вашингтоны пакт (Рерихийн пакт)-ын дагуу үүрэг хүлээсэн болон энэхүү конвенцийн оролцогч болсон гүрнүүдийн хоорондын харилцаанд энэхүү конвенц нь Рерихийн пактын нэмэлт болох бөгөөд энэхүү конвенц, түүнийг хэрэгжүүлэх журамд бэлгэ тэмдгийг хэрэглэхээр заасан тохиолдол бүрт Пактын 3 дугаар зүйлд заасан ялгах далбааг энэхүү конвенцийн 16 дугаар зүйлд заасан бэлгэ тэмдэг орлоно.

*37 дугаар зүйл*

**Цуцлах**

1. Хэлэлцэн тохирогч эрхэм дээд тал бүр өөрийн нэрийн өмнөөс, эсхүл олон улсын харилцаанд үүрэг хүлээх аливаа нутаг дэвсгэрийн нэрийн өмнөөс энэхүү конвенцийг цуцалж болно.

2. Цуцлах тухай баримт бичгийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын Ерөнхий захиралд бичгээр мэдэгдэнэ.

3. Цуцлах тухай баримт бичгийг хүлээн авснаас хойш нэг жилийн дараа энэхүү цуцлалт нь хүчин төгөлдөр болно. Хэрэв энэ хугацаа дуусахад цуцалсан улс зэвсэгт мөргөлдөөний оролцогч тал байвал, уг цуцлалт нь дайтах ажиллагаа дуусах хүртэл, эсхүл соёлын үнэт зүйлсийг эх оронд буцаах ажиллагаа дуусах хүртэл үйлчлэхгүй.

*38 дугаар зүйл*

**Мэдэгдэл**

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын Ерөнхий захирал 30 болон 32 дугаар зүйлд заасан улсуудад болон Нэгдсэн Үндэстний Байгууллагад 31, 32 болон 39 дүгээр зүйлд заасан соёрхон батласан, нэгдэн орсон, эсхүл хүлээн зөвшөөрсөн тухай баримт бичгийг хадгалуулсан тухай, 35, 37 болон 39 дүгээр зүйлтэй холбогдуулан мэдэгдэл хийсэн, цуцалсан тухай мэдэгдэнэ.

*39 дүгээр зүйл*

**Конвенц, түүний хэрэгжүүлэх журамд нэмэлт өөрчлөлт оруулах**

1. Хэлэлцэн тохирогч эрхэм дээд тал бүр энэхүү конвенц, түүнийг хэрэгжүүлэх журамд нэмэлт өөрчлөлт оруулах саналыг тавьж болно. Нэмэлт өөрчлөлт оруулахыг санал болгосон аливаа эх бичвэрийн талаар Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын Ерөнхий захиралд мэдэгдэх бөгөөд тэрбээр хэлэлцэн тохирогч эрхэм дээд тал бүрт түүнийг хүргүүлж, тухайн талаас дараахь асуудалд дөрвөн сарын дотор хариу ирүүлэх хүсэлт гаргана:

(а) санал болгосон нэмэлт өөрчлөлтийн хэлэлцэх Бага хурлыг зарлан хуралдуулахыг тухайн тал хүсч буй өсөх;

(b) Бага хурал хийхгүйгээр санал болгосон нэмэлт өөрчлөлтийг хүлээн зөвшөөрөхөд бэлэн байгаа эсэх;

(c) Бага хурал хийхгүйгээр санал болгосон нэмэлт өөрчлөлтийг татгалзахыг зөвшөөрч буй эсэх.

2. Ерөнхий захирал энэ зүйлийн 1 дэх хэсгийн дагуу хүлээн авсан хариуг хэлэлцэн тохирогч эрхэм дээд бүх талд хүргүүлнэ.

3. Хэрэв хэлэлцэн тохирогч эрхэм дээд бүх тал дурдсан хугацаанд энэ зүйлийн 1 дэх хэсгийн “b”-д заасны дагуу Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын Ерөнхий захиралд Бага хурал хийхгүйгээр санал болгосон нэмэлт өөрчлөлтийг хүлээн зөвшөөрөхөд бэлэн байгаагаа мэдэгдвэл Ерөнхий захирал тэдгээрийн шийдвэрийн талаархи мэдэгдлийг 38 дугаар зүйлийн дагуу хийнэ. Нэмэлт өөрчлөлт нь тухайн мэдэгдлийг хийсэн өдрөөс өрэн (90) хоногийн дараа хэлэлцэн тохирогч эрхэм дээд бүх талын хувьд хүчин төгөлдөр болно.

4. Нэмэлт өөрчлөлтийг хэлэлцэх Бага хурлыг зарлан хуралдуулахыг хэлэлцэн тохирогч эрхэм дээд талуудын гуравны нэгээс доошгүй улс санал болговол хэлэлцэн тохирогч эрхэм дээд талуудын Бага хурлыг Ерөнхий захирал зарлан хуралдуулна.

5. Өмнөх заалтанд дурдсан журмын дагуу энэхүү конвенц, түүнийг хэрэгжүүлэх журамд оруулах нэмэлт өөрчлөлт нь Бага хуралд оролцсон хэлэлцэн тохирогч эрхэм дээд талуудаас түүнийг нэгэн зэрэг баталж, хэлэлцэн тохирогч эрхэм дээд тал бүр хүлээн зөвшөөрснөөр хүчин төгөлдөр болно.

6. Энэхүү конвенц, түүнийг хэрэгжүүлэх журамд оруулах 4 болон 5 дахь хэсэгт заасан Бага хурлаас батласан нэмэлт өөрчлөлтийг хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд хүлээн зөвшөөрөх тухай баримт бичиг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын Ерөнхий захиралд хадгалуулснаар хүчин төгөлдөр болно.

7. Энэхүү конвенц, түүнийг хэрэгжүүлэх журамд оруулсан нэмэлт өөрчлөлт хүчин төгөлдөр болсны дараа нэмэлт өөрчлөлт орсон энэхүү конвенц, түүнийг хэрэгжүүлэх журмын эх бичвэр нь соёрхон батлах, эсхүл нэгдэн ороход нээлттэй байна.

*40 дүгээр зүйл  
Бүртгэх*

Энэхүү конвенцийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын Ерөнхий захирлын хүсэлтээр Нэгдсэн Үндэстний Байгууллагын Нарийн бичгийн дарга нарын газарт Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрмийн 102 дугаар зүйлийн дагуу бүртгэнэ.

Дээр дурдсаныг нотолж, дор гарын үсэг зурагсад энэхүү конвенцид гарын үсэг зурав.

Энэхүү конвенцийг 1954 оны 5 дугаар сарын 14-ны өдөр Гаага хотноо Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагад хадгалагдах нэг жинхэнэ эх хувь үйлдсэн бөгөөд түүний баталгаат хуулбарыг 30 болон 32 дугаар зүйлийн дагуу бүх улс, түүнчлэн Нэгдсэн Үндэстний Байгууллагад хүргүүлнэ.

## ЗЭВСЭГТ МӨРГӨЛДӨӨНИЙ ҮЕД СОЁЛЫН ҮНЭТ ЗҮЙЛСИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ КОНВЕНЦИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЖУРАМ

### I бүлэг Хяналт

1 дүгээр зүйл

#### Хүмүүсийн олон улсын жагсаалт

Энэхүү конвенцийг хүчин төгөлдөр болсноор Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын Ерөнхий захирал хэлэлцэн тохирогч эрхэм дээд талуудаас соёлын өвийн ерөнхий комиссарын үүрэг гүйцэтгэхэд нэр дэвшүүлсэн хүмүүсийн олон улсын жагсаалтыг гаргана. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын Ерөнхий захирлын санаачилгаар энэхүү жагсаалтыг хэлэлцэн тохирогч эрхэм дээд талуудын шаардлагын үндсэн дээр тогтмол хянаж үзнэ.

2 дугаар зүйл

#### Хяналт зохион байгуулах

Зэвсэгт мөргөлдөөнд татагдаж оролцсон хэлэлцэн тохирогч эрхэм дээд аливаа тал энэхүү конвенцийн 18 дугаар зүйлийг дараах хэлбэрээр хэрэглэнэ:

(а) Өөрийн нутаг дэвсгэрт байрлаж буй соёлын үнэт зүйлсийг хамгаалах төлөөлөгчийг томилно, хэрэв энэ нь өөр нутаг дэвсгэрт байрлаж байвал тухайн нутаг дэвсгэрт байрлаж буй соёлын үнэт зүйлсийг хамгаалах тусгай төлөөлөгчийг томилно;

(б) Хэлэлцэн тохирогч эрхэм дээд ийм талтай мөргөлдөөнд оролцогч тал бүрийн нэрийн өмнөөс үйл ажиллагааг явуулж буй хамгаалагч гүрэн хэлэлцэн тохирогч эрхэм дээд тухайн талд дор дурдсан 3 дугаар зүйлийн дагуу төлөөлөгчдийг томилно;

(с) Соёлын үнэт зүйлсийг хамгаалах ерөнхий комиссарыг хэлэлцэн тохирогч эрхэм дээд тухайн талын хувьд 4 дүгээр зүйлийн дагуу томилно.

3 дугаар зүйл

#### Хамгаалагч гүрнүүдийн төлөөлөгчдийг томилох

Хамгаалагч гүрэн төлөөлөгчдөө өөрийн дипломат буюу консулын ажилтнуудаас, эсхүл тэдгээрийн томилогдох талын зөвшөөрөлтэйгээр өөр хүмүүсээс томилно.

4 дүгээр зүйл

#### Ерөнхий комиссарыг томилох

1. Соёлын үнэт зүйлсийг хамгаалах ерөнхий комиссарыг түүний томилох тал, эсрэг талуудын нэрийн өмнөөс үйл ажиллагаагаа явуулж буй хамгаалагч талын хамтарсан тохиролцоогоор хүмүүсийн олон улсын жагсаалтаас сонгоно.

2. Энэ асуудлаар хэлэлцээ эхлүүлснээс хойш гурван долоо хоногийн дотор талууд тохиролцоонд хүрэхгүй тохиолдолд тэд Олон улсын шүүхийн даргаас ерөнхий комиссарыг томилохыг хүснэ. Энэ комиссар нь түүний томилогдох тал томилгоог зөвшөөрөх хүртэл үүрэгт ажилдаа орохгүй.

*5 дугаар зүйл*  
**Төлөөлөгчдийн чиг үүрэг**

Хамгаалагч гүрнүүдийн төлөөлөгчид нь конвенцийн зөрчлийг тэмдэглэж, томилогдсон талын зөвшөөрөлтэйгээр болон нөхцөл байдалд тааруулж мөрдөн байцаалтыг явуулж, мөргөлдөөнийг зогсоох явдлыг хангах зорилгоор орон нутагт төлөөлөл бий болгох, шаардлагатай тохиолдолд зөрчлийн тухай Ерөнхий комиссарт мэдэгдэнэ. Тэд өөрийн үйл ажиллагааны талаар Ерөнхий комиссарыг тогтмол мэдээлнэ.

*6 дугаар зүйл*

**Ерөнхий комиссарын чиг үүрэг**

1. Соёлын үнэт зүйлсийг хамгаалах ерөнхий комиссар конвенцийн хэрэгжилттэй холбогдолтой түүнд оногдсон бүх асуудлыг томилогдсон талын төлөөлөгч болон холбогдох төлөөлөгчидтэй хамтран эрхэлнэ.

2. Энэхүү журамд тусгагдсан асуудлаар шийдвэр гаргах, томилох эрх мэдэлтэй байна.

3. Томилогдсон талын зөвшөөрөлтэйгээр мөрдөн байцаалт эхлүүлэх, эсхүл өөрөө мөрдөн байцаал явуулах эрхтэй байна.

4. Конвенцийн хэрэгжилтэнд хэрэгтэй гэж үзсэн аливаа төлөөллийг мөргөлдөөнд оролцогч тал буюу тэдний хамгаалагч гүрэнд бий болгоно.

5. Конвенцийн хэрэгжилтэд шаардлагатай байж болох илтгэлийг бэлтгэж холбогдох талуудад илгээнэ. Илтгэлийн хувийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын Ерөнхий захиралд илгээж, тэрбээр илтгэлийн зөвхөн техникийн агуулгыг ашиглаж болно.

6. Хамгаалагч гүрэн байхгүй тохиолдолд Ерөнхий комиссар Конвенцийн 21, 22 дугаар зүйлд заасны дагуу хамгаалагч гүрний үүрэг гүйцэтгэнэ.

*7 дугаар зүйл*  
**Байцаагч, шинжээч нар**

1. Соёлын үнэт зүйлсийг хамгаалах ерөнхий комиссар шаардлагатай гэж үзэх, эсхүл холбогдох төлөөлөгчдийн хүсэлтээр буюу тэдэнтэй зөвлөлдсөний дараа томилогдсон талд тусгай үүрэгтэй соёлын үнэт зүйлсийг хамгаалах байцаагчийг батлуулахаар санал болгоно.

2. Ерөнхий комиссар, төлөөлөгчид болон байцаагчид дээрх хэсэгт дурдсаны адил санал болгож болох шинжээч томилж болно.

*8 дугаар зүйл*

**Хяналтын үүргээс чөлөөлөх**

Соёлын үнэт зүйлсийг хамгаалах ерөнхий комисsar, хамгаалагч гүрнүүдийн төлөөлөгчид, байцаагчид болон шинжээчид ямар ч тохиолдолд эрх мэдлээ хэтрүүлж болохгүй. Тухайлбал, тэд томилогдсон хэлэлцэн тохирогч эрхэм дээд талын аюулгүй байдлын шаардлагыг анхааралдаа авах бөгөөд бүх тохиолдолд хэлэлцэн тохирогч эрхэм дээд талын тавьсан дайны байдлын шаардлагад нийцүүлж үйл ажиллагаагаа явуулна.

*9 дүгээр зүйл*

**Хамгаалагч гүрэнг орлуулах**

Хэрэв мөргөлдөөнд оролцогч тал хамгаалагч гүрний үйл ажиллагаанаас ашиг хүртэхгүй байх, эсхүл ашиг олохoo болих тохиолдолд төвийг сахигч улсыг хамгаалагч гүрний үүргийг хүлээн авахыг хүсэж болно. Чингэхдээ Соёлын үнэт зүйлсийг хамгаалах комиссарыг дээрх 4 дүгээр зүйлд заасан журмын дагуу томилно. Ийнхүү томилогдсон Ерөнхий комисsar шаарлагатай тохиолдолд энэ журамд заасны дагуу хамгаалагч гүрнүүдийн төлөөлөгчдийн үүргийг байцаагчдад хүлээлгэнэ.

*10 дугаар зүйл*  
**Зардал**

Соёлын үнэт зүйлсийг хамгаалах ерөнхий комисsar, байцаагчид болон шинжээчдийн урамшуулал, зардлыг томилогдсон тал хариуцна. Хамгаалагч гүрнүүдийн төлөөгчдийн урамшуулал, зардлыг тухайн гүрнүүд болон эрхийг нь хамгаалж буй улсууд хоорондын тохиролцоогоор зохицуулна.

**II бүлэг**

**Тусгай хамгаалт**

*11 дүгээр зүйл*

**Түр хугацаагаар хорогдох байр**

1. Зэвсэгт мөргөлдөөний үеэр хэлэлцэн тохирогч эрхэм дээд аливаа тал урдьчилан харах боломжгүй нөхцөл байдлын улмаас түр хугацаагаар хорогдох байр байгуулах шаардлагатай болсон бөгөөд түүнийг тусгай хамгаалалтад байрлуулах хүсэлтэй байх тохиолдолд энэ талаар тухайн талд томилогдсон Ерөнхий комиссарт мэдэгдэнэ.

2. Хэрэв Ерөнхий комисsar ийм арга хэмжээг тухайн нөхцөл байдалд болон тухайн түр хугацаагаар хорогдох байрт байрлаж буй соёлын үнэт зүйлсийг ач холбогдлын хувьд шаардлагатай гэж үзвэл ийм түр хугацаагаар хорогдох байранд Конвенцийн 16 дугаар зүйлд заасан бэлгэ тэмдгийг байрлуулахыг хэлэлцэн тохирогч эрхэм дээд талуудад зөвшөөрч болно. Тэрбээр шийдвэрээ холбогдох хамгаалагч гүрнүүдийн төлөөлөгчдөд цаг алдалгүй илгээж, төлөөлөгч бүр 30 хоногийн хугацаанд багтааж бэлгэ тэмдгийг буцаахыг тушаана.

3. Ийм төлөөлөгчид зөвшөөрлөө илэрхийлсэн, эсхүл 30 хоногийн хугацаанд холбогдох төлөөлөгчид татгалзлаа илэрхийлээгүй тохиолдолд, эсхүл Ерөнхий комиссар хорогдох байранд Конвенцийн 8 дугаар зүйлд заасан шаардлага хангасан гэж үзвэл Ерөнхий комиссар Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын Ерөнхий захирлыг түр орогнох байрыг тусгай хамгаалалтад авсан соёлын үнэт зүйлсийн жагсаалтад оруулахыг хүснэ.

*12 дугаар зүйл*

**Тусгай хамгаалалтад авсан соёлын үнэт зүйлсийн олон улсын бүртгэл**

1. Тусгай хамгаалалтад авсан соёлын үнэт зүйлсийн олон улсын жагсаалтыг бэлтгэнэ.

2. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын Ерөнхий захирал энэ бүртгэлийг хөтлөнө. Тэрбээр бүртгэлийн хуулбарыг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий захирал болон хэлэлцэн тохирогч эрхэм дээд талуудад хүргүүлнэ.

3. Бүртгэлийг хэлэлцэн тохирогч эрхэм дээд талуудын нэрээр ангилна. Хэсэг бүрийг дараахь гарчигтай гурван дэд хэсэгт хуваана: Түр хугацаагаар орогнох байр, хөшөө бүхий төвүүд, соёлын бусад үл хөдлөх үнэт зүйлс. Ерөнхий захирал хэсэг бүрт тусгах зүйлийг нарийвчлан тодорхойлно.

*13 дугаар зүйл*

**Бүртгүүлэхийг хүсэх**

1. Хэлэлцэн тохирогч эрхэм дээд аливаа тал өөрийн нутаг дэвсгэрт байрлаж буй тодорхой түр хугацаагаар орогнох байр, хөшөө бүхий төвүүд, хөдлөшгүй бусад соёлын бусад үл хөдлөх үнэт зүйлсийг бүртгэлд оруулах өргөдлийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын Ерөнхий захиралд өгч болно. Ийм өргөдөл уг үнэт зүйлсийн байрлалын тодорхойлолт болон тухайн үнэт зүйлс нь Конвенцийн 8 дугаар зүйлийн заалттай нийцэж байгааг нотлоно.

2. Эзлэгдсэн тохиолдолд эзлэгч гүрэн нь ийм өргөдөл гаргах эрхтэй байна.

3. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын Ерөнхий захирал бүртгүүлэх өргөдлийн хуулбарыг хэлэлцэн тохирогч эрхэм дээд тал бүрт цаг алдалгүй илгээнэ.

*14 дүгээр зүйл*

**Татгалзах**

1. Хэлэлцэн тохирогч эрхэм дээд аливаа тал Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын Ерөнхий захиралд захидал илгээж соёлын үнэт зүйлсийг бүртгэхээс татгалзаж болно. Энэ захидалыг Ерөнхий захирал бүртгүүлэх өргөдөл илгээнээс хойш 4 сарын дотор хүлээн авсан байх ёстой.

2. Ийм татгалзалд татгалзах болсон шалтгааныг дурдах бөгөөд үүнд гагцхүү дараахь үндэслэлийг хүчинтэйд тооцно:

(а) үнэт зүйлс нь соёлын үнэт зүйлс бус байх;

(б) үнэт зүйлс нь Конвенцийн 8 дугаар зүйлийн шаардлагад нийцэхгүй байх.

3. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын Ерөнхий захирал татгалзсан тухай захидалтын хуулбарыг хэлэлцэн тохирогч эрхэм дээд талуудад цаг алдалгүй илгээнэ. Шаардлагатай тохиолдолд тэрбээр Хөшөө, урлагийн болон түүхийн барилга, археологийн малтмалын олон улсын хорооны болон зохистой гэж үзвэл бусад эрх бүхий аливаа байгууллага буюу хүний зөвлөгөөг авна.

4. Бүртгүүлэхийг хүссэн Ерөнхий захирал, эсхүл хэлэлцэн тохирогч эрхэм дээд тал татгалзлыг буцаалгуулах зорилгоор шаардлагатай гэж үзсэн аливаа төлөөллийг хэлэлцэн тохирогч эрхэм дээд татгалзсан талд бий болгож болно.

5. Хэрэв бүртгүүлэх өргөдлийг тайван цагт гаргасан хэлэлцэн тохирогч эрхэм дээд тал бүртгэлээс өмнө зэвсэгт мөргөлдөөнд оролцвол нотлох, буцаах, эсхүл хийж болох буюу хийсэн татгалзлыг хүчингүй болгох хүртэл Ерөнхий захирал тухайн үнэт зүйлсийг бүртгэлд түр хугацаагаар оруулна.

6. Хэрэв татгалзсан тухай захидал хүлээн авснаас хойш 6 сарын хугацаанд хэлэлцэн тохирогч эрхэм дээд талаас татгалзлыг буцаасан тухай мэдэгдэл хүлээн авахгүй бол бүртгүүлэх өргөдөл гаргасан хэлэлцэн тохирогч эрхэм дээд тал дараах хэсэгт заасан журмын дагуу арбитрын шүүхээр шийдвэрлүүлэх хүсэлт гаргаж болно.

7. Арбитрын шүүхээр шийдвэрлүүлэх хүсэлтийг Ерөнхий захирал татгалзсан тухай захидал хүлээн авснаас хойш нэг жилийн хугацаанаас хойшгүй гаргана. Маргаанд оролцогч тал бүр нэг арбитрч томилно. Хэрэв нэгээс илүү татгалзал байх тохиолдолд татгалзсан хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд нийтийн тохиролцоогоор нэг арбитрч томилно. Эдгээр хоёр арбитрч нь энэхүү журмын 1 дүгээр зүйлд дурдсан олон улсын жагсаалтаас арбитрын даргыг сонгоно. Хэрэв эдгээр арбитрч тохиролцоонд хүрэхгүй бол тэд Олон улсын шүүхийн даргаас арбитрын даргыг томилохыг шаардах бөгөөд энэ тохиолдолд түүнийг олон улсын жагсаалтаас сонгох шаардлагагүй. Ийнхүү байгуулагдсан арбитрын шүүх үйл ажиллагааны журмаа өөрөө тодорхойлно. Арбитрын шүүхийн шийдвэрийг давж заалдахгүй.

8. Хэлэлцэн тохирогч эрхэм дээд тал бүр түүнийг хамарсан маргаан гарах үед өмнөх хэсэгт заасан арбитрын журмыг хэрэглэхийг хүсэхгүй байгаагаа мэдэгдэж болно. Ийм тохиолдолд бүртгүүлэх өргөдлийн татгалзлыг Ерөнхий захирал хэлэлцэн тохирогч эрхэм дээд талуудад дамжуулна. Татгалзлыг зөвхөн санал асуулгад оролцсон хэлэлцэн тохирогч эрхэм дээд талуудын гуравны хоёрын олонхийн саналаар батална. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын Ерөнхий захирал Конвенцийн 27 дугаар зүйлээр түүнд олгосон эрхийн дагуу уулзалт зарлан хуралдуулахгүй бол санал асуулгыг захидал харилцаагаар явуулна. Хэрэв Ерөнхий захирал санал асуулгыг захидал харилцаагаар явуулахыг шийдвэл тэрбээр хэлэлцэн тохирогч эрхэм дээд талуудыг санал өгөхөөр уригдсанаас хойш 6 сарын хугацаанд саналаа лацадсан захидаар ирүүлэхийг хүсэлт болгоно.

15 дугаар зүйл

### Бүртгэл

1. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын Ерөнхий захирал 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан хугацаанд татгалзал хүлээн аваагүй бол бүртгүүлэх өргөдөл өгсөн үнэт зүйл бүрийг серийн дугаартайгаар бүртгэлд оруулна.

2. Татгалзал илэрхийлсэн бөгөөд 14 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийн заалтыг хөндөхгүйгээр Ерөнхий захирал татгалзлыг буцаасан, эсхүл 14 дүгээр зүйлийн 7, эсхүл 8 дахь хэсэгт заасан журмын дагуу батлагдаагүй тохиолдолд л үнэт зүйлсийг бүртгэлд оруулна.

3. 11 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг хэрэглэх үед Соёлын үнэт зүйлсийг хамгаалах ерөнхий комисsar хүсэлт гаргах тохиолдолд Ерөнхий захирал соёлын үнэт зүйлсийг бүртгэлд оруулна.

4. Ерөнхий захирал өвийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга, хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд болон бүртгүүлэх өргөдөл гаргасан талын хүсэлтээр Конвенцийн 30 болон 32 дугаар зүйлд заасан бусад бүх улсад бүртгэлд оруулсан үнэт зүйлсийн баталгаат хуулбарыг цаг алдалгүй илгээнэ.

16 дугаар зүйл

### Хүчингүй болгох

1. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын Ерөнхий захирал бүртгүүлсэн аливаа үнэт зүйлсийн бүртгэлийг дараахь тохиолдолд хүчингүй болгоно:

(а) соёлын үнэт зүйлс нутаг дэвсгэрт нь байрлаж буй хэлэлцэн тохирогч эрхэм дээд талын хүсэлтээр;

(б) бүртгүүлэхийг хүссэн хэлэлцэн тохирогч эрхэм дээд тал Конвенцийг цуцалсан болон уг цуцлалт хүчин төгөлдөр болсон;

(с) 14 дүгээр зүйлийн 7, эсхүл 8 дахь хэсэгт заасан журмаар татгалзал батлагдах талаар 5 дахь хэсэгт дурдсан онцгой тохиолдолд.

2. Ерөнхий захирал Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга болон бүртгэлд оруулсаны хуулбарыг хүлээн авсан бүх улсад татгалзлын хуулбарыг цаг алдалгүй илгээнэ. Ийм хуулбарыг илгээсний дараа 30 хоногийн дараа татгалзал хүчин төгөлдөр болно.

**III бүлэг**  
**Соёлын үнэт зүйлсийг тээвэрлэх**

17 дугаар зүйл

**Дархан эрх олгох журам**

1. Конвенцийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан хүсэлтийг Соёлын үнэт зүйлсийг хамгаалах ерөнхий комиссарт илгээнэ. Тэрбээр хүсэлтийн үндэслэл, шилжүүлэх зүйлийн ойролцоо тоо болон ач холбогдол, тэдгээрийн одоо байрлаж буй байрлал, зөвөрлөх зам, шилжүүлэх өдрийн санал болон бусад аливаа мэдээллийг дурдана.

2. Ерөнхий комиссар шаардлагатай гэж үзсэн саналыг сонссоны дараа ийм шилжүүлгийг зохистой гэж үзвэл тэрбээр гүйцэтгэхээр санал болгосон арга хэмжээний асуудлаар хамгаалагч холбогдох гүрнүүдийн төлөөлөгчидтэй зөвлөлдөнө.

3. Ерөнхий комиссар зөвхөн хүсэлтэд дурдсан үнэт зүйлсийг шилжүүлэх гэж буй бөгөөд тээвэрлэлийг зөвшөөрсөн аргаар явуулах бөгөөд бэлгэ тэмдэгтэй байгааг баталгаажуулах нэг, эсхүл түүнээс илүү байцаагч томилно. Байцаагч буюу байцаагчид хүрэх газарт нь очтол үнэт зүйлсийг дагалдаж явна.

18 дугаар зүйл  
**Хилийн чанадад тээвэрлэх**

Тусгай хамгаалалтад авсан шилжүүлгийг өөр орны нутаг дэвсгэр рүү чиглэгдсэн үед түүнийг зөвхөн Конвенцийн 12 дугаар зүйлээр болон энэхүү журмын 17 дугаар зүйлээр бус зөвхөн дараахъяа заалтаар зохицуулна:

(a) соёлын үнэт зүйлс өөр улсын нутаг дэвсгэрт үлдэх тохиолдолд тухайн улс түүний хадгалагч нь байх бөгөөд уг үнэт зүйлстэй ижил хэмжээний ач холбогдол бүхий өөрийн соёлын үнэт зүйлсэд үзүүлдэгийн адил хамгаалалт үзүүлнэ;

(b) хадгалагч улс үнэт зүйлсийг зөвхөн мөргөлдөөн дууссаны дараа буцаана; энэ тохиолдолд буцаахыг хүссэн өдрөөс хойш зургаан сарын хугацаанд буцаана;

(c) шилжүүлгийн төрөл бүрийн үйл ажиллагааны үеэр болон энэ нь өөр улсын нутаг дэвсгэрт үлдэх хугацаанд соёлын үнэт зүйлсийг хураахгүй бөгөөд хадгалуулагч, эсхүл хадгалагч үрэгдүүлж болохгүй. Гэхдээ үнэт зүйлсийн аюулгүй байдлын шаардлагаар хадгалагч нь хадгалуулагчийн зөвшөөрөлтэйгөөр үнэт зүйлсийг өөр улсын нутаг дэвсгэр рүү энэ зүйлийн нөхцөлөөр тээвэрлэж болно;

(d) тусгай хамгаалалтад авах хүсэлтэд үнэт зүйлсийг нутаг дэвсгэрт нь шилжүүлж буй улс энэ зүйлийн заалтыг хүлээн зөвшөөрч буйг заах ёстой.

19 дүгээр зүйл

**Эзлэгдсэн нутаг дэвсгэр**

Хэлэлцэн тохирогч эрхэм дээд өөр талын нутаг дэвсгэрийг эзлэсэн хэлэлцэн тохирогч эрхэм дээд тал соёлын үнэт зүйлсийн тухай журмын 17 дугаар зүйлд заасан

журмыг дагаж мөрдөх боломжгүйгээр тэнд байрладаг түр хугацаагаар орогнох байр уруу шилжүүлэх тохиолдолд Соёлын үнэт зүйлсийг хамгаалах ерөнхий комиссар жирийн хамгаалагч нартай зөвлөлдсөний дараа тухайн шилжүүлэг нь нөхцөл байдлын шаардлагын дагуу үйлдсэнийг бичгээр гэрчлэх тохиолдолд ийм шилжүүлгийг Конвенцийн 4 дүгээр зүйлийн утгаар хууль бусаар эзэмшсэнд тооцохгүй.

#### **IV бүлэг**

*20 дугаар зүйл*

##### **Бэлгэ тэмдгийг хавсаргах**

1. Бэлгэ тэмдгийг байрлуулах буюу түүний харагдах хэмжээг хэлэлцэн тохирогч эрхэм дээд тал бүрийн эрх бүхий байгууллагууд тодорхойлно. Үүнийг далбаа, гарын тузанд байрлуулж болно. Түүнийг байгууламж дээр будах, эсхүл бусад аливаа аргаар илэрхийлж болно.

2. Гэхдээ илүү тод тэмдэглэлээг хөндөхгүйгээр бэлгэ тэмдгийг зэвсэгт мөргөлдөөний үед болон Конвенцийн 12 болон 13 дугаар зүйлд заасан тохиолдолд өдрийн гэрэлд агаараас болон газраас тод харагдахаар тээврийн хэрэгслийн дугуйн дээр байрлуулна. Бэлгэ тэмдэг нь газраас дараах тохиолдолд харагдах ёстой:

- (a) хамгаалалтад авсан хөшөө бүхий төвийн периметр нь ердийн зайнаас тод харахад хангалттай;
- (b) тусгай хамгаалалтад авсан үл хөдлөх соёлын бусадүнэт зүйлсэд нэвтрэхэд.

*21 дүгээр зүйл*

##### **Хүмүүсийг танъж тогтоох**

1. Конвенцийн 17 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн (b) болон (c) дэд хэсэгт дурдсан этгээдүүд эрх бүхий байгууллагаас тамгалж олгосон бэлгэ тэмдэг бүхий гарын туз зүүж болно.

2. Ийм этгээдүүд таних бэлгэ тэмдэг бүхий тусгай биеийн байцаалт авч явна. Ийм биеийн байцаалтад наад зах нь эзэмшигчийн овог, нэр, төрсөн он, сар, өдөр, зэрэг, цол болон чиг үүргийг тусгана. Биеийн байцаалтад эзэмшигчийн зураг, эсхүл гарын үсэг, эсхүл аль аль нь байна. Биеийн байцаалт эрх бүхий байгууллагын товгор тамгатай байна.

3. Хэлэлцэн тохирогч эрхэм дээд тал бүр хавсралт загвар, аргачлалын дагуу өөрийн биеийн байцаалтын хэлбэрийг боловсруулна. Хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд ашиглаж буй загвараа бие биедээ өгнө. Биеийн байцаалтыг боломжийн хэрээр наад зах нь хоёр хувь үйлдэж нэгийг нь олгогч гүрэн хадгална.

4. Уг этгээдүүдээс хууль ёсны шалтгаангүйгээр биеийн байцаалтыг авч явах, эсхүл гарын тууз зүүж явах эрхээс нь түдгэлзүүлж болохгүй.

**95. БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ АРГА ХЭРЭГСЛИЙГ ЦЭРГИЙН БУЮУ  
ДАЙСАГНАХ БУСАД АЛИВАА ЗОРИЛГООР АШИГЛАХЫГ  
ХОРИГЛОХ ТУХАЙ КОНВЕНЦ**

1976 оны 12 дугаар сарын 10-ны өдөр баталж,  
1976 оны 10 дугаар сарын 5-ны өдөр хүчин төгөлдөр болсон\*

Энэхүү конвенцид оролцогч улсууд,

энх тайвныг бататгах, олон улсын үр дүнтэй хатуу хяналтын дор зэвсэглэлээр хөөцөлдөх явдлыг зогсоох, зэвсгийг бүх нийтээр бүрэн хураах болон дайныг өдөөх шинэ арга хэрэгслийг ашиглах аюулаас хүн төрөлхтнийг хамгаалах ашиг сонирхолыг удирдлага болгож,

зэвсэг хураах салбарт цаашид авах арга хэмжээний хүрээнд үр дүнтэй дэвшилд хүрэх зорилгоор явуулж буй хэлэлцээг үргэлжлүүлэх шийдвэр төгс байж,

шинжлэх ухаан, техникийн дэвшил нь байгаль орчны салбарт нөлөөлөх шинэ боломжийг нээж болохыг хүлээн зөвшөөрч,

Хүний хүрээлэн орчны асуудлаархи Нэгдсэн Үндэстний Байгууллагын Бага хурлаас Стокгольм хотноо 1972 оны 6 дугаар сарын 16-ны өдөр батласан тунхаглалыг анхааралдаа авч,

байгаль орчинд нөлөөлөх арга хэрэгслийг энх тайвны зорилгоор ашиглах нь хүн болон байгалийн шүтэлцээг сайжруулж, өнөөгийн болон хойч үеийнхний ашиг тусын төлөө байгаль орчныг хадгалан сайжруулахад дэмжлэг үзүүлж болохыг ухамсарлаж,

гэхдээ ийм арга хэрэгслийг цэргийн буюу дайсагнах бусад аливаа зорилгоор ашиглах нь хүмүүсийн сайн сайхан байдалд ноцтой хохирол учруулж болохыг хүлээн зөвшөөрч,

ийнхүү ашигласнаас хүн төрөлхтөнд учирч болох аюулыг таслан зогсоохын тулд байгаль орчинд нөлөөлөх арга хэрэгслийг цэргийн буюу дайсагнах бусад аливаа зорилгоор ашиглах явдлыг үр дүнтэйгээр хориглохыг хүсч, эдгээр зорилтод хүрэх өөрсдийн эрмэлзлийг нотолж,

Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрмийн зорилго, зарчимд нийцүүлэн улс үндэстэн хоорондын итгэлцлийг бэхжүүлэх, олон улсын нөхцөл байдлыг цаашид сайжруулахад дэмжлэг үзүүлэхийг эрмэлзэж,

дараахь зүйлийг хэлэлцэн тохиров:

*I дүгээр зүйл*

1. Энэхүү конвенцийн оролцогч улс бүр оролцогч бусад аливаа улсын эсрэг эвдэн сүйтгэх, хор хохирол учруулахын тулд байгаль орчинд удаан хугацаанд буюу

\* Монгол Улс 1977.05.18-нд гарын үсэг зурж, 1978.05.19-нд соёрхон батласан

өргөн хүрээгээр ноцтой нөлөө үзүүлэх арга хэрэгслийг цэргийн буюу дайсагнах бусад аливаа зорилгоор ашиглахгүй байх үүрэг хүлээнэ.

2. Энэхүү конвенцид оролцогч улс бүр энэ зүйлийн 1 дэх хэсгийн заалтад харшилсан үйл ажиллагаанд оролцох аливаа улс, эсхүл бүлэг улс, олон улсын байгууллагад туслалцаа үзүүлэхгүй, дэмжихгүй буюу өдөөн хатгахгүй байх үүрэг хүлээнэ.

#### *2 дугаар зүйл*

1 дүгээр зүйлд дурдсан “байгаль орчинд нөлөөлөх арга хэрэгсэл” гэдэгт байгалийн үйл явц, хөдөлгөөнийг санаатайгаар өөрчлөх замаар дэлхийн бүтэц буюу бүрэлдэхүүн, түүний дотор шим мандал, чулуун мандал, усан мандал болон агаар мандал, эсхүл сансрын огторгуйг өөрчлөх аливаа арга хэрэгсэл хамаарна.

#### *3 дугаар зүйл*

1. Энэхүү конвенцийн заалтууд нь байгаль орчинд нөлөөлөх арга хэрэгслийг энх тайвны зорилгоор ашиглахад саад болохгүй бөгөөд ийнхүү ашиглахтай холбогдсон олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд болон дагаж мөрдөх хэм хэмжээг хөндөхгүй.

2. Энэхүү конвенцийн оролцогч улсууд байгаль орчинд нөлөөлөх арга хэрэгслийг энх тайвны зорилгоор ашиглах тухай шинжлэх ухаан, технологийн мэдээллийг аль болох бүрэн солилцох үүрэг хүлээх бөгөөд ийнхүү солилцоход оролцох эрхтэй байна. Дангаараа буюу оролцогч бусад улс, эсхүл олон улсын байгууллагатай хамтран ажиллах оролцогч улсууд дэлхийн хөгжиж буй бүсүүдийн хэрэгцээг зохих ёсоор харгалзан байгаль орчныг хамгаалах, сайжруулах, түүнийг энх тайвны зорилгоор ашиглах олон улсын эдийн засаг, шинжлэх ухааны хамтын ажиллагаанд өөрийн хувь нэмрээ оруулна.

#### *4 дүгээр зүйл*

Энэхүү конвенцид оролцогч улс бүр өөрийн хууль тогтоомжийн дагуу шаардлагатай гэж үзвэл конвенцийн заалтуудыг зөрчсөн аливаа үйл ажиллагааг хаана үйлдсэнээс үл хамааран тухайн улсын хэргийн харьяалал буюу хяналтын хүрээнд хориглох, урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах үүрэг хүлээнэ.

#### *5 дугаар зүйл*

1. Энэхүү конвенцид оролцогч улсууд энэхүү конвенцийн зорилго, түүний заалтуудыг хэрэглэхтэй холбогдон үүсч болох аливаа асуудлыг шийдвэрлэх талаар харилцан зөвлөлдөх, хамтран ажиллах үүрэг хүлээнэ. Түүнчлэн энэ зүйлийн дагуу хийх зөвлөлдөөн болон хамтын ажиллагааг Нэгдсэн Үндэстний Байгууллагын хүрээнд болон түүний дүрмийн дагуу олон улсын зохих үйл ажиллагааг хэрэгжүүлэх замаар явуулж болно. Олон улсын тухайн үйл ажиллагаанд олон улсын холбогдох байгууллагууд, түүнчлэн энэ зүйлийн 2 дахь хэсэгт дурдсан Шинжээчдийн зөвлөлдөх хорооны үйлчилгээг хамааруулж болно.

2. Конвенцийн эх хадгалагч нь энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан зорилгоор конвенцийн оролцогч аль нэг улсын хүсэлтийг хүлээн авснаас хойш нэг сарын дотор Шинжээчдийн зөвлөлдөх хороог хуралдуулна. Оролцогч аливаа улс чиг үүрэг, дүрэм журмыг нь энэхүү конвенцийн салшгүй хэсэг болох хавсралтад заасан хороонд өөрийн мэргэжилтнээ томилж болно. Энэхүү хороо нь түүний хуралдааны явцад гарсан бүх санал, мэдээллийг нэгтгэж тухайн нөхцөл байдлыг дүгнэсэн товч илтгэлийг

конвенцийн эх хадгалагчид хүргүүлнэ. Конвенцийн эх хадгалагч нь уг товч илтгэлийг оролцогч бүх улсад тараана.

3. Энэхүү конвенцид оролцогч аливаа улс нь конвенцийн заалтуудын дагуу хүлээсэн үүргээ конвенцид оролцогч нөгөө улс зөрчиж байна гэж үзвэл Нэгдсэн Үндэстний Байгууллагын Аюулгүйн Зөвлөлд нэхэмжлэл гаргаж болно. Уг нэхэмжлэлд тухайн хэрэгт хамаарах мэдээлэл, түүнийг үндэслэлийг батлах боломжтой бүх нотлох баримтыг оруулсан байна.

4. Энэхүү конвенцид оролцогч улс бүр Аюулгүйн Зөвлөлөөс хүлээн авсан нэхэмжлэлд үндэслэн түүнээс санаачилж болох аливаа мөрдөн байцаалтыг Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрмийн заалтуудын дагуу явуулахад хамтран ажиллах үүрэг хүлээнэ. Аюулгүйн Зөвлөл нь мөрдөн байцаалтын үр дүнгийн талаар конвенцид оролцогч улсад мэдээлнэ.

5. Хэрэв Аюулгүйн Зөвлөл энэхүү конвенцийг зөрчсөний улмаас нэхэмжлэл гаргасан улсад хохирол учирсан буюу учирч болзошгүй гэж шийдвэр гаргавал энэхүү конвенцид оролцогч улс бүр Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрмийн заалтуудын дагуу ийнхүү хүсэлт гаргасан оролцогч аль ч улсад дэмжлэг туслалцаа үзүүлэх үүрэг хүлээнэ.

#### *6 дугаар зүйл*

1. Энэхүү конвенцид оролцогч аливаа улс түүнд нэмэлт өөрчлөлт оруулах санал гаргаж болно. Ийнхүү санал болгосон нэмэлт өөрчлөлтийн талаарх бичвэрийг конвенцийн эх хадгалагчид хүргүүлэх бөгөөд конвенцийн эх хадгалагч бичвэрийг конвенцид оролцогч бүх улсад нэн даруй хүргүүлнэ.

2. Тухайн нэмэлт өөрчлөлт нь түүнийг хүлээн зөвшөөрсөн конвенцид оролцогч улс бүрийн хувьд тэдний олонхи нь хүлээн зөвшөөрсөн тухай баримт бичгээ конвенцийн эх хадгалагчид хадгалуулснаар хүчин төгөлдөр болно. Үүнээс хойш нэмэлт өөрчлөлтийг хүлээн зөвшөөрсөн улсын хувьд түүнийг батласан тухай баримт бичгээ хадгалуулахаар өгсөн өдөр хүчин төгөлдөр болно.

#### *7 дугаар зүйл*

Энэхүү конвенцийг хугацаагүй байгуулав.

#### *8 дугаар зүйл*

1. Конвенцийн эх хадгалагч энэхүү конвенц хүчин төгөлдөр болсноос хойш таван жилийн дараа Швейцарь Улсын Женев хотноо Конвенцид оролцогч улсуудын бага хурлыг зарлан хуралдуулна. Уг бага хурал нь конвенцийн зорилго, заалтын хэрэгжилтийг хангах зорилгоор түүний үйл ажиллагааг дүгнэх, тухайлбал, байгаль орчинд нөлөөлөх арга хэрэгслийг цэргийн буюу дайсагнах бусад аливаа зорилгоор ашиглах аюулыг арилгахад чиглэгдсэн 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн заалтын үр дүнг авч хэлэлцэнэ.

2. Үүнээс хойш таваас доошгүй жилийн хугацаанд дээрх зорилгоор Конвенцид оролцогч улсуудын олонхи нь конвенцийн эх хадгалагчид бага хурлыг хуралдуулах тухай санал тавьж түүнийг зарлан хуралдуулж болно.

3. Хэрэв бага хурлыг энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хуралдуулаагүй бол өмнөх бага хурлыг дүгнэснээс хойш арван жилийн дотор конвенцийн эх хадгалагч

нь тийм бага хурал хуралдуулах тухай саналыг энэхүү конвенцид оролцогч бүх улсаас авна. Хэрэв конвенцид оролцогч улсуудын гуравны нэг, эсхүл арван улс зөвшөөрсөн саналаа өгвөл конвенцийн эх хадгалагч нь бага хурлыг хуралдуулах арга хэмжээг нэн даруй авна.

**9 дүгээр зүйл**

1. Энэхүү конвенц нь бүх улсад гарын үсэг зурахад нээлттэй байна. Энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу Конвенцийг хүчин төгөлдөр болохоос өмнө түүнд гарын үсэг зураагүй аливаа улс хэдийд ч энэхүү конвенцид нэгдэн орж болно.

2. Энэхүү конвенцийг түүнд гарын үсэг зурсан улсууд соёрхон батална. Соёрхон батласан батламж жуух бичиг буюу нэгдэн орсон тухай баримт бичгийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулна.

3. Энэхүү конвенц нь энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хорин улсын засгийн газар соёрхон батласан тухай батламж жуух бичгээ хадгалуулснаар хүчин төгөлдөр болно.

4. Энэхүү конвенцийг хүчин төгөлдөр болсноос хойш соёрхон батласан батламж жуух бичиг буюу нэгдэн орсон тухай баримт бичгээ хадгалуулахаар өгсөн улсуудын хувьд соёрхон батласан батламж жуух бичиг буюу нэгдэн орсон тухай баримт бичгийг хадгалуулахаар өгсөн өдрөөс энэхүү конвенц хүчин төгөлдөр болно.

5. Конвенцийн эх хадгалагч нь энэхүү конвенцид гарын үсэг зурсан, соёрхон батласан буюу нэгдэн орсон тухай батламж жуух бичгийг хадгалуулсан, энэхүү конвенц хүчин төгөлдөр болсон, түүнд оруулсан аливаа нэмэлт өөрчлөлтийн болон бусад мэдэгдлийг хүлээн авсан он, сар, өдрийн тухай гарын үсэг зурсан болон нэгдэн орсон бүх улсад нэн даруй мэдээлнэ.

6. Эх хадгалагч нь энэхүү конвенцийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрмийн 102 дугаар зүйлийн дагуу бүртгүүлнэ.

**10 дугаар зүйл**

Англи, араб, хятад, франц, орос болон испани хэлээр үйлдсэн эх бичвэрүүд нь адил хүчинтэй байх энэхүү конвенцийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга хадгалах бөгөөд тэрбээр түүний баталгаат хуулбарыг Конвенцид гарын үсэг зурсан болон түүнд нэгдэн орсон улсын засгийн газруудад хүргүүлнэ.

Дээр дурдсаныг нотолж, өөрсдийн засгийн газраас зохих ёсоор бүрэн эрх олгогдсон дор гарын үсэг зурагсад энэхүү конвенцид гарын үсэг зурав. Энэхүү конвенц нь нэг мянга есөн зуун далан долоон оны тав дугаар сарын арван наймны өдрөөс Женев хотноо гарын үсэг зурахад нээлттэй байна.

Женев хотноо 1977 оны 5 дугаар сарын 18-ны өдөр үйлдэв.

Конвенцийн хавсралт

**ШИНЖЭЭЧДИЙН ЗӨВЛӨЛДӨХ ХОРОО**

1. Шинжээчдийн зөвлөлдөх хороо нь тухайн нөхцөл байдлыг зохих ёсоор дүгнэх болон хороог хуралдуулах хүсэлт гаргасан оролцогч улсаас энэхүү конвенцийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу гаргасан аливаа асуудалтай холбогдуулан шинжээчийн зохих дүгнэлт гаргана.

2. Шинжээчдийн зөвлөлдөх хорооны ажлыг энэхүү хавсралтын 1 дэх хэсэгт заасан чиг үүргийг хэрэгжүүлэх боломж олгох замаар зохион байгуулна. Уг хороо нь өөрийн ажлын зохион байгуулалттай холбогдолтой дэгийн асуудлыг хэрэв боломжтой бол зөвшилцлөөр, хэрэв боломжгүй бол санал хураахад оролцогчдын олонхийн саналаар шийдвэрлэнэ. Үндсэн асуудлаар санал хураахгүй.

3. Конвенцийн эх хадгалагч, эсхүл түүний төлөөлөгч энэхүү хорооны дарга байна.

4. Хуралдаанд оролцож буй шинжээч бүрд нэг буюу хэд хэдэн зөвлөх туслалцаа үзүүлж болно.

5. Шинжээч бүр хорооны ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай гэж үзэх тийм мэдээлэл, туслалцааг хорооны даргаар дамжуулан оролцогч улсууд болон олон улсын байгууллагуудаас хүсэх эрхтэй.

**96. АМЬСГАЛ БООГДУУЛАГЧ, ХОРТОЙ БУЮУ ТЭДГЭЭРТЭЙ ИЖИЛ  
БУСАД ХИЙ БОЛОН БАКТЕРИОЛОГИЙН ХЭРЭГСЛИЙГ ДАЙНД  
ХЭРЭГЛЭХИЙГ ХОРИГЛОХ ТУХАЙ ПРОТОКОЛ**

*1925 оны 6 дугаар сарын 17-ны өдөр баталж,  
1928 оны 2 дугаар сарын 8-ний өдөр хүчин төгөлдөр болсон\**

Дор гарын үсэг зурсан бүрэн эрхт төлөөлөгчид өөрсдийн засгийн газрын нэрийн өмнөөс:

иргэншсэн ертөнцийн олон нийтийн санаа бодлоор амьсгал боогдуулагч, хортой буюу тэдгээртэй ижил төрлийн хий, бусад бүх төрлийн шингэн, бодис болон хэрэгслэлийг дайнд хэрэглэх явдлыг шударгаар буруушаасан гэж үзэж,

ийм хэрэглээг дэлхийн ихэнх гүрнүүд оролцогч тал нь болох гэрээгээр хориглосон болохыг дурдаж,

энэхүү хориглолтыг ард түмний ёс суртахуун, дадал заншлын хувьд заавал дагаж мөрдөх олон улсын эрх зүйд нийтээр хүлээн зөвшөөрүүлэх зорилгоор тунхаглах нь:

Хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд дээр дурдсан хэрэглээг хориглосон гэрээнүүдийн оролцогч байхаа больсон учир энэ хориглолтыг хүлээн зөвшөөрч,

\* Монгол Улс 1968.11.10-нд батласан

бактериологийн хэрэгслийг дайнд ашиглах явдалд уг хориглолтыг хамааруулахыг зөвшөөрч, мөн өөрсдийгөө энэхүү тунхаглалын нөхцөлийн дагуу өөр хоорондоо холбоотой хэмээн хэлэлцэн тохир.

Хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд энэхүү протоколд нэгдэн орохыг бусад улсад уриалахад бүх чармайлтад гаргана. Ийнхүү нэгдэн орсон тухай Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газарт мэдэгдэх бөгөөд гарын үсэг зурсан, нэгдэн орсон бүх улс гүрэнд Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар мэдэгдэнэ. Нэгдэн орсон нь Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар мэдэгдсэн өдөр хүчин төгөлдөр болно.

Англи, франц хэлээрх эх бичвэрүүд нь нь адил хүчинтэйд тооцогдох энэхүү протоколыг аль болох богино хугацаанд соёрхон батална. Протоколын он, сар, өдрийг өнөөдөрөөр тооцно.

Энэхүү протоколын соёрхон батласан батламж жуух бичгийг Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газарт хүргүүлэх бөгөөд тэрбээр батламж жуух бичгийг хадгалахаар хүлээн авснаа гарын үсэг зурсан, нэгдэн орсон улс бүрт мэдэгдэнэ.

Батламж жуух бичиг, нэгдэн орсон баримт бичгүүд нь Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газрын архивт хадгалагдана.

Энэхүү протокол нь гарын үсэг зурсан гүрэн бүрийн хувьд батламж жуух бичгээ хадгалуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болох бөгөөд тийм гүрэн нь энэ үеэс эхлэн батламж жуух бичгээ хадгалуулахаар өмнө нь өгсөн гүрнүүдтэй холбоотой болно.

Дээр дурдсаныг нотолж бүрэн эрхт төлөөлөгчид энэхүү протоколд гарын үсэг зурав.

Нэг мянга есөн зуун хорин таван оны зургадугаар сарын арван долооны өдөр Женев хотноо нэг эх хувь үйлдэв.

## **97. БАКТЕРИОЛОГИЙН (БИОЛОГИЙН) БОЛОН ТОКСИНЫ ЗЭВСЭГ БОЛОВСРУУЛАХ, ҮЙЛДВЭРЛЭХ, НӨӨЦЛӨХИЙГ ХОРИГЛОХ, ТЭДГЭЭРИЙГ УСТГАХ ТУХАЙ КОНВЕНЦИЯН**

*1972 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр баталж,  
1972 оны 5 дугаар сарын 18-ны өдөр хүчин төгөлдөр болсон\**

Энэхүү конвенцид оролцогч улс,

үй олноор хөнөөх бүх төрлийн зэвсгийг хориглох болон устгахыг оролцуулан зэвсгийг бүх нийтээр бүрэн хураах зорилгод хүрэхэд үр дүнтэй ахиц гаргах зорилгоор ажиллах шийдвэр төгс байж, үр дүнтэй арга хэмжээ авах замаар химийн болон бактериологийн (биологийн) зэвсэг боловсруулах, үйлдвэрлэх, нөөцлөхийг хориглох, тэдгээрийг устгах нь зэвсгийг олон улсын хатуу, үр бүтээлтэй хяналтын дор бүх нийтээр бүрэн хураахад тус дөхөм үзүүлнэ гэдэгт итгэж,

\* Монгол Улс 1972.04.10-нд гарын үсэг зурж, 1972.09.14-нд соёрхон батласан

Амьсгал боогдуулагч, хортой буюу ижил төстэй бусад хийн болон бактериологийн (биологийн) зэвсгийг дайнд хэрэглэхийг хориглох тухай Женевийн 1925 оны 6 дугаар сарын 17-ны протоколын чухал ач холбогдлыг болон дайны гамшгийг багасгах үйлст уг протокол хувь нэмрээ оруулсан, оруулсаар байгааг хүлээн зөвшөөрч,

энэхүү протоколын зарчим, зорилгыг чанд мөрдөхөө нотолж, түүнийг биелүүлэхийг бүх улсад уриалж,

Женевийн 1925 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн протоколын зарчим, зорилгод харшилсан бүх үйлдлийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблей удаа дараа буруушаасныг дурдаж,

улс түмний харилцан итгэлцэх явдлыг гүнзгийрүүлэх, олон улсын байдлыг нийтэд нь эрүүлжүүлэхэд тус дөхөм үзүүлэхийг эрмэлзэн,

Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрмийн зорилго, зарчмыг хэрэгжүүлэхэд хувь нэмрээ оруулахыг мөн эрмэлзэж,

химийн буюу бактериологийн (биологийн) бодисыг ашиглаж хийсэн үй олноор хөнөөх аюулт зэвсгийг үр нөлөөтэй арга хэмжээ авах замаар улс гүрнүүдийн зэвсгийн сангаас хасах нь чухал бөгөөд хойшлуулшгүй гэдэгт итгэл төгс байж,

бактериологийн (биологийн) болон токсины зэвсэг хэрэглэхийг хориглох тухай хэлэлцээр нь химийн зэвсгийг боловсруулах, үйлдвэрлэх, нөөцлөхийг хориглох талаар үр бүтээлтэй арга хэмжээ авах тухай тохиролцоонд хүрэхэд чиглэсэн анхны, боломжтой алхам гэдгийг хүлээн зөвшөөрч, хэлэлцээг эл зорилгоор үргэлжлүүлэх шийдвэр төгс байж,

бактериологийн (биологийн) бодис, токсиныг зэвсэг болгон хэрэглэх боломжийг бүх хүн төрөлхтний тусын тулд бүрэн хаах шийдвэр төгс байж,

ийнхүү хэрэглэх нь хүн төрөлхтний нинжин сэтгэлд харшлах тул уг аюулыг багасгахын төлөө хүч чармайлтаа дайчлах хэрэгтэй гэдэгт итгэн,

дараах зүйлийг хэлэлцэн тохиро:

*I дүгээр зүйл*

Энэхүү конвенцид оролцогч улс бүр хэзээ ч, ямар ч нөхцөлд дараах зүйлийг боловсруулахгүй, үйлдвэрлэхгүй, нөөцлөхгүй буюу өөр ямар нэгэн аргаар олж авахгүй буюу хадгалахгүй байх үүрэг хүлээнэ:

(1) гарал үүсэл, үйлдвэрлэсэн аргаас үл хамаарч урьдчилан сэргийлэх, хамгаалах болон энх тайвны бусад зориулалтын бус төрөл, тоо хэмжээний бичил биологийн, биологийн бусад бодис буюу токсин;

(2) ийм бодис, токсиныг дайсагнасан зорилго буюу зэвсэгт мөргөлдөөнд ашиглахад зориулсан зэвсэг, тоног төхөөрөмж, зөөгч хэрэгсэл.

*2 дугаар зүйл*

Энэхүү конвенцид оролцогч улс бүр өөрийн эзэмшил, хэргийн харьялал буюу хяналтын дор байгаа энэхүү конвенцийн 1 дүгээр зүйлд заасан бүх бодис, токсин, зэвсэг, тоног төхөөрөмж, зөөгч хэрэгслийг аль болох эрт, гэхдээ энэхүү конвенцийг хүчин төгөлдөр болсноос хойш 9 сараас доошгүй хугацаанд устгах буюу энх тайвны зорилгод сэлгүүлэх үүрэг хүлээнэ. Энэ зүйлийн заалтыг хэрэгжүүлэхдээ хүн ам, хүрээлэн буй орчныг хамгаалах зорилгоор урьдчилан сэргийлэх зайлшгүй бүх арга хэмжээг авбал зохино.

*3 дугаар зүйл*

Энэхүү конвенцид оролцогч улс бүр Конвенцийн 1 дүгээр зүйлд заасан бодис, токсин, зэвсэг, тоног төхөөрөмж, зөөгч хэрэгслийг шууд буюу шууд бусаар хэнд ч шилжүүлэхгүй байх, аливаа улс, хэсэг улс, олон улсын байгууллагаас тэдгээрийг үйлдвэрлэх буюу аливаа аргаар олж авахад нь хэрхэвч туслах, өөгшүүлэх буюу өдөөхгүй байх үүрэг хүлээнэ.

*4 дүгээр зүйл*

Энэхүү конвенцид оролцогч улс бүр Конвенцийн 1 дүгээр зүйлд заасан бодис, токсин, зэвсэг, тоног төхөөрөмж, зөөгч хэрэгслийг боловсруулах, үйлдвэрлэх, нөөцлөх, олж авах буюу хадгалахыг хориглох, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх шаардлагатай арга хэмжээг өөрийн нутаг дэвсгэр, хэргийн харьялал буюу хяналтандaa байгаа аливаа газарт үндсэн хуулиараа тогтоосон журмын дагуу авах үүрэг хүлээнэ.

*5 дугаар зүйл*

Энэхүү конвенцид оролцогч улсууд энэхүү конвенцийн зорилго, эсхүл түүний заалтыг биелүүлэхтэй холбогдон гарч болох аливаа асуудлыг шийдвэрлэхдээ харилцан зөвлөлдөж, хамтран ажиллах үүрэг хүлээнэ. Түүнчлэн энэхүү заалтыг биелүүлэх зөвлөлдөөн болон хамтын ажиллагааг Нэгдсэн Үндэстний Байгууллага болон түүний дүрмийн хүрээнд олон улсын зоих журмын дагуу хэрэгжүүлж болно.

*6 дугаар зүйл*

(1) Энэхүү конвенцид оролцогч бусад улс уг конвенцийн заалтын дагуу хүлээсэн үүргээ зөрчиж байгааг энэхүү конвенцид оролцогч аливаа улс тогтоовол Нэгдсэн Үндэстний Байгууллагын Аюулгүйн Зөвлөлд гомдол гаргаж болно. Тухайн гомдолд түүний үндэслэлийг батлах боломжтой бүх нотолгоо болон уг гомдлыг Аюулгүйн Зөвлөлөөр хэлэлцүүлэх хүсэлтийг тусгана.

(2) Конвенцид оролцогч улс бүр Зөвлөлийн хүлээж авсан гомдлыг үндэслэн Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрмийн дагуу Аюулгүйн Зөвлөлөөс санаачилж болох аливаа мөрдөн байцаалт явуулахад хамтран ажиллах үүрэг хүлээнэ. Аюулгүйн Зөвлөл нь мөрдөн байцаалтын дүнг энэхүү конвенцид оролцогч улсуудад мэдээлнэ.

*7 дугаар зүйл*

Хэрэв Аюулгүйн Зөвлөл тусламж дэмжлэг хүсч буй энэхүү конвенцид оролцогч аливаа улсад энэхүү конвенцийг зөрчсөний улмаас аюул учирсан гэж шийдвэрлэсэн

бол Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрмийн дагуу тухайн улсад тусламж, дэмжлэг үзүүлэх үүргийг энэхүү конвенцид оролцогч улс бүр хүлээнэ.

*8 дугаар зүйл*

Амьсгал боогдуулагч, хортой буюу ижил төстэй бусад хийн болон бактериологийн зэвсгийг дайнд хэрэглэхийг хориглох тухай Женев хотноо 1925 оны 6 дугаар сарын 17-ны өдөр гарын үсэг зурсан протоколын дагуу аливаа улсын хүлээсэн үүргийг энэхүү конвенцийн аль ч заалтыг ямар нэг хэмжээгээр хязгаарласан буюу үгүйсгэсэн мэтээр тайлбарлаж хэрхэвч болохгүй.

*9 дүгээр зүйл*

Химиин зэвсгийг үр дүнтэй хориглох хүлээн зөвшөөрөгдсөн зорилгыг энэхүү конвенцид оролцогч улс бүр нотолж эл зорилгоор химиин зэвсгийг боловсруулах, үйлдвэрлэх, нөөцлөхийг хориглож тэдгээрийг устгах үр дүнтэй арга хэмжээ авах болон химиин бодисыг зэвсэг болгон үйлдвэрлэх буюу ашиглахад тусгайлан зориулсан тоног төхөөрөмж, зөөгч хэрэгслийн талаар зохих арга хэмжээ авах талаар аль болох эрт тохиролцох зорилгоор сайн дураар хэлэлцээгээ үргэлжлүүлэх үүрэг хүлээнэ.

*10 дугаар зүйл*

(1) Энэхүү конвенцид оролцогч улсууд бактериологийн (биологийн) бодис, токсиныг энх тайвны зорилгод хэрэглэх зорилгоор тоног төхөөрөмж, материал, шинжлэх ухаан, техникийн мэдээллийг аль болох өргөн хэмжээнд солилцоход тус дөхөм үзүүлэх үүрэг хүлээн бөгөөд тийм солилцоонд оролцох эрхтэй. Конвенцид оролцогч улсууд хэрэв шаардлагатай гэж үзвэл бактериологийн (биологийн) салбар дахь шинжлэх ухааны нээлтийг цаашид хөгжүүлэх, өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх зэрэг энх тайвны зорилгод ашиглахад хувь нэмрээ дангаараа оруулах буюу бусад улс, олон улсын байгууллагатай энэ талаар хамтран ажиллана.

(2) Энэхүү конвенцийг түүнд оролцогч улсуудын эдийн засаг, техникийн хөгжил, эсхүл бактериологийн (биологийн) энх тайвны үйл ажиллагааны салбар дахь олон улсын хамтын ажиллагаанд, тухайлбал бактериологийн (биологийн) хэрэгсэл, токсин, тоног төхөөрөмжийг энэхүү конвенцийн заалтын дагуу энх тайвны зорилгоор боловсруулах, ашиглах, үйлдвэрлэхэд зориулсан олон улсын хамтын ажиллагаанд саад тогтор учруулахаас зайлсхийх хэлбэрээр хэрэгжүүлнэ.

*11 дүгээр зүйл*

Энэхүү конвенцид оролцогч аль ч улс энэхүү конвенцид нэмэлт өөрчлөлт оруулах санал гаргаж болно. Энэхүү конвенцид оролцогч улсуудын олонхи нь нэмэлт өөрчлөлтийг хүлээн зөвшөөрсний дараа түүнийг хүлээн зөвшөөрсөн оролцогч улс бүрийн хувьд хүчин төгөлдөр болох бөгөөд харин үлдсэн оролцогч улс бүрийн хувьд тухайн нэмэлт өөрчлөлтийг хүлээн зөвшөөрсөн өдрөөс хүчин төгөлдөр болно.

*12 дугаар зүйл*

Энэхүү конвенц хүчин төгөлдөр болсноос хойш 5 жилийн дараа, эсхүл түүнд оролцогч улсуудын олонхи нь энэхүү конвенцийн эхийг хадгалагч засгийн газруудад энэ зорилгоор санал тавибал дурдсан хугацаанаас өмнө энэхүү конвенц хэрхэн үйлчилж байгааг хэлэлцэх, энэхүү конвенцийн удиртгалд заасан зорилт, энэхүү конвенцийн заалтууд, тэдгээрийн дотор химиин зэвсгийн талаар хэлэлцээ хийх тухай

заалт хэрэгжиж байгаад итгэл төгс байх үүднээс Швейцарийн Женев хотноо энэхүү конвенцид оролцогч улсуудын бага хурлыг зарлан хуралдуулна. Ийнхүү хэлэлцэх үед энэхүү конвенцид хамаарах шинжлэх ухаан-техникийн бүх шинэ ололтыг анхаарч үзнэ.

*13 дугаар зүйл*

(1) Энэхүү конвенц нь хугацаагүйгээр үйлчилнэ.

(2) Энэхүү конвенцид оролцогч улс бүр энэхүү конвенцийн агуулгатай холбогдсон онцгой нөхцөл байдал нь тухайн орны эрхэм дээд ашиг сонирхолд аюул учруулсан гэж үзвэл улсынхаа бүрэн эрхийг хэрэгжүүлэх журмаар энэхүү конвенциос гарах эрхтэй. Тухайн улс энэхүү конвенциос гарах тухайгаа Конвенцид оролцогч бүх улс болон Нэгдсэн Үндэстний Байгууллагын Аюулгүйн Зөвлөлд гурван сарын өмнө мэдэгдэнэ. Уг мэдэгдэлд тухайн орны эрхэм дээд ашиг сонирхолд аюул учруулсан гэж үзэж байгаа онцгой нөхцөл байдлын тухай мэдэгдлийг тусгана.

*14 дүгээр зүйл*

(1) Энэхүү конвенц бүх улс гарын үсэг зурахад нээлттэй байна. Энэхүү конвенц энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу хүчин төгөлдөр болохоос өмнө гарын үсэг зураагүй аливаа улс түүнд аль ч үед нэгдэн орж болно.

(2) Энэхүү конвенцид гарын үсэг зурсан улсууд түүнийг соёрхон батална. Соёрхон батласан батламж жуух бичиг болон нэгдэн орсон тухай баримт бичгийг үүгээр эх хадгалагч засгийн газраар томилогдсон Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улс, Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улс, Америкийн Нэгдсэн Улсын засгийн газарт хадгалуулахаар хүргүүлнэ.

(3) Энэхүү конвенц нь Конвенцийн эх хадгалагчаар томилогдсон засгийн газруудыг оролцуулан хорин хоёр засгийн газар соёрхон батласан батламж жуух бичгээ хадгалуулахаар өгсний дараа хүчин төгөлдөр болно.

(4) Энэхүү конвенц хүчин төгөлдөр болсны дараа соёрхон батласан батламж жуух бичиг болон нэгдэн орсон тухай баримт бичгээ хадгалуулахаар өгөх улсын хувьд энэхүү конвенц соёрхон батласан батламж жуух бичиг, нэгдэн орсон тухай баримт бичгээ хадгалуулахаар өгсөн өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

(5) Энэхүү конвенцийн эх хадгалагч засгийн газрууд нь улс тус бүрийн гарын үсэг зурсан огноо, соёрхон батласан батламж жуух бичиг болон нэгдэн орсон тухай баримт бичгээ хадгалуулсан огноо, энэхүү конвенц хүчин төгөлдөр болсон огноо, түүнчлэн бусад мэдэгдэл хүлээн авсан тухайгаа энэхүү конвенцид гарын үсэг зурсан болон нэгдэн орсон улсуудад нэн даруй мэдэгдэж байна.

(6) Энэхүү конвенцийг эх хадгалагч засгийн газрууд Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрмийн 102 дугаар зүйлийн дагуу бүртгүүлнэ.

*15 дугаар зүйл*

Англи, испани, орос, франц, хятад хэлээр үйлдсэн эх бичвэрүүд нь адил хүчинтэй байх энэхүү конвенцийг эх хадгалагч засгийн газруудын архивт хадгалуулна.

Эх хадгалагч засгийн газрууд энэхүү конвенцийн зохих хэлбэрээр баталгаажуулсан хуулбарыг энэхүү конвенцид гарын үсэг зурсан болон түүнд нэгдэн орсон улсуудын засгийн газарт хүргүүлнэ.

Дээр дурдсаныг нотолж зохих ёсоор олгосон бүрэн эрх бүхий төлөөлөгчид энэхүү конвенцид гарын үсэг зурав.

Нэг мянга есөн зуун далан хоёр оны дөрөвдүгээр сарын аравны өдөр Москва, Вашингтон, Лондон хотноо гурван эх хувь үйлдэв.

**98. ҮЛЭМЖ ХОХИРОЛ УЧРУУЛАХ БУЮУ НЭЛД НЬ ХӨНӨӨХ  
ЧАНАРТАЙД ТООЦОГДОХ ТОДОРХОЙ ТӨРЛИЙН ЕРДИЙН ЗЭВСЭГ  
ХЭРЭГЛЭХИЙГ ХОРИГЛОХ БУЮУ ХЯЗГААРЛАХ ТУХАЙ  
КОНВЕНЦ**

*1980 оны 10 дугаар сарын 10-ны өдөр баталжс,  
1983 оны 12 дугаар сарын 2-ны өдөр хүчин төгөлдөр болсон\**

Хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд,

Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрмийн дагуу улс бүр олон улсын харилцаандаа аливаа улсын бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн халдашгүй дархан байдал, улс төрийн тусгаар тогтолын эсрэг буюу Нэгдсэн Үндэстний Байгууллагын зорилгод нийцэхгүй аливаа бусад байдлаар хүч хэрэглэхээр заналхийлэх буюу хэрэглэхээс татгалзах үүрэгтэйг эргэн санаж,

энгийн хүн амыг дайтах ажиллагааны нөлөөнөөс хамгаалах ерөнхий зарчмыг цаашид мөн эргэн санаж,

зэвсэгт мөргөлдөөнд оролцогч тал байлдаан явуулах арга, хэрэгслийг сонгох эрх нь хязгааргүй биш болох тухай олон улсын эрх зүйн зарчим болон үлэмж хохирол учруулах буюу шаардлагагүй зовиурт хүргэх зэвсэг, хэрэгсэл болон материал болон байлдаан явуулах аргыг зэвсэгт мөргөлдөөнд хэрэглэхийг хориглосон зарчмыг үндэс болгож,

түүнчлэн өргөн тархсан, удаан хугацааны болон ноцтой хохирол байгаль орчинд учруулахад чиглэсэн буюу учруулж болох байлдааны арга, хэрэгсэл хэрэглэхийг хориглосныг эргэн санаж,

энэхүү конвенц болон түүний хавсралт протоколууд, эсхүл олон улсын бусад хэлэлцээрээр зохицуулаагүй тохиолдолд энгийн хүн ам болон байлдагч нар бүх үед тогтсон заншил, нигүүлсэнгүй ёсны зарчим болон нийгмийн ухамсырын шаардлагаас үүссэн олон улсын эрх зүйн зарчмуудын дагуу хамгаалалтад үлдэх ёстой гэж үздэгээ нотолж,

олон улсын намжмал байдал, зэвсгээр хөөцөлдөхийг зогсоох, улс хооронд итгэлцлийг бий болгох болон энх тайвнаар аж төрөх гэсэн бүх улс түмний хүсэл эрмэлзлийг хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулахыг хүсч,

\* Монгол Улс 1981.04.10-нд гарын үсэг зурж, 1982.06.08-нд соёрхон батласан

олон улсын үр дүнтэй, хатуу хяналтын дор зэвсгийг бүх нийтээр бүрэн хураах үйл хэрэгт дэвшил гаргахад хувь нэмэр оруулж болох бүхий л хүч чармайлтын ач холбогдлыг хүлээн зөвшөөрч,

зэвсэгт мөргөлдөөнд хэрэглэж болох олон улсын эрх зүйн хэм хэмжээг төрөлжүүлэн хуульчлах, дэвшилттэй хөгжүүлэх явдлыг үргэлжлүүлэх шаардлагатайг дахин нотолж,

тодорхой төрлийн ердийн зэвсэг хэрэглэхийг цаашид хориглох буюу хязгаарлахыг хүсч, энэ салбарт хүрсэн эерэг үр дүн нь ийм зэвсэг үйлдвэрлэх, хуримтлуулах болон дэлгэрүүлэхийг эцэс болгох зорилгоор зэвсэг хураах үндсэн хэлэлцээнд дөхөм үзүүлж болно гэж итгэж,

бүх улс, ялангуяа цэргийн салбарыг чухалчилдаг улсуудыг энэхүү конвенц болон түүний хавсралт протоколуудад оролцогч тал болгохыг хүсч байгааг цохон тэмдэглэж,

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблей болон Нэгдсэн Үндэстний Байгууллагын Зэвсэг хураах комисс энэхүү конвенц, түүний хавсралт протоколуудад заасан хориглолт, хязгаарлалтын хүрээг өргөтгөх боломжийн тухай асуудлыг судлах шийдвэр гаргаж болохыг харгалзан,

тодорхой төрлийн ердийн зэвсгийг хэрэглэхийг хориглох буюу хязгаарлах талаар цаашид авах арга хэмжээний тухай асуудлыг Зэвсэг хураах хороо авч хэлэлцэх шийдвэр гаргаж болохыг цаашид харгалзан,

дараах зүйлийг хэлэлцэн тохиро:

*1 дүгээр зүйл*

### **Хэрэглэх хүрээ**

Энэхүү конвенц, түүний хавсралт протоколуудыг Дайнд хэлмэгдэгсдийг хамгаалах тухай 1949 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн Женевийн Конвенцуудын 2 дугаар зүйл, мөн эдгээр конвенцийн I нэмэлт протоколын 1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан аливаа тохиолдолд хэрэглэнэ.

*2 дугаар зүйл*

### **Олон улсын бусад хэлэлцээртэй холбогдох нь**

Энэхүү конвенц буюу түүний хавсралт протоколуудын аль ч заалтыг зэвсэгт мөргөлдөөний үед хэрэглэх олон улсын хүмүүнлэгийн эрх зүйгээр хэлэлцэн тохирогч эрхэм дээд талуудад хүлээлгэсэн бусад үүргийг багасгана гэж тайлбарлаж болохгүй.

*3 дугаар зүйл*

### **Гарын үсэг зурах**

Энэхүү конвенц бүх улсын хувьд Нью-Йорк дахь Нэгдсэн Үндэстний Байгууллагын төв байранд 1981 оны 4 дүгээр сарын 10-аас эхлэн арван хоёр сарын хугацаанд гарын үсэг зурахад нээлттэй байна.

*4 дүгээр зүйл*

**Соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, батлах буюу нэгдэн орох**

1. Энэхүү конвенцид гарын үсэг зурсан улс түүнийг соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх буюу батлана. Энэхүү конвенцид гарын үсэг зураагүй аливаа улс түүнд нэгдэн орж болно.

2. Батламж жуух бичиг, хүлээн зөвшөөрсөн, батласан буюу нэгдэн орсон тухай баримт бичгийг эх хадгалагчид хадгалуулахаар хүргүүлнэ.

3. Энэхүү конвенцийг соёрхон батласан батламж жуух бичиг, хүлээн зөвшөөрсөн, батласан буюу түүнд нэгдэн орсон тухай баримт бичгээ хадгалуулахаар өгөхдөө энэхүү конвенцийн хавсралт хоёр буюу түүнээс илүү протоколыг заавал биелүүлэх зөвшөөрлөө аливаа улс эх хадгалагчид мэдэгдсэн нөхцөлд тухайн улсын хувьд энэхүү конвенцийн хавсралт протоколуудын алийг нь заавал биелүүлэхээр зөвшөөрснөө үзэмжээрээ илэрхийлнэ.

4. Энэхүү конвенцийг соёрхон батласан батламж жуух бичиг, хүлээн зөвшөөрсөн, батласан буюу нэгдэн орсон тухай баримт бичгээ хадгалуулахаар өгсний дараа аливаа улс түүнд холбогдолгүй хавсралт аль ч протоколыг заавал биелүүлэхээр зөвшөөрснөө аль ч үед эх хадгалагчид мэдэгдэж болно.

5. Хэлэлцэн тохирогч эрхэм дээд талаас заавал биелүүлэх аливаа протокол нь оролцогч тухайн талын хувьд энэхүү конвенцийн салшгүй хэсэг байна.

*5 дугаар зүйл*  
**Хүчин төгөлдөр болох**

1. Энэхүү конвенц нь хорь дахь батламж жуух бичиг, хүлээн зөвшөөрсөн, батласан буюу нэгдэн орсон тухай баримт бичгийг хадгалуулахаар өгсөн өдрөөс хойш зургаан сарын дараа хүчин төгөлдөр болно.

2. Хорь дахь батламж жуух бичиг, хүлээн зөвшөөрсөн, батласан буюу нэгдэн орсон тухай баримт бичгийг хадгалуулахаар өгсний дараа батламж жуух бичиг, хүлээн зөвшөөрсөн, батласан буюу нэгдэн орсон тухай баримт бичгээ хадгалуулахаар өгсөн аливаа улсын хувьд батламж жуух бичиг, хүлээн зөвшөөрсөн, батласан буюу нэгдэн орсон тухай баримт бичгээ хадгалуулахаар өгснөөс хойш зургаан сарын дараа хүчин төгөлдөр болно.

3. Энэхүү конвенцийн хавсралт протокол бүр нь энэхүү конвенцийн 4 дүгээр зүйлийн 3 буюу 4 дэх хэсэгт заасны дагуу хорин улс түүнийг заавал биелүүлэхээ зөвшөөрч мэдэгдсэн өдрөөс хойш зургаан сарын дараа хүчин төгөлдөр болно.

4. Хорин улс энэхүү конвенцийн хавсралт протоколыг заавал биелүүлэхээ зөвшөөрч мэдэгдсэн өдрөөс хойш түүнийг заавал биелүүлэхээ зөвшөөрснөө мэдэгдсэн аливаа улсын хувьд ийнхүү зөвшөөрснөө мэдэгдсэнээс хойш зургаан сарын дараа тухайн протокол нь хүчин төгөлдөр болно.

*6 дугаар зүйл*

**Түгээн сурталчлах**

Хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд энэхүү конвенц болон заавал биелүүлэх хавсралт протоколуудыг өөрийн оронд аль болох өргөнөөр түгээн сурталчлах, тухайлбал эдгээр баримт бичгийг зэвсэгт хүчиндээ таниулах үүднээс тэдгээрийг цэргийн сургалтын хөтөлбөрт оруулах үүргийг зэвсэгт мөргөлдөөний үед болон тайван цагт хүлээнэ.

*7 дугаар зүйл*

**Энэхүү конвенц хүчин төгөлдөр болсны  
дараахь гэрээ эрхийн харилцаа**

1. Хэрэв мөргөлдөөнд оролцогч талуудын аль нэг нь аливаа хавсралт протоколыг заавал биелүүлдэггүй бол энэхүү конвенц болон түүний хавсралт протоколыг заавал биелүүлдэг талууд тэдгээрийг өөр хоорондын харилцаандаа заавал биелүүлнэ.

2. Энэхүү конвенцид оролцогч биш тал буюу түүний хавсралт холбогдох протоколыг заавал биелүүлдэггүй боловч энэхүү конвенц буюу холбогдох протоколыг хэрэв хүлээн зөвшөөрч, хэрэглэж байгаа болон энэ тухай эх хадгалагчид мэдэгдсэн улсын хувьд аливаа хэлэлцэн тохирогч эрхэм дээд тал өөрийнх нь хувьд хүчин төгөлдөр болсон энэхүү конвенц болон түүний аливаа хавсралт протоколыг 1 дүгээр зүйлд заасан аль ч нөхцөлд заавал биелүүлнэ.

3. Эх хадгалагч нь энэ зүйлийн 2 дахь хэсгийн дагуу хүлээн авсан аливаа мэдэгдлийг хэлэлцэн тохирогч эрхэм дээд холбогдох талуудад нэн даруй мэдэгдэж байна.

4. Хэлэлцэн тохирогч эрхэм дээд талаас заавал биелүүлэх энэхүү конвенц болон түүний хавсралт протоколуудыг хэлэлцэн тохирогч эрхэм дээд тухайн талын эсрэг чиглэсэн Дайнд хэлмэгдэгчдийг хамгаалах тухай 1949 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн Женевийн Конвенцуудын I нэмэлт протоколын 1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан зэвсэгт мөргөлдөөний дараахь нөхцөлд хэрэглэнэ:

а) хэлэлцэн тохирогч эрхэм дээд тал нь I нэмэлт протоколд оролцогч тал байх буюу энэхүү протоколын 3 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан эрх бүхий байгууллага нь дурдсан протоколын 96 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн дагуу Женевийн Конвенцууд болон I нэмэлт протоколыг хэрэглэх үүрэг хүлээсэн, мөн тухайн мөргөлдөөний хувьд энэхүү конвенц болон холбогдох хавсралт протоколуудыг хэрэглэх үүрэг хүлээсэн бол; эсхүл

б) хэлэлцэн тохирогч эрхэм дээд тал нь I протоколд оролцогч бус тал байх буюу дээрх (а) дэд хэсэгт дурдсантай ижил төрлийн эрх бүхий байгууллага нь тухайн мөргөлдөөний хувьд Женевийн Конвенцууд, мөн энэхүү конвенц болон холбогдох хавсралт протоколуудыг хүлээн зөвшөөрч хэрэглэхээр бол ийнхүү хүлээн зөвшөөрч хэрэглэх нь тухайн мөргөлдөөний хувьд дор дурдсан нөлөө үзүүлнэ:

- (i) Женевийн Конвенцууд, мөн энэхүү конвенц болон түүний хавсралт холбогдох протоколууд нь уг мөргөлдөөнд оролцогч талуудын хувьд нэн даруй хүчин төгөлдөр болно;
- (ii) дээр дурдсан эрх бүхий байгууллага нь Женевийн Конвенцууд, мөн энэхүү конвенц болон түүний хавсралт холбогдох протоколуудын хэлэлцэн тохирогч эрхэм дээд талын хүлээсэн эрх үүрэгтэй нэгэн адил эрх үүрэгтэй байх;
- (iii) мөргөлдөөнд оролцогч бүх тал Женевийн Конвенцууд, мөн энэхүү конвенц болон түүний хавсралт холбогдох протоколуудыг нэгэн адил заавал биелүүлнэ.

Хэлэлцэн тохирогч эрхэм дээд тал болон эрх бүхий байгууллага нь Женевийн конвенцийн I нэмэлт протоколын дагуу хүлээх үүргийг харилцан адил байх үндсэн дээр хүлээн зөвшөөрч хэрэглэж болно.

#### 8 дугаар зүйл

#### Хянаж үзэх, нэмэлт өөрчлөлт оруулах

1. а) Энэхүү конвенц хүчин төгөлдөр болсноос хойш хэлэлцэн тохирогч эрхэм дээд аливаа тал энэхүү конвенц болон өөрийнх нь хувьд заавал биелэгдэх хавсралт протоколд нэмэлт өөрчлөлт оруулах санал аль ч үед тавьж болно. Нэмэлт өөрчлөлт оруулах аливаа саналыг эх хадгалагчид хүргүүлэх бөгөөд тэрбээр энэ тухай хэлэлцэн тохирогч бүх талд мэдэгдэж, уг саналыг хэлэлцэх зорилгоор бага хурал хуралдуулах эсэхээр тэдний саналыг авна. Хэрэв хэлэлцэн тохирогч эрхэм дээд талуудын олонх нь болох арван наймаас доошгүй хэлэлцэн тохирогч тал зөвшөөрвөл эх хадгалагч бага хурлыг цаг алдалгүй зарлан хуралдуулж хэлэлцэн тохирогч эрхэм дээд бүх талыг урина. Энэхүү конвенцид оролцогч тал бус улсыг уг бага хуралд ажиглагчаар оролцохыг урина.

б) Энэхүү конвенцид оруулах нэмэлт өөрчлөлтийг гагцхүү хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд баталж, түүний хавсралт аливаа тодорхой протоколд оруулах нэмэлт өөрчлөлтийг гагцхүү уг протоколыг заавал биелүүлэх хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд тус тус батлах нөхцлөөр л уг бага хурал тухайн нэмэлт өөрчлөлтийг хэлэлцэж энэхүү конвенц болон түүний хавсралт протоколуудын адилаар баталж, хүчин төгөлдөр болгож болно.

2. а) Энэхүү конвенц хүчин төгөлдөр болсноос хойш хэлэлцэн тохирогч эрхэм дээд аливаа тал хавсралт протоколуудад тусгагдаагүй ердийн зэвсгийн бусад төрлийн талаар нэмэлт протокол байгуулах санал аль ч үед тавьж болно. Нэмэлт протокол байгуулах аливаа саналыг эх хадгалагчид хүргүүлж, тэрбээр энэ тухай 1 дэх хэсгийн (а) дэд хэсэгт заасны дагуу хэлэлцэн тохирогч эрхэм дээд бүх талд мэдэгдэнэ. Хэрэв хэлэлцэн тохирогч эрхэм дээд талуудын олонхи нь болох арван наймаас доошгүй хэлэлцэн тохирогч тал зөвшөөрвөл эх хадгалагч бага хурлыг нэн даруй зарлан хуралдуулж хэлэлцэн тохирогч эрхэм дээд бүх талыг урина.

б) Бүх улс бүрэн оролцсон ийм бага хурал нэмэлт протоколуудыг энэхүү конвенцийг баталсны адилаар баталж, түүнд хавсарган, энэхүү конвенцийн 5 дугаар зүйлийн 3, 4 дэх хэсэгт заасны дагуу хүчин төгөлдөр болгоно.

3. а) Энэхүү конвенц хүчин төгөлдөр болсноос хойш арван жилийн хугацаанд энэ зүйлийн 1 дэх хэсгийн (а) буюу 2 дахь хэсгийн (а) дэд хэсгийн дагуу бага хурал хуралдаагүй бол хэлэлцэн тохирогч эрхэм дээд аливаа тал энэхүү конвенц болон түүний хавсралт протоколуудын үйлчлэх хүрээ, үйлчлэл болон энэхүү конвенц, түүний хавсралт протоколуудад нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг хянаж үзэх зорилгоор хэлэлцэн тохирогч эрхэм дээд бүх талыг урьсан бага хурлыг зарлан хуралдуулах хүсэлтийг эх хадгалагчид гаргаж болно. Энэхүү конвенцид оролцогч тал бус улсыг уг бага хуралд ажиглагчаар оролцуулахаар урина. Бага хурлаар дээрх 1 дэх хэсгийн (б) дэд хэсгийн дагуу батлагдаж, хүчин төгөлдөр болох нэмэлт өөрчлөлтийг хэлэлцэж болно.

б) Уг бага хурлаар протоколуудад тусгагдаагүй ердийн зэвсгийн бусад төрлийн тухай нэмэлт протокол байгуулах аливаа саналыг хэлэлцэж болно. Бага хуралд оролцож байгаа бүх улс тухайн хэлэлцүүлэгт бүрэн хэмжээгээр оролцож болно. Аливаа нэмэлт протоколыг энэхүү конвенцийн адилаар баталж, түүнд хавсарган энэхүү конвенцийн 5 дугаар зүйлийн 3, 4 дэх хэсгийн дагуу хүчин төгөлдөр болгоно.

с) Уг бага хурлаар энэ зүйлийн 3 дахь хэсгийн (а) дэд хэсэгт заасан хугацаанд энэ зүйлийн 1 дэх хэсгийн (а) буюу 2 дахь хэсгийн (а) дэд хэсгийн дагуу бага хурлыг зарлан хуралдуулаагүй тохиолдолд хэлэлцэн тохирогч эрхэм дээд аливаа талын хүсэлтээр цаашид бага хурал зарлан хуралдуулах тухай заалт оруулах эсэх асуудлыг хэлэлцэж болно.

#### *9 дүгээр зүйл*

#### **Цуцлалт**

1. Хэлэлцэн тохирогч эрхэм дээд аливаа тал эх хадгалагчид мэдэгдэж энэхүү конвенц болон түүний хавсралт аливаа протоколыг цуцалж болно.

2. Аливаа ийм цуцлалт нь цуцлах тухай мэдэгдлийг эх хадгалагч хүлээн авснаас хойш нэг жилийн дараа хүчин төгөлдөр болно. Хэрэв энэ хугацаа дуусах үед хэлэлцэн тохирогч эрхэм дээд цуцлагч тал 1 дүгээр зүйл дурдсан аль нэг нөхцөлд байвал тухайн тал зэвсэгт мөргөлдөөн буюу эзлэлт дуусах хүртэл буюу аль ч тохиолдолд зэвсэгт мөргөлдөөнд хэрэглэдэг олон улсын эрх зүйн хэм хэмжээний дагуу хамгаалалтад байдаг хүмүүсийг эцэслэн сулах, эх оронд нь буцаах буюу нөхөн сэргээх ажиллагаа дуустал болон мөн Нэгдсэн Үндэстний Байгууллагын энхийг сахиулах хүчин буюу холбогдох бүсийн төлөөлөгчид энхийг сахиулах ажиллагаа, ажиглалт буюу үүний адил ажиллагаа явуулах нөхцөлийн тухай заалт аливаа хавсралт протоколд тусгагдсан байвал уг ажиллагааг дуустал энэхүү конвенц болон холбогдох хавсралт протоколоор хүлээсэн үргийг заавал биелүүлнэ.

3. Энэхүү конвенцийн цуцлалт нь хэлэлцэн тохирогч эрхэм дээд цуцлагч талын заавал биелүүлэх хавсралт бүх протоколд нэгэн адил хамаарна.

4. Аливаа цуцлалт нь гагцхүү хэлэлцэн тохирогч эрхэм дээд цуцлагч талын хувьд л хүчинтэй байна.

5. Аливаа цуцлалт нь хэлэлцэн тохирогч эрхэм дээд цуцлагч талын хувьд цуцлалт хүчин төгөлдөр болохоос өмнө эхэлсэн зэвсэгт мөргөлдөөнтэй холбогдуулан

хийсэн аливаа үйлдлийн хувьд энэхүү конвенц болон түүний хавсралт протоколуудаар хүлээсэн үүргийг хөндөхгүй.

*10 дугаар зүйл*

**Эх хадгалагч**

1. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга энэхүү конвенц болон түүний хавсралт протоколуудын эх хадгалагч байна.

2. Эх хадгалагч өөрийн ердийн үүргийн сацуу дараахь зүйлийг бүх улсад мэдэгдэнэ:

а) 3 дугаар зүйлийн дагуу энэхүү конвенцид гарын үсэг зурсан тухай;

б) 4 дүгээр зүйлийн дагуу энэхүү конвенцийн соёрхон батласан батламж жуух бичиг, хүлээн зөвшөөрсөн, батласан буюу нэгдэн орсон тухай баримт бичгийг хадгалуулахаар өгсөн тухай;

с) 4 дүгээр зүйлийн дагуу хавсралт протоколуудыг заавал биелүүлэхийг зөвшөөрсөн тухай мэдэгдэл,

д) 5 дугаар зүйлийн дагуу энэхүү конвенц болон түүний хавсралт протокол бүрийн хүчин төгөлдөр болсон өдрийн тухай;

е) 9 дүгээр зүйлийн дагуу цуцлах тухай мэдэгдэл хүлээн авсан болон уг цуцлалт хүчин төгөлдөр болсон өдрийн тухай.

*11 дүгээр зүйл*

**Адил хүчинтэй эх бичвэрүүд**

Араб, хятад, англи, франц, орос, испани хэлээрх эх бичвэр нь адил хүчинтэй энэхүү конвенц болон түүний хавсралт протоколуудын эх хувийг эх хадгалагчид хадгалуулахаар өгч, тэрбээр түүний баталгаат хуулбарыг бүх улсад хүргүүлнэ.

**99. ИЛРҮҮЛЭХ БОЛОМЖГҮЙ ХЭЛТЭРХИЙН  
ТУХАЙ ПРОТОКОЛ (I ПРОТОКОЛ)**

*1980 оны 10 дугаар сарын 10-ны өдөр баталж,  
1983 оны 12 дугаар сарын 2-ны өдөр хүчин төгөлдөр болсон\**

Хүний биед рентгений туяагаар илэрдэггүй хэлтэрхийнүүдээр гэмтэл учруулах үндсэн ажиллагаа бүхий аливаа зэвсгийг хэрэглэхийг хориглоно.

\* Монгол Улс 1981.04.10-нд гарын үсэг зурж, 1982.06.08-нд соёрхон батласан

**100. МИНА, УРХИН МИНА БОЛОН БУСАД ТӨХӨӨРӨМЖ ХЭРЭГЛЭХИЙГ  
ХОРИГЛОХ БУЮУ ХЯЗГААРЛАХ ТУХАЙ ПРОТОКОЛ (II ПРОТОКОЛ)**

*1980 оны 10 дугаар сарын 10-ны өдөр баталжс,  
1983 оны 12 дугаар сарын 2-ны өдөр хүчин төгөлдөр болсон\**

*I дүгээр зүйл  
Материалын хувьд хэрэглэх хүрээ*

Энэхүү протокол нь мина, урхин мина болон энэхүү баримт бичгээр тодорхойлсон бусад төхөөрөмж, түүний дотор эрэг орчмын зуравс, усан зам буюу гол гатлах явдлыг саатуулах зорилгоор хуурай газарт мина тавьж хэрэглэхэд хамаарах бөгөөд харин тэнгис буюу дотоодын усан зам дээр хөлөг онгоцны эсрэг тавьсан минад хамаарахгүй.

*2 дугаар зүйл*

**Тодорхойлолт**

Энэхүү протоколын зорилгоор:

1. "Мина" гэж хүн буюу хөдөлгөөнт хэрэгсэл шууд нөлөөлсөн, ойртсон буюу хүрснээс болж тэсрэх буюу авалцах зориулалт бүхий газрын доор, газрын дээр буюу ойролцоо, эсхүл бусад гадаргад байрлуулсан аливаа байлдааны хэрэгслийг хэлэх бөгөөд "зайнаас тавих мина" гэж артиллер, пуужин, минамёт буюу тэдгээртэй адил төрлийн хэрэгслээр буюу хөлөг онгоцноос хаяж тавьсан дээр тодорхойлсон аливаа миныг хэлнэ.

2. "Урхин мина" гэж хор учруулахгүй мэт зүйлд хүн хүрэх буюу ойртох, эсхүл аюулгүй мэт үйлдэл хийхэд гэнэт ажиллаж үхэлд хүргэх буюу гэмтэл учруулахаар зориулагдсан, зохион бүтээсэн буюу тохируулсан аливаа төхөөрөмж буюу материалыг хэлнэ.

3. "Бусад төхөөрөмж" гэж гар ажиллагаагаар байрлуулж, алсын удирдлагын тусламжтайгаар, эсхүл тодорхой хугацаа өнгөрсний дараа автоматаар ажиллаж үхэлд хүргэх, гэмтэл буюу хохирол учруулах зориулалттай байлдааны хэрэгсэл, төхөөрөмжийг хэлнэ.

4. "Цэргийн объект" гэж шинж төрх, байрлал, зориулалт буюу хэрэглээний хувьд цэргийн үйл ажиллагаанд үр дүнтэй нөлөө үзүүлж бүхэлд нь буюу хэсэгчлэн сөнөөх, эзэлж авах буюу тухайн нөхцөл байдалд саармагжуулах чанар нь цэргийн илэрхий давуу байдал олгох объектуудыг аль нэг хэмжээгээр хамрах аливаа объектыг хэлнэ.

5. "Иргэний объект" гэж цэргийн объект гэж 4 дэх хэсэгт тодорхойлсон цэргийн объектоос бусад объектыг хэлнэ.

6. "Бүртгэл хөтлөх" гэж минын талбай, мина болон урхин минын байрлалыг тогтоох явдлыг хөнгөвчлөх бүх мэдээллийг албан ёсны баримт бичигт бүртгэх

\* Монгол Улс 1981.04.10-нд гарын үсэг зурж, 1982.06.08-нд соёрхон батласан

зорилгоор цуглуулахад зориулсан захиргаа, техникийн чанартай болон биет үйлдлийг хэлнэ.

*3 дугаар зүйл*

**Мина, урхин мина болон бусад төхөөрөмж  
хэрэглэхтэй холбогдсон нийтлэг хязгаарлалтууд**

1. Энэ зүйл нь дор дурдсанд хамаарна:

- a) мина;
- b) урхин мина;
- c) бусад төхөөрөмж.

2. Энэ зүйлд хамаарах зэвсгийг энгийн хүн ам буюу энгийн иргэний эсрэг дайрч довтлох, батлан хамгаалах, эсхүл халдах байдлаар ямар ч нөхцөл байдалд хэрэглэхийг хориглоно.

3. Энэ зүйлд хамаарах зэвсгийг нэлд нь хэрэглэхийг хориглоно. Нэлд нь хэрэглэх гэдэгт зэвсгийг дараах байдлаар байрлуулахыг хэлнэ:

- a) цэргийн бус объектод буюу цэргийн объектыг эсрэг чиглээгүй; буюу
- b) цэргийн тодорхой объектын эсрэг чиглэсэн ажиллагаа явуулах боломжгүй аргаар зөөвөрлөх буюу хэрэгсэл ашиглаж байрлуулсан; эсхүл
- c) санамсаргүй байдлаар энгийн хүн амыг үхэлд хүргэх, энгийн иргэнд гэмтэл учруулах, энгийн иргэний объектод хохирол учруулах буюу эдгээрийн аль алиныг зэрэг учруулж болохуйц, энэ нь цэргийн тодорхой, шууд давуу байдлын хувьд тооцоолж байснаас хэтрэх.

4. Энэ зүйлд хамаарах зэвсгийн нөлөөллөөс энгийн иргэдийг хамгаалах зорилгоор сэргийлэн болгоомжлох бололцоотой бүх арга хэмжээг авна. Сэргийлэн болгоомжлох бололцоотой арга хэмжээ гэж хүмүүнлэгийн болон цэргийн шаардлагыг оролцуулан тухайн үеийн бүх нөхцөл байдлыг харгалзан хэрэглэж байгаа буюу хэрэглэх бололцоотой арга хэмжээг хэлнэ.

*4 дүгээр зүйл*

**Зайнаас тавих минаас бусад мина, урхин мина  
болон бусад төхөөрөмжийг суурин газарт  
хэрэглэхэд хамаарах хязгаарлалт**

1. Энэ зүйл нь дор дурдсанд хамаарна:

- a) зайнаас тавих минаас бусад мина;
- b) урхин мина; болон

с) бусад төхөөрөмж.

2. Энэ зүйлд хамаарах зэвсгийг хуурай замын хүчний хооронд байлдааны ажиллагаа шууд явуулаагүй буюу зайлшгүй гэж үзэхгүй бол аливаа хот, суурин, тосгон, эсхүл ижил хэмжээний энгийн иргэд төвлөрсөн бусад бүсэд дараахь аль нэг тохиолдоос бусад үед хэрэглэхийг хориглоно:

а) эсрэг талын цэргийн объект буюу түүний хяналтад нь орших цэргийн объектонд, эсхүл ойр хэсэгт нь байрлуулсан; эсхүл

б) уг зэвсгийн нөлөөллөөс энгийн иргэдийг хамгаалах арга хэмжээ авсан, тухайлбал, анхааруулах тэмдэг тавьсан, харуул гаргасан, анхааруулж зарласан буюу хаалт тавьсан байх.

#### 5 дугаар зүйл

#### **Зайнаас тавих мина хэрэглэхэд хамаарах хязгаарлалт**

1. Зайнаас тавих миных зөвхөн өөрөө цэргийн объект болох бүс буюу цэргийн объект байрлах бүсэд хэрэглэхээс бусад дараахь тохиолдолд уг төрлийн миных хэрэглэхийг хориглоно:

а) 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн (а)-д заасны дагуу тэдгээрийн байрлалыг нарийвчлан бүртгэсэн; эсхүл

б) ийм мина бүрт өөрийгөө устгах үр дүнтэй механизмыг хэрэглэсэн байх, өөрөөр хэлбэл байлдааны зорилгоор тавьсан мина нь энэ зорилгод зориулагдахаа болих нь урьдчилан мэдэгдэхэд мина ангижруулах буюу түүнийг устгахад зориулагдсан өөрөө ажиллах механизм, эсхүл байлдааны зорилгоор тавьсан мина нь энэ зорилгод зориулагдахаа болиход мина ангижруулах буюу түүнийг устгахад зориулагдсан алсын удирдлагатай механизмыг хэрэглэсэн байх.

2. Боломжгүй нөхцөл байдлаас бусад тохиолдолд энгийн хүн амд хор уршиг учруулж болох зайнаас тавих миных байрлуулах буюу хаяж байрлуулах бүрд үр дүнтэй анхааруулгыг урьдчилж өгнө.

#### 6 дугаар зүйл

#### **Тодорхой төрлийн урхин мина хэрэглэхийг хориглох тухай**

1. Итгэл эвдэх, гэнэтийн довтолгоотой холбогдолтой зэвсэгт мөргөлдөөний үед хэрэглэдэг олон улсын эрх зүйн хэм хэмжээнд нөлөөлөхгүйгээр ямар ч нөхцөлд дараахь зүйлийг хэрэглэхийг хориглоно:

а) тэсрэх бодис агуулахаар тусгайлан зориулагдан зохион бүтээгдэж ойртох буюу хүрэхэд тэсэрч дэлбэрэх хор учруулахааргүй өөр төрлийн эд зүйлсийн хэлбэрээр хийгдсэн аливаа урхин мина; эсхүл

б) аливаа байдлаар дараахь зүйлтэй нэгтгэсэн буюу хамтатгасан урхин мина:

- (i) олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн хамгаалалтын бэлгэ тэмдэг, тэмдэг буюу дохио;
- (ii) өвчтөн, шархтан буюу үхдэл;
- (iii) оршуулгын газар буюу шарил чандарлах газар эсхүл булш;
- (iv) эмнэлгийн багаж, эмнэлгийн тоног төхөөрөмж, эмнэлгийн хэрэгсэл буюу эмнэлгийн тээвэр;
- (v) хүүхдийн тоглоом буюу хүүхэд хооллох, хүүхдийн эрүүл мэнд, ариун цэвэр, хувцас буюу боловсролд тусгайлан зориулсан бусад бага оврын зүйл буюу хүнсний зүйл;
- (vi) хүнсний буюу ундааны зүйл;
- (vii) цэргийн байгууллага, цэргийн байрлал буюу цэргийн нөөцийн агуулахад байгаагаас бусад гал тогооны багаж хэрэгсэл;
- (viii) шашин шүтлэгийн илэрхий шинж чанартай зүйл;
- (ix) ард түмний соёл, оюун санааны өв болсон түүхийн хөшөө дурсгал, урлагийн бүтээл буюу тахилга шүтлэгийн газар;
- (x) амьтан буюу тэдгээрийн цогцос.

2. Хэт хүнд гэмтэл буюу шаардлагагүй өвдөлт гэмтэл учруулахад зориулагдсан аливаа урхин миныг ямар ч нөхцөл байдалд хэрэглэхийг хориглоно.

#### 7 дугаар зүйл

##### **Миний талбай, мина болон урхин минын байрлалыг бүртгэх болон хэвлэн нийтлүүлэх**

1. Мөргөлдөөнд оролцогч талууд дараах зүйлийн байрлалыг бүртгэнэ:

- a) мина тавихаар урьдчилан төлөвлөсөн бүх талбайн байрлал;
- b) урьдчилсан төлөвлөгөөний дагуу урхин миныг өргөн хэмжээгээр хэрэглэсэн бүх бүс.

2. Талууд минын бусад бүх талбай, өөрсдийн тавьсан буюу байрлуулсан мина болон урхин минын байрлалыг бүртгэх явдлыг хангахыг эрмэлзэнэ.

3. Ийм бүх бүртгэлийг талууд хадгалах бөгөөд:

- a) дайтах идэвхтэй ажиллагаа зогссоны дараа цаг алдалгүй:

- (i) тухайн бүртгэлийг ашиглахыг оролцуулан миний талбай, мина болон урхин минын нөлөөллөөс энгийн иргэдийг хамгаалах шаардлагатай болон тохиromжтой бүх арга хэмжээг авна;
- (ii) аль ч талын зэвсэгт хүчин эсрэг талын нутаг дэвсгэрт байрлаагүй тохиолдолд эсрэг талын нутаг дэвсгэр дэх миний талбай, мина болон урхин минын байрлалын тухай өөрсдийн мэдэлд байгаа бүх мэдээллийг

өөр хоорондоо болон Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад өгөх; эсхүл

(iii) эсрэг талын нутаг дэвсгэрээс талууд өөрийн зэвсэгт хүчинг бүрэн гаргасны дараа эсрэг талын нутаг дэвсгэр дэх минын талбай, мина болон урхин минын байрлалын тухай өөрсдийн мэдэлд байгаа бүх мэдээллийг эсрэг талд болон Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад өгнө.

b) Нэгдсэн Үндэстний Байгууллагын энхийг сахиулах хүчин буюу төлөөлөгчид аливаа бүсэд үүрэг гүйцэтгэж байгаа тохиолдолд 8 дугаар зүйлд дурдсан байгууллагад уг зүйлийн дагуу шаардагдах мэдээллийг өгнө.

c) Боломжтой үед хоёр тал харилцан тохиролцсоны дагуу минын талбай, мина болон урхин минын байрлалын тухай мэдээллийг нийтэд зарлах, тухайлбал дайтах ажиллагааг зогсоох асуудлыг зохицуулах хэлэлцээрт энэ тухай заана.

*8 дугаар зүйл*

**Миний талбай, мина болон урхин минын нөлөөллөөс  
Нэгдсэн Үндэстний Байгууллагын энхийг сахиулах хүчин  
болон төлөөлөгчдийг хамгаалах**

1. Нэгдсэн Үндэстний Байгууллагын энхийг сахиулах хүчин буюу төлөөлөгчид аливаа бүсэд энхийг сахиулах, ажиглах буюу үүнтэй ижил төрлийн үүрэг гүйцэтгэж байгаа үед мөргөлдөөнд оролцогч тал бүр тухайн бүсэд Нэгдсэн Үндэстний Байгууллагын энхийг сахиулах хүчин буюу төлөөлөгчдийн тэргүүнийг хүссэн тохиолдолд дараахь зүйлийг боломжийн хэрээр хийнэ:

a) тухайн бүс дэх бүх мина буюу урхин миныг цэвэрлэх буюу аюулгүй болгоно;

b) Нэгдсэн Үндэстний Байгууллагын энхийг сахиулах хүчин буюу төлөөлөгчийн албан үүргээ гүйцэтгэж байх үед минын талбай, мина болон урхин минын нөлөөллөөс хамгаалахад шаардагдаж болох арга хэмжээ авна;

c) тухайн бүс дэх минын талбай, мина болон урхин минын байрлалын тухай уг талд байгаа бүх мэдээллийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын тухайн бүсэд байгаа энхийг сахиулах хүчин буюу төлөөлөгчдийн тэргүүнд өгнө.

2. Нөхцөл байдлыг тогтоох үүрэг бүхий Нэгдсэн Үндэстний Байгууллагын төлөөлөгчид аливаа бүсэд үүргээ гүйцэтгэж байгаа үед холбогдох мөргөлдөөнд оролцогч аливаа тал уг төлөөлөгчдийн бүрэлдэхүүний тооноос шалтгаалж тэдгээрийг зохих ёсоор хамгаалж чадахгүй тохиолдолоос бусад тохиолдолд тухайн төлөөлөгчдийг хамгаалалтаар хангана. Энэ тохиолдолд дурдсан тал тухайн бүс дэх минын талбай, мина болон урхин минын байрлалын тухай өөрийн мэдэлд байгаа мэдээллийг төлөөлөгчдийн тэргүүнд өгнө.

*9 дүгээр зүйл*

**Миний талбай, мина болон урхин миниг цэвэрлэх талаар  
олон улсын хэмжээнд хамтран ажиллах**

Дайтах идэвхтэй ажиллагааг зогссоны дараа мөргөлдөөнд оролцогч талууд мөргөлдөөний үеэр минажуулсан талбай, мина болон урхин миниг цэвэрлэх буюу өөр бусад аргаар аюулгүй болгоход шаардагдах мэдээлэл өгөх, түүнчлэн зохих нөхцөл байдалд хамтын үйл ажиллагаа явуулахыг оролцуулан техникийн болон материалын туслалцаа үзүүлэх тухай өөр хоорондоо, мөн зохих нөхцөлд бусад улс болон олон улсын байгууллагуудтай хэлэлцээр байгуулахыг эрмэлзэнэ.

**МИНА, УРХИН МИНА БОЛОН БУСАД ТӨХӨӨРӨМЖИЙГ  
ХЭРЭГЛЭХИЙГ ХОРИГЛОХ БУЮУ ХЯЗГААРЛАХ  
ТУХАЙ ПРОТОКОЛ (II ПРОТОКОЛ)-ЫН ТЕХНИКИЙН ХАВСРАЛТ**

Протоколын дагуу миний талбай, мина болон урхин минийн байрлалыг бүртгэх үүрэг гарагад дараахь удирдамжийг анхааралд авна:

1. Урьдчилан төлөвлөсөн минийн талбай болон урхин миниг өргөн хэмжээгээр урьдчилан төлөвлөн хэрэглэхийн хувьд:

а) газрын зураг, диаграмм болон бусад бүртгэлийг минийн талбай буюу урхин мина тавьсан бүсийн хязгаарыг заасан байхаар үйлдсэн байна;

б) минийн талбай буюу урхин мина тавьсан бүсийг нэгдсэн цэгийн солбицлын байрлалтай холбон тогтоож, мина буюу урхин мина бүхий бүсийн ойролцоолсон хэмжээг тухайн нэгдсэн цэгтэй холбон минийн талбай буюу урхин мина тавьсан бүсийн байрлалыг тогтооно.

2. Байрлуулсан буюу минажуулсан бусад талбай, мина болон урхин минийн хувьд:

Дээрх 1 дэх хэсэгт дурдсан холбогдох мэдээллийг боломжийн хэрээр минийн талбай, мина болон урхин мина бүхий бүсийг тогтоож болох байдлаар бүртгэнэ.

**101. ШАТААХ ЗЭВСЭГ ХЭРЭГЛЭХИЙГ ХОРИГЛОХ БУЮУ ХЯЗГААРЛАХ ТУХАЙ  
ПРОТОКОЛ (III ПРОТОКОЛ)**

*1980 оны 10 дугаар сарын 10-ны өдөр баталж,  
1983 оны 12 дугаар сарын 2-ны өдөр хүчин төгөлдөр болсон\**

*1 дүгээр зүйл*

**Тодорхойлолт**

Энэхүү протоколын зорилгоор:

\* Монгол Улс 1981.04.10-нд гарын үсэг зурж, 1982.06.08-нд соёрхон батласан

1. "Шатаах зэвсэг" гэж оныилсон байд хүргэсэн бодисын химийн урвалын үр дүнд дөл, дулаан буюу аль алины үйлчилсний улмаас объектод гал гаргах буюу хүнийг түлэх үндсэн зориулалт бүхий аливаа зэвсэг буюу байлдааны хэрэгслийг хэлнэ.

a) шатаах зэвсэг нь дараахь хэлбэрээр, тухайлбал гал харвуул, фугас, сум, пуужин, гранат, мина, бөмбөг болон шатах шингэн агуулсан бусад зүйл байж болно.

b) дараахь зүйл шатаах зэвсэгт хамаарахгүй:

(i) Гэрэлтүүлэх хэрэгсэл, гэрэлт сум, утааны болон дохионы систем зэрэг гэнэтийн тохиолдлоор шатаах үйлчлэл үзүүлж болох хэрэгсэл;

(ii) Шатаах үйлчилгээ нь хүнд түлэгдэл учруулахад тусгайлан зориулагдаагүй боловч хуягт машин, хөлөг онгоц, тоног төхөөрөмж буюу барилга байгууламж зэрэг цэргийн объектын эсрэг хэрэглэдэг хуягт нэвтлэх сум, хэлтэрхий сум, тэсрэх бөмбөг болон үүний ижил давхар үйлчилгээтэй нэвтрэх, тэсрэх эсхүл задран дэлбэрэхийн зэрэгцээ шатаах чадварыг хослуулан үйлчлэх зориулалт бүхий байлдааны хэрэгсэл.

2. "Энгийн хүн амын төвлөрөл" гэж байнга, эсхүл түр хугацааны аль нь болохоос үл хамааран хотын суурин хэсэг, суурин гацаа буюу тосгон, эсхүл дүрвэгсэд буюу нүүлгэж байгаа хүмүүсийн лагерь, хуаран, эсхүл нүүдэлчдийн хэсэгт байдгийн адил аливаа энгийн хүн амын төвлөрөлтийг хэлнэ.

3. "Цэргийн объект" гэж шинж төрх, байрлал, зориулалт буюу хэрэглээний хувьд цэргийн үйл ажиллагаанд үр дүнтэй нөлөө үзүүлж бүхэлд нь буюу хэсэгчлэн сөнөөх, эзэлж авах буюу тухайн нөхцөл байдалд саармагжуулах чанар нь цэргийн илэрхий давуу байдал олгох объектуудыг аль нэг хэмжээгээр хамрах аливаа объектыг хэлнэ.

4. "Иргэний объект" гэж цэргийн объект гэж З дахь хэсэгт тодорхойлсон цэргийн объектоос бусад объектыг хэлнэ.

5. "Сэргийлэн болгоомжлох бололцоотой арга хэмжээ" гэж хүмүүнлэгийн болон цэргийн шаардлагыг оролцуулан тухайн үеийн бүх нөхцөл байдлыг харгалзан хэрэглэж байгаа буюу хэрэглэх бололцоотой арга хэмжээг хэлнэ.

*2 дугаар зүйл*

### **Энгийн хүн ам, энгийн иргэний объектыг хамгаалах**

1. Шатаах зэвсэг хэрэглэн энгийн хүн ам буюу энгийн иргэний объектод ямар ч нөхцөл байдалд халдахыг хориглоно.

2. Агаараар хүргэсэн шатаах зэвсгийг хэрэглэн энгийн хүн ам төвлөрсөн бүсэд орших аливаа цэргийн объектод ямар ч нөхцөл байдалд халдахыг хориглоно.

3. Цэргийн объект нь энгийн хүн амын төвлөрөлтөөс тодорхой тусгаарлагдсан болон цэргийн объектод учрах шатаах нөлөөллийг хязгаарлах аливаа тохиолдолд

санамсаргүй байдлаар энгийн иргэдийг үхэлд хүргэх, гэмтэл учруулах, энгийн иргэний объектод хохирол учруулах явдлыг хамгийн бага хэмжээнд хүргэхэд чиглэсэн сэргийлэн болгоомжлох бололцоотой бүх арга хэмжээг авсан байх тохиолдоос бусад тохиолдолд энгийн хүн ам төвлөрсөн газар байрлуулсан аливаа цэргийн объектыг агаараар тээвэрлээгүй шатаах зэвсэг хэрэглэн халдахыг мөн хориглоно.

4. Байгалийн элементүүд нь байлдагч буюу цэргийн объектыг хучих, нуун халхлах, өнгөлөн далдлахад ашиглагдах буюу өөрсдөө цэргийн объектууд болох тохиолдоос бусад тохиолдолд ой мод буюу ургамлын бусад төрөлд шатаах зэвсэг хэрэглэн халдахыг хориглоно.

## 102. НҮД СОХЛОГЧ ЛАЗЕРИЙН ЗЭВСГИЙН ТУХАЙ ПРОТОКОЛ (IV ПРОТОКОЛ)

*1995 оны 10 дугаар сарын 13-ны өдөр баталж,  
1998 оны 7 дугаар сарын 30-ны өдөр хүчин төгөлдөр болсон\**

### *1 дүгээр зүйл*

Нүдний харааны хэрэгсэл ашигладаггүй хүний харах эрхтэн, өөрөөр хэлбэл хамгаалалтгүй нүд, эсхүл хараа засах үүрэгтэй харах эрхтнийг бүрмөсөн хараагүй болгох зориулалт бүхий лазерын зэвсэгийг зориудаар, эсхүл дайтах ажиллагаанд тусгайлан хэрэглэхийг хориглоно. Хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд ийм зэвсгийг аль ч улсад, аль ч улс бус байгууллагад дамжуулахгүй.

### *2 дугаар зүйл*

Хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд лазерийн систем хэрэглэвэл харааны хэрэгсэл ашигладаггүй хүний харааны эрхтнийг бүрмөсөн хараагүй болгох явдлаас зайлсхийх арга хэмжээ авна. Урьдчилан сэргийлэх тухайн арга хэмжээнд өөрийн зэвсэгт хүчнийг сургах болон бусад практик арга хэмжээ багтана.

### *3 дугаар зүйл*

Тохиолдоор сохрох болон лазерийн системийг дайны зорилгод, түүний дотор харааны тоног төхөөрөмжийн эсрэг хууль ёсоор хэрэглэснээс үүдэн хараагүй болохыг энэхүү протоколоор хориглосон гэж үзэхгүй.

### *4 дүгээр зүйл*

Энэхүү протоколын зорилгод “бүрмөсөн хараагүй болох” гэж эргэж засашгүйгээр хараагүй болсноос эмчлэгдэшгүй хүнд хэмжээгээр тахир дутуу болохыг хэлнэ. Снеллийн хүснэгтээр хоёр нүдийг нь шалгахад харааны хурц нь 20/200-гаас доош болсныг хүнд хэмжээгээр тахир дутуу болсонд тооцно.

\* Монгол Улс 1998.11.16-нд нэгдэн орсон

**103. ХИМИЙН ЗЭВСЭГ БОЛОВСРУУЛАХ, ҮЙЛДВЭРЛЭХ,  
НӨӨЦЛӨХ БОЛОН ХЭРЭГЛЭХИЙГ ХОРИГЛОХ,  
ТҮҮНИЙГ УСТГАХ ТУХАЙ КОНВЕНЦ**

*1993 оны 1 дүгээр сарын 13-ны өдөр баталж,  
1997 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр хүчин төгөлдөр болсон\**

Энэхүү конвенцид оролцогч улсууд,

олон улсын чанд бөгөөд үр дүнтэй хяналтын дор зэвсгийг бүх нийтээр, бүрэн хураах, түүний дотор үй олноор хөнөөх зэвсгийн бүх төрлийг хориглох болон устгах чиглэлд үр дүнтэй дэвшилд хүрэх үүднээс үйл ажиллагаа явуулах шийдвэр төгс байж,

Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрмийн зорилго, зарчмыг хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулахыг хүсч,

Амьсгал боогдуулагч, хортой буюу тэдгээртэй ижил бусад хий болон бактериологийн хэрэгслийг дайнд хэрэглэхийг хориглох тухай 1925 оны 6 дугаар сарын 17-ны өдөр Женев хотноо гарын үсэг зурсан протокол (1925 оны Женевийн протокол)-ын зарчим, зорилгод харшлах бүх үйл ажиллагааг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблей нэг бус удаа буруушааж ирснийг санаж,

1925 оны Женевийн протокол, мөн Лондон, Москва, Вашингтон хотноо 1972 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр гарын үсэг зурсан Бактериологийн (биологийн) болон токсины зэвсэг боловсруулах, үйлдвэрлэх, нөөцлөхийг хориглох болон тэдгээрийг устгах тухай конвенцийн зарчим, зорилго болон дээрх протокол, конвенцийн дагуу хүлээсэн үүргийг энэхүү конвенцид дахин нотолж байгааг хүлээн зөвшөөрч,

Бактериологийн (биологийн) болон токсины зэвсэг боловсруулах, үйлдвэрлэх, нөөцлөхийг хориглох болон тэдгээрийг устгах тухай конвенцийн 9 дүгээр зүйлд тусгагдсан зорилгыг анхаарч,

бүх хүн төрөлхтний ашиг тусын тулд энэхүү конвенцийн заалтуудыг хэрэгжүүлэх замаар химийн зэвсэг хэрэглэх боломжийг бүрмөсөн арилгаж, улмаар 1925 оны Женевийн протоколын дагуу хүлээсэн үүргийг нэмэгдүүлэх шийдвэр төгс байж,

гербицидийг дайны хэрэгсэл болгон ашиглахыг зохих хэлэлцээр болон олон улсын эрх зүйн холбогдох зарчимд хориглосныг хүлээн зөвшөөрч,

химийн шинжлэх ухааны ололт амжилтыг гагцхүү хүн төрөлхтний сайн сайхны төлөө хэрэглэх ёстой хэмээн үзэж,

оролцогч бүх улсын эдийн засаг, технологийн хөгжлийг урагшуулахын тулд энэхүү конвенцоор хориглоогүй зорилгоор химийн бодисын чөлөөт худалдаа явуулах, түүнчлэн химийн үйл ажиллагааны салбарт олон улсад хамтран ажиллах, шинжлэх ухаан, техникийн мэдээлэл солилцоход дэмжлэг үзүүлэхийг хүсч,

химийн зэвсэг боловсруулах, үйлдвэрлэх, олж авах, нөөцлөх, хадгалах, шилжүүлэх болон хэрэглэхийг бүрмөсөн үр дүнтэй хориглох, түүнийг устгах нь эдгээр нийтлэг зорилгод хүрэхэд шаардлагатай алхам мөн гэдэгт итгэж,

\* Монгол Улс 1993.01.14-нд гарын үсэг зурж, 1994.11.17-нд соёрхон батласан

дараахь зүйлийг хэлэлцэн тохирв:

*1 дүгээр зүйл*  
**Нийтлэг үүрэг**

1. Энэхүү конвенцид оролцогч улс бүр дараахь үйл ажиллагааг хэзээ ч ямар ч нөхцөл байдалд явуулахгүй байх үүрэг хүлээнэ:

(a) химийн зэвсэг боловсруулах, үйлдвэрлэх, өөрөөр олж авах, нөөцлөх буюу хадгалах, эсхүл шууд буюу шууд бусаар аливаа этгээдэд шилжүүлэх;

(b) химийн зэвсэг хэрэглэх;

(c) химийн зэвсэг хэрэглэх цэргийн аливаа бэлтгэл ажиллагаа явуулах;

(d) оролцогч улсад энэхүү конвенцоор хориглосон аливаа үйл ажиллагаа явуулахад нь аливаа этгээдэд ямарваа байдлаар туслах, өөгшүүлэн дэмжих, ятган нөлөөлөх.

2. Оролцогч улс бүр өмчилж буюу эзэмшиж байгаа, эсхүл өөрийн хэргийн харьяалал буюу хяналтан дор орших аливаа газарт байрлах химийн зэвсгийг энэхүү конвенцийн заалтад нийцүүлэн устгах үүрэг хүлээнэ.

3. Оролцогч өөр улсын нутаг дэвсгэрт орхисон химийн бүх зэвсгээ оролцогч улс бүр энэхүү конвенцийн заалтад нийцүүлэн устгах үүрэг хүлээнэ.

4. Оролцогч улс бүр өмчилж буюу эзэмшиж байгаа, эсхүл өөрийн хэргийн харьяалал буюу хяналтан дор орших аливаа газарт байрлах химийн зэвсэг үйлдвэрлэх аливаа байгууламжийг энэхүү конвенцийн заалтад нийцүүлэн устгах үүрэг хүлээнэ.

5. Оролцогч улс бүр хэв журам сахиулах зорилгоор хэрэглэдэг бодисыг дайны хэрэгсэл болгон ашиглахгүй байх үүрэг хүлээнэ.

*2 дугаар зүйл*

**Тодорхойлолт, шалгуур нөхцөл**

Энэхүү конвенцийн зорилгод:

1. “Химийн зэвсэг” гэж хамтад нь буюу тус тусад нь дараахь зүйлийг хэлнэ:

(a) төрөл, тоо хэмжээ нь эдгээр зорилгод нийцэж байгаа тохиолдолд энэхүү конвенцоор хориглоогүй зорилгод ашиглахаас бусад химийн хорт бодис болон тэдгээрийн прекурсор;

(b) тийм байлдааны хэрэгсэл, төхөөрөмж ашигласны үр дүнд (a) дэд хэсэгт заасан химийн хорт бодисын хорт шинж ялгарч үхэлд хүргэх буюу бусад гэм хор учруулах тусгай зориулалт бүхий байлдааны хэрэгсэл, төхөөрөмж;

(c) (b) дэд хэсэгт заасан байлдааны хэрэгсэл, төхөөрөмжийг ашиглахтай шууд холбогдуулан хэрэглэх тусгай зориулалт бүхий аливаа тоног төхөөрөмж.

**2. “Химийн хортой бодис” гэж:**

Химиийн үйлчлэлээрээ амьдралын явцад нөлөө үзүүлснээр хүн буюу амьтныг үхэлд хүргэх, чадварыг нь түр алдагдуулах, мөн байнгын гэм хор учруулж болох химиийн аливаа бодисыг хэлнэ. Үүнд гарал үүсэл, эсхүл үйлдвэрлэсэн аргаас үл хамааран, түүнчлэн аливаа байгууламжид, эсхүл байлдааны хэрэгслийн хэлбэрээр, эсхүл аливаа өөр газарт үйлдвэрлэснээс үл хамааран химиийн бүх ийм бодис хамаарна.

(Энэхүү конвенцийг хэрэгжүүлэх зорилгоор, нягтлан шалгах арга хэмжээг хэрэглэхийн тулд танъж тогтоосон химиийн хорт бодисыг Химиийн бодисын тухай хавсралт дахь Жагсаалтуудад тусгасан.)

**3. “Прекурсор” гэж:**

Химиийн хорт бодисыг аливаа аргаар үйлдвэрлэх явцад аль ч шатанд оролцдог химиийн аливаа урвалжийг хэлнэ. Үүнд хоёр буюу олон найрлагат химиийн системийн аливаа гол бүрдүүлэгч бодис хамарагдана.

(Энэхүү Конвенцийг хэрэгжүүлэх зорилгоор нягтлан шалгах арга хэмжээг хэрэглэхийн тулд танъж тогтоосон прекурсорыг Химиийн бодисын тухай хавсралт дахь Жагсаалтуудад тусгасан.)

**4. “Хоёр буюу олон найрлагат системийн гол бүрдүүлэгч бодис” (цаашид “гол бүрдүүлэгч бодис” гэх) гэж:**

Эцсийн бүтээгдэхүүний хорт шинжийг тодорхойлоход хамгийн чухал үүрэг гүйцэтгэж, хоёр буюу олон найрлагат химиийн систем дэх бусад химиийн бодистой урвалд түргэн ордог прекурсорыг хэлнэ.

**5. “Химиийн хуучин зэвсэг” гэж:**

(d) 1925 оноос өмнө үйлдвэрлэсэн химиийн зэвсэг; эсхүл

(e) 1925-аас 1945 оны хооронд үйлдвэрлэсэн бөгөөд химиийн зэвсэг болгон хэрэглэх боломжгүй болох хэмжээнд муудсан химиийн зэвсгийг хэлнэ.

**6. “Орхисон химиийн зэвсэг” гэж:**

Бусад улсын нутаг дэвсгэрт тухайн улсын зөвшөөрөлгүйгээр 1925 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хойш аль нэг улсын орхисон химиийн зэвсэг, түүний дотор химиийн хуучин зэвсгийг хэлнэ.

**7. “Хэв журам сахиулах зорилгоор хэрэглэдэг бодис” гэж:**

Аль нэг жагсаалтад ороогүй, түргэн хугацаанд хүний биеийн мэдрэх эрхтнийг цочроох, эсхүл бие маходийг хямруулж болох бөгөөд уг үйлчлэл нь тухайн нөхцөл дууссаны дараа богино хугацаанд арилдаг химиийн аливаа бодисыг хэлнэ.

**8. “Химиийн зэвсэг үйлдвэрлэх байгууламж” гэж:**

(a) 1946 оны 1 дүгээр 1-ний өдрөөс хойш хэдийд ч зохион бүтээсэн, барьсан буюу ашиглаж байсан аливаа тоног төхөөрөмж, мөн тийм тоног төхөөрөмжийг дараахь байдлаар байрлуулж буй аливаа барилгыг хэлнэ:

(i) химийн бодис үйлдвэрлэх шат (“технологийн эцсийн шат”)-ны тоног төхөөрөмжийн ажиллагааны үед материалын урсгал нь дараахь бодисыг агуулах хэсэг болгож:

(1) Химийн бодисын тухай хавсралтын I жагсаалтад орсон химийн аливаа бодис; эсхүл

(2) Оролцогч улсын нутаг дэвсгэр, эсхүл оролцогч улсын хэргийн харьялал буюу хяналтан дор байгаа аливаа өөр газарт жилд 1 тонноос илүү хэмжээгээр энэхүү конвенцоор хориглоогүй зорилгод хэрэглэгдэггүй боловч химийн зэвсгийн зорилгоор хэрэглэж болох химийн аливаа бусад бодис; эсхүл

(ii) химийн зэвсэг цэнэглэх, түүний дотор *inter alia* I жагсаалтад орсон химийн бодисоор байлдааны хэрэгсэл, төхөөрөмж, хадгалах зориулалт бүхий чингэлгүүдийг цэнэглэх; угсрагдсан байлдааны хоёрлосон хэрэгсэл болон төхөөрөмжийн хэсэг болох чингэлгийг эсхүл угсрагдсан байлдааны ганц хэрэгсэл болон төхөөрөмжийн хэсэг болох химийн дэд хэрэгслийг химийн бодисоор цэнэглэх, мөн чингэлэг болон химийн дэд хэрэгслийг холбогдох байлдааны хэрэгсэл, төхөөрөмж болгон суурилуулах зорилгоор;

(b) Дараахь байгууламжийг хэлэхгүй:

(i) (a)(i) дэд хэсэгт заасан химийн бодисын синтезийн 1 тонноос доош үйлдвэрлэх хүчин чадал бүхий аливаа байгууламж;

(ii) (a)(i) дэд хэсэгт заасан химийн бодис энэхүү конвенцоор хориглоогүй зорилгоор явуулсан үйл ажиллагааны зайлшгүй дагалт бүтээгдэхүүн хэлбэрээр үйлдвэрлэгдэж байгаа буюу байсан аливаа байгууламж, чингэхдээ уг химийн бодис нь нийт бүтээгдэхүүний 3 хувиас хэтрээгүй бөгөөд уг байгууламж нь Хэрэгжүүлэлт болон няглан шалгалтын тухай хавсралт (цаашид “Няглан шалгалтын тухай хавсралт” гэх)-ын дагуу мэдүүлэг, хянан шалгалтанд хамрагдаж байвал зохино; эсхүл

(iii) Няглан шалгалтын тухай хавсралтын VI хэсэгт дурдсанчлан энэхүү конвенцоор хориглоогүй зорилгоор I жагсаалтад оруулсан химийн бодисыг үйлдвэрлэх жижиг хэмжээний ганц байгууламж.

9. “Энэхүү конвенцоор хориглоогүй зорилго” гэж:

(a) аж үйлдвэр, хөдөө аж ахуй, эрдэм шинжилгээ, анагаах ухаан, эм зүй болон энхийн бусад зорилго;

(b) хамгаалах зорилго, тухайлбал, химийн хорт бодисоос хамгаалах болон химийн зэвсгээс хамгаалахтай шууд холбоотой зорилго;

(c) химийн зэвсэг хэрэглэхтэй холбоогүй бөгөөд химийн бодисын хорт шинжийг дайны хэрэгсэл болгон ашиглахаас хамаарахгүй цэргийн зорилго;

(d) хууль хэрэгжүүлэх, түүний дотор дотоодын хэв журам сахиулах зорилго.

10. “Үйлдвэрлэх хүчин чадал” гэж:

Холбогдох байгууламжид хэрэглэгдэж байгаа технологийн процесс, эсхүл уг процесийг хараахан ашиглаагүй байгаа бол ашиглахаар төлөвлөсөн технологийн процесст үндэслэсэн химийн тодорхой нэг бодис бэлтгэх жилийн тоон хүчин чадлыг хэлнэ. Үүнийг номинал хүчин чадалтай, эсхүл хэрэв номинал хүчин чадал нь тодорхойгүй бол төлөвлөсөн хүчин чадалтай тэнцэнэ гэж үзнэ. Номинал хүчин чадал нь нэг буюу хэд хэдэн туршилтаар тухайн үйлдвэрлэх байгууламжид үйлдвэрлэх дээд хэмжээнд тохируулсан нөхцөлд үйлдвэрлэх бүтээгдэхүүний хэмжээ байна. Төлөвлөсөн хүчин чадал нь онолын хувьд тооцоолсон үйлдвэрлэх бүтээгдэхүүний холбогдох хэмжээ байна.

11. “Байгууллага” гэж энэхүү конвенцийн 8 дугаар зүйлийн дагуу байгуулагдсан Химийн зэвсэг хориглох байгууллагыг хэлнэ.

12. 6 дугаар зүйлийн зорилгод:

(а) химийн бодис “үйлдвэрлэх” гэж химийн бодис химийн урвалаар бүрдэхийг хэлнэ;

(б) химийн бодис “боловсруулах” гэж химийн аль нэг бодис химийн өөр бодис болж хувирдаггүй бүрэлдүүлэх, ялгаруулах, цэвэршүүлэх гэх мэт физикийн процессыг хэлнэ;

(с) химийн бодис “хэрэглэх” гэж химийн бодис химийн урвалаар химийн өөр бодис болж хувирахыг хэлнэ.

### *З дугаар зүйл*

#### **Мэдүүлэг**

1. Оролцогч улс бүр энэхүү конвенц тухайн улсын хувьд хүчин төгөлдөр болсноос хойш 30 хоногийн дотор дараах асуудлаар Байгууллагад мэдүүлнэ:

(а) химийн зэвсгийн хувьд:

(i) химийн аливаа зэвсэг өмчилж буюу эзэмшиж байгаа эсэх, эсхүл харьялал буюу хяналтан дор нь орших аливаа газарт байрлуулсан химийн аливаа зэвсэг байгаа эсэхийг мэдүүлнэ;

(ii) (iii) дэд хэсэгт дурдсан химийн зэвсгээс бусад, өөрийн өмчилж буюу эзэмшиж байгаа, эсхүл өөрийн хэргийн харьялал буюу хяналтан доорх аливаа газарт байрлуулсан химийн аливаа зэвсгийн тодорхой байршил, нийт тоо хэмжээ болон нарийвчлан тодорхойлсон бүтцийг Нягтлан шалгалтын тухай хавсралтын IV хэсгийн (A) ангийн 1-ээс 3 дахь хэсэгт нийцүүлэн заах;

(iii) нутаг дэвсгэрт нь өөр улсын өмчилж, эзэмшиж байгаа болон өөр улсын хэргийн харьялал буюу хяналтан доорх аливаа газар байрлуулсан химийн аливаа зэвсгийн талаар Нягтлан шалгалтын тухай хавсралтын IV хэсгийн (A) ангийн 4 дэх хэсэгт нийцүүлэн мэдээлэх;

(iv) Нягтлан шалгалтын тухай хавсралтын IV хэсгийн (A) ангийн 5 дахь хэсэгт нийцүүлэн 1946 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хойш химийн аливаа

зэвсгийг шууд буюу шууд бусаар дамжуулсан буюу хүлээн авсан эсэхээ мэдүүлж, ийм зэвсэг дамжуулсан буюу авсныг заах;

(v) Өөрийн өмчилж буюу эзэмшиж байгаа, эсхүл өөрийн хэргийн харьяалал буюу хяналтан доорх аливаа газарт байрлуулсан химийн зэвсгийг устгах өрөнхий төлөвлөгөөгөө Нягтлан шалгалтын тухай хавсралтын IV хэсгийн (A) ангийн 6 дахь хэсэгт нийцүүлэн бэлтгэж өгөх.

(b) Химийн хуучин зэвсэг болон химийн орхисон зэвсгийн хувьд:

(i) Нягтлан шалгалтын тухай хавсралтын IV хэсгийн (B) ангийн 3 дахь хэсэгт нийцүүлэн нутаг дэвсгэртээ химийн хуучин зэвсэгтэй эсэхээ мэдүүлж, боломжтой бүх мэдээллийг бэлтгэж өгөх;

(ii) Нягтлан шалгалтын тухай хавсралтын IV хэсгийн (B) ангийн 8 дахь хэсэгт нийцүүлэн нутаг дэвсгэрт нь химийн орхисон зэвсэг байгаа эсэхийг мэдүүлж, боломжтой бүх мэдээллийг бэлтгэж өгөх;

(iii) Нягтлан шалгалтын тухай хавсралтын IV хэсгийн (B) ангийн 10 дахь хэсэгт нийцүүлэн өөр улсуудын нутаг дэвсгэрт орхисон химийн зэвсэгтэй эсэхээ мэдүүлж, боломжтой бүх мэдээллийг бэлтгэж өгөх;

(c) химийн зэвсэг үйлдвэрлэх байгууламжийн хувьд:

(i) 1946 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хойшхи аливаа хугацаанд өмчлөл буюу эзэмшилдээ химийн зэвсэг үйлдвэрлэх аливаа байгууламжтай байгаа буюу байсан эсэх, эсхүл өөрийн хэргийн харьяалал буюу хяналтан доорх аливаа газарт тийм байгууламж байрлуулж байгаа буюу байсан эсэхийг мэдүүлэх;

(ii) (iii) дэд хэсэгт дурдсан байгууламжаас бусад, 1946 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хойшхи аливаа хугацаанд өмчлөл буюу эзэмшилд нь байгаа буюу байсан, эсхүл өөрийн хэргийн харьяалал буюу хяналтан доорх аливаа газарт байрлуулж байгаа буюу байсан химийн зэвсэг үйлдвэрлэх аливаа байгууламжийг Нягтлан шалгалтын тухай хавсралтын V хэсгийн 1 дэх хэсэгт нийцүүлэн заах;

(iii) 1946 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хойшхи аливаа хугацаанд нутаг дэвсгэрт нь өөр улсын өмчлөл буюу эзэмшилд байгаа буюу байсан, эсхүл өөр улсын хэргийн харьяалал буюу хяналтан доорх аливаа газарт байрлуулж байгаа буюу байсан химийн зэвсэг үйлдвэрлэх аливаа байгууламжийн талаар Нягтлан шалгалтын тухай хавсралтын V хэсгийн 2 дахь хэсэгт нийцүүлэн мэдээлэх;

(iv) Нягтлан шалгалтын тухай хавсралтын V хэсгийн 3-аас 5 дахь хэсэгт нийцүүлэн 1946 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хойш химийн зэвсэг үйлдвэрлэхээр аливаа тоног төхөөрөмж шууд буюу шууд бусаар дамжуулсан буюу хүлээн авсан эсэхээ мэдүүлж, ийм тоног төхөөрөмж дамжуулсан буюу авсныг заах;

(v) өөрийн өмчилж буюу эзэмшиж байгаа, эсхүл өөрийн хэргийн харьяалал буюу хяналтан доорх аливаа газарт байрлуулсан химийн зэвсэг

үйлдвэрлэх байгууламжийг устгах ерөнхий төлөвлөгөөгөө Нягтлан шалгалтын тухай хавсралтын V хэсгийн 6 дахь хэсэгт нийцүүлэн бэлтгэж өгөх;

(vi) өөрийн өмчилж буюу эзэмшиж байгаа, эсхүл өөрийн хэргийн харьялал буюу хяналтан доорх аливаа газарт байрлуулсан химийн зэвсэг үйлдвэрлэх аливаа байгууламжийг хаахаар авах арга хэмжээг Нягтлан шалгалтын тухай хавсралтын V хэсгийн 1 дэх хэсгийн (i) дэд хэсэгт нийцүүлэн заах;

(vii) өөрийн өмчилж буюу эзэмшиж байгаа, эсхүл өөрийн хэргийн харьялал буюу хяналтан доорх аливаа газарт байрлуулсан химийн зэвсэг үйлдвэрлэх байгууламжийг химийн зэвсэг устгах байгууламж болгон түр хугацаагаар хувиргах ерөнхий төлөвлөгөөгөө Нягтлан шалгалтын тухай хавсралтын V хэсгийн 7 дахь хэсэгт нийцүүлэн бэлтгэж өгөх;

(d) бусад байгууламжийн хувьд:

Өөрийн өмчлөл буюу эзэмшилд байгаа, эсхүл өөрийн хэргийн харьялал буюу хяналтан доорх аливаа газарт байрлуулсан, түүнчлэн голчлон химийн зэвсэг боловсруулах зорилгоор 1946 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хойш зохион бүтээсэн, барысан буюу ашиглаж ирсэн аливаа байгууламж буюу байгууллагын тодорхой байршил, үйл ажиллагааны шинж чанар болон ерөнхий хүрээг заах. Ийм мэдүүлэгт *inter alia* лаборатори, туршилтын болон үнэлгээний талбайг багтаана;

(e) хэв журам сахиулахад хэрэглэдэг бодисын хувьд:

Хэв журам сахиулах зорилгоор эзэмшиж буй химийн бодис бүрийн химийн нэршил, бүтцийн томъёо болон хэрэв тогтоогдсон бол “Химийн бодисын үйлчилгээ” (ХБҮ)-ний бүртгэлийн дугаарыг заах. Ийм мэдүүлгийг аливаа өөрчлөлт хүчин төгөлдөр болсноос хойш 30 хоногийн дотор шинэчилж байна.

2. Энэ зүйлийн заалт болон Нягтлан шалгалтын тухай хавсралтын IV хэсгийн холбогдох заалтуудыг 1977 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс өмнө оролцогч аль нэг улсын нутаг дэвсгэрт булсан бөгөөд булагдсан хэвээр байгаа, мөн 1985 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс өмнө далайд хаясан химийн зэвсгийн хувьд оролцогч тухайн улсын үзэмжээр хэрэглэхгүй.

#### *4 дүгээр зүйл*

#### **Химийн зэвсэг**

1. Нягтлан шалгалтын тухай хавсралтын IV хэсгийн (B) анги хэрэглэгдэж буй химийн хуучин зэвсэг болон химийн орхисон зэвсгээс бусад, оролцогч аль нэг улсын өмчилж буюу эзэмшиж байгаа, эсхүл түүний хэргийн харьялал буюу хяналтан доорх аливаа газарт байрлуулсан химийн бүх зэвсгийн хувьд энэ зүйлийн заалтууд болон түүнийг хэрэгжүүлэх нарийвчилсан журмыг хэрэглэнэ.

2. Энэ зүйлийг хэрэгжүүлэх нарийвчилсан журмыг Нягтлан шалгалтын тухай хавсралтад заасан болно.

3. 1 дэх хэсэгт заасан химийн зэвсгийг хадгалдаг буюу устгадаг бүх газрыг Нягтлан шалгалтын тухай хавсралтын IV хэсгийн (A) ангид нийцүүлэн газар дээр нь

хянан шалгах болон газар дээр нь байрлуулсан багаж хэрэгслээр ажиглан шинжих замаар байнгын нягтлан шалгалтанд хамруулна.

4. Оролцогч улс бүр 3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн (а) дэд хэсгийн дагуу мэдүүлэг өгсний дараа нэн даруй газар дээр нь хянан шалгах замаар байнгын нягтлан шалгалт хийх зорилгоор 1 дэх хэсэгт заасан химийн зэвсэгт хүрэх боломжийг олгоно. Үүний дараа оролцогч улс бүр химийн зэвсэг устгах байгууламжаас бусад газар уруу химийн эдгээр зэвсгийн алиныг ч зайлцуулж болохгүй. Оролцогч улс бүр газар дээр нь байнгын нягтлан шалгалт хийх зорилгоор химийн тийм зэвсэгт хүрэх боломжийг олгоно.

5. Оролцогч улс бүр газар дээр нь хянан шалгах болон газар дээр нь байрлуулсан багаж хэрэгслээр ажиглан шинжих замаар байнгын нягтлан шалгалт хийх зорилгоор өөрийн өмчилж буюу эзэмшиж байгаа, эсхүл өөрийн хэргийн харьялал буюу хяналтан доорх аливаа газарт байрлуулсан химийн зэвсэг устгах аливаа байгууламж болон түүний агуулах талбайд хүрэх боломжийг олгоно.

6. Оролцогч улс бүр 1 дэх хэсэгт заасан химийн бүх зэвсгийг Нягтлан шалгалтын тухай хавсралтын дагуу, устгах талаар тохиролцсон хэмнэл, дараалал (цаашид “устгах журам” гэх)-д нийцүүлэн устгана. Устгах ажиллагааг энэхүү конвенц тухайн улсын хувьд хүчин төгөлдөр болсноос хойш хоёр жилийн дотор эхэлж, энэхүү конвенц хүчин төгөлдөр болсноос хойш 10 жилийн дотор дуусгана. Оролцогч улс химийн ийм зэвсгийг үүнээс хурдан хэмнэлээр устгаж болно.

7. Оролцогч улс бүр:

(а) 1 дэх хэсэгт заасан химийн зэвсгийг устгах нарийвчилсан төлөвлөгөөг устгах ажиллагааны жил бүр эхлэхээс 60 хоногоос багагүй хугацааны өмнө Нягтлан шалгалтын тухай хавсралтын IV хэсгийн (А) ангийн 29 дэх хэсэгт нийцүүлэн бэлтгэж өгнө; нарийвчилсан төлөвлөгөөнд устгах ажиллагааны дараагийн жилд устгах бүх нөөцийг хамааруулна;

(б) 1 дэх хэсэгт заасан дурдсан химийн зэвсгийг устгах төлөвлөгөөний хэрэгжилтийн талаархи мэдүүлгийг устгах ажиллагааны жил бүр дууссанаас хойш 60 хоногийн дотор бэлтгэж өгнө;

(с) 1 дэх хэсэгт заасан химийн бүх зэвсгийг устгасан тухайгаа устгах ажиллагаа дууссанаас хойш 30 хоногийн дотор нотолно.

8. Хэрэв 6 дахь хэсэгт заасан 10 жилийн дотор устгах хугацаанаас хойш аль нэг улс энэхүү конвенцийг соёрхон батласан буюу түүнд нэгдэж орсон бол 1 дэх хэсэгт заасан химийн зэвсгийг аль болох түргэн устгана. Оролцогч ийм улсын хувьд мөрдөж устгах журам болон хатуу нягтлан шалгалтын журмыг Гүйцэтгэх зөвлөл тодорхойлно.

9. Химийн зэвсгийн тухай өгсөн анхны мэдүүлгийн дараа оролцогч улсын илрүүлсэн химийн аливаа зэвсгийн талаар Нягтлан шалгалтын тухай хавсралтын IV хэсгийн (А) ангид нийцүүлэн мэдээлж, уг зэвсгийг хамгаалалтанд авч, устгана.

10. Оролцогч улс бүр химийн зэвсгийг тээвэрлэх, сорыц авах, хадгалах болон устгах явцад хүмүүсийн аюулгүй байдлыг хангах болон байгаль орчныг хамгаалахыг эн тэргүүнд чухалчилна. Оролцогч улс бүр химийн зэвсгийг аюулгүй байдал болон хаягдлын талаархи үндэсний жишигтээ нийцүүлэн тээвэрлэж, сорыц авч, хадгалж, устгана.

11. Өөрийн нутаг дэвсгэрт өөр улсын өмчилж буюу эзэмшиж байгаа, эсхүл өөр улсын хэргийн харьяалал буюу хяналтан доорх аливаа газарт байрлуулсан химийн зэвсэгтэй оролцогч аливаа улс энэхүү конвенц тухайн улсын хувьд хүчин төгөлдөр болсноос хойш нэг жилийн дотор химийн эдгээр зэвсгийг өөрийн нутаг дэвсгэрээс зайлзуулах талаар бүхий л чармайлт гаргана. Хэрэв тэдгээрийг нэг жилийн дотор зайлзуулаагүй бол оролцогч улс нь Байгууллага болон оролцогч бусад улсад хандаж химийн эдгээр зэвсгийг устгахад туслалцаа үзүүлэхийг хүсч болно.

12. Химийн зэвсгийг аюулгүй бөгөөд үр нөлөөтэйгээр устгах арга зүй болон технологийн талаар хоёр талын шугамаар буюу Техникийн нарийн бичгийн дарга нарын газраар дамжуулан мэдээлэл буюу туслалцаа хүсч буй оролцогч бусад улстай хамтран ажиллах үүргийг оролцогч улс бүр хүлээнэ.

13. Энэ зүйл болон Нягтлан шалгалтын тухай хавсралтын IV хэсгийн (A) ангийн дагуу нягтлан шалгах үйл ажиллагаа явуулахдаа Байгууллага нь оролцогч улсуудын хооронд байгуулсан химийн зэвсэг хадгалах болон устгахад нягтлан шалгалт хийх тухай хоёр буюу олон талт хэлэлцээрийг шаардлагагүйгээр хувилахаас зайлсхийх арга хэмжээг авч үзнэ.

Эл зорилгоор Гүйцэтгэх зөвлөл нь хоёр болон олон талт ийм хэлэлцээрийн дагуу авах арга хэмжээнд нэмэлт болох арга хэмжээгээр нягтлан шалгалтыг дараахь тохиолдолд хязгаарлахаар шийдвэрлэнэ:

(a) Ийм хэлэлцээрийн нягтлан шалгалтын тухай заалтууд энэ зүйл болон Нягтлан шалгалтын тухай хавсралтын IV хэсгийн (A) ангийн нягтлан шалгалтын тухай заалтуудтай нийцэж байна гэж Гүйцэтгэх зөвлөл үзсэн;

(b) Ийм хэлэлцээрийн хэрэгжилт нь энэхүү конвенцийн холбогдох заалтуудтай нийцэж байгаа гэх хангалттай баталгаа өгч байна гэж Гүйцэтгэх зөвлөл үзсэн;

(c) Тухайн хоёр буюу олон талт хэлэлцээрийн талууд нягтлан шалгалтын үйл ажиллагааныхаа талаар Байгууллагад бүрэн мэдээлж байна гэж Гүйцэтгэх зөвлөл үзсэн.

14. Хэрэв Гүйцэтгэх зөвлөл нь 13 дахь хэсгийн дагуу шийдвэр гаргавал Байгууллага нь хоёр буюу олон талт хэлэлцээрийн хэрэгжилтийг ажиглан шинжих эрхтэй байна.

15. 13 болон 14 дэх хэсгийн аль ч заалт 3 дугаар зүйл, энэ зүйл болон Нягтлан шалгалтын тухай хавсралтын IV хэсгийн (A) ангийн дагуу мэдүүлэг өгөх оролцогч улсын үүргийг хөндөхгүй.

16. Оролцогч улс бүр өөрийн устгах үүрэгтэй химийн зэвсэг үйлдвэрлэх байгууламжийг устгах зардлыг хариуцна. Гүйцэтгэх зөвлөл өөрөөр шийдвэрлээгүй бол оролцогч улс нь мөн химийн эдгээр зэвсгийн хадгалалт болон устгалтыг нягтлан шалгах зардлыг хариуцна. Хэрэв Гүйцэтгэх зөвлөл нь 13 дахь хэсгийн дагуу Байгууллагаас авах нягтлан шалгалтын арга хэмжээг хязгаарлахаар шийдвэрлэвэл Байгууллагаас явуулах нэмэлт нягтлан шалгалтын болон ажиглан шинжих зардлыг 8 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт зааснаар Нэгдсэн Үндэстний Байгууллагын татварын хуваарийн дагуу төлнө.

17. Энэ зүйлийн заалтууд болон Нягтлан шалгалтын тухай хавсралтын IV хэсгийн холбогдох заалтуудыг 1977 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс өмнө оролцогч аль нэг улсын нутаг дэвсгэрт булсан бөгөөд булагдсан хэвээр байгаа, мөн 1985 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс өмнө далайд хаясан химийн зэвсгийн хувьд оролцогч тухайн улсын үзэмжээр хэрэглэхгүй.

*5 дугаар зүйл*

**Химийн зэвсэг үйлдвэрлэх байгууламж**

1. Оролцогч аль нэг улсын өмчилж буюу эзэмшиж байгаа, эсхүл түүний хэргийн харьялал буюу хяналтан доорх аливаа газарт байрлуулсан химийн зэвсэг үйлдвэрлэх аливаа болон бүх байгууламжийн хувьд энэ зүйлийн заалтууд болон түүнийг хэрэгжүүлэх нарийвчилсан журмыг хэрэглэнэ.

2. Энэ зүйлийг хэрэгжүүлэх нарийвчилсан журмыг Нягтлан шалгалтын тухай хавсралтад заасан болно.

3. 1 дэх хэсэгт заасан химийн зэвсэг үйлдвэрлэх бүх байгууламжийг Нягтлан шалгалтын тухай хавсралтын V хэсэгт нийцүүлэн газар дээр нь хянан шалгах болон газар дээр нь байрлуулсан багаж хэрэгслээр ажиглан шинжих замаар байнгын нягтлан шалгалтанд хамруулна.

4. Оролцогч улс бүр химийн зэвсэг үйлдвэрлэх 1 дэх хэсэгт заасан байгууламжид түүнийг хаахад шаардагдахаас бусад бүх үйл ажиллагаа явуулахыг нэн даруй зогсоон.

5. Оролцогч аль ч улс химийн зэвсэг үйлдвэрлэх буюу энэхүү конвенцоор хориглосон аливаа бусад үйл ажиллагаа явуулах зорилгоор химийн зэвсэг үйлдвэрлэх аливаа шинэ байгууламж барьж байгуулахгүй буюу одоо байгаа аливаа байгууламжийг шинэчлэн өөрчлөхгүй.

6. Оролцогч улс бүр 3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн (с) дэд хэсэгт заасны дагуу үйлдэх мэдүүлгийг бэлтгэж өгсний дараа түүнийг байнга нягтлан шалгах зорилгоор газар дээр нь хянан шалгах замаар 1 дэх хэсэгт заасан химийн зэвсэг үйлдвэрлэх байгууламжид нэвтрэхийг нэн даруй зөвшөөрнө.

7. Оролцогч улс бүр:

(а) 1 дэх хэсэгт заасан химийн зэвсэг үйлдвэрлэх бүх байгууламжийг энэхүү конвенц тухайн улсын хувьд хүчин төгөлдөр болсноос хойш 90 хоногийн дотор Нягтлан шалгалтын тухай хавсралтын V хэсэгт нийцүүлэн хааж, энэ тухай мэдэгдэл өгнө;

(б) мөн 1 дэх хэсэгт заасан химийн зэвсэг үйлдвэрлэх байгууламжийг хааснаас хойш тухайн байгууламжийг хаалттай хэвээр байлгаж, хойшид устгах явдлыг хангахын тулд хаасан даруйд газар дээр нь хянан шалгах болон газар дээр нь байрлуулсан багаж хэрэгслээр ажиглан шинжих замаар түүнийг байнга нягтлан шалгах зорилгоор түүнд нэвтрэхийг зөвшөөрнө.

8. Оролцогч улс бүр 1 дэх хэсэгт заасан химийн зэвсэг үйлдвэрлэх байгууламж, холбогдох бусад байгууламж болон тоног төхөөрөмжийг Нягтлан шалгалтын тухай хавсралтын дагуу, устгах талаар тохиролцсон хэмнэл, дараалал (цаашид “устгах

журам” гэх)-д нийцүүлэн устгана. Устгах ажиллагааг энэхүү конвенц тухайн улсын хувьд хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш нэг жилийн дотор эхэлж, энэхүү конвенц хүчин төгөлдөр болсноос хойш 10 жилийн дотор дуусгана. Оролцогч улс эдгээр байгууламжийг үүнээс хурдан хэмнэлээр устгаж болно.

**9. Оролцогч улс бүр:**

(а) 1 дэх хэсэгт заасан химийн зэвсэг үйлдвэрлэх байгууламжийг устгах нарийвчилсан төлөвлөгөөг байгууламж тус бүрийг устгах ажиллагаа эхлэхээс 180 хоногоос багагүй хугацааны өмнө бэлтгэж өгнө;

(б) 1 дэх хэсэгт заасан химийн зэвсэг үйлдвэрлэх бүх байгууламжийг устгах төлөвлөгөөний хэрэгжилтийн талаархи мэдүүлгийг устгах ажиллагааны жил бүр дууссанаас хойш 90 хоногийн дотор жил бүр бэлтгэж өгнө;

(с) 1 дэх хэсэгт заасан химийн зэвсэг үйлдвэрлэх бүх байгууламжийг устгасан тухайгаа устгах ажиллагаа дууссанаас хойш 30 хоногийн дотор нотолно.

10. Хэрэв аль нэг улс 8 дахь хэсэгт заасан 10 жилийн дотор устгах хугацаанаас хойш энэхүү конвенцийг соёрхон батласан буюу түүнд нэгдэж орсон бол 1 дэх хэсэгт заасан химийн зэвсэг үйлдвэрлэх байгууламжийг аль болох түргэн устгана. Оролцогч ийм улсын хувьд мөрдөх устгах журам болон хатуу нягтлан шалгалтын журмыг Гүйцэтгэх зөвлөл тодорхойлно.

11. Оролцогч улс бүр химийн зэвсэг үйлдвэрлэх байгууламжийг устгах явцад хүмүүсийн аюулгүй байдлыг хангах болон байгаль орчныг хамгаалахыг эн тэргүүнд чухалчилна. Оролцогч улс бүр химийн зэвсэг үйлдвэрлэх байгууламжийг аюулгүй байдал болон хаягдлын талаархи үндэсний жишигтээ нийцүүлэн устгана.

12. 1 дэх хэсэгт заасан химийн зэвсэг үйлдвэрлэх байгууламжийг Нягтлан шалгалтын тухай хавсралтын V хэсгийн 18-аас 25 дахь хэсэгт нийцүүлэн химийн зэвсэг устгах зорилгоор түр хугацаагаар хувиргаж болно. Ийнхүү хувиргасан байгууламжийг химийн зэвсэг устгах зорилгоор цаашид ашиглахгүй болмогц, чингэхдээ аливаа тохиолдолд энэхүү конвенц хүчин төгөлдөр болсноос хойш 10 жилийн дотор устгасан байх ёстой.

13. Нэн шаардлагатай онцгой тохиолдолд 1 дэх хэсэгт заасан химийн зэвсэг үйлдвэрлэх байгууламжийг энэхүү конвенцоор хориглоогүй зорилгоор ашиглах зөвшөөрлийг оролцогч улс хүснж болно. Гүйцэтгэх зөвлөлийн зөвлөмжийн дагуу Оролцогч улсуудын бага хурал дээрх хүсэлтийг хүлээн зөвшөөрөх эсэхийг шийдвэрлэж, уг зөвшөөрөл нь Нягтлан шалгалтын тухай хавсралтын V хэсгийн D ангид нийцэх нөхцлийг бүрдүүлнэ.

14. Химийн зэвсэг үйлдвэрлэх байгууламжийг хувиргахдаа түүнийг эргүүлэн өөрчилж химийн зэвсэг үйлдвэрлэх байгууламж болгох боломж нь I жагсаалтад орсон химийн бодисыг ашигладаггүй үйлдвэрлэл, хөдөө аж ахуй, эрдэм шинжилгээ, анагаах ухаан, эм зүй буюу энхийн бусад зорилгоор ашиглах аливаа бусад байгууламжтай харьцуулбал илүүгүй байхаар хувиргана.

15. Хувиргасан бүх байгууламжид Нягтлан шалгалтын тухай хавсралтын V хэсгийн D ангид нийцүүлэн газар дээр нь хянан шалгалт болон газар дээр нь байрлуулсан багаж хэрэгслээр ажиглан шинжих замаар байнгын нягтлан шалгалт хийнэ.

16. Энэ зүйл болон Нягтлан шалгалтын тухай хавсралтын V хэсгийн дагуу нягтлан шалгах үйл ажиллагаа явуулахдаа Байгууллага нь оролцогч улсуудын хооронд байгуулсан химийн зэвсэг хадгалах болон устгахад нягтлан шалгалт хийх тухай хоёр буюу олон талт хэлэлцээрийг шаардлагагүйгээр хувилахаас зайлсхийх арга хэмжээг авч үзнэ.

Эл зорилгоор Гүйцэтгэх зөвлөл нь хоёр болон олон талт ийм хэлэлцээрийн дагуу авах арга хэмжээнд нэмэлт болох арга хэмжээгээр нягтлан шалгалтыг дараахь тохиолдолд хязгаарлахаар шийдвэрлэнэ:

(а) ийм хэлэлцээрийн нягтлан шалгалтын тухай заалтууд энэ зүйл болон Нягтлан шалгалтын тухай хавсралтын V хэсгийн нягтлан шалгалтын тухай заалтуудтай нийцэж байна гэж Гүйцэтгэх зөвлөл үзсэн;

(б) уг хэлэлцээрийн хэрэгжилт нь энэхүү конвенцийн холбогдох заалтуудтай нийцэж байгаа гэх хангалттай баталгаа өгч байна гэж Гүйцэтгэх зөвлөл үзсэн;

(с) тухайн хоёр буюу олон талт хэлэлцээрийн талууд нягтлан шалгалтын үйл ажиллагааныхаа талаар Байгууллагад бүрэн мэдээлж байна гэж Гүйцэтгэх зөвлөл үзсэн.

17. Хэрэв Гүйцэтгэх зөвлөл нь 16 дахь хэсгийн дагуу шийдвэр гаргавал Байгууллага нь хоёр буюу олон талт хэлэлцээрийн хэрэгжилтийг ажиглан шинжих эрхтэй байна.

18. 16 болон 17 дахь хэсгийн аль ч заалт III зүйл, энэ зүйл болон Нягтлан шалгалтын тухай хавсралтын V хэсгийн дагуу мэдүүлэг өгөх оролцогч улсын үүргийг хөндөхгүй.

19. Оролцогч улс бүр өөрийн устгах үүрэгтэй химийн зэвсэг үйлдвэрлэх байгууламжийг устгах зардлыг хариуцна. Гүйцэтгэх зөвлөл өөрөөр шийдвэрлээгүй бол оролцогч улс нь мөн химийн эдгээр зэвсгийн хадгалалт болон устгалтыг нягтлан шалгах зардлыг хариуцна. Хэрэв Гүйцэтгэх зөвлөл нь 16 дахь хэсгийн дагуу Байгууллагаас авах нягтлан шалгалтын арга хэмжээг хязгаарлахаар шийдвэрлэвэл Байгууллагаас явуулах нэмэлт нягтлан шалгалтын болон ажиглан шинжих зардлыг 8 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт зааснаар Нэгдсэн Үндэстний Байгууллагын татварын хуваарийн дагуу төлнө.

#### 6 дугаар зүйл

#### Энэхүү конвенцоор хориглоогүй үйл ажиллагаа

1. Оролцогч улс бүр энэхүү конвенцийн заалтуудыг мөрдөхийн хамт энэхүү конвенцоор хориглоогүй зорилгоор химийн хорт бодис болон түүний прекурсорыг боловсруулах, үйлдвэрлэх, өөрөөр олж авах, хадгалах, дамжуулах, ашиглах эрхтэй байна.

2. Химийн хорт бодис болон түүний прекурсорыг өөрийн нутаг дэвсгэрийн дотор, эсхүл өөрийн хэргийн харьяалал буюу хяналтад байгаа аливаа бусад газарт зөвхөн энэхүү конвенцоор хориглоогүй зорилгоор боловсруулах, үйлдвэрлэх, өөрөөр

олж авах, хадгалах, дамжуулах, ашиглах явдлыг хангахад шаардлагатай арга хэмжээг оролцогч улс бүр авна. Энэ үүднээс, түүнчлэн дээрх үйл ажиллагаа энэхүү конвенцоор хүлээсэн үүрэгт нийцэж буйг нягтлан шалгахын тулд оролцогч улс бүр Химийн бодисын тухай хавсралтын I, II болон III жагсаалтад орсон химийн хорт бодис, түүний прекурсор, химийн эдгээр бодистой холбогдох байгууламж, мөн өөрийн нутаг дэвсгэрт буюу өөрийн хэргийн харьялал буюу хяналтан дор орших аливаа бусад газарт байрласан бөгөөд Нягтлан шалгалтын тухай хавсралтад заасан бусад байгууламжийг Нягтлан шалгалтын тухай хавсралтад заасны дагуу нягтлан шалгалтын арга хэмжээнд хамруулна.

3. Оролцогч улс бүр I жагсаалтад орсон химийн бодис (цаашид “I жагсаалтын химийн бодис” гэх)-ыг Нягтлан шалгалтын тухай хавсралтын VI хэсэгт заасан үйлдвэрлэх, олж авах, хадгалах, дамжуулах, ашиглахтай холбогдох хорионд хамруулна. Оролцогч улс бүр I жагсаалтын химийн бодис болон Нягтлан шалгалтын тухай хавсралтын VI хэсэгт заасан байгууламжийг Нягтлан шалгалтын тухай хавсралтын мөн хэсэгт нийцүүлэн газар дээр нь хянан шалгах болон газар дээр нь байрлуулсан багаж хэрэгслээр ажиглан шинжих замаар хийх байнгын хянан шалгалтанд хамруулна.

4. Оролцогч улс бүр II жагсаалтад орсон химийн бодис (цаашид “II жагсаалтын химийн бодис” гэх) болон Нягтлан шалгалтын тухай хавсралтын VII хэсэгт заасан байгууламжийг Нягтлан шалгалтын тухай хавсралтын мөн хэсэгт нийцүүлэн тоо баримт ажиглан шинжих болон газар дээр нь нягтлан шалгах арга хэмжээнд хамруулна.

5. Оролцогч улс бүр 3 дугаар жагсаалтад орсон химийн бодис (цаашид “III жагсаалтын химийн бодис” гэх) болон Нягтлан шалгалтын тухай хавсралтын VIII хэсэгт заасан байгууламжийг Нягтлан шалгалтын тухай хавсралтын мөн хэсэгт нийцүүлэн тоо баримт ажиглан шинжих болон газар дээр нь нягтлан шалгах арга хэмжээнд хамруулна.

6. Нягтлан шалгалтын тухай хавсралтын IX хэсгийн 22 дахь хэсгийн дагуу Оролцогч улсуудын бага хурал өөрөөр шийдвэрлээгүй бол оролцогч улс бүр Нягтлан шалгалтын тухай хавсралтын IX хэсэгт заасан байгууламжийг Нягтлан шалгалтын тухай хавсралтын мөн хэсэгт нийцүүлэн тоо баримт ажиглан шинжих болон газар дээр нь эцэслэн нягтлан шалгах арга хэмжээнд хамруулна.

7. Оролцогч улс бүр энэхүү конвенц тухайн улсын хувьд хүчин төгөлдөр болсноос хойш 30 хоногийн дотор Нягтлан шалгалтын тухай хавсралтад нийцүүлэн холбогдох химийн бодис болон байгууламжийн талаар анхны мэдүүлэг хийнэ.

8. Оролцогч улс бүр Нягтлан шалгалтын тухай хавсралтад нийцүүлэн холбогдох химийн бодис болон байгууламжийн талаар жил бүр мэдүүлэг хийнэ.

9. Газар дээр нь нягтлан шалгах зорилгоор оролцогч улс бүр Нягтлан шалгалтын тухай хавсралтад заасан шаардлагын дагуу байгууламжид нэвтрэхийг хянан шалгагчдад зөвшөөрнө.

10. Нягтлан шалгах үйл ажиллагаа явуулахдаа Техникийн нарийн бичгийн дарга нарын газар энэхүү конвенцоор хориглоогүй зорилгоор оролцогч улсаас явуулж байгаа химийн үйл ажиллагаанд зүй бусаар хөндлөнгөөс оролцохоос зайлсхийх бөгөөд ялангуяа нууц мэдээллийг хамгаалах тухай хавсралт (цаашид “Нууцлалын тухай хавсралт” гэх)-д тусгасан заалтыг дагаж мөрдөнө.

11. Оролцогч улсуудын эдийн засаг буюу технологийн хөгжил болон энэхүү конвенцоор хориглоогүй зорилгоор явуулж буй химийн үйл ажиллагааны салбар дахь олон улсын хамтын ажиллагаа, түүний дотор энэхүү конвенцоор хориглоогүй зорилгоор химийн бодисыг үйлдвэрлэх, боловсруулах, ашиглах шинжлэх ухаан, техникийн мэдээлэл, химийн бодис, тоног төхөөрөмжийг олон улсын хэмжээнд солилцоход саад учруулахаас зайлсхийх байдлаар энэ зүйлийн заалтыг хэрэгжүүлнэ.

*7 дугаар зүйл*  
**Үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх арга хэмжээ**

**Ерөнхий үүрэг**

1. Оролцогч улс бүр энэхүү конвенцоор хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхэд шаардагдах арга хэмжээг өөрийн хууль тогтоомжид нийцүүлэн авна. Тухайлбал:

(а) Өөрийн нутаг дэвсгэрийн аль ч хэсэгт, эсхүл олон улсын эрх зүйгээр хүлээн зөвшөөрөгдсөн өөрийн хэргийн харьялалд орших аливаа бусад газарт байгаа хувь хүн болон хуулийн этгээдэд энэхүү конвенцоор оролцогч улсын хувьд хориглосон аливаа үйл ажиллагаа явуулахыг хориглоно, түүний дотор тийм үйл ажиллагааны хувьд эрүүгийн хууль тогтоомж гаргана;

(б) Өөрийн хяналтан дор байгаа аливаа газарт энэхүү конвенцоор оролцогч улсын хувьд хориглосон аливаа үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрөхгүй;

(с) өөрийх нь харьят хувь хүний аливаа газарт явуулж буй энэхүү конвенцоор оролцогч улсын хувьд хориглосон аливаа үйл ажиллагаанд (а) дэд хэсгийн дагуу гаргасан эрүүгийн хууль тогтоомжкоо олон улсын эрх зүйд нийцүүлэн хамруулна.

2. Оролцогч улс бүр оролцогч бусад улстай хамтран ажиллаж, 1 дэх хэсгийн дагуу хүлээсэн үүргийг хэрэгжүүлэхийг хөнгөвчлөн дэмжихээр эрх зүйн зохих хэлбэрийн туслалцаа үзүүлнэ.

3. Оролцогч улс бүр энэхүү конвенцоор хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх явцад хүн амын аюулгүй байдлыг хангах, хүрээлэн буй орчныг хамгаалахыг эн тэргүүнд чухалчилж, энэ талаар оролцогч бусад улстай зохих хэлбэрээр хамтран ажиллана.

**Оролцогч улс болон Байгууллага хоорондын харилцаа**

4. Энэхүү конвенцоор хүлээсэн үүргээ биелүүлэхийн тулд оролцогч улс бүр Байгууллага болон оролцогч бусад улстай үр дүнтэй харилцаа холбоотой байх үндэсний зохицуулах төвийн үүрэг гүйцэтгэх Үндэсний албыг томилох буюу байгуулна. Оролцогч улс бүр энэхүү конвенц түүний хувьд хүчин төгөлдөр болох үед Үндэсний албынхаа талаар Байгууллагад мэдэгдэнэ.

5. Оролцогч улс бүр энэхүү конвенцийг хэрэгжүүлэхээр авсан хууль тогтоох болон захиргааны арга хэмжээний талаар Байгууллагад мэдээлнэ.

6. Оролцогч улс бүр энэхүү конвенцийг хэрэгжүүлэхтэй холбогдуулж Байгууллагаас нууц байдлаар хүлээн авч буй мэдээлэл болон тоо баримтыг нууц гэж үзэж, тэдгээрийг ашиглах тусгай журам тогтооно.

Мөн түүнчлэн эдгээр мэдээлэл болон тоо баримтыг гагцхүү энэхүү конвенцийн дагуу олгосон эрх, хүлээсэн үүрэгтэй холбогдуулж Нууцлалын тухай хавсралтад заасан заалтад нийцүүлэн ашиглана.

7. Оролцогч улс бүх чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь Байгууллагатай хамтран ажиллах, тухайлбал, Техникийн нарийн бичгийн дарга нарын газарт тусlamж үзүүлж байх үүргийг хүлээнэ.

*8 дугаар зүйл*

**Байгууллага  
А. Ерөнхий зүйл**

1. Энэхүү конвенцийн зүйл, зорилгод хүрэх, түүний заалтууд, түүний дотор Конвенцийг дагаж мөрдөж байгааг олон улсын түвшинд нягтлан шалгах талаархи заалтын хэрэгжилтийг хангах, мөн оролцогч улсуудын хооронд зөвлөлдөж, хамтран ажиллах зохион байгуулалтын хэлбэрийг бий болгох үүднээс Химиин зэвсэг хориглох байгууллагыг энэхүү конвенцид оролцогч улсууд үүгээр байгуулж байна.

2. Энэхүү конвенцид оролцогч бүх улс Байгууллагын гишүүн байна. Оролцогч аль ч улсыг Байгууллагын гишүүнээс хасахгүй.

3. Байгууллагын төв байр нь Нидерландын Вант Улсын Гаага хотноо байрлана.

4. Байгууллагын бүрэлдэхүүнд багтах байгууллагуудаар Оролцогч улсуудын бага хурал, Гүйцэтгэх зөвлөл болон Техникийн нарийн бичгийн дарга нарын газрыг үүгээр байгуулж байна.

5. Байгууллага энэхүү конвенцид заасан нягтлан шалгах үйл ажиллагаагаа хамгийн түрэмгий бус байдлаар, зорилтоо цаг тухайд нь үр ашигтай биелүүлэхээр явуулна. Байгууллага нь зөвхөн энэхүү конвенцоор хүлээсэн үүрэг хариуцлагаа биелүүлэхэд шаардлагатай мэдээлэл, тоо баримтыг л хүснэ. Байгууллага нь энэхүү конвенцийг хэрэгжүүлэх явцад иргэний болон цэргийн үйл ажиллагаа, байгууламжийн талаар мэдэж авсан мэдээллийн нууцлалыг хамгаалах үүднээс урьдчилан анхаарах бүхий л арга хэмжээг авах бөгөөд ялангуяа Нууцлалын тухай хавсралтад заасан заалтыг дагаж мөрдөнө.

6. Байгууллага нь нягтлан шалгах үйл ажиллагаагаа явуулахдаа шинжлэх ухаан, технологийн ололт амжилтыг ашиглах талаархи арга хэмжээг авч үзнэ.

7. Байгууллагын үйл ажиллагааны зардлыг Нэгдсэн Үндэстний Байгууллага болон энэхүү Байгууллагын гишүүнчлэлийн хоорондох ялгааг харгалzan тохируулсан Нэгдсэн Үндэстний Байгууллагын гишүүний татварын хуваарьт нийцүүлэн 4 болон 5 дугаар зүйлийн заалтын дагуу оролцогч улсууд төлнө. Оролцогч улсуудаас Бэлтгэлийн комисст төлсөн татварыг байнгын төсөвт төлөх татвараас нь зохих хэлбэрээр хасаж тооцно. Байгууллагын төсөв нь захиргааны болон бусад зардал, нягтлан шалгах зардал гэсэн хоёр хэсгээс бүрдэнэ.

8. Байгууллагын гишүүнээс Байгууллагад төлөх татварын өр нь өмнөх бүтэн хоёр жилд түүний төлөх ёстой татварын хэмжээтэй тэнцүү буюу илүү гарсан тохиолдолд уг гишүүн Байгууллагад санал өгөх эрхгүй болно. Гэхдээ тухайн гишүүн

өөрийн нь хяналтаас гадуур нөхцлийн улмаас татвараа төлж чадахгүй байгаа гэж Оролцогч улсуудын бага хурал хүлээн зөвшөөрвөл санал өгөхийг уг гишүүнд зөвшөөрч болно.

**В. Оролцогч улсуудын бага хурал**

**Бүрэлдэхүүн, дэг, шийдвэр гаргах**

9. Оролцогч улсуудын бага хурал (цаашид “Бага хурал” гэх) энэхүү Байгууллагын бүх гишүүнээс бүрдэнэ. Гишүүн бүр Бага хуралд нэг төлөөлөгчтэй байх бөгөөд түүнийг орлогч болон зөвлөх дагалдаж болно.

10. Эх хадгалагч энэхүү конвенц хүчин төгөлдөр болсноос хойш 30 хоногийн дотор Бага хурлын анхдугаар чуулганыг зарлан хуралдуулна.

11. Бага хурал өөрөөр шийдвэрлээгүй бол ээлжит чуулганаа жил бүр хуралдуулна.

12. Бага хурлын ээлжит бус чуулганыг:

(a) Бага хурлын шийдвэрээр;

(b) Гүйцэтгэх зөвлөлийн хүсэлтээр;

(c) аливаа гишүүний хүсэлтээр бөгөөд гишүүдийн гуравны нэг нь дэмжсэнээр; эсхүл

(d) энэхүү конвенцийн үйлчлэлийг хянан үзэх үүднээс 22 дахь хэсэгт нийцүүлэн зарлан хуралдуулна.

(d) дэд хэсэгт зааснаас бусад тохиолдолд ээлжит бус чуулганыг хүсэлтэд өөрөөр заагаагүй бол Техникийн нарийн бичгийн дарга нарын газрын Ерөнхий захирлын хүсэлтийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор зарлан хуралдуулна.

13. Бага хурлыг мөн 15 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт нийцүүлэн Нэмэлт өөрчлөлт оруулах бага хурлын хэлбэрээр зарлан хуралдуулна.

14. Бага хурал өөрөөр шийдвэрлээгүй бол Бага хурлын чуулганыг Байгууллагын байрлаж буй газар зохион явуулна.

15. Бага хурал дэгийн журмаа батална. Ээлжит чуулган бүрийн эхэнд Бага хурал нь дарга болон шаардлагатай байж болох бусад албан тушаалтныг сонгоно. Дараагийн ээлжит чуулганаар шинэ дарга болон бусад албан тушаалтныг сонгох хүртэл тэд албан үүргээ гүйцэтгэнэ.

16. Байгууллагын гишүүдийн олонхи Бага хурлын ирцийг бүрдүүлнэ.

17. Байгууллагын гишүүн бүр Бага хуралд саналын нэг эрхтэй байна.

18. Бага хурал нь Бага хуралд оролцон санал өгч буй гишүүдийн ердийн олонхийн саналаар дэгийн асуудлаар шийдвэр гаргана. Зарчмын асуудлаархи шийдвэрийг аль болох зөвшилцлөөр гаргана. Хэрэв тухайн асуудлыг шийдвэрлэхэд зөвшилцэлд хүрч чадахгүйд хүрвэл дарга аливаа санал хураалтыг 24 цагаар хойшлуулж,

хойшшуулсан энэ хугацаанд зөвшилцөлд хүрэх явцыг хөнгөвчлөн дэмжих талаар бүхий л чармайлт гаргаж, энэ хугацааг дуусахаас өмнө Бага хуралд илтгэнэ. 24 цаг дуусахад зөвшилцөлд хүрээгүй тохиолдолд энэхүү конвенцид өөрөөр заагаагүй бол Бага хуралд оролцон санал өгч буй гишүүдийн гуравны хоёрын саналаар шийдвэр гаргана. Тухайн асуудал зарчмын асуудал мөн эсэх талаар маргаан гарсан тохиолдолд зарчмын асуудлыг шийдвэрлэхэд шаардагдах олонхийн саналаар Бага хурал өөрөөр шийдвэрлээгүй бол түүнийг зарчмын асуудал гэж үзнэ.

**Эрх мэдэл, чиг үүрэг**

19. Бага хурал нь Байгууллагын гол байгууллага байна. Бага хурал нь энэхүү конвенцийн хүрээнд хамрагдах аливаа асуудал, түүний дотор Гүйцэтгэх зөвлөл болон Техникийн нарийн бичгийн дарга нарын газрын эрх мэдэл, чиг үүрэгт хамаарах асуудлыг авч хэлэлцэнэ. Бага хурал нь аль нэг оролцогч улсаас дэвшүүлсэн буюу Гүйцэтгэх зөвлөлөөс түүний анхааралд өргөн мэдүүлсэн энэхүү конвенцид хамаарах аливаа асуудлаар зөвлөмж өгч, шийдвэр гаргаж болно.

20. Бага хурал нь энэхүү конвенцийн хэрэгжилтийг хянаж, түүний зүйл, зорилгыг биелүүлэхэд тус дөхөм үзүүлэх талаар ажиллана. Бага хурал нь энэхүү конвенцийг дагаж мөрдөж байгаа явцыг хянан үзэж байна. Түүнчлэн Бага хурал нь Гүйцэтгэх зөвлөл болон Техникийн нарийн бичгийн дарга нарын газрын үйл ажиллагааг хянаж, чиг үүргээ хэрэгжүүлэхдээ баримтлах удирдамжийг алинд нь ч энэхүү конвенцид нийцүүлэн гарган өгч болно.

**21. Бага хурал нь:**

(a) ээлжит чуулганаараа Гүйцэтгэх зөвлөлөөс өргөн барьсан Байгууллагын илтгэл, хөтөлбөр болон төсвийг хэлэлцэн баталж, мөн бусад илтгэлийг хэлэлцэнэ;

(b) 7 дахь хэсэгт нийцүүлэн оролцогч улсуудаас төлөх татварын хуваарийг шийдвэрлэн тогтооно;

(c) Гүйцэтгэх зөвлөлийн гишүүдийг сонгоно;

(d) Техникийн нарийн бичгийн дарга нарын газрын Ерөнхий захирал (цаашид “Ерөнхий захирал” гэх)-ыг томилно;

(e) Гүйцэтгэх зөвлөлөөс өргөн барьсан уг зөвлөлийн дэгийн журмыг батална;

(f) энэхүү конвенцид нийцүүлэн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ шаардлагатай гэж үзсэн туслах байгууллагыг байгуулна;

(g) химийн үйл ажиллагааны салбарт олон улсын хамтын ажиллагааг энхийн зорилгоор хөгжүүлнэ;

(h) энэхүү конвенцийн үйлчлэлд нөлөөлж болох шинжлэх ухаан болон технологийн ололтыг хянан үзэж, энэ утгаар чиг үүргээ хэрэгжүүлэхдээ энэхүү конвенцид холбогдох шинжлэх ухаан болон технологийн салбараар Бага хурал, Гүйцэтгэх зөвлөл буюу оролцогч улсуудад мэргэжлийн зөвлөгөө өгөх боломжийг Ерөнхий захиралд олгох үүднээс Эрдэм шинжилгээний зөвлөх товчоо нь Бага хурлаас батласан журамд нийцүүлэн томилсон бие даасан шинжээчдээс бүрдэнэ;

(i) Анхдугаар чуулганаараа Бэлтгэх комиссоос боловсруулсан аливаа хэлэлцээр, заалт болон удирдамжийн төслийг хэлэлцэж батална;

(j) Анхдугаар чуулганаараа 10 дугаар зүйлд нийцүүлэн тусlamж үзүүлэх сайн дурын санг байгуулна;

(k) энэхүү конвенцийг дагаж мөрдөх болон 12 дугаар зүйлд нийцүүлэн энэхүү конвенцийн заалтад харшилж буй аливаа байдлыг засаж залруулахад шаардлагатай арга хэмжээг авна.

22. Бага хурал нь энэхүү конвенцийн үйлчлэлийг хянан үзэх ээлжит бус чуулгынг энэхүү конвенц хүчин төгөлдөр болсноос хойш тав дахь болон арав дахь жил дууссаны дараа нэг жилийн дотор, түүнчлэн энэ хугацааны дотор шийдвэрлэж болох өөр цагт зарлан хуралдуулна. Ийнхүү хянан үзэхдээ шинжлэх ухаан болон технологийн аливаа холбогдох ололтыг харгалzan үзнэ. Түүнээс хойш өөрөөр шийдвэрлэгүй бол тав, таван жилийн хугацаатайгаар мөн адил зорилгоор Бага хурлын чуулгын цаашид зарлан хуралдуулна.

### **С. Гүйцэтгэх зөвлөл**

#### **Бүрэлдэхүүн, дэг, шийдвэр гаргах**

23. Гүйцэтгэх зөвлөл 41 гишүүнтэй байна. Оролцогч улс бүр ээлжлэх зарчимд нийцүүлэн Гүйцэтгэх зөвлөлийн бүрэлдэхүүнд орох эрхтэй. Гүйцэтгэх зөвлөлийн гишүүдийг Бага хурал хоёр жилийн хугацаатайгаар сонгоно. Энэхүү конвенцийн үр дүнтэй хэрэгжилтийг хангахын тулд, чингэхдээ газар зүйн тэгш шударга хуваарилалт, химийн үйлдвэрийн ач холбогдол, түүнчлэн улс төр, аюулгүй байдлын ашиг сонирхолд онцгой анхаарсны үндсэн дээр Гүйцэтгэх зөвлөл дараахь бүрэлдэхүүнтэй байна:

(a) Африк тивээс оролцогч есөн улсыг тус бүс нутгийн оролцогч улсууд томилно. Ийнхүү томилохдоо оролцогч эдгээр есөн улсаас тогтсон журмын дагуу гурван гишүүн нь үндэсний химийн үйлдвэр нь бүс нутагтаа хамгийн нөлөөтэй гэж олон улсын хэмжээнд илтгэн нийтлэсэн тоо баримтаар тодорхойлогдсон оролцогч улс байх зарчмыг үндэс болгоно гэж ойлгох бөгөөд энэ гурван гишүүнийг томилохдоо тус бүс нутгийн бүлэг нь бүс нутгийн бусад хүчин зүйлийг мөн харгалzan үзэхийг зөвшөөрнө;

(b) Ази тивээс оролцогч есөн улсыг тус бүс нутгийн оролцогч улсууд томилно. Ийнхүү томилохдоо оролцогч эдгээр есөн улсаас тогтсон журмын дагуу дөрвөн гишүүн нь үндэсний химийн үйлдвэр нь бүс нутагтаа хамгийн нөлөөтэй гэж олон улсын хэмжээнд илтгэн нийтлэсэн тоо баримтаар тодорхойлогдсон оролцогч улс байх зарчмыг үндэс болгоно гэж ойлгох бөгөөд энэ дөрвөн гишүүнийг томилохдоо тус бүс нутгийн бүлэг нь бүс нутгийн бусад хүчин зүйлийг мөн харгалzan үзэхийг зөвшөөрнө;

(c) Дорнод Европоос оролцогч таван улсыг тус бүс нутгийн оролцогч улсууд томилно. Ийнхүү томилохдоо оролцогч эдгээр таван улсаас тогтсон журмын дагуу нэг гишүүн нь үндэсний химийн үйлдвэр нь бүс нутагтаа хамгийн нөлөөтэй гэж олон улсын хэмжээнд илтгэн нийтлэсэн тоо баримтаар тодорхойлогдсон оролцогч улс байх зарчмыг үндэс болгоно гэж ойлгох бөгөөд энэ нэг гишүүнийг томилохдоо тус бүс нутгийн бүлэг нь бүс нутгийн бусад хүчин зүйлийг мөн харгалzan үзэхийг зөвшөөрнө;

(d) Латин Америк, Карибын тэнгисийн бүс нутгаас оролцогч долоон улсыг тус бүс нутгийн оролцогч улсууд томилно. Ийнхүү томилохдоо оролцогч эдгээр долоон

улсаас тогтсон журмын дагуу гурван гишүүн нь үндэсний химийн үйлдвэр нь бүс нутагтаа хамгийн нөлөөтэй гэж олон улсын хэмжээнд илтгэн нийтлэсэн тоо баримтаар тодорхойлогдсон оролцогч улс байх зарчмыг үндэс болгоно гэж ойлгох бөгөөд энэ гурван гишүүнийг томилоходоо тус бүс нутгийн бүлэг нь бүс нутгийн бусад хүчин зүйлийг мөн харгалзан үзэхийг зөвшөөрнө;

(e) Өрнөд Европ болон бусад улсаас оролцогч арван улсыг тус бүс нутгийн оролцогч улсууд томилно. Ийнхүү томилоходоо оролцогч эдгээр арван улсаас тогтсон журмын дагуу таван гишүүн нь үндэсний химийн үйлдвэр нь бүс нутагтаа хамгийн нөлөөтэй гэж олон улсын хэмжээнд илтгэн нийтлэсэн тоо баримтаар тодорхойлогдсон оролцогч улс байх зарчмыг үндэс болгоно гэж ойлгох бөгөөд энэ таван гишүүнийг томилоходоо тус бүс нутгийн бүлэг нь бүс нутгийн бусад хүчин зүйлийг мөн харгалзан үзэхийг зөвшөөрнө;

(f) Үлдсэн нэг оролцогч улсыг Ази болон Латин Америк, Карибын тэнгисийн бүс нутгийн оролцогч улсууд дараалан томилно. Ийнхүү томилоходоо оролцогч энэ улс нь эдгээр бүс нутгаас ээлжээр томилогдох гишүүн байх зарчмыг үндэс болгоно гэж ойлгоно.

24. Гүйцэтгэх зөвлөлийн анхны сонгуулиар 20 гишүүнийг нэг жилийн хугацаатайгаар сонгох бөгөөд чингэхдээ 23 дахь хэсэгт тодорхойлон тогтоосон тоон харьцааг зохих ёсоор анхаарна.

25. 4 болон 5 дугаар зүйлийг бүрэн хэрэгжүүлсний дараа Бага хурал Гүйцэтгэх зөвлөлийн гишүүдийн олонхийн хүсэлтээр түүний бүрэлдэхүүнийг хянан үзэж болох бөгөөд чингэхдээ уг бүрэлдэхүүнийш зохицуулж буй 23 дахь хэсэгт заасан зарчимд хамаарах өөрчлөлтийг харгалзан үзнэ.

26. Гүйцэтгэх зөвлөл нь өөрийн дэгийн журмыг боловсруулж Бага хуралд батлуулахаар өргөн барина.

27. Гүйцэтгэх зөвлөл нь даргаа гишүүдээсээ сонгоно.

28. Гүйцэтгэх зөвлөл нь ээлжит чуулганаар хуралдана. Гүйцэтгэх зөвлөл нь ээлжит чуулгануудын хооронд өөрийн эрх мэдэл, чиг үүргийг биелүүлэхэд шаардлагатай тухай бүр хуралдана.

29. Гүйцэтгэх зөвлөлийн гишүүн бүр саналын нэг эрхтэй байна. Энэхүү конвенцид өөрөөр заагаагүй бол Гүйцэтгэх зөвлөл зарчмын асуудлаар бүх гишүүнийхээ гуравны хоёрын олонхийн саналаар шийдвэр гаргана. Гүйцэтгэх зөвлөл бүх гишүүнийхээ ердийн олонхийн саналаар дэгийн асуудлаар шийдвэр гаргана. Тухайн асуудал зарчмын асуудал мөн эсэх талаар маргаан гарсан тохиолдолд зарчмын асуудлыг шийдвэрлэхэд шаардлагдах олонхийн саналаар Гүйцэтгэх зөвлөл өөрөөр шийдвэрлээгүй бол түүнийг зарчмын асуудал гэж үзнэ.

#### Эрх мэдэл, чиг үүрэг

30. Гүйцэтгэх зөвлөл нь Байгууллагын гүйцэтгэх байгууллага байна. Гүйцэтгэх зөвлөл нь Бага хуралд ажлаа тайлagnана. Гүйцэтгэх зөвлөл нь энэхүү конвенцоор түүнд олгосон эрх мэдэл, чиг үүрэг, түүнчлэн Бага хурлаас түүнд шилжүүлсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ. Чингэхдээ Бага хурлын зөвлөмж, шийдвэр, удирдамжид нийцүүлэн ажиллаж, тэдгээрийг зохих ёсоор тууштай хэрэгжүүлэх явдлыг хангана.

31. Гүйцэтгэх зөвлөл энэхүү конвенцийг үр дүнтэй хэрэгжүүлэх, дагаж мөрдөхөд тус дөхөм үзүүлнэ. Гүйцэтгэх зөвлөл нь Техникийн нарийн бичгийн дарга нарын газрын үйл ажиллагааг хянаж, оролцогч улс бүрийн үндэсний эрх бүхий байгууллагатай хамтран ажиллаж, оролцогч улс хоорондын зөвлөлдөөн, хамтын ажиллагааг тэдний хүсэлтээр хөнгөвчлөн дэмжинэ.

32. Гүйцэтгэх зөвлөл нь:

(а) Байгууллагын хөтөлбөр, төсвийн төслийг хэлэлцэж Бага хуралд өргөн барина;

(б) энэхүү конвенцийн хэрэгжилтийн талаархи Байгууллагын илтгэлийн төсөл, өөрийн үйл ажиллагааны биелэлтийн талаархи илтгэл, түүнчлэн шаардлагатай гэж үзсэн буюу Бага хурлаас хүссэн тусгай илтгэлүүдийг хэлэлцэж Бага хуралд өргөн барина;

(с) Бага хурлын чуулганыг зохион байгуулна, түүний дотор хэлэлцэх хэргийн төслийг бэлтгэнэ.

33. Гүйцэтгэх зөвлөл нь Бага хурлын ээлжит бус чуулганыг зарлан хуралдуулахыг хүсч болно.

34. Гүйцэтгэх зөвлөл нь:

(а) Бага хурлын зөвшөөрлийг урьдчилан авсны дагуу Байгууллагын нэрийн өмнөөс улс болон олон улсын байгууллагуудтай хэлэлцээр, тохиролцоо байгуулна;

(б) 10 дугаар зүйлтэй холбогдуулан оролцогч улсуудтай Байгууллагын нэрийн өмнөөс хэлэлцээр байгуулах бөгөөд 10 дугаар зүйлд дурдсан сайн дурын санд хяналт тавина;

(с) Техникийн нарийн бичгийн дарга нарын газраас оролцогч улсуудтай хэлэлцсэн нягтлан шалгалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд хамаарах хэлэлцээ буюу тохиролцоог батална.

35. Гүйцэтгэх зөвлөл нь энэхүү конвенц болон түүний хэрэгжилтэд нөлөөлөх өөрийн эрх хэмжээний аливаа асуудал, түүний дотор дагаж мөрдөхтэй холбоотой сэтгэл зовнил, дагаж мөрдөхгүй байгаа тохиолдлыг хэлэлцэж, шаардлагатай үед оролцогч улсуудад мэдээлж, асуудлыг Бага хурлын анхааралд хүргэнэ.

36. Дагаж мөрдөхтэй холбоотой эргэлзээ, сэтгэл зовнил, түүнчлэн дагаж мөрдөхгүй байгаа тохиолдол, түүний дотор *inter alia* энэхүү конвенцийн дагуу олгосон эрхийг урвуулан ашигласан асуудлыг авч хэлэлцэхдээ Гүйцэтгэх зөвлөл холбогдох оролцогч улстай зөвлөлдөж, байдлыг тодорхой заасан хугацаанд засаж залруулах арга хэмжээ авахыг тухайн оролцогч улсаас шаардлагатай үед хүснэ. Гүйцэтгэх зөвлөл цаашид арга хэмжээ авах шаардлагатай гэж үзвэл дараахь арга хэмжээнээс *inter alia* нэг, эсхүл хэд хэдийг авч хэрэгжүүлнэ:

(а) тухайн асуудлын талаар оролцогч бүх улсад мэдээлэх;

(б) тухайн асуудлыг Бага хурлын анхааралд хүргэх;

(с) байдлыг засаж залруулах болон дагаж мөрдөх явдлыг хангах арга хэмжээний талаар Бага хуралд зөвлөмж өгөх.

Тун ноцтой бөгөөд яаралтай тохиолдолд Гүйцэтгэх зөвлөл тухайн асуудал, түүний дотор холбогдох мэдээлэл болон дүгнэлтийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблей болон Нэгдсэн Үндэстний Байгууллагын Аюулгүйн Зөвлөлийн анхааралд шууд хүргэнэ. Энэ алхмын талаар Гүйцэтгэх зөвлөл оролцогч бүх улсад тухайн үед нь мэдээлнэ.

#### D. Техникийн нарийн бичгийн дарга нарын газар

37. Техникийн нарийн бичгийн дарга нарын газар Бага хурал болон Гүйцэтгэх зөвлөлийг чиг үүргээ гүйцэтгэхэд нь туслалцаа үзүүлнэ. Техникийн нарийн бичгийн дарга нарын газар нь энэхүү конвенцид заасан нягтлан шалгалтын арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Техникийн нарийн бичгийн дарга нарын газар нь энэхүү конвенцоор түүнд олгосон бусад чиг үүрэг, түүнчлэн Бага хурал болон Гүйцэтгэх зөвлөлөөс түүнд шилжүүлсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

38. Техникийн нарийн бичгийн дарга нарын газар нь:

(а) Байгууллагын хөтөлбөр, төсвийн төслийг бэлтгэж Гүйцэтгэх зөвлөлд өргөн барина;

(б) энэхүү конвенцийн хэрэгжилтийн талаархи Байгууллагын илтгэлийн төсөл, түүнчлэн Бага хурал болон Гүйцэтгэх зөвлөлөөс хүссэн бусад илтгэлийг бэлтгэж Гүйцэтгэх зөвлөлд өргөн барина;

(с) Бага хурал, Гүйцэтгэх зөвлөл болон туслах байгууллагуудад захиргааны болон техникийн туслалцаа үзүүлнэ;

(д) энэхүү конвенцийг хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлаар Байгууллагын нэрийн өмнөөс оролцогч улсуудад мэдээлэл тарааж, мэдээлэл хүлээн авна;

(е) оролцогч улсуудад энэхүү конвенцийн заалтыг хэрэгжүүлэхэд нь техникийн туслалцаа үзүүлж, техникийн дүгнэлт, түүний дотор жагсаалтад орсон болон ороогүй химиийн бодисын талаархи дүгнэлт гаргаж өгнө.

39. Техникийн нарийн бичгийн дарга нарын газар нь:

(а) нягтлан шалгалтын үйл ажиллагаа хэрэгжүүлэх асуудлаар Гүйцэтгэх зөвлөл зөвшөөрсний дагуу хэлэлцээр буюу тохиролцоо байгуулах талаар оролцогч улсуудтай хэлэлцээ хийнэ;

(б) яаралтай болон хүмүүнлэгийн тусlamжийн байнгын нөөцийг оролцогч улсууд Х зүйлийн 7 дахь хэсгийн (а) болон (с) дэд хэсэгт заасны дагуу байгуулж, ажиллуулах арга хэмжээг энэхүү конвенц хүчин төгөлдөр болсноос хойш 180 хоногийн дотор зохицуулан авч хэрэгжүүлнэ. Техникийн нарийн бичгийн дарга нарын газар ашиглахад найдвартай эсэхийг тодорхойлох үүднээс нөөцлөх зүйлсийг хянан шалгаж болно. Нөөцлөх зүйлсийн жагсаалтыг дээрх 21 дэх хэсгийн (i) дэд хэсгийн дагуу Бага хурал хэлэлцэж батлана;

(с) 10 дугаар зүйлд дурдсан сайн дурын санг удирдаж, оролцогч улсуудаас хийсэн мэдэгдлийг нэгтгэж, хүсэлт тавьсан тохиолдолд 10 дугаар зүйлийн зорилгоор

оролцогч улсууд хоорондоо буюу аль нэг оролцогч улс болон Байгууллагын хооронд байгуулсан хоёр талт хэлэлцээрийг бүртгэнэ.

40. Техникийн нарийн бичгийн дарга нарын газар нь чиг үүргээ гүйцэтгэхтэй холбогдон гарсан аливаа асуудал, түүний дотор нягтлан шалгалтын үйл ажиллагааг явуулах үед илэрсэн бөгөөд оролцогч холбогдох улстай зөвлөлдөх замаар шийдвэрлэх буюу тодруулж чадаагүй, энэхүү конвенцийг дагаж мөрдөхтэй холбоотой эргэлзээ, ойлгомжгүй буюу тодорхойгүй асуудлын талаар Гүйцэтгэх зөвлөлд мэдээнэ.

41. Техникийн нарийн бичгийн дарга нарын газар нь түүний тэргүүн бөгөөд захиргааны дээд албан тушаалтан болох Ерөнхий захирал, хянан шалгагчид, түүнчлэн шаардагдаж болох шинжлэх ухаан, техникийн болон бусад ажилтнаас бүрдэнэ.

42. Хянан шалгах алба нь Техникийн нарийн бичгийн дарга нарын газрын нэгж байх бөгөөд Ерөнхий захирлын хяналтан дор ажиллана.

43. Ерөнхий захирлыг Гүйцэтгэх зөвлөлийн зөвлөмж болгосноор Бага хурал дөрвөн жилийн хугацаатайгаар томилох бөгөөд уг хугацааг дахин нэг л удаа сунгаж болно.

44. Ерөнхий захирал нь Техникийн нарийн бичгийн дарга нарын газрын боловсон хүчнийг томилох асуудал болон зохион байгуулалт, үйл ажиллагааны асуудлаар Бага хурал болон Гүйцэтгэх зөвлөлийн өмнө тайлагнан хариуцна. Боловсон хүчнийг сонгон томилох, ажлын нөхцлийг тодорхойлоходоо хамгийн үр ашигтай, чадварлаг, үнэнч шударга байх шаардлагыг эн тэргүүнд харгалзана. Зөвхөн оролцогч улсуудын харьят иргэд Ерөнхий захирал, хянан шалгагчид буюу мэргэжлийн болон техникийн бусад ажилтнаар ажиллана. Боловсон хүчнийг сонгон аваадаа газар зүйн төлөөллийг аль болох өргөн хамруулах нь чухал гэдэгт зохих ёсоор анхаарна. Боловсон хүчнийг сонгон аваадаа Техникийн нарийн бичгийн дарга нарын газрын үүргийг зохих түвшинд биелүүлэхэд шаардлагатай хамгийн цомхон бүрэлдэхүүнтэй байх зарчмыг удирдлага болгоно.

45. Ерөнхий захирал нь 21 дэх хэсгийн (h) дэд хэсэгт дурдсан Эрдэм шинжилгээний зөвлөх товчооны зохион байгуулалт, үйл ажиллагааг хариуцна. Ерөнхий захирал нь оролцогч улсуудтай зөвлөлдөн Эрдэм шинжилгээний зөвлөх товчооны гишүүдийг томилох бөгөөд тэд үүрэгт ажлаа бие даан гүйцэтгэнэ. Товчооны гишүүдийг энэхүү конвенцийг хэрэгжүүлэхтэй холбогдох шинжлэх ухааны тодорхой салбар дахь мэдлэг, чадварт нь үндэслэн томилно. Ерөнхий захирал мөн тодорхой асуудлаар зөвлөмж өгөх үүрэг бүхий эрдэм шинжилгээний шинжээчдийн ажлын хэсгийг Товчооны гишүүдтэй зөвлөлдөн шаардлагатай үед түр хугацаагаар байгуулж болно. Дээрхтэй холбогдуулан оролцогч улсууд шинжээчдийн нэrsийн жагсаалтыг Ерөнхий захиралд өгч болно.

46. Ерөнхий захирал, хянан шалгагчид болон бусад ажилтан үүргээ гүйцэтгэхдээ аливаа засгийн газар, эсхүл Байгууллагаас гадуур аливаа эх сурвалжаас заавар зөвлөгөө авахыг эрэлхийлэх буюу хүлээн авахгүй. Тэд зөвхөн Бага хурал болон Гүйцэтгэх зөвлөлийн өмнө хариуцлага хүлээх олон улсын байгууллагын албан тушаалтны хувьд байр суурьд нь тусаж болох аливаа үйлдлээс татгалзана.

47. Оролцогч улс бүр Ерөнхий захирал, шинжээчид болон бусад ажилтны үүрэг хариуцлагын гагцхүү олон улсын шинж чанарыг хүндэтгэж, ажил үүргээ гүйцэтгэхэд нь тэдэнд нөлөө үзүүлэхийг оролдохгүй.

### **Е. Эрх ямба, дархан эрх**

48. Байгууллага нь оролцогч улсын нутаг дэвсгэрт болон хэргийн харьяалал буюу хяналтан дор нь орших аливаа өөр газарт чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай эрх зүйн чадвар, эрх ямба, дархан эрх эдлэнэ.

49. Оролцогч улсуудын төлөөлөгчид, тэдний орлогч болон зөвлөхүүд, Гүйцэтгэх зөвлөлд томилогдсон төлөөлөгчид орлогч болон зөвлөхүүдийнхээ хамт, Ерөнхий захирал болон Байгууллагын ажилтнууд Байгууллагатай холбогдо чиг үүргээ бие даан хэрэгжүүлэхэд шаардлагатай эрх ямба, дархан эрх эдлэнэ.

50. Энэ зүйлд дурдсан эрх зүйн чадвар, эрх ямба, дархан эрхийг Байгууллага болон оролцогч улсуудын хоорондын хэлэлцээр, түүнчлэн Байгууллага болон түүний удирдах төв байрлаж буй улсын хоорондын хэлэлцээрээр тодорхойлно. Эдгээр хэлэлцээрийг 21 дэх хэсгийн (i) дэд хэсгийн дагуу Бага хурлаар хэлэлцэж батлана.

51. 48 болон 49 дэх хэсгийг үл харгалзан, Ерөнхий захирал болон Техникийн нарийн бичгийн дарга нарын газрын ажилтнуудын нягтлан шалгалтын үйл ажиллагаа явуулах үед эдлэх эрх ямба, дархан эрх нь Нягтлан шалгалтын тухай хавсралтын II хэсгийн (B) ангид заасан эрх ямба, дархан эрх байна.

### ***9 дүгээр зүйл***

#### **Зөвлөлдөх, хамтран ажиллах, баримтыг олж тогтоох**

1. Энэхүү конвенцийн зүйл, зорилго, түүнчлэн түүний заалтыг хэрэгжүүлэхтэй холбогдон үүсч болох аливаа асуудлаар оролцогч улсууд шууд өөр хоорондоо, эсхүл Байгууллагаар дамжуулан буюу олон улсын зохих бусад журам, түүний дотор Нэгдсэн Үндэстний Байгууллагын хүрээнд болон түүний дүрэмд нийцсэн журмаар зөвлөлдөж, хамтран ажиллана.

2. Хүсэлтийн дагуу хянан шалгалт хийхийг хүсэх оролцогч аливаа улсын эрхийг хөндөхгүйгээр оролцогч улсууд энэхүү конвенцийг дагаж мөрдөж буй талаар эргэлзээ төрүүлж болох, эсхүл ойлгомжгүй гэж үзэж болох холбогдох асуудлын талаар сэтгэл зовнил үүсгэж буй аливаа асуудлыг өөр хоорондоо мэдээлэл солилцох болон зөвлөлдөх замаар тодруулж шийдвэрлэх талаар бүхий л чармайлтыг эн түрүүнд боломжтой бүхий л үед гаргах нь зүйтэй. Аливаа асуудлыг ийм эргэлзээ буюу сэтгэл зовнил төрүүлж байна гэж итгэн оролцогч нөгөө улсаас уг асуудлыг тодруулж өгөх хүсэлтийг хүлээн авсан оролцогч улс ийнхүү үүссэн эргэлзээ буюу сэтгэл зовнилд хариу болох хангалттай мэдээллийг уг мэдээлэл нь асуудлыг хэрхэн шийдвэрлэж буй талаархи тайлбарын хамт аль болох түргэн, гэхдээ ямар ч тохиолдолд хүсэлт гаргаснаас хойш 10 хоногийн дотор хүсэлт гаргагч оролцогч улсад гаргаж өгнө. Энэхүү конвенцийг дагаж мөрдөж буй талаар эргэлзээ төрүүлж болох, эсхүл ойлгомжгүй гэж үзэж болох холбогдох асуудлын талаар сэтгэл зовнил үүсгэж буй аливаа асуудлыг тодруулж шийдвэрлэх зорилгоор харилцан тохиролцсоны үндсэн дээр өөр хоорондоо хянан шалгалт хийх буюу аливаа бусад журам хэрэглэх талаар тохиролцох аливаа хоёр болон түүнээс дээш оролцогч улсын эрхийг энэхүү конвенцийн аль ч заалт хөндөхгүй. Ийм тохиролцоо нь энэхүү конвенцийн бусад заалтын дагуу оролцогч аливаа улсад олгосон эрх, хүлээсэн үүрэгт нөлөөлөхгүй.

**Тодруулга хүсэх журам**

3. Ойлгомжгүй гэж үзэж болох, эсхүл оролцогч өөр улс энэхүү конвенцийг дагаж мөрдөхгүй байж болзошгүй гэсэн сэтгэл зовнил үүсгэж буй аливаа байдлыг тодруулахад нь туслахыг оролцогч улс Гүйцэтгэх зөвлөлөөс хүсэх эрхтэй. Гүйцэтгэх зөвлөл нь дээрх сэтгэл зовнилтой холбогдох өөрт байгаа зохих мэдээллээр хангана.

4. Ойлгомжгүй гэж үзэж болох, эсхүл оролцогч нөгөө улс энэхүү конвенцийг дагаж мөрдөхгүй байж болзошгүй гэсэн сэтгэл зовнил үүсгэж буй аливаа байдлын тодруулгыг оролцогч өөр улсаас гаргуулж өгөхийг оролцогч улс Гүйцэтгэх зөвлөлөөс хүсэх эрхтэй. Энэ тохиолдолд дараах журмыг баримтална:

(a) Гүйцэтгэх зөвлөл нь тодруулга авах хүсэлтийг хүлээн авснаас хойш 24 цагийн дотор Ерөнхий захирлаар дамжуулан холбогдох оролцогч улсад уламжилна;

(b) хүсэлт хүлээн авсан холбогдох оролцогч улс тодруулгыг аль болох түргэн хугацаанд, гэхдээ ямар ч тохиолдолд хүсэлт хүлээн авснаас хойш 10 хоногийн дотор Гүйцэтгэх зөвлөлд гаргаж өгнө;

(c) Гүйцэтгэх зөвлөл нь тодруулгыг тэмдэглэн авч түүнийг хүлээн авснаас хойш 24 цагийн дотор хүсэлт гаргагч оролцогч улсад уламжилна;

(d) хэрэв хүсэлт гаргагч оролцогч улс тодруулгыг хангалтгүй гэж үзвэл хүсэлт хүлээн авсан оролцогч улсаас нэмэлт тодруулга гаргуулж өгөхийг Гүйцэтгэх зөвлөлөөс хүсэх эрхтэй;

(e) (d) дэд хэсгийн дагуу нэмэлт тодруулга гаргуулах зорилгоор Гүйцэтгэх зөвлөл сэтгэл зовнилыг үүсгэж буй байдалд холбогдох боломжтой бүх мэдээллийг шалгах зорилгоор Техникийн нарийн бичгийн дарга нарын газраас, эсхүл хэрэв Техникийн нарийн бичгийн дарга нарын газарт зохих ажилтан байхгүй бол өөр газраас шинжээчдийн хэсэг байгуулахыг Ерөнхий захиралд санал болгож болно. Шинжээчдийн хэсэг нь олж тогтоосон үйл баримтын талаархи илтгэлийг Гүйцэтгэх зөвлөлд өргөн барина;

(f) хэрэв хүсэлт гаргагч оролцогч улс (d) болон (e) дэд хэсгийн дагуу гаргуулж авсан тодруулгыг хангалтгүй гэж үзвэл Гүйцэтгэх зөвлөлийн гишүүн бус холбогдох оролцогч улсууд оролцох эрх эдлэх Гүйцэтгэх зөвлөлийн ээлжит бус чуулганыг хуралдуулахыг хүсэх эрхтэй. Ээлжит бус ийм чуулганаар Гүйцэтгэх зөвлөл уг асуудлыг хэлэлцэж, байдлыг шийдвэрлэхэд зохимжтой гэж үзсэн аливаа арга хэмжээг зөвлөмж болгож болно.

5. Оролцогч улс мөн ойлгомжгүй гэж үзэж болох, эсхүл энэхүү конвенцийг дагаж мөрдөхгүй байж болзошгүй гэсэн сэтгэл зовнил үүсгэж буй аливаа байдлыг тодруулахыг Гүйцэтгэх зөвлөлөөс хүсэх эрхтэй. Гүйцэтгэх зөвлөл нь зохих тусlamж үзүүлэх замаар хариу өгнө.

6. Гүйцэтгэх зөвлөл нь энэ зүйлд заасан тодруулга авах аливаа хүсэлтийн талаар оролцогч улсуудад мэдээлнэ.

7. Хэрэв энэхүү конвенцийг дагаж мөрдөхгүй байж болзошгүй талаархи оролцогч улсын эргэлзээ буюу сэтгэл зовнилын талаар тодруулга гаргуулж өгөх тухай хүсэлтийг Гүйцэтгэх зөвлөлд гаргаснаас хойш 60 хоногийн дотор шийдвэрлэж чадаагүй, эсхүл хүсэлтийн дагуу шалгalt хийхийг хүсэх эрхээ үл харгалзан уг эргэлзээ

нь асуудлыг яаралтай авч үзэхийг шаардаж байна гэж тухайн оролцогч улс итгэж байгаа бол 8 дугаар зүйлийн 12 дахь хэсгийн (с) дэд хэсэгт нийцүүлэн Бага хурлын ээлжит бус чуулганыг хуралдуулахыг хүсч болно.

#### Хүсэлтийн дагуу хянан шалгалт хийх журам

8. Оролцогч улс бүр энэхүү конвенцийг дагаж мөрдөхгүй байж болзошгүй гэсэн аливаа асуудлыг тодруулан шийдвэрлэх ганц зорилгоор оролцогч аливаа бусад улсын нутаг дэвсгэрт эсхүл түүний хэргийн харьялал буюу хяналтан дор орших аливаа өөр газарт байгаа аливаа байгууламж буюу байршилд газар дээр нь хянан шалгалт хийх, түүнчлэн уг хянан шалгалтыг Ерөнхий захирлаас томилсон хянан шалгах хэсгээр Нягтлан шалгалтын тухай хавсралтад нийцүүлэн хаана ч цаг алдалгүйгээр хийлгэх хүсэлт гаргах эрхтэй.

9. Оролцогч улс бүр хянан шалгалт хийлгэх хүсэлтээ энэхүү конвенцийн хамрах хүрээгээр хязгаарлах, түүнчлэн Нягтлан шалгалтын тухай хавсралтад зааснаар энэхүү конвенцийг дагаж мөрдөхгүй байж болзошгүй гэсэн сэтгэл зовнил үүсэх үндэслэл болсон зохих бүх мэдээллийг хянан шалгалт хийлгэх хүсэлтдээ тусгах үүрэг хүлээнэ. Оролцогч улс бүр шалгалт хийлгэх үндэслэлгүй хүсэлт гаргахаас татгалзах бөгөөд чингэхдээ эрхээ урвуулан ашиглахаас зайлсхийхэд анхаарна. Хүсэлтийн дагуу хянан шалгалтыг энэхүү конвенцийг дагаж мөрдөхгүй байж болзошгүй талаархи үйл баримтыг тодорхойлох ганц зорилгоор явуулна.

10. Энэхүү конвенцийг дагаж мөрдөж байгааг нягтлан шалгах зорилгоор оролцогч улс бүр 8 дахь хэсгийн дагуу хүсэлтийн дагуу газар дээр нь хянан шалгалт хийхийг Техникийн нарийн бичгийн дарга нарын газарт зөвшөөрнө.

11. Байгууламж буюу байршилд хүсэлтийн дагуу хянан шалгалт хийлгэхээр гаргасан хүсэлтийн дагуу, түүнчлэн Нягтлан шалгалтын тухай хавсралтад заасан журамд нийцүүлэн хянан шалгуулж буй оролцогч улс нь:

(а) энэхүү конвенцийг дагаж мөрдөж байгаагаа харуулахаар боломжит бүхий л чармайлт гаргах, энэ үүднээс хянан шалгах хэсгийг үүрэгт ажлаа гүйцэтгэх боломж олгох эрх, үүрэгтэй;

(б) энэхүү конвенцийг дагаж мөрдөхгүй байж болзошгүй гэсэн сэтгэл зовнилтой холбогдох үйл баримтыг тогтоох ганц зорилгоор хүссэн газар дотор нэвтрэх боломжийг олгох үүрэгтэй;

(с) өндөр мэдрэмж бүхий тоног төхөөрөмжийг хамгаалах, энэхүү конвенцид үл хамаарах нууц мэдээлэл, тоо баримтыг задруулахаас урьдчилан сэргийлэх талаар арга хэмжээ авах эрхтэй байна.

#### 12. Ажиглагчийн хувьд дараахь журмыг баримтлана:

(а) хүсэлтийн дагуу хийх хянан шалгалтыг ажиглах зорилгоор хүсэлт гаргагч оролцогч улс хянан шалгуулж буй оролцогч улс зөвшөөрсний үндсэн дээр өөрийн буюу гуравдагч оролцогч улсын харьят байж болох төлөөлөгчийг илгээж болно;

(б) хянан шалгуулж буй оролцогч улс Нягтлан шалгалтын тухай хавсралтад нийцүүлэн ажиглагчид нэвтрэх эрх олгоно;

(с) хянан шалгуулж буй оролцогч улс санал болгосон ажиглагчийг тогтсон журмын дагуу хүлээн авах бөгөөд хэрэв хянан шалгуулж буй оролцогч улс татгалзвал энэ тухай эцсийн илтгэлд тэмдэглэнэ.

13. Хүсэлт гаргагч оролцогч улс хүсэлтийн дагуу газар дээр нь хянан шалгалт хийлгэх тухай хүсэлтээ нэн даруй хянуулахаар Гүйцэтгэх зөвлөлд, түүнчлэн Ерөнхий захиралд нэгэн зэрэг гаргана.

14. Ерөнхий захирал хянан шалгалт хийлгэх тухай хүсэлтийг Нягтлан шалгалтын тухай хавсралтын X хэсгийн 4 дэх хэсэгт заасан шаардлагад нийцэж буй эсэхийг нэн даруй тогтоож, шаардлагатай бол хянан шалгалт хийлгэх тухай хүсэлтээ зохих журмын дагуу гаргахад нь хүсэлт гаргагч оролцогч улсад туслана. Хянан шалгалт хийлгэх тухай хүсэлт шаардлагыг хангасан тохиолдолд хүсэлтийн дагуу хийх хянан шалгалтын бэлтгэл эхэлнэ.

15. Ерөнхий захирал хянан шалгалт хийлгэх тухай хүсэлтийг хянан шалгах баг нэвтрэх цэгт очибоор товлосон хугацаанаас 12 цагаас баагүй хугацааны өмнө хянан шалгуулах гэж буй оролцогч улсад дамжуулна.

16. Хянан шалгалт хийлгэх тухай хүсэлтийг хүлээж авсны дараа Гүйцэтгэх зөвлөл уг хүсэлтийн талаар Ерөнхий захирлын авсан арга хэмжээтэй танилцаж хянан шалгалт хийх бүхий л хугацаанд асуудлыг авч үзнэ. Гэхдээ ийнхүү авч үзэхдээ хянан шалгалтын явцыг saatuulaahgүй.

17. Хэрэв Гүйцэтгэх зөвлөл нь хянан шалгалт хийлгэх тухай хүсэлтийг утгагүй, эрх мэдлээ урвуулан ашигласан, эсхүл 8 дахь хэсэгт тодорхойлсноор энэхүү конвенцийн хамрах хүрээнээс илт хальсан гэж үзвэл гишүүдийнхээ дөрөвний гурвын олонхийн саналаар уг хянан шалгалтыг хийлгэхгүй байх тухай шийдвэрийг хянан шалгалт хийлгэх тухай хүсэлтийг хүлээн авснаас хойш 12 цагийн дотор гаргаж болно. Хүсэлт гаргагч болон шалгуулах гэж буй оролцогч улсын аль нь ч ийм шийдвэр гаргахад үл оролцено. Хэрэв Гүйцэтгэх зөвлөл хүсэлтийн дагуу шалгалт хийлгэхгүй байх тухай шийдвэр гаргавал бэлтгэлийг зогсоож, хянан шалгалт хийлгэх тухай хүсэлтийн дагуу цаашид ямарваа арга хэмжээ авахгүй бөгөөд энэ тухай оролцогч холбогдох улсуудад мэдээлнэ.

18. Хүсэлтийн дагуу хянан шалгалт хийх эрхийг Ерөнхий захирал олгоно. Хянан шалгалт хийх эрх гэж ажлын хэллэгт оруулсан 8 болон 9 дэх хэсэгт дурдсан хянан шалгалт хийлгэх тухай хүсэлтийг хэлэх бөгөөд хянан шалгалт хийлгэх тухай хүсэлтэд нийцэж байна.

19. Хүсэлтийн дагуу хийх хянан шалгалтыг Нягтлан шалгалтын тухай хавсралтын X хэсэг, эсхүл химийн зэвсэг хэрэглэж байна гэж үзсэн тохиолдолд XI хэсэгт нийцүүлэн явуулна. Хянан шалгах баг хүсэлтийн дагуу хийх хянан шалгалтыг хамгийн түрэмгий бус байдлаар, зорилтоо цаг тухайд нь үр ашигтай биелүүлэхээр явуулах зарчмыг удирдлага болгоно.

20. Шалгуулж буй оролцогч улс хүсэлтийн дагуу хийх шалгалтын туршид хянан шалгах багт туслаж, үүрэгт ажлаа гүйцэтгэхэд нь дэмжлэг үзүүлнэ. Хэрэв шалгуулж буй оролцогч улс нь бүрэн, чөлөөтэй нэвтрэх эрх олгохын оронд энэхүү конвенцийг дагаж мөрдөж байгаагаа харуулах арга хэмжээг Нягтлан шалгалтын тухай хавсралтын X хэсгийн С ангийн дагуу санал болговол тухайн улс нь дагаж мөрдөж байгаагаа харуулах зорилгоор үйл баримтыг тогтоох журмын талаар хянан шалгах багтай зөвлөлдөж тохиролцоонд хүрэхийн тулд боломжит бүхий л чармайлт гаргана.

21. Олж тогтоосон баримт, түүнчлэн хүсэлтийн дагуу хийх шалгалтыг хангалттай хэрэгжүүлэх үүднээс олгосон нэвтрэх эрх болон хамтын ажиллагааны хэмжээ, шинж чанарын талаар хянан шалгах багийн гаргасан үнэлгээг эцсийн илтгэлд тусгана. Ерөнхий захидал хянан шалгах багийн эцсийн илтгэлийг хүсэлт гаргагч оролцогч улс, хянан шалгуулж буй оролцогч улс, Гүйцэтгэх зөвлөл болон оролцогч бусад бүх улсад даруй тараана. Цаашилбал, Ерөнхий захидал нь энэ зорилгоор түүнд илгээж болох хүсэлт гаргагч болон хянан шалгуулж буй оролцогч улсын үнэлгээ, түүнчлэн оролцогч бусад улсын үзэл бодлыг Гүйцэтгэх зөвлөлд даруй дамжуулж, дараа нь оролцогч бүх улсад өгнө.

22. Гүйцэтгэх зөвлөл хянан шалгах багийн эцсийн илтгэлийг танилцуулсан даруйд өөрийн эрх мэдэл, чиг үүрэгт нийцүүлэн хянан үзэж, дараахь асуудалд анхаарлаа хандуулна:

(а) энэхүү конвенцийг дагаж мөрдөөгүй аливаа үйлдэл гарсан эсэх;

(б) хүсэлт нь энэхүү конвенцийн хамрах хүрээнд багтсан эсэх;

(с) хүсэлтийн дагуу хянан шалгалт хийлгэх тухай хүсэлт тавих эрхийг урвуулан ашигласан эсэх.

23. Хэрэв Гүйцэтгэх зөвлөл өөрийн эрх мэдэл, чиг үүргийн хүрээнд 22 дахь хэсэгтэй холбогдуулан цаашид арга хэмжээ авах шаардлагатай гэсэн дүгнэлтэд хүрвэл байдлыг засаж залруулах болон энэхүү конвенцийг дагаж мөрдөх явдлыг хангахтай холбогдох арга хэмжээ авна, түүний дотор Бага хуралд тодорхой зөвлөмж оруулна. Эрхээ урвуулан ашигласан тохиолдолд Гүйцэтгэх зөвлөл хүсэлтийн дагуу хийх хянан шалгалтыг явуулснаас үүдэн гарсан санхүүгийн аливаа үр дагаврыг хүсэлт гаргагч оролцогч улс хариуцах ёстой эсэхийг шалган шийдвэрлэнэ.

24. Хүсэлт гаргагч оролцогч улс болон хянан шалгуулж буй оролцогч улс хянан үзэх ажиллагаанд оролцох эрхтэй. Энэ ажлын үр дүнгийн талаар Гүйцэтгэх зөвлөл нь оролцогч улсууд, түүнчлэн Бага хурлын дараагийн чуулганд мэдээлнэ.

25. Хэрэв Гүйцэтгэх зөвлөл Бага хуралд тодорхой зөвлөмж өгсөн бол 12 дугаар зүйлд нийцүүлэн арга хэмжээ авах асуудлыг Бага хурал авч үзнэ.

*10 дугаар зүйл*

### **Тусlamж үзүүлэх, химиин зэвсгээс хамгаалах**

1. Энэ зүйлийн зорилгоор, “Тусlamж” гэж химиийн зэвсгээс хамгаалах явдлыг зохицуулах болон оролцогч улсуудад ийм хамгаалалтыг олгох, түүний дотор *inter alia* дараах зүйлийг хэлнэ: илрүүлэх тоног төхөөрөмж болон дохиоллын систем; хамгаалах тоног төхөөрөмж; цэвэрлэх тоног төхөөрөмж болон ариутгагч; хор тайлах эм болон эмчилгээ; түүнчлэн эдгээр хамгаалах арга хэмжээний алиных нь ч талаар зөвлөгөө өгөх.

2. Энэхүү конвенцийн аль ч заалтыг энэхүү конвенциоор хориглоогүй зорилгоор химиийн зэвсгээс хамгаалах хэрэгслийг судлах, боловсруулах, үйлдвэрлэх, олж авах, шилжүүлэх буюу хэрэглэх оролцогч аливаа улсын эрхийг saatuулж байна гэж тайлбарлахгүй.

3. Оролцогч улс бүр химийн зэвсгээс хамгаалах тоног төхөөрөмж, материал болон ийнхүү хамгаалах арга хэрэгслийн талаархи шинжлэх ухаан, технологийн мэдээллийг боломжтой бүх байдлаар харилцан солилцохыг хөнгөвлөн дэмжих үүрэг хүлээх бөгөөд ийнхүү харилцан солилцоход оролцох эрхтэй.

4. Химийн зэвсгээс хамгаалах зорилгод хамаарах үндэсний хөтөлбөрийн ил тод байдлыг дээшлүүлэх зорилгоор оролцогч улс бүр хөтөлбөрийнхөө тухай мэдээллийг 8 дугаар зүйлийн 21 дэх хэсгийн (i) дэд хэсгийн дагуу Бага хурлаас хэлэлцэж батлах журамд нийцүүлэн Техникийн нарийн бичгийн дарга нарын газарт жил бүр өгнө.

5. Техникийн нарийн бичгийн дарга нарын газар химийн зэвсгээс хамгаалах янз бүрийн арга хэрэгслийн талаархи чөлөөтэй олгох мэдээлэл, түүнчлэн оролцогч улсуудаас өгч болох мэдээллийг агуулсан мэдээллийн санг хүсэлт гаргагч оролцогч аливаа улсад ашиглуулах зорилгоор энэхүү конвенц хүчин төгөлдөр болсноос хойш 180 хоногийн дотор байгуулж ажиллуулна.

Түүнчлэн Техникийн нарийн бичгийн дарга нарын газар нь химийн зэвсгээс хамгаалах чадавхиа хөгжүүлж, сайжруулах хөтөлбөрөө хэрхэн хэрэгжүүлж болохыг тодорхойлоход оролцогч улсын хүсэлтээр тухайн улсад өөрийн нөөц бололцооны хүрээнд шинжээчийн зөвлөгөө өгч, туслана.

6. Энэхүү конвенцийн аль ч заалтыг хоёр талын шугамаар тусламж хүсэх болон үзүүлэх, түүнчлэн яаралтай тусламж үзүүлэх талаар оролцогч бусад улстай тус тусад нь хэлэлцээр байгуулах оролцогч улсын эрхийг saatuulж байна гэж тайлбарлахгүй.

7. Оролцогч улс бүр Байгууллагаар дамжуулан тусламж үзүүлэх, энэ үүднээс дор дурдсан нэг буюу хэд хэдэн арга хэмжээг авахаар сонгох үүрэг хүлээнэ:

(a) Бага хурлын анхдугаар чуулганаар байгуулагдах тусламжийн сайн дурын санд хандив оруулах;

(b) шаардлагын дагуу тусламж үзүүлэх талаар энэхүү конвенц тухайн улсын хувьд хүчин төгөлдөр болсноос хойш боломжтой бол 180 хоногийн дотор Байгууллагатай хэлэлцээр байгуулах;

(c) Байгууллагаас уриалсны дагуу үзүүлж болох тусламжийн хэлбэрийн талаар энэхүү конвенц тухайн улсын хувьд хүчин төгөлдөр болсноос хойш 180 хоногийн дотор зарлан мэдэгдэх. Гэхдээ хэрэв хожим нь оролцогч улс мэдэгдэлдээ дурдсан тусламжийг үзүүлэх боломжгүй бол тэрээр энэ хэсэгт нийцүүлэн тусламж үзүүлэх үүргийг хүлээсэн хэвээр байна.

8. Хэрэв оролцогч улс:

(a) түүний эсрэг химийн зэвсэг хэрэглэсэн;

(b) хэв журам сахиулах зорилгоор хэрэглэдэг бодисыг дайны хэрэгсэл болгон түүний эсрэг ашигласан; эсхүл

(c) оролцогч улсуудын хувьд 1 дүгээр зүйлээр хориглосон үйлдэл буюу үйл ажиллагааг явуулахаар аливаа оролцогч улс заналхийлсэн

гэж үзвэл оролцогч улс бүр химийн зэвсэг хэрэглэхийн буюу хэрэглэхээр заналхийлэхийн эсрэг тусlamж, хамгаалалтыг хүсэх болон 9, 10 болон 11 дэх хэсэгт заасан журмын дагуу авах эрхтэй.

9. Холбогдох мэдээллээр баталгаажсан хүсэлтийг Ерөнхий захиралд өгөх бөгөөд тэрбээр уг хүсэлтийг Гүйцэтгэх зөвлөл болон оролцогч бүх улсад нэн даруй дамжуулна. Ерөнхий захирал уг хүсэлтийг химийн зэвсэг буюу хэв журам сахиулах зорилгоор хэрэглэдэг бодисыг дайны хэрэгсэл болгон ашигласан тохиолдолд яаралтай тусlamжийг, эсхүл химийн зэвсэг буюу хэв журам сахиулах зорилгоор хэрэглэдэг бодисыг дайны хэрэгсэл болгон ашиглах ноцтой аюул заналхийлсэн тохиолдолд хүмүүнлэгийн тусlamжийг 7 дахь хэсгийн (b) болон (c) дэд хэсэгт нийцүүлэн оролцогч холбогдох улсад үзүүлэхээ сайн дураар илэрхийлсэн оролцогч улсуудад хүсэлтийг хүлээн авснаас хойш 12 цагийн дотор нэн даруй дамжуулна. Ерөнхий захирал цаашид авах арга хэмжээний үндсийг тодорхойлохын тулд мөрдөн шинжилгээг хүсэлт хүлээн авснаас хойш 24 цагийн дотор эхлүүлнэ. Тэрбээр мөрдөн шинжилгээг 72 цагийн дотор дуусгаж Гүйцэтгэх зөвлөлд илтгэл илгээнэ. Хэрэв мөрдөн шинжилгээг дуусгахад нэмэлт хугацаа шаардагдах тохиолдолд завсрын илтгэлийг дээр дурдсан хугацаанд бэлтгэж өгнө. Мөрдөн шилжилгээ хийх нэмэлт хугацаа нь 72 цагаас хэтрэхгүй. Гэхдээ энэ хугацааг адил хугацаагаар дахин сунгаж болно. Нэмэлт хугацаа дуусах бүр Гүйцэтгэх зөвлөлд илтгэл бэлтгэж өгнө. Мөрдөн шинжилгээгээр хүсэлтэд хамаарах холбогдох үйл баримт, хэрэгтэй нэмэлт тусlamж, хамгаалалтын төрөл, хамрах хүрээг шаардлагатай үед хүсэлт болон түүнийг дагалдсан мэдээлэлд нийцүүлэн тогтооно.

10. Гүйцэтгэх зөвлөл нь мөрдөн шинжилгээний тухай илтгэлийг хүлээн авснаас хойш 24 цагийн дотор байдлыг хэлэлцэхээр хуралдаж, нэмэлт тусlamж үзүүлэхийг Техникийн нарийн бичгийн дарга нарын газарт даалгах эсэх талаар ердийн олонхийн санаалаар дараагийн 24 цагийн дотор шийдвэр гаргана. Техникийн нарийн бичгийн дарга нарын газар нь мөрдөн шинжилгээний тухай илтгэл болон Гүйцэтгэх зөвлөлөөс гаргасан шийдвэрийг оролцогч бүх улс, олон улсын холбогдох байгууллагуудад нэн даруй дамжуулна. Гүйцэтгэх зөвлөл тусlamж үзүүлэхээр шийдвэрлэсэн бол Ерөнхий захирал уг тусlamжийг нэн даруй үзүүлнэ. Эл зорилгоор Ерөнхий захирал нь хүсэлт гаргагч оролцогч улс, оролцогч бусад улс болон олон улсын холбогдох байгууллагуутдай хамтран ажиллаж болно. Оролцогч улсууд тусlamж үзүүлэхийн тулд бүхий л боломжтой чармайлтыг гаргана.

11. Хэрэв химийн зэвсэг хэрэглэснээс хохирогч байгаа бөгөөд нэн даруй арга хэмжээ авах зайлшгүй шаардлагатай байгааг мөрдөн шинжилгээ буюу бусад баталгаатай эх сурвалжаас авсан мэдээлэл хангалттай нотолж байвал Ерөнхий захирал оролцогч бүх улсад мэдэгдэж, Бага хурлаас түүний мэдэлд ийм тохиолдолд хэрэглэхээр олгосон нөөц хөрөнгөөс яаралтай тусlamжийн арга хэмжээ авна. Ерөнхий захирал энэ хэсгийн дагуу авсан арга хэмжээнийхээ талаар Гүйцэтгэх зөвлөлд мэдээлж байна.

*11 дүгээр зүйл  
Эдийн засаг, технологийн хөгжил*

1. Энэхүү конвенцийн заалтыг оролцогч улсуудын эдийн засаг буюу технологийн хөгжилд, түүнчлэн энэхүү конвенцоор хориглоогүй зорилгоор химийн үйл ажиллагаа явуулах салбар дахь олон улсын хамтын ажиллагаа, түүний дотор энэхүү конвенцоор хориглоогүй зорилгоор шинжлэх ухаан, технологийн мэдээлэл, химийн бодис болон химийн бодис үйлдвэрлэх, боловсруулах буюу хэрэглэхэд

шаардагдах тоног төхөөрөмжийг олон улсын хэмжээнд харилцан солилцоход саад учруулахаас зайлсхийх байдлаар хэрэгжүүлнэ.

2. Энэхүү конвенцийн заалтыг мөрдөхийн хамт, түүнчлэн олон улсын эрх зүйн зарчим болон хэрэглэгдэх хэм хэмжээг үл хөндөн оролцогч улсууд:

(а) бие даан буюу хамтран химиин бодисын судалгаа хийх, химиин бодис боловсруулах, үйлдвэрлэх, олж авах, хадгалах, шилжүүлэх болон ашиглах эрхтэй;

(б) энэхүү конвенцоор хориглоогүй зорилгоор химиин шинжлэх ухааныг хөгжүүлэх, түүнийг хэрэглэхэд хамаарах химиин бодис, тоног төхөөрөмж болон шинжлэх ухаан, техникийн мэдээллийг боломжтой бүх байдлаар харилцан солилцохыг хөнгөвчлөн дэмжих үүрэг хүлээж, ийнхүү харицан солилцоход оролцох эрхтэй;

(с) худалдаанд, түүнчлэн химиин шинжлэх ухааны салбарт шинжлэх ухаан, технологийн мэдлэгийг аж үйлдвэр, хөдөө аж ахуй, эрдэм шинжилгээ, анагаах ухаан, эм зүй буюу энхийн бусад зорилгоор хөгжүүлэх болон дэлгэрүүлэхэд хязгаарлалт буюу саад болох бөгөөд энэхүү конвенцийн дагуу хүлээсэн үүрэгт үл нийцэх аливаа хязгаарлалт, түүний дотор олон улсын аливаа хэлэлцээрийн хүрээн дэх хязгаарлалтыг хоорондоо цаашид үл хэрэгжүүлнэ;

(д) энэхүү конвенцийг энэхүү конвенцид заасан буюу зөвшөөрснөөс бусад аливаа арга хэмжээ авах үндэслэл болгон ашиглахгүй, мөн олон улсын аливаа өөр хэлэлцээрийг энэхүү конвенцид үл нийцэх зорилгод ашиглахгүй;

(е) химиин бодисын худалдааны салбарт мөрдөж буй үндэсний журмаа энэхүү конвенцийн зүйл, зорилгод нийцүүлэхийн тулд хянан үзэх үүрэг хүлээнэ.

*12 дугаар зүйл*

**Байдлыг засаж залруулах, Конвенцийг дагаж мөрдөх явдлыг хангах,  
түүний дотор албадах арга хэмжээ авах**

1. Энэхүү конвенцийг дагаж мөрдөх явдлыг хангах, түүнчлэн энэхүү конвенцийн заалтад харшилж буй аливаа байдлыг засаж залруулах үүднээс Бага хурал нь 2, 3 болон 4 дэх хэсэгт заасан шаардлагатай арга хэмжээг авна. Энэ хэсгийн дагуу авах арга хэмжээг Бага хурал хэлэлцэхдээ Гүйцэтгэх зөвлөлөөс өргөн барьсан асуудлын талаархи бүх мэдээлэл, зөвлөмжийг харгалзан үзнэ.

2. Энэхүү конвенцийг дагаж мөрдөж буй эсэх талаар гарсан асуудлыг буй болгож байгаа байдлыг засаж залруулах арга хэмжээ авахыг Гүйцэтгэх зөвлөл оролцогч аливаа улсаас хүссэн бөгөөд уг хүсэлтийг дээрх оролцогч улс тогтоосон хугацаанд биелүүлэгүй тохиолдолд Бага хурал энэхүү конвенцоор түүнд олгосон эрх болон эрх ямбыг энэхүү конвенцоор хүлээсэн үүргээ биелүүлэхэд шаардлагатай арга хэмжээ авах хүртэл нь Гүйцэтгэх зөвлөлийн зөвлөмжийн дагуу *inter alia* хязгаарлах буюу түдгэлзүүлж болно.

3. Энэхүү конвенцоор, ялангуяа 1 дүгээр зүйлээр хориглосон үйл ажиллагааны үр дүнд энэхүү конвенцийн зүйл, зорилгод ноцтой хохирол учирж болох тохиолдолд Бага хурал олон улсын эрх зүйд нийцүүлэн хамтарсан арга хэмжээ авахыг оролцогч улсуудад зөвлөмж болгож болно.

4. Онц ноцтой тохиолдолд Бага хурал уг асуудлыг, түүний дотор холбогдох мэдээлэл, дүгнэлтийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблей болон Нэгдсэн Үндэстний Байгууллагын Аюулгүйн Зөвлөлийн анхааралд хүргэнэ.

*13 дугаар зүйл*

**Олон улсын бусад хэлэлцээртэй холбогдох нь**

Амьсгал боогдуулагч, хортой буюу тэдгээртэй ижил бусад хий болон бактериологийн хэрэгслийг дайнд хэрэглэхийг хориглох тухай 1925 оны 6 дугаар сарын 17-ны өдөр Женев хотноо гарын үсэг зурсан протокол, мөн 1925 оны Женевийн протокол, мөн 1972 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр Лондон, Москва, Вашингтон хотноо гарын үсэг зурсан Бактериологийн (биологийн) болон токсины зэвсэг боловсруулах, үйлдвэрлэх, нөөцлөхийг хориглох болон тэдгээрийг устгах тухай конвенцийн дагуу аливаа улсын хүлээсэн үүргийг аливаа байдлаар хязгаарлаж буюу бууруулж байна гэж энэхүү конвенцийн аль ч заалтыг тайлбарлахгүй.

*14 дүгээр зүйл*

**Маргаан зохицуулах**

1. Энэхүү конвенцийг хэрэглэх буюу тайлбарлахтай холбогdon үүсч болох маргааныг энэхүү конвенцийн холбогдох заалтууд, түүнчлэн Нэгдсэн Үндэстний дүрмийн заалтуудад нийцүүлэн зохицуулна.

2. Хэрэв хоёр буюу хэд хэдэн оролцогч улсын хооронд, эсхүл нэг буюу хэд хэдэн оролцогч улс болон Байгууллагын хооронд энэхүү конвенцийг тайлбарлах буюу хэрэглэхтэй холбогdon маргаан үүсвэл хэлэлцээний буюу тухайн талуудын сонгох эв зүйгээр шийдэх бусад арга, түүний дотор энэхүү конвенцийн холбогдох байгууллагад, түүнчлэн харилцан тохиролцсоны үндсэн дээр Олон улсын шүүхэд уг шүүхийн дүрэмд нийцүүлэн хандаж тухайн маргааныг шуурхай зохицуулах үүднээс холбогдох талууд зөвлөлдөнө. Авч байгаа арга хэмжээнийхээ талаар оролцогч улсууд Гүйцэтгэх зөвлөлд мэдээлж байна.

3. Гүйцэтгэх зөвлөл зохимжтой гэж үзсэн бүхий л арга, түүний дотор зуучлал, өөрсдийн сонгосон аргаар маргааныг зохицуулж эхлэхийг оролцогч улсуудад уриалах, түүнчлэн тохиролцсон аливаа арга хэмжээ авах цаг хугацааны хязгаарыг тодорхойлсон зөвлөмж өгөх зэргээр маргааныг зохицуулахад хувь нэмэр оруулж болно.

4. Бага хурал оролцогч улсуудаас үүсгэсэн буюу Гүйцэтгэх зөвлөлөөс оруулсан маргаанд хамаарах асуудлыг хэлэлцэнэ. Бага хурал нь шаардлагатай гэж үзвэл эдгээр маргааныг зохицуулах үүрэг бүхий байгууллагыг 8 дугаар зүйлийн 21 дэх хэсгийн (f) дэд хэсэгт нийцүүлэн байгуулахад буюу байгууллагад уг үүргийг даалгана.

5. Бага хурал болон Гүйцэтгэх зөвлөл нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн зөвшөөрлийн үндсэн дээр Байгууллагын үйл ажиллагааны хүрээнд үүсч буй эрх зүйн аливаа асуудлаар зөвлөх дүгнэлт өгөхийг Олон улсын шүүхээс хүсэх эрхийг тус тусдаа эдлэнэ. Байгууллага болон Нэгдсэн Үндэстний Байгууллагын хооронд 8 дугаар зүйлийн 34 дэх хэсгийн (a) дэд хэсэгт нийцүүлэн энэ зорилгоор хэлэлцээр байгуулна.

6. Энэ зүйл 9 дүгээр зүйл болон байдлыг засаж залруулах, энэхүү конвенцийг дагаж мөрдөх явдлыг хангах, түүний дотор албадах арга хэмжээ авах тухай заалтуудыг хөндөхгүй.

**15 дугаар зүйл  
Нэмэлт өөрчлөлт**

1. Оролцогч аливаа улс энэхүү конвенцид нэмэлт өөрчлөлт оруулах санал гаргаж болно. 4 дэх хэсэгт заасны дагуу оролцогч аливаа улс энэхүү конвенцийн хавсралтуудад өөрчлөлт оруулах санал гаргаж болно. Нэмэлт өөрчлөлт оруулах саналыг 2 болон 3 дахь хэсэгт заасан журмын дагуу гаргана. 4 дэх хэсэгт зааснаар өөрчлөлт оруулах саналыг 5 дахь хэсэгт дурдсан журмын дагуу гаргана.

2. Санал болгосон нэмэлт өөрчлөлтийн эхийг оролцогч бүх улс болон хадгалагчид тараах зорилгоор Ерөнхий захиралд өгнө. Санал болгосон нэмэлт өөрчлөлтийг зөвхөн Нэмэлт өөрчлөлт оруулах бага хурлаар хэлэлцэнэ. Санал болгосон нэмэлт өөрчлөлтийг тарааснаас хойш 30 хоногийн дотор оролцогч бүх улсын гуравны нэг буюу түүнээс дээш хувь нь саналыг цаашид хэлэлцэхийг дэмжиж байгаагаа Ерөнхий захиралд мэдэгдвэл Нэмэлт өөрчлөлт оруулах бага хурлыг хуралдуулна. Хүсэлт гаргагч оролцогч улсууд Нэмэлт өөрчлөлт оруулах бага хурлыг хугацаанаас нь өмнө хуралдуулах хүсэлт гаргаагүй бол түүнийг Бага хурлын ээлжит чуулганы дараа нэн даруй хуралдуулна. Санал болгосон нэмэлт өөрчлөлтийг тарааснаас хойш 60-аас доош хоногийн дотор Нэмэлт өөрчлөлт оруулах бага хурлыг ямар ч тохиолдолд хуралдуулахгүй.

3. Нэмэлт өөрчлөлт нь доорхи (b) дэд хэсэгт дурдсан оролцогч бүх улс батламж жуух бичиг буюу хүлээн зөвшөөрсөн тухай баримт бичгээ хадгалуулснаас хойш 30 хоногийн дараа оролцогч бүх улсын хувьд дараахь тохиолдолд хүчин төгөлдөр болно:

(a) хэрэв уг нэмэлт өөрчлөлтийг оролцогч бүх улсын олонхи нь дэмжих санал өгч, оролцогч нэг ч улс татгалзах санал өгөлгүйгээр Нэмэлт өөрчлөлт оруулах бага хурлаар батласан; бөгөөд

(b) нэмэлт өөрчлөлт оруулах бага хурал дээр дэмжих санал өгсөн оролцогч бүх улс уг нэмэлт өөрчлөлтийг соёрхон батласан буюу хүлээн зөвшөөрсөн.

4. Энэхүү конвенцийн үр нөлөө, үр ашгийг хангах үүднээс Хавсралтын заалтуудад зөвхөн санал болгосон өөрчлөлт нь захиргаа буюу техникийн шинж чанар бүхий асуудалд хамаарах бол 5 дахь хэсэгт нийцүүлэн өөрчлөлт оруулж болно. Химиин бодисын тухай хавсралтад оруулах бүх өөрчлөлтийг 5 дахь хэсэгт нийцүүлэн гүйцэтгэнэ. Нууцлалын тухай хавсралтын А болон С анги, Нягтлан шалгалтын тухай хавсралтын Х хэсэг, түүнчлэн зөвхөн хүсэлтийн дагуу хийлгэх хянан шалгалтад хамаарах I хэсэгт орсон тодорхойлолтод 5 дахь хэсэгт нийцүүлэн өөрчлөлт оруулахгүй.

5. 4 дэх хэсэгт дурдсан санал болгосон өөрчлөлтийг дараахь журамд нийцүүлэн оруулна:

(a) санал болгосон өөрчлөлтийн хувилбарыг шаардлагатай мэдээллийн хамт Ерөнхий захиралд дамжуулна. Саналыг дүгнэх үүднээс нэмэлт мэдээллийг оролцогч аливаа улс болон Ерөнхий захирал өгч болно. Ерөнхий захирал ийм санал болон мэдээллийг оролцогч бүх улс, Гүйцэтгэх зөвлөл болон хадгалагчид даруй хүргүүлнэ;

(b) саналыг хүлээн авснаас хойш 60 хоногийн дотор Ерөнхий захирал энэхүү конвенцийн заалт, түүний хэрэгжилтэд нөлөөлөх боломжтой бүх үр дагаврыг тодорхойлох үүднээс түүнд үнэлэлт дүгнэлт өгч, энэ талаархи аливаа мэдээллийг оролцогч бүх улс болон Гүйцэтгэх зөвлөлд хүргүүлнэ;

(c) Гүйцэтгэх зөвлөл саналыг, түүний дотор уг санал 4 дэх хэсгийн шаардлагыг хангаж буй эсэхийг өөртөө байгаа бүх мэдээллийг ашиглан шалгаж үзнэ. Саналыг хүлээн авснаас хойш 90 хоногийн дотор Гүйцэтгэх зөвлөл өөрийн зөвлөмжийг холбогдох тайлбарын хамт хэлэлцүүлэхээр оролцогч бүх улсад мэдэгдэнэ. Оролцогч улсууд түүнийг хүлээн авсан тухайгаа 10 хоногийн дотор батална;

(d) саналыг батлахыг Гүйцэтгэх зөвлөл оролцогч бүх улсад зөвлөмж болгосон тохиолдолд түүнийг татгалзаж байгаагаа оролцогч нэг ч улс зөвлөмжийг хүлээн авснаас хойш 90 хоногийн дотор мэдэгдээгүй бол уг саналыг батлагдсан гэж үзнэ. Саналыг хүлээн авахгүй байхыг Гүйцэтгэх зөвлөл зөвлөмж болгосон тохиолдолд татгалзаж байгаагаа оролцогч нэг ч улс зөвлөмжийг хүлээн авснаас хойш 90 хоногийн дотор мэдэгдээгүй бол уг саналыг хүлээн авсангүй гэж үзнэ;

(e) Гүйцэтгэх зөвлөлөөс гаргасан зөвлөмж нь (d) дэд хэсгийн дагуу шаардагдах хүлээн зөвшөөрөх журамд нийцэхгүй бол саналын талаархи шийдвэр, түүний дотор уг санал 4 дэх хэсгийн шаардлагыг хангаж буй эсэх талаархи шийдвэрийг зарчмын асуудал хэмээн Бага хурал ээлжит чуулганаараа авч үзнэ;

(f) Ерөнхий захирал энэ хэсгийн дагуу гаргасан аливаа шийдвэрийн талаар оролцогч бүх улс болон хадгалагчид мэдэгдэнэ;

(g) энэ журмын дагуу батлагдсан өөрчлөлт нь өөр хугацааг тогтоохоор Гүйцэтгэх зөвлөлөөс зөвлөмж болгоогүй буюу Бага хурлаас шийдвэрлээгүй бол ийнхүү батласан тухай Ерөнхий захирал мэдэгдсэн өдрөөс хойш 180 хоногийн дараа оролцогч бүх улсын хувьд хүчин төгөлдөр болно.

*16 дугаар зүйл*

### **Конвенцийн хугацаа, конвенцоос гарах**

1. Энэхүү конвенцийн үйлчлэл хугацаагүй байна.
2. Оролцогч улс бүр энэхүү конвенцийн зүйл болох асуудалд хамаарах онцгой үйл явдал тухайн улсын дээд эрх ашигт занал учруулсан гэж шийдвэл үндэснийхээ бүрэн эрхт байдлыг хэрэгжүүлэн энэхүү конвенцоос гарах эрхтэй. Ийнхүү гарч буй тухайгаа оролцогч улс 90 хоногийн өмнө оролцогч бусад бүх улс, Гүйцэтгэх зөвлөл, хадгалагч болон Нэгдсэн Үндэстний Байгууллагын Аюулгүйн зөвлөлд мэдэгдэнэ. Уг мэдэгдэл тухайн улсын дээд эрх ашигт занал учруулсан гэж үзэж буй онцгой үйл явдлын талаарх мэдээллийг оруулна.
3. Энэхүү конвенцоос оролцогч улс гарах нь улсууд олон улсын эрх зүйн аливаа холбогдох хэм хэмжээ, ялангуяа 1925 оны Женевийн протоколын дагуу хүлээсэн үүргээ үргэлжлүүлэн биелүүлэх үүрэгт аливаа байдлаар нөлөөлөхгүй.

*17 дугаар зүйл*

### **Хавсралтуудын статус**

Хавсралтууд нь энэхүү конвенцийн салшгүй хэсэг мөн. Энэхүү конвенцийг иш татах бүрийд хавсралтууд нь мөн адил хамарагдана.

*18 дугаар зүйл*

### **Гарын үсэг зурах**

Энэхүү конвенц нь хүчин төгөлдөр болохоос өмнө түүнд бүх улс гарын үсэг зурахад нээлттэй байна.

*19 дүгээр зүйл*

### **Соёрхон батлах**

Энэхүү конвенцид гарын үсэг зурсан улсууд түүнийг тус тусын хууль тогтоомжийнхoo дагуу соёрхон батална.

*20 дугаар зүйл*

### **Нэгдэн орох**

Энэхүү конвенц хүчин төгөлдөр болохоос өмнө гарын үсэг зураагүй аливаа улс түүнээс хойш хэдийд ч түүнд нэгдэн орж болно.

*21 дүгээр зүйл*

### **Хүчин төгөлдөр болох**

1. Энэхүү конвенц нь 65 дахь батламж жуух бичгийг хадгалуулсан өдрөөс хойш 180 хоногийн дараа хүчин төгөлдөр болно, гэхдээ ямар ч тохиолдолд түүнд гарын үсэг зурахад нээлттэй болсноос хойш хоёр жилээс өмнө хүчин төгөлдөр болохгүй.

2. Батламж жуух бичиг буюу нэгдэн орсон тухай баримт бичгээ энэхүү конвенц хүчин төгөлдөр болсноос хойш хадгалуулсан улсын хувьд энэхүү конвенц тухайн батламж жуух бичиг буюу нэгдэн орсон тухай баримт бичгийг хадгалуулсан өдрөөс хойш 30 дахь өдөр хүчин төгөлдөр болно.

*22 дугаар зүйл*

### **Тайлбар**

Энэхүү конвенцийн заалтуудад тайлбар хийж үл болно. Энэхүү конвенцийн хавсралтуудад түүний зүйл, зорилгод харшлах тайлбарыг хийж үл болно.

23 дугаар зүйл

### Эх хадгалагч

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргыг энэхүү Конвенцийн хадгалагчаар үүгээр томилж байгаа бөгөөд тэрбээр *inter alia*:

(а) гарын үсэг зурсан өдөр, батламж жуух бичиг буюу нэгдэн орсон тухай баримт бичиг хадгалуулсан өдөр, энэхүү конвенц хүчин төгөлдөр болсон өдөр бүрийн тухай, түүнчлэн бусад мэдэгдлийг хүлээн авсан тухай гарын үсэг зурсан болон нэгдэн орсон бүх улсад шуурхай мэдээлнэ;

(б) энэхүү конвенцийн зохих баталгаатай хуулбарыг гарын үсэг зурсан болон нэгдэн орсон бүх улсын засгийн газарт дамжуулна; түүнчлэн

(с) энэхүү конвенцийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Дүрмийн 102 дугаар зүйлийн дагуу бүртгүүлнэ.

24 дүгээр зүйл

### Адил хүчинтэй эх бичвэр

Англи, араб, испани, орос, франц, хятад, хэлээрх эх бичвэр нь адил хүчинтэй энэхүү Конвенцийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулна.

Дээр дурдсаныг нотолж, эл зорилгоор зохих ёсоор бүрэн эрх олгогдсон дор гарын үсгээ зурагсад энэхүү конвенцид гарын үсэг зурав.

Нэг мянга есөн зуун ерэн гурван оны нэгдүгээр сарын арван гуравны өдөр Парис хотноо үйлдэв.

## ХИМИЙН БОДИСЫН ТУХАЙ ХАВСРАЛТ

### A. Химиин бодисын жагсаалт гаргахад удирдлага болгох зүйлс

#### I жагсаалт гаргахад удирдлага болгох зүйлс

1. Химиин хорт бодис буюу прекурсорыг I жагсаалтад оруулах ёстой эсэхийг авч үзэхдээ дараахь шалгуурыг харгалzan үзнэ:

(а) уг бодис буюу прекурсорыг 2 дугаар зүйлд тодорхойлсноор химиин зэвсгийн хувьд боловсруулсан, үйлдвэрлэсэн, нөөцөлсөн эсхүл хэрэглэсэн;

(б) дараахь нөхцлийн нэг буюу хэд хэд нь бүрэлдсэн учир уг бодис буюу прекурсор нь энэхүү конвенцийн дагуу хориглосон үйл ажиллагаанд хэрэглэгдэх өндөр магадлалтайн улмаас энэхүү конвенцийн зүйл, зорилгод өөрөөр аюул учруулах өндөр эрсдэлтэй;

(i) химиийн бүтэц нь I жагсаалтад орсон химиийн хорт бодистой нягт холбоотой бөгөөд уг бодис буюу прекурсор нь адилтгах шинж чанар агуулсан, эсхүл агуулсан гэж үзэх боломжтой;

(ii) амь нас, эсхүл хэвийн амьдарч хөдөлмөрлөх чадварыг үгүй болгох хэмжээний хорт чанар, түүнчлэн түүнийг химиийн зэвсгийн хувьд хэрэглэх боломжтой болгох бусад шинж чанартай;

(iii) түүнийг I жагсаалтад орсон химиийн хорт бодисыг үйлдвэрлэх технологийн төгсгөлийн ганц шатанд энэ шат нь байгууламж, байлдааны хэрэгсэл, эсхүл аливаа өөр газарт хэрэгжсэн эсэхээс үл хамааран прекурсорын хувьд хэрэглэж болно;

(с) уг бодис буюу прекурсорыг энэхүү конвенцийн дагуу хориглосон зорилгод бага хэрэглэдэг буюу огт хэрэглэдэггүй.

#### II жагсаалт гаргахад удирдлага болгох зүйлс

2. I жагсаалтад ороогүй химиийн хорт бодис, эсхүл I жагсаалтад орсон химиийн бодисын прекурсор буюу II жагсаалтын А хэсэгт орсон химиийн бодисын прекурсорыг II жагсаалтад оруулах ёстой эсэхийг авч үзэхдээ дараахь шалгуурыг харгалzan үзнэ:

(а) амь нас эсхүл хэвийн амьдарч хөдөлмөрлөх чадварыг үгүй болгох хэмжээний хорт чанар, түүнчлэн түүнийг химиийн зэвсгийн хувьд хэрэглэх боломжтой болгох бусад шинж чанар агуулсан учир энэхүү конвенцийн зүйл, зорилгод аюул учруулах ихээхэн эрсдэлтэй;

(б) I жагсаалт, эсхүл II жагсаалтын А хэсэгт орсон химиийн бодис бүрдэх төгсгөлийн шатанд химиийн аль нэг урвал прекурсорын хувьд түүнийг хэрэглэж болно;

(с) I жагсаалт, эсхүл II жагсаалтын А хэсэгт орсон химиийн бодис үйлдвэрлэхэд чухал улмаас энэхүү конвенцийн зүйл, зорилгод аюул учруулах ихээхэн эрсдэлтэй;

(д) энэхүү конвенцийн дагуу хориглоогүй зорилгоор түүнийг их хэмжээгээр арилжааны зорилгоор үйлдвэрлэдэггүй.

#### III жагсаалт гаргахад удирдлага болгох зүйлс

3. Бусад жагсаалтад ороогүй химиийн хорт бодис буюу прекурсорыг III жагсаалтад оруулах ёстой эсэхийг авч үзэхдээ дараахь шалгуурыг харгалzan үзнэ:

(а) уг бодис буюу прекурсорыг химиийн зэвсгийн хувьд үйлдвэрлэсэн, нөөцөлсөн эсхүл хэрэглэсэн;

(б) амь нас, эсхүл хэвийн амьдарч хөдөлмөрлөх чадварыг үгүй болгох хэмжээний хорт чанар, түүнчлэн түүнийг химиийн зэвсгийн хувьд хэрэглэх боломжтой болгох бусад шинж чанартай учир энэхүү конвенцийн зүйл, зорилгод өөрөөр аюул учруулах эрсдэлтэй;

(с) I жагсаалт, эсхүл II жагсаалтын В хэсэгт орсон нэг буюу хэд хэдэн химиийн бодис үйлдвэрлэхэд чухал улмаас энэхүү конвенцийн зүйл, зорилгод аюул учруулах эрсдэлтэй;

(d) энэхүү конвенцийн дагуу хориглоогүй зорилгоор түүнийг их хэмжээгээр арилжааны зорилгоор үйлдвэрлэж болно.

### **В.Химийн бодисын жагсаалт**

Дараахь жагсаалтуудад химийн хорт бодис болон тэдгээрийн прекурсорыг оруулсан. Энэхүү конвенцийг хэрэгжүүлэх зорилгоор эдгээр жагсаалт нь Нягтлан шалгах тухай хавсралтын заалтуудад нийцүүлэн нягтлан шалгах арга хэмжээг хэрэглэхийн тулд химийн бодисыг таньж тогтооно. 2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн (a) дэд хэсгийн дагуу эдгээр жагсаалт нь химийн зэвсгийн тодорхойлолт болохгүй.

(Араас нь хаалтан дотор алкилын бүлгийн жагсаалтыг тусгасан диалкил бүхий химийн бодисын бүлгийг дурдах бүрийд хаалтан дотор жагсаасан алкилын бүлгүүдийн боломжтой бүх нийлмэл дээр үндэслэсэн химийн бүх бодисыг холбогдох жагсаалтад орохгүй гэж шууд заагаагүй бол уг жагсаалтад орсон гэж үзнэ. II жагсаалтын А хэсэгт “\*” тэмдгээр тэмдэглэсэн химийн бодис нь Нягтлан шалгалтын тухай хавсралтын VII хэсэгт зааснаар тогтоосон мэдүүлэг болон нягтлан шалгалтын тусгай босгонд хамрагдана.)

#### **I. Жагсаалт**

A.	Химийн хорт бодис	CAS бүртгэлийн дугаар
(1)	O-алкил ( $\leq$ C10, циклоалкилыг оролцуулан) алкил (Me, Et, n-Pr or i-Pr)-фторфосфонат	
	Жишээлбэл: Зарин: O-изопропилметилфторфосфонат Зоман: O-пинаколилметилфторфосфонат	(107-44-8) (96-64-0)
(2)	O-алкил ( $\leq$ C10, циклоалкилыг оролцуулан) N,N-диалкил (Me, Et, n-Pr or i-Pr) амидоцианфосфат	
	Жишээлбэл: Табун: O-этил N,N-диметиламидоцианфосфат	(77-81-6)
(3)	O-алкил (Н эсхүл $\leq$ C10, циклоалкилыг оролцуулан) S-2-диалкил (Me, Et, n-Pr or i-Pr)-аминоэтил алкил (Me, Et, n-Pr or i-Pr) тиофосфонат болон алкил буюу протон бүхий холбогдох давс	
	Жишээлбэл: VX: О-этил S-2-дизопропиламиноэтилметил-тиофосфат	(50782-69-9)
(4)	Xүхрийн иприт:	
	2-хлорэтилхлорметилхүхэр Иприт хий: Хоёр(2-хлорэтил)хүхэр Хоёр (2-хлорэтил)метан Сесквииприт: 1,2- Хоёр (2-хлорэтил)этан	(2625-76-5) (505-60-2) (63869-13-6) (3563-36-8)

1,3- Хоёр (2-хлорэтилтио)-n-пропан	(63905-10-2)
1,4- Хоёр (2-хлорэтилтио)-n-бутан	(142868-93-7)
1,5- Хоёр (2-хлорэтилтио)-n-пентан	(142868-94-8)
Хоёр (2-хлорэтилтиометил) эфир	(63918-90-1)
О-иприт: Хоёр (2-хлорэтилтиоэтил)эфир	(63918-89-8)

(5) Люизит:

Люизит 1: 2-Хлорвинилдихлорарсин	(541-25-3)
Люизит 2: Хоёр (2-хлорвинил)хлорарсин	(40334-69-8)
Люизит 3: Гурав(2- хлорвиниларсин	(40334-70-1)

(6) Азотот иприт:

HN1: Хоёр (2-хлорэтил)этоламин	(538-07-8)
HN2: Хоёр (2-хлорэтил)метиламин	(51-75-2)
HN3: Гурав(2-хлорэтил)амин	(555-77-1)

(7) Сакситоксин

(35523-89-8)

(8) Рицин

(9009-86-3)

B. Прекурсор:

(9) Алкил (Me, Et, n-Pr or i-Pr) фосфонилдифторид  
Жишээлбэл:  
DF: Метилфосфонилдифторид

(676-99-3)

(10) О-Алкил (Н эсхүл ≤ C10 циклоалкилыг оролцуулан) О-2-диалкил (Me, Et, n-Pr or i-Pr)-аминоэтил алкил (Me, Et, n-Pr or i-Pr) фосфонит болон алкил буюу протон бүхий холбогдох давс

Жишээлбэл:  
QL: О-Этил О-2-дизопропиламиноэтилметилфосфонит

(57856-11-8)

(11) Хлорзарин: О-изопропилметилхлорфосфонат

(1445-76-7)

(12) Хлорзоман: О-пинаколилметилхлорфосфонат

(7040-57-5)

## II жагсаалт

A. Химийн хорт бодис:

- (1) Амитон: О,О-диэтил S-[2-(диэтиламино)этил] тиофосфат болон алкил буюу протон бүхий холбогдох давс
- (2) PFIB: 1,1,3,3,3-пентафтор-2-(гурунфторметил)-1-пропен
- (3) BZ: 3-хинуклидинилбензилат (\*)

(78-53-5)

(382-21-8)

(6581-06-2)

- В. Прекурсор:
- (4) I жагсаалтад орсноос бусад, метил, этил буюу пропилийн (энгийн эсхүл изо-) бүлэг холбоотой, гэхдээ хүчилтөрөгчийн бусад атом холбоогүй фосфорын атом агуулсан химийн бодис
- Жишээлбэл:
- метилфосфонилдихлорид (676-97-1)  
Диметил метилфосфонат (756-79-6)
- Үүнд үл хамаарах: фонофос: О-этил S-фенил (944-22-9)  
этилфосфониолтионат
- (5) N,N-диалкил (Me, Et, n-Pr or i-Pr)  
амиодигалоидфосфат
- (6) Диалкил (Me, Et, n-Pr or i-Pr) N,N-диалкил  
(Me, Et, n-Pr or i-Pr)-амидофосфат
- (7) Гурван хлорт хүнцэл (7784-34-1)
- (8) 2,2-дифенил-2-окси цууны хүчил (76-93-7)
- (9) Хинуклидин-3-ол (1619-34-7)
- (10) N,N-диалкил (Me, Et, n-Pr or i-Pr) аминоэтил-2-хлорид  
болон протон бүхий холбогдох давс
- (11) N,N-диалкил (Me, Et, n-Pr or i-Pr) аминоэтан-2-ол  
болон протон бүхий холбогдох давс
- Үүнд үл хамаарах: N,N-диметиламиноэтанол (108-01-0)  
болон протон бүхий холбогдох давс
- N,N-диэтиламиноэтанол (100-37-8)  
болон протон бүхий холбогдох давс
- (12) N,N-диалкил (Me, Et, n-Pr or i-Pr) аминоэтан-2-тиол  
болон протон бүхий холбогдох давс
- (13) Тиодигликоль: хоёр(2-гидроксиэтил)хүхэр (111-48-8)
- (14) Пинаколилын спирт: 3,3-диметилбутан-2-ол (464-07-3)

III жагсаалт

- A. Химийн хорт бодис:
- (1) Фосген: нүүрс хүчлийн дихлорид (75-44-5)
- (2) Хлорциан (506-77-4)

(3)	Циант устөрөгч	(74-90-8)
(4)	Хлорпикрин: Гурванхлорнитрометан	(76-06-2)
B. Прекурсор:		
(5)	Фосфорын хлорын эсэл	(10025-87-3)
(6)	Гурван хлорт фосфор	(7719-12-2)
(7)	Таван хлорт фосфор	(10026-13-8)
(8)	Гурванметилфосфит	(121-45-9)
(9)	Гурванэтил фосфат	(122-52-1)
(10)	Диметилфосфат	(868-85-9)
(11)	Диэтилфосфат	(762-04-9)
(12)	Нэг хлорт хүхэр	(10025-67-9)
(13)	Хоёр хлорт хүхэр	(10545-99-0)
(14)	Хлорт тионил	(7719-09-7)
(15)	Этилдиэтаноламин	(139-87-7)
(16)	Метилдиэтаноламин	(105-59-9)
(17)	Гурванэтаноламин	(102-71-6)

**ХЭРЭГЖҮҮЛЭЛТ БОЛОН НЯГТЛАН ШАЛГАЛТЫН ТУХАЙ ХАВСРАЛТ  
("НЯГТЛАН ШАЛГАЛТЫН ТУХАЙ ХАВСРАЛТ")**

**I ХЭСЭГ**  
**ТОДОРХОЙЛОЛТ**

1. “Батлагдсан тоног төхөөрөмж” гэж энэхүү хавсралтын II хэсгийн 27 дахь хэсгийн дагуу Техникийн нарийн бичгийн дарга нарын газраас бэлтгэсэн журамд нийцүүлэн Техникийн нарийн бичгийн дарга нарын газраас нотолсон хянан шалгах багийн үүргийг гүйцэтгэхэд шаардлагатай төхөөрөмж, хэрэгслийг хэлнэ. Ийм тоног төхөөрөмж нь мөн хянан шалгах багийн хэрэглэх бичиг хэргийн зүйлс буюу бүртгэлийн материалд хамаарч болно.

2. 2 дугаар зүйлд заасан химийн зэвсэг үйлдвэрлэх байгууламжийн тодорхойлолтод заасан “барилга” гэдэгт тусгай барилга болон ердийн барилга багтана.

(а) “Тусгай барилга” гэж:

Үйлдвэрлэлийн буюу цэнэглэх конфигурацид тусгай тоног төхөөрөмж агуулж буй аливаа барилга, түүний дотор газар доорх байгууламжийг;

Энэхүү конвенцоор хориглоогүй химийн үйлдвэрлэл буюу цэнэглэх үйл ажиллагаанд ерөнхийдөө хэрэглэгддэг барилгаас түүнийг таниулах ялгах шинж тэмдэг бүхий аливаа барилга, түүний дотор газар доорх байгууламжийг хэлнэ.

(b) “Ердийн барилга” гэж 2 дугаар зүйлийн 8 дахь хэсгийн (a)(i) дэд хэсэгт заасан химийн аливаа бодис, эсхүл устгагч химийн бодис үйлдвэрлэдэггүй байгууламжийн хувьд түгээмэл аж үйлдвэрийн жишигт нийцүүлэн барьсан аливаа барилга, түүний дотор газар доорх байгууламжийг хэлнэ.

3. “Хүсэлтийн дагуу хийх хянан шалгалт” гэж оролцогч улсын нутаг дэвсгэр, эсхүл хэргийн харьялал буюу хяналтан дор нь орших аливаа өөр газар дахь аливаа байгууламж буюу байрлалд 9 дүгээр зүйлийн 8-аас 25 дахь хэсгийн дагуу оролцогч өөр улсын хүсэлтээр хийх хянан шалгалтыг хэлнэ.

4. “Химийн органик тодорхой бодис” гэж химийн нэршил, бүтцийн томъёолол нь мэдэгдэж байгаа бол түүгээр, түүнчлэн “Химийн абстракт үйлчилгээний” бүртгэлийн дугаар заагдсан бол түүгээрээ танигдах оксид, хүхэр болон металлын карбонатаас нь бусад карбоны бүх нийлмэлээс бүрдэх химийн нийлмэлийн ангилалд хамаарах химийн аливаа бодисыг хэлнэ.

5. 2 дугаар зүйлд заасан химийн зэвсэг үйлдвэрлэх байгууламжийн тодорхойлолтод заасан “тоног төхөөрөмж” гэдэгт тусгай тоног төхөөрөмж болон ердийн тоног төхөөрөмж багтана.

(a) “Тусгай тоног төхөөрөмж” гэж:

(i) үйлдвэрлэлийн аливаа шугам, түүний дотор бүтээгдэхүүний синтез, тусгаарлах буюу цэвэршүүлэх аливаа урвалж буюу тоног төхөөрөмж, урвалж буюу бүтээгдэхүүнийг тусгаарлах зэрэг технологийн эцсийн шатанд дулаан дамжуулахад шууд хэрэглэдэг аливаа тоног төхөөрөмж, түүнчлэн 2 дугаар зүйлийн 8 дахь хэсгийн (a)(i) дэд хэсэгт заасан химийн аливаа бодистой харьцаанд байсан, эсхүл байгууламж ажиллаж байсан бол химийн тийм бодистой харьцаанд байх байсан аливаа бусад тоног төхөөрөмжийг;

(ii) химийн зэвсэг цэнэглэх аливаа механизм;

(iii) 2 дугаар зүйлийн 8 дахь хэсгийн (a)(i) дэд хэсэгт заасан химийн аливаа бодис эсхүл устгагч химийн бодис үйлдвэрлэдэггүй байгууламжийн хувьд түгээмэл аж үйлдвэрийн жишигт нийцүүлэн барьсан байгууламжаас ялгаатайгаар химийн зэвсэг үйлдвэрлэх байгууламжийн хувьд ажиллах байгууламжид зориулан тусгайлан зохион бүтээсэн, барьсан эсхүл угсарсан аливаа бусад тоног төхөөрөмжийг хэлнэ, тухайлбал: никель ихээр агуулсан хайлмаг эсхүл амархан мууддаггүй бусад тусгай материал; хаягдал хянах, хаягдал цэвэрлэх, агаар шүүх буюу уусгагч сэргээх тусгай тоног төхөөрөмж; тусгаарлагч тусгай сав болон хамгаалах хашлага; химийн зэвсгийн зорилгоор химийн хорт бодист дүн шинжилгээ хийхэд хэрэглэдэг лабораторийн ердийн бус тоног төхөөрөмж; явц хянах зориулалтаар тусгайлан тохируулж зохион бүтээсэн пульт; эсхүл тусгай тоног төхөөрөмжид зориулсан сэлбэг хэрэгсэл.

(b) “Ердийн тоног төхөөрөмж” гэж:

(i) химийн аж үйлдвэрт ер нь хэрэглэдэг бөгөөд тусгай тоног төхөөрөмжийн төрөлд багтдаггүй үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийг;

(ii) химийн аж үйлдвэрт өргөн хэрэглэдэг бусад тоног төхөөрөмж, тухайлбал: гал сөнөөх тоног төхөөрөмж; хамгаалалтын болон аюулгүй байдлыг хянах тоног төхөөрөмж; эмнэлгийн хэрэгсэл, лабораторийн хэрэгсэл; эсхүл холбоо харилцааны тоног төхөөрөмжийг хэлнэ

6. 6 дугаар зүйлд орсон утгаар “байгууламж” гэж дор тодорхойлсон аж үйлдвэрийн аль нэг талбай (“үйлдвэрийн талбай”, “үйлдвэр” болон “нэгж”)-г хэлнэ.

(а) “Үйлдвэрийн талбай” ( завод, фабрик) гэж захиргааны завсрын ўе шаттай, үйл ажиллагааны нэг хяналтан дор оршдог, тухайлбал, дараах нэгдсэн дэд бүтэцтэй нэг буюу хэд хэдэн үйлдвэрийн орон нутгийн нэгдлийг хэлнэ:

- (i) захиргааны болон бусад алба;
- (ii) засвар, арчилгааны цех;
- (iii) эмнэлгийн цэг;
- (iv) нийтийн үйлчилгээ;
- (v) дүн шинжилгээний төв лаборатори;
- (vi) туршилт, судалгааны лаборатори;
- (vii) бохир ус болон хог хаягдал цэвэрлэх төв талбай;
- (viii) агуулах.

(б) “Үйлдвэр” (үйлдвэрлэх байгууламж, цех) гэж, тухайлбал, дараах нэмэлт болон туслах бүтэцтэй нэг буюу хэд хэдэн нэгжээс бүрдсэн харьцангуй бие даасан талбай, бүтэц буюу барилгыг хэлнэ:

- (i) захиргааны жижиг хэлтэс;
- (ii) түүхий эд болон бүтээгдэхүүн хадгалах/боловсруулах талбай;
- (iii) бохир ус/хог хаягдал боловсруулах/цэвэрлэх талбай;
- (iv) хяналт/шинжилгээний лаборатори;
- (v) анхны тусламжийн алба/эмнэлгийн холбогдох хэсэг;

(vi) үйлдвэрийн талбай руу орох, талбай дотор явах, талбайгаас гарагтай холбогдох мэдүүлсэн химийн бодис болон тэдгээрийн түүхий эд, эсхүл тэдгээрээс үйлдвэрлэсэн химийн бүтээгдэхүүний зохих бүртгэл.

(с) “Нэгж” (үйлдвэрлэх нэгж, технологийн нэгж) гэж химийн бодис үйлдвэрлэх, боловсруулах буюу хэрэглэхэд шаардлагатай тоног төхөөрөмжийн зүйл, түүний дотор урвалжийн сав болон систем савны нийлмэлийг хэлнэ.

7. “Байгууламжийн тухай хэлэлцээр” гэж 4, 5 болон 6 дугаар зүйлийн дагуу газар дээрх нягтлан шалгалтад хамрагдах тодорхой байгууламжид хамаарах оролцогч улс болон Байгууллагын хоорондын хэлэлцээр буюу тохиролцоог хэлнэ.

8. “Хүлээн авагч улс” гэж энэхүү конвенцийн дагуу хянан шалгалтад хамрагдах энэхүү конвенцийн оролцогч болох өөр улсын байгууламж буюу талбай нутаг дэвсгэрт нь оршиж буй улсыг хэлнэ.

9. “Орон нутгийн дагалдан яваа хүмүүс” гэж тухайн оронд байх хугацаанд хянан шалгах багийг дагалдан явж туслахаар хянан шалгуулж буй оролцогч улсаас, түүнчлэн зохих тохиолдолд хэрэв тэд хүсвэл хүлээн авагч улсаас томилсон хувь хүмүүсийг хэлнэ.

10. “Тухайн оронд байх хугацаа” гэж хянан шалгах багийн тухайн улсад нэвтрэх боомтод хүрэлцэн ирснээс эхлэн тухайн нэвтрэх боомтоос буцах хүртэлх хугацааг хэлнэ.

11. “Анхны хянан шалгалт” гэж 3, 4, 5, 6 дугаар зүйл, түүнчлэн энэхүү хавсралтын дагуу бэлтгэж өгсөн мэдүүлгийг нягтлан шалгахаар байгууламжид хийх газар дээрх анхны хянан шалгалтыг хэлнэ.

12. “Хянан шалгуулж буй оролцогч улс” гэж нутаг дэвсгэр, эсхүл хэргийн харьяалал буюу хяналтан дор нь орших аливаа бусад газарт нь энэхүү конвенцийн дагуу хянан шалгалт явагдаж буй оролцогч улс, эсхүл хүлээн авагч улсын нутаг дэвсгэрт байгаа байгууламж буюу талбай нь тийм хянан шалгалтад хамрагдаж буй оролцогч улсыг хэлнэ; гэхдээ үүнд энэхүү хавсралтын II хэсгийн 21 дэх хэсэгт заасан оролцогч улсыг хамааруулахгүй.

13. “Хянан шалгагчийн туслах” гэж хянан шалгагчад хянан шалгалт хийх буюу ороход нь туслахаар энэхүү хавсралтын II хэсгийн A ангид зааснаар Техникийн нарийн бичгийн дарга нарын газраас томилсон хувь хүн, тухайлбал, эмнэлгийн, хамгаалалтын, захиргааны ажилтан болон хэлмэрчийг хэлнэ.

14. “Хянан шалгах мандат” гэж тодорхой хянан шалгалт явуулахад нь хянан шалгах багт Ерөнхий захирлаас өгсөн зааварчилгааг хэлнэ.

15. “Хянан шалгах заавар” гэж хянан шалгалт явуулах талаар Техникийн нарийн бичгийн дарга нарын газраас боловсруулсан нэмэлт журмын эмхэтгэлийг хэлнэ.

16. “Хянан шалгах талбай” гэж хянан шалгалт явуулж буй бөгөөд байгууламжийн тухай холбогдох хэлэлцээр, эсхүл хянан шалгалт хийлгэх тухай хүсэлт, эсхүл хянан шалгах мандат, эсхүл нэмэлт буюу эцсийн периметрээр өргөжүүлсэн хянан шалгалт хийлгэх тухай хүсэлтэд тусгайлан тодорхойлсон аливаа байгууламж буюу талбайг хэлнэ.

17. “Хянан шалгах баг” гэж тодорхой хянан шалгалт хийхээр Ерөнхий захирлаас томилсон бүлэг хянан шалгагч болон хянан шалгагчийн туслахыг хэлнэ.

18. “Хянан шалгагч” гэж энэхүү конвенцид нийцүүлэн хянан шалгалт хийх, эсхүл түүнд оролцох энэхүү хавсралтын II хэсгийн A ангид заасан журамд нийцүүлэн Техникийн нарийн бичгийн дарга нарын газраас томилсон хувь хүнийг хэлнэ.

19. “Загвар хэлэлцээр” гэж энэхүү хавсралтад тусгасан нягтлан шалгалтын тухай заалтыг биелүүлэхээр оролцогч улс болон Байгууллагын хооронд байгуулах хэлэлцээрийн ерөнхий хэлбэр, агуулгыг толдорхойлж буй баримт бичгийг хэлнэ.

20. “Ажиглагч” гэж хүсэлтийн дагуу хийх хянан шалгалтыг ажиглах хүсэлт гаргагч оролцогч улс, эсхүл гуравдагч улсын төлөөлөгчийг хэлнэ.

21. Хүсэлтийн дагуу хийх хянан шалгалтын тохиолдолд “периметр” гэж газарзүйн солбицол, эсхүл газрын зураг дээрх тодорхойлолтоор тодорхойлсон хянан шалгах талбайн гадаад хил хязгаарыг хэлнэ.

(a) “Хүсэлт болгосон периметр” гэж энэхүү хавсралтын X хэсгийн 8 дахь хэсэгт нийцүүлсэн хянан шалгалтын талбайн периметрийг хэлнэ;

(b) “Нэмэлт периметр” гэж хүсэлт болгосон периметрийн оронд хэрэглэхээр хянан шалгуулж буй оролцогч улсаас заасан хянан шалгалтын талбайн периметрийг хэлэх бөгөөд энэ нь энэхүү хавсралтын X хэсгийн 17 дахь хэсэгт заасан шаардлагад нийцсэн байна;

(c) “Эцсийн периметр” гэж энэхүү хавсралтын X хэсгийн 16-гаас 21 дэх хэсэгт нийцүүлэн хянан шалгах баг болон хянан шалгуулж буй оролцогч улсын хооронд хийсэн хэлэлцээгээр тохиролцсон хянан шалгах талбайн эцсийн периметрийг хэлнэ;

(d) “Мэдүүлсэн периметр” гэж 3, 4, 5 болон 6 дугаар зүйлийн дагуу мэдүүлсэн байгууламжийн гадаад хил хязгаарыг хэлнэ.

22. 9 дүгээр зүйлийн зорилгоор “хянан шалгах хугацаа” гэж хянан шалгах талбайд нэвтрэх эрхийг хянан шалгах багт олгосноос эхлэн хянан шалгах талбайгаас явах хүртэлх хугацааг хэлэх бөгөөд үүнд нягтлан шалгах үйл ажиллагааны өмнө болон хойш зааварчилгаа өгөхөд зарцуулсан хугацааг оруулна.

23. 4, 5 болон 6 дугаар зүйлийн зорилгоор “хянан шалгах хугацаа” гэж хянан шалгах баг хянан шалгах талбайд хүрэлцэн ирснээс эхлэн хянан шалгах талбайгаас явах хүртэлх хугацааг хэлэх бөгөөд үүнд нягтлан шалгах үйл ажиллагааны өмнө болон хойш зааварчилгаа өгөхөд зарцуулсан хугацааг оруулна.

24. “Нэвтрэх боомт”/“Гарах боомт” гэж энэхүү конвенцийн дагуу хянан шалгалт хийхээр хянан шалгах баг тухайн оронд хүрэлцэн ирэхэд, эсхүл үүргээ гүйцэтгээд буцахад зориулан заасан газрыг хэлнэ.

25. “Хүсэлт гаргагч оролцогч улс” гэж 9 дүгээр зүйлийн дагуу хүсэлтийн дагуу хянан шалгалт хийх хүсэлт гаргасан оролцогч улсыг хэлнэ.

26. “Тонн” гэж метр тонн, өөрөөр хэлбэл, 1.000 кг-ыг хэлнэ.

## II ХЭСЭГ

### НЯГТЛАН ШАЛГАЛТЫН ЕРӨНХИЙ ДҮРЭМ

#### A. Хянан шалгагч болон хянан шалгагчийн туслахыг томилох

1. Энэхүү конвенцийг хүчин төгөлдөр болсноос хойш 30 хоногийн дотор Техникийн нарийн бичгийн дарга нарын газар нь томилохоор санал болгож буй хянан шалгагч болон хянан шалгагчийн туслахын нэр, иргэний харьяалал, албан тушаал, түүнчлэн тэдний мэдлэг чадвар, мэргэжлийн туршлагын талаархи танилцуулгыг оролцогч бүх улсад бичгээр мэдэгдэнэ.

2. Оролцогч улс бүр өөрт нь мэдэгдсэн томилохоор санал болгосон хянан шалгагч болон хянан шалгагчийн туслахуудын нэрийн жагсаалтыг хүлээж авснаа нэн даруй нотолно. Оролцогч улс уг жагсаалтыг хүлээж авснаа нотолсноос хойш 30 хоногийн дотор хянан шалгагч болон хянан шалгагчийн туслах бүрийг хүлээн зөвшөөрсөн тухайгаа Техникийн нарийн бичгийн дарга нарын газарт бичгээр мэдэгдэнэ. Энэ жагсаалтад орсон аливаа хянан шалгагч болон хянан шалгагчийн туслахыг оролцогч аль нэг улс хүлээн зөвшөөрөхгүй байгаагаа уг жагсаалтыг хүлээж авснаа нотолсноос хойш 30 хоногийн дотор бичгээр зарлан мэдэгдээгүй бол томилогдсон гэж үзнэ. Оролцогч улс татгалзсан шалтгаанаа зааж болно.

Хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд санал болгосон хянан шалгагч буюу хянан шалгагчийн туслах хүлээн зөвшөөрөөгүйгээ зарлан мэдэгдсэн оролцогч улсын нутаг дэвсгэр, эсхүл хэргийн харьяалал буюу хяналтан дор нь орших аливаа өөр газарт нягтлан шалгах үйл ажиллагаа явуулахгүй буюу тийм үйл ажиллагаанд оролцохгүй. Техникийн нарийн бичгийн дарга нарын газар нь шаардлагатай бол анхны жагсаалтад нэмж өөр нэр цаашид санал болгоно.

3. Энэхүү конвенцийн дагуу явуулах нягтлан шалгах үйл ажиллагааг зөвхөн томилогдсон хянан шалгагч болон хянан шалгагчийн туслах гүйцэтгэнэ.

4. 5 дахь хэсгийн заалтыг дагаж мөрдөхийн хамт, оролцогч улс өмнө томилогдсон хянан шалгагч болон хянан шалгагчийн туслахаас хэдийд ч татгалзах эрхтэй. Тухайн оролцогч улс нь татгалзсан тухайгаа Техникийн нарийн бичгийн дарга нарын газарт мэдэгдэх бөгөөд татгалзсан шалтгаанаа зааж болно. Ийм татгалзал нь түүнийг Техникийн нарийн бичгийн дарга нарын газар хүлээж авснаас хойш 30 хоногийн дараа хүчин төгөлдөр болно. Техникийн нарийн бичгийн дарга нарын газар нь хянан шалгагч болон хянан шалгагчийн туслахын томилгоог эгүүлэн авсан тухайгаа холбогдох оролцогч улсад нэн даруй мэдэгдэнэ.

5. Хянан шалгалтын тухай мэдэгдэл авсан оролцогч улс хянан шалгах багийн нэрийн жагсаалтад нэр заасан бөгөөд томилогдсон аль ч хянан шалгагч болон хянан шалгагчийн туслахыг тухайн хянан шалгат явуулах хянан шалгах багаас хасахыг эрэлхийлэхгүй.

6. Оролцогч улсын хүлээж авсан буюу түүнд томилогдсон хянан шалгагч болон хянан шалгагчийн туслахын тоо нь хянан шалгагч болон хянан шалгагчийн туслахыг зохих тоогоор хүрэлцээтэй байлгаж, ээлжлэн ажиллуулахад хангалттай байх ёстай.

7. Хэрэв, Ерөнхий захирлын бодлоор, санал болгосон хянан шалгагч болон хянан шалгагчийн туслахыг хүлээж аваагүй нь хангалттай тооны хянан шалгагч болон

хянан шалгагчийн туслахыг томилоход саад болж байгаа, эсхүл Техникийн нарийн бичгийн дарга нарын газрын үүрэг даалгаврыг үр дүнтэй биелүүлэхэд өөрөөр саад учруулж байгаа бол уг асуудлыг Ерөнхий захирал Гүйцэтгэх зөвлөлд толилуулна.

8. Хянан шалгагч болон хянан шалгагчийн туслахын дээр дурдсан жагсаалтад нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай буюу нэмэлт өөрчлөлт оруулах хүсэлт гарсан тухай бүрийд оронд нь ажиллах хянан шалгагч болон хянан шалгагчийн туслахыг анхны жагсаалтад холбогдуулан тогтоосон журмын адил журмаар томилно.

9. Оролцогч өөр улсын нутаг дэвсгэрт байрлаж буй оролцогч аль нэг улсын байгууламжид хянан шалгалт явуулж буй хянан шалгах багийн гишүүдийг хянан шалгуулж буй оролцогч улс болон хүлээн авагч оролцогч улсын аль алинд хэрэглэх энэхүү хавсралтад заасан журамд нийцүүлэн томилно.

#### **В. Эрх ямба, дархан эрх**

10. Оролцогч улс бүр хянан шалгагч болон хянан шалгагчийн туслахын нэрийн жагсаалт, эсхүл түүнд орсон өөрчлөлтийг хүлээж авснаа нотолсноос хойш 30 хоногийн дотор хянан шалгагч болон хянан шалгагчийн туслах бүрт хянан шалгах үйл ажиллагаа явуулах зорилгоор оролцогч тухайн улсын нутаг дэвсгэрт нэвтэрч, үлдэх боломжийг олгохын тулд олон удаагийн орох /гараах болон/, эсхүл дамжин өнгөрөх виз болон бусад ийм баримт бичгийг олгоно. Эдгээр баримт бичиг нь тэдгээрийг Техникийн нарийн бичгийн дарга нарын газарт бэлтгэж өгснөөс хойш наад зах нь хоёр жил хүчин төгөлдөр байна.

11. Чиг үүргээ үр дүнтэйгээр хэрэгжүүлэхийн тулд хянан шалгагч болон хянан шалгагчийн туслахад (a)-(i) дэд хэсэгт заасан эрх ямба, дархан эрхийг олгоно. Эрх ямба, дархан эрхийг хянан шалгах багийн гишүүдэд энэхүү конвенцийн ашиг тусын тулд олгох бөгөөд хувь хүмүүсийн өөрсдийнх нь хувийн ашиг тусын тулд олгохгүй. Ийм эрх ямба, дархан эрхийг тэдэнд хянан шалгуулж буй оролцогч улс, эсхүл хүлээн авагч улсын нутаг дэвсгэрт хүрэлцэн ирэх болон уг нутаг дэвсгэрээс явах хоорондын бүхэл хугацаанд, түүнчлэн албан чиг үүргээ хэрэгжүүлэхдээ өмнө нь гүйцэтгэсэн үйлдлийн хувьд дараа нь олгоно.

(a) Хянан шалгах багийн гишүүдэд Дипломат харилцааны тухай 1961 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн Венийн конвенцийн 29 дүгээр зүйлийн дагуу дипломат төлөөлөгчдийн эдлэх халдашгүй эрхийг олгоно.

(b) Энэхүү конвенцийн дагуу хянан шалгах үйл ажиллагаа явуулж буй хянан шалгах багийн орон сууц болон албан байранд Дипломат харилцааны тухай 1961 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн Венийн конвенцийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн дагуу дипломат төлөөлөгчдийн байранд олгодог халдашгүй байдал болон хамгаалалтыг олгоно.

(c) Хянан шалгах багийн бичиг цаас болон захидал харилцаа, түүний дотор бүртгэл тэмдэглэл нь Дипломат харилцааны тухай 1961 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн Венийн конвенцийн 30 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн дагуу дипломат төлөөлөгчдийн бүх бичиг цаас болон захидал харилцаанд олгодог халдашгүй байдлыг олгоно. Хянан шалгах баг нь Техникийн нарийн бичгийн дарга нарын газартай харьцахдаа томъёолбор хэрэглэх эрхтэй байна.

(d) Хянан шалгах багийн гишүүдийн авч яваа дээж болон батлагдсан тоног төхөөрөмж нь энэхүү конвенцийн заалтад нийцэхийн хамт халдашгүй байх бөгөөд

гаалийн бүх татвараас чөлөөлөгднө. Аюултай дээжийг холбогдох журамд нийцүүлэн тээвэрлэнэ.

(e) Хянан шалгах багийн гишүүдэд Дипломат харилцааны тухай 1961 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн Венийн конвенцийн 31 дүгээр зүйлийн 1, 2 болон 3 дахь хэсгийн дагуу дипломат төлөөлөгчдөд олгодог дархан эрхийг олгоно.

(f) Энэхүү конвенцид заасан үйл ажиллагааг явуулж буй хянан шалгах багийн гишүүд Дипломат харилцааны тухай 1961 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн Венийн конвенцийн 34 дүгээр зүйлийн дагуу дипломат төлөөлөгчдийг чөлөөлдөг татвар, хураамжаас чөлөөлөгднө.

(g) Хянан шалгах багийн гишүүдэд хянан шалгуулж буй оролцогч улс, эсхүл хүлээн авагч оролцогч улсын нутаг дэвсгэрт импорт буюу экспорт нь хуулиар хориотой, эсхүл хорио цээрийн журмаар хянагдаж буй зүйлээс бусад хувийн хэрэглээний зүйлийг гаалийн аливаа татвар буюу холбогдох хураамжгүйгээр оруулахыг зөвшөөрнө.

(h) Хянан шалгах багийн гишүүдэд гадаадын засгийн газрын төлөөлөгчдөд түр хугацааны албан томилолтын үед олгодог валютын болон валют солих хөнгөлөлтийн адил хөнгөлөлтийг олгоно.

(i) Хянан шалгах багийн гишүүд нь хянан шалгуулж буй оролцогч улс, эсхүл хүлээн авагч улсын нутаг дэвсгэрт хувийн ашиг хонжооны зорилгоор мэргэжлийн буюу арилжааны аливаа үйл ажиллагаа эрхлэхгүй.

12. Хянан шалгуулахгүй байгаа оролцогч улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөхөд нь хянан шалгах багийн гишүүдэд Дипломат харилцааны тухай 1961 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн Венийн конвенцийн 40 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн дагуу дипломат төлөөлөгчдийн эдлэх эрх ямба, дархан эрхийг олгоно. Тэдний авч явж буй бичиг цаас болон захидал харилцаа, түүний дотор бүртгэл тэмдэглэл, түүнчлэн дээж болон батлагдсан тоног төхөөрөмжид 11 дэх хэсгийн (c) болон (d) дэд хэсэгт заасан эрх ямба, дархан эрх олгоно.

13. Эрх ямба, дархан эрхээ хөндөхгүйгээр, хянан шалгах багийн гишүүд хянан шалгуулж буй улс, эсхүл хүлээн авагч улсын хууль, журмыг хүндэтгэх үүрэгтэй бөгөөд хянан шалгах мандаттай нь нийцэж буй хэмжээнд тухайн улсын дотоод хэрэгт хөндлөнгөөс үл оролцох үүрэгтэй байна. Хэрэв энэхүү хавсралтад заасан эрх ямба, дархан эрхийг урвуулан ашигласан гэж хянан шалгуулж буй улс, эсхүл хүлээн авагч улс үзвэл ийнхүү урвуулан ашигласан эсэхийг тогтоох, хэрэв тийнхүү тогтоосон бол дахин урвуулан ашиглахаас урьдчилан сэргийлэх зорилгоор тухайн оролцогч улс болон Ерөнхий захирал хоорондоо зөвлөлдөнө.

14. Хэргийн харьяаллаас чөлөөлөгдөх хянан шалгах багийн гишүүдийн дархан эрх нь шүүх ажиллагааны явцад саад учруулах бөгөөд түүнийг энэхүү конвенцийн залтын хэрэгжилтийг хөндөхгүйгээр эгүүлэн авч болно гэж Ерөнхий захирал үзэж байгаа бол уг дархан эрхийг эгүүлэн авч болно. Дархан эрхийг ямагт илэрхий эгүүлэн авна.

15. 11 дэх хэсгийн (d) дэд хэсгийн дагуу олгодгоос бусад энэ ангийн дагуу хянан шалгагчдад олгодог эрх ямба, дархан эрхийг ажиглагчдад мөн олгоно.

## **С. Байнгын тохиролцоо**

### **Нэвтрэх боомт**

16. Оролцогч улс бүр нэвтрэх боомтыг заах бөгөөд Техникийн нарийн бичгийн дарга нарын газарт шаардлагатай мэдээллийг энэхүү конвенц түүний хувьд хүчин төгөлдөр болсноос хойш 30 хоногийн дотор бэлтгэж өгнө. Эдгээр нэвтрэх боомт нь хянан шалгах баг наад зах нь нэг нэвтрэх боомтоос 12 цагийн дотор хянан шалгах аль нэг талбайд хүрэхүйц байна. Нэвтрэх боомтын байрлалыг Техникийн нарийн бичгийн дарга нарын газар оролцогч бүх улсад мэдэгдэнэ.

17. Оролцогч улс бүр нэвтрэх боомтыг өөрчлөх тухайгаа Техникийн нарийн бичгийн дарга нарын газар мэдэгдэх замаар нэвтрэх боомтыг өөрчилж болно. Оролцогч бүх улсад зохих ёсоор мэдэгдэх боломж олгох үүднээс өөрчлөлт нь Техникийн нарийн бичгийн дарга нарын газар уг мэдэгдлийг хүлээж асуудлыг шийдвэрлэхийн тулд оролцогч холбогдох улстай зөвлөлдөнэ.

18. Хэрэв хянан шалгалтыг цаг тухайд нь явуулахад нэвтрэх боомтын тоо хангалтгүй байгаа, эсхүл оролцогч улсын санал болгосон нэвтрэх боомтын өөрчлөлт нь хянан шалгалтыг цаг тухайд нь явуулахад саад учруулна гэж Техникийн нарийн бичгийн дарга нарын газар үзвэл уг асуудлыг шийдвэрлэхийн тулд оролцогч холбогдох улстай зөвлөлдөнэ.

19. Хянан шалгуулж буй оролцогч улсын байгууламж буюу талбай нь хүлээн авагч улсын нутаг дэвсгэрт байгаа, эсхүл нэвтрэх боомтоос хянан шалгалт явуулах байгууламж буюу талбайд хүрэхийн тулд оролцогч өөр улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх шаардлагатай тохиолдолд хянан шалгуулж буй оролцогч улс энэхүү хавсралттай нийцүүлэн уг хянан шалгалттай холбогдох эрхийг хэрэгжүүлж, үүргийг биелүүлнэ. Хүлээн авагч улс тэдгээр байгууламж буюу талбайд хийх хянан шалгалтыг хөнгөвчлөн дэмжих бөгөөд хянан шалгах багийг үүрэг даалгавраа цаг тухайд нь үр дүнтэй байдлаар гүйцэтгэх боломжийг олгохын тулд шаардлагатай дэмжлэг үзүүлнэ. Хянан шалгуулж буй оролцогч улсын байгууламж буюу талбайд хянан шалгалт хийхийн тулд нутаг дэвсгэрээр нь дамжин өнгөрөх шаардлагатай оролцогч улсууд ийнхүү дамжин өнгөрөхийг хөнгөвчлөн дэмжинэ.

20. Хянан шалгуулж буй оролцогч улсын байгууламж буюу талбай энэхүү конвенцийн оролцогч бус улсын нутаг дэвсгэрт байрлаж байгаа тохиолдолд хянан шалгуулж буй улс тэдгээр байгууламж буюу талбайд хийх хянан шалгалтыг энэхүү хавсралтын заалтад нийцүүлэн явуулах явдлыг хангах талаар шаардлагатай бүх арга хэмжээг авна. Энэхүү конвенцийн оролцогч бус улсын нутаг дэвсгэрт нэг буюу хэд хэдэн байгууламж буюу талбайтай оролцогч улс тухайн оролцогч улсад томилсон хянан шалгагч болон хянан шалгагчийн туслахыг хүлээн авагч улс хүлээж авах явдлыг хангах талаар шаардлагатай бүх арга хэмжээг авна. Хэрэв хянан шалгуулж буй оролцогч улс байгууламж буюу талбайд хүрэх боломжийг хангаж чадахгүй бол уг боломжийг хангах талаар шаардлагатай бүх арга хэмжээг авсан гэдгээ харуулна.

21. Хянан шалгалт явуулах хүсэлт гаргасан байгууламж буюу талбай нь оролцогч улсын нутаг дэвсгэрт боловч энэхүү конвенцийн оролцогч бус улсын хэргийн харьялал буюу хяналтан дор орших газарт байрлаж байгаа тохиолдолд оролцогч улс эдгээр байгууламж буюу талбайд хийх хянан шалгалтыг энэхүү хавсралтын заалтад нийцүүлэн явуулах явдлыг хангах талаар хянан шалгуулж буй оролцогч улс болон хүлээн авагч оролцогч улсаас шаардагдаж болох шаардлагатай бүх арга хэмжээг авна. Хэрэв оролцогч улс тэдгээр байгууламж буюу талбайд хүрэх

боловжийг хангаж чадахгүй бол уг боловжийг хангах талаар шаардлагатай бүх арга хэмжээг авсан гэдгээ харуулна. Хянан шалгалт явуулах хүсэлт гаргасан байгууламж буюу талбай нь оролцогч улсын байгууламж буюу талбай байгаа тохиолдолд энэ хэсгийг хэрэглэхгүй.

**Хуваарьт бус агаарын хөлгийг хэрэглэх тохиролцоо**

22. 9 дүгээр зүйлийн дагуу хийх хянан шалгалт болон арилжааны хуваарьт тээвэр хэрэглэсэн тохиолдолд цаг тухайд нь хүрэх боловжгүй бусад хянан шалгалтын хувьд Техникийн нарийн бичгийн дарга нарын газрын өмчилж буй буюу түрээслэж буй агаарын хөлгийг хэрэглэх хэрэгтэй байж болно. Энэхүү конвенц түүний хувьд хүчин төгөлдөр болсноос хойш 30 хоногийн дотор оролцогч улс бүр хянан шалгах талбай байрлаж буй нутаг дэвсгэр рүү болон уг нутаг дэвсгэрээс хянан шалгах баг болон тоног төхөөрөмжийг тээвэрлэж буй хуваарьт бус агаарын хөлгийн дипломат зөвшөөрлийн байнгын дугаарыг Техникийн нарийн бичгийн дарга нарын газарт мэдээлнэ. Заагдсан нэвтрэх боомтод хүрэх болон уг боомтоос явах агаарын хөлгийн чиглэл нь дипломат ийм зөвшөөрлийн үндэс болгон оролцогч улсууд болон Техникийн нарийн бичгийн дарга нарын газрын хооронд тохиролцсон агаарын олон улсын тогтсон замын дагуу байна.

23. Хуваарьт бус агаарын хөлгийг хэрэглэж байгаа тохиолдолд Техникийн нарийн бичгийн дарга нарын газар нь агаарын хөлөгт хянан шалгалт хийх талбай байрлаж буй улсын агаарын орон зайд нэвтрэхээс өмнөх сүүлчийн нисэх зурvasaas нэвтрэх боомт хүртэлх аяллын төлөвлөгөөг хянан шалгуулж буй ороцогч улсад Үндэсний албаар дамжуулан тухайн нисэх зурvasaas хуваарийн дагуу гарах цагаас зургаагаас доошгүй цагийн өмнө өгнө. Ийм төлөвлөгөөг иргэний агаарын хөлөгт хэрэглэх Олон улсын иргэний нисэхийн байгууллагын журамд нийцүүлэн өгнө. Өөрийн өмчилж буй буюу түрээслэж буй агаарын хөлгийн аяллын хувьд Техникийн нарийн бичгийн дарга нарын газар нь аяллын төлөвлөгөө бүрийн тэмдэглэх хэсэгт дипломат зөвшөөрлийн байнгын дугаар болон тухайн агаарын хөлгийг хянан шалгах агаарын хөлөг гэдгийг таниулж буй зохих тэмдэглэлийг тусгана.

24. Хянан шалгалт явуулах гэж буй улсын агаарын орон зайд нэвтрэхийн өмнө хянан шалгах багийн сүүлчийн нисэх зурvasaas хуваарийн дагуу гарахаас гурваас доошгүй цагийн өмнө хянан шалгуулж буй оролцогч улс, эсхүл хүлээн авагч оролцогч улс нь 23 дахь хэсэгт нийцүүлэн бэлтгэж өгсөн аяллын төлөвлөгөөг хянан шалгах баг хүрэлцэн ирэхээр тооцоолсон цагаас өмнө нэвтрэх боомтод хүрэлцэн ирж болохоор батална.

25. Хянан шалгах багийн агаарын хөлгийг Техникийн нарийн бичгийн дарга нарын газар өмчилж буюу түрээслэж буй тохиолдолд хянан шалгуулж буй оролцогч улс нь нэвтрэх боомтод уг агаарын хөлгийг Техникийн нарийн бичгийн дарга нарын газрын шаардсанаар буудал, аюулгүй байдлын хамгаалалт, засвар үйлчилгээ болон түлшээр хангана. Уг агаарын хөлөг нь газардсаны хураамж, хөөрсний хураамж, адилтгах хураамжийг хариуцахгүй. Техникийн нарийн бичгийн дарга нарын газар нь уг түлш, аюулгүй байдлын хамгаалалт болон засвар үйлчилгээний зардлыг хариуцна.

**Захиргааны тохиролцоо**

26. Хянан шалгуулж буй оролцогч улс нь холбоо харилцааны хэрэгсэл, асуулт хариулт явуулах болон бусад үүрэг даалгавар гүйцэтгэхэд шаардлагатай хэмжээнд хэлмэрчийн үйлчилгээ, тээвэр, ажлын орон зайд, орон сууц, хоол, эмнэлгийн үйлчилгээ зэрэг хянан шалгах багт шаардлагатай үйлчилгээгээр хангах буюу ийм

үйлчилгээг зохицуулна. Үүнтэй холбогдуулан хянан шалгах багийн гаргасан дээрх зардлыг Байгууллага хянан шалгуулж буй оролцогч улсад нөхөн олгоно.

#### Батлагдсан тоног төхөөрөмж

27. 29 дэх хэсгийг мөрдөхийн хамт, хянан шалгах шаардлагыг биелүүлэхэд шаардлагатай гэж Техникийн нарийн бичгийн дарга нарын газраас тодорхойлсон бөгөөд 28 дахь хэсэгт нийцүүлэн батласан тоног төхөөрөмжийг хянан шалгах талбайд авч ирэхэд нь хянан шалгуулж буй оролцогч улсын зүгээс хянан шалгах багт хязгаарлалт тавихгүй. Техникийн нарийн бичгийн дарга нарын газар нь дээр тодорхойлсон зорилгод хэрэгтэй байж болох батлагдсан тоног төхөөрөмжийн жагсаалт болон уг тоног төхөөрөмжийг зохицуулж буй бөгөөд энэхүү хавсралтад нийцэх журмыг бэлтгэж, шаардлагатай үед шинэчлэнэ. Батлагдсан тоног төхөөрөмжийн жагсаалт болон эдгээр журмыг тогтоохдоо Техникийн нарийн бичгийн дарга нарын газар нь уг тоног төхөөрөмжийг хэрэглэх магадлалтай бүх төрлийн байгууламжийн талаархи аюулгүй байдлыг бүрэн харгалзаж үзнэ. Батлагдсан тоног төхөөрөмжийн жагсаалтыг 8 дугаар зүйлийн 21 дэх хэсгийн (i) дэд хэсгийн дагуу Бага хурал хэлэлцэж, батална.

28. Тоног төхөөрөмж нь Техникийн нарийн бичгийн дарга нарын газрын хамгаалалтад байж, түүнийг Техникийн нарийн бичгийн дарга нарын газар сонгож, хэмжин тэмдэглэж, батална. Техникийн нарийн бичгийн дарга нарын газар нь шаардлагатай тодорхой төрлийн хянан шалгалтад тусгайлан зориулагдсан тоног төхөөрөмжийг боломжтой хэмжээнд сонгоно. Сонгож, батласан тоног төхөөрөмжийг зөвшөөрөлгүйгээр өөрчлөхөөс тусгайлан хамгаална.

29. Хянан шалгуулж буй оролцогч улс нь тогтоосон цагийн хязгаарыг хөндөхгүйгээр нэвтрэх боомтод хянан шалгах багийн гишүүдийг байлуулан тоног төхөөрөмжийг шалгах, өөрөөр хэлбэл, хянан шалгуулж буй оролцогч улс, эсхүл хүлээн авагч оролцогч улсын нутаг дэвсгэрт оруулсан буюу нутаг дэвсгэрээс гаргасан тоног төхөөрөмжийг танъж тогтоохоор үзлэг хийх эрхтэй байна. Тийнхүү танъж тогтоохыг хөнгөвчлөн дэмжихийн тулд Техникийн нарийн бичгийн дарга нарын газар нь тухайн тоног төхөөрөмжийг сонгож, батласнаа нотлох баримт бичиг, төхөөрөмжийг хавсаргана. Түүнчлэн тоног төхөөрөмжийг шалгаснаар уг тоног төхөөрөмж нь тодорхой төрлийн хянан шалгалтанд зориулж батласан тоног төхөөрөмжийн тодорхойлолттой нийцэж байгааг хянан шалгуулж буй оролцогч улс хангалттай үзсэнийг нотолно. Хянан шалгуулж буй оролцогч улс уг толорхойлолтод тохироогүй, эсхүл дээр дурдсан нотлох баримт бичиг болон төхөөрөмжгүй тоног төхөөрөмжийг хасаж болно. Тоног төхөөрөмжийг шалгах журмыг 8 дугаар зүйлийн 21 дэх хэсгийн (i) дэд хэсгийн дагуу Бага хурал хэлэлцэж, батална.

30. Хянан шалгах баг Техникийн нарийн бичгийн дарга нарын газарт хамаарахгүй боловч тухайн талбайд байгаа тоног төхөөрөмжийг хэрэглэх шаардлагатай гэж үзсэн бөгөөд уг тоног төхөөрөмжийг ашиглах боломж олгохыг хянан шалгуулж буй оролцогч улсаас хүссэн тохиолдолд хянан шалгуулж буй оролцогч улс боломжтой хэмжээндээ дээрх хүсэлтийг биелүүлнэ.

#### **D. Хянан шалгалтын өмнөх үйл ажиллагаа**

##### Мэдэгдэл

31. Ерөнхий захирал нь хянан шалгалт явуулах гэж буйгаа хянан шалгах баг нэвтрэх боомтод төлөвлөсөн ёсоор хүрэлцэн ирэхээс өмнө, хэрэв цагийн хязгаар тогтоосон бол түүний хүрээнд оролцогч улсад мэдэгдэнэ.

32. Ерөнхий захирлын хийх мэдэгдэлд дараах мэдээлэл багтана:

- (a) хянан шалгалтын төрөл;
- (b) нэвтрэх боомт;
- (c) нэвтрэх боомтод хүрэлцэн ирэх он, сар, өдөр болон цаг;
- (d) нэвтрэх боомтод хүрэлцэн ирэх хэрэгсэл;
- (e) хянан шалгалт хийх талбай;
- (f) хянан шалгагч болон хянан шалгагчийн туслахын нэрс;
- (g) шаардлагатай үед тусгай аяллын хөлөг онгоцны зөвшөөрөл.

33. Хянан шалгуулж буй оролцогч улс нь хянан шалгалт явуулах гэж буйгаа Техникийн нарийн бичгийн дарга нарын газар мэдэгдсэнийг хүлээж авснаа уг мэдэгдлийг хүлээж авснаас хойш нэг цагийн дотор нотолно.

34. Оролцогч өөр улсын нутаг дэвсгэрт байрлаж буй оролцогч аль нэг улсын байгууламжийг хянан шалгах тохиолдолд оролцогч хоёр улсад 31 болон 32 дахь хэсэгт нийцүүлэн нэгэн зэрэг мэдэгдэнэ.

Хянан шалгуулж буй оролцогч улс, эсхүл хүлээн авагч улсын нутаг дэвсгэр рүү нэвтрэх, хянан шалгах талбай уруу хөдлөх

35. Хянан шалгах баг хүрэлцэн ирэх тухай мэдэгдэл авсан хянан шалгуулж буй оролцогч улс, эсхүл хүлээн авагч улс түүнийг нутаг дэвсгэртээ нэн даруй нэвтрэх явдлыг хангах бөгөөд хянан шалгах баг болон түүний тоног төхөөрөмж, хангамжийг нэвтрэх боомтоос хянан шалгах талбай(нууд) уруу болон гарах боомт уруу аюулгүй хүрэх явдлыг хангах талаар өөрөөс хамаарах бүхнийг орон нутгийн дагалдан яваа хүмүүс, эсхүл бусад аргаар хийнэ.

36. Хянан шалгуулж буй оролцогч улс, эсхүл хүлээн авагч оролцогч улс нь хянан шалгах багт хянан шалгах талбайд нэвтрэх боомтод хүрэлцэн ирснээс хойш 12 цагийн дотор хүрэхэд нь шаардлагатай үед туслана.

#### Хянан шалгалтын өмнөх зааварчилгаа

37. Хянан шалгах талбайд хүрэлцэн ирмэгц, хянан шалгалт эхлэхээс өмнө тухайн байгууламж, тэнд явуулж буй үйл ажиллагаа, хянан шалгалтад шаардлагатай аюулгүй байдлын арга хэмжээ болон захиргаа, зохион байгуулалтын зохицуулалтын талаар газрын зураг болон бусад бичиг баримтын тусламжтайгаар байгууламжийн төлөөлөгчид хянан шалгах багт зааварчилгаа өгнө. Зааварчилгаанд зарцуулах цаг нь шаардлагатай наад захын хэмжээнд хязгаарлагдах бөгөөд ямар ч тохиолдолд гурван цагаас хэтрэхгүй.

#### **E. Хяналт шалгалт явуулах**

**Ерөнхий дүрэм**

38. Хянан шалгах багийн гишүүд чиг үүргээ энэхүү конвенцийн заалт, түүнчлэн Ерөнхий захирлын тогтоосон дүрэм, оролцогч улсууд болон Байгууллагын хооронд байгуулсан байгууламжийн тухай хэлэлцээрт нийцүүлэн гүйцэтгэнэ.

39. Хянан шалгах баг нь Ерөнхий захирлын олгосон хянан шалгах мандатыг чанд сахина. Хянан шалгах баг нь энэ мандатаас гадуур ямарваа үйл ажиллагаанаас түдгэлзэнэ.

40. Хянан шалгах багийн үйл ажиллагааг түүнийг чиг үүргээ цаг тухайд нь үр дүнтэйгээр гүйцэтгэх явдлыг хангахаар, хянан шалгуулж буй оролцогч улс, эсхүл хүлээн авагч улс, түүнчлэн хянан шалгуулж буй байгууламж буюу талбайд боломжийн хэмжээнд хамгийн саад бага учруулахаар зохицуулна. Хянан шалгах баг нь байгууламжийн ажиллагаанд шаардлагагүй саад учруулах буюу саатуулахаас, түүнчлэн түүний аюулгүй байдалд нөлөөлөхөөс зайлсхийнэ. Ялангуяа, хянан шалгах баг нь ямарваа байгууламжийг ажиллуулахгүй. Хэрэв хянан шалгагчид мандатаа гүйцэтгэхийн тулд байгууламжид тодорхой ажиллагаа явуулах нь зүйтэй гэж үзвэл хянан шалгуулж буй байгууламжийн томилогдсон төлөөлөгчөөс уг ажиллагааг гүйцэтгэхийг хүснэ. Төлөөлөгч нь боломжтой хэмжээнд хүсэлтийг биелүүлнэ.

41. Хянан шалгуулж буй оролцогч улс, эсхүл хүлээн авагч улсын нутаг дэвсгэрт үүргээ гүйцэтгэхэд хэрэв хянан шалгуулж буй оролцогч улс тийнхүү хүсвэл хянан шалгах багийн гишүүдийг хянан шалгуулж буй оролцогч улсын төлөөлөгчид дагалдах боловч ингэснээр хянан шалгах баг чиг үүргээ хэрэгжүүлэхийг саатуулах буюу өөрөөр саад учруулах ёсгүй.

42. Хянан шалгалт явуулах дэлгэрэнгүй журмыг Техникийн нарийн бичгийн дарга нарын газар хянан шалгах зааварт оруулахаар 8 дугаар зүйлийн 21 дэх хэсгийн (i) дэд хэсгийн дагуу Бага хурлаар хэлэлцэж, батлах удирдамжийг харгалзан боловсруулна.

**Аюулгүй байдал**

43. Үйл ажиллагаагаа явуулахдаа хянан шалгагч болон хянан шалгагчийн туслах нь хянан шалгах талбайд тогтоосон аюулгүй байдлын журам, түүний дотор байгууламжийн доторхи хяналтан дор орших талбайг хамгаалах болон хувийн аюулгүй байдлын талаархи журмыг мөрдөнө.

**Холбоо харилцаа**

44. Хянан шалгагчид нь тухайн оронд байх хугацааны турш Техникийн нарийн бичгийн дарга нарын газрын Төв байртай холбоо харилцаатай байх эрхтэй. Энэхүү зорилгоор тэд зохих ёсоор гэрчлэгдэн батлагдсан өөрийн тоног төхөөрөмжийг хэрэглэж болох бөгөөд тэдэнд алсын бусад холбоо харилцаатай байх боломж олгохыг хянан шалгуулж буй оролцогч улс эсхүл хүлээн авагч оролцогч улсаас хүсэж болно. Хянан шалгах баг нь периметрийг харуулдан хамгаалж байгаа ажилтнууд болон хянан шалгах багийн бусад гишүүний хооронд хоёр талт радио харилцааны өөрийн системийг хэрэглэх эрхтэй.

**Хянан шалгах баг, хянан шалгуулж буй оролцогч улсын эрх**

45. Хянан шалгах баг нь энэхүү конвенцийн холбогдох зүйлүүд болон хавсралтууд, түүнчлэн хянан шалгах заасан байгууламжийн тухай хэлэлцээр болон журамд нийцүүлэн хянан шалгах талбайд саадгүй нэвтрэх эрхтэй. Хянан шалгах зүйлсийг хянан шалгагч нар сонгоно.

46. Хянан шалгагч нар нь холбогдох баримтыг тогтоох зорилгоор хянан шалгуулж буй оролцогч улсын төлөөлөгчдийг байлцуулан байгууламжийн аливаа ажилтныг байцаах эрхтэй. Хянан шалгагч нар нь зөвхөн тухайн хянан шалгалтыг явуулахад шаардлагатай мэдээлэл, тоо баримтыг хүсэх бөгөөд хянан шалгуулж буй оролцогч улс нь уг мэдээллийг хүсэлтийн дагуу гарган өгнө. Хэрэв байгууламжийн ажилтанд тавьсан асуулт нь хянан шалгалтад холбогдолгүй гэж үзвэл хянан шалгуулж буй оролцогч улс нь уг асуултад хариулахаас татгалзах эрхтэй. Хэрэв хянан шалгах багийн тэргүүн тэргээрийн холбогдоос татгалзаж, энэ тухай мэдэгдвэл асуултыг хариу авахаар хянан шалгуулж буй оролцогч талд бичгээр өгнө. Хянан шалгах баг асуулт хариулт явуулахыг зөвшөөрөхөөс буюу асуултад хариулахаас татгалзсан тухай болон өгсөн тайлбарын талаар хянан шалгалтын илтгэлийн хянан шалгуулж буй оролцогч улсын зүгээс хамтран ажилласан тухай хэсэгт тэмдэглэж болно.

47. Хянан шалгагч нар нь үүргээ биелүүлэхэд нь холбогдолтой гэж үзсэн бичиг баримт, бүртгэл тэмдэглэлийг хянан шалгах эрхтэй.

48. Хянан шалгагч нар нь тэдний хүсэлтээр хянан шалгуулж буй оролцогч улсын, эсхүл хянан шалгуулж буй байгууламжийн төлөөлөгчдийн авсан гэрэл зургийг авах эрхтэй. Шууд гарах гэрэл зураг авах боломжоор мөн хангана. Хянан шалгах баг нь гэрэл зураг нь хүсэлтэд нь нийцэж буй эсэхийг тодорхойлох бөгөөд хэрэв нийцээгүй бол давтан гэрэл зураг авна. Хянан шалгах баг болон хянан шалгуулж буй оролцогч улс гэрэл зураг бүрээс тус бүр нэг хувийг авч үлдэнэ.

49. Хянан шалгуулж буй оролцогч улсын төлөөлөгчид нь хянан шалгах багийн хэрэгжүүлж буй нягтлан шалгах бүх үйл ажиллагааг ажиглах эрхтэй.

50. Хянан шалгуулж буй оролцогч улс нь байгууламж(үүд)-ийнх нь талаар Техникийн нарийн бичгийн дарга нарын газрын цуглуулсан мэдээлэл, тоо баримтын хуулбарыг хүсэлт гарган авна.

51. Хянан шалгагч нар хянан шалгалтын явцад үүсэх бүрхэг байдалтай холбогдуулан тодруулга хүсэх эрхтэй. Ийм хүсэлтийг хянан шалгуулж буй оролцогч улсын төлөөлөгчөөр дамжуулан шуурхай гаргана. Хянан шалгуулж буй оролцогч улсын төлөөлөгч нь тухайн бүрхэг байдлыг арилгахад шаардлагатай байж болох тодруулгыг хянан шалгалтын явцад хянан шалгах багт өгнө. Хэрэв хянан шалгах талбай дотор байрласан зүйл буюу барилгад хамаарах асуудлыг шийдвэрлээгүй бол шинж чанар, зориулалтыг тодруулах зорилгоор тухайн зүйл буюу барилгын гэрэл зургийг хэрэв тийнхүү хүссэн бол авна. Хэрэв хянан шалгалтын явцад бүрхэг байдлыг арилгаж чадахгүй бол хянан шалгагч нар нэн даруй Техникийн нарийн бичгийн дарга нарын газарт мэдэгдэнэ. Хянан шалгагч нар шийдвэрлэгдээгүй аливаа асуудал, холбогдох тодруулга, түүнчлэн авсан аливаа гэрэл зургийн хувийг хянан шалгалтын илтгэлд оруулна.

#### Дээж цуглуулах, боловсруулах, шинжлэх

52. Хянан шалгуулж буй оролцогч улсын буюу хянан шалгуулж буй байгууламжийн төлөөлөгчид хянан шалгагч нарыг байлцуулан хянан шалгах багийн хүсэлтээр дээж авна. Хэрэв хянан шалгуулж буй оролцогч улсын буюу хянан

шалгуулж буй байгууламжийн төлөөлөгчидтэй урьдчилан тохиролцсон бол хянан шалгах баг нь өөрөө дээж авч болно.

53. Боломжтой тохиолдолд дээжийн шинжилгээг газар дээр нь гүйцэтгэнэ. Хянан шалгах баг нь дээжийн газар дээрх шинжилгээг өөрийн авч ирсэн батлагдсан тоног төхөөрөмжийг хэрэглэн гүйцэтгэх эрхтэй. Хянан шалгах багийн хүсэлтээр хянан шалгуулж буй оролцогч улс тохиролцсон журамд нийцүүлэн дээжийг газар дээр нь шинжлэхэд тусламж үзүүлнэ. Үүний оронд хянан шалгах баг нь газар дээрх зохих шинжилгээг уг багийг байлцуулан гүйцэтгэхийг хүсэж болно.

54. Хянан шалгуулж буй оролцогч улс нь авсан бүх дээжээс зарим хэсгийг авч үлдэх буюу дээжийг хувилах, түүнчлэн дээжийг газар дээр нь шинжлэхэд байлцах эрхтэй.

55. Хянан шалгах баг нь хэрэв шаардлагатай гэж үзвэл дээжийг Байгууллагын заасан лабораторид талбайгаас гаднах шинжилгээ хийхээр шилжүүлнэ.

56. Ерөнхий захирал нь дээжийн аюулгүй, бүрэн бүтэн байдал болон хадгалалтыг, түүнчлэн талбайгаас гаднах шинжилгээнд шилжүүлж буй дээжийн нууцлалыг хамгаалах явдлыг хангах гол хариуцлагыг хүлээнэ. Ерөнхий захирал нь 8 дугаар зүйлийн 21 дэх хэсгийн (i) дэд хэсгийн дагуу Бага хурлаар хэлэлцэж, батлах журамд нийцүүлэн хянан шалгах зааварт оруулахаар ийнхүү гүйцэтгэнэ. Тэрбээр:

(a) дээж цуглуулах, боловсруулах, тээвэрлэх болон шинжлэхийг зохицуулах чанга дэглэм тогтооно;

(b) өөр өөр төрлийн шинжилгээ хийхээр томилогдсон лабораторид гэрчилгээ олгоно;

(c) эдгээр томилогдсон лаборатори дахь тоног төхөөрөмж, журам, түүнчлэн шинжилгээний хөдөлгөөнт тоног төхөөрөмж, журмыг стандартчилж, эдгээр лаборатори, хөдөлгөөнт тоног төхөөрөмж, журамд гэрчилгээ олгохтой хамааруулан чанарын шалгалт болон ерөнхий жишгийг ажиглан шинжинэ;

(d) томилогдсон лабораториудаас тодорхой мөрдөн шинжилгээтэй хамааруулан шинжилгээний буюу бусад чиг үүрэг гүйцэтгэх лабораторийг сонгоно.

57. Талбайгаас гадна шинжилгээ хийх тохиолдолд дээжийг наад зах нь томилогдсон хоёр лабораторид шинжилнэ. Техникийн нарийн бичгийн дарга нарын газар нь шинжилгээг шуурхай хийх явдлыг хангана. Техникийн нарийн бичгийн дарга нарын газар дээжийн тооллого хийж, хэрэглээгүй аливаа дээж буюу тэдгээрийн хэсгийг Техникийн нарийн бичгийн дарга нарын газарт буцааж өгнө.

58. Техникийн нарийн бичгийн дарга нарын газар нь энэхүү конвенцийг биелүүлэхтэй холбоотой дээжийн лабораторийн шинжилгээний дүнг нэгтгэж, хянан шалгалтын эцсийн илтгэлд оруулна. Техникийн нарийн бичгийн дарга нарын газар нь томилогдсон лабораторийн ашигласан тоног төхөөрөмж болон аргачлалын талаархи дэлгэрэнгүй мэдээллийг илтгэлд оруулна.

#### Хянан шалгалтын хугацааг сунгах

59. Хянан шалгалтын хугацааг хянан шалгуулж буй оролцогч улсын төлөөлөгчийн зөвшөөрлөөр сунгаж болно.

**Үр дүнгийн талаархи зөвлөгөөн**

60. Хянан шалгалт дуусмагц хянан шалгах баг хянан шалгах багийн урьдчилсан дүнг хянан үзэх болон аливаа бүрхэг байдлыг тодруулахаар хянан шалгуулж буй оролцогч улсын төлөөлөгчид болон хянан шалгах талбайг хариуцаж буй ажилтнуудтай уулзана. Хянан шалгах баг нь хянан шалгуулж буй оролцогч улсын төлөөлөгчдөд урьдчилсан дүнг стандартчилсан маягтад нийцүүлэн аливаа дээжийн жагсаалт, түүнчлэн цуглуванс бичгэн мэдээлэл, тоо баримт болон талбайгаас гадна авсан бусад материалын хуулбарын хамт бичгээр өгнө. Уг баримт бичигт хянан шалгах багийн тэргүүн гарын үсэг зурна. Баримт бичгийн агуулгатай танилцсанаа тэмдэглэхийн тулд хянан шалгуулж буй оролцогч улсын төлөөлөгч уг баримт бичигт дараа нь гарын үсэг зурна. Энэ уулзалтыг хянан шалгалтыг дууссанаас хойш 24 цагийн дотор дуусгана.

**F. Явах**

61. Хянан шалгалтын дараахь журмыг гүйцэтгэж дуусмагц хянан шалгах баг нь хянан шалгуулж буй оролцогч улс, эсхүл хүлээн авагч улсын нутаг дэвсгэрээс аль болох түргэн явна.

**G. Илтгэл**

62. Хянан шалгалтаас хойш 10 хоногийн дотор хянан шалгагч нар явуулсан үйл ажиллагаа, олж тогтоосон зүйлийнхээ талаар эцсийн бодит илтгэл бэлтгэнэ. Илтгэлд хянан шалгах мандатын дагуу зөвхөн энэхүү конвенцийн биелэхтэй холбоотой үйл баримтыг тусгана. Илтгэлд мөн хянан шалгуулж буй оролцогч улс хянан шалгах багтай хамтран ажилласан тухай мэдээллийг мөн тусгана. Хянан шалгагч нарын ялгаатай саналыг илтгэлд хавсаргаж болно. Илтгэл нь нууц байна.

63. Эцсийн илтгэлийг нэн даруй хянан шалгуулж буй оролцогч улсад өгнө. Хянан шалгуулж буй оролцогч улсын олж тогтоосон зүйлийнхээ талаар нэн даруй бичгээр гаргаж болох аливаа саналыг илтгэлд хавсаргана. Эцсийн илтгэлийг хянан шалгуулж буй оролцогч улсын гаргаж хавсаргасан саналын хамт Ерөнхий захиралд хянан шалгалтаас хойш 30 хоногийн дотор өгнө.

64. Уг илтгэлд тодорхой бус зүйл байвал, эсхүл Үндэсний алба болон хянан шалгагч нарын хоорондын хамтын ажиллагаа шаардлагатай жишгийн хэмжээнд хүрэхгүй бол Ерөнхий захирал нь тодруулга авахаар оролцогч тухайн улсад хандана.

65. Хэрэв тодорхой бус зүйлийг арилгах боломжгүй, эсхүл тогтоосон баримт нь шинж чанараараа энэхүү конвенцийн дагуу хүлээсэн үүргийг биелүүлээгүй гэж үзэхэд хүргэж байгаа бол Ерөнхий захирал нь Гүйцэтгэх зөвлөлд сааталгүй мэдээлнэ.

**H. Ерөнхий заалтыг хэрэглэх**

66. Энэ хэсгийн заалт нь энэхүү хавсралтын III – XI хэсэгт тусгай төрлийн хянан шалгалтын хувьд заасан заалтаас ялгаатай байх (энэ тохиолдолд энэхүү хавсралтын III – XI хэсэгт тусгай төрлийн хянан шалгалтын хувьд заасан заалт давамгайлна)-аас бусад тохиолдолд энэ хэсгийн заалтыг энэхүү конвенцийн дагуу явуулах бүх хянан шалгалтад хэрэглэнэ.

### III ХЭСЭГ

#### **4, 5 ДУГААР ЗҮЙЛ БОЛОН 6 ДУГААР ЗҮЙЛИЙН ЗАХАРЫН ДАГУУ ХЯНАН ШАЛГАЛТЫН АРГА ХЭМЖЭЭ АВАХ ТАЛААРХИИ ЕРӨНХИЙ ЗААЛТ**

##### **A. Анхны хянан шалгалт, байгууламжийн тухай хэлэлцээр**

1. 4, 5 дугаар зүйл болон 6 дугаар зүйлийн дагуу газар дээрх хянан шалгалтад хамрагдах мэдүүлсэн байгууламж бүр тухайн байгууламжийн тухай мэдүүлсний дараа анхны хянан шалгалтыг шуурхай явуулна. Энэ хянан шалгалтын зорилго нь өгсөн мэдээллийг нягтлан шалгах, тухайн байгууламжид цаашид нягтлан шалгах үйл ажиллагаа явуулах, түүний дотор газар дээр нь хянан шалгах болон газар дээр нь байрлуулсан багаж хэрэгслээр тасралтгүй ажиглан шинжихээр төлөвлөхөд хэрэгтэй аливаа нэмэлт мэдээлэл олж авах, түүнчлэн байгууламжийн тухай хэлэлцээрт ажиллахад оршино.

2. Оролцогч улсууд энэхүү конвенц тэдгээр улсын хувьд хүчин төгөлдөр болсны дараа тогтоосон цагийн хязгаарт мэдүүлэг нягтлан шалгах болон нягтлан шалгах тогтмол арга хэмжээг эхлүүлэх ажлыг Техникийн нарийн бичгийн дарга нарын газар бүх байгууламжид гүйцэтгэж чадах явдлыг хангана.

3. Оролцогч улс бүр мэдүүлсэн бөгөөд 4, 5 дугаар зүйл болон 6 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн дагуу газар дээр нь хянан шалгах байгууламж бүрийн хувьд Байгууллагатай байгууламжийн тухай хэлэлцээр байгуулна.

4. химийн зэвсэг устгах 5 болон 7 дахь хэсгийг хэрэглэх байгууламжаас бусад тохиолдолд байгууламжийн тухай хэлэлцээрийг энэхүү конвенц тухайн улсын хувьд хүчин төгөлдөр болсноос хойш эсхүл уг байгууламжийг анхны удаа мэдүүлснээс хойш 180 хоногийн дотор байгуулж дуусна.

5. Энэхүү конвенц оролцогч тухайн улсын хувьд хүчин төгөлдөр болсноос хойш нэг жилээс илүү хугацааны дараа ажиллаж эхлэх химийн зэвсэг устгах байгууламжийн тохиолдолд байгууламжийн тухай хэлэлцээрийг тухайн байгууламж ажиллаж эхлэхээс өмнө 180 хоногоос хойшлулахгүйгээр байгуулж дуусгана.

6. Энэхүү хавсралтын IV хэсгийн A ангийн 51 дэх хэсэгт нийцүүлэн батлагдсан бөгөөд байгууламжийн тухай шилжилтийн хэлэлцээр, газар дээр нь хянан шалгах болон газар дээр нь байрлуулсан багаж хэрэгслээр ажиглан шинжих замаар нягтлан шалгалт хийх тухай заалт, түүнчлэн тухайн тохиролцоог хэрэглэх цагийн хязгаар бүхий нягтлан шалгалтын шилжилтийн тохиролцоо нь хангалттай гэж Гүйцэтгэх зөвлөл шийдвэрлэж болохоос бусад тохиолдолд энэхүү конвенц оролцогч тухайн улсын хувьд хүчин төгөлдөр болоход ажиллаж байгаа, эсхүл түүнээс хойш нэг жилийн дотор ажиллаж эхлэх химийн зэвсэг устгах байгууламжийн тохиолдолд байгууламжийн тухай хэлэлцээрийг энэхүү конвенц тухайн оролцогч улсын хувьд хүчин төгөлдөр болсноос хойш 210 хоногийн дотор байгуулж дуусгана.

7. 6 дахь хэсэгт дурдсан бөгөөд энэхүү конвенц тухайн оролцогч улсын хувьд хүчин төгөлдөр болсноос хойш хоёр жилийн дотор ажиллахаа болих байгууламжийн тохиолдолд энэхүү хавсралтын IV хэсгийн A ангийн 51 дэх хэсэгт нийцүүлэн батлагдсан бөгөөд байгууламжийн тухай шилжилтийн хэлэлцээр, газар дээр нь хянан шалгах болон газар дээр нь байрлуулсан багаж хэрэгслээр ажиглан шинжих замаар

нягтлан шалгалт хийх тухай заалт, түүнчлэн тухайн тохиролцоог хэрэглэх цагийн хязгаар бүхий нягтлан шалгалтын шилжилтийн тохиролцоо нь хангалттай гэж Гүйцэтгэх зөвлөл шийдвэрлэж болно.

8. Байгууламжийн тухай хэлэлцээр нь тийм хэлэлцээрийн загварт үндэслэх бөгөөд байгууламж бүрт явуулах хянан шалгалтыг зохицуулах дэлгэрэнгүй тохиролцоог тусгана. Загвар хэлэлцээр нь технологийн ирээдүйн ололтыг харгалзан үзэж, түүнийг 8 дугаар зүйлийн 21 дэх хэсгийн (i) дэд хэсгийн дагуу Бага хурлаар хэлэлцэж, батална.

9. Техникийн нарийн бичгийн дарга нарын газар нь дараагийн хянан шалгалтын явцад хэрэглэхийг хүсэж болох гэрэл зураг, төлөвлөгөө болон бусад мэдээллийг хадгалах лацлагдсан чингэлгийг талбай бүрт авч үлдэж болно.

## **В. Байнгын тохиролцоо**

10. Холбогдох тохиолдолд, энэхүү конвенцийн зохих заалт болон оролцогч улсууд болон Байгууллагын хоорондын байгууламжийн тухай хэлэлцээрт нийцүүлэн Техникийн нарийн бичгийн дарга нарын газар нь байнга ажиглан шинжих багаж хэрэгсэл, систем болон лацыг суурилуулах, тэдгээрийг хэрэглэх эрхтэй.

11. Хянан шалгуулж буй оролцогч улс нь тохиролцсон журамд нийцүүлэн хянан шалгах багийн хэрэглэсэн буюу суурилуулсан аливаа багаж хэрэгслийг хянан шалгах, түүнчлэн хянан шалгуулж буй оролцогч улсын төлөөлөгчдийг байлцуулан туршиж үзэх эрхтэй. Хянан шалгах баг нь хянан шалгуулж буй улсын химийн зэвсэг устгах технологийн явцыг өөрөө ажиглан шинжихээр суурилуулсан багаж хэрэгслийг хэрэглэх эрхтэй. Энэ үүднээс хянан шалгах баг нь химийн зэвсэг устгасныг нягтлан шалгах зорилгоор хэрэглэх гэж буй багаж хэрэгслийг хянан шалгах, түүнчлэн тэдгээрийг уг багийг байлцуулан туршуулах эрхтэй.

12. Хянан шалгуулж буй оролцогч улс нь байнга ажиглан шинжих багаж хэрэгсэл болон системийг тогтооход шаардлагатай бэлтгэлээр хангаж, дэмжлэг үзүүлнэ.

13. 11 болон 12 дахь хэсгийг хэрэгжүүлэхийн тулд Бага хурал 8 дугаар зүйлийн 21 дэх хэсгийн (i) дэд хэсгийн дагуу зохих дэлгэрэнгүй журмыг хэлэлцэж, батална.

14. Хэрэв ажиглан шинжих багаж хэрэгслийг суурилуулсан байгууламжид ажиглан шинжих системд нөлөөлж болох үйл явдал үүссэн буюу үүсч болох бол хянан шалгуулж буй оролцогч улс Техникийн нарийн бичгийн дарга нарын газарт нэн даруй мэдэгдэнэ. Хянан шалгуулж буй оролцогч улс ажиглан шинжих системийн ажиллагааг сэргээх болон хэрэв шаарлагатай бол завсрын арга хэмжээг аль болох түргэн тогтоох үүднээс дараагийн үйлдлээ Техникийн нарийн бичгийн дарга нарын газартай уялдуулна.

15. Хянан шалгах баг нь ажиглан шинжих систем зөв ажиллаж байгаа бөгөөд тогтоосон лац нь бүрэн бүтэн болохыг хянан шалгалт бүрийн үед нягтлан шалгана. Үүнээс гадна, тоног төхөөрөмжийг арчилж засварлах буюу солих, эсхүл шаардлагатай бол ажиглан шинжих системийн хүрээг тохируулахаар ажиглан шинжих системд засвар үйлчилгээ хийхээр тухайн газарт очих шаардлагатай байж болно.

16. Хэрэв ажиглан шинжих системд аливаа доголдол илэрвэл Техникийн нарийн бичгийн дарга нарын газар энэ нь тоног төхөөрөмжийн доголдоос, эсхүл

байгууламжийн үйл ажиллагаанаас үүссэн эсэхийг тодорхойлоохор нэн даруй арга хэмжээ авна. Хэрэв энэ үзлэгийн дараа асуудал шийдвэрлэгдээгүй үлдвэл Техникийн нарийн бичгийн дарга нарын газар нь бодит байдлыг нэн даруй тогтооно, түүний дотор шаардлагатай бол байгууламжид газар дээрх хянан шалгалт хийх, эсхүл байгууламжид очих замаар тогтооно. Техникийн нарийн бичгийн дарга нарын газар нь аливаа ийм асуудлыг илрүүлсний дараа нэн даруй хянан шалгуулж буй оролцогч улсад илтгэж, тухайн улс нь уг асуудлыг шийдвэрлэхэд нь туслана.

### **C. Хянан шалгалтын өмнөх үйл ажиллагаа**

17. 18 дахь хэсэгт зааснаас бусад тохиолдолд хянан шалгах баг нэвтрэх боомтод төлөвлөсөн ёсоор хүрэлцэн ирэхээс өмнө 24 цагаас хойшлуулахгүйгээр хянан шалгуулж буй оролцогч улсад хянан шалгалтын тухай мэдэгдэнэ.

18. Хянан шалгах баг нэвтрэх боомтод тооцоолсон ёсоор хүрэлцэн ирэхээс өмнө 72 цагаас хойшлуулахгүйгээр хянан шалгуулж буй оролцогч улсад анхны хянан шалгалтын тухай мэдэгдэнэ.

## **IV ХЭСЭГ А АНГИ**

### **4 ДҮГЭЭР ЗҮЙЛИЙН ДАГУУ ХИМИЙН ЗЭВСГИЙГ УСТГАХ БОЛОН УСТГАЛЫГ НЯГТЛАН ШАЛГАХ**

#### **A.Мэдүүлэг**

##### **Химийн зэвсэг**

1. 3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн (a)(ii) дэд хэсгийн дагуу оролцогч улсын гаргах мэдүүлэг нь дараахь зүйлийг хамаарна:

(a) мэдүүлсэн химийн бодис бүрийн нийт тоо хэмжээ;

(b) химийн зэвсэг агуулах байгууламж бүрийн дараахь зүйлээр илэрхийлсэн тодорхой байрлал:

(i) нэр;

(ii) газар зүйн солбицол;

(iii) талбайн дэлгэрэнгүй бүдүүвч зураг, түүний дотор хил хязгаарын зураг болон байгууламж доторхи агуулахын байрлал.

(a) Химийн зэвсэг агуулах байгууламж бүрийн дараахь зүйлийг багтаасан эд хөрөнгийн жагсаалт:

(i) 2 дугаар зүйлд нийцүүлэн химийн зэвсэг гэж тодорхойлсон химийн бодис;

(ii) химийн зэвсэг гэж тодорхойлсон цэнэглээгүй байлдааны хэрэгсэл, нэмэлт цэнэг, төхөөрөмж болон тоног төхөөрөмж;

(iii) (ii) дэд хэсэгт заасан байлдааны хэрэгсэл, нэмэлт цэнэг, төхөөрөмж болон тоног төхөөрөмж ашиглахтай холбогдуулан шууд хэрэглэхээр тусгайлан зориулсан тоног төхөөрөмж;

(iv) (ii) дэд хэсэгт заасан байлдааны хэрэгсэл, нэмэлт цэнэг, төхөөрөмж болон тоног төхөөрөмж ашиглахтай холбогдуулан шууд хэрэглэхээр тусгайлан зориулсан химиин бодис.

2. 1 дэх хэсгийн (c)(i) дэд хэсэгт дурдсан химиин бодисыг мэдүүлэхэд дараахь заалтыг хэрэглэнэ:

(a) химиин бодисыг Химиин бодисын тухай хавсралтад заасан жагсаалтад нийцүүлэн мэдүүлнэ;

(b) химиин бодисын тухай хавсралтын жагсаалтуудад ороогүй химиин бодисын хувьд тухайн химиин бодисыг зохих жагсаалтад зааж оруулж болоход шаардлагатай мэдээлэл, түүний дотор цэвэр нийлмэлийн хорт шинжийн тухай мэдээллээр хангана. Прекурсорын хувьд урвалын эцсийн гол бүтээгдэхүүн(үүд)ий хорт шинж болон шинж чанарын тухай мэдээллээр хангана;

(c) химиин бодисыг Цэвэр болон хавсарга химиин шинжлэх ухааны олон улсын холбоо (IUPAC)-ны нэр томъёоны мөрдөгдөж буй систем, бүтцийн томъёо болон хэрэв Химиин бодисын үйлчилгээний бүртгэлийн дугаар заасан бол уг дугаарт нийцүүлэн химиин нэршлээр нь таньж тогтооно. Прекурсорын хувьд урвалын эцсийн гол бүтээгдэхүүн(үүд)ий хорт шинж болон шинж чанарын тухай мэдээллээр хангана;

(d) нэг буюу хэд хэдэн химиин бодисын холимогийн тохиолдолд химиин бодис бүрийг таньж тогтоож, тус бүрийн хувь хэмжээг заах бөгөөд уг холимогийг химиин хамгийн хорт бодисын ангиллын дагуу мэдүүлнэ. Хэрэв хоёр найрлагат химиин зэвсгийн бүрдүүлэгч бодис нь нэг буюу хэд хэдэн химиин бодисын холимогоос бүрдэж байвал химиин бодис бүрийг таньж тогтоож, тус бүрийн хувь хэмжээг заана.

(e) хоёр найрлагат химиин зэвсгийг 16 дахь хэсэгт дурдсан химиин зэвсгийн ангиллын хүрээнд холбогдох эцсийн бүтээгдэхүүний дагуу мэдүүлнэ. Хоёр найрлагат химиин байлдааны хэрэгсэл/төхөөрөмжийн төрөл бүрт дараахь нэмэлт мэдээллийг гаргаж өгнө:

- (i) эцсийн хорт бүтээгдэхүүний химиин нэршил;
- (ii) бүрдүүлэгч бодис бүрийн химиин найрлага болон тоо хэмжээ;
- (iii) бүрдүүлэгч бодисын хоорондын жингийн бодит харьцаа;
- (iv) аль бүрдүүлэгч бодисыг гол бүрдүүлэгч гэж үзсэн;

(v) 100 хувийн гарцаар тооцоолон гол бүрдүүлэгч бодисоос стехиометрийн үндсэн дээр тооцоолон гаргасан эцсийн хорт бүтээгдэхүүний төлөвлөсөн тоо хэмжээ. Тодорхой эцсийн хорт бүтээгдэхүүнд зориулсан гол бүрдүүлэгч бодисын мэдүүлсэн тоо хэмжээ (тонноор)-г тухайн эцсийн хорт бүтээгдэхүүний 100 хувийн гарцаар тооцоолон стехиометрийн үндсэн дээр тооцоолон гаргасан тоо хэмжээ (тонноор)-тэй тэнцүү гэж үзнэ.

(f) олон найрлагат химийн зэвсгийн хувьд мэдүүлэг нь хоёр найрлагат химийн зэвсгийн хувьд заасантай адил байна;

(g) химийн бодис бүрийн хувьд хадгалах хэлбэр, өөрөөр хэлбэл, байлдааны хэрэгсэл, нэмэлт цэнэг, төхөөрөмж, тоног төхөөрөмж буюу чингэлэг болон бусад савны талаар мэдүүлнэ. Хадгалах хэлбэр бүрийн хувьд дараахь зүйлийг жагсаана:

- (i) төрөл;
- (ii) хэмжээ;
- (iii) зүйлийн тоо;
- (iv) зүйл бүрийн химийн цэнэгийн номинал жин.

(h) химийн бодис бүрийн хувьд хадгалах байгууламжид байгаа нийт жинг мэдүүлнэ;

(i) үүнээс гадна, том саванд хадгалагдаж байгаа химийн бодисын хувьд хэрэв мэдэгдэж байгаа бол хувь хэмжээний цэвэр байдлыг мэдүүлнэ.

3. 1 дэх хэсгийн (c)(ii)т дурдсан цэнэглээгүй байлдааны хэрэгсэл, нэмэлт цэнэг, төхөөрөмж болон тоног төхөөрөмжийн төрөл бүрийн хувьд дараахь мэдээллийг агуулна.

- (a) нэгжийн тоо;
- (b) нэгж бүрийн цэнэглэх багтаамжийн номинал хэмжээ;
- (c) багцаалсан химийн бодисын цэнэг.

3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн (a)(iii) дэд хэсгийн дагуу химийн зэвсгийн тухай мэдүүлэг гаргах

4. 3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн (a)(iii) дэд хэсгийн дагуу гаргасан химийн зэвсгийн тухай мэдүүлэг нь дээрх 1-ээс 3 дахь хэсэгт заасан бүх мэдээллийг агуулна. Мэдүүлгийг гаргасан байх явдлыг хангах талаар оролцогч нөгөө улстай зохих тохиролцоонд хүрэх нь химийн зэвсэг нутаг дэвсгэрт нь байрлаж буй оролцогч улсын үүрэг хариуцлага болно. Хэрэв нутаг дэвсгэрт нь химийн зэвсэг байрлаж буй оролцогч улс энэ хэсэгт заасан үүргээ биелүүлж чадахгүй бол үүний шалтгааныг заана.

#### Омнө нь шилжүүлсэн болон хүлээн авсан тухай мэдүүлэг

5. Оролцогч улс нь 1946 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хойш химийн зэвсэг шилжүүлсэн, эсхүл хүлээн авсан, зэвсгийн хэлбэр болон хэмжээг жилд химийн бодис бүрээс 1 тонн хэтрүүлэн шилжүүлсэн, эсхүл хүлээн авсан тохиолдолд тийнхүү шилжүүлсэн, эсхүл хүлээн авсан тухайгаа 3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн (a)(iii) дэд хэсгийн дагуу мэдүүлнэ. Ийм мэдүүлгийг 1 болон 2 дахь хэсэгт заасан эд хөрөнгө данслах маягтын дагуу гаргана. Энэ мэдүүлэгт мөн нийлүүлэгч болон хүлээн авагч улс, шилжүүлсэн, эсхүл хүлээн авсан он, сар, өдөр, түүнчлэн шилжүүлсэн зүйлсийн одоогийн байрлалыг аль болох тодорхой заана. 1946 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 1970 оны 1 дүгээр сарын 1-ний өдрийн хоорондох хугацаанд химийн зэвсэг шилжүүлсэн, эсхүл хүлээн авсан талаар дээр заасан бүх мэдээлэл байхгүй бол

оролцогч улс өөрт байгаа бүх мэдээллийг мэдүүлэх бөгөөд мэдүүлгийг бүрэн гаргаж өгч чадахгүй байгаа талаар тайлбар гаргана.

**Химийн зэвсэг устгах ерөнхий төлөвлөгөө танилцуулах**

6. 3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн (a)(v) дэд хэсгийн дагуу химийн зэвсгийг устгах ерөнхий төлөвлөгөөнд оролцогч улсын химийн зэвсэг устгах үндэсний хөтөлбөрийн тойм болон энэхүү конвенцид тусгасан устгалын шаардлагыг биелүүлэх оролцогч улсын чармайлтын тухай мэдээллийг ерөнхийд нь тусгана. Төлөвлөгөөнд дараах зүйлийг заана:

(a) химийн зэвсгийг устгах байгууламж, хэрэв боломжтой бол химийн зэвсэг устгахаар төлөвлөж буй байгууламж бүрийн жил бүр устгах хугацаанд устгахаар төлөвлөж буй химийн зэвсгийн төрөл болон ойролцоо тоог заасан устгах ерөнхий хуваарь;

(b) химийн зэвсэг устгах одоо байгаа эсхүл устгах үед ажиллуулахаар төлөвлөж буй байгууламжийн тоо;

(c) байгаа болон төлөвлөж буй химийн зэвсэг устгах байгууламжийн хувьд:

(i) нэр болон байршил;

(ii) устгах химийн зэвсгийн төрөл, ойролцоо тоо болон химийн цэнэгийн төрөл (жишээлбэл: мэдрэлийн саа өвчин тээгч, эсхүл цэврүү тээгч), ойролцоо тоо;

(d) устгах байгууламжийг ажиллуулах боловсон хүчнийг бэлтгэх төлөвлөгөө болон хөтөлбөр;

(e) аюулгүй байдал болон хаягдалтай холбоотой устгах байгууламжийн биелүүлэх ёстой үндэсний стандарт;

(f) химийн зэвсэг устгах шинэ арга боловсруулах болон одоо байгаа аргыг сайжруулах талаархи мэдээлэл;

(g) химийн зэвсгийг устгах өртгийн тооцоо;

(h) устгах үндэсний хөтөлбөрт сөргөөр нөлөөлж болох аливаа асуудал.

**В. Хадгалах байгууламжийг хамгаалах арга хэмжээ болон хадгалах байгууламжийг бэлтгэх**

7. Оролцогч улс химийн зэвгийн тухай мэдүүлгийг өгөх хугацаанаас хэтрүүлэлгүй хадгалах байгууламжийг хамгаалах талаар зохистой гэж үзсэн арга хэмжээ авах бөгөөд өөрийн химийн зэвсгийг устгахаар гаргахаас бусад тохиолдолд түүнийг байгууламжаас шилжүүлэхээс сэргийлнэ.

8. Оролцогч улс хадгалах байгууламжид нь байгаа химийн зэвсгийг 37-гоос 49 дэх хэсэгт нийцүүлэн нягтлан шалгах зорилгоор чөлөөтэй нэвтрэхээр зохицуулах явдлыг хангана.

9. Устгахаар гаргахаас бусад тохиолдолд байгууламжаас аливаа химийн зэвсгийг шилжүүлэхэд хадгалах байгууламж хаалттай байгаа үед оролцогч улс байгууламжид тогтсон засвар арчилгааны үйл ажиллагаа, түүний дотор химийн зэвсгийн тогтсон засвар арчилгаа; аюулгүй байдлыг ажиглан шинжих болон биечлэн хамгаалахтай холбоотой үйл ажиллагаа; түүнчлэн химийн зэвсгийг устгалд оруулахад бэлтгэх ажиллагаагааг үргэлжлүүлэн явуулж болно.

10. Химийн зэвсгийн засвар арчилгааны үйл ажиллагаанд дараахь зүйл орохгүй:

- (а) хордуулах бодис, эсхүл байлдааны хэрэгслийн гадна талыг солих;
- (б) байлдааны хэрэгслийн анхны шинж чанар, эсхүл түүний хэсэг болон эд ангийг өөрчлөх.

11. Засвар арчилгааны бүх үйл ажиллагааг Техникийн нарийн бичгийн дарга нарын газар ажиглан хянана.

### **C. Устгах**

#### **Химийн зэвсэг устгах зарчим, арга**

12. “Химийн зэвсэг устгах” гэж химийн бодисыг химийн зэвсэг үйлдвэрлэхэд тохиромжгүй хэлбэрт эргэж буцаах боломжгүй байдлаар агуулгаар нь хувиргах, түүнчлэн байлдааны хэрэгсэл болон бусад төхөөрөмжийг хэрэглэх боломжгүй байдалд эргэж буцаах боломжгүй байдлаар оруулах явцыг хэлнэ.

13. Оролцогч улс бүр дараахь аргыг хэрэглэхээс бусад тохиолдолд ямар аргаар химийн зэвсгийг устгахаа тодорхойлно: аливаа усанд живүүлэх, газарт булах, эсхүл ил агаарт шатаах. Тухайн улс химийн зэвсгийг зөвхөн тусгайлан заасан, түүнчлэн зохих ёсоор зохион бүтээж, тоноглосон байгууламжид устгана.

14. Оролцогч улс бүр химийн зэвсэг устгах байгууламж нь химийн зэвсэг устгах явдлыг хангах байдлаар баригдаж, ажиллах явдлыг; түүнчлэн устгах явцыг энэхүү конвенцийн заалтын дагуу нягтлан шалгах боломжоор хангана.

#### **Устгах дараалал**

15. Химийн зэвсгийг устгах дараалал нь 1 дүгээр зүйл болон бусад зүйлд заасан үүрэг, түүний дотор газар дээр нь тогтмол нягтлан шалгах үүрэгт тулгуурлана. Уг дараалалд устгах үед аюулгүй байдлыг багасгахгүй байх; устгах эхний шатанд итгэлцлийг бэхжүүлэх; химийн зэвсгийг устгах явцад тогтмол туршлага хуримтлуулах; түүнчлэн химийн зэвсгийн байгаа бодит нөөц болон устгахад сонгосон аргыг үл харгалzan хэрэглэхийг оролцогч улс анхаарна. Устгах дараалал нь тэнцүүлэх зарчим дээр тулгуурлана.

16. Оролцогч улс бүрийн мэдүүлсэн химийн зэвсгийг устгах зорилгоор гурван ангилалд хуваана:

1 дүгээр ангилал: I жагсаалтад орсон химийн бодисын үндсэн дээрх химийн зэвсэг болон түүний хэсэг буюу эд анги;

2 дугаар ангилал: Бусад бүх химийн бодисын үндсэн дээрх химийн зэвсэг болон түүний хэсэг буюу эд анги;

3 дугаар ангилал: Цэнэггүй байлдааны хэрэгсэл болон төхөөрөмж, түүнчлэн химийн зэвсэг ашиглахтай шууд холбоотойгоор хэрэглэхээр тусгайлан зориулагдсан тоног төхөөхөмж.

17. Оролцогч улс:

(a) 1 дүгээр ангилалд орсон химийн зэвсгийг энэхүү конвенц хүчин төгөлдөр болсны дараа хоёр жилийн дотор устгаж эхлэх бөгөөд энэхүү конвенц хүчин төгөлдөр болсны дараа 10 жилийн дотор устгалаа дуусгана. Оролцогч улс дараахь устгах хугацаанд нийцүүлэн химийн зэвсгээ устгана:

(i) 1 дүгээр үе: энэхүү конвенц хүчин төгөлдөр болсны дараа хоёр жилийн дотор анхны устгах байгууламжийн туршилтыг дуусгана. Энэхүү конвенц хүчин төгөлдөр болсны дараа гурван жилийн дотор 1 дүгээр ангилалд орсон химийн зэвсгийн 1-ээс доошгүй хувийг устгана;

(ii) 2 дугаар үе: энэхүү конвенц хүчин төгөлдөр болсны дараа таван жилийн дотор 1 дүгээр ангилалд орсон химийн зэвсгийн 20-иос доошгүй хувийг устгана;

(iii) 3 дугаар үе: энэхүү конвенц хүчин төгөлдөр болсны дараа долоон жилийн дотор 1 дүгээр ангилалд орсон химийн зэвсгийн 45-аас доошгүй хувийг устгана;

(iv) 4 дүгээр үе: энэхүү конвенц хүчин төгөлдөр болсны дараа 10 жилийн дотор 1 дүгээр ангилалд орсон химийн бүх зэвсгийг устгана.

(b) 2 дугаар агилалд орсон химийн зэвсгийг энэхүү конвенц хүчин төгөлдөр болсны дараа нэг жилийн дотор устгах бөгөөд энэхүү конвенц хүчин төгөлдөр болсны дараа таван жилийн дотор устгалыг дуусгана. 2 дугаар ангилалд орсон химийн зэвсгийг устгах бүхий л хугацаанд жил бүр тэнцүү өсөх тоогоор устгана. Тийм зэвсгийн үндсэн харьцуулалт нь 2 дугаар ангиллын хүрээн дэх химийн бодисын жин байна;

(c) 3 дугаар ангилалд орсон химийн зэвсгийг энэхүү конвенц хүчин төгөлдөр болсны дараа нэг жилийн дотор устгах бөгөөд энэхүү конвенц хүчин төгөлдөр болсны дараа таван жилийн дотор устгалаа дуусгана. 3 дугаар ангилалд орсон химийн зэвсгийг устгах бүхий л хугацаанд жил бүр тэнцүү өсөх тоогоор устгана. Харьцуулах хүчин зүйлийг цэнэггүй байлдааны хэрэгсэл болон төхөөрөмжийн хувьд цэнэгийн номинал багтаамж (m3)-аар, тоног төхөөрөмжийн хувьд нэгжийн тоогоор илэрхийлнэ.

18. Химийн хоёрлосон зэвсгийг устгахад дараах зүйлийг хэрэглэнэ:

(a) устгах дарааллын зорилгоор, тодорхой эцсийн хорт бүтээгдэхүүнд зориулагдсан гол бүрдүүлэгчийн мэдүүлсэн тоо хэмжээ (тонноор) нь 100 хувийн гарцаар тооцоолон гол бүрдүүлэгч бодисоос стехиометрийн үндсэн дээр тооцоолон гаргасан эцсийн хорт бүтээгдэхүүний тоо хэмжээ (тонноор)-тэй тэнцүү гэж үзнэ.

(b) өгөгдсөн тоо хэмжээний гол бүрдүүлэгчийг устгах шаардлага нь холбогдох төрлийн химийн хоёрлосон байлдааны хэрэгсэл/төхөөрөмж дэх бүрдүүлэгч хэсгүүдийн бодит жингийн харьцаанаас тооцоолон гаргах өөр бүрдүүлэгч хэсгийн холбогдох хэмжээг устгах шаардлагыг дагуулна.

(с) Хэрэв бүрдүүлэгч хоорондын бодит жингийн харьцааны үндсэн дээр өөр бүрдүүлэгчийг шаардлагатайгаас илүү хэмжээгээр мэдүүлвэл устгах ажиллагааг эхэлснээс хойшхи эхний хоёр жилийн хугацаанд илүүдлийг устгана.

(д) Оролцогч улс ажлын дараагийн жил бурийн эцэст бодит жингийн холбогдох төрлийн хоёрлосон байлдааны хэрэгсэл/төхөөрөмж дэх бүрдүүлэгчийн бодит жингийн харьцааны үндсэн дээр тодорхойлогдох өөр мэдүүлсэн хэмжээтэй бүрдүүлэгчийг үлдээж болно.

19. Олон найрлагат химийн зэвсгийн хувьд устгах дараалал нь хоёр найрлагат химийн зэвсгийн хувьд заасантай адил байна.

**Устгалын завсрыйн хугацааг өөрчлөх**

20. Гүйцэтгэх зөвлөл 3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн (а) (v) дэд хэсгийн дагуу *inter alia* 6 дахь хэсэгт нийцүүлэн химийн зэвсэг устгах өрөөнчийн төлөвлөгөөг 15-аас 19 дэх хэсэгт заасан устгах дараалалд нийцэж буйг нь дүгнэх үүднээс хянан үзнэ. Тийм даараалалд төлөвлөгөө нь нийцэхгүй байгаа төлөвлөгөөг нийцүүлэх зорилгоор Гүйцэтгэх зөвлөл оролцогч аливаа улстай зөвлөлдөнө.

21. Хэрэв оролцогч улс 1 дүгээр ангилалд орсон химийн зэвсгийг устгах дарааллын 1 дүгээр үе, 2 дугаар үе, эсхүл 3 дугаар үед заасан устгах түвшинд хүрч чадахгүй гэж түүнээс хамаарахгүй онцгой нөхцөл байдлаас үзэж байгаа бол тэдгээр түвшинг өөрчлөх санал гаргаж болно. Тийм саналыг энэхүү конвенц хүчин төгөлдөр болсноос хойш 120 хоногийн дотор гаргах бөгөөд уг санал гаргах болсон шалтгааны дэлгэрэнгүй тайлбарыг тусгасан байна.

22. Оролцогч улс бүр 1 дүгээр ангилалд орсон химийн зэвсгийг 21 дүгээр хэсгийн дагуу өөрчилсөн 17 дахь хэсгийн (а) дэд хэсэгт заасан устгах хугацаанд нийцүүлэн устгах явдлыг хангах талаар шаардлагатай бүх арга хэмжээ авна. Гэхдээ хэрэв оролцогч улс устгалын завсрыйн хугацаанд шаардлагатай 1 дүгээр ангилалд орсон химийн зэвсгийн хувь хэмжээнд устгах явдлыг хангаж чадахгүй гэж үзвэл тэрхүү хугацааг мөрдөх үүргийг нь сунгахыг Бага хуралд зөвлөмж болгохыг Гүйцэтгэх зөвлөлөөс хүсэж болно. Тийм хүсэлтийг устгалын завсрыйн хугацаанаас 180-аас доошгүй хоногийн өмнө гаргах бөгөөд тийм хүсэлт гаргах болсон шалтгааны дэлгэрэнгүй тайлбар болон дараагийн устгалын завсрыйн хугацааг мөрдөх үүргээ биелүүлэх боломжтой гэсэн баталгаа бүхий оролцогч улсын төлөвлөгөөг тусгана.

23. Хэрэв хугацааг сунгавал оролцогч улс дараагийн устгах хугацааны хувьд заасан устгах цогц шаардлагыг мөрдөх үүргийг хүлээсээр байх болно. Энэ ангийн дагуу олгосон хугацаа сунгалт нь энэхүү конвенц хүчин төгөлдөр болсноос хойш 10 жилийн дотор 1 дүгээр ангилалд орсон химийн бүх зэвсгийг устгах оролцогч улсын үүргийг ямарваа байдлаар өөрчлөхгүй.

**Устгалыг дуусгах хугацааг сунгах**

24. Хэрэв оролцогч улс энэхүү конвенц хүчин төгөлдөр болсноос хойш 10 жилийн дотор 1 дүгээр ангилалд орсон бүх химийн зэвсгийн устгах явдлыг хангаж чадахгүй гэж үзвэл тийм химийн зэвсгийг устгах хугацааг сунгах талаархи хүсэлтээ Гүйцэтгэх зөвлөлд гаргаж болно. Тийм хүсэлтийг энэхүү конвенц хүчин төгөлдөр болсноос хойш есөн жилийн дотор гаргана.

25. Хүсэлтэд дараах зүйлийг тусгана:

- (а) санал болгосон сунгалтын үргэлжлэх хугацаа;
- (б) санал болгосон сунгалтын шалтгааны дэлгэрэнгүй тайлбар;
- (с) санал болгосон сунгалтын хугацаа болон устгалын анхны 10 жилийн хугацааны үлдсэн хэсэгт хийх устгалын дэлгэрэнгүй төлөвлөгөө.

26. Хүсэлтийн талаархи шийдвэрийг Гүйцэтгэх зөвлөлийн зөвлөмжөөр Бага хурал дараагийн чуулганаараа гаргана. Аливаа сунгалт нь шаардлагатай хамгийн бага хугацаанд байх бөгөөд оролцогч улс бүх химийн зэвсгээ устгаж дуусах хугацааг энэхүү конвенц хүчин төгөлдөр болсны дараа 15 жилээс илүү гарах хугацаагаар сунгахгүй. Гүйцэтгэх зөвлөл хугацаа сунгах нөхцлийг, түүний дотор шаардлагатай гэж үзсэн нягтлан шалгах тодорхой арга хэмжээ болон оролцогч улс устгах хөтөлбөртэйгөө холбогдон үссэн бэрхшээлийг даван туулахын тулд авсан тодорхой үйлдлийг тодорхойлно. Сунгасан хугацааны нягтлан шалгалтын зардлыг 4 дүгээр зүйлийн 16 дахь хэсэгт нийцүүлэн хуваарилна.

27. Хэрэв хугацааг сунгавал оролцогч улс дараагийн хугацааг мөрдөх талаар зохих арга хэмжээ авна.

28. Хэрэв оролцогч улс 29 дэх хэсэгт нийцүүлэн устгалын тухай жил бүрийн дэлгэрэнгүй төлөвлөгөө болон 1 дүгээр ангилалд орсон химийн бүх зэвсгийг устгаж дуустал 36 дахь хэсэгт нийцүүлэн 1 дэх ангилалд орсон химийн зэвсгийг устгасан тухай жил бүрийн илгэлийг бэлтгэж өгсөөр байх болно. Түүнээс гадна сунгасан 90 хоног бүр дуусахаас өмнө оролцогч улс устгалын үйл ажиллагааны талаар Гүйцэтгэх зөвлөлд илтгэнэ. Гүйцэтгэх зөвлөл устгалыг дуусгахад чиглэсэн явцыг хянан үзэж энэ явцыг баримтжуулахад шаардлагатай арга хэмжээг авна. Сунгасан хугацаан дахь устгалын үйл ажиллагаатай холбоотой бүх мэдээллийг Гүйцэтгэх зөвлөл оролцогч улсад хүсэлтийн дагуу өгнө.

#### Устгалын тухай жил бүрийн дэлгэрэнгүй төлөвлөгөө

29. Устгалын тухай жил бүрийн дэлгэрэнгүй төлөвлөгөөг 4 дүгээр зүйлийн 7 дахь хэсгийн (а) дэд хэсгийн дагуу жил бүрийн устгах хугацаа эхлэхээс 60-аас доошгүй хоногийн өмнө Техникийн нарийн бичгийн дарга нарын газарт өгөх бөгөөд уг төлөвлөгөөнд дараахь зүйлийг заана:

(а) устгах байгууламж бүрт устгах гэж буй химийн зэвсгийн тодорхой төрөл бүрийн тоо хэмжээ болон химийн зэвсгийн тодорхой төрөл бүрийг устгаж дуусах эцсийн он, сар, өдөр;

(б) химийн зэвсэг устгах байгууламж бүрийн талбайн нарийвчилсан бүдүүвч зураг болон өмнө нь гаргасан бүдүүвч зурагт орсон аливаа өөрчлөлт;

(с) байгууламжийн зураг төсөл гаргах, байгууламжийг барих, эсхүл өөрчлөх, тоног төхөөрөмж суурилуулах, тоног төхөөрөмж шалгах болон оператор бэлтгэх, химийн зэвсгийн тодорхой төрөл бүрийн хувьд устгах ажиллагаа явуулах хугацаа, түүнчлэн сүл зогсолтын төлөвлөгдсөн хугацааг заасан химийн зэвсэг устгах байгууламж бүрийн ирэх жилийн үйл ажиллагааны дэлгэрэнгүй хуваарь.

30. Оролцогч улс химийн зэвсэг устгах байгууламж бүрийн хувьд Техникийн нарийн бичгийн дарга нарын газрыг байгууламж дээр ашиглах урьдчилсан хянан

шалгах журмыг боловсруулахад нь туслах зорилгоор байгууламжийн тухай дэлгэрэнгүй мэдээллээр хангана.

31. Устгах байгууламж бүрийн байгууламжийн талаархи байгууламжийн тухай дэлгэрэнгүй мэдээлэл нь дараахь зүйлийг агуулна:

(a) нэр, хаяг болон байршил;

(b) байгууламжийн дэлгэрэнгүй, тайлбартай зураг;

(c) байгууламжийн ажлын зураг, технологийн зураг болон хоолой, багаж хэрэгслийн ажлын хүснэгт;

(d) дараахь ажиллагаанд шаардлагатай тоног төхөөрөмжийн техникийн дэлгэрэнгүй дүрслэл, түүний дотор ажлын хүснэгт болон багаж хэрэгслийн тодорхойлолт: байлдааны хэрэгсэл, төхөөрөмж болон савнаас химийн цэнэгийг арилгах; химийн шавхагдсан цэнэгийг түр хугацаагаар хадгалах; химийн хорт бодисыг устгах; түүнчлэн байлдааны хэрэгсэл, төхөөрөмж болон савыг устгах;

(e) устгах явцын техникийн дэлгэрэнгүй дүрслэл, түүний дотор материалын урсгал хөдөлгөөний хурд, хэм болон даралт, түүнчлэн устгалын тооцоолсон үр ашиг;

(f) химийн тодорхой зэвсгийн төрөл бүрийн тооцоолсон хүчин чадал;

(g) устгах бүтээгдэхүүн болон тэдгээрийг эцэслэн зайлзуулах аргын дэлгэрэнгүй дүрслэл;

(h) энэхүү конвенцид нийцүүлэн хянан шалгалтыг хөнгөвчлөн дэмжих арга хэмжээний техникийн дэлгэрэнгүй дүрслэл;

(i) химийн зэвсгийг устгах байгууламжид шууд хүргэхэд хэрэглэгдэх устгах байгууламж дахь түр байлгах аливаа талбайн дэлгэрэнгүй дүрслэл, түүний дотор талбайн болон байгууламжийн зураг, байгууламжид устгагдах химийн зэвсгийн тодорхой төрөл бүрийн хадгалах хүчин чадлын тухай мэдээлэл;

(j) байгууламжид үйлчилж байгаа аюулгүй байдал болон эмчилгээний арга хэмжээний дэлгэрэнгүй дүрслэл;

(k) хянан шалгагч нарт зориулсан амьдрах болон ажлын байрны дэлгэрэнгүй дүрслэл;

(l) олон улсын хянан шалгалтын талаар санал болгож буй арга хэмжээ.

32. Оролцогч улс химийн зэвсэг устгах өөрийн байгууламж бүрт үйлдвэрийн ажиллагааны заавар, аюулгүй байдал болон эмчилгээний төлөвлөгөө, лаборатори ашиглах болон чанарын хангамж, хяналтын заавар, түүнчлэн өмнө нь олгосон материалыг оруулснаас бусад тохиолдолд олж авсан байгаль орчны зөвшөөрлийг гаргана.

33. Оролцогч улс өөрийн устгах байгууламж дахь хянан шалгах үйл ажиллагаанд нөлөөлж болох аливаа үйл явдлын талаар Техникийн нарийн бичгийн дарга нарын газарт шуурхай мэдэгдэнэ.

34. 30-аас 32 дахь хэсэгт заасан мэдээлэл өгөх хугацааг 8 дугаар зүйлийн 21 дэх хэсгийн (i) дэд хэсгийн дагуу Бага хурал хэлэлцэж, батална.

35. Устгах байгууламж бүртэй холбоотой байгууламжийн тухай дэлгэрэнгүй мэдээллийг хянан үзсэний дараа Техникийн нарийн бичгийн дарга нарын газар нь химийн зэвсэг устгах байгууламж нь химийн зэвсэг устгана гэдгийг батлахаар зохион бүтээгдсэн гэдгийг хангах, нягтлан шалгах арга хэмжээг хэрхэн хэрэглэж болох талаар урьдчилан төлөвлөх боломж олгох, түүнчлэн нягтлан шалгах арга хэмжээ хэрэглэх нь байгууламжийн зохих ажиллагаатай нийцэж байгаа бөгөөд байгууламжийн ажиллагаа нь зохих нягтлан шалгалт явуулах боломж олгох явдлыг хангахын тулд хэрэв хэрэгцээ гарвал холбогдох оролцогч улстай зөвлөлдөж эхлэнэ.

#### Устгалын тухай жил бүрийн илтгэл

36. Химийн зэвсэг устгах төлөвлөгөөг хэрэгжүүлэхтэй холбоотой мэдээллийг 4 дүгээр зүйлийн 7 дахь хэсгийн (b) дэд хэсгийн дагуу Техникийн нарийн бичгийн дарга нарын газарт устгалын жил бүрийн хугацаа дууссаны дараа 60 хоногийн дотор өгөх бөгөөд уг мэдээлэлд өнгөрсөн жилийн турш устгах байгууламж бүрт устгасан химийн зэвсгийн бодит тоог заана. Зохих тохиолдолд устгах зорилгод хүрээгүй шалтгааныг заана.

#### **D. Нягтлан шалгалт**

Газар дээр нь хянан шалгах замаар химийн зэвсгийн мэдүүлгийг нягтлан шалгах

37. Химийн зэвсгийн мэдүүлгийг нягтлан шалгах зорилго нь 3 дугаар зүйлийн дагуу хийсэн холбогдох мэдүүлгийн үнэн зөвийг газар дээр нь нягтлан шалгах замаар батлахад оршино.

38. Хянан шалгагч нар тийм нягтлан шалгалтыг мэдүүлэг өгсний дараа даруй явуулна. Тэд химийн бодисын тоо хэмжээ болон шинж, байлдааны хэрэгсэл, төхөөрөмж болон бусад тоног төхөөрөмжийн төрөл болон тоог *inter alia* нягтлан шалгана.

39. Химийн зэвсэг үйлдвэрлэх байгууламж бүр дэх химийн зэвсгийг үнэн зөв данслахыг хөнгөвчлөн дэмжих зорилгоор хянан шалгагч нар тохиролцсон лац, тэмдэглэгээ, эсхүл эд хөрөнгийн хяналтын бусад журмыг хэрэглэнэ.

40. Эд хөрөнгө данслах явцад хянан шалгагч нар аливаа нөөцийг зайлцуулсныг тодорхой заахад, түүнчлэн данслах явцад хадгалах байгууламжийг хамгаалахад шаардлагатай байж болох тохиролцсон лацыг байрлуулна. Дансалж дууссаны дараа лацыг өөрөөр тохиролцоогүй бол авна.

#### Хадгалах байгууламжийг тогтмол нягтлан шалгах

41. Хадгалах байгууламжийг тогтмол нягтлан шалгах зорилго нь уг байгууламжаас химийн зэвсэг нууцаар гаргахгүй байх явдлыг хангахад оршино.

42. Тогтмол нягтлан шалгалтыг химийн зэвсгийг мэдүүлсний дараа аль болох түргэн эхлүүлэх бөгөөд хадгалах байгууламжаас химийн бүх зэвсгийг гаргаж дуусах хүртэл үргэлжилнэ. Энэ нь байгууламжийн тухай хэлэлцээрт нийцүүлэн газар дээр нь

хянан шалгах болон газар дээр нь байрлуулсан багаж хэрэгслээр ажиглан шинжихийг хослуулна.

43. Хадгалах байгууламжаас химиийн бүх зэвсгийг гаргасны дараа Техникийн нарийн бичгийн дарга нарын газар энэ талаархи оролцогч улсын мэдүүлгийг батална. Ийнхүү баталсны дараа Техникийн нарийн бичгийн дарга нарын газар хадгалах байгууламжийн тогтмол нягтлан шалгалтыг дуусгавар болгож, хянан шалгагч нарын суурилуулсан ажиглан шинжих багаж хэрэгслийг даруй зайлзуулна.

#### **Хянан шалгах, очих**

44. Хянан шалгалт хийвэл зохих хадгалах тодорхой байгууламжийг Техникийн нарийн бичгийн дарга нарын газар байгууламжийг хянан шалгах хугацааг яг тодорхой урьдчилан мэдэх боломжгүй байхаар сонгоно. Газар дээр нь тогтмол хийх хянан шалгалтын давтамжийг тодорхойлох удирдамжийг Техникийн нарийн бичгийн дарга нарын газар 8 дугаар зүйлийн 21 дэх хэсгийн (i) дэд хэсгийн дагуу Бага хурлаас хэлэлцэж, батласан зөвлөмжийг харгалзана.

45. Техникийн нарийн бичгийн дарга нарын газар хадгалах байгууламжид хянан шалгалт хийх, эсхүл тэнд очих шийдвэрийнхээ тухай хянан шалгах баг байгууламжид тогтмол хянан шалгалт хийх, эсхүл тэнд очихоор төлөвлөгдсөн хугацаанаас 48 цагийн өмнө хянан шалгуулж буй оролцогч улсад мэдэгдэнэ. Яаралтай асуудлыг шийдвэрлэхээр хянан шалгалт хийх, эсхүл очих тохиолдолд энэ хугацааг богиносгож болно. Техникийн нарийн бичгийн дарга нарын газар хянан шалгах, эсхүл очих зорилгыг заана.

46. Хянан шалгуулж буй оролцогч улс хянан шалгагч нарыг ирэхэд зориулж аливаа шаардлагатай бэлтгэлийг хийх бөгөөд тэднийг нэвтрэх боомтоос хадгалах байгууламж уруу шуурхай хүргэх явдлыг хангана. Байгууламжийн тухай хэлэлцээрт хянан шалгагч нарт зориулсан захиргааны тохиролцоог заана.

47. Хянан шалгуулж буй оролцогч улс хянан шалгах багийг химиийн зэвсэг хадгалах байгууламжид хүрэлцэн хянан шалгалт явуулахаар ирмэгц байгууламжийн талаархи дараахь тоо баримтаар хангана:

(a) хадгалах барилга болон хадгалах талбайн тоо;

(b) хадгалах барилга болон хадгалах талбай бүрийн хувьд төрөл, таних дугаар, эсхүл талбайн бүдүүвч зураг дээр харуулсан тэмдэглэгээ;

(c) байгууламж дахь хадгалах барилга болон хадгалах талбай бүрийн хувьд химиийн зэвсгийн тодорхой төрөл бүрийн нэгж тоо, түүнчлэн байлдааны хоёрлосон хэрэгслийн хэсэг бус савны хувьд сав бүрт байгаа химиийн цэнэгийн бодит тоо хэмжээ.

48. Боломжтой хугацааны хүрээнд эд хөрөнгө данслах үедээ хянан шалгагч нар дараахь эрхтэй байна:

(a) хянан шалгалтын дараахь аргаас аль нэгийг хэрэглэх;

(i) байгууламжид хадгалж байгаа химиийн бүх зэвсгийг данслах;

(ii) хянан шалгагч нарын сонгосноор тусгай барилга буюу талбайд хадгалж байгаа химиийн бүх зэвсгийг данслах;

(iii) хянан шалгагч нарын сонгосноор байгууламжид хадгалж байгаа нэг буюу хэд хэдэн тодорхой төрлийн химиин бүх зэвсгийг данслах;

(b) дансалсан бүх эд зүйлийг тохиролцсон бүртгэлтэй тулгаж шалгах.

49. Байгууламжийн тухай хэлэлцээрт нийцүүлэн хянан шалгагч нар нь:

(a) хадгалах байгууламжийн бүх хэсэгт, түүний дотор тэнд байгаа аливаа байлдааны хэрэгсэл, төхөөрөмж, том чингэлэг болон бусад савд саадгүй нэвтрэх эрхтэй. Үйл ажиллагаагаа явуулахдаа хянан шалгагч нар тухайн байгууламж дахь аюулгүй ажиллагааны дүрмийг сахина. Хянан шалгах эд зүйлсийг хянан шалгагч нар сонгоно;

(b) химиин зэвсэг хадгалах бүрт явуулах анхны болон дараагийн хянан шалгалтын явцад дээж авах байлдааны хэрэгсэл, төхөөрөмж болон чингэлэг савыг зааж сонгох, мөн тэдгээр байлдааны хэрэгсэл, төхөөрөмж болон чингэлэг савд салгах буюу өөрчлөх оролдлогыг тухай бүр мэдэх боломж олгох онцгой шошго тэмдэг тавих эрхтэй. Шошго тэмдэг тавигдсан эд зүйлсээс химиин зэвсэг хадгалах байгууламж дээр эсхүл химиин зэвсэг устгах байгууламж дээр дээж авах бөгөөд дээжийг устгалын холбогдох хөтөлбөрт нийцүүлэн аль болох боломжтой түргэн хугацаанд, ямар ч тохиолдолд устгах ажиллагаа дуусахаас хойшгүй авна.

#### Химиин зэвсгийн устгалыг тогтмол нягтлан шалгах

50. Химиин зэвсгийн устгалыг нягтлан шалгах зорилго нь дараахид оршино:

(a) устгавал зохих химиин зэвсгийн нөөцийн шинж болон тоо хэмжээг батлах;  
(b) эдгээр нөөцийг устгасныг батлах.

51. Энэхүү конвенц хүчин төгөлдөр болсны дараа эхний 390 хоногийн турш химиин зэвсгийн устгалын ажиллагааг нягтлан шалгалтын шилжилтийн тохиролцоогоор зохицуулна. Ийм тохиролцоо, түүний дотор байгууламжийн тухай шилжилтийн хэлэлцээр, газар дээр нь хянан шалгах болон газар дээр нь байрлуулсан багаж хэрэгслээр ажиглан шинжих аргаар нягтлан шалгах тухай заалт, түүнчлэн тохиролцоог хэрэглэх цагийн хязгаарыг Байгууллага болон хянан шалгуулж буй оролцогч улс хоорондоо тохиролцоно. Эдгээр тохиролцоог энэхүү конвенц тухайн оролцогч улсын хувьд хүчин төгөлдөр болсноос хойш 60 хоногийн дотор Гүйцэтгэх зөвлөл 31 дэх хэсэгт нийцүүлэн өгсөн байгууламжийн талаархи дэлгэрэнгүй мэдээллийн үнэлгээнд үндэслэх Техникийн нарийн бичгийн дарга нарын газрын зөвлөмжийг харгалзан батална. Гүйцэтгэх зөвлөл нь 8 дугаар зүйлийн 21 дэх хэсгийн (i) дэд хэсгийн дагуу Бага хурлаас хэлэлцэж, батлах зөвлөмжид үндэслэн нягтлан шалгалтын шилжилтийн тийм тохиролцоо байгуулахад удирдлага болгох зүйлийг анхдугаар чуулганаараа тогтооно. Нягтлан шалгалтын шилжилтийн тохиролцоо нь 50 дахь хэсэгт заасан үүрэг зорилгод нийцүүлэн химиин зэвсгийн устгалыг шилжилтийн бүхий л хугацааны туршид нягтлан шалгах, түүнчлэн явагдаж буй устгалын ажиллагаанд саад учруулахаас зайлсхийхэд зориулагдана.

52. 53-аас 61 дахь хэсгийн заалтыг энэхүү конвенц хүчин төгөлдөр болсноос хойш 390-ээс доошгүй хоногийн дараа эхлэх химиин зэвсэг устгах ажиллагаанд хэрэглэнэ.

53. Техникийн нарийн бичгийн дарга нарын газар нь энэхүү конвенц, устгах байгууламжийн талаархи дэлгэрэнгүй мэдээлэл, мөн тухайн тохиолдолд өмнөх хянан шалгалтын туршлагын үндсэн дээр устгах байгууламж бүр дээр хийгдэх химиин зэвсгийн устгалыг хянан шалгах төлөвлөгөөний төслийг бэлтгэнэ. Төлөвлөгөөг тухайн байгууламж энэхүү конвенцийн дагуу устгах ажиллагааг эхлэхээс 270-аас доошгүй хоногийн өмнө дуусгаж, хянан шалгуулж буй оролцогч улсад саналыг нь авахаар өгнө. Техникийн нарийн бичгийн дарга нарын газар болон оролцогч улсын хооронд үүссэн аливаа саналын зөрүүг зөвлөлдөх замаар шийдвэрлэнэ. Шийдвэрлэж чадаагүй аливаа асуудлыг энэхүү конвенцийг бүрэн хэрэгжүүлэхийг хөнгөвчлөн дэмжих үүднээс зохих арга хэмжээ авахуулахаар Гүйцэтгэх зөвлөлд уламжилна.

54. Техникийн нарийн бичгийн дарга нарын газар хянан шалгуулж буй оролцогч улсын химиин зэвсэг устгах байгууламж бүрд энэхүү конвенцийн дагуу устгах ажиллагаа эхлэхээс 270-аас доошгүй хоногийн өмнө байгууламжтай танилцаж, хянан шалгалтын төлөвлөгөөний зөв зохистой байдлыг дүгнэхээр анхлан очно.

55. Химиин зэвсгийн устгах ажиллагаа нэгэнт эхэлсэн устгах байгууламжийн хувьд Техникийн нарийн бичгийн дарга нарын газар анхлан очибоос өмнө байгууламжийг хоргуйжуулэх шаардлагыг хянан шалгуулж буй оролцогч улсад тавихгүй. Очих хугацаа нь таван хоногоос хэтрэхгүй бөгөөд очих ажилтны тоо 15-аас хэтрэхгүй байна.

56. Нягтлан шалгах дэлгэрэнгүй төлөвлөгөөг Техникийн нарийн бичгийн дарга нарын газрын зохих зөвлөмжийн хамт хянуулахаар Гүйцэтгэх зөвлөлд өгнө. Гүйцэтгэх зөвлөл нь конвенцид заасан nyaгтлан шалгах зорилт, үүрэгт нийцүүлэн төлөвлөгөөг батлах үүднээс хянан үзнэ. Гүйцэтгэх зөвлөл нь мөн устгалыг nyaгтлан шалгах төлөвлөгөө нь nyaгтлан шалгалтын зорилгод нийцэж буй бөгөөд үр ашигтай, хэрэгжих боломжтойг батлах нь зүйтэй. Устгал эхлэх хугацаа эхлэхээс 180-аас доошгүй хоногийн өмнө хянан үзэж дуусах нь зүйтэй.

57. Гүйцэтгэх зөвлөлийн гишүүн бүр nyaгтлан шалгалтын талаархи аливаа асуудлаар Техникийн нарийн бичгийн дарга нарын газартай зөвлөлдөж болно. Гүйцэтгэх зөвлөлийн аливаа гишүүний зүгээс татгалзал гараагүй бол төлөвлөгөөг хэрэгжүүлж эхлэнэ.

58. Аливаа бэрхшээл гарсан бол Гүйцэтгэх зөвлөл тэдгээрийг зохицуулан шийдвэрлэхээр оролцогч улстай зөвлөлдөнө. Хэрэв аливаа бэрхшээл нь шийдвэрлэгдээгүй үлдвэл тэдгээрийг Бага хуралд уламжилна.

59. Химиин зэвсэг устгах байгууламжид зориулсан байгууламжийн тухай дэлгэрэнгүй хэлэлцээрт устгах байгууламж болон түүнийг ажиллуулах арга барилын онцлог шинжийг нь харгалзан дараах зүйлийг заана:

- (а) газар дээр нь хийх хянан шалгалтын дэлгэрэнгүй журам;
- (б) газар дээр нь байрлуулсан багаж хэрэгсэл ашиглан тасралтгүй ажиглан шинжих болон хянан шалгагч нарыг биечлэн байлцуулах замаар nyaгтлан шалгах тухай заалт.

60. Байгууламж дээр энэхүү конвенцийн дагуу устгал эхлэхээс 60-аас доошгүй хоногийн өмнө хянан шалгагч нарт химиин зэвсэг устгах байгууламж бүрт нэвтрэх зөвшөөрөл олгоно. Ийнхүү нэвтрэх нь хянан шалгах тоног төхөөрөмж суурилуулах, энэ тоног төхөөрөмжийг хянан шалгах, түүний ажиллагааг турших, мөн

байгууламжийн инженерийн эцсийн үзлэг хийх зорилготой байна. Химиин зэвсгийн устгах ажиллагаа нэгэнт эхэлсэн устгах байгууламжийн хувьд хянан шалгах тоног төхөөрөмжийг суурилуулж, турших зорилгоор 60 хоногоос хэтрэхгүй шаардлагатай хамгийн бага хугацаанд устгах ажиллагааг зогсоно. Туршилт болон үзлэгийн үр дүнгээс хамааран оролцогч улс болон Техникийн нарийн бичгийн дарга нарын газар тухайн байгууламжид холбогдох байгууламжийн тухай дэлгэрэнгүй хэлэлцээрт нэмэлт, эсхүл өөрчлөлт оруулах талаар тохиролцож болно.

61. Хянан шалгуулж буй оролцогч улс химиин зэвсэг хадгалах байгууламжаас тухайн устгах байгууламж уруу химиин зэвсэг зөөвөрлөх бүрдээ гарахаас дөрвөөс доошгүй цагийн өмнө химиин зэвсэг устгах байгууламж дахь хянан шалгах багийн ахлагчид бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд хадгалах байгууламжийн нэр, гарах, хүрэхээр тооцоолсон цаг, тээвэрлэж буй химиин зэвсгийн тодорхой төрөл болон тоо хэмжээ, шошго тэмдэг бүхий аливаа эд зүйлийг гаргасан эсэх, мөн тээвэрлэх аргын талаар тусгана. Энэ мэдэгдэлд нэгээс илүү зөөвөрлөлтийн талаар мэдэгдэж болно. Энэ мэдээлэлд гарсан аливаа өөрчлөлтийн талаар хянан шалгах багийн ахлагчид даруй бичгээр мэдэгдэнэ.

**Химиин зэвсэг устгах байгууламж дахь химиин зэвсэг хадгалах байгууламж**

62. Хянан шалгагч нар химиин зэвсгийг устгах байгууламжид авч ирсэн болон эдгээр химиин зэвсгийг хадгалсныг нягтлан шалгана. Хянан шалгагч нар химиин зэвсгийг устгахаас өмнө байгууламжийн аюулгүйн дүрэмтэй нийцэх тохиролцсон журмыг ашиглан зөөвөрлөлт бүрийн дансалсан жагсаалтыг нягтлан шалгана. Тэд зохих тохиолдолд устгахаас өмнө химиин зэвсгийн үнэн зөв дансалсан жагсаалт гаргах явцыг хялбарчлахын тулд тохиролцсон лац, тэмдэглэгээ, эсхүл эд хөрөнгө данслах хяналтын бусад журмыг хэрэглэнэ.

63. Химиин зэвсэг устгах байгууламжид байрлуулсан химиин зэвсэг хадгалах байгууламжид химиин зэвсэг хадгалуулмагц, түүнчлэн тийнхүү хадгалж байх хугацаанд эдгээр хадгалах байгууламжийг байгууламжийн тухай холбогдох хэлэлцээрт нийцүүлэн тогтмол хянан шалгалтад хамруулна.

64. Устгалын идэвхтэй үе дуусахад хянан шалгагч нар хадгалах байгууламжаас устгахаар гаргасан химиин бүх зэвсгийг дансална. Тэд 62 дахь хэсэгт дурдсан эд хөрөнгө данслах хяналтын журам ашиглан үлдэж буй химиин зэвсгийг үнэн зөв дансалсныг нягтлан шалгана.

**Химиин зэвсэг устгах байгууламжид газар дээр нь нягтлан шалгах тогтмол арга хэмжээ**

65. Устгалын бүхий л идэвхтэй үеийн турш химиин зэвсэг устгах байгууламжид болон тэдгээр байгууламжид байрлуулсан химиин зэвсэг хадгалах байгууламжид үйл ажиллагаагаа явуулах үүднээс нэвтрэх эрхийг хянан шалгагч нарт олгоно.

66. Химиин зэвсэг устгах байгууламж бүрд химиин зэвсгийг өөр чиглэлд зөөвөрлөхгүй бөгөөд устгах явц дууссаныг нотлохын тулд хянан шалгагч нар биечлэн байлцах болон газар дээр нь байрлуулсан багаж хэрэгсэл ашиглан ажиглан шинжих аргаар дараах зүйлийг нягтлан шалгах эрхтэй:

- (а) байгууламжид химиин зэвсэг хүлээн авах;

(b) химийн зэвсэг түр хугацаагаар байлгах талбай болон уг талбайд хадгалж буй химийн зэвсгийн тодорхой төрөл, тоо хэмжээ;

(c) устгаж буй химийн зэвсгийн тодорхой төрөл болон тоо хэмжээ;

(d) устгалын явц;

(e) устгалын эцсийн бүтээгдэхүүн;

(f) металл хэсгийн хэлбэрийг өөрчлөх;

(g) устгах явц болон байгууламжийн цогц байдал.

67. Хянан шалгагч нар химийн зэвсэг устгах байгууламжид түр байлгах талбай дахь байлдааны хэрэгсэл, төхөөрөмж буюу саванд дээж авах зорилгоор шошго тэмдэг тавих эрхтэй.

68. Хянан шалгалтын шаардлагад нийцэх хэмжээнд байгууламжийн өрдийн үйл ажиллагааны үед авсан мэдээллийг зохих тоо баримтын жинхэнэ гэдгийг тогтоосны хамт хянан шалгах зорилгоор ашиглана.

69. Устгах үе бүхэн дууссаны дараа Техникийн нарийн бичгийн дарга нарын газар тогтоогдсон тоо хэмжээний химийн зэвсгийг устгаж дууссаныг илтгэсэн оролцогч улсын мэдүүлгийг батална.

70. Байгууламжийн тухай хэлэлцээрт нийцүүлэн хянан шалгагч нар:

(a) химийн зэвсэг устгах байгууламж болон тэдгээр байгууламжид байрлуулсан химийн зэвсэг хадгалах байгууламжийн бүх хэсэг, түүний дотор тэнд байгаа аливаа байлдааны хэрэгсэл, төхөөрөмж, чингэлэг болон бусад саванд саадгүй хүрнэ. Хянан шалгах зүйлийг хянан шалгуулж буй оролцогч улсын зөвшөөрсөн бөгөөд Гүйцэтгэх зөвлөлийн батласан нягтлан шалгалтын төлөвлөгөөнд нийцүүлэн хянан шалгагч нар сонгоно;

(b) устгах явцын турш дээжийг газар дээр нь тогтмол шинжлэхийг хийхийг ажиглан шинжинэ;

(c) шаардлагатай бол устгах байгууламж, эсхүл тэдгээр дэх хадгалах байгууламж дахь аливаа төхөөрөмж, чингэлэг болон бусад савнаас тэдний хүсэлтээр авсан дээжийг хүлээж авна.

#### IV ХЭСЭГ В АНГИ

### ХИМИЙН ХУУЧИН ЗЭВСЭГ БОЛОН ОРХИСОН ХИМИЙН ЗЭВСЭГ

#### A. Ерөнхий зүйл

1. Химийн хуучин зэвсгийг В ангид заасны дагуу устгана.

2. Орхисон химийн зэвсгийг, түүний дотор 2 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн (b) дэд хэсгийн тодорхойлолтод нийцэж байгаа зэвсгийг С ангид заасны дагуу устгана.

## **В. Химийн хуучин зэвсэгт зориулсан горим**

3. 2 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн (а) дэд хэсэгт тодорхойлсон химийн хуучин зэвсэг нутаг дэвсгэрт нь байгаа оролцогч улс энэхүү конвенц түүний хувьд хүчин төгөлдөр болсны дараа 30 хоногийн дотор химийн эдгээр хуучин зэвсгийн байршил, төрөл, тоо хэмжээ болон одоогийн нөхцөл байдлын талаар боломжтой хэмжээнд тусгасан холбогдох бүх байгаа мэдээллийг Техникийн нарийн бичгийн дарга нарын газарт өгнө.

2 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн (б) дэд хэсэгт тодорхойлсон химийн хуучин зэвсгийн тохиолдолд оролцогч улс энэхүү хавсралтын IV хэсгийн А ангийн 1-ээс 3 дахь хэсэгт заасан мэдээллийг боломжтой хэмжээнд тусгасан мэдүүлгийг 3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн (б) (i) дэд хэсгийн дагуу Техникийн нарийн бичгийн дарга нарын газарт өгнө.

4. Энэхүү конвенц түүний хувьд хүчин төгөлдөр болсны дараа химийн хуучин зэвсэг илрүүлсэн оролцогч улс химийн хуучин зэвсэг илрүүлсний дараа 180 хоногийн дотор 3 дахь хэсэгт заасан мэдээллийг Техникийн нарийн бичгийн дарга нарын газарт өгнө.

5. 3 болон 4 дэх хэсгийн дагуу өгсөн мэдээллийг нягтлан шалгах, түүнчлэн химийн зэвсэг нь 2 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасан химийн хуучин зэвсгийн тодорхойлолттой нийцэж байгаа эсэхийг тодорхойлох зорилгоор Техникийн нарийн бичгийн дарга нарын газар анхны хянан шалгалт болон шаардлагатай байж болох аливаа цаашдын хянан шалгалтыг явуулна. 1925 болон 1946 оны хооронд үйлдвэрлэсэн химийн зэвсгийг ашиглах боломжтой эсэхийг тодорхойлоход удирдлага болгох зүйлийг 8 дугаар зүйлийн 21 дэх хэсгийн (i) дэд хэсгийн дагуу Бага хурлаар хэлэлцэж, батална.

6. Оролцогч улс 2 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн (а) дэд хэсгийн тодорхойлолттой нийцэж байгаа гэж Техникийн нарийн бичгийн дарга нарын газраас батласан химийн хуучин зэвсгийг хорт хаягдлын хувьд авч үзнэ. Оролцогч улс нь химийн хуучин зэвсгийг хорт хаягдлын хувьд үндэсний хууль тогтоомжийн дагуу устгах, эсхүл өөрөөр зайлцуулах талаар авч байгаа арга хэмжээнийхээ тухай Техникийн нарийн бичгийн дарга нарын газарт мэдээлнэ.

7. 3-аас 5 дахь хэсгийг мөрдөхийн хамт, оролцогч улс 2 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн (б) дэд хэсгийн тодорхойлолттой нийцэж байгаа гэж Техникийн нарийн бичгийн дарга нарын газраас батласан химийн хуучин зэвсгийг 4 дүгээр зүйл болон энэхүү хавсралтын IV хэсгийн А ангид нийцүүлэн устгана.

## **С. Орхисон химийн зэвсэгт зориулсан горим**

8. Орхисон химийн зэвсэг нутаг дэвсгэрт нь байгаа оролцогч улс (цаашид “нутаг дэвсгэрт нь химийн зэвсэг орхигдсон оролцогч улс” гэх) энэхүү конвенц түүний хувьд хүчин төгөлдөр болсны дараа 30 хоногийн дотор орхисон химийн зэвсгийн талаархи холбогдох бүх байгаа мэдээллийг Техникийн нарийн бичгийн дарга нарын газарт өгнө. Энэ мэдээлэлд орхисон химийн зэвсгийн байршил, төрөл, тоо хэмжээ болон одоогийн нөхцөл байдал, түүнчлэн орхисон талаар боломжтой хэмжээнд тусгана.

9. Энэхүү конвенц түүний хувьд хүчин төгөлдөр болсны дараа орхисон химийн зэвсэг илрүүлсэн оролцогч улс орхисон химийн зэвсэг илрүүлсний дараа 180 хоногийн

дотор илрүүлсэн орхисон химийн зэвсгийн талаархи холбогдох бүх байгаа мэдээллийг Техникийн нарийн бичгийн дарга нарын газарт өгнө. Энэ мэдээлэлд орхисон химийн зэвсгийн байршил, төрөл, тоо хэмжээ болон одоогийн нөхцөл байдал, түүнчлэн орхисон талаар боломжтой хэмжээнд тусгана.

10. Оролцогч өөр улсын нутаг дэвсгэрт химийн зэвсэг орхисон оролцогч улс (цаашид “Химийн зэвсэг орхигч оролцогч улс” гэх) энэхүү конвенц түүний хувьд хүчин төгөлдөр болсноос хойш 30 хоногийн дотор орхисон химийн зэвсгийн талаархи холбогдох бүх байгаа мэдээллийг Техникийн нарийн бичгийн дарга нарын газарт өгнө. Энэ мэдээлэлд орхисон химийн зэвсгийн байршил, төрөл, тоо хэмжээ болон одоогийн нөхцөл байдал, түүнчлэн орхисон талаар боломжтой хэмжээнд тусгана.

11. 8-аас 10 дахь хэсгийн дагуу өгсөн холбогдох бүх байгаа мэдээллийг нягтлан шалгах, түүнчлэн энэхүү хавсралтын IV хэсгийн А ангийн 41-ээс 43 дахь хэсэгт нийцүүлэн тогтмол нягтлан шалгалт шаардлагатай эсэхийг тодорхойлох зорилгоор Техникийн нарийн бичгийн дарга нарын газар анхны хянан шалгалт болон шаардлагатай байж болох аливаа цаашдын хянан шалгалтыг явуулна.

12. Техникийн нарийн бичгийн дарга нарын газрын илтгэлийг Гүйцэтгэх зөвлөл, нутаг дэвсгэрт нь химийн зэвсэг орхигдсон оролцогч улс болон химийн зэвсэг орхигч оролцогч улс, эсхүл химийн зэвсэг орхисон гэж нутаг дэвсгэрийн оролцогч улс мэдуулсэн буюу Техникийн нарийн бичгийн дарга нарын газраас тогтоосон аливаа оролцогч улсад өгнө. Хэрэв шууд хамаарал бүхий аль нэг оролцогч улс илтгэлийн талаар сэтгэл хангалаа бус байвал асуудлаа энэхүү конвенцийн заалтад нийцүүлэн зохицуулах, эсхүл асуудлыг шуурхай шийдвэрлүүлэх үүднээс Гүйцэтгэх зөвлөлд тавих эрхтэй.

13. 1 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн дагуу, орхисон химийн зэвсгийг нутаг дэвсгэр дээр нь химийн зэвсэг орхигдсон оролцогч улстай хамтран устгах зорилгоор зөвлөлдөхийг нутаг дэвсгэрт нь химийн зэвсэг орхигдсон оролцогч улс 8-аас 12 дахь хэсгийн дагуу химийн зэвсэг орхигч оролцогч улс гэж тогтоогдсон оролцогч улсаас хүсэх эрхтэй. Тухайн улс ийм хүсэлтийн тухай Техникийн нарийн бичгийн дарга нарын газарт нэн даруй мэдээлнэ.

14. Устгах талаар харилцан тохиролцсон төлөвлөгөө байгуулах үүднээс нутаг дэвсгэр нь химийн зэвсэг орхигдсон оролцогч улс болон химийн зэвсэг орхигч оролцогч улс хоорондын зөвлөлдөн нь 13 дахь хэсэгт дурдсан хүсэлтийн тухай мэдээг Техникийн нарийн бичгийн дарга нарын газар хүлээж авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор эхлэнэ. Устгах талаар харилцан тохиролцсон төлөвлөгөөг 13 дахь хэсэгт дурдсан хүсэлтийн тухай мэдээг Техникийн нарийн бичгийн дарга нарын газар хүлээж авсан өдрөөс хойш 180 хоногийн дотор Техникийн нарийн бичгийн дарга нарын газарт өгнө. Химийн зэвсэг орхигч оролцогч улс болон нутаг дэвсгэрт нь химийн зэвсэг орхигдсон оролцогч улсын хүсэлтээр Гүйцэтгэх зөвлөл нь устгах талаар харилцан тохиролцсон төлөвлөгөөг тараах цагийн хязгаарыг сунгаж болно.

15. Орхисон химийн зэвсгийг устгах зорилгоор химийн зэвсэг орхигч оролцогч улс нь шаардлагатай бүх санхүүгийн, техникийн, шинжээчийн, байгууламжийн болон бусад эх сурвалжаар хангана. Нутаг дэвсгэрт нь химийн зэвсэг орхигдсон оролцогч улс зохих ёсоор хамтран ажиллана.

16. Хэрэв химийн зэвсэг орхигч оролцогч улс нь тогтоогдох боломжгүй, эсхүл энэхүү конвенцийн оролцогч улс биш бол нутаг дэвсгэрт нь химийн зэвсэг орхигдсон оролцогч улс тэдгээр орхисон химийн зэвсгийг устгах явдлыг хангахын тулд тэдгээр

орхисон химийн зэвсгийг устгахад тусlamж үзүүлэхийг Байгууллага болон оролцогч бусад улсаас хүсэж болно.

17. 8-аас 16 дахь хэсгийг мөрдөхийн хамт, 4 дүгээр зүйл болон энэхүү хавсралтын IV хэсгийн А ангийг орхисон химийн зэвсгийг устгахад мөн хэрэглэнэ. 2 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн (b) дэд хэсэгт заасан химийн хуучин зэвсгийн тодорхойлолтод мөн нийцэж байгаа орхисон химийн зэвсгийн тохиолдолд Гүйцэтгэх зөвлөл нь устгах тухай заалтыг өөрчлөх, эсхүл онцгой тохиолдолд хэрэглэхийг түдгэлзүүлэх нь энэхүү конвенцийн зүйл, зорилгод аюул учруулахгүй гэж тодорхойлвол нутаг дэвсгэрт нь химийн зэвсэг орхигдсон оролцогч улсын хүсэлтээр дангаараа эсхүл химийн зэвсэг орхигч оролцогч улстай хамтран тухайн заалтыг өөрчлөх, эсхүл онцгой тохиолдолд хэрэглэхийг түдгэлзүүлж болно. 2 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн (b) дэд хэсэгт заасан химийн хуучин зэвсгийн тодорхойлолтод нийцэхгүй байгаа орхисон химийн зэвсгийн тохиолдолд Гүйцэтгэх зөвлөл нь цагийн хязгаар болон устгах дарааллын тухай заалтыг онцгой тохиолдолд өөрчлөх нь энэхүү конвенцийн зүйл, зорилгод аюул учруулахгүй гэж тодорхойлвол нутаг дэвсгэрт нь химийн зэвсэг орхигдсон оролцогч улсын хүсэлтээр дангаараа, эсхүл химийн зэвсэг орхигч оролцогч улстай хамтран тухайн заалтыг онцгой тохиолдолд өөрчиж болно. Энэ хэсэгт дурдсан аливаа хүсэлтэд заалтыг өөрчлөх тодорхой санал болон өөрчлөх санал болгож байгаа шалтгааны дэлгэрэнгүй тайлбарыг тусгана.

18. Оролцогч улсууд хоорондоо орхисон химийн зэвсгийг устгах талаар хэлэлцээр, эсхүл тохиролцоо байгуулж болно. Нутаг дэвсгэрт нь химийн зэвсэг орхигдсон оролцогч улсын хүсэлтээр Гүйцэтгэх зөвлөл нь орхисон химийн зэвсгийн устгал нь 17 дахь хэсэгт нийцэх явдлыг тухайн хэлэлцээр буюу тохиролцоо хангаж байна гэж үзвэл тэдгээр хэлэлцээр буюу тохиролцооны сонгосон заалт нь энэ ангийн заалтыг давамгайлах хүчинтэй гэж дангаараа, эсхүл химийн зэвсэг орхигч оролцогч улстай хамтран шийдвэрлэж болно.

## V ХЭСЭГ

### **ХИМИЙН ЗЭВСЭГ ҮЙЛДВЭРЛЭХ БАЙГУУЛАМЖИЙГ УСТГАХ, УСТГАЛЫГ 5 ДУГААР ЗҮЙЛИЙН ДАГУУ НЯГТЛАН ШАЛГАХ**

#### **A. Мэдүүлэг**

##### **Химиийн зэвсэг үйлдвэрлэх байгууламжийн тухай мэдүүлэг**

1. Конвенцийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн (c) (ii) дэд хэсгийн дагуу оролцогч улсын химийн зэвсэг үйлдвэрлэх байгууламжийн тухай мэдүүлэгт байгууламж бүрийн хувьд дараах зүйлийг тусгана:

(а) байгууламжийн нэр, өмчлөгчдийн нэр, 1946 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хойш байгууламжийг ажиллуулж буй компани буюу аж ахуйн нэгжийн нэр;

(б) байгууламжийн тодорхой байршил, түүний дотор хаяг, цогцолборын байршил, цогцолбор дахь тухайн байгууламжийн байршил, түүний дотор хэрэв байгаа бол тодорхой барилга байгууламжийн дугаар;

(с) энэ нь химийн зэвсэг гэж тодорхойлсон химийн бодис бэлтгэхэд зориулагдсан байгууламж мөн эсэх, эсхүл энэ нь химийн зэвсэг цэнэглэхэд зориулагдсан байгууламж эсэх, эсхүл хоёулаа эсэх тухай мэдэгдэл;

(d) байгууламжийг барьж дууссан он, сар, өдөр болон байгууламжид байгууламжийн үйлдвэрлэх явцын шинжийг ихээхэн өөрчилсөн аливаа өөрчлөлт хийхэд, түүний дотор шинэ эсхүл засварлагдсан тоног төхөөрөмж суурилуулахад зарцуулсан хугацаа;

(e) химийн зэвсэг гэж тодорхойлсон байгууламжид бэлтгэгдсэн химийн бодис; байгууламжид цэнэглэгдсэн байлдааны хэрэгсэл, төхөөрөмж болон сав; тийнхүү бэлтгэж буюу цэнэглэж эхэлсэн болон дууссан хугацааны талаархи мэдээлэл:

(i) химийн зэвсэг гэж тодорхойлсон байгууламжид бэлтгэгдсэн химийн бодисын хувьд тухайн мэдээлэл нь Цэвэр болон хавсарга химийн шинжлэх ухааны олон улсын холбоо (IUPAC)-ны нэр томъёоны мөрдөгдөж буй систем, бүтцийн томъёо болон хэрэв Химийн бодисын үйлчилгээний бүртгэлийн дугаар заасан бол уг дугаарт нийцүүлэн химийн нэршлийг заасан бэлтгэсэн химийн бодисын тодорхой төрлийн хэлбэрээр, түүнчлэн тонноор хэмжигдсэн жингээр илэрхийлсэн химийн бодис бүрийн хэмжээний хэлбэрээр илэрхийлэгдэнэ;

(ii) байгууламжид цэнэглэгдсэн байлдааны хэрэгсэл, төхөөрөмж болон савны хувьд тухайн мэдээлэл нь цэнэглэгдсэн химийн зэвсгийн тодорхой төрлийн болон нэгж бүрийн химийн бодисын цэнэгийн жингийн хэлбэрээр илэрхийлэгдэнэ;

(f) химийн зэвсэг үйлдвэрлэх байгууламжийн үйлдвэрлэх хүчин чадал:

(i) химийн зэвсэг үйлдвэрлэсэн байгууламжийн хувьд үйлдвэрлэх хүчин чадал нь тухайн байгууламжид бодитоор ашиглагдаж буй, эсхүл бодитоор ашиглагдахгүй байгаа явцын тохиолдолд ашиглагдахаар төлөвлөгдөж буй технологийн горимд үндэслэн тодорхой бодисыг жилд үйлдвэрлэх хүчин чадлын тоо хэмжээний хэлбэрээр илэрхийлэгдэнэ;

(ii) химийн зэвсгийг цэнэглэсэн байгууламжийн хувьд үйлдвэрлэлийн хүчин чадал нь жилд тодорхой төрлийн химийн зэвсэг бүрт байгууламжийн цэнэглэж болох химийн бодисын тоо хэмжээний хэлбэрээр илэрхийлэгдэнэ;

(g) химийн зэвсэг үйлдвэрлэх устгагдаагүй байгууламж бүрийн хувьд тухайн байгууламжийн тухай дараах зүйлийг агуулсан тодорхойлолт:

(i) талбайн бүдүүвч зураг;

(ii) байгууламжийн технологийн урсгалын бүдүүвч зураг;

(iii) байгууламж дахь барилга, байгууламж дахь тусгай тоног төхөөрөмж болон уг тоног төхөөрөмжийн аливаа эд ангийн дансалсан жагсаалт;

(h) дараах зүйлийг заасан байгууламжийн тухайн үеийн байдал:

(i) тухайн байгууламжид химийн зэвсэг хамгийн сүүлд үйлдвэрлэсэн он, сар, өдөр;

(ii) байгууламжийг устгасан эсэх, түүний дотор устгасан он, сар, өдөр болон арга хэлбэр;

(iii) энэхүү конвенц хүчин төгөлдөр болохоос өмнө тухайн байгууламжийг химиин зэвсэг үйлдвэрлэхэд хамааралгүй үйл ажиллагаанд ашигласан, эсхүл өөрчилсөн эсэх, хэрэв тийм бол ямар өөрчлөлт хийгдсэн талаархи мэдээлэл, химиин зэвсэг үйлдвэрлэхэд хамааралгүй үйл ажиллагаа эхэлсэн он, сар, өдөр, түүнчлэн зохих тохиолдолд бүтээгдэхүүний төрлийг заасан уг үйл ажиллагааны шинж чанар;

(i) байгууламжийг хаахаар оролцогч улсын авсан арга хэмжээний тухай тодорхойлолт, түүнчлэн байгууламжийн үйл ажиллагааг зогсоохоор оролцогч улсын авсан болон авах арга хэмжээний тухай тодорхойлолт;

(j) үйл ажиллагааг нь зогсоосон байгууламжийн аюулгүй байдлыг хангахад чиглэсэн хэвийн үйл ажиллагааны тухай тодорхойлолт;

(k) байгууламжийг химиин зэвсгийг устгахаар хувиргах эсэх тухай мэдэгдэл, хэрэв тийм бол тийнхүү хувиргах он, сар, өдөр.

**3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн (c) (iii) дэд хэсгийн дагуу гаргах химиин зэвсэг үйлдвэрлэх байгууламжийн тухай мэдүүлэг**

2. 3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн (c) (iii) дэд хэсгийн дагуу гаргах химиин зэвсэг үйлдвэрлэх байгууламжийн тухай мэдүүлэг нь дээрх 1 дэх хэсэгт заасан бүх мэдээллийг агуулна. Мэдүүлэг гаргах явдлыг хангахын тулд өөр улстай хамтран зохих тохиролцоо хийх нь тухайн байгууламж нутаг дэвсгэрт нь байгаа эсхүл байсан оролцогч улсын үүрэг хариуцлага юм. Хэрэв тухайн байгууламж нутаг дэвсгэрт нь байгаа, эсхүл байсан оролцогч улс энэ үүргээ биелүүлэх боломжгүй бол үүний шалтгааныг заана.

**Урьд нь шилжүүлсэн болон хүлээн авсан тухай мэдүүлэг**

3. Оролцогч улс нь 1946 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хойш химиин зэвсэг үйлдвэрлэх тоног төхөөрөмж шилжүүлсэн, эсхүл хүлээн авсан тохиолдолд тийнхүү шилжүүлсэн, эсхүл хүлээн авсан тухайгаа 3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн (a)(iii) дэд хэсгийн дагуу, түүнчлэн 5 дахь хэсэгт нийцүүлэн мэдүүлнэ. 1946 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 1970 оны 1 дүгээр сарын 1-ний өдрийн хоорондох хугацаанд химиин зэвсэг үйлдвэрлэх тоног төхөөрөмж шилжүүлсэн, эсхүл хүлээн авсан талаар дээр заасан бүх мэдээлэл байхгүй бол оролцогч улс өөрт байгаа бүх мэдээллийг мэдүүлэх бөгөөд мэдүүлгийг бүрэн гаргаж өгч чадахгүй байгаа талаар тайлбар гаргана.

4. 3 дахь хэсэгт дурдсан химиин зэвсэг үйлдвэрлэх тоног төхөөрөмж гэж:

(a) тусгай тоног төхөөрөмж;

(b) химиин зэвсэг хэрэглэхтэй шууд холбоотойгоор ашиглахад тусгайлан зориулагдсан тоног төхөөрөмжийг үйлдвэрлэхэд чиглэсэн тоног төхөөрөмж;

(c) химиин байлдааны хэрэгслийн химиин бус эд ангийг үйлдвэрлэхэд гагцхүү зориулагдсан, эсхүл ашиглагдаж буй тоног төхөөрөмж.

5. Химиин зэвсэг үйлдвэрлэх тоног төхөөрөмжийг шилжүүлсэн, эсхүл хүлээн авсан тухай мэдүүлэг нь дараах зүйлийг заана:

(a) химийн зэвсэг үйлдвэрлэх тоног төхөөрөмжийг хэн хүлээн авсан/шилжүүлсэн;

(b) тухайн тоног төхөөрөмжийн шинж;

(c) шилжүүлсэн буюу хүлээн авсан он, сар, өдөр;

(d) хэрэв мэдэгдэж буй бол тухайн тоног төхөөрөмжийг устгасан эсэх;

(e) хэрэв мэдэгдэж буй бол одоо байгаа газар.

**Устгах тухай ерөнхий төлөвлөгөөг өргөн барих**

6. Химийн зэвсэг үйлдвэрлэх байгууламж бүрийн хувьд оролцогч улс нь дараах мэдээллийг гарган өгнө:

(a) авах арга хэмжээний төлөвлөсөн цагийн хязгаар;  
(b) устгах арга.

7. Оролцогч улс химиийн зэвсгийг устгах байгууламжид түр хугацаагаар хувиргах гэж буй химиийн зэвсэг үйлдвэрлэх байгууламж бүрийн хувьд тухайн оролцогч улс дараах мэдээллийг гарган өгнө:

(a) устгах байгууламжид хувиргахад зарцуулахаар төлөвлөсөн цагийн хязгаар;

(b) байгууламжийг химиийн зэвсэг устгах байгууламжийн хувьд ашиглахад зарцуулахаар төлөвлөсөн цагийн хязгаар;

(c) шинэ байгууламжийн тухай тодорхойлолт;

(d) тусгай тоног төхөөрөмжийг устгах арга;

(e) химиийн зэвсэг устгах зорилгоор ашигласны нь дараа байгууламжийг устгахад зарцуулах цагийн хязгаар;

(f) хувиргасан байгууламжийг устгах арга.

**Устгах тухай жилийн төлөвлөгөө болон устгалын тухай илтгэлийг өргөн барих**

8. Оролцогч улс нь устгах тухай жилийн төлөвлөгөөг дараагийн устгалын жил эхлэхээс 90-ээс доошгүй хоногийн өмнө бэлтгэж өгнө. Жилийн төлөвлөгөөнд дараах зүйлийг тусгана:

(a) устгагдах хүчин чадал;

(b) устгал явагдах байгууламжийн нэр, байршил;

(c) байгууламж бүрт устгагдах барилга, тоног төхөөрөмжийн жагсаалт;

(d) устгах талаар төлөвлөсөн арга.

9. Оролцогч улс нь устгалын тухай жилийн илтгэлийг өмнөх устгалын жил дууссанаас хойш 90 хоногийн дотор бэлтгэж өгнө. Жилийн илтгэлд дараахь зүйлийг тусгана:

- (a) устгасан хүчин чадал;
- (b) устгал явагдсан байгууламжийн нэр, байршил;
- (c) байгууламж бүрт устгасан барилга, тоног төхөөрөмжийн жагсаалт;
- (d) устгасан арга.

10. Конвенцийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн (с) (iii) дэд хэсгийн дагуу мэдүүлсэн химийн зэвсэг үйлдвэрлэх байгууламжийн хувьд, дээрх 6-аас 9 дэх хэсэгт заасан мэдүүлгийг гаргах явдлыг хангахын тулд өөр улстай хамтран зохих тохиролцоо хийх нь тухайн байгууламж нутаг дэвсгэрт нь байгаа, эсхүл байсан оролцогч улсын үүрэг хариуцлага юм. Хэрэв тухайн байгууламж нутаг дэвсгэрт нь байгаа, эсхүл байсан оролцогч улс энэ үүргээ биелүүлэх боломжгүй бол үүний шалтгааныг заана.

## B. Устгах

### Химийн зэвсэг үйлдвэрлэх байгууламжийг устгах ерөнхий зарчим

11. Оролцогч улс бүр 5 дугаар зүйлд болон энэ хэсэгт заасан зарчмын дагуу химийн зэвсэг үйлдвэрлэх байгууламжийг устгахад хэрэглэх аргыг тодорхойлно.

### Химийн зэвсэг үйлдвэрлэх байгууламжийг хаахад баримтлах зарчим, арга

12. Химийн зэвсэг үйлдвэрлэх байгууламжийг хаахын зорилго нь байгууламжийн үйл ажиллагааг зогсооход оршино.

13. Байгууламжийг хаах талаар тохиролцсон арга хэмжээг оролцогч улс байгууламж бүрийн онцлог шинж чанарыг харгалзан авч хэрэгжүүлнэ. Эдгээр арга хэмжээнд дараахь зүйл *inter alia* хамрагдана:

- (a) тохиролцсон үйл ажиллагаанаас бусад зорилгоор байгууламжийн тусгай барилга болон ердийн барилгыг эзэмшихийг хориглох;
- (b) химийн зэвсэг үйлдвэрлэхтэй шууд холбоотой тоног төхөөрөмж, түүний дотор *inter alia* үйл ажиллагааг хянах тоног төхөөрөмж, хэрэгслийг салгах;
- (c) химийн зэвсэг үйлдвэрлэх байгууламжийн аюулгүй ажиллагааг хангахад гагцхүү ашиглаж буй хамгаалалтын суурилуулалт, тоног төхөөрөмжийг ашиглалтаас гаргах;
- (d) Химийн зэвсэг гэж тодорхойлсон химийн бодисыг синтезэд оруулах, салгах буюу цэвэршүүлэхэд зориулагдсан технологийн аливаа тусгай тоног төхөөрөмж, аливаа хадгалах төмөр сав, эсхүл химийн зэвсэг цэнэглэх аливаа машинд химийн бодис нэмэх эсхүл түүнээс химийн бодис гарахаас, түүнчлэн халаалт, хөргөлт, эсхүл ийм тоног төхөөрөмж, хадгалах төмөр сав буюу машиныг цахилгаан болон бусад төрлийн эрчим хүчээр хангахаас сэргийлэх чимээ дарагч болон бусад төхөөрөмжийг суурилуулах;

(е) тохиролцсон үйл ажиллагаанд шаардлагатайгаас бусад химиин зэвсэг үйлдвэрлэх байгууламж уруу чиглэсэн хүнд даацын тээврийн хэрэгсэл зорчих төмөр зам, авто зам болон бусад замыг хаах.

14. Химиин зэвсэг үйлдвэрлэх байгууламжийг хаасан үед ч оролцогч улс нь байгууламж дахь аюулгүй байдлыг хангах болон биечлэн хамгаалах үйл ажиллагааг үргэлжлүүлж болно.

**Химиин зэвсэг үйлдвэрлэх байгууламжийг устгахаас өмнөх техникийн засвар арчилгааг хангах**

15. Оролцогч улс нь химиин зэвсэг үйлдвэрлэх байгууламжид техникийн ердийн засвар арчилгааг хангах, түүний дотор харагдах орчны хянан шалгалт, урьдчилан сэргийлэх засвар арчилгаа, урсгал засвар хийх үйл ажиллагааг зөвхөн аюулгүй байдлын үүднээс явуулж болно.

16. Засвар арчилгааны төлөвлөгдсөн бүх үйл ажиллагааг устгалын ерөнхий буюу дэлгэрэнгүй төлөвлөгөөнд тусгана. Засвар арчилгааны үйл ажиллагаанд дараах зүйл багтахгүй:

- (а) технологийн аливаа тоног төхөөрөмжийг солих;
- (б) химиин технологийн тоног төхөөрөмжийн шинж чанарыг өөрчлөх;
- (с) аливаа төрлийн химиин бодис үйлдвэрлэх.

17. Засвар үйлчилгээний бүх үйл ажиллагааг Техникийн нарийн бичгийн дарга нарын газар хянана.

**Химиин зэвсэг үйлдвэрлэх байгууламжийг химиин зэвсэг устгах байгууламж болгон түр хугацаагаар хувиргах зарчим, арга**

18. Химиин зэвсэг үйлдвэрлэх байгууламжийг химиин зэвсэг устгах байгууламж болгон түр хугацаагаар хувиргахтай холбоотой арга хэмжээ нь түр хугацаагаар хувиргасан байгууламжид үйлчлэх горим нь химиин зэвсэг үйлдвэрлэх хувиргаагүй байгууламжид үйлчлэх горимын нэгэн адил чанд байх явдлыг хангана.

19. Энэхүү конвенц хүчин төгөлдөр болохоос өмнө химиин зэвсэг устгах байгууламж болгон түр хугацаагаар хувиргасан химиин зэвсэг үйлдвэрлэх байгууламжийг химиин зэвсэг үйлдвэрлэх байгууламжийн ангиллын дор мэдүүлнэ.

Эдгээр байгууламжид тухайн байгууламжийн талаархи мэдээллийн үнэн зөвийг батлахаар хянан шалгач нар анхлан очно. Байгууламжийг химиин зэвсэг дахин үйлдвэрлэх байгууламжийн хувьд ажиллах боломжгүй болгохуйц байдлаар эдгээр байгууламжийг хувиргах ажиллагааг явуулсныг нягтлан шалгах шаардлагатай бөгөөд ийм нягтлан шалгалт нь конвенц хүчин төгөлдөр болсноос хойш 90 хоногийн дотор үйл ажиллагаа явуулах боломжгүй болох байгууламжид чиглэсэн арга хэмжээний хүрээнд хэрэгжинэ.

20. Химиин зэвсэг үйлдвэрлэх байгууламжийг хувиргах гэж буй оролцогч улс нь энэхүү конвенц түүний хувьд хүчин төгөлдөр болсноос хойш 30 хоногийн дотор, эсхүл түр хугацаагаар хувиргах тухай шийдвэр гарснаас хойш 30 хоногийн дотор

байгууламжийг хувиргах тухай ерөнхий төлөвлөгөө, дараа нь жилийн төлөвлөгөөгөө Техникийн нарийн бичгийн дарга нарын газарт өргөн барина.

21. Хэрэв оролцогч улс нь энэхүү конвенц түүний хувьд хүчин төгөлдөр болсны дараа хаагдсан химийн зэвсэг үйлдвэрлэх нэмэлт байгууламжийг химийн зэвсэг устгах байгууламж болгон хувиргах хэрэгтэй болбол энэ талаар Техникийн нарийн бичгийн дарга нарын газарт хувиргахаас 150-иас доошгүй хоногийн өмнө мэдээлнэ. Техникийн нарийн бичгийн дарга нарын газар нь байгууламжийг хувиргасны дараа химийн зэвсэг үйлдвэрлэх боломжгүй болгоход чиглэсэн шаардлагатай арга хэмжээг авах явдлыг оролцогч улсын хамт хангана.

22. Химийн зэвсэг устгахаар хувиргасан байгууламж нь химийн зэвсгийн үйлдвэрлэлийг сэргээх талаар хаагдсан бөгөөд засвар үйлчилгээ хийгдэж буй химийн зэвсэг үйлдвэрлэх байгууламжаас илүүгүй боломжтой байна. Үйл ажиллагааг нь сэргээхэд хаагдсан бөгөөд засвар үйлчилгээ хийгдэж буй химийн зэвсэг үйлдвэрлэх байгууламжид зарцуулахаас доошгүй цаг шаардана.

23. Химийн зэвсэг үйлдвэрлэх хувиргасан байгууламжийг энэхүү конвенц хүчин төгөлдөр болсноос хойш 10 жилийн дотор устгана.

24. Химийн зэвсэг үйлдвэрлэх аливаа байгууламжийг хувиргах аливаа арга хэмжээ нь байгууламж бүрт тусгай байх бөгөөд байгууламж бүрийн онцлог шинжээс шалтгаална.

25. Химийн зэвсэг үйлдвэрлэх байгууламжийг химийн зэвсэг устгах байгууламж болгон хувиргах зорилгоор хэрэгжүүлэх цогц арга хэмжээ нь энэхүү конвенц тухайн оролцогч улсын хувьд хүчин төгөлдөр болсноос хойш 90 хоногийн дотор хэрэгжүүлэх химийн зэвсэг үйлдвэрлэх бусад байгууламжийн үйл ажиллагааг зогсооход чиглэсэн цогц арга хэмжээнээс бага байж болохгүй.

**Химийн зэвсэг үйлдвэрлэх байгууламжийг устгахад хамаарах зарчим, арга**

26. Оролцогч улс нь химийн зэвсэг үйлдвэрлэх байгууламжийн тодорхойлолтод хамаарах тоног төхөөрөмж, барилгыг дараахь байдлаар устгана:

- (а) бүх төрлийн тусгай тоног төхөөрөмж болон ердийн тоног төхөөрөмжийг биечлэн устгана;
- (б) бүх төрлийн тусгай барилга болон ердийн барилгыг биечлэн устгана.

27. Оролцогч улс нь химийн цэнэглээгүй байлдааны хэрэгсэл, түүнчлэн химийн зэвсгийг ажиллуулах тоног төхөөрөмж үйлдвэрлэх байгууламжийг дараахь байдлаар устгана:

(а) химийн байлдааны хэрэгсэл, химийн зэвсгийг ажиллуулахтай шууд холбоотойгоор ашиглахаар тусгайлан бүтээгдсэн тоног төхөөрөмжийн химийн бус эд ангийг үйлдвэрлэхэд гагцхүү ашиглагдаж буй байгууламжийг мэдүүлж, устгана. Устгах ажиллагаа болон түүний нягтлан шалгалтыг химийн зэвсэг үйлдвэрлэх байгууламжийг устгах асуудлыг зохицуулсан 5 дугаар зүйл болон энэхүү хавсралтын энэ хэсгийн заалтуудын дагуу явуулна;

(б) химийн байлдааны хэрэгслийн химийн бус эд ангийг үйлдвэрлэхэд гагцхүү зориулсан буюу ашиглагдаж буй бүх тоног төхөөрөмжийг биечлэн устгана. Тусгайлан

бүтээгдсэн цутгуур, металл бүрэлдүүлэгч хэв зэрэг тоног төхөөрөмжийг устгахаар тусгай байршилд авч ирж болно.

(c) үйлдвэрлэлийн ийм үйл ажиллагаанд ашиглагдаж буй бүх барилга, ердийн тоног төхөөрөмжийг устгана, эсхүл шаардлагатай бол 9 дүгээр зүйлд заасны дагуу зөвлөлдөөн, хянан шалгалт хийх замаар баталж энэхүү конвенцоор хориглоогүй зорилгоор хувиргана.

(d) Устгах, эсхүл хувиргах ажиллагаа явагдаж байсан ч энэхүү конвенцоор хориглоогүй үйл ажиллагаа үргэлжилж болно.

#### Устгах дараалал

28. Химиин зэвсэг үйлдвэрлэх байгууламжийг устгах дараалал нь 1 дүгээр зүйл болон энэхүү конвенцийн бусад зүйлд заасан үүрэг, түүний дотор газар дээр нь тогтмол нягтлан шалгалт хийхтэй холбоотой үүрэгт үндэслэнэ. Энэ нь устгал явуулах үед аюулгүй байдлыг багасгахгүй байх талаархи оролцогч улсын ашиг сонирхол; устгалын эхний шатанд итгэлцлийг бэхжүүлэх; химиин зэвсэг үйлдвэрлэх байгууламжийг устгах явцад аажмаар туршлага хуримтлуулах; байгууламжийн бодит шинж байдал болон түүнийг устгах талаар сонгосон аргаас хамаарахгүйгээр хэрэглэх асуудлыг харгалзана. Устгах дараалал нь тэнцвэржүүлэх зарчимд тулгуурлана.

29. Устгал явуулах үе бүрт оролцогч улс химиин зэвсэг үйлдвэрлэх аль байгууламжийг устгахаа тодорхойлох бөгөөд устгалын үе бүрийн эцэст 30 болон 31 дэх хэсэгт зааснаас илүүгүй зүйл үлдэхээр устгалыг хийнэ. Оролцогч улс нь өөрийн байгууламжийг илүү хурдан устгахыг хориглохгүй.

30. I жагсаалтад орсон химиин бодисыг үйлдвэрлэдэг химиин зэвсэг үйлдвэрлэх байгууламжид дараахь заалтыг хэрэглэнэ:

(a) оролцогч улс нь тухайн байгууламжийн устгалыг энэхүү конвенц түүний хувьд хүчин төгөлдөр болсноос хойш нэг жилийн дотор эхлэх бөгөөд энэхүү конвенц хүчин төгөлдөр болсноос хойш 10 жилийн дотор дуусгана. Энэхүү конвенц хүчин төгөлдөр болоход гишүүн байсан улсын хувьд энэ бүх хугацаа нь устгалын гурван тусадаа үед, тухайлбал 2-5 жил, 6-8 жил болон 9-10 жилд хуваагдана. Энэхүү конвенц хүчин төгөлдөр болсны дараа гишүүн болсон улсын хувьд устгалын хугацааг 28 болон 29 дэх хэсгийг харгалзан тохируулна;

(b) үйлдвэрлэх хүчин чадлыг тухайн байгууламжийн хувьд харьцуулах хүчин зүйл болгон хэрэглэнэ. Түүнийг химиин хоёрлосон зэвсэгт зориулагдсан журмыг харгалзан хордуулах бодисын тонноор илэрхийлнэ;

(c) үйлдвэрлэх хүчин чадлын талаар тохиролцсон зохих түвшинг энэхүү конвенц хүчин төгөлдөр болсноос хойшихи 8 дахь жилийн эцэст тогтооно. Холбогдох түвшингээс хэтэрсэн үйлдвэрлэх хүчин чадлыг устгалын эхний 2 үе шатны турш тэнцүү өсөх тоогоор устгана;

(d) өгөгдсөн хэмжээ бүхий хүчин чадлыг устгах шаардлага нь I жагсаалтад орсон байгууламжид нийлүүлэлт хийсэн, эсхүл тэнд үйлдвэрлэсэн I жагсаалтад орсон химиин бодисоор байлдааны хэрэгсэл буюу төхөөрөмжийг цэнэглэсэн химиин зэвсэг үйлдвэрлэх аливаа бусад байгууламжийг устгах шаардлагыг дагуулна;

(e) химийн зэвсэг устгах байгууламжид түр хугацаагаар хувирсан химийн зэвсэг үйлдвэрлэх байгууламж нь энэ хэсгийн заалтын дагуу хүчин чадлыг устгах үүрэгт хамаарсан хэвээр байна.

31. Оролцогч улс нь 30 дахь хэсэгт хамрагдаагүй химийн зэвсэг үйлдвэрлэх байгууламжийн устгалыг энэхүү конвенц түүний хувьд хүчин төгөлдөр болсноос хойш нэг жилийн дотор эхлэх бөгөөд энэхүү конвенц хүчин төгөлдөр болсноос хойш таван жилийн дотор дуусгана.

**Устгах дэлгэрэнгүй төлөвлөгөө**

32. Химийн зэвсэг үйлдвэрлэх байгууламжийг устгахаас 180-аас доошгүй хоногийн өмнө оролцогч улс *inter alia* дараах зүйлийн талаар байгууламжийг хувиргах дэлгэрэнгүй төлөвлөгөө, түүний дотор 33 дахь хэсэгт дурдсан устгалыг нягтлан шалгах талаар санал болгож буй арга хэмжээг тусгасан дэлгэрэнгүй төлөвлөгөөг Техникийн нарийн бичгийн дарга нарын газарт өгнө.

(a) устгах байгууламжид хянан шалгагч нарыг байлгах хугацаа;

(b) мэдүүлсэн эд хөрөнгийн жагсаалтын зүйл бүрт хэрэглэгдэх арга хэмжээг нягтлан шалгах журам.

33. Химийн зэвсэг үйлдвэрлэх байгууламж бүрийг устгах дэлгэрэнгүй төлөвлөгөөнд дараах зүйлийг тусгана:

(a) устгах явцын дэлгэрэнгүй хуваарь;

(b) байгууламжийн бүтцийн зураг;

(c) технологийн урсгалын бүдүүвч зүраг;

(d) устгах тоног төхөөрөмж, барилга болон бусад зүйлийн дансалсан дэлгэрэнгүй жагсаалт;

(e) эд хөрөнгийн жагсаалтын зүйл бүрт хэрэглэх арга хэмжээ;

(f) нягтлан шалгах талаар санал болгож буй арга хэмжээ;

(g) байгууламжийг устгах явцад мөрдөх аюулгүй байдлын арга хэмжээ;

(h) хянан шалгагч нарыг хангах ажлын болон амьдрах нөхцөл.

34. Хэрэв оролцогч улс химийн зэвсэг үйлдвэрлэх байгууламжийг химийн зэвсэг устгах байгууламж болгон түр хугацаагаар хувиргах гэж буй бол аливаа хувиргах үйл ажиллагаа явуулахаас өмнө 150-иас доошгүй хоногийн өмнө Техникийн нарийн бичгийн дарга нарын газарт мэдэгдэнэ. Мэдэгдэлд:

(a) байгууламжийн нэр, хаяг, байршилыг заана;

(b) химийн зэвсгийг устгахад хамарагдах бүх бүтэц, газрын талбайн бүдүүвч зургийг гарган өгч, мөн химийн зэвсэг үйлдвэрлэх байгууламжийн түр хугацаагаар хувиргах бүх бүтцийг тогтооно;

(с) устгавал зохих химиин зэвсгийн төрөл, түүнчлэн химиин цэнэгийн төрөл, тоо хэмжээг заана;

(д) устгах аргыг заана;

(е) химиин зэвсгийг устгах зорилгоор үйлдвэрлэлийн үйл явц болон тусгай тоног төхөөрөмжийн аль хэсгийг хувиргахыг заасан технологийн урсгалын бүдүүвч зургийг гаргаж өгнө;

(ф) хувиргах явцад хөндөгдөж болох лац, хянан шалгалтын тоног төхөөрөмжийг холбогдох тохиолдолд заана;

(г) дараахь хугацааг тогтоосон хуваарийг гаргаж өгнө: төсөл боловсруулах, байгууламжийг түр хугацаагаар хувиргах, тоног төхөөрөмж суурилуулах, тоног төхөөрөмжийг шалгах, устгах ажиллагаа болон хаалтад зориулсан хугацаа.

35. Химиин зэвсгийг устгах зорилгоор түр хугацаагаар хувиргасан байгууламжийг устгахтай холбогдуулан мэдээллийг 32 болон 33 дахь хэсэгт нийцүүлэн гаргаж өгнө.

#### Дэлгэрэнгүй төлөвлөгөөг хянан үзэх

36. Техникийн нарийн бичгийн дарга нарын газар нь оролцогч улсын санал болгосон устгалын дэлгэрэнгүй төлөвлөгөө болон нягтлан шалгалтын арга хэмжээнд үндэслэн оролцогч улстай нягт зөвлөлдөж байгууламжийн устгалыг нягтлан шалгах төлөвлөгөөг бэлтгэнэ. Техникийн нарийн бичгийн дарга нарын газар болон оролцогч улсын хооронд холбогдох арга хэмжээний талаар үүссэн аливаа саналын зөрүүг зөвлөлдөх замаар шийдвэрлэнэ. Шийдвэрлэж чадаагүй аливаа асуудлыг энэхүү конвенцийг бүрэн хэрэгжүүлэхийг хөнгөвчлөн дэмжих үүднээс зохих арга хэмжээ авахуулахаар Гүйцэтгэх зөвлөлд уламжилна.

37. 5 дугаар зүйл болон энэ хэсгийн заалтын биелэлтийг хангахын тулд Гүйцэтгэх зөвлөл болон оролцогч улс устгал болон нягтлан шалгалт явуулах нэгтгэсэн төлөвлөгөөг тохиролцно. Энэ тохиролцоог устгал эхлэхээр төлөвлөсөн хугацаанаас 60-аас доошгүй хоногийн өмнө дуусгах нь зүйтэй.

38. Гүйцэтгэх зөвлөлийн гишүүн бүр устгал болон нягтлан шалгалт явуулах нэгтгэсэн төлөвлөгөөний зүй зохистой байдлын талаархи аливаа асуудлаар Техникийн нарийн бичгийн дарга нарын газартай зөвлөлдөж болно. Гүйцэтгэх зөвлөлийн аливаа гишүүний зүгээс татгалзал гараагүй бол төлөвлөгөөг хэрэгжүүлж эхлэнэ.

39. Аливаа бэрхшээл гарсан бол Гүйцэтгэх зөвлөл тэдгээрийг зохицуулан шийдвэрлэхээр оролцогч улстай зөвлөлдөнө. Хэрэв аливаа бэрхшээл нь шийдвэрлэгдээгүй үлдвэл тэдгээрийг Бага хуралд уламжилна. Устгах аргын талаархи аливаа саналын зөрүүг шийдвэрлэх нь устгах төлөвлөгөөний хүлээж авах боломжтой бусад хэсгийг хэрэгжүүлэхийг saatuulж болохгүй.

40. Хэрэв нягтлан шалгалтын асуудлаар Гүйцэтгэх зөвлөлтэй тохиролцоонд хүрч чадаагүй эсхүл нягтлан шалгалтын батлагдсан төлөвлөгөөг хэрэгжүүлэх боломжгүй бол устгалын нягтлан шалгалтыг газар дээр нь байрлуулсан багаж хэрэгслээр байнга ажиглан шинжих болон хянан шалгагч нарыг байлцуулах замаар хэрэгжүүлнэ.

41. Устгал болон нягтлан шалгалтыг тохиролцсон төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлнэ. Нягтлан шалгалт нь устгах үйл явцад зохисгүйгээр саад учруулахгүй бөгөөд устгалыг гэрчлэх хянан шалгагч нарыг газар дээр нь байлцуулах замаар нягтлан шалгалтыг хэрэгжүүлнэ.

42. Хэрэв нягтлан шалгалтын болон устгалын шаардлагатай арга хэмжээг төлөвлөсөн ёсоор аваагүй бол энэ тухай оролцогч бүх улсад мэдээлнэ.

### **C. Нягтлан шалгалт**

Химиин зэвсэг үйлдвэрлэх байгууламжийн мэдүүлгийг газар дээр нь хянан шалгах замаар нягтлан шалгах

43. Техникийн нарийн бичгийн дарга нарын газар нь энэхүү конвенц оролцогч улсын хувьд хүчин төгөлдөр болсноос хойш 90 болон 120 хоногийн хоорондын хугацаанд химиийн зэвсэг үйлдвэрлэх байгууламж бүрт анхны хянан шалгалт явуулна.

44. Анхны хянан шалгалт нь дараахь зорилготой байна:

(а) химиин зэвсэг үйлдвэрлэхийг зогсоосон бөгөөд байгууламжийг энэхүү конвенцид нийцүүлэн ашиглалтаас хассаныг нотлох;

(б) байгууламжид химиин зэвсэг үйлдвэрлэхийг зогсоохоор авсан арга хэмжээтэй танилцахыг Техникийн нарийн бичгийн дарга нарын газарт зөвшөөрөх;

(с) түр хугацаагаар лацдахыг хянан шалгагч нарт зөвшөөрөх;

(д) барилгын эд хөрөнгийн болон тусгай тоног төхөөрөмжийн жагсаалтыг батлахыг хянан шалгагч нарт зөвшөөрөх;

(е) байгууламжид явуулах хянан шалгалтын үйл ажиллагааг төлөвлөхөд, түүний дотор зөвшөөрөлгүй хөндсөнийг илэрхийлж буй лац болон тухайн байгууламжийн хувьд байгууламжийн тухай дэлгэрэнгүй хэлэлцээрийн дагуу суурилуулах бусад тохиролцсон тоног төхөөрөмж хэрэглэхийг төлөвлөхөд шаардлагатай мэдээллийг олж авах;

(f) байгууламжид хянан шалгалт хийх журмын тухай дэлгэрэнгүй хэлэлцээрийн талаар урьдчилсан хэлэлцүүлэг явуулах.

45. Химиин зэвсэг үйлдвэрлэх байгууламж бүр дэх мэдүүлсэн эд зүйлсийг үнэн зөв данслахыг хөнгөвчлөн дэмжих зорилгоор хянан шалгагч нар тохиролцсон лац, тэмдэглэгээ, эсхүл эд хөрөнгийн хяналтын бусад журмыг хэрэглэнэ.

46. Хянан шалгагч нар химиин зэвсэг үйлдвэрлэхийг сэргээсэн, эсхүл мэдүүлсэн аливаа эд зүйлийг зайлуулсныг илрүүлэх шаардлагатай байж болох тохиролцсон төхөөрөмжийг суурилуулна. Тэд хянан шалгуулж буй оролцогч улсын хэрэгжүүлж буй хаах арга хэмжээнд саад болохгүй байхын тулд шаардлагатай арга хэмжээ авна. Хянан шалгагч нар төхөөрөмжид засвар арчилгаа хийх, бүрэн бүтэн байдлыг нягтлан шалгахаар эргэж ирж болно.

47. Хэрэв анхны хянан шалгалтын үндсэн дээр Ерөнхий захирал байгууламжийг энэхүү конвенцид нийцүүлэн ашиглалтаас хасахад нэмэлт арга хэмжээ авах шаардлагатай гэж үзвэл хянан шалгуулж буй оролцогч улсаас уг конвенц түүний хувьд

хүчин төгөлдөр болсноос хойш 180 хоногийн дотор дээрх арга хэмжээг хэрэгжүүлэхийг энэхүү конвенцийг оролцогч улсын хувьд хүчин төгөлдөр болсноос хойш 135 хоногийн дотор хүсэж болно. Хянан шалгуулж буй оролцогч улс хүсэлтийг өөрийн үзэмжээр шийдвэрлэнэ. Хэрэв хянан шалгуулж буй оролцогч улс хүсэлтийг биелүүлэхгүй бол Ерөнхий захирал болон уг улс энэ асуудлыг шийдвэрлэхээр зөвлөлдөнө.

**Химиин зэвсэг үйлдвэрлэх байгууламжид тогтмол нягтлан шалгалт хийх болон тэдгээрийн үйл ажиллагааг зогсоох**

48. Химиин зэвсэг үйлдвэрлэх байгууламжид тогтмол хийх нягтлан шалгалтын зорилго нь химиин зэвсэг үйлдвэрлэхийг сэргээсэн, эсхүл мэдүүлсэн аливаа эд зүйлийг зайлуулсныг уг байгууламжид илрүүлэх явдлыг хангахад оршино.

49. Химиин зэвсэг үйлдвэрлэх байгууламж бүрт зориулсан байгууламжийн тухай дэлгэрэнгүй хэлэлцээрт дараахь зүйлийг заана:

(a) газар дээр нь хийх хянан шалгалтын дэлгэрэнгүй журам. Үүнд дараахь зүйлийг багтааж болно:

(i) нүдээр хийх үзлэг;

(ii) лац, бусад тохиролцсон төхөөрөмжийг шалгах буюу засвар үйлчилгээ хийх;

(iii) дээж авах, шинжлэх;

(b) байгууламжийг нууцаар дахин ашиглах явдлаас урьдчилан сэргийлэхийн тулд зөвшөөрөлгүй хөндсөнийг илрхийлж буй лац болон бусад зөвшөөрөгдсөн тоног төхөөрөмжийг ашиглах журам. Үүнд дараахь зүйлийг заана:

(i) суурилуулах төрөл, байрлал, журам;

(ii) тийм лац болон тоног төхөөрөмжид хийх засвар арчилгаа;

(c) бусад тохиролцсон арга хэмжээ;

50. Тухайн байгууламжид хянан шалгалт хийх арга хэмжээний тухай дэлгэрэнгүй хэлэлцээрт заасан лац болон бусад батлагдсан тоног төхөөрөмжийг энэхүү конвенц оролцогч улсын хувьд хүчин төгөлдөр болноос хойш 240 хоногийн дотор байрлуулна. Тийм лац болон тоног төхөөрөмж суурилуулах зорилгоор химиин зэвсэг үйлдвэрлэх байгууламж бүрт очихыг хянан шалгагч нарт зөвшөөрнө.

51. Химиин зэвсэг үйлдвэрлэх байгууламж бүрт хуанлийн жил бүрийн туршид дөрөв хүртэл удаа хянан шалгалт хийхийг Техникийн нарийн бичгийн дарга нарын газарт зөвшөөрнө.

52. Ерөнхий захирал химиин зэвсэг үйлдвэрлэх байгууламжид хянан шалгалт хийх, эсхүл тэнд очих шийдвэрийнхээ тухай хянан шалгах баг байгууламжид тогтмол хянан шалгалт хийх, эсхүл тэнд очихоор төлөвлөсөн хугацаанаас 48 цагийн өмнө хянан шалгуулж буй оролцогч улсад мэдэгдэнэ. Яаралтай асуудлыг шийдвэрлэхээр хянан шалгалт хийх, эсхүл очих тохиолдолд энэ хугацааг богиносгож болно. Ерөнхий захирал хянан шалгах, эсхүл очих зорилгыг заана.

53. Хянан шалгагч нар нь химийн зэвсэг үйлдвэрлэх байгууламжийн бүх хэсэгт байгууламжийн хэлэлцээрт нийцүүлэн саадгүй нэвтрэх эрхтэй. Мэдүүлсэн эд хөрөнгийн жагсаалтаас хянан шалгавал зохих эд зүйлийг хянан шалгагч нар сонгоно.

54. Газар дээр нь тогтмол хийх хянан шалгалтын давтамжийг тодорхойлох удирдамжийг 8 дугаар зүйлийн 21 дэх хэсгийн (i) дэд хэсгийн дагуу Бага хурал хэлэлцэж, батална. Хянан шалгалт хийвэл зохих үйлдвэрлэлийн тодорхой байгууламжийг Техникийн нарийн бичгийн дарга нарын газар байгууламжийг хянан шалгах хугацааг яг тодорхой урьдчилан мэдэх боломжгүй байхаар сонгоно.

**Химийн зэвсэг үйлдвэрлэх байгууламжийн устгалыг нягтлан шалгах**

55. Химийн зэвсэг үйлдвэрлэх байгууламжийн устгалыг тогтмол нягтлан шалгах зорилго нь байгууламжийг энэхүү конвенцийн дагуу хүлээсэн үүрэгт нийцүүлэн устгасан, түүнчлэн мэдүүлсэн эд хөрөнгийн жагсаалтын эд зүйл бүрийг устгал хийх тохиролцсон дэлгэрэнгүй төлөвлөгөөнд нийцүүлэн устгасныг нотлоход оршино.

56. Мэдүүлсэн эд хөрөнгийн жагсаалтын бүх эд зүйлийг устгасны дараа Техникийн нарийн бичгийн дарга нарын газар нь энэ талаархи оролцогч улсын мэдүүлгийг батална. Ийнхүү баталсны дараа Техникийн нарийн бичгийн дарга нарын газар нь химийн зэвсэг үйлдвэрлэх байгууламжийн устгалын тогтмол нягтлан шалгалтыг дуусгавар болгож, хянан шалгагч нарын суурилуулсан бүх төхөөрөмж, ажиглан шинжих багаж хэрэгслийг даруй зайлцуулна.

57. Ийнхүү баталсны дараа оролцогч улс байгууламжийг устгасан тухай мэдүүлэг хийнэ.

**Химийн зэвсэг үйлдвэрлэх байгууламжийг химийн зэвсэг устгах байгууламж болгон түр хугацаагаар хувиргасныг нягтлан шалгах**

58. Үйлдвэрлэлийн байгууламжийг түр хугацаагаар хувиргах гэж буй тухай анхны мэдэгдлийг хүлээж авснаас хойш 90 хоногийн дотор хянан шалгагч нар түр хугацаагаар хийх гэж буй хувиргалттай танилцах болон хувиргах явцад шаардлагатай болох хянан шалгалтын боломжтой арга хэмжээний талаар судлахаар байгууламжид очих эрхтэй.

59. Ийнхүү очсоноос хойш 60 хоногийн дотор Техникийн нарийн бичгийн дарга нарын газар болон хянан шалгуулж буй оролцогч улс түр хугацаанд хувиргах үеийн хянан шалгалтын нэмэлт арга хэмжээг тусгасан шилжилтийн хэлэлцээр байгуулна. Шилжилтийн хэлэлцээрт хувиргах явцад химийн зэвсэг үйлдвэрлэхгүй байгаа тухай итгэл төрүүлэх хянан шалгалтын журмыг, түүний дотор лац, ажиглан шинжих тоног төхөөрөмж, хяналт шалгалт хэрэглэх талаар заана. Энэ хэлэлцээр нь түр хугацаагаар хувиргах үйл ажиллагааг эхлэхээс байгууламжийг химийн зэвсэг устгах байгууламж болгон ажиллуулж эхлэх хүчин төгөлдөр хэвээр байна.

60. Шалгуулж буй оролцогч улс нь шилжилтийн хэлэлцээрийг байгуулах хүртэл байгууламжийн аливаа хэсгийг зайлцуулах буюу хувиргахгүй, эсхүл түүнчлэн энэхүү конвенцийн дагуу суурилуулсан байж болох аливаа лац буюу хянан шалгалтын бусад тохиролцсон тоног төхөөрөмжийг зайлцуулах буюу хувиргахгүй.

61. Байгууламж нь нэгэнт түүнийг химийн зэвсэг устгах байгууламжийн хувьд ажиллуулж эхэлсэн бол энэхүү хавсралтын химийн зэвсэг устгах байгууламжид

хэрэглэгдэх IV хэсгийн А ангид хамрагдана. Ажиллуулж эхлэхээс өмнөх үед хамаарах тохиролцоог шилжилтийн хэлэлцээрээр зохицуулна.

62. Устгах ажиллагааны явцад хянан шалгагч нар түр хугацаагаар хувиргасан химийн зэвсэг үйлдвэрлэх байгууламжийн бүх хэсэгт, түүний дотор химийн зэвсэг устгахад шууд хамааралгүй хэсэгт нэвтрэх эрхтэй.

63. Байгууламжийг химийн зэвсэг устгах зорилгоор түр хугацаагаар хувиргах ажиллагааг эхлэхээс өмнө болон түүнийг химийн зэвсэг устгах байгууламжийн хувьд ажиллууллахаа больсны дараа уг байгууламж нь химийн зэвсэг үйлдвэрлэх байгууламжид хэрэглэгдэх энэ хэсгийн заалтуудад хамрагдана.

**D. Химийн зэвсэг үйлдвэрлэх байгууламжийг энэхүү конвенцоор хориглоогүй зорилгоор хувиргах**

**Хувиргах хүсэлт гаргах журам**

64. Химийн зэвсэг үйлдвэрлэх байгууламжийг энэхүү конвенцоор хориглоогүй зорилгоор ашиглах хүсэлтийг оролцогч улс энэхүү конвенц түүний хувьд хүчин төгөлдөр болохоос өмнө тийм зорилгоор ашиглаж байсан, эсхүл тийм зорилгоор ашиглахаар төлөвлөж буй аливаа байгууламжийн хувьд гаргаж болно.

65. Энэхүү конвенц оролцогч улсын хувьд хүчин төгөлдөр болоход энэхүү конвенцоор хориглоогүй зорилгоор ашиглаж байгаа химийн зэвсэг үйлдвэрлэх байгууламжийн хувьд хүсэлтийг энэхүү конвенц тухайн оролцогч улсын хувьд хүчин төгөлдөр болсноос хойш 30 хоногийн дотор Ерөнхий захиралд өгнө. Хүсэлтэд 1 дэх хэсгийн (h)( iii) дэд хэсэгт нийцүүлэн өгсөн тоо баримтаас гадна дараах мэдээллийг тусгана:

- (a) хүсэлт гаргах болсон дэлгэрэнгүй үндэслэл;
- (b) дараахь зүйлийг тусгасан байгууламжийг хувиргах ерөнхий төлөвлөгөө:
  - (i) байгууламжид явуулах үйл ажиллагааны шинж чанар;
  - (ii) хэрэв төлөвлөж буй үйл ажиллагаа нь химийн бодисыг үйлдвэрлэх, боловсруулах, эсхүл хэрэглэхтэй холбоотой бол: химийн бодис бүрийн нэр, байгууламжийн бүдүүвч зураг, жилд үйлдвэрлэх, боловсруулах, эсхүл хэрэглэхээр төлөвлөсөн тоо хэмжээ;
  - (iii) аль барилга байгууламжийг ашиглахаар санал болгож буй болон хэрэв өөрчлөлт хийхээр санал болгож буй бол ямар өөрчлөлт санал болгож буй тухай;
  - (iv) аль барилга байгууламжийг устгасан эсхүл устгахаар төлөвлөсөн тухай болон устгах төлөвлөгөө;
  - (v) байгууламжид ямар тоног төхөөрөмж ашиглах тухай;
  - (vi) ямар тоног төхөөрөмжийг зайлцуулсан, устгасан эсхүл ямар тоног төхөөрөмжийг устгахаар санал болгосон тухай болон устгах төлөвлөгөө;
  - (vii) холбогдох тохиолдолд, санал болгосон хувиргах хуваарь;

(viii) тухайн талбайд ажиллаж буй бусад байгууламж бүрийн үйл ажиллагааны шинж чанар;

(c) (b) дэд хэсэгт заасан арга хэмжээ, түүнчлэн оролцогч улсын санал болгосон аливаа бусад арга хэмжээ нь байгууламж дээр химиин зэвсэг үйлдвэрлэх нөөц хүчин чадлыг бий болгохгүй байх явдлыг яаж хангах тухай дэлгэрэнгүй тайлбар.

66. Энэхүү конвенц оролцогч улсын хувьд хүчин төгөлдөр болоход энэхүү конвенцоор хориглоогүй зорилгоор ашиглахгүй байгаа химиин зэвсэг үйлдвэрлэх байгууламжийн хувьд хүсэлтийг хувирах тухай шийдвэр гаргаснаас хойш 30 хоногийн дотор, гэхдээ ямар ч тохиолдолд энэхүү конвенц оролцогч улсын хувьд хүчин төгөлдөр болсноос хойш дөрвөн жилийн дотор Ерөнхий захирадл өгнө. Хүсэлтэд дараах мэдээллийг тусгана:

(a) хүсэлт гаргах болсон дэлгэрэнгүй үндэслэл, түүний дотор эдийн засгийн хэрэгцээг тусгасан үндэслэл;

(b) дараахь зүйлийг тусгасан байгууламжийг хувирах өрөнхий төлөвлөгөө:

(i) байгууламжид явуулах үйл ажиллагааны шинж чанар;

(ii) хэрэв төлөвлөж буй үйл ажиллагаа нь химиин бодисыг үйлдвэрлэх, боловсруулах, эсхүл хэрэглэхтэй холбоотой бол: химиин бодис бүрийн нэр, байгууламжийн бүдүүвч зураг, жилд үйлдвэрлэх, боловсруулах, эсхүл хэрэглэхээр төлөвлөсөн тоо хэмжээ;

(iii) аль барилга байгууламжийг үлдээхээр санал болгож буй болон хэрэв өөрчлөлт хийхээр санал болгож буй бол ямар өөрчлөлт санал болгож буй тухай;

(iv) аль барилга байгууламжийг устгасан, эсхүл устгахаар төлөвлөсөн тухай болон устгах төлөвлөгөө;

(v) байгууламжид ямар тоног төхөөрөмж ашиглах тухай;

(vi) ямар тоног төхөөрөмжийг зайлцуулах, устгахаар санал болгосон тухай болон устгах төлөвлөгөө;

(vii) санал болгосон хувирах хуваарь;

(viii) тухайн талбайд ажиллаж буй бусад байгууламж бүрийн үйл ажиллагааны шинж чанар;

(c) (b) дэд хэсэгт заасан арга хэмжээ, түүнчлэн оролцогч улсын санал болгосон аливаа бусад арга хэмжээ нь байгууламж дээр химиин зэвсэг үйлдвэрлэх нөөц хүчин чадлыг бий болгохгүй байх явдлыг яаж хангах тухай дэлгэрэнгүй тайлбар.

67. Оролцогч улс хүсэлтдээ итгэлийг бэхжүүлэхэд зохистой гэж үзэж буй аливаа бусад арга хэмжээг санал болгож болно.

#### Шийдвэр гаргахаас өмнөх үlldэл

68. Бага хурлын шийдвэр гаргахаас өмнө оролцогч улс энэхүү конвенц түүний хувьд хүчин төгөлдөр болохоос өмнө тийм зорилгоор ашиглаж байсан байгууламжийг

энэхүү конвенцоор хориглоогүй зорилгоор үргэлжлүүлэн ашиглаж болно, гэхдээ зөвхөн хэрэв оролцогч улс хүсэлтдээ аливаа тусгай тоног төхөөрөмж болон тусгай барилга ашиглахгүй байгаа бөгөөд 13 дахь хэсэгт заасан аргаар ашиглалтын бус байдалд шилжүүлснийг нотолвол тийнхүү ашиглаж болно.

69. Хэрэв хүсэлт гаргасан байгууламжийг энэхүү конвенц тухайн оролцогч улсын хувьд хүчин төгөлдөр болохоос өмнө энэхүү конвенцоор хориглоогүй зорилгоор ашиглаагүй, эсхүл 68 дахь хэсэгт заасан нотолгоо хийгдээгүй бол оролцогч улс 5 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу бүх үйл ажиллагаагаа нэн даруй зогсоон. Оролцогч улс энэхүү конвенц түүний хувьд хүчин төгөлдөр болсноос хойш 90 хоногийн дотор 13 дахь хэсэгт нийцүүлэн байгууламжийг хаана.

#### Хувиргах нөхцөлүүд

70. Химийн зэвсэг үйлдвэрлэх байгууламжийг энэхүү конвенцоор хориглоогүй зорилгоор хувиргах нөхцөл болгож байгууламж дээрх бүх тусгай тоног төхөөрөмжийг устгах ёстой бөгөөд уг байгууламжийг энэхүү конвенцоор хориглоогүй зорилгоор ашиглаж буй бусад барилга байгууламжаас ялгаж буй болон I жагсаалтад орсон химийн бодистой холбоогүй бүх тусгай шинж чанарыг арилгах ёстой.

71. Хувиргасан байгууламжийг дараах зорилгоор ашиглахгүй:

(а) I жагсаалтад орсон химийн бодис эсхүл 2 дугаар жагсаалтад орсон химийн бодисыг үйлдвэрлэх, боловсруулах эсхүл хэрэглэхтэй холбоотой аливаа үйл ажиллагаанд;

(б) гүйцэтгэх зөвлөл ихээхэн хортой химийн аливаа бодис, түүний дотор ихээхэн хортой органофосфорын химийн аливаа бодис үйлдвэрлэх, эсхүл ихээхэн хортой буюу муутган устгах өндөр чанар бүхий химийн бодистой ажиллахад тусгай тоног төхөөрөмж шаардагдаа аливаа бусад үйл ажиллагаа нь 8 дугаар зүйлийн 21 дэх хэсгийн (i) дэд хэсгийн дагуу Бага хурлаар хэлэлцэж батлавал зохих хортой байдлын үзүүлэлт, муутган устгах чанар болон холбогдох тохиолдолд техникийн бусад хүчин зүйлийг харгалзаж үзэхэд энэхүү конвенцийн зүйл, зорилгод аюул учруулахааргүй гэж шийдвэрлээгүй бол тийм үйлдвэрлэл болон үйл ажиллагаанд.

72. Химийн зэвсэг үйлдвэрлэх байгууламжийг хувиргах ажиллагааг энэхүү конвенц хүчин төгөлдөр болсноос хойш зургаан жилийн дотор явуулж дуусгана.

72bis. Хэрэв тухайн улс 72 дахь хэсэгт заасан хувиргах зургаан жилийн хугацааны дараа энэхүү конвенцийг соёрхон батлах, эсхүл түүнд нэгдэн орвол Гүйцэтгэх зөвлөл химийн зэвсэг үйлдвэрлэх байгууламжийг энэхүү конвенцоор хориглоогүй зорилгоор хувиргах хүсэлт гаргах эцсийн хугацааг дараагийн ээлжит хоёрдугаар чуулганаараа тогтооно. Тийм хүсэлтийг батлах тухай Бага хурлын шийдвэрт 75 дахь хэсгийн дагуу хувиргах ажиллагааг дуусгах хамгийн ойрын хамгийн боломжтой хугацааг тогтооно. Хувиргах ажиллагааг аль болох түргэн, гэхдээ ямар ч тохиолдолд конвенц тухайн оролцогч улсын хувьд хүчин төгөлдөр болсноос хойш зургаан жилийн дотор дуусгана. Энэ хэсэгт өөрчилснөөс бусад тохиолдолд энэхүү хавсралтын энэ хэсгийн D ангийн бүх заалтыг хэрэглэнэ.

#### Гүйцэтгэх зөвлөлийн болон Бага хурлын шийдвэр

73. Ерөнхий захирал хүсэлтийг хүлээн авснаас хойш 90 хоногийн дотор Техникийн нарийн бичгийн дарга нарын газар байгууламжийн анхны хянан

шалгалтыг хийнэ. Энэхүү хянан шалгалтын зорилго нь хүсэлтэд заасан мэдээллийн үнэн зөв эсэхийг тогтоох, хувиргах гэж буй байгууллагын техникийн шинж байдлын тухай мэдээллийг авах, байгууламжийг энэхүү конвенцоор хориглоогүй зорилгоор ашиглахыг зөвшөөрч болох нөхцөлийг дүгнэхэд оршино. Ерөнхий захирал байгууламжийг энэхүү конвенцоор хориглоогүй зорилгоор хувиргах ажлыг гүйцэтгэх болон хувиргасан байгууламж нь зөвхөн энэхүү конвенцоор хориглоогүй зорилгод ашиглагдах тухай итгэл төрүүлэхэд шаардлагатай арга хэмжээний талаархи зөвлөмжөө багтаасан илтгэлийг Гүйцэтгэх зөвлөл, Бага хурал, оролцогч бүх улсад шуурхай өгнө.

74. Хэрэв байгууламж нь энэхүү конвенц оролцогч улсын хувьд хүчин төгөлдөр болохоос өмнө энэхүү конвенцоор хориглоогүй зорилгоор ашиглагдаж байсан бөгөөд ашиглагдсан хэвээр байгаа боловч 68 дахь хэсэгт заасан нотлох шаардлагатай арга хэмжээ авагдаагүй бол Ерөнхий захирал энэ тухай Гүйцэтгэх зөвлөлд нэн даруй мэдээлнэ. Гүйцэтгэх зөвлөл шаардлагатай гэж үзсэн бусад арга хэмжээг хэрэгжүүлэхийг, *inter alia* байгууламжийг хаах, тусгай тоног төхөөрөмжийг зайлцуулах, барилга байгууламжийг өөрчлөхийг шаардаж болно. Гүйцэтгэх зөвлөл эдгээр арга хэмжээг хэрэгжүүлэх хугацааг тогтоож тэдгээрийг хангалттай хэрэгжүүлэх хүртэл хугацаагаар хүсэлтийг хэлэлцэхийг түдгэлзүүлнэ. Энэ хугацааг дууссан даруй уг арга хэмжээг хэрэгжүүлсэн эсэхийг тогтоохоор байгууламжид хянан шалгалт хийнэ. Хэрэв эдгээр арга хэмжээг хэрэгжүүлээгүй бол байгууламжийн бүх ажиллагааг бүрэн зогсоохыг тухайн оролцогч улсаас шаардана.

75. Бага хурал Гүйцэтгэх зөвлөмжийн дагуу Ерөнхий захирлын илтгэлийг хүлээж авснаас хойш аль болох түргэн илтгэл болон оролцогч улсуудын аливаа саналыг харгалзан хүсэлтийг батлах эсэх асуудлыг шийдвэрлэж, тийнхүү батлах нөхцөлийг тогтооно. Хэрэв аливаа оролцогч улс хүсэлтийг батлахыг болон холбогдох нөхцөлийг эсэргүүцвэл сонирхогч оролцогч улсууд харилцан хүлээж авахуйц шийдэлд хүрэх зорилгоор 90 хүртэл хоногийн хугацаагаар зөвлөлдөнө. Хүсэлт болон холбогдох нөхцөлийн тухай шийдвэрийг түүнд оруулахаар санал болгож буй аливаа өөрчлөлтийн хамт зөвлөлдөх хугацаа дууссанаас хойш зарчмын асуудлын хувьд аль болох түргэн гаргана.

76. Хэрэв хүсэлтийг батласан бол тийм шийдвэр гарснаас хойш 90 хоногийн дотор байгууламжийн тухай хэлэлцээрийг байгуулна. Байгууламжийн тухай хэлэлцээрт байгууламжийг хувиргах болон ашиглахыг зөвшөөрөх нөхцөлүүд, түүний дотор нягтлан шалгалтын арга хэмжээг тусгана. Байгууламжийн тухай хэлэлцээр байгуулагдааас өмнө байгууламжийг хувиргах ажлыг эхлэхгүй.

#### Хувиргах дэлгэрэнгүй төлөвлөгөө

77. Химийн зэвсэг үйлдвэрлэх байгууламжийг хувиргахаас 180-аас доошгүй хоногийн өмнө оролцогч улс *inter alia* дараах зүйлийн талаар байгууламжийг хувиргах дэлгэрэнгүй төлөвлөгөө, түүний дотор хувиргалтыг нягтлан шалгах талаар санал болгож буй арга хэмжээг тусгасан дэлгэрэнгүй төлөвлөгөөг Техникийн нарийн бичгийн дарга нарын газарт өгнө:

- (a) хувиргах байгууламжид хянан шалгагч нарыг байлгах хугацаа;
- (b) мэдүүлсэн эд хөрөнгийн жагсаалтын зүйл бүрт хэрэглэгдэх арга хэмжээг нягтлан шалгах журам.

78. Химийн зэвсэг үйлдвэрлэх байгууламж бүрийг хувиргах дэлгэрэнгүй төлөвлөгөөнд дараах зүйлийг тусгана:

- (a) хувиргах явцын дэлгэрэнгүй хуваарь;
- (b) байгууламжийг хувиргахын өмнөх болон дараахь бүтцийн зураг;
- (c) байгууламжийг хувиргахын өмнөх болон зохих тохиолдолд дараахь технологийн урсгалын бүдүүвч зураг;
- (d) устгах тоног төхөөрөмж, барилга байгууламж болон бусад зүйл, түүнчлэн өөрчлөх барилга байгууламжийн дансалсан дэлгэрэнгүй жагсаалт;
- (e) эд хөрөнгийн жагсаалтын зүйл бүрт хэрэглэх арга хэмжээ байгаа бол тэдгээр арга хэмжээ;
- (f) нягтлан шалгах талаар санал болгож буй арга хэмжээ;
- (g) байгууламжийг хувиргах явцад мөрдөх аюулгүй байдлын арга хэмжээ;
- (h) хянан шалгагч нарыг хангах ажлын болон амьдрах нөхцөл.

#### Дэлгэрэнгүй төлөвлөгөөг хянан үзэх

79. Техникийн нарийн бичгийн дарга нарын газар нь оролцогч улсын санал болгосон хувиргах дэлгэрэнгүй төлөвлөгөө болон нягтлан шалгах талаар санал болгож буй арга хэмжээ, түүнчлэн өмнөх хянан шалгалтын туршлагад үндэслэн оролцогч улстай нягт зөвлөлдөж байгууламжийн хувиргалыг нягтлан шалгах дэлгэрэнгүй төлөвлөгөөг бэлтгэнэ. Техникийн нарийн бичгийн дарга нарын газар болон оролцогч улсын хооронд холбогдох арга хэмжээний талаар үссэн аливаа саналын зөрүүг зөвлөлдөх замаар шийдвэрлэнэ. Энэхүү конвенцийг бүрэн хэрэгжүүлэхийг хангах үүднээс шийдвэрлэж чадаагүй аливаа асуудлыг зохих арга хэмжээ авахуулаар Гүйцэтгэх зөвлөлд уламжилна.

80. 5 дугаар зүйл болон энэ хэсгийн заалтын биелэлтийг хангахын тулд Гүйцэтгэх зөвлөл болон оролцогч улс хувиргал болон нягтлан шалгалт явуулах талаархи нэгтгэсэн төлөвлөгөөг хоорондоо тохиролцоно. Энэ тохиролцоог хувиргах ажиллагаа эхлэхээр төлөвлөсөн хугацаанаас 60-аас доошгүй хоногийн өмнө дуусгана.

81. Гүйцэтгэх зөвлөлийн гишүүн бүр хувиргал болон нягтлан шалгалт явуулах нэгтгэсэн төлөвлөгөөний зүй зохистой байдлын талаар аливаа асуудлаар Техникийн нарийн бичгийн дарга нарын газартай зөвлөлдөж болно. Гүйцэтгэх зөвлөлийн аливаа гишүүний зүгээс татгалзал гараагүй бол төлөвлөгөөг хэрэгжүүлж эхлэнэ.

82. Аливаа бэрхшээл гарсан бол Гүйцэтгэх зөвлөл тэдгээрийг зохицуулан шийдвэрлэхээр оролцогч улстай зөвлөлдөнө. Хэрэв аливаа бэрхшээл нь шийдвэрлэгдээгүй үлдвэл тэдгээрийг Бага хуралд уламжилна. Хувиргах аргын талаархи аливаа саналын зөрүүг шийдвэрлэх нь хувиргах төлөвлөгөөний хүлээж авах боломжтой бусад хэсгийг хэрэгжүүлэхийг saatuuulж болохгүй.

83. Хэрэв нягтлан шалгалтын асуудлаар Гүйцэтгэх зөвлөлтэй тохиролцоонд хүрч чадаагүй, эсхүл нягтлан шалгалтын батлагдсан төлөвлөгөөг хэрэгжүүлэх боломжгүй бол хувиргалын нягтлан шалгалтыг газар дээр нь байрлуулсан багаж хэрэгслээр тасралтгүй ажиглан шинжих болон хянан шалгагч нарыг байлцуулах замаар хэрэгжүүлнэ.

84. Хувиргал болон нягтлан шалгалтыг тохиролцсон төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлнэ. Нягтлан шалгалт нь хувиргах үйл явцад зохисгүйгээр саад учруулахгүй бөгөөд хувиргалыг гэрчлэх хянан шалгагч нарыг газар дээр нь байлцуулах замаар нягтлан шалгалтыг хэрэгжүүлнэ.

85. Хувиргах ажиллагаа дууссаныг Ерөнхий захирал нотолсны дараа 10 жилийн турш оролцогч улс байгууламжид хэдийд ч саадгүй нэвтрэх боломжийг хянан шалгагч нарт олгоно. Хянан шалгагч нар байгууламжийн бүх талбай, бүх үйл ажиллагаа, тоног төхөөрөмжийн бүх зүйлийг ажиглах эрхтэй. Хянан шалгагч нар байгууламж дээрх үйл ажиллагаа нь Гүйцэтгэх зөвлөл болон Бага хурлын энэ ангийн дагуу тогтоосон аливаа нөхцөлд нийцэж байгааг нягтлан шалгах эрхтэй. Хянан шалгагч нар энэхүү хавсралтын II хэсгийн Е ангийн заалтад нийцүүлэн байгууламжийн аль ч хэсгээс дээж авч, I жагсаалтад орсон химийн бодис, тэдгээрийн тогтмол дайвар болон задлах бүтээгдхүүн, түүнчлэн 2 дугаар жагсаалтад орсон химийн бодис байхгүй гэдгийг нягтлан шалгах, мөн байгууламж дээрх үйл ажиллагаа нь энэ ангийн дагуу Гүйцэтгэх зөвлөл болон Бага хурлаас химийн үйл ажиллагааны хувьд тогтоосон аливаа бусад нөхцөлд нийцэж байгааг нягтлан шалгах эрхтэй. Хянан шалгагч нар энэхүү хавсралтын X хэсгийн С ангид нийцүүлэн байгууламж байрлаж байгаа үйлдвэрийн талбайд удирдлаган дор нэвтрэх эрхтэй. Уг 10 жилийн турш оролцогч улс хувиргасан байгууламж дээрх үйл ажиллагааны талаар жил бүр илтгэнэ. 10 жилийн хугацаа дусмагц Гүйцэтгэх зөвлөл Техникийн нарийн бичгийн дарга нарын газрын зөвлөмжийг харгалзан цаашид авах нягтлан шалгалтын арга хэмжээний шинж чанарыг тодорхойлно.

86. Хувирсан байгууламжийг нягтлан шалгахтай холбоотой зардлыг 5 дугаар зүйлийн 19 дэх хэсэгт нийцүүлэн хуваарилна.

## VI ХЭСЭГ

### 6 ДУГААР ЗҮЙЛД НИЙЦҮҮЛСЭН ЭНЭХҮҮ КОНВЕНЦООР ХОРИГЛООГҮЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА

#### I ЖАГСААЛТАД ОРСОН ХИМИЙН БОДИС БОЛОН ТИЙМ ХИМИЙН БОДИСТ ХАМААРАХ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИД ЗОРИУЛСАН ГОРИМ

##### A. Нийтлэг заалт

1. Оролцогч улс I жагсаалтад орсон химийн бодисыг оролцогч улсын нутаг дэвсгэрээс гадна үйлдвэрлэх, олж авах, хадгалах буюу ашиглахгүй бөгөөд дээрх химийн бодисыг өөр оролцогч улсаас өөр нутаг дэвсгэрт шилжүүлэхгүй.

2. Оролцогч улс I жагсаалтад орсон химийн бодисыг доор дурдсанаас бусад тохиолдолд үйлдвэрлэх, олж авах, хадгалах, шилжүүлэх буюу ашиглахгүй:

(а) химийн бодисыг эрдэм шинжилгээ, анагаах ухаан, эм зүйн болон хамгаалах зорилгоор хэрэглэх;

(б) химийн бодисын төрөл, тоо хэмжээг дээрх зорилгоор батлагдаж болох төрөл, тоо хэмжээгээр хатуу хязгаарлах;

(с) тийм химийн бодисын нийт хэмжээ тодорхой хугацаанд дээрх зорилгоор 1 тоннотой тэнцэх буюу бага байх;

(д) үйлдвэрлэл болон химийн зэвсгийн нөөцөөс гаргах болон шилжүүлэх замаар аливаа нэг жилд дээрх зорилгоор оролцогч улсын олж авсан нийт хэмжээ нь 1 тоннотой тэнцэх буюу бага байх.

### **В. Шилжүүлэх**

3. Оролцогч улс I жагсаалтад орсон химийн бодисыг зөвхөн өөр оролцогч улсад зөвхөн 2 дахь хэсэгт нийцүүлэн эрдэм шинжилгээ, анагаах ухаан, эм зүйн болон хамгаалах зорилгоор өөрийн газар нутгаас гадагш шилжүүлж болно.

4. Шилжүүлсэн химийн бодисыг гуравдагч улс уруу дахин шилжүүлэхгүй.

5. Химийн бодисыг өөр оролцогч улсад шилжүүлэхээс 30-аас доошгүй хоногийн өмнө шилжүүлсэн тухай оролцогч хоёр улс хоёулаа Техникийн нарийн бичгийн дарга нарын газарт мэдэгдэнэ.

5bis. 5 миллиграм буюу түүнээс бага тоо хэмжээний хувьд хэрэв анагаах ухаан/оношлогооны зорилгоор шилжүүлэх бол I жагсаалтад орсон сакситоксин хэмээх химийн бодис нь 5 дахь хэсэгт заасан мэдэгдэл өгөх хугацаанд хамрагдахгүй. Энэ тохиолдолд шилжүүлэхийн өмнөхөн мэдэгдлийг өгнө.

6. Оролцогч улс бүр өмнөх жил хийсэн шилжүүлгийн талаар жил бүрийн дэлгэрэнгүй мэдүүлэг хийнэ. Мэдүүлгийг тухайн жил дууссанаас хойш 90 хоногийн өмнө өгөх бөгөөд I жагсаалтад орсон шилжүүлсэн химийн бодис бүрийн хувьд дараахь мэдээллийг агуулна:

(а) химийн бодисын нэр, бүтцийн томъёолол болон хэрэв өгөгдсөн бол Химийн абстракт үйлчилгээний бүртгэлийн дугаар;

(б) бусад оролцогч улсаас олж авсан буюу бусад оролцогч улс уруу шилжүүлсэн тоо хэмжээ. Шилжүүлэг бүрийн хувьд тоо хэмжээ, хүлээн авагч болон зорилгыг тусгана.

### **С. Үйлдвэрлэх**

#### **Үйлдвэрлэх ерөнхий зарчим**

7. 8-аас 12 дахь хэсэгт заасан үйлдвэрлэлийн явцад оролцогч улс бүр хүмүүсийн аюулгүй байдлыг хангах болон байгаль орчныг хамгаалахыг эн тэргүүнд чухалчилна. Оролцогч улс бүр химийн зэвсгийн аюулгүй байдал болон хаягдлын талаархи үндэсний жишигтээ нийцүүлэн үйлдвэрлэл явуулна.

#### **Бага оврын ганц байгууламж**

8. Оролцогч улс бүр эрдэм шинжилгээ, анагаах ухаан, эм зүйн буюу хамгаалах зорилгоор I жагсаалтад орсон химийн бодисыг 10, 11 болон 12 дахь хэсэгт зааснаас бусад тохиолдолд тухайн оролцогч улсын батласан бага оврын ганц байгууламж дээр үйлдвэрлэнэ.

9. Бага оврын ганц байгууламж дээрх үйлдвэрлэлийг тасралтгүй ажиллахаар зохицуулаагүй үйлдвэрлэлийн шугам дээр урвалын саванд явуулна. Урвалын савны багтаамж нь 100 литрээс хэтрэхгүй бөгөөд 5 литрээс илүү багтаамжтай урвалын савны нийт багтаамж нь 500 литрээс илүүгүй байна.

#### Бусад байгууламж

10. Нэг жилд нийт 10 кг-аас хэтрэхгүй тоо хэмжээгээр I жагсаалтад орсон химийн бодисыг хамгаалалтын зорилгоор бага оврын ганц байгууламжаас гадна өөр нэг байгууламж дээр үйлдвэрлэж болно. Энэ байгууламжийг оролцогч улс батална.

11. Нэг жилд 100 гр-аас илүү тоо хэмжээгээр I жагсаалтад орсон химийн бодисыг эрдэм шинжилгээ, анагаах ухаан буюу эм зүйн зорилгоор бага оврын ганц байгууламжаас гадна нийт хэмжээ нь байгууламж бүрт нэг жилд 10 кг-аас хэтрэхгүй байхаар өөр байгууламж дээр үйлдвэрлэж болно. Эдгээр байгууламжийг оролцогч улс батална.

12. I жагсаалтад орсон химийн бодисын синтезийг эрдэм шинжилгээ, анагаах ухаан болон эм зүйн зорилгоор, гэхдээ хамгаалах зорилгоор бус нийт хэмжээ нь байгууламж бүрт нэг жилд 100 гр-аас доош байхаар лабораторид хийж болно. D болон E ангид заасан мэдүүлэг болон нягтлан шалгалтад хамаарах аливаа үүрэгт эдгээр байгууламж хамрагдахгүй.

#### **D. Мэдүүлэг**

##### Бага оврын ганц байгууламж

13. Бага оврын ганц байгууламж ажиллууллахаар төлөвлөж буй оролцогч улс бүр байгууламжийн тодорхой байрлал болон техникийн дэлгэрэнгүй тодорхойлолт, түүний дотор тоног төхөөрөмжийн дансалсан жагсаалт болон нарийвчилсан бүдүүвч зургийг Техникийн нарийн бичгийн дарга нарын газарт өгнө. Байгаа байгууламжийн хувьд анхны энэ мэдүүлгийг энэхүү конвенц тухайн оролцогч улсын хувьд хүчин төгөлдөр болсноос хойш 30 хоногийн дотор өгнө. Шинэ байгууламжийн тухай анхны мэдүүлгийг үйл ажиллагаагаа эхлэхээс 180-аас доошгүй хоногийн өмнө өгнө.

14. Оролцогч улс бүр анхны мэдүүлэгт хамаарах төлөвлөсөн өөрчлөлтийн талаар Техникийн нарийн бичгийн дарга нарын газарт урьдчилсан мэдэгдэл өгнө. Мэдэгдлийг өөрчлөлт хийгдэхээс 180-аас доошгүй хоногийн өмнө өгнө.

15. I жагсаалтад орсон химийн бодисыг бага оврын ганц байгууламж дээр үйлдвэрлэж буй оролцогч улс өмнөх жилийн байгууламжийн үйл ажиллагаанд холбогдох жил бүрийн дэлгэрэнгүй мэдүүлэг хийнэ. Мэдүүлгийг тухайн он дууссанаас хойш 90-ээс доошгүй хоногийн дотор өгөх бөгөөд түүнд дараах зүйлийг тусгана:

- (a) байгууламжийн тодорхойлолт;
- (b) байгууламжид үйлдвэрлэсэн, олж авсан, хэрэглэсэн буюу хадгалсан I жагсаалтад орсон химийн бодис бүрийн хувьд дараах мэдээлэл:
  - (i) химийн бодисын нэр, бүтцийн томъёо болон хэрэв Химийн бодисын үйлчилгээний бүртгэлийн дугаар заасан бол уг дугаар;
  - (ii) ашигласан арга болон үйлдвэрлэсэн тоо хэмжээ;

(iii) I жагсаалтад орсон химийн бодис үйлдвэрлэхэд ашигласан 1, 2 эсхүл 3 дугаар жагсаалтад орсон прекурсорын нэр, тоо хэмжээ;

(iv) байгууламжид болон хэрэглээний зорилгоор хэрэглэсэн тоо хэмжээ;

(v) оролцогч улс дахь өөр байгууламжаас хүлээн авсан болон өөр байгууламж уруу зөөвөрлөсөн тоо хэмжээ. Зөөвөрлөлт бүрийн тоо хэмжээ, хүлээн авагч болон зорилгыг тусгана;

(vi) жилийн аль ч цагт хадгалах дээд тоо хэмжээ;

(vii) он дуусахад хадгалсан тоо хэмжээ;

(c) өмнө нь өгсөн байгууламжийн техникийн дэлгэрэнгүй тодорхойлолт, түүний дотор тоног төхөөрөмжийн дансалсан жагсаалт болон нарийвчилсан бүдүүвч зурагтай харьцуулахад тухайн жилийн турш байгууламжид гарсан аливаа өөрчлөлтийн талаархи мэдээлэл.

16. I жагсаалтад орсон химийн бодисыг бага оврын ганц байгууламж дээр үйлдвэрлэж буй оролцогч улс бүр ирэх жил байгууламж дээр явуулахаар төлөвлөж буй үйл ажиллагаа болон үйлдвэрлэлийн талаар жил бүрийн дэлгэрэнгүй мэдүүлэг хийнэ. Мэдүүлгийг тухайн он эхлэхээс 90-ээс доошгүй хоногийн өмнө өгөх бөгөөд түүнд дараах зүйлийг тусгана:

(a) байгууламжийн тодорхойлолт;

(b) байгууламжид үйлдвэрлэх, олж авах, хэрэглэх буюу хадгалахаар төлөвлөж буй I жагсаалтад орсон химийн бодис бүрийн хувьд дараах мэдээлэл:

(i) химийн бодисын нэр, бүтцийн томъёо болон хэрэв Химийн бодисын үйлчилгээний бүртгэлийн дугаар заасан бол уг дугаар;

(ii) үйлдвэрлэхээр төлөвлөсөн тоо хэмжээ болон үйлдвэрлэлийн зорилго;

(c) өмнө нь өгсөн байгууламжийн техникийн дэлгэрэнгүй тодорхойлолт, түүний дотор тоног төхөөрөмжийн дансалсан жагсаалт болон нарийвчилсан бүдүүвч зурагтай харьцуулахад тухайн жилийн турш байгууламжид гарна гэж үзэж буй аливаа өөрчлөлтийн талаархи мэдээлэл.

#### 10 болон 11 дэх хэсэгт дурдсан бусад байгууламж

17. Байгууламж бүрийн хувьд оролцогч улс байгууламж буюу түүний холбогдох хэсгийн нэр, байршил болон техникийн дэлгэрэнгүй тодорхойлолтыг Техникийн нарийн бичгийн дарга нарын газраас хүссэний дагуу Техникийн нарийн бичгийн дарга нарын газарт өгнө. I жагсаалтад орсон химийн бодисыг хамгаалалтын зорилгоор үйлдвэрлэдэг багийтууламжийг тусгайлан заана. Байгаа байгууламжийн хувьд анхны энэ мэдүүлгийг энэхүү конвенц тухайн оролцогч улсын хувьд хүчин төгөлдөр болсноос хойш 30 хоногийн дотор өгнө. Шинэ байгууламжийн тухай анхны мэдүүлгийг үйл ажиллагаагаа эхлэхээс 180-аас доошгүй хоногийн өмнө өгнө.

18. Оролцогч улс бүр анхны мэдүүлэгт хамаарах төлөвлөсөн өөрчлөлтийн талаар Техникийн нарийн бичгийн дарга нарын газарт урьдчилсан мэдэгдэл өгнө. Мэдэгдлийг өөрчлөлт хийгдэхээс 180-аас доошгүй хоногийн өмнө өгнө.

19. Оролцогч улс бүр өмнөх жилийн байгууламжийн үйл ажиллагаанд холбогдох жил бүрийн дэлгэрэнгүй мэдүүлгийг байгууламж бүрийн хувьд хийнэ. Мэдүүлгийг тухайн он дууссанас хойш 90-ээс доошгүй хоногийн дотор өгөх бөгөөд түүнд дараахь зүйлийг тусгана:

- (a) байгууламжийн тодорхойлолт;
- (b) I жагсаалтад орсон химийн бодис бүрийн хувьд дараахь мэдээлэл:
  - (i) химийн бодисын нэр, бүтцийн томъёо болон хэрэв Химийн бодисын үйлчилгээний бүртгэлийн дугаар заасан бол уг дугаар;
  - (ii) үйлдвэрлэсэн тоо хэмжээ болон хамгаалах зорилгоор үйлдвэрлэсэн тохиолдолд ашигласан арга;
  - (iii) I жагсаалтад орсон химийн бодис үйлдвэрлэхэд ашигласан I, II эсхүл III жагсаалтад орсон прекурсорын нэр, тоо хэмжээ;
  - (iv) байгууламжид болон хэрэглээний зорилгоор хэрэглэсэн тоо хэмжээ;
  - (v) оролцогч улс дахь өөр байгууламжид шилжүүлсэн тоо хэмжээ. Шилжүүлэг бүрийн тоо хэмжээ, хүлээн авагч болон зорилгыг тусгана;
  - (vi) жилийн аль ч цагт хадгалах дээд тоо хэмжээ;
  - (vii) он дуусахад хадгалсан тоо хэмжээ;
- (c) өмнө нь өгсөн байгууламжийн техникийн дэлгэрэнгүй тодорхойлолттой харьцуулахад тухайн жилийн турш байгууламж, эсхүл түүний холбогдох хэсгүүдэд гарсан аливаа өөрчлөлтийн талаархи мэдээлэл.

20. Оролцогч улс бүр ирэх жил байгууламж дээр явуулахаар төлөвлөж буй үйл ажиллагаа болон үйлдвэрлэлийн талаар жил бүрийн дэлгэрэнгүй мэдүүлгийг байгууламж бүрийн хувьд хийнэ. Мэдүүлгийг тухайн он эхлэхээс 90-ээс доошгүй хоногийн өмнө өгөх бөгөөд түүнд дараахь зүйлийг тусгана:

- (a) байгууламжийн тодорхойлолт;
- (b) I жагсаалтад орсон химийн бодис бүрийн хувьд дараахь мэдээлэл:
  - (i) химийн бодисын нэр, бүтцийн томъёо болон хэрэв Химийн бодисын үйлчилгээний бүртгэлийн дугаар заасан бол уг дугаар;
  - (ii) үйлдвэрлэхээр төлөвлөж буй тоо хэмжээ, үйлдвэрлэл явагдах цаг хугацаа болон үйлдвэрлэлийн зорилго;
- (c) өмнө нь өгсөн байгууламжийн техникийн дэлгэрэнгүй тодорхойлолттой харьцуулахад тухайн жилийн турш байгууламж, эсхүл түүний холбогдох хэсгүүдэд гарна гэж үзэж буй аливаа өөрчлөлтийн талаархи мэдээлэл.

## **Е. Нягтлан шалгалт**

### **Бага оврын ганц байгууламж**

21. Бага оврын ганц байгууламж дээр нягтлан шалгалтын үйл ажиллагаа явуулах зорилго нь үйлдвэрлэж буй I жагсаалтад орсон химийн бодисын тоо хэмжээг зөв мэдүүлсэн бөгөөд ялангуяа нийт хэмжээ нь 1 тонноос хэтрэхгүй байгааг нягтлан шалгахад оршино.

22. Байгууламжийг газар дээр нь хянан шалгах болон газар дээр нь байрлуулсан багаж хэрэгслээр ажиглан шинжих замаар тогтмол нягтлан шалгалтанд хамруулна.

23. Тодорхой байгууламжид явуулах хянан шалгалтын тоо, эрч, үргэлжлэх хугацаа, цаг хугацаа болон арга хэлбэр нь холбогдох химийн бодисоор энэхүү конвенцийн зүйл, зорилгод учруулж буй аюул, байгууламжийн онцлог, түүн дээр явуулж буй үйл ажиллагааны шинж чанарт үндэслэнэ. Удирдлага болговол зохих зүйлсийг 8 дугаар зүйлийн 21 дэх хэсгийн (i) дэд хэсгийн дагуу Бага хурлаар хэлэлцэж, батална.

24. Анхны хянан шалгалтын зорилго нь байгууламжийн талаар өгсөн мэдээллийг нягтлан шалгах, түүний дотор 9 дэх хэсэгт заасан урвалын савны хязгаарыг нягтлан шалгахад оршино.

25. Энэхүү конвенц оролцогч улсын хувьд хүчин төгөлдөр болсноос хойш 180 хоногийн дотор тухайн улс загвар хэлэлцээрт сууриссан, байгууламжийн хянан шалгалтын нарийвчилсан журмыг хамарсан байгууламжийн тухай хэлэлцээрийг Байгууллагатай байгуулна.

26. Энэхүү конвенц түүний хувьд хүчин төгөлдөр болсны дараа бага оврын ганц байгууламж байгуулахаар төлөвлөж буй оролцогч улс бүр загвар хэлэлцээрт сууриссан, байгууламжийн хянан шалгалтын нарийвчилсан журмыг хамарсан байгууламжийн тухай хэлэлцээрийг байгууламжийг ашиглах болон түүний ажиллуулж эхлэхээс өмнө Байгууллагатай байгуулна.

27. Хэлэлцээрийн загварыг 8 дугаар зүйлийн 21 дэх хэсгийн (i) дэд хэсгийн дагуу Бага хурлаар хэлэлцэж, батална.

### **10 болон 11 дэх хэсэгт дурдсан бусад байгууламж**

28. 10 болон 11 дэх хэсэгт дурдсан аливаа байгууламж дээр нягтлан шалгалтын үйл ажиллагаа явуулах зорилго нь доор дурдсаныг нягтлан шалгахад оршино:

(а) байгууламжийг мэдүүлсэн химийн бодисоос бусад I жагсаалтад орсон ямарваа химийн бодисыг үйлдвэрлэхэд ашиглаагүй;

(б) үйлдвэрлэсэн, боловсруулсан эсхүл хэрэглэсэн I жагсаалтад орсон химийн бодисын тоо хэмжээг зөв мэдүүлсэн бөгөөд уг тоо хэмжээ нь мэдүүлсэн зорилгын хэрэгцээнд нийцэж байгаа;

(с) I жагсаалтад орсон химийн бодисыг өөр чиглэлд зөөвөрлөхгүй буюу өөр зорилгоор ашиглахгүй.

29. Байгууламжийг газар дээр нь хянан шалгах болон газар дээр нь байрлуулсан багаж хэрэгслээр ажиглан шинжих замаар тогтмол нягтлан шалгалтанд хамруулна.

30. Тодорхой байгууламжид явуулах хянан шалгалтын тоо, эрч, үргэлжлэх хугацаа, цаг хугацаа болон арга хэлбэр нь үйлдвэрлэсэн химиийн бодисын тоо хэмжээгээр энэхүү конвенцийн зүйл, зорилгод учруулж буй аюул, байгууламжийн онцлог, түүн дээр явуулж буй үйл ажиллагааны шинж чанарт үндэслэнэ. Удирдлага болговол зохих зүйлийг 8 дугаар зүйлийн 21 дэх хэсгийн (i) дэд хэсгийн дагуу Бага хурлаар хэлэлцэж, батална.

31. Энэхүү конвенц оролцогч улсын хувьд хүчин төгөлдөр болсноос хойш 180 хоногийн дотор тухайн улс загвар хэлэлцээрт суурилсан, байгууламж бүрийн хянан шалгалтын нарийвчилсан журмыг хамарсан байгууламжийн тухай хэлэлцээрүүдийг Байгууллагатай байгуулна.

32. Энэхүү конвенц хүчин төгөлдөр болсны дараа тийм байгууламж байгуулахаар төлөвлөж буй оролцогч улс бүр байгууламжийн тухай хэлэлцээрийг байгууламжийг ашиглах болон түүний ажиллуулж эхлэхээс өмнө Байгууллагатай байгуулна.

## VII ХЭСЭГ

### **6 ДУГААР ЗҮЙЛД НИЙЦҮҮЛЭН ЭНЭХҮҮ КОНВЕНЦООР ХОРИГЛООГҮЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА**

#### **II ЖАГСААЛТАД ОРСОН ХИМИЙН БОДИС БОЛОН ХИМИЙН ТИЙМ БОДИСТ ХАМААРАХ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИД ЗОРИУЛСАН ГОРИМ**

##### **A. Мэдүүлэг**

###### **Үндэсний нийт тоо баримтын талаархи мэдүүлэг**

1. 6 дугаар зүйлийн 7 болон 8 дахь хэсгийн дагуу оролцогч улс бүрээс гаргах анхны болон жил бүрийн мэдүүлэгт II жагсаалтад орсон химиийн бодисыг өмнөх хуанлийн жилд үйлдвэрлэсэн, боловсруулсан, хэрэглэсэн, импортлосон болон экспортлосон тоо хэмжээний талаархи үндэсний нийт тоо баримт, түүнчлэн холбогдох орон бүрийн хувьд импорт болон экспортын тоо хэмжээний тодорхойлолтыг багтаана.

###### **2. Оролцогч улс бүр:**

(a) энэхүү конвенц түүний хувьд хүчин төгөлдөр болсноос хойш 30 хоногийн дотор; түүнчлэн дараагийн хуанлийн жилээс эхлэн 1 дэх хэсгийн дагуу анхны мэдүүлгийг;

(b) өмнөх хуанлийн жил дууссанаас хойш 90 хоногийн дотор жил бүрийн мэдүүлгийг тус тус өгнө.

**II жагсаалтад орсон химиийн бодисыг үйлдвэрлэх, боловсруулах буюу хэрэглэх үйлдвэрийн талбайн талаарх мэдүүлэг**

3. Дараахь хэмжээнээс илүүгээр хуанлийн өмнөх гурван жилийн хугацаанд үйлдвэрлэсэн, боловсруулсан буюу хэрэглэсэн, эсхүл хуанлийн дараагийн жил үйлдвэрлэх, боловсруулах буюу хэрэглэхээр төлөвлөж буй нэг буюу хэд хэдэн үйлдвэрээс бүрдэх үйлдвэрийн бүх талбайн хувьд анхны болон жил бүрийн мэдүүлгийг шаардана:

- (a) II жагсаалтын А хэсэгт “\*” тэмдгээр заасан химийн бодисын 1 кг;
- (b) II жагсаалтын А хэсэгт жагсаасан химийн аливаа бусад бодисын 100 кг;
- (c) II жагсаалтын В хэсэгт жагсаасан химийн бодисын 1 тонн.

4. Оролцогч улс бүр:

(a) энэхүү конвенц түүний хувьд хүчин төгөлдөр болсноос хойш 30 хоногийн дотор; түүнчлэн дараагийн хуанлийн жилээс эхлэн 3 дахь хэсгийн дагуу анхны мэдүүлгийг;

(b) өмнөх хуанлийн жил дууссанаас хойш 90 хоногийн дотор өнгөрсөн үйл ажиллагааны тухай жил бүрийн мэдүүлгийг;

(c) дараагийн хуанлийн жил эхлэхээс өмнө 60 хоногоос хойшшуулахгүйгээр төлөвлөж буй үйл ажиллагааны талаархи жил бүрийн мэдүүлгийг тус тус өгнө. Жил бүрийн мэдүүлгийг өгсний дараа төлөвлөсөн нэмэлт аливаа үйл ажиллагааны талаар уг үйл ажиллагаа эхлэхээс өмнө тав хоногоос хойшшуулахгүйгээр мэдүүлнэ.

5. З дахь хэсгийн дагуу мэдүүлэг өгөхийг II жагсаалтад орсон химийн бодисын бага концентрац бүхий хольцын хувьд ер нь шаардахгүй. Зөвхөн II жагсаалтад орсон химийн бодисыг хольцоос гарган авах нь амархан бөгөөд түүний нийт жин нь энэхүү конвенцийн зүйл, зорилгод аюул учруулна гэж үзэх тохиолдолд мэдүүлэг өгөхийг удирдамжийн дагуу шаардана. Ийм удирдамжийг 8 дугаар зүйлийн 21 дэх хэсгийн (i) дэд хэсгийн дагуу Бага хурлаар хэлэлцэж, батална.

6. З дахь хэсгийн дагуу өгөх үйлдвэрийн талбайн талаархи мэдүүлэгт дараахь зүйлийг тусгана:

(a) үйлдвэрийн талбайн нэр, түүнийг ажиллуулж буй өмчлөгч, компани буюу аж ахуйн нэгжийн нэр;

(b) хаяг бүхий түүний тодорхой байршил;

(c) энэхүү хавсралтын VIII хэсгийн дагуу мэдүүлсэн үйлдвэрийн талбай дахь үйлдвэрийн тоо.

7. З дахь хэсгийн дагуу өгөх үйлдвэрийн талбайн талаархи мэдүүлэгт үйлдвэрийн талбайд байрлах бөгөөд 3 дахь хэсэгт заасан тодорхойлолтод хамрагдаж байгаа үйлдвэр бүрийн хувьд дараахь зүйлийг тусгана:

(a) үйлдвэрийн нэр, түүнийг ажиллуулж буй өмчлөгч, компани буюу аж ахуйн нэгжийн нэр;

(b) үйлдвэрийн талбай дахь түүний тодорхой байршил, түүний дотор хэрэв байвал тусгай барилга байгууламжийн дугаар;

(с) түүний гол үйл ажиллагаа;

(д) үйлдвэр нь:

(i) II жагсаалтад орсон мэдүүлсэн химиин бодис үйлдвэрлэдэг, боловсруулдаг эсхүл хэрэглэдэг эсэх;

(ii) тийм үйл ажиллагаанд эсхүл олон зорилгод чиглэсэн эсэх;

(iii) II жагсаалтад орсон мэдүүлсэн химиин бодисын хувьд бусад үйл ажиллагаа явуулдаг, түүний дотор тийм бусад үйл ажиллагаа (жишээлбэл, хадгалах)-ны тодорхойлолт хийдэг эсэх.

(е) II жагсаалтад орсон мэдүүлсэн химиин бодис бүрийн хувьд үйлдвэрийн үйлдвэрлэх хүчин чадал.

8. З дахь хэсгийн дагуу өгөх үйлдвэрийн талбайн талаархи мэдүүлэгт мэдүүлгийн босгоос дээшхи II жагсаалтад орсон химиин бодис бүрийн талаархи дараах мэдээллийг мөн тусгана:

(а) химиин бодисын нэр, байгууламжийн ашиглаж буй ердийн буюу барааны нэр, бүтцийн томъёо болон хэрэв Химиин бодисын үйлчилгээний бүртгэлийн дугаар заасан бол уг дугаар;

(б) анхны мэдүүлгийн тохиолдолд: өнгөрсөн хуанлийн гурван жил тутамд үйлдвэрийн талбайн үйлдвэрлэсэн, боловсруулсан, хэрэглэсэн, импортлосон болон экспортлосон нийт хэмжээ;

(с) өнгөрсөн үйл ажиллагааны талаархи жил бүрийн мэдүүлгийн тохиолдолд: өнгөрсөн хуанлийн жилд үйлдвэрийн талбайн үйлдвэрлэсэн, боловсруулсан, хэрэглэсэн, импортлосон болон экспортлосон нийт хэмжээ;

(д) төлөвлөсөн үйл ажиллагааны талаархи жил бүрийн мэдүүлгийн тохиолдолд: дараагийн хуанлийн жилд үйлдвэрийн талбайн үйлдвэрлэх, боловсруулах, хэрэглэх, импортлох болон экспортлохоор төлөвлөж буй нийт хэмжээ, түүний дотор үйлдвэрлэх, боловсруулах буюу хэрэглэхээр төлөвлөсөн хугацаа;

(е) химиин бодисыг үйлдвэрлэсэн, боловсруулсан буюу хэрэглэсэн, эсхүл үйлдвэрлэх, боловсруулах буюу хэрэглэх зорилго:

(i) бүтээгдэхүүний төрлийг тодорхойлохын хамт талбайд боловсруулах болон хэрэглэх;

(ii) бусад үйлдвэрийн салбар, худалдааны байгууллага буюу өөр чиглэл, түүнчлэн хэрэв боломжтой бол эцсийн бүтээгдэхүүний төрлийг тодорхойлохын хамт оролцогч улсын нутаг дэвсгэр дотор, эсхүл хэргийн харьяалал буюу хяналтан дор нь орших аливаа бусад газарт худалда, эсхүл шилжүүлэх;

(iii) холбогдох улсуудыг тодорхойлохын хамт шууд экспортлох; эсхүл

(iv) бусад зорилго, түүний дотор эдгээр бусад зорилгыг тодорхойлох.

**Химиин зэвсгийн зорилгоор II жагсаалтад орсон химиин бодисыг урьд нь үйлдвэрлэсэн талаархи мэдүүлэг**

9. Оролцогч улс бүр энэхүү конвенц түүний хувьд хүчин төгөлдөр болсноос хойш 30 хоногийн дотор II жагсаалтад орсон химиин бодисыг 1946 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хойш хэдийд ч химиин зэвсгийн зорилгоор үйлдвэрлэсэн үйлдвэрүүдээс бүрдсэн үйлдвэрийн бүх талбайн талаар мэдүүлнэ.

10. 9 дэх хэсгийн дагуу өгөх үйлдвэрийн талбайн талаархи мэдүүлэгт дараахь зүйлийг тусгана:

(a) үйлдвэрийн талбайн нэр, түүнийг ажиллуулж буй өмчлөгч, компани буюу аж ахуйн нэгжийн нэр;

(b) хаяг бүхий түүний тодорхой байршил;

(c) үйлдвэрийн талбайд байрлах бөгөөд 9 дэх хэсэгт заасан тодорхойлолтод хамрагдах үйлдвэр бүрийн хувьд 7 дахь хэсгийн (a) болон (e) дэд хэсгийн дагуу шаардагдах адил мэдээлэл;

(d) химиин зэвсгийн зорилгоор үйлдвэрлэсэн II жагсаалтад орсон химиин бодис бүрийн хувьд:

(i) химиин бодисын нэр, химиин зэвсэг үйлдвэрлэх зорилготой үйлдвэрийн талбайн ашиглаж буй өрдийн буюу барааны нэр, бүтцийн томъёо болон хэрэв Химиин бодисын үйлчилгээний бүртгэлийн дугаар заасан бол уг дугаар;

(ii) химиин бодис үйлдвэрлэсэн он, сар, өдөр болон үйлдвэрлэсэн тоо хэмжээ;

(iii) химиин бодис хүргэсэн байршил болон хэрэв мэдэж байгаа бол тэнд үйлдвэрлэсэн эцсийн бүтээгдэхүүн.

**Оролцогч улсуудад мэдээлэх**

11. Энэ ангийн дагуу мэдүүлсэн үйлдвэрийн талбайн жагсаалтыг 6 дахь хэсэг, 7 дахь хэсгийн (a) дэд хэсэг, 7 дахь хэсгийн (c) дэд хэсэг, 7 дахь хэсгийн (d) (i) дэд хэсэг, 7 дахь хэсгийн (d) (iii) дэд хэсэг, 8 дахь хэсгийн (a) дэд хэсэг болон 10 дахь хэсгийн дагуу өгсөн мэдээллийн хамт Техникийн нарийн бичгийн дарга нарын газраас оролцогч улсуудад хүсэлтээр нь хүргүүлнэ.

**В. Нягтлан шалгах**

**Ерөнхий зүйл**

12. Дараахь хэмжээнээс илүүгээр хуанлийн өмнөх гурван жилийн хугацаанд үйлдвэрлэсэн, боловсруулсан буюу хэрэглэсэн, эсхүл хуанлийн дараагийн жил үйлдвэрлэх, боловсруулах буюу хэрэглэхээр төлөвлөж буй нэг буюу хэд хэдэн үйлдвэрээс бүрдэх үйлдвэрийн мэдүүлсэн талбайд газар дээр нь хянан шалгалт хийх замаар 6 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан нягтлан шалгалтыг явуулна:

(a) II жагсаалтын А хэсэгт “\*” тэмдгээр заасан химиин бодисын 10 кг;

- (b) II жагсаалтын А хэсэгт жагсаасан химийн аливаа бусад бодисын 1 тонн;  
(c) II жагсаалтын В хэсэгт жагсаасан химийн бодисын 10 тонн.

13. 8 дугаар зүйлийн 21 дэх хэсгийн (а) дэд хэсгийн дагуу Бага хурлаас батлах Байгууллагын хөтөлбөр, төсөвт энэ ангийн дагуу нягтлан шалгахад зориулсан хөтөлбөр, төсвийг тусдаа зүйл болгон оруулна. 6 дугаар зүйлийн дагуу нягтлан шалгалт явуулах боломжийг олгох эх үүсвэрийг хуваарилахдаа Техникийн нарийн бичгийн дарга нарын газар нь энэхүү конвенц хүчин төгөлдөр болсноос хойш эхний гурван жилийн хугацаанд А ангийн дагуу мэдүүлсэн үйлдвэрийн талбайд анхны хянан шалгалт хийхийг чухалчлан үзнэ. Хуваарилалтыг олж авсан туршлага дээр үндэслэн дараа нь хянан үзнэ.

14. Техникийн нарийн бичгийн дарга нарын газар нь анхны хянан шалгалт болон дараагийн хянан шалгалтыг 15-аас 22 дахь хэсэгт нийцүүлэн явуулна.

#### Хянан шалгалтын зорилго

15. Хянан шалгалтын ерөнхий зорилго үйл ажиллагаа нь энэхүү конвенцоор хүлээсэн үүрэг болон мэдүүлэгт заасан мэдээлэлд нийцэж буйг нягтлан шалгахад оршино. А ангийн дагуу мэдүүлсэн үйлдвэрийн талбайд хийх хянан шалгалтын тусгай зорилгод дараахь зүйлийн нягтлан шалгалт хамаарна:

- (a) энэхүү хавсралтын VI хэсэгт нийцүүлснээс бусад тохиолдолд I жагсаалтад орсон химийн бодис байхгүй, ялангуяа түүнийг үйлдвэрлээгүй;
- (b) II жагсаалтад орсон химийн бодисыг үйлдвэрлэх, боловсруулах, эсхүл хэрэглэх түвшин мэдүүлэгтэй нийцэж байгаа;
- (c) II жагсаалтад орсон химийн бодисыг энэхүү конвенцоор хориглосон үйл ажиллагаанд чиглүүлээгүй.

#### Анхны хянан шалгалт

16. 12 дахь хэсгийн дагуу хянан шалгагдах үйлдвэрийн талбай бүр аль болох түргэн, гэхдээ болбол энэхүү конвенц хүчин төгөлдөр болсны дараа гурван жилийн дотор анхны хянан шалгалтыг хүлээж авна. Энэ хугацааны дараа мэдүүлсэн үйлдвэрийн талбайд үйлдвэрлэх, боловсруулах эсхүл хэрэглэх тухай анх мэдүүлсний дараа нэг жилийн дотор анхны хянан шалгалтыг хүлээж авна. Анхны хянан шалгалтад хамаарах үйлдвэрийн талбайг Техникийн нарийн бичгийн дарга нарын газар үйлдвэрийн талбайг хянан шалгах хугацааг яг тодорхой урьдчилан мэдэх боломжгүй байхаар сонгоно.

17. Анхны хянан шалгалтын үед үйлдвэрийн талбайн хувьд байгууламжийн тухай хэлэлцээрийн төслийг хянан шалгуулж буй оролцогч улс болон Техникийн нарийн бичгийн дарга нарын газар үүнийг хэрэггүй гэж тохиролцоогүй бол бэлтгэнэ.

18. Дараагийн хянан шалгалтын давтамж, эрчийн хувьд хянан шалгагч нар химийн холбогдох бодисоор энэхүү конвенцийн зүйл, зорилгод учруулж болох аюул, үйлдвэрийн талбайн шинж чанар, тэнд явуулж буй үйл ажиллагааны мөн чанарыг дараахь шалгуурыг *inter alia* харгалзан анхны хянан шалгалтын явцад үнэлж дүгнэнэ:

(а) жагсаалтад орсон химийн бодисын болон хэрэв байгаа бол түүнтэй хамт үйлдвэрлэгдсэн эцсийн бүтээгдэхүүний хордуулах чанал;

(б) хянан шалгуулж буй талбайд ер нь хадгалдаг жагсаалтад орсон химийн бодисын тоо хэмжээ;

(с) хянан шалгуулж буй талбайд ер нь хадгалдаг жагсаалтад орсон химийн бодисын түүхий эд бүхий химийн бодисын тоо хэмжээ;

(д) II жагсаалтад орсон үйлдвэрийн үйлдвэрлэх хүчин чадал;

(е) хянан шалгуулж буй талбайд химийн хорт бодис анхлан үйлдвэрлэх, хадгалах болон цэнэглэх боломж, хувиргах боломж.

#### Хянан шалгах

Анхны хянан шалгалт хүлээж авснаар 12 дахь хэсгийн дагуу хянан шалгагдах үйлдвэрийн талбай бүр нь дараагийн хянан шалгалтуудад хамрагдана.

19. Хянан шалгах үйлдвэрийн тодорхой талбайг сонгохдоо, түүнчлэн хянан шалгалтын давтамж, эрчийг тодорхойлохдоо Техникийн нарийн бичгийн дарга нарын газар нь байгууламжийн тухай холбогдох хэлэлцээр, түүнчлэн анхны хянан шалгалт болон дараагийн хянан шалгалтын үр дүнг харгалзан химийн холбогдох бодисоор энэхүү конвенцийн зүйл, зорилгод учруулж болох аюул, үйлдвэрийн талбайн шинж чанар, тэнд явуулж буй үйл ажиллагааны мөн чанарыг зохих ёсоор харгалзан үзнэ.

20. Хянан шалгагдах үйлдвэрийн талбайг Техникийн нарийн бичгийн дарга нарын газар түүнийг хянан шалгах хугацааг яг тодорхой урьдчилан мэдэх боломжгүй байхаар сонгоно.

21. Энэ ангийн заалтуудын дагуу нэг жилд үйлдвэрийн талбайд хоёроос олон хянан шалгалт хүлээж авахгүй. Гэхдээ энэ нь 9 дүгээр зүйлийн дагуу хийх хянан шалгалтыг хязгаарлахгүй.

#### Хянан шалгалтын журам

22. Удирдлага болгохоор тохиролцсон зүйлс, энэхүү хавсралтын холбогдох бусад заалт болон Нууцлалын тухай хавсралтаас гадна доорхи 24-өөс 30 дахь хэсгийг хэрэглэнэ.

23. Анхны хянан шалгалтыг дууссаны дараа 90 хоногийн дотор мэдүүлсэн үйлдвэрийн талбайн хувьд байгууламжийн тухай хэлэлцээрийг хянан шалгуулж буй оролцогч улс болон Байгууллагын хооронд хянан шалгуулж буй оролцогч улс болон Техникийн нарийн бичгийн дарга нарын газар үүнийг хэрэггүй гэж тохиролцоогүй бол байгуулна. Энэ нь загвар хэлэлцээрт үндэслэх бөгөөд мэдүүлсэн үйлдвэрийн талбайд хянан шалгалт явуулах ажиллагааг зохицуулна. Хэлэлцээрт хянан шалгалтын давтамж болон эрч, түүнчлэн 25-аас 29 дэх хэсэгт нийцүүлэн хянан шалгалтын нарийвчилсан журмыг заана.

24. Мэдүүлсэн үйлдвэрийн талбайн хүрээн дэх II жагсаалтад орсон мэдүүлсэн үйлдвэрүүд нь хянан шалгалтын гол объект болно. Хэрэв хянан шалгах баг үйлдвэрийн талбайн бусад хэсэгт нэвтрэхийг хүсвэл энэхүү хавсралтын II хэсгийн 51 дэх хэсгийн дагуу тодруулга өгөх үүрэгт, түүнчлэн байгууламжийн тухай хэлэлцэээрт эсхүл байгууламжийн тухай хэлэлцээр байхгүй бол энэхүү хавсралтын X хэсгийн 51

дэх хэсэгт зааснаар удирдлаган дор нэвтрэх журамд нийцүүлэн тэдгээр талбайд нэвтрэх эрхийг олгоно.

25. Мэдүүлсэн химиин бодисыг өөр чиглэлд явуулаагүй бөгөөд үйлдвэрлэл нь мэдүүлэгтэй нийцсэнийг нотлох үүднээс бүртгэл тэмдэглэлд хүрэх эрхийг зохих тохиолдолд олгоно.

26. Химиин бодисын жагсаалтад орсон бөгөөд мэдүүлээгүй химиин бодис байхгүйг шалгахаар дээж авч шинжилнэ.

27. Хянан шалгалт хийх талбайд дараахь талбай багтана:

(а) химиин бодис (урвалж) хүргэж өгөх буюу хадгалж байгаа талбай;

(б) урвалын саванд нэмэхээс өмнө урвалж дээр үйл ажиллагаа гүйцэтгэх талбай;

(с) (а) дэд хэсэг эсхүл (б) дэд хэсэгт дурдсан талбайгаас урвалын сав руу холбогдох клапан, ургал хэмжүүр гэх мэтийн хамт хүрэх түүхий эд нийлүүлэх шугам;

(д) урвалын савны гадаад байдал болон туслах тоног төхөөрөмж;

(е) урвалын савнаас урт болон богино хугацаанд хадгалах агуулах, эсхүл II жагсаалтад орсон химиин бодисын цаашид боловсруулах тоног төхөөрөмжид хүрэх шугам;

(f) (а)-(е) дэд хэсгийн дагуу аливаа зүйлтэй холбоотой хяналтын тоног төхөөрөмж;

(g) хог болон хаягдал боловсруулах тоног төхөөрөмж болон талбай;

(h) шаардлага хангахгүй байгаа химиин бодисыг зайлцуулах тоног төхөөрөмж болон талбай.

29. Хянан шалгалтын хугацаа 96 цагаас илүү үргэлжлэхгүй; гэхдээ хянан шалгах баг болон хянан шалгуулж буй оролцогч улс хоорондоо тохиролцож хугацааг сунгаж болно.

#### **Хянан шалгалтын тухай мэдэгдэх**

30. Хянан шалгуулах гэж буй үйлдвэрийн талбайд хянан шалгах баг ирэхээс 48-аас доошгүй цагийн өмнө оролцогч улсад хянан шалгалтын тухай Техникийн нарийн бичгийн дарга нарын газар мэдэгдэнэ.

#### **C. Энэхүү конвенцийн оролцогч бус улсад шилжүүлэх**

31. II жагсаалтад орсон химиин бодисыг зөвхөн оролцогч улсуудад шилжүүлэх эсхүл тэдгээрээс хүлээн авна. Энэ үүрэг энэхүү конвенц хүчин төгөлдөр болсноос хойш гурван жилийн дараа хүчин төгөлдөр болно.

32. Завсрыйн ийм гурван жилийн хугацаанд, оролцогч улс бүр энэхүү конвенцийн оролцогч бус улсуудад II жагсаалтад орсон химиин бодисыг шилжүүлэх талаар доор тодорхойлсон эцсийн хэрэглээний тухай гэрчилгээ шаардана. Тийм

шилжүүлгийн хувьд оролцогч улс бүр шилжүүлж буй химиин бодисыг зөвхөн энэхүү конвенцоор хориглоогүй зорилгод ашиглах явдлыг хангах талаар шаардлагатай арга хэмжээ авна. Оролцогч улс шилжүүлж буй химиин бодистой хамааруулан дараахь зүйлийн нотолгоог хүлээн авагч улсаас *inter alia* шаардана.

- (a) уг химиин бодисыг зөвхөн энэхүү конвенцоор хориглоогүй зорилгод ашиглана;
- (b) тэдгээрийг цааш шилжүүлэхгүй;
- (c) тэдгээрийн төрөл, тоо хэмжээ,;
- (d) тэдгээрийн эцсийн хэрэглээ;
- (e) эцсийн хэрэглэгчдийн нэр, хаяг.

### VIII ХЭСЭГ

#### 6 ДУГААР ЗҮЙЛД НИЙЦҮҮЛЭН ЭНЭХҮҮ КОНВЕНЦООР ХОРИГЛООГҮЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА

#### II ЖАГСААЛТАД ОРСОН ХИМИИН БОДИС БОЛОН ТИЙМ ХИМИИН БОДИСТ ХАМААРАХ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИД ЗОРИУЛСАН ГОРИМ

##### A. Мэдүүлэг

###### Үндэсний нийт тоо баримтын талаархи мэдүүлэг

1. 6 дугаар зүйлийн 7 болон 8 дахь хэсгийн дагуу оролцогч улсаас гаргах анхны болон жил бүрийн мэдүүлэгт III жагсаалтад орсон химиин бодисыг өмнөх хуанлийн жилд үйлдвэрлэсэн, импортлосон болон экспортлосон тоо хэмжээний талаархи үндэсний нийт тоо баримт, түүнчлэн холбогдох орон бүрийн хувьд импорт болон экспортын тоо хэмжээний тодорхойлолтыг багтаана.

3. Оролцогч улс бүр:

(a) энэхүү конвенц түүний хувьд хүчин төгөлдөр болсноос хойш 30 хоногийн дотор; түүнчлэн дараагийн хуанлийн жилээс эхлэн 1 дэх хэсгийн дагуу анхны мэдүүлгийг;

(b) өмнөх хуанлийн жил дууссанаас хойш 90 хоногийн дотор жил бүрийн мэдүүлгийг тус тус өгнө.

###### III жагсаалтад орсон химиин бодисыг үйлдвэрлэх үйлдвэрийн талбайн талаархи мэдүүлэг

3. 3 дугаар жагсаалтад орсон химиин бодисын 30 тонноос илүүгээр хуанлийн өмнөх жилийн хугацаанд үйлдвэрлэсэн эсхүл хуанлийн дараагийн жил үйлдвэрлэхээр төлөвлөж буй нэг буюу хэд хэдэн үйлдвэрээс бүрдэх үйлдвэрийн бүх талбайн хувьд анхны болон жил бүрийн мэдүүлгийг шаардана.

4. Оролцогч улс бүр:

(а) энэхүү конвенц түүний хувьд хүчин төгөлдөр болсноос хойш 30 хоногийн дотор; түүнчлэн дараагийн хуанлийн жилээс эхлэн 3 дахь хэсгийн дагуу анхны мэдүүлгийг;

(б) өмнөх хуанлийн жил дууссанаас хойш 90 хоногийн дотор өнгөрсөн үйл ажиллагааны тухай жил бүрийн мэдүүлгийг;

(с) дараагийн хуанлийн жил эхлэхээс өмнө 60 хоногоос хойшлуулахгүйгээр төлөвлөж буй үйл ажиллагааны талаархи жил бүрийн мэдүүлгийг тус тус өгнө. Жил бүрийн мэдүүлгийг өгсний дараа төлөвлөсөн нэмэлт аливаа үйл ажиллагааны талаар уг үйл ажиллагаа эхлэхээс өмнө тав хоногоос хойшлуулахгүйгээр мэдүүлнэ.

5. З дахь хэсгийн дагуу мэдүүлэг өгөхийг III жагсаалтад орсон химийн бодисын бага концентрац бүхий хольцын хувьд ер нь шаардахгүй. Зөвхөн III жагсаалтад орсон химийн бодисыг хольцоос гарган авах нь амархан бөгөөд түүний нийт жин нь энэхүү конвенцийн зүйл, зорилгод аюул учруулна гэж үзэх тохиолдолд мэдүүлэг өгөхийг удирдамжийн дагуу шаардана. Ийм удирдамжийг 8 дугаар зүйлийн 21 дэх хэсгийн (i) дэд хэсгийн дагуу Бага хурлаар хэлэлцэж, батална.

6. З дахь хэсгийн дагуу өгөх үйлдвэрийн талбайн талаархи мэдүүлэгт дараахь зүйлийг тусгана:

(а) үйлдвэрийн талбайн нэр, түүнийг ажиллуулж буй өмчлөгч, компани буюу аж ахуйн нэгжийн нэр;

(б) хаяг бүхий түүний тодорхой байршил;

(с) энэхүү хавсралтын VII хэсгийн дагуу мэдүүлсэн үйлдвэрийн талбай дахь үйлдвэрийн тоо.

7. З дахь хэсгийн дагуу өгөх үйлдвэрийн талбайн талаархи мэдүүлэгт үйлдвэрийн талбайд байрлах бөгөөд 3 дахь хэсэгт заасан тодорхойлолтод хамрагдаж байгаа үйлдвэр бүрийн хувьд дараахь зүйлийг тусгана:

(а) үйлдвэрийн нэр, түүнийг ажиллуулж буй өмчлөгч, компани буюу аж ахуйн нэгжийн нэр;

(б) үйлдвэрийн талбай дахь түүний тодорхой байршил, түүний дотор хэрэв байвал тусгай барилга байгууламжийн дугаар;

(с) түүний гол үйл ажиллагаа.

8. З дахь хэсгийн дагуу өгөх үйлдвэрийн талбайн талаархи мэдүүлэгт мэдүүлгийн босгоос дээшхи II жагсаалтад орсон химийн бодис бүрийн талаархи дараахь мэдээллийг мөн тусгана:

(а) Химийн бодисын нэр, байгууламжийн ашиглаж буй ердийн буюу барааны нэр, бүтцийн томъёо болон хэрэв Химийн бодисын үйлчилгээний бүртгэлийн дугаар заасан бол уг дугаар;

(b) Хуанлийн өмнөх жил үйлдвэрлэсэн, эсхүл төлөвлөж буй үйл ажиллагааны талаар мэдүүлэг өгсөн тохиолдолд хуанлийн дараагийн жилд үйлдвэрлэхээр төлөвлөсөн химийн бодисын дараахь шатлаалаар илэрхийлэгдсэн ойролцоо хэмжээ: 30-аас 200 тонн, 200-гаас 1.000 тонн, 1000-аас 10.000 тонн, 10.000-аас 100.000 тонн болон 100.000-аас дээш тонн;

(c) Химийн бодисыг үйлдвэрлэсэн, эсхүл үйлдвэрлэх зорилго.

**Химийн зэвсгийн зорилгоор III жагсаалтад орсон химийн бодисыг урьд нь үйлдвэрлэсэн талаархи мэдүүлэг**

9. Оролцогч улс бүр энэхүү конвенц түүний хувьд хүчин төгөлдөр болсноос хойш 30 хоногийн дотор II жагсаалтад орсон химийн бодисыг 1946 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хойш хэдийд ч химийн зэвсгийн зорилгоор үйлдвэрлэсэн үйлдвэрүүдээс бүрдсэн үйлдвэрийн бүх талбайн талаар мэдүүлнэ.

10. 9 дэх хэсгийн дагуу өгөх үйлдвэрийн талбайн талаархи мэдүүлэгт дараахь зүйлийг тусгана:

(a) үйлдвэрийн талбайн нэр, түүнийг ажиллуулж буй өмчлөгч, компани буюу аж ахуйн нэгжийн нэр;

(b) хаяг бүхий түүний тодорхой байршил;

(c) үйлдвэрийн талбайд байрлах бөгөөд 9 дэх хэсэгт заасан тодорхойлолтод хамрагдах үйлдвэр бүрийн хувьд 7 дахь хэсгийн (a) болон (c) дэд хэсгийн дагуу шаардагдах адил мэдээлэл;

(d) химийн зэвсгийн зорилгоор үйлдвэрлэсэн III жагсаалтад орсон химийн бодис бүрийн хувьд:

(i) Химийн бодисын нэр, химийн зэвсэг үйлдвэрлэх зорилготой үйлдвэрийн талбайн ашиглаж буй ердийн буюу барааны нэр, бүтцийн томъёо болон хэрэв Химийн бодисын үйлчилгээний бүртгэлийн дугаар заасан бол уг дугаар;

(ii) Химийн бодис үйлдвэрлэсэн он, сар, өдөр болон үйлдвэрлэсэн тоо хэмжээ;

(iii) Химийн бодис хүргэсэн байршил болон хэрэв мэдэж байгаа бол тэнд үйлдвэрлэсэн эцсийн бүтээгдэхүүн.

**Оролцогч улсуудад мэдээлэх**

11. Энэ ангийн дагуу мэдүүлсэн үйлдвэрийн талбайн жагсаалтыг 6 дахь хэсэг, 7 дахь хэсгийн (a) дэд хэсэг, 7 дахь хэсгийн (c) дэд хэсэг, 8 дахь хэсгийн (a) дэд хэсэг болон 10 дахь хэсгийн дагуу өгсөн мэдээллийн хамт Техникийн нарийн бичгийн дарга нарын газраас оролцогч улсуудад хүсэлтээр нь хүргүүлнэ.

**B. Нягтлан шалгах  
Ерөнхий зүйл**

12. 3 дугаар жагсаалтад орсон химийн аливаа бодисыг мэдүүлгийн 30 тонны босгоос дээш нийт 200 тонноос хэтрүүлэн хуанлийн өмнөх жилийн хугацаанд үйлдвэрлэсэн эсхүл хуанлийн дараагийн жил үйлдвэрлэхээр төлөвлөж буй үйлдвэрийн мэдүүлсэн талбайд газар дээр нь хянан шалгалт хийх замаар 6 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан нягтлан шалгалтыг явуулна.

13. 8 дугаар зүйлийн 21 дэх хэсгийн (а) дэд хэсгийн дагуу Бага хурлаас батлах Байгууллагын хөтөлбөр, төсөвт энэ ангийн дагуу нягтлан шалгахад зориулсан хөтөлбөр, төсвийг тусадаа зүйл болгон энэхүү хавсралтын VII хэсгийн 13 дахь хэсгийг харгалзан оруулна.

14. Энэ ангийн дагуу Техникийн нарийн бичгийн дарга нарын газар дараах чухал хүчин зүйлсийн үндсэн дээр тусгайлан зохион бүтээсэн компьютерийн програм хангамж ашиглах зэрэг зохих механизмаар хянан шалгалт хийгдэх үйлдвэрийн талбайг таамгаар сонгоно:

- (а) хянан шалгалтын газар зүйн шударга хуваарилалт;
- (б) холбогдох химийн бодис, үйлдвэрийн талбайн шинж болон үйлдвэрийн талбайд явуулж буй үйл ажиллагаанын мөн чанарт хамаарах мэдүүлсэн үйлдвэрийн талбайн талаархи Техникийн нарийн бичгийн дарга нарын газарт байгаа мэдээлэл.

15. Энэ ангийн заалтуудын дагуу нэг жилд үйлдвэрийн талбайд хоёроос олон хянан шалгалт хүлээж авахгүй. Гэхдээ энэ нь 9 дүгээр зүйлийн дагуу хийх хянан шалгалтыг хязгаарлахгүй.

16. Энэ ангийн дагуу хянан шалгалт хийхээр үйлдвэрийн талбайг сонгохдоо Техникийн нарийн бичгийн дарга нарын газар энэхүү хавсралтын энэ хэсэг болон IX хэсгийн дагуу хуанлийн жилд оролцогч улсын хүлээн авах хянан шалгалтын нэгтгэсэн тоонд дараах хязгаарлалтыг мөрдөнө: хянан шалгалтын нэгтгэсэн тоо нь гурав дээр энэхүү хавсралтын энэ хэсэг болон IX хэсгийн дагуу оролцогч улсын мэдүүлсэн үйлдвэрийн талбайн нийт тооны 5 хувийг нэмсэн тоо, эсхүл 20 хянан шалгалтаас, чингэхдээ энэ хоёр тооны аль багаас хэтрэхгүй.

#### Хянан шалгалтын зорилго

17. А ангийн дагуу мэдүүлсэн үйлдвэрийн талбайд хийх хянан шалгалтын ерөнхий зорилго нь уг үйл ажиллагаа нь мэдүүлэгт заах мэдээлэлд нийцэж буйг нягтлан шалгахад оршино. Хянан шалгалтын тодорхой зорилго нь энэхүү хавсралтын VI хэсэгт нийцсэнээс бусад тохиолдолд I жагсаалтад орсон химийн аливаа бодис байхгүйг, ялангуяа түүнийг үйлдвэрлээгүйг нягтлан шалгахад оршино.

#### Хянан шалгалтын журам

18. Удирдлага болгоо тохиролцсон зүйлс, энэхүү хавсралтын холбогдох бусад заалт болон Нууцлалын тухай хавсралтаас гадна доорхи 19-өөс 25 дахь хэсгийг хэрэглэнэ.

19. Хянан шалгуулж буй оролцогч улс хүсэлт гаргаагүй бол байгууламжийн тухай хэлэлцээр байгуулахгүй.

20. Мэдүүлсэн үйлдвэрийн талбайн хүрээн дэх III жагсаалтад орсон мэдүүлсэн үйлдвэрүүд нь хянан шалгалтын гол объект болно. Хэрэв энэхүү хавсралтын II

хэсгийн 51 дэх хэсэгт нийцүүлэн хянан шалгах баг бүрхэг байдлыг тодруулахаар үйлдвэрийн талбайн бусад хэсэгт нэвтрэхийг хүсвэл нэвтрэх эрхийн хэмжээг хянан шалгах баг болон хянан шалгуулж буй оролцогч улсын хооронд тохиролцно.

21. Бүртгэл тэмдэглэлийг үзэх нь хянан шалгалтын зорилтод хүрэхэд тус дөхөм болно гэж хянан шалгах баг болон хянан шалгуулж буй оролцогч улс зөвшөөрсөн тохиолдолд хянан шалгах баг тийнхүү үзэж болно.

22. Химийн бодисын жагсаалтад орсон бөгөөд мэдүүлээгүй химийн бодис байхгүйг шалгахаар дээж авч, газар дээр нь шинжилж болно. Бүрхэг байдлыг шийдвэрлээгүй тохиолдолд хянан шалгуулж буй оролцогч улсын зөвшөөрөлтэйгөөр талбайгаас гаднах лабораториид дээжийг шинжилж болно.

23. Хянан шалгалт хийх талбайд дараах талбай багтана:

(a) химийн бодис (урвалж) хүргэж өгөх буюу хадгалж байгаа талбай;

(b) урвалын саванд нэмэхээс өмнө урвалж дээр үйл ажиллагаа гүйцэтгэх талбай;

(c) (a) дэд хэсэг эсхүл (b) дэд хэсэгт дурдсан талбайгаас урвалын сав уруу холбогдох клапан, урсгал хэмжүүр гэх мэтийн хамт хүрэх түүхий эд нийлүүлэх шугам;

(d) урвалын савны гадаад байдал болон туслах тоног төхөөрөмж;

(e) урвалын савнаас урт болон богино хугацаанд хадгалах агуулах, эсхүл III жагсаалтад орсон химийн бодисын цаашид боловсруулах тоног төхөөрөмжид хүрэх шугам;

(f) (a)-(e) дэд хэсгийн дагуу аливаа зүйлтэй холбоотой хяналтын тоног төхөөрөмж;

(g) хог болон хаягдал боловсруулах тоног төхөөрөмж болон талбай;

(h) шаардлага хангахгүй байгаа химийн бодисыг зайлцуулах тоног төхөөрөмж болон талбай.

24. Хянан шалгалтын хугацаа 24 цагаас илүү үргэлжлэхгүй; гэхдээ хянан шалгах баг болон хянан шалгуулж буй оролцогч улс хоорондоо тохиролцож хугацааг сунгаж болно.

#### Хянан шалгалтын тухай мэдэгдэх

25. Хянан шалгуулах гэж буй үйлдвэрийн талбайд хянан шалгах баг ирэхээс 120-иос доошгүй цагийн өмнө оролцогч улсад хянан шалгалтын тухай Техникийн нарийн бичгийн дарга нарын газар мэдэгдэнэ.

#### **C. Энэхүү конвенцийн оролцогч бус улсад шилжүүлэх**

26. 3 дугаар жагсаалтад орсон химийн бодисыг энэхүү конвенцийн оролцогч бус улсад шилжүүлэх бол оролцогч улс бүр шилжүүлж буй химийн бодисыг зөвхөн энэхүү конвенцоор хориглоогүй зорилгод ашиглах явдлыг хангах талаар шаардлагатай арга хэмжээ авна. Оролцогч улс шилжүүлж буй химийн бодистой хамааруулан дараахь зүйлийн нотолгоог хүлээн авагч улсаас *inter alia* шаардана.

(а) уг химийн бодисыг зөвхөн энэхүү конвенцоор хориглоогүй зорилгод ашиглана;

(б) тэдгээрийг цааш шилжүүлэхгүй;

(с) тэдгээрийн төрөл, тоо хэмжээ,;

(д) тэдгээрийн эцсийн хэрэглээ;

(е) эцсийн хэрэглэгчдийн нэр, хаяг.

27. Энэхүү конвенцийн оролцогч бус улсад III жагсаалтад орсон химийн бодисыг шилжүүлэх талаар Бага хурал энэхүү конвенц хүчин төгөлдөр болсноос хойш таван жилийн дараа бусад арга хэмжээг тогтоох хэрэгтэй эсэх талаар асуудлыг хэлэлцэнэ.

## IX ХЭСЭГ

### 6 ДУГААР ЗҮЙЛД НИЙЦҮҮЛЭН ЭНЭХҮҮ КОНВЕНЦООР ХОРИГЛООГҮЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА

#### ХИМИЙН БОДИС ҮЙЛДВЭРЛЭХ БУСАД БАЙГУУЛАМЖИД ХАМААРАХ ГОРИМ

##### **A. Мэдүүлэг**

Химийн бодис үйлдвэрлэх бусад байгууламжийн жагсаалт

1. 6 дугаар зүйлийн 7 дахь хэсгийн дагуу оролцогч улс бүрээс гаргах анхны мэдүүлэгт дараахь бүх үйлдвэрийн талбайн жагсаалт багтана:

(а) хуанлийн өмнөх жилийн хугацаанд жагсаалтад ороогүй тодорхой органик химийн бодисыг 200 тонноос дээш хэмжээгээр синтезийн аргаар үйлдвэрлэсэн; эсхүл

(б) фосфор, хүхэр буюу фторын элемент агуулсан бөгөөд жагсаалтад ороогүй тодорхой органик химийн бодисыг 30 тонноос дээш хэмжээгээр синтезийн аргаар хуанлийн өмнөх жилийн хугацаанд үйлдвэрлэсэн нэг буюу хэд хэдэн үйлдвэр (цаашид “ФХФ-үйлдвэр” болон “ФХФ-химийн бодис” гэх)-ээс бүрддэг.

2. 1 дэх хэсгийн дагуу өгөх химийн бодис үйлдвэрлэх бусад байгууламжийн жагсаалтад дэлбэрэх буюу нүүрс төрөгч гагцхүү үйлдвэрлэсэн үйлдвэрийн талбайг оруулахгүй.

3. Оролцогч улс бүр 1 дэх хэсгийн дагуу химийн бодис үйлдвэрлэх бусад байгууламжийн жагсаалтыг өөрийн анхны мэдэгдлийн нэг хэсэг болгон энэхүү конвенц түүний хувьд хүчин төгөлдөр болсноос хойш 30 хоногийн дотор өгнө. Оролцогч улс бүр дараагийн хуанлийн жил эхлэснээс хойш 90 хоногийн дотор уг жагсаалтыг шинэчлэхэд шаардлагатай мэдээллийг жил бүр өгнө.

4. 1 дэх хэсгийн дагуу өгөх химийн бодис үйлдвэрлэх бусад байгууламжийн жагсаалтад үйлдвэрийн талбай бүрийн талаар дараахь мэдээллийг тусгана:

(a) үйлдвэрийн талбайн нэр, түүнийг ажиллуулж буй өмчлөгч, компани буюу аж ахуйн нэгжийн нэр;

(b) үйлдвэрийн талбайн хаяг бүхий тодорхой байршил;

(c) түүний гол үйл ажиллагаа;

(d) 1 дэх хэсэгт заасан химийн бодисыг үйлдвэрийн талбайд үйлдвэрлэж буй үйлдвэрийн ойролцоо тоо.

5. 1 дэх хэсгийн (a) дэд хэсгийн дагуу жагсаасан үйлдвэрийн талбайн хувьд жагсаалтад ороогүй тодорхой органик химийн бодисыг хуанлийн өмнөх жилд үйлдвэрлэсэн дараах шаталаар илэрхийлэгдсэн ойролцоо нийт хэмжээний тухай мэдээллийг жагсаалтад мөн тусгана: 1.000 хүртэл тонн, 1.000-аас 10.000 хүртэл тонн, 10.000-аас дээш тонн.

6. 1 дэх хэсгийн (b) дэд хэсгийн дагуу жагсаасан үйлдвэрийн талбайн хувьд жагсаалтад үйлдвэрийн талбай доторхи ФХФ-үйлдвэрийн тоог зааж, ФХФ-үйлдвэрийн хуанлийн өмнөх жилд үйлдвэрлэсэн ФХФ-химийн бодисын дараах шаталаар илэрхийлэгдсэн ойролцоо нийт хэмжээний тухай мэдээллийг жагсаалтад мөн тусгана: 200 хүртэл тонн, 200-гаас 1.000 хүртэл тонн, 1.000-аас 10.000 хүртэл тонн болон 10.000-аас дээш тонн.

#### Техникийн нарийн бичгийн дарга нарын газраас туслалцаа үзүүлэх

7. Хэрэв оролцогч улс 1 дэх хэсгийн дагуу химийн бодис үйлдвэрлэх байгууламжийн жагсаалтаа гаргахад нь туслалцаа үзүүлэхийг хүсэх шаардлагатай гэж захиргааны шалтгаанаар үзвэл тийм туслалцаа үзүүлэхийг Техникийн нарийн бичгийн дарга нарын газраас хүсэж болно. Жагсаалт бүрэн эсэх талаархи асуудлыг дараа нь оролцогч улс болон Техникийн нарийн бичгийн дарга нарын хооронд зөвлөлдөөний замаар шийдвэрлэнэ.

#### Оролцогч улсуудад мэдээлэх

8. 1 дэх хэсгийн дагуу өгсөн химийн бодис үйлдвэрлэх бусад байгууламжийн жагсаалт, түүний дотор 4 дэх хэсгийн дагуу өгсөн мэдээллийг Техникийн нарийн бичгийн дарга нарын газраас оролцогч улсуудад хүсэлтээр нь хүргүүлнэ.

### **B. Нягтлан шалгах**

#### Ерөнхий зүйл

9. Сангийн заалтуудыг мөрдөхийн хамт, 6 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт заасан наягтлан шалгалтыг газар дээр нь хийх хянан шалгалтаар дамжуулан дараах талбайд хийнэ:

(a) 1 дэх хэсгийн (a) дэд хэсэгт заасан үйлдвэрийн талбай;

(b) Хуанлийн өмнөх жилийн хугацаанд 200 тонноос илүү ФХФ-химийн бодис үйлдвэрлэсэн нэг буюу хэд хэдэн ФХФ-үйлдвэрээс бүрдэх 1 дэх хэсгийн (b) дэд хэсгийн дагуу жагсаасан үйлдвэрийн талбай.

10. 8 дугаар зүйлийн 21 дэх хэсгийн (а) дэд хэсгийн дагуу Бага хурлаас батлах Байгууллагын хөтөлбөр, төсөвт түүнийг хэрэгжүүлж эхэлсний дараа энэ ангийн дагуу нягтлан шалгахад зориулсан хөтөлбөр, төсвийг тусдаа зүйл болгон оруулна.

11. Энэ ангийн дагуу Техникийн нарийн бичгийн дарга нарын газар дараах чухал хүчин зүйлсийн үндсэн дээр тусгайлан зохион бүтээсэн компьютерийн програм хангамж ашиглах зэрэг зохих механизмаар хянан шалгалт хийгдэх үйлдвэрийн талбайг таамгаар сонгоно:

(а) хянан шалгалтын газар зүйн шударга хуваарилалт;

(б) үйлдвэрийн талбайн шинж болон үйлдвэрийн талбайд явуулж буй үйл ажиллагаанд хамаарах жагсаасан үйлдвэрийн талбайн талаархи Техникийн нарийн бичгийн дарга нарын газарт байгаа мэдээлэл;

(с) 25 дахь хэсэгт нийцүүлэн тохиролцох үндсийн талаар оролцогч улсуудаас гаргасан санал.

12. Энэ ангийн заалтуудын дагуу нэг жилд үйлдвэрийн талбайд хоёроос олон хянан шалгалт хүлээж авахгүй. Гэхдээ энэ нь 9 дүгээр зүйлийн дагуу хийх хянан шалгалтыг хязгаарлахгүй.

13. Энэ ангийн дагуу хянан шалгалт хийхээр үйлдвэрийн талбайг сонгоходоо Техникийн нарийн бичгийн дарга нарын газар энэхүү хавсралтын энэ хэсэг болон VIII хэсгийн дагуу хуанлийн жилд оролцогч улсын хүлээн авах хянан шалгалтын нэгтгэсэн тоонд дараахь хязгаарлалтыг мөрдөнө: хянан шалгалтын нэгтгэсэн тоо нь гурав дээр энэхүү хавсралтын энэ хэсэг болон VIII хэсгийн дагуу оролцогч улсын мэдүүлсэн үйлдвэрийн талбайн нийт тооны 5 хувийг нэмсэн тоо, эсхүл 20 хянан шалгалтаас, чингэхдээ энэ хоёр тооны аль багаас хэтрэхгүй.

#### Хянан шалгах зорилго

14. А ангийн дагуу мэдүүлсэн үйлдвэрийн талбайд хийх хянан шалгалтын ерөнхий зорилго нь уг үйл ажиллагаа нь мэдүүлэгт заах мэдээлэлд нийцэж буйг нягтлан шалгахад оршино. Хянан шалгалтын тодорхой зорилго нь энэхүү хавсралтын VI хэсэгт нийцсэнээс бусад тохиолдолд I жагсаалтад орсон химийн аливаа бодис байхгүйг, ялангуяа түүнийг үйлдвэрлээгүйг нягтлан шалгахад оршино.

#### Хянан шалгалтын журам

15. Удирдлага болгохоор тохиролцсон зүйлс, энэхүү хавсралтын холбогдох бусад заалт болон Нууцлалын тухай хавсралтаас гадна доорхи 16-гаас 20 дахь хэсгийг хэрэглэнэ.

16. Хянан шалгуулж буй оролцогч улс хүсэлт гаргаагүй бол байгууламжийн тухай хэлэлцээр байгуулахгүй.

17. 1 дэх хэсэгт заасан химийн бодис үйлдвэрлэж буй үйлдвэрийн талбай, ялангуяа, 1 дэх хэсгийн (b) дэд хэсгийн дагуу заасан жагсаалтад орсон ФХФ-үйлдвэр нь хянан шалгахаар сонгосон үйлдвэрийн талбайд хянан шалгалт явуулах гол объект болно. Хянан шалгуулж буй оролцогч улс энэхүү хавсралтын X хэсгийн С ангид заасан удирдлаган дор нэвтрэх журамд нийцүүлэн тэдгээр үйлдвэрт нэвтрэхийг удирдан зохицуулах эрхтэй. Хэрэв энэхүү хавсралтын II хэсгийн 51 дэх хэсэгт

нийцүүлэн хянан шалгах баг бүрхэг байдлыг тодруулахаар үйлдвэрийн талбайн бусад хэсэгт нэвтрэхийг хүсвэл нэвтрэх эрхийн хэмжээг хянан шалгах баг болон хянан шалгуулж буй оролцогч улсын хооронд тохиролцоно.

18. Бүртгэл тэмдэглэлийг үзэх нь хянан шалгалтын зорилтод хүрэхэд тус дөхөм болно гэж хянан шалгах баг болон хянан шалгуулж буй оролцогч улс зөвшөөрсөн тохиолдолд хянан шалгах баг тийнхүү үзэж болно.

19. Химийн бодисын жагсаалтад орсон бөгөөд мэдүүлээгүй химийн бодис байхгүйг шалгахаар дээж авч, газар дээр нь шинжилж болно. Бүрхэг байдлыг шийдвэрлээгүй тохиолдолд хянан шалгуулж буй оролцогч улсын зөвшөөрөлтэйгөөр талбайгаас гаднах лабораториид дээжийг шинжилж болно.

20. Хянан шалгалтын хугацаа 24 цагаас илүү үргэлжлэхгүй; гэхдээ хянан шалгах баг болон хянан шалгуулж буй оролцогч улс хоорондоо тохиролцож хугацааг сунгаж болно.

#### **Хянан шалгалтын тухай мэдэгдэх**

21. Хянан шалгуулах гэж буй үйлдвэрийн талбайд хянан шалгах баг ирэхээс 120-иос доошгүй цагийн өмнө оролцогч улсад хянан шалгалтын тухай Техникийн нарийн бичгийн дарга нарын газар мэдэгдэнэ.

#### **C. Вангийг хэрэгжүүлэх болон хянан үзэх**

##### **Хэрэгжүүлэх**

22. Хэрэв энэхүү конвенц хүчин төгөлдөр болсноос хойш гурав дахь жилд Бага хурал ээлжит чуулганаараа өөрөөр шийдвэрлээгүй бол энэхүү конвенц хүчин төгөлдөр болсноос хойш дөрөв дэх жил эхлэхэд Вангийг хэрэгжиж эхэнэ.

23. Ерөнхий захирал энэхүү конвенц хүчин төгөлдөр болсноос хойш гурав дахь жилд болох Бага хурлын ээлжит чуулганд зориулан энэхүү Хавсралтын VII болон VIII хэсэг, түүнчлэн энэ хэсгийн A вангийн заалтуудыг хэрэгжүүлэх талаархи Техникийн нарийн бичгийн дарга нарын газрын туршлагыг тусгасан илтгэл бэлтгэнэ.

24. Энэхүү конвенц хүчин төгөлдөр болсноос хойш гурав дахь жилд болох ээлжит чуулганаараа Бага хурал ФХФ-үйлдвэр болон химийн бодис үйлдвэрлэх бусад байгууламжийн хооронд Вангийн дагуу нягтлан шалгахад шаардлагатай нөөцийг хуваарилах асуудлыг Ерөнхий захирлын илтгэлийг үндэслэн шийдвэрлэнэ. Үгүй бол, хуваарилалтын асуудлыг Техникийн нарийн бичгийн дарга нарын газрын шинжээчийн дүгнэлтэд орхих бөгөөд 11 дэх хэсэгт заасан чухал хүчин зүйлст нэмнэ.

25. Хянан шалгалтын талаар оролцогч улсуудаас гаргасан саналыг 11 дэх хэсэгт заасан сонгох үйл явц дахь чухал хүчин зүйл гэж харгалзан үзэхүйцээр ямар үндсэн дээр (жишээлбэл, бус нутгийн) толилуулахыг Гүйцэтгэх зөвлөлийн зөвлөснөөр Бага хурал энэхүү конвенц хүчин төгөлдөр болсноос хойш гурав дахь жилд болох ээлжит чуулганаараа шийдвэрлэнэ.

##### **Хянан үзэх**

26. 8 дугаар зүйлийн 22 дахь хэсгийн дагуу зарлан хуралдуулсан Бага хурлын анхны ээлжит бус чуулганаар Нягтлан шалгалтын тухай хавсралтын энэ хэсгийн

заалтуудыг олж авсан туршлагын үндсэн дээр химийн бодисын үйлдвэрлэлд хамаарах нягтлан шалгалтын нийтлэг горимыг иж бүрэн хянан үзэх хүрээнд дахин шалгана. Бага хурал дараа нь нягтлан шалгалтын горимыг улам үр дүнтэй болгохоор зөвлөмж гаргана.

## **X ХЭСЭГ**

### **9 ДҮГЭЭР ЗҮЙЛД ЗААСАН ХҮСЭЛТИЙН ДАГУУ ХИЙХ ХЯНАН ШАЛГАЛТ**

#### **A. Хянан шалгагч болон хянан шалгагчийн туслахыг томилох**

1. 9 дүгээр зүйлд заасан хүсэлтийн дагуу хийх хянан шалгалтыг энэ үүргийг биелүүлэх зорилгоор зөвхөн тусгайлан томилогдсон хянан шалгагч болон хянан шалгагчийн туслах хийнэ. 9 дүгээр зүйлд заасан хүсэлтийн дагуу ердийн хянан шалгалтыг хийх хянан шалгагч болон хянан шалгагчийн туслахыг томилохын тулд Ерөнхий захирал хянан шалгах ердийн үйл ажиллагааны хянан шалгагч болон хянан шалгагчийн туслахуудаас тэдгээрийг сонгож, санал болгох хянан шалгагч болон хянан шалгагчийн туслахын жагсаалтыг гаргана. Уг жагсаалт нь шаардлагатай мэргэшлийг эзэмшсэн, туршлагатай, мэргэжлийн бэлтгэлтэй, мэдлэг чадвартай хангалттай тооны хянан шалгагч болон хянан шалгагчийн туслахуудаас бүрдэх бөгөөд тэдгээрийн боломж, ээлж дарааллын шаардлагыг харгалзан хянан шалгагч нарыг уян хатан байдлаар сонгож болохоор хийгдсэн байна. Үүнтэй холбогдуулан хянан шалгагч болон хянан шалгагчийн туслахыг сонгоходоо аль болох газар зүйн өргөн хүрээг хамруулахыг чухалчилж үзнэ. Хянан шалгагч болон хянан шалгагчийн туслах энэхүү хавсралтын II хэсгийн А ангийн дагуу гаргасан журмыг дагаж мөрдөнө.

2. Ерөнхий захирал хянан шалгах багийн бүрэлдэхүүний хэмжээг тодорхойлж, гаргсан тодорхой хүсэлт, нөхцөл байдлыг харгалzsаны үндсэн дээр түүний гишүүдийг сонгоно. Хянан шалгах багийн бүрэлдэхүүний хэмжээ нь хянан шалгах мандатыг бодитоор хэрэгжүүлэхэд шаардлагатай доод хэмжээнд байна. Хянан шалгах багийн гишүүн нь хүсэлт гаргагч оролцогч улс, эсхүл хянан шалгуулж буй оролцогч улсын харьят бус этгээд байна.

#### **B. Урьдчилсан хянан шалгах үйл ажиллагаа**

3. Хүсэлтийн дагуу хийх хянан шалгалтын хувьд Техникийн нарийн бичгийн дарга нарын газар хүсэлтийн дагуу нэн даруй арга хэмжээг авахад бэлэн байгаа эсэхийн талаар Ерөнхий захирлаас хянан шалгуулах хүсэлтийг хүргүүлэхээс өмнө оролцогч улс бүр нотолгоо хүсч болно. Хэрэв Ерөнхий захирал ийм нотолгоо нэн даруй өгч чадахгүй бол, тэрбээр хүсэлтийг нотлох ажлыг дарааллыг харгалзан аль болох боломжийн хэрээр эрт хийнэ. Түүнчлэн, тэрбээр яаралтай тухайн арга хэмжээг хэзээ авч болох талаар оролцогч улсад мэдээлнэ. Хэрэв Ерөнхий захирал хүсэлтийн дагуу авах арга хэмжээг цаашид авч чадахгүй гэсэн дүгнэлтэд хүрвэл, тэрбээр цаашид нөхцөл байдлыг сайжруулах холбогдох арга хэмжээ авахыг Гүйцэтгэх зөвлөлөөс хүсч болно.

#### **Мэдэгдэл**

4. Гүйцэтгэх зөвлөл болон Ерөнхий захиралд хүргүүлэх хүсэлтийн дагуу хийх хянан шалгах тухай хянан шалгах хүсэлт нь наад зах нь дараах мэдээлэл агуулна:

- (a) хянан шалгалт хийлгэх оролцогч улс, хэрэв боломжтой бол хүлээн авагч улс;
- (b) ашиглагдаж буй нэвтрэх цэг;
- (c) хянан шалгах талбайн хэмжээ, төрөл;
- (d) энэхүү конвенцийг мөрдөхгүй байж болохтой холбоотой асуудал, түүний дотор тухайн асуудлыг үүсгэх энэхүү конвенцийн холбогдох заалтуудын онцлог байдал, мөрдөхгүй байх боломжийн талаархи шинж чанар, нөхцөл байдал, түүнчлэн асуудал үүссэнээс үүдэх холбогдох бүх мэдээлэл;
- (e) хүсэлт гаргагч оролцогч улсын ажиглагчийн нэр.

Хүсэлт гаргагч оролцогч улс шаардлагатай гэж үзсэн нэмэлт аливаа мэдээллийн хүргүүлнэ.

5. Ерөнхий захирал хүсэлт гаргагч оролцогч улсад түүний хүсэлтийг хүлээн авсан тухайгаа нэг цагийн дотор мэдэгдэнэ.

6. Нэвтрэх боомтод хянан шалгах баг хүрэлцэн ирэхээс өмнө 12 цагаас доошгүй хугацаанд хянан шалгалт хийлгэж буй оролцогч улсыг тухайн мэдээллээр Ерөнхий захирал хангах боломж олгох үүднээс хүсэлт гаргагч оролцогч улс хянан шалгах талбайн байршилыг Ерөнхий захиралд мэдэгдэнэ.

7. Хянан шалгах талбайг хүсэлт гаргагч оролцогч улсын хүсэлтээр газар зүйн солбилцлыг маш тодорхой, хэрэв боломжтой бол хамгийн ойролцоо секундийг заасан цэгтэй холбоотой талбайн бүдүүвч зургаар аль болох боломжийн хэрээр тодорхой заана. Хэрэв боломжтой бол хүсэлт гаргагч оролцогч улс хянан шалгах талбайн ерөнхий үзүүлэлттэй газрын зураг болон хянан шалгалт хийгдэх талбайн хүсэлт болгосон периметрийг аль болох боломжийн хэрээр тодорхой заасан бүдүүвч зургийг гаргаж өгнө.

8. Хүсэлт болгосон периметр нь:

(a) аливаа барилга буюу бусад байгууламжийн гадна талаас гадагш наад зах нь 10 метрийн зайд байрласан байх;

(b) хамгаалалтын тухайн бүсийг огтлохгүй байх;

(c) хүсэлт гаргагч оролцогч улс хүсэлт болгосон периметрийн зах хязгаарт оруулах чиг санаа бүхий хамгаалалтын тухайн бүсийн гадна талаас гадагш наад зах нь 10 метрийн байрласан байх.

9. Хэрэв хүсэлт болгосон периметр нь 8 дахь хэсэгт заасан тодорхойлолтод нийцэхгүй бол түүнийг тухайн заалттай нийцүүлэх зорилгоор хянан шалгах баг дахин бүдүүвчилнэ.

10. Ерөнхий захирал нэвтрэх цэгт хянан шалгах баг товлосон хугацаанд хүрэлцэн ирэхээс өмнө 12 цагаас доошгүй хугацаанд 7 дахь хэсэгт тодорхойлсон хянан шалгах газрын байршилын тухай Гүйцэтгэх зөвлөлд мэдэгдэнэ.

11. 10 дахь хэсэгт заасны дагуу Гүйцэтгэх зөвлөлд мэдэгдэхдээ Ерөнхий захирал хянан шалгах хүсэлт, түүний дотор 7 дахь хэсэгт тодорхойлсон хянан шалгах талбайн байршлын талаархи мэдээллийг хянан шалгуулж буй оролцогч улсад илгээнэ. Энэ мэдэгдэлд энэхүү хавсралтын II хэсгийн 32 дахь хэсэгт заасан мэдээллийг мөн оруулна.

12. Нэвтрэх боомтод хянан шалгах баг хүрэлцэн ирэхдээ хянан шалгах мандатын талаар хянан шалгуулж буй оролцогч улсад хянан шалгах баг мэдээлнэ.

**Хянан шалгуулж буй оролцогч улсын, эсхүл хүлээн авагч улсын нутаг дэвсгэрт нэвтрэх**

13. 9 дүгээр зүйлийн 13-18 дахь хэсгийн дагуу Ерөнхий захирал хянан шалгах хүсэлтийг хүлээн авсны дараа аль болох богино хугацаанд хянан шалгах багийг илгээнэ. Хянан шалгах баг 10 болон 11 дэх хэсгийн заалтуудын дагуу аль болох богино хугацаанд хүсэлтэд заасан нэвтрэх боомтод хүрэлцэн ирнэ.

14. Хэрэв хүсэлт болгосон периметрийг хянан шалгуулж буй оролцогч улс хүлээн зөвшөөрвэл, хянан шалгах баг нэвтрэх боомтод хүрэлцэн ирснээс хойш 24 цагийн дотор дээрх хүсэлт болгосон периметрийг аль болох богино хугацаанд эцсийн периметр гэж тогтооно. Хянан шалгуулж буй оролцогч улс хянан шалгах багийг хянан шалгах талбайн эцсийн периметрт хүргэж өгнө. Хэрэв хянан шалгуулж буй оролцогч улс үүнийг шаардлагатай гэж үзвэл, энэ хэсэгт тодорхойлсон эцсийн периметрийг тогтоосон хугацаа өнгөрснөөс хойш 12 цагийн тэднийг хүргэж өгөх ажлыг эхлүүлнэ. Ямар ч тохиолдолд хянан шалгах баг нэвтрэх боомтод хүрэлцэн ирснээс хойш 36 цагийн дотор хүргэж өгөх явдлыг дуусгана.

15. Мэдүүлсэн бүх байгууламжийн хувьд (а) болон (б) дэд хэсэгт заасан журмыг (энэ хэсгийн зорилгод, “мэдүүлсэн байгууламж” гэж 3, 4 болон 5 дугаар зүйлийн дагуу мэдүүлсэн бүх байгууламжуудыг хэлнэ. 6 дугаар зүйлийн хувьд “мэдүүлсэн байгууламж” гэж энэхүү хавсралтын VI хэсгийн дагуу мэдүүлсэн байгууламж түүнчлэн, энэхүү хавсралтын VII хэсгийн 7 болон 10 (с) дэд хэсэг, VIII хэсгийн 7 болон 10 (с) дэд хэсгийн дагуу мэдүүлсэн үйлдвэрийн байгууламжийг зөвхөн хэлнэ) хэрэглэнэ.

(а) Хэрэв хүсэлт болгосон периметр нь мэдүүлсэн периметртэй адил, эсхүл түүний дотор бол мэдүүлсэн периметрийг эцсийн периметр гэж үзнэ. Гэхдээ хянан шалгуулж буй оролцогч улс зөвшөөрсөн бол, эцсийн периметрийг хүсэлт гаргагч оролцогч улсын хүсэлт болгосон периметртэй нийцүүлэн баагсаж болно.

(б) Хянан шалгуулж буй оролцогч улс хянан шалгалтын багийг эцсийн периметрт аль болох богино хугацаанд хүргэж өгөх бөгөөд гэхдээ ямар ч тохиолдолд хянан шалгах баг нэвтрэх боомтод хүрэлцэн ирснээс хойш 24 цагийн дотор периметрт тэднийг ирүүлэх нөхцлийг хангана.

#### **Эцсийн периметрийн нэмэлт периметрийг тогтоох**

16. Хэрэв хянан шалгуулж буй оролцогч улс нэвтрэх боомтонд хүсэлт болгосон периметрийг хүлээн зөвшөөрч чадахгүй бол нэмэлт периметрийг аль болох богино хугацаанд, гэхдээ ямар ч тохиолдолд хянан шалгах баг нэвтрэх боомтод хүрэлцэн ирснээс хойш 24 цагийн дотор санал болгоно. Санал зөрүүтэй тохиолдолд хянан шалгуулж буй оролцогч улс болон хянан шалгах баг эцсийн периметрийг тохиролцох зорилгоор хэлэлцээ хийнэ.

17. Нэмэлт периметрийг 8 дахь хэсэгт заасны дагуу аль болох тодорхой тогтооно. Энэ нь хүсэлт болгосон бүх периметрийг багтаах бөгөөд журам ёсоор тухайн газрын жам ёсны байршил болон тогтоосон хил хязгаарыг харгалзан сүүлчинхтэй нягт холбоотой байна. Хэрэв хамгаалалтын халхавч байгаа бол энэ нь хүрээлэн байгаа тухайн халхавчийн ойролцоо байна. Хянан шалгуулж буй оролцогч улс дараах аргуудаас ядаж хоёрыг нь хослуулж периметрүүдийн хоорондын уялдааг тогтоохыг эрмэлзэнэ:

- (а) хүсэлт болгосон периметрийн талбайгаас мэдэгдэхүйцээр илүү гарсан талбайг үл хамрах нэмэлт периметр;
- (б) хүсэлт болгосон периметрээс бага зэргийн адил зайд байрлах нэмэлт периметр;
- (с) нэмэлт периметрийн талбайгаас хүсэлт болгосон периметрийн ядаж аль нэг хэсэг нь харагдах.

18. Хэрэв нэмэлт периметрийг хянан шалгах баг хүлээн зөвшөөрвөл түүнийг эцсийн периметр гэж үзэх бөгөөд хянан шалгах багийг нэвтрэх боомтоос тухайн периметрт хүргэж өгнө. Хэрэв хянан шалгуулж буй оролцогч улс үүнийг шаардлагатай гэж үзвэл 16 дахь хэсэгт заасан хугацаа дуусахаас өмнө 12 цагийн дотор нэмэлт периметрийг санал болгох зорилгоор тийнхүү хүргэж өгөх явдлыг эхлүүлж болно. Ямар ч тохиолдолд хянан шалгах баг нэвтрэх боомтод хүрэлцэн ирснээс хойш 36 цагийн дотор хүргэж өгөх явдлыг дуусгана.

19. Хэрэв эцсийн периметрийг тохиролцоогүй бол периметрийн талаархи хэлэлцээг аль болох богино хугацаанд дуусгах бөгөөд түүнийг аль ч тохиолдолд хянан шалгах баг нэвтрэх боомтод хүрэлцэн ирснээс хойш 24-өөс илүү цагаар үргэлжлүүлэхгүй. Хэрэв хянан шалгуулж буй оролцогч улс үүнийг шаардлагатай гэж үзвэл 16 дахь хэсэгт заасан хугацаа дуусахаас өмнө 12 цагийн дотор нэмэлт периметрийг санал болгох зорилгоор тийнхүү хүргэж өгөх явдлыг эхлүүлж болно. Ямар ч тохиолдолд хянан шалгах баг нэвтрэх боомтод хүрэлцэн ирснээс хойш 36 цагийн дотор хүргэж өгөх явдлыг дуусгана.

20. Тухайн газарт хүрэлцэн ирсний дараа хэлэлцээ хийх явдлыг хөнгөвчлөх, эцсийн периметрийн талаар тохиролцоонд хүрэх, эцсийн периметрт нэвтрүүлэх зорилгоор хянан шалгуулж буй оролцогч улс хянан шалгах багийг нэмэлт периметрт саадгүй нэвтрүүлнэ.

21. Хэрэв тухайн газарт хянан шалгах баг хүрэлцэн ирснээс хойш 72 цагийн дотор тохиролцоонд хүрч чадаагүй бол нэмэлт периметрийг эцсийн периметр болгон тогтооно.

#### **Байрлалын нягтлан шалгах**

22. Хянан шалгах багийн хүрэлцэн ирсэн хянан шалгалт хийх талбайг хүсэлт гаргагч оролцогч улсаас тодорхойлсон хянан шалгах талбайтай нийцүүлэх явдлыг хөнгөвчлөх зорилгоор хянан шалгах баг байрлал тогтоох батлагдсан тоног төхөөрөмжийг ашиглах эрхтэй бөгөөд түүнчлэн тухайн тоног төхөөрөмжийг зааврых нь дагуу суурилуулах эрхтэй. Хянан шалгах баг газрын зурагт заасан тухайн газрын тэмдэглэгээг үндэслэн түүний байршлийг нягтлан шалгаж болно. Хянан шалгуулж буй оролцогч улс уг асуудлаар хянан шалгах багт туслалцаа үзүүлнэ.

**Хамгаалагдсан талбай, гарцыг хянах**

23. Нэвтрэх боомтод хянан шалгах баг хүрэлцэн ирснээс хойш 12 цагаас илүүгүй хугацааны дараа хянан шалгуулж буй оролцогч улс хүсэлт болгосон периметрээс хуурай газар, агаар болон усан замын тээврийн хэрэгслийг гарах бүх цэгээс гаргах талаархи үйл ажиллагааны талаархи бодит баримтын мэдээллийг цуглуулж эхэлнэ. Тухайн улс нэмэлт буюу эцсийн периметрийн алинд нь түрүүлж ирснээс шалтгаалан хүрэлцэн ирсэн хянан шалгах багд уг мэдээллийг өгнө.

24. Энэ үүргийг замын хуудас, фото зураг, видео бичлэг, эсхүл гарах тухайн үйл ажиллагааг ажиглах зориулалтаар хянан шалгах багаас олгосон химиин илрүүлэгч тоног төхөөрөмжийн тусламжтайгаар мэдээлэл хэлбэрээр цуглуулсан бодит баримтын мэдээллийг цуглуулах аргаар гүйцэтгэж болно. Нөгөө талаас хянан шалгуулж буй оролцогч улс хянан шалгах багийн нэг, эсхүл зарим гишүүнд бие дааж замын хуудас хөтлөх, фото зураг авах, гарч буй тээврийн хэрэгслийн видео бичлэг хийх, эсхүл химиин илрүүлэгч тоног төхөөрөмж ажилглах зэрэг хянан шалгуулж буй оролцогч улс болон хянан шалгах багийн хооронд тохиролцож болох бусад аргаар тухайн үүргийг гүйцэтгүүлэхээр зөвшөөрч болно.

25. Хянан шалгах баг нэмэлт периметр, эсхүл эцсийн периметрийн алинд нь түрүүлж хүрэлцэн ирснээс шалтгаалан хянан шалгах багаас гарах үйл ажиллагааг хянах журмыг хэрэгжүүлэх талбайг хамгаалах ажлыг эхлүүлнэ.

26. Тухайн журамд дараах зүйл багтана: гарч буй тээврийн хэрэгслийн тодорхойлолт, замын хуудсыг бөглөх, фото зураг авах болон хянан шалгах багаас гарч буй тээврийн хөдөлгөөн болон гарч буй тээврийн хэрэгслийн видео бичлэгийг хийх. Хянан шалгах баг гарах өөр ажиллагаа байхгүй эсэхийг хянан шалгахаар периметрийн дагалдах бусад аливаа хэсэгт очих эрхтэй.

27. Хянан шалгах баг болон хянан шалгуулж буй оролцогч улс хооронд тохиролцсон гарцыг хянах үйл ажиллагааны талаархи нэмэлт журамд түүнчлэн дараах зүйл *inter alia* хамаарна:

- (a) мэдрэмтгий багаж ашиглах;
- (b) таамгаар сонгон нэвтрэх;
- (c) дээжинд шинжилгээ хийх.

28. Хамгаалагдсан талбай болон гарцыг хянах бүхий л үйл ажиллагааг периметрийн гадна талаас хэмжигдэх 50 хүртэлх метрийн өргөнтэй периметрийн гадна талын дагуу байрлах зурvasын хүрээнд хэрэгжүүлнэ.

29. Хянан шалгах баг талбайгаас гарах тээврийн хэрэгсэлд нэвтрэх зохицуулалтын дагуу хянан шалгалт хийх эрхтэй. Хянан шалгуулж буй оролцогч улс хянан шалгалтад хамрагдах тээврийн аливаа хэрэгсэлд хянан шалгах баг бүрэн нэвтрэх чадахгүй, хянан шалгах хүсэлтэд тусгасан асуудлыг биелүүлэх боломжгүй гэх зорилгод ашиглахгүй байх тохиолдолд хянан шалгах багд туслах бүхий л боломжит хүчин чармайлтыг гаргана.

30. Талбайд нэвтрэх албан хаагч болон тээврийн хэрэгсэл, талбайгаас гарах албан хаагч болон хувийн зорчигчийг хянан шалгахгүй.

31. Дээр дурдсан журмыг хянан шалгалт явуулах хугацааны туршид хэрэглэх бөгөөд, аль ч үед байгууламжийн хэвийн үйл ажиллагаанд ямар ч шалтгаангүйгээр саад учруулах, эсхүл удаашруулж болохгүй.

**Урьдчилан хянан шалгах заавар, хянан шалгах төлөвлөгөө**

32. Хянан шалгах төлөвлөгөөг боловсруулах ажлыг хөнгөвчлөх зорилгоор хянан шалгуулж буй оролцогч улс талбайд нэвтрүүлэхээс өмнө хянан шалгах багийн аюулгүй байдлыг хангаж, материал-техникийн туслалцаа үзүүлнэ.

33. Урьдчилан хянан шалгах зааврыг энэ Хавсралтын II хэсгийн 37 дахь хэсгийн дагуу явуулна. Урьдчилан хянан шалгах зааврын хэрэгжилтийн тухайд хянан шалгуулж буй оролцогч улс хүсэлтийн дагуу хийх хянан шалгалтын зорилгод хамаарахгүй, мэдрэмж бүхий гэж үзсэн тоног төхөөрөмж, баримт бичгүүд буюу бүсийг хянан шалгах багт тодорхойлж болно. Түүнчлэн талбайг хариуцах албан хаагч талбайн байршлын төлөвлөгөө болон бусад холбогдох шинж чанарын талаар хянан шалгах багт заавар өгнө. Хянан шалгах багт талбайн зохих газар зүйн онцлог байдал болон эргэн тойрон дахь байгууламжийг илэрхийлсэн газрын зураг, эсхүл бүдүүвч зургийг мөн олгоно. Хянан шалгах багийг албан хаагчдын объект болон тайлангийн талаархи мэдээллээр мөн хангана.

34. Урьдчилан хянан шалгах зааварчилгааны дараа хянан шалгах баг холбогдох мэдээллийн үндсэн дээр хянан шалгах багаас явуулах үйл ажиллагаа, түүний дотор нэвтрэхийг хүссэн талбайн тусгай бүсийг тодорхойлсон хянан шалгах анхны төлөвлөгөөг бэлтгэнэ. Хянан шалгах төлөвлөгөөнд түүнчлэн хянан шалгах баг дэд бүлэгт хуваагдах эсэх талаар тусгана. Хянан шалгах төлөвлөгөөг хянан шалгуулж буй оролцогч улсын болон хянан шалгалт явуулж буй талбайн төлөөлөгчдөд өгнө. Түүнийг С хэсэг, түүний дотор нэвтрэх болон үйл ажиллагаатай холбоотой заалтуудын дагуу хэрэгжүүлнэ.

**Периметр явуулах үйл ажиллагаа**

35. Хянан шалгах баг эцсийн периметр, эсхүл нэмэлт периметрийн алинд нь түрүүлж хүрэлцэн ирснээс шалтгаалан энэ хэсэгт заасан журмын дагуу периметрт явуулах үйл ажиллагааг нэн даруй явуулах, хүсэлтийн дагуу хийх хянан шалгалтыг гүйцэтгэж дуусах хүртэл тухайн үйл ажиллагааг үргэлжлүүлэх эрхтэй.

36. Периметрт явуулах үйл ажиллагаа хэрэгжүүлэхдээ, хянан шалгах баг дараах эрхтэй байна:

(а) энэхүү хавсралтын II хэсгийн 27-30 дахь хэсгийн дагуу хяналтын төхөөрөмжийг ашиглах;

(б) ус, агаар, хөрс, эсхүл урсгалаас дээж авах;

(с) хянан шалгах баг болон хянан шалгуулж буй оролцогч улсын хооронд тохиролцсон байж болох аливаа нэмэлт үйл ажиллагааг явуулах.

37. Хянан шалгах багийн периметр явуулах үйл ажиллагааг периметрийн гадна талаас хэмжигдэх 50 хүртэлх метрийн өргөнтэй периметрийн гадна талын дагуу байрлах зурвасын хүрээнд хэрэгжүүлнэ. Хэрэв хянан шалгуулж буй оролцогч улс зөвшөөрвөл хянан шалгах баг периметрийн зурvas дахь аливаа барилга байгууламж буюу бүтцэд нэвтэрч болно. Зайнаас хийх хяналт шалгалтын төхөөрөмж нь дотогшоо

хандсан байна. Мэдүүлсэн байгууламжийн хувьд тухайн зуравс нь хянан шалгуулж буй оролцогч улсын үзэмжээр мэдүүлсэн периметрийн дотор, эсхүл гадна талаар, эсхүл аль алинаар дайрч болно.

### **C. Хянан шалгалт хийх**

#### **Ерөнхий журам**

38. Хянан шалгуулж буй оролцогч улс хүсэлт болгосон периметрт түүнчлэн хэрэв энэ нь ялгаатай бол эцсийн периметрт нэвтрэх нөхцлийг хангана. Тэдгээр периметрийн доторх тодорхой газар буюу газруудад нэвтрэх түвшин болон шинж чанарыг хянан шалгах баг болон хянан шалгуулж буй оролцогч улс нэвтрэх зохицуулалтыг үндэслэн хоорондоо тохиролцоно.

39. Хянан шалгуулж буй оролцогч улс хүсэлт болгосон периметрт аль болох богино хугацаанд гэхдээ ямар ч тохиолдолд хянан шалгах хүсэлт гаргаснаар энэ конвенцийг биелүүлэхгүй байх боломжтой холбоотой асуудлыг тодруулах зорилгоор хянан шалгах баг нэвтрэх боомтод хүрэлцэн ирснээс хойш 108 цагаас илүүгүй хугацаанд нэвтрэх нөхцлөөр хангана.

40. Хянан шалгах багийн хүсэлтийн дагуу хянан шалгуулж буй оролцогч улс хянан шалгах талбайд агаараар нэвтрэх нөхцлийг олгоно.

41. 38 дахь хэсэгт заасан нэвтрэх нөхцлийг олгох шаардлагыг биелүүлэхдээ хянан шалгуулж буй оролцогч улс өмчлөх эрх, эсхүл эрж хайх болон хураахтай холбоотой байж болох үндсэн хуулийн аливаа үүргийг харгалзан хамгийн дээд түвшинд нэвтрүүлэх үүргийг дагаж мөрдөнө. Хянан шалгуулж буй оролцогч улс нэвтрэх зохицуулалтын үндсэн дээр үндэсний аюулгүй байдлыг хамгаалахад шаардлагатай тийм арга хэмжээг авах эрхтэй. Хянан шалгуулж буй оролцогч улс энэхүү конвенцоор хориглосон үйл ажиллагаанд оролцохгүй байх өөрийн үүргээс татгалзаж байгаа гэж энэ хэсгийн заалтуудыг ишлэл болгохгүй.

42. Хэрэв хянан шалгуулж буй улс байгууламж, үйл ажиллагаа эсхүл мэдээлэлд нэвтрэх бүрэн бус нөхцөл олговол тэрээр хүсэлтийн дагуу хийх хянан шалгалтыг төөрөгдүүлэхтэй холбогдож гарах биелүүлэхгүй байж болох асуудлыг тодруулахад нэмэлт арга хэмжээгээр хангах бүхий л зохих хүчин чармайлтыг авах үүрэгтэй.

43. 4, 5 болон 6 дугаар зүйлийн дагуу мэдүүлсэн байгууламжийн эцсийн периметрт хүрэлцэн ирмэгц урьдчилсан хянан шалгах талаар зааварчилгаа болон хамгийн наад захын шаардлагыг хангасан хянан шалгах төлөвлөгөөг хэлэлцээний дараа нэвтрэх эрхийг олгох бөгөөд аль ч тохиолдолд энэ нь гурван цагаас хэтрэхгүй байна. Мэдүүлсэн байгууламжийн хувьд 3 дугаар зүйлийн 1 (d) хэсгийн дагуу хэлэлцээг эхлүүлэх бөгөөд эцсийн периметрт хүрэлцэн ирснээс хойш 12 цагийн дотор зохицуулалттайгаар нэвтрэнэ.

44. Хянан шалгах хүсэлтийн дагуу хүсэлтээр хийх хянан шалгалтын явуулахдаа хянан шалгах баг энэхүү конвенцийн заалтыг биелүүлэхгүй байж болохтой холбоотой асуудлыг тодруулах зорилгоор хангалттай баримтыг тогтооход шаардлагатай тийм арга хэмжээг авах бөгөөд түүнтэй холбоогүй бусад үйл ажиллагаанаас татгалзана. Тэрээр хянан шалгуулж буй оролцогч улсаас энэхүү конвенцийн заалтыг биелүүлэхгүй байж болохтой холбоотой тийм баримтыг цуглувж баримтжуулах бөгөөд хянан шалгуулж буй оролцогч улс үүний талаар хүсэлт тавиагүй бол түүнтэй илэрхий холбоогүй

мэдээллийг цуглуулж баримтжуулахгүй. Тухайн хэрэгтэй холбоогүй болсон цуглуулагдсан болон нэмэлт аливаа материалыг хадгалахгүй.

45. Хянан шалгах баг өөрийн зорилгыг үр дүнтэй, цаг хугацаанд нь биелүүлэх, хамгийн нарийн аргаар хүсэлтийн дагуу хийх хянан шалгалтыг явуулах зарчмыг удирдлага болгоно. Энэ нь боломжтой бол тухайн баг хэрэглэж болох наад захын нарийн журмыг бүх тохиолдолд хэрэглэх бөгөөд шаардлагатай гэж үзвэл илүү нарийн зохицуулалт бүхий нарийн журмыг ашиглана.

#### Зохицуулалттай нэвтрэх

46. Хянан шалгах баг хянан шалгах төлөвлөгөөнд хянан шалгалтын аль ч үед хянан шалгуулж буй оролцогч улсаас оруулж болох өөрчлөлт болон санал, түүний дотор химиин зэвсэгтэй холбоогүй өндөр мэдрэмж бүхий тоног төхөөрөмж, мэдээлэл, эсхүл бүсийг хамгаалах талаар урьдчилан хянан шалгах зааварчилгааг харгалзан үзнэ.

47. Хянан шалгуулж буй оролцогч улс нэвтрэхэд ашиглах периметрийн орох/гараах цэгийг тогтооно. Хянан шалгах баг болон хянан шалгуулж буй оролцогч улс дараах зүйлийн талаар хэлэлцээ хийнэ: 48 дахь хэсэгт заасан эцсийн буюу хүсэлт болгосон периметрийн хүрээнд тодорхой аливаа газар буюу газруудад нэвтрэх түвшин; хянан шалгах багаас явуулах тодорхой аливаа үйл ажиллагаа, түүний дотор дээж авах; хянан шалгуулж буй оролцогч улсаас тодорхой үйл ажиллагааг явуулах; болон хянан шалгуулж буй оролцогч улсаас тодорхой мэдээллээр хангах.

48. Нууцлалын тухай хавсралтын холбогдох заалтуудад нийцүүлэн хянан шалгуулж буй оролцогч улс нууц мэдээлэл болон химиин зэвсэгтэй холбоогүй мэдээллийг задлахаас урьдчилан сэргийлэх, мэдрэмж бүхий төхөөрөмжийг хамгаалах арга хэмжээг авах эрхтэй. Тийм арга хэмжээнд дараах зүйлүүд багтана:

- (a) албан газраас мэдрэмж бүхий баримт бичгүүдийг гаргах;
- (b) мэдрэмж бүхий самбар, өмч хөрөнгө болон тоног төхөөрөмжийг нуух;
- (c) мэдрэмж бүхий компьютер, эсхүл цахим системийн мэдрэмж бүхий тоног төхөөрөмжийн элементийг нуух;
- (d) компьютерийн системийг хязгаарлах болон илрүүлэх төхөөрөмжийг унтраах;
- (e) I, II болон III жагсаалтад дурдсан химиин бодис байгаа, эсхүл байхгүй эсэхийг тогтоох зорилгоор дээжинд хийсэн дүгнэлтийг хязгаарлах;
- (f) хянан шалгагчдад хянан шалгах зүйлийн тодорхой хувь хэмжээ, эсхүл барилга байгууламжийн тоог үзэмжээрээ сонгохыг санал болгож хянан шалгалтыг явуулах үзэмжээрээ сонгон нэвтрэх аргыг ашиглах; энэ зарчмыг барилга байгууламжийн дотоод хэсэг болон мэдрэмж бүхий хэсэгт мөн адил хэрэглэнэ;
- (g) зарим хязгаарлагдмал тохиолдолд зөвхөн тусгай хянан шалгагчдыг хянан шалгах талбайн тодорхой хэсэгт нэвтрүүлэх.

49. Хянан шалгуулж буй оролцогч улс аливаа эд зүйл, барилга, байгууламж, чингэлэг, эсхүл тээврийн хэрэгсэлд хянан шалгах баг бүрэн нэвтрээгүй, эсхүл 48 дахь хэсгийн дагуу хамгаалагдсан бол биелүүлэх боломжгүй асуудлыг тусгасан хянан

шалгах хүсэлтэд хамаарах зорилгод эдгээрийг ашиглахгүй байх талаар хянан шалгах багт таниулах боломжит бүхий л хүчин чармайлтыг гаргана.

50. Үүнийг *inter alia* агаар мандлын нөлөөллөөс хамгаалахын тулд бүрхүүлийг нь хэсэгчлэн авах, эсхүл бүтээх зэргээр хянан шалгуулж буй оролцогч улсын үзэмжийн дагуу хаалттай орон зайн доторхийг нэвтрэх хэсгээс нь харуулах байдлаар хянан шалгах аргаар, эсхүл бусад аргаар хийнэ.

51. 4, 5 болон 6 дугаар зүйлийн дагуу мэдүүлсэн байгууламжийн хувьд дараахь зүйлийг хэрэглэнэ:

(а) байгууламжийн хэлэлцээрт заасан байгууламжийн хувьд эцсийн периметрт нэвтрэх болон түүний хүрээнд явуулах үйл ажиллагааг хэлэлцээрээр тогтоосон хил хязгаарын дотор хэрэгжүүлнэ;

(б) байгууламжийн хэлэлцээрт заагаагүй байгууламжийн хувьд нэвтрэх талаархи хэлэлцээ болон үйл ажиллагааг энэхүү конвенцийн дагуу тогтоосон хянан шалгах нийтлэг хэрэглэгдэх үндсэн зарчмын зохицуулна;

(с) 4, 5 болон 6 дугаар зүйлийн дагуу явуулах хянан шалгалтын хувьд нэвтрэх эрхийн хүрээнээс гадна нэвтрэх асуудлыг энэ хэсгийн журмын дагуу зохицуулна.

52. 3 дугаар зүйлийн 1 (d) хэсгийн дагуу мэдүүлсэн байгууламжийн хувьд дараахь зүйлийг хэрэглэнэ: хэрэв хянан шалгуулж буй оролцогч улс 47 болон 48 дахь хэсгийн журмыг хэрэглэн химиин зэвсэгтэй холбоогүй газар, эсхүл байгууламжид бүрэн нэвтрэх эрх олгоогүй бол биелүүлэх боломжгүй асуудлыг тусгасан хянан шалгах хүсэлтэд хамаарах зорилгод тухайн газар, эсхүл байгууламжийг ашиглахгүй байх талаар хянан шалгах багт таниулах боломжит бүхий л хүчин чармайлтыг гаргана.

#### Ажиглагч

53. 9 дүгээр зүйлийн 12 дахь хэсгийн заалтуудын дагуу хүсэлтийн дагуу хийх хянан шалгалтад ажиглагч оролцуулахад хүсэлт гаргагч оролцогч улс хянан шалгах баг ирсэн зохих хугацаанд түүнтэй адил нэвтрэх боомтод ажиглагч ирүүлэх асуудлыг зохицуулахаар Техникийн нарийн бичгийн дарга нарын газартай харилцана.

54. Ажиглагч хянан шалгалтын хугацаанд хянан шалгуулж буй оролцогч улсад, эсхүл хүлээн авагч улсад байгаа хүсэлт гаргагч оролцогч улсын элчин сайд яам, эсхүл элчин сайдын яам байхгүй тохиолдолд хүсэлт гаргагч оролцогч улстай байнга холбоотой байх эрхтэй. Хянан шалгуулж буй оролцогч улс ажиглагчийг холбооны хэрэгслээр хангана.

55. Ажиглагч хянан шалгах талбайн нэмэлт, эсхүл эцсийн периметрийн аль нэгэнд нь ямар ч нөхцөлд түрүүлж ирэх, хянан шалгуулж буй оролцогч улсаас заасан хянан шалгах талбайд нэвтрэх эрхтэй. Хянан шалгах баг шаардлагатай гэж үзвэл ажиглагч түүнд зөвлөмж өгөх эрхтэй. Хянан шалгалтын хугацаанд хянан шалгах баг хянан шалгалтын үйл ажиллагаа болон дүгнэлтийн тухай ажиглагчид байнга мэдээлж байна.

56. Тухайн оронд байх хугацаанд нь хянан шалгуулж буй оролцогч улс ажиглагчийг холбооны хэрэгсэл, орчуулагч, тээврийн хэрэгсэл, ажлын болон амьдрах орон байр, хоол хүнс болон эмнэлгийн тусламж зэрэг шаардлагатай үйлчилгээгээр хангана. Хянан шалгуулж буй оролцогч улсын, эсхүл хүлээн авагч улсын нутаг

дэвсгэрт ажиглагч хүрэлцэн ирэхтэй холбоотой бүхий л зардлыг хүсэлт гаргагч оролцогч улс хариуцана.

#### Хянан шалгах хугацаа

57. Хянан шалгалтын хугацаа хянан шалгуулж буй оролцогч улстай байгуулсан хэлэлцээрээр сунгаагүй бол 84 цагаас хэтрэхгүй байна.

#### **D. Хянан шалгалтын дараах үйл ажиллагаа**

##### Буцах

58. Хянан шалгах талбайд хянан шалгалтын журмыг биелүүлснээр хянан шалгах болон хүсэлт гаргагч оролцогч улсын ажиглагч нэвтрэх боомтод нэн даруй хүрэлцэн ирэх бөгөөд аль болох богино хугацаанд хянан шалгуулж буй оролцогч улсын нутаг дэвсгэрээс гарна.

##### Илтгэл

59. Хянан шалгах тухай илтгэлд хянан шалгах багаас явуулсан үйл ажиллагаа, ялангуяа хүсэлтийн дагуу хийх хянан шалгалтын хүсэлтэд дурдсан энэхүү конвенцийг биелүүлэхгүй байх боломжтой холбоотой асуудалд бодит дүгнэлт хийсэн тухай ерөнхийлөн дүгнэж, энэхүү конвенцид шууд хамаарах мэдээллээр хязгаарлагдана. Уг илтгэлд хянан шалгагчдыг нэвтрүүлсэн байдал болон тэдэнд үзүүлсэн туслалцаа шинж байдлын талаархи хянан шалгах багийн дүгнэлт оруулахаас гадна, хянан шалгалтын мандатыг бүрэн хэрэгжүүлэх түвшний талаар мөн оруулна. Хүсэлтийн дагуу хийх хянан шалгах хүсэлтэд дурдсан энэхүү конвенцийг биелүүлэхгүй байх боломжтой холбоотой нарийвчилсан мэдээллийг төгсгөлийн илтгэл хавсралт болгох бөгөөд мэдрэмж бүхий мэдээллийг хамгаалахтай холбогдох заалтыг мөрдөх нөхцөлөөр Техникийн нарийн бичгийн дарга нарын газарт хадгалуулна.

60. Хянан шалгах баг өөрийн ажлын үндсэн байранд ирсний дараа 72 цагаас хойшгүй хугацаанд хянан шалгалтын тухай урьдчилсан илтгэлийг Нууцлалын тухай хавсралтын 17 дахь хэсгийг *inter alia* харгалzan үзэж Ерөнхий захиралд хүргүүлнэ. Ерөнхий захирал хянан шалгалтын тухай урьдчилсан илтгэлийг хүсэлт гаргагч оролцогч улс, хянан шалгуулж буй оролцогч улс болон Гүйцэтгэх зөвлөлд нэн даруй хүргүүлнэ.

61. Хянан шалгах тухай илтгэлийн эцсийн төслийг хүсэлтийн дагуу хийх хянан шалгалт дууссаны дараа 20 хоногоос илүүгүй хугацаанд хянан шалгуулж буй оролцогч улс хийнэ. Хянан шалгуулж буй оролцогч улс химийн зэвсэгтэй холбоогүй, эсхүл тэдний үзэж байгаагаар Техникийн нарийн бичгийн дарга нарын газраас гадагш гарах ёсгүй нууцад хамаарах аливаа мэдээллийг тодорхойлох эрхтэй. Техникийн нарийн бичгийн дарга нарын газар хянан шалгуулж буй оролцогч улсаас гаргасан хянан шалгалтын тухай илтгэлийн эцсийн төслийг өөрчлөх саналыг авч үзэх бөгөөд ямар ч тохиолдолд боломжтой бол түүнийг батална. Дараа нь төслийн эцсийн хувилбарыг хүсэлтийн дагуу хийх хянан шалгалт дууссанас хойш 30-аас илүүгүй хоногийн хугацаанд цаашид тараах болон 9 дүгээр зүйлийн 21-ээс 25 дахь хэсэгт заасны дагуу хэлэлцүүлэхээр Ерөнхий захиралд өгнө.

## XI ХЭСЭГ

### ХИМИЙН ЗЭВСГИЙГ АШИГЛАСАН БАЙЖ БОЛОХ ТОХИОЛДОЛД ЯВУУЛАХ МӨРДӨН БАЙЦААЛТ

#### A. Ерөнхий заалтууд

- Химийн зэвсгийг хэрэглэсэн гэж сэжиглэж буй, эсхүл дайн өдөөх хэлбэртэй үймээнийг зогсоох зорилгоор химийн арга хэрэгслийг хэрэглэсэн гэж сэжиглэх тохиолдолд 9 болон 10 дугаар зүйлийн дагуу үүсгэх мөрдөн байцаалтыг энэхүү хавсралт болон Ерөнхий захирлаас тогтоосон журмын дагуу явуулна.
- Тусгай журамд хамаарах дор дурдсан нэмэлт заалтууд химийн зэвсгийг ашигласан гэж сэжиглэх тохиолдолд шаардагдана.

#### B. Урьдчилсан хянан шалгалтын үйл ажиллагаа

##### Мөрдөн байцаалт явуулах хүсэлт

- Химийн зэвсгийг ашигласан гэж сэжиглэх тохиолдолд мөрдөн байцаалт явуулах хүсэлтийг Ерөнхий захиралд аль болох боломжийн хугацаанд хүргүүлэх бөгөөд түүнд дараахь мэдээллийг тусгана:

- (a) нутаг дэвсгэрт нь химийн зэвсэг хэрэглэсэн гэж сэжиглэгдэж буй оролцогч улс;
- (b) орох цэг, эсхүл нэвтрэхэд санал болгосон аюулгүй маршрут;
- (c) химийн зэвсгийг хэрэглэсэн гэж сэжиглэгдэж буй бүсийн байршил, шинж чанар;
- (d) химийн зэвсгийг хэрэглэсэн гэж сэжиглэж буй цаг хугацаа;
- (e) хэрэглэсэн гэж сэжиглэгдэж буй химийн зэвсгийн төрөл;
- (f) хэрэглэсэн гэж сэжиглэж буй түвшин;
- (g) хорт химийн бодисын шинж чанарын боломжит тодорхойлолт;
- (h) хүн, амьтан болон ургамалд үзүүлэх нөлөөлөл;
- (i) хэрэв шаардлагатай бол тодорхой төрлийн туслалцааг хүсэх.

- Мөрдөн байцаалт явуулахыг хүссэн оролцогч улс шаардлагатай гэж үзсэн нэмэлт алива мэдээллийг хэдийд ч хүргүүлж болно.

##### Мэдэгдэл

- Ерөнхий захирал хүсэлт гаргагч оролцогч улсад түүний хүсэлтийг хүлээн авсан тухайгаа нэн даруй мэдэгдэж Гүйцэтгэх зөвлөл болон оролцогч бүх улсад энэ тухай мэдээлнэ.

6. Зохих үед Ерөнхий захирал нутаг дэвсгэрт нь мөрдөн байцаалт явуулахыг хүссэн оролцогч улсад мэдэгдэнэ. Ерөнхий захирал хэрэв мөрдөн байцаалт явуулахад оролцогч бусад улсын нутаг дэвсгэрт нэвтрэх шаардлагатай бол тэдгээрт энэ тухай мэдэгдэнэ.

#### Хянан шалгах багийг томилох

7. Ерөнхий захирал химиийн бодисыг ашигласан гэж сэжиглэгдэх тохиолдолд мөрдөн байцаалт явуулахад шаардагдаж болох тодорхой салбарт мэргэшсэн шинжээчийн жагсаалтыг бэлтгэж энэ жагсаалтыг байнга шинэчилж байна. Уг жагсаалтын талаар энэхүү конвенц хүчин төгөлдөр болсноос хойш 30 хоногоос илүүгүй хугацаанд болон жагсаалтад өөрчлөлт орсны дараа оролцогч улс бүрт мэдээлж байна. Оролцогч улс уг жагсаалтыг хүлээн авснаас хойш 30 хоногийн хугацаанд түүнийг хүлээн зөвшөөрөхгүй байгаагаа бичгээр мэдэгдээгүй тохиолдолд эл жагсаалтад орсон аливаа мэргэшсэн шинжээчийг томилогдсон гэж үзнэ.

8. Ерөнхий захирал хүсэлтэд заасан тодорхой нөхцөл байдал, онцгой шинж чанарыг харгалзан хүсэлтийн дагуу хийх хянан шалгалтыг хийхээр урьд нь томилогдсон хянан шалгагч болон хянан шалгагчийн туслахаас хянан шалгах багийн ахлагч, гишүүдийг сонгоно. Үүнээс гадна өмнө нь томилогдсон хянан шалгагчдын дунд тодорхой мөрдөн байцаалтыг зохих хэмжээнд явуулахад шаардлагатай шинжээч байхгүй байна гэж Ерөнхий захирал үзвэл мэргэшсэн шинжээчдийн жагсаалтаас нэмэлт болгон хянан шалгах багийн гишүүдийг сонгож болно.

9. Ерөнхий захирал хянан шалгах багийн зааварчилгааг хэрэгжүүлэхдээ хүсэлт гаргагч оролцогч улсаас өгсөн аливаа нэмэлт мэдээлэл, эсхул хянан шалгалтыг илүү үр дүнтэй хурдан хийх нөхцлийг хангах аливаа бусад эх үүсвэрийг ашиглана.

#### Хянан шалгах багийг илгээх

10. Химиийн зэвсгийг ашигласан гэж сэжиглэгдэх тохиолдолд мөрдөн байцаалт явуулах хүсэлтийг хүлээн авсны дараа Ерөнхий захирал оролцогч холбогдох улстай нэн даруй холбоо барих замаар багийг хүлээн авах талаар тохиролцох талаар хүсэлт гаргаж аюулгүй байдлыг хангуулах нотолгоо гаргуулна.

11. Ерөнхий захирал багийн аюулгүй байдлын харгалзан аль болох богино хугацаанд багийг илгээнэ.

12. Хэрэв хянан шалгах баг хүсэлт хүлээн авснаас хойш 24 цагийн дотор гараагүй бол Ерөнхий захирал saatсан тухай шалтгааныг Гүйцэтгэх зөвлөл болон оролцогч улсуудад мэдээлнэ.

#### Зааварчилгаа

13. Хянан шалгах баг хянан шалгах хугацаанд хэдийд ч хянан шалгуулж буй оролцогч улсын төлөөлөгчдөөс зааварчилгаа авах эрхтэй.

14. Хянан шалгалт явуулахаас өмнө хянан шалгах баг материал-техникийн хангамж болон техникийн аюулгүй байдлыг хангахад хэрэглэх хянан шалгах төлөвлөгөөг бэлтгэнэ. Хянан шалгах төлөвлөгөөг шаардлага гарсан үед шинэчилж байна.

## **С. Хянан шалгах ажиллагаа явуулах**

### **Нэвтрэх**

15. Хянан шалгах баг химийн зэвсгийг ашигласан гэж сэжиглэгдэж буй аливаа болон бүх бүсэд нэвтрэх эрхтэй. Тухайн баг химийн зэвсгийг ашигласан гэж сэжиглэгдэх тохиолдолд идэвхтэй мөрдөн байцаалт явуулахад шаардлагатай гэж үзэж буй эмнэлэг, дүрвэгсэдийн хуарин болон бусад байранд нэвтрэх эрхтэй. Тийнхүү нэвтрэхдээ хянан шалгах баг хянан шалгуулж буй оролцогч улстай зөвлөлдөнө.

### **Дээж авах**

16. Хянан шалгах баг шаардлагатай гэж үзэж буй төрөл, тоо хэмжээгээр дээж авах эрхтэй. Хэрэв хянан шалгах баг үүнийг шаардлагатай гэж үзэж, холбогдох хүсэлт гаргавал хянан шалгуулж буй оролцогч улс хянан шалгагч, хянан шалгагчийн туслахын хяналтын дор дээжийг цуглуулахад туслалцаа үзүүлнэ. Хянан шалгуулж буй оролцогч улс хэрэглэсэн гэж сэжиглэгдэж буй газрын зэргэлдээх талбай болон хянан шалгах багийн хүссэн бусад бүсээс холбогдох хяналтын дээж авахыг нь зөвшөөрөх бөгөөд түүнд энэ талаар зохих туслалцаа үзүүлнэ.

17. Хэрэглэсэн гэж сэжиглэгдэж байгаа тохиолдлыг мөрдөн байцаахад чухал гэж тооцогдох дээжинд химийн хорт бодис, зэвсэг хэрэгсэл болон төхөөрөмж, зэвсэг хэрэгслийн үлдэгдэл, байгалийн зэрэг дээж (агаар, хөрс, ургамал, ус, цас гэх мэтийн дээжис) хүн, эсхүл амьтнаас гаралтай био-эмнэлгийн дээж (цус, шээс, ялгадас, эд эс гэх мэтийн дээжис) тус тус хамаарна.

18. Хэрэв цуглуулсан дээжийг олшруулах боломжгүй бол дүгнэлтийг байгууламжийн гадна орших лабораторид хийлгэж, үлдсэн дээжийг дүгнэлт хийсний дараа хүсэлтийн дагуу хянан шалгуулж буй оролцогч улсад эгүүлэн өгнө.

### **Хянан шалгах талбайг томсгох**

19. Хэрэв хянан шалгалтын явцад хянан шалгах баг оролцогч хөрш улсад мөрдөн байцаалтыг явуулах шаардлагатай гэж үзвэл Ерөнхий захирал оролцогч тухайн улсын нутаг дэвсгэрт нэвтрэх шаардлагын тухай түүнд мэдэгдэх бөгөөд багийг хүлээн авах талаар тохиролцох талаар хүсэлт гаргаж аюулгүй байдлыг хангуулах нотолгоо гаргуулна.

### **Хянан шалгах хугацааг сунгах**

20. Хэрэв мөрдөн байцаалттай холбоотой тусгай бүсэд аюулгүй нэвтрэх боломжгүй гэж хянан шалгах баг үзвэл хүсэлт гаргагч оролцогч улсад нэн даруй мэдэгдэнэ. Хэрэв шаардлагатай бол хянан шалгах хугацааг аюулгүй нэвтрэх нөхцөл бүрдэх, хянан шалгах баг өөрийн үүргийг биелүүлж дуусах хүртэл хугацааг сунгана.

### **Асуулга**

21. Хянан шалгах баг химийн зэвсгийг хэрэглэсэн гэж сэжиглэгдсэнээс үүдэж үр дүнд нь өртөгдсөн байж болох аливаа этгээдэд асуулга тавьж, шалгах эрхтэй. Түүнчлэн, тэрээр химийн зэвсгийг хэрэглэсэн гэж сэжиглэгдсэн тохиолдолд түүнийг харсан гэрч, эмнэлгийн албан хаагч, бусад этгээд болон химийн зэвсгийг хэрэглэсэн гэж сэжиглэгдсэнээс үүдэж үр дүнд нь өртөгдөж эмчилгээ хийлгэсэн, эсхүл тухайн этгээдүүдтэй холбоотой байж болох этгээдэд асуулга тавих эрхтэй. Хянан шалгах баг

өвчтөний түүх байгаа бол түүнийг үзэж болох бөгөөд, зохих үед химиин зэвсгийг хэрэглэсэн гэж сэжиглэгдсэнээс үүдэж үр дүнд нь өртөгсдийн цогцсонд задлан хийхэд оролцохыг тэдэнд зөвшөөрнө.

#### **D. Илтгэл**

##### Журам

22. Хянан шалгах баг хянан шалгуулж буй оролцогч улсын нутаг дэвсгэрт ирснээс хойш 24 цагаас илүүгүй хугацаанд нөхцөл байдлын тухай илтгэлийг Ерөнхий захиралд илгээнэ. Тухайн баг мөрдөн байцаалтын явцад шаардлагатай бол явцын тухай илтгэлийг мөн илгээнэ.

23. Хянан шалгах баг өөрийн ажлын үндсэн байранд ирсний дараа 72 цагаас хойшгүй хугацаанд хянан шалгалтын тухай урьдчилсан илтгэлийг Ерөнхий захиралд хүргүүлнэ. Илтгэлийн эцсийн хувилбарыг өөрийн ажлын үндсэн байранд ирсний дараа 30 хоногоос илүүгүй хугацаанд Ерөнхий захиралд хүргүүлнэ. Ерөнхий захирал урьдчилсан болон илтгэлийн эцсийн хувилбарыг Гүйцэтгэх зөвлөл болон оролцогч бус улсад нэн даруй хүргүүлнэ.

##### Агуулга

24. Нөхцөл байдлын тухай илтгэлд туслалцаа үзүүлэх яаралтай шаардлага болон бусад холбогдох мэдээллийг тусгана. Явцын тухай илтгэлд мөрдөн байцаалтын явцад тодорхойлж болох үзүүлэх туслалцаа болон цаашдын яаралтай шаардлагын тухай тусгана.

25. Төгсгөлийн илтгэлд хянан шалгалтын талаархи ,тухайлбал хүсэлтэд дурдсан ашигласан гэж сэжиглэгдэх нөхцөлтэй холбоотой бодит дүгнэлтийг тусгана. Үүнээс гадгна ашигласан гэж сэжиглэгдэх тохиолдолд мөрдөн байцаалт явуулсан тухай илтгэлд мөрдөн байцаалтын явц, дараах зүйлийг агуулсан түүний янз бүрийн үе шатыг нэмэлт болгон тодорхойлж оруулна:

(а) дээж авсан газар болон хугацаа, шинжилгээ хийсэн газар; болон

(б) нотлох баримт, түүнчлэн асуулга явуулсан бичлэг, эмнэлгийн үзлэгийн үр дүн, шинжлэх ухааны дүгнэлт, хянан шалгах багаас шалгасан баримт бичгүүд.

26. Хэрэв хянан шалгах баг дээжийг лаборатороор шинжлэх хугацаанд аливаа бохирдол, эсхүл бусад бодисыг *inter alia* тодорхойлох зорилгоор хэрэглэсэн аливаа химиин зэвсгийн үүсвэрийг тогтооход үйлчилж болох түүний мөрдөн байцаалтад хамаарах мэдээллийг цуглувансан бол тухайн мэдээллийг илтгэлд оруулна.

#### **E. Энэхүү конвенцийн оролцогч бус улсууд**

27. Энэхүү конвенцийн оролцогч бус улс оролцсон, эсхүл оролцогч улсын хяналтан дор байдаггүй нутаг дэвсгэрт химиин зэвсгийг ашигласан сэжиглэгдэх тохиолдолд Байгууллага Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргатай нягт хамтран ажиллана. Зохих хүсэлтийн дагуу Байгууллага Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргын мэдэлд захиран зарцуулуулахаар өөрийн эх үүсвэрийг өгнө.

**НУУЦ МЭДЭЭЛЛИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХАВСРАЛТ  
(“НУУЦЛАЛЫН ТУХАЙ ХАВСРАЛТ”)**

**A. Нууц мэдээлэлтэй харьцах ерөнхий зарчим**

1. Нууц мэдээллийг хамгаалах үүрэг нь иргэний болон цэргийн үйл ажиллагаа, байгууламжийн аль алины нягтлан шалгалтад хамаарна. 8 дугаар зүйлд заасан ерөнхий үүргийн дагуу Байгууллага нь:

(a) энэхүү конвенцоор хүлээсэн үүрэг хариуцлагаа цаг тухайд нь үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардлагатай хамгийн бага хэмжээний мэдээлэл, тоо баримтыг зөвхөн шаардана;

(b) техникийн нарийн бичгийн дарга нарын газрын хянан шалгагч нар болон бусад ажилтан у, ажлын үр ашиг, ур чадвар, шударга байдлын дээд жишгийг хангахад шаардлагатай арга хэмжээг авна;

(c) энэхүү конвенцийн заалтыг хэрэгжүүлэх үүднээс хэлэлцээр, дүрэм боловсруулах бөгөөд хүрэх боломжийг оролцогч улсаас Байгууллагад олгох мэдээллийг аль болох тодорхой заана.

2. Ерөнхий захирал нууц мэдээллийн хамгаалалтыг хангах үндсэн үүрэг хариуцлагатай. Ерөнхий захирал Техникийн нарийн бичгийн дарга нарын газрын нууц мэдээлэлтэй харьцахыг зохицуулах чанд дэглэм тогтоох бөгөөд чингэхдээ дараах зүйлийг удирдлага болгон мөрдөнө:

(a) мэдээллийг дараах тохиолдолд нууц гэж үзнэ:

(i) мэдээллийг олж авсан эх сурвалж болох болон энэхүү мэдээлэл хамаарах оролцогч улс ингэж тогтоосон;

(ii) Ерөнхий захирлын бодлоор мэдээллийг зөвшөөрөлгүйгээр задлах нь уг мэдээлэлийн хамаарах оролцогч улсад эсхүл энэхүү конвенцийг хэрэгжүүлэх механизмд хохирол учруулна гэх үндэслэл байгаа;

(b) Техникийн нарийн бичгийн дарга нарын газрын олж авсан бүх тоо баримт болон мэдээлэлийг нууц мэдээлэл агуулсан эсэхийг тогтоох зорилгоор Техникийн нарийн бичгийн дарга нарын газрын зохих нэгж дүгнэнэ. Оролцогч бусад улсад энэхүү конвенцийг үргэлжлүүлэн биелүүлж байгааг нотлоход нь оролцогч улсуудад шаардлагатай тоо баримтыг тэдгээр улсад ердийн журмаар өгнө. Ийм тоо баримтад дараах зүйлийг хамруулна:

(i) Нягтлан шалгалтын тухай хавсралтад нийцүүлэн 3, 4, 5 болон 6 дугаар зүйлийн дагуу оролцогч улсуудын өгсөн анхны болон жил бүрийн илтгэл болон мэдүүлэг;

(ii) нягтлан шалгах үйл ажиллагааны үр дүн болон үр өгөөжийн тухай ерөнхий илтгэл;

(iii) энэхүү конвенцийн заалтад нийцүүлэн оролцогч бүх улсад өгөх мэдээлэл;

(с) байгууллагын олж авсан энэхүү конвенцийг хэрэгжүүлэхтэй холбогдох мэдээллийг дараахиас бусад тохиолдолд хэвлэн нийтлэхгүй эсхүл өөрөөр нийтийн хүртээл болгохгүй:

(i) Энэхүү конвенцийн хэрэгжилтийн тухай ерөнхий мэдээллийг Бага хурал, эсхүл Гүйцэтгэх зөвлөлийн шийдвэрт нийцүүлэн нийтэд зориулан эмхэтгэж, нийтийн хүртээл болгож болно;

(ii) тухайн мэдээлэл хамаарах оролцогч улсаас илэрхий зөвшөөрөл авсны үндсэн дээр аливаа мэдээллийг нийтийн хүртээл болгож болно;

(iii) нууцын зэрэглэлд багтаж байгаа мэдээллийг зөвхөн энэхүү конвенцийн хэрэгцээнд чанд нийцүүлэн нийтийн хүртээл болгохыг хангах журмын дагуу Байгууллагаас нийтийн хүртээл болгоно. Тийм журмыг 8 дугаар зүйлийн 21 дэх хэсгийн (i) дэд хэсгийн дагуу Бага хурлаас хэлэлцэж, батална.

(d) нууц тоо баримт буюу баримт бичгийн эмзэг байдлын түвшинг тэдгээртэй зохих ёсоор харьцах, хамгаалахыг хангахын тулд нэг мөр хэрэглэх шалгуурт үндэслэн тогтооно. Эл зорилгоор ангиллын тогтолцоог нэвтрүүлэх бөгөөд уг тогтолцоо нь энэхүү конвенцийг бэлтгэх явцад хийсэн ажлыг харгалzan мэдээллийг нууцлалын зохих ангилалд оруулахыг болон мэдээллийн нууц шинж чанарын үргэлжлэх үндэслэлтэй хугацааг хангах тодорхой шалгуурыг хангана. Ангиллын тогтолцоо нь хэрэгжих явцдаа шаардлагатай уян хатан байдлыг хангахын сацуу нууц мэдээлэл өгч буй оролцогч улсуудыг хамгаална. Ангиллын тогтолцоог 8 дугаар зүйлийн 21 дэх хэсгийн (i) дэд хэсгийн дагуу Бага хурлаас хэлэлцэж, батална;

(e) нууц мэдээллийг Байгууллагын байранд аюулгүй хадгална. Зарим тоо баримт болон баримт бичгийг оролцогч улсын Үндэсний албанад мөн хадгалж болно. Зөвхөн тодорхой байгууламжийг хянан шалгахад шаардлагатай эмзэг мэдээллийг, түүний дотор *inter alia* гэрэл зураг, төлөвлөгөө болон бусад баримт бичгийг тухайн байгуулламжид цоожлон хадгална;

(f) Техникийн нарийн бичгийн дарга нарын газар энэхүү конвенцийн нягтлан шалгах тухай заалтуудыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд дээд зэргээр нийцэх хэмжээнд мэдээлэлтэй харьцаж, түүнийг тухайн мэдээлэл хамаарах байгууламжийг шууд таньж тогтоох боломж олгохгүй хэлбэрээр хадгална;

(g) байгууламжаас гаргасан нууц мэдээлэл нь энэхүү конвенцийн нягтлан шалгах тухай заалтуудыг цаг тухайд нь үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардлагатай хамгийн бага хэмжээнд байна;

(h) нууц мэдээлэлд нэвтрэхийг ангилалд нийцүүлэн зохицуулна. Байгууллага дотор нууц мэдээллийг тараахад “мэдэх шаардлагатай хэмжээ” гэсэн зарчмыг хатуу баримтална.

3. Ерөнхий захирал Техникийн нарийн бичгийн дарга нарын газрын нууц мэдээлэлтэй харьцахыг зохицуулсан горимын хэрэгжилтийн талаар Бага хуралд жил бүр илтгэнэ.

4. Оролцогч улс бүр Байгууллагаас хүлээн авсан мэдээлэлтэй тухайн мэдээллийн хувьд тогтоосон нууцлалын түвшинд нийцүүлэн харьцана. Холбогдох хүсэлтийн дагуу оролцогч улс Байгууллагаас түүнд өгсөн мэдээлэлтэй харьцах тухай дэлгэрэнгүй мэдээллийг өгнө.

**В. Техникийн нарийн бичгийн дарга нарын газрын ажилтныг ажилд авах, ажиллуулах**

5. Ажилтныг ажилд авах нөхцөл нь нууц мэдээлэлд хүрэх болон түүнтэй харьцах нь Ерөнхий захирлын А ангид нийцүүлэн тогтоосон журамд нийцэх явдлыг хангахуйц байна.

6. Техникийн нарийн бичгийн дарга нарын газрын албан тушаал бүрийг тухайн албан тушаалд хэрэв нууц мэдээлэл хэрэгцээтэй бол тийнхүү хэрэгцээтэй нууц мэдээлэлд хүрэх хэмжээг заасан албан ёсны ажлын байрны тодорхойлолтоор зохицуулна.

7. Ерөнхий захирал, хянан шалгагч нар болон бусад ажилтан албан үүргээ гүйцэтгэх явцад мэдэж авсан аливаа нууц мэдээллийг чиг үүрэг нь дууссаны дараа ч аливаа зөвшөөрөлгүй этгээдэд задруулахгүй. Тэд аливаа оролцогч улстай хамаарах үйл ажиллагаатайгаа холбогдуулан хүрэх эрхтэй аливаа мэдээллийг Техникийн нарийн бичгийн дарга нарын газраас гадна аливаа улс, байгууллага буюу этгээдэд мэдэгдэхгүй.

8. Хянан шалгагч нар чиг үүргээ гүйцэтгэхдээ зөвхөн мандатаа биелүүлэхэд нь шаардлагатай мэдээлэл, тоо баримтыг шаардана. Тэд тохиолдлоор цуглуулсан бөгөөд энэхүү конвенцийг дагаж мөрдөж байгааг нягтлан шалгахад хамааралгүй мэдээллийг бүртгэн тэмдэглэхгүй.

9. Ажилтнууд ажиллах хугацаа болон түүнийг дууссаны дараа таван жилийг хамарсан нууцлалын тухай хэлэлцээрийг Техникийн нарийн бичгийн дарга нарын газартай тус бүрчлэн байгуулна.

10. Зүй бусаар задруулахаас зайлсхийхийн тулд хянан шалгагч нар болон ажилтнуудад аюулгүй байдал, түүнчлэн зүй бусаар задруулсан тохиолдолд хүлээж болох шийтгэлийн талаар зохих ёсоор зөвлөж, сануулна.

11. Оролцогч улсын нутаг дэвсгэр, эсхүл хэргийн харьялал буюу хяналтан дор нь орших аливаа өөр газарт явуулж буй үйл ажиллагаанд хамаарах нууц мэдээлэлд хүрэх боломжийг ажилтанд олгохоос 30-аас доошгүй хоногийн өмнө ийнхүү хүрэх боломж олгох саналын тухай холбогдох оролцогч улсад мэдэгдэнэ. Хянан шалгагч нарын хувьд томилгооны талаархи санал нь энэ шаардлагыг хангана.

12. Хянан шалгагч нар болон Техникийн нарийн бичгийн дарга нарын газрын бусад ажилтны ажлын гүйцэтгэлийг дүгнэхдээ нууц мэдээлэл хамгаалах талаархи тухайн ажилтны үзүүлэлтийг тусгайлан анхаарна.

**С. Газар дээр нь нягтлан шалгах явцад эмзэг суурилуулалтыг хамгаалах болон нууц тоо баримтыг задруулахаас сэргийлэх арга хэмжээ**

13. Оролцогч улсууд нууцлалыг хамгаалахад шаардлагатай гэж үзсэн арга хэмжээг авч болох бөгөөд чингэхдээ тэд үүргээ холбогдох зүйлүүд болон Нягтлан шалгалтын тухай хавсралтад нийцүүлж байгаагаа харуулахаар биелүүлнэ. Хянан шалгалт хүлээж аваходаа оролцогч улс эмзэг бөгөөд хянан шалгах зорилгод хамааралгүй гэж үзэж байгаа тоног төхөөрөмж, бичиг баримт буюу талбайг хянан шалгах багт зааж өгч болно.

14. Хянан шалгах баг газар дээр нь хийх хянан шалгалтыг хамгийн түрэмгийг бус байдлаар, зорилтоо цаг тухайд нь үр ашигтай биелүүлэхээр явуулах зарчмыг удирдлага болгоно. Тэд химиийн зэвсэгт хамааралгүй эмзэг тоног төхөөрөмж болон

мэдээллийг хамгаалах явдлыг хангах үүднээс хянан шалгах аль ч шатанд хянан шалгуулж буй оролцогч улсаас гаргаж болох саналыг харгалзан үзнэ.

15. Хянан шалгах баг хянан шалгалтыг зохицуулж буй холбогдох зүйлүүд болон хавсралтад заасан заалтуудыг чанд мөрдөнө. Тэд эмзэг тоног төхөөрөмжийг хамгаалах болон нууц тоо баримтыг задруулахаас сэргийлэх зориулалттай журмыг бүрэн хүндэтгэнэ.

16. Тохиролцоо болон байгууламжийн тухай хэлэлцээрийг боловсруулах явцад нууц мэдээлэл хамгаалах шаардлагад зохих анхаарлыг хандуулна. Байгууламж тус бүрийн хянан шалгах журмын тухай хэлэлцээрт хянан шалгагч нар нэвтрэх эрх олгогдсон байгууламжийн бүсүүдийг тодорхойлох, газар дээр нь нууц мэдээллийг хадгалах асуудал, тохиролцсон бүс дэх хянан шалгалтын арга хэмжээний хүрээ, дээж авах болон шинжлэх, бүртгэлд нэвтрэх, түүнчлэн багаж хэрэгсэл болон тасралтгүй ажиглан шинжих тоног төхөөрөмжийг ашиглах асуудлаархи тусгай бөгөөд нарийвчилсан тохиролцоог тусгана.

17. Хянан шалгалт бүрийн дараа бэлтгэх илтгэлд зөвхөн энэхүү конвенцийг дагаж мөрдөхтэй холбоотой баримтыг тусгана. Илтгэлийг нууц мэдээлэлтэй харьцах асуудлыг зохицуулсан Байгууллагаас тогтоосон дүрэмд нийцүүлэн ашиглана. Шаардлагатай бол илтгэлд байгаа мэдээллийг Техникийн нарийн бичгийн дарга нарын газар болон хянан шалгуулж буй оролцогч улсаас гадагш дамжуулахаас өмнө арай эмзэг бус хэлбэрт оруулж болно.

#### **D. Нууцлалыг зөрчсөн эсхүл зөрчсөн гэх тохиолдолд хэрэглэх журам**

18. Ерөнхий захирал 8 дугаар зүйлийн 21 дэх хэсгийн (i) дэд хэсгийн дагуу Бага хурлаас хэлэлцэж, батласан зөвлөмжийг харгалзан нууцлалыг зөрчсөн, эсхүл зөрчсөн гэх тохиолдолд дагаж мөрдөх шаардлагатай журмыг тогтооно.

19. Ерөнхий захирал тус бүрчлэн байгуулсан нууцлалын тухай хэлэлцээрийн хэрэгжилтийг хянана. Нууц мэдээллийг хамгаалах талаархи үүргээ зөрчсөн гэх хангалттай шинж тэмдэг илэрсэн гэж Ерөнхий захирал үзэж байгаа бол мөрдөн байцаалтыг даруй эхлүүлнэ. Хэрэв нууцлалыг зөрчсөн тухай оролцогч улс мэдэгдвэл Ерөнхий захирал мөн мөрдөн байцаалтыг даруй эхлүүлнэ.

20. Нууц мэдээллийг хамгаалах талаархи үүргээ зөрчсөн ажилтнуулын хувьд Ерөнхий захирал шийтгэлийн болон сахилгын зохих арга хэмжээ авна. Ноцтойгоор зөрчсөн тохиолдолд Ерөнхий захирал хэргийн харьяаллын хувьд олгосон дархан эрхийг нь эгүүлэн авч болно.

21. Оролцогч улсууд нууцлалыг зөрчсөн эсхүл зөрчсөн гэх тохиолдолд мөрдөн байцаалт явуулахад нь болон зөрчлийг тогтоосон тохиолдолд зохих арга хэмжээ авахад нь Ерөнхий захиралтай боломжтой хэмжээнд хамтран ажиллаж, дэмжлэг үзүүлнэ.

22. Байгууллага нь Техникийн нарийн бичгийн дарга нарын газрын ажилтнуудын гаргасан нууцлалын талаархи ямарваа зөрчилд хариуцлага хүлээхгүй.

23. Оролцогч улс болон Байгууллагын аль алинтай холбоотой зөрчлийн хувьд Бага хурлын туслах байгууллага хэлбэрээр байгуулагдсан “Нууцлалтай холбоотой маргаан шийдвэрлэх комисс” хэргийг хэлэлцэнэ. Энэ комиссыг Бага хурал томилно. Түүний бүрэлдэхүүн, үйл ажиллагааны журмыг зохицуулсан дүрмийг Бага хурал анхдугаар чуулганаараа батална.

**МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ**

**БОТЬ VI**

УИХ-ын Тамгын газрын хэвлэх хэсэгт хэвлэв.

Утас 329487

Хэвлэлийн хуудас 32,5